

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө
зэрлэгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх
гэрээний Ерөнхий хэлэлцээр

1. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200001

ГҮЙЦЭТГЭГЧ

Г. Мороний

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

МОНГОЛ УЛС

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК

БОЛОН

“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ”

НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН

**“БОГДХАН ТӨМӨР ЗАМ” ТӨСЛИЙН ДООД БҮТЭЦ, ӨРТӨӨ,
ЗӨРЛӨГИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР**

ГЭРЭЭНИЙ ДУГААР 773-м нэгж/03

ГЭРЭЭНИЙ ДУГААР 111/482

УЛААНБААТАР ХОТ
2022 он

**"БОГДХАН ТӨМӨР ЗАМ" ТӨСЛИЙН ДООД БҮТЭЦ, ӨРТӨӨ, ЗӨРЛӨГИЙН
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ХЭЛЭЛЦЭЭР**

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар... ТТЗ-МН22/03
Дугаар... МН/Н82.....

Улаанбаатар
хот

Энэхүү ГЭРЭЭГ дор дурдсан **ТАЛУУД** харилцан тохиролцож байгуулав.

Нэг талаас: Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг Б блок, 11 давхарт байрлах "Тавантолгой төмөр зам" ХХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал;

Нөгөө талаас: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө-51 хаят байрлах Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг "Зэвсэгт хүчний Жанжин штаб" (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж дарга дэслэгч генерал Д.Ганзориг нар.

A. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг;

B. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 71 дүгээр тогтоолоор төмөр замын зарим шинэ чиглэлүүдийн талаарх нэмэлт, өөрчлөлтийг;

C. Монгол Улсын Зам, тээврийн яам, ОХУ-ын "ОТЗ" НН-ийн I хооронд 2014 оны 9 дүгээр сард байгуулсан "Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай хэлэлцээрийг;

D. Ташкент хотноо 2016 онд болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 16 дугаар хуралдааны үеэр Монгол улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтаар тохиролцсон 32 төслийг хамтарч хэрэгжүүлэх Хятад - Монгол - Орос гурван улсын эдийн засгийн коридор байгуулах төсөл хөтөлбөрийг;

E. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг;

F. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг;

G. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг;

ЗАХИАЛАГЧ

3ХЖШ 2200003

Н. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг;

I. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн захиалгаар “Урбан девелопмент консалтинг групп” ХХК-аас боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 243/2021 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадалсныг үндэслэн “Богдхан төмөр зам”-ын ТЭЗҮ-г дэмжсэнийг;

J. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр шийдвэрээр “Богдхан төмөр зам”-ын ТЭЗҮ-ийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэнийг;

K. Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 100/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр “Богдхан төмөр зам”-ын ТЭЗҮ-ийг магадалсныг тус тус дурьдаж;

I. Монгол Улсын Засгийн газрын “Богдхан төмөр зам” төслийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 206 дугаар тогтоолд “... “Богдхан төмөр зам” төслийн санхүүжилтийн асуудлыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдэд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохих журмын дагуу Засгийн газраар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт тус тус даалгав” гэж тогтоосныг;

II. Монгол Улсын Засгийн газрын “Тусгай зөвшөөрөл олгох тухай” 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 230 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой Төмөр Зам” ХХК-д олгосныг;

III. Монгол Улсын Засгийн газрын “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой Төмөр Зам” ХХК-д олгосныг;

IV. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлд “... “Тавантолгой төмөр зам” ХХК-тай холбоотой хэсгийн 2-т “Богдхан төмөр зам”-ын төслийн барилгын ажлын хүрээнд өмнө гарсан шийдвэрүүдийг судалж, холбогдох өөрчлөлт оруулсны үндсэн дээр төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабаар гүйцэтгүүлэхээр тооцож, зохих арга хэмжээ авахыг Зам, тээвэр хөгжлийн сайд Л.Халтар, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал нарт даалгав” гэж тэмдэглэснийг;

V. “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн мн/01, мн/03, мн/28 дугаартай хамтарсан тушаалд “... “Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн барилгын ажлыг “Зэвсэгт

ЗАХИАЛАГЧ

хүчний Жанжин штаб"-аар гүйцэтгүүлэхийг "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү), Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал), санхүүжилтийг барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2022-2024 онд гүйцэтгэлээр шууд санхүүжүүлэх нөхцөлөөр ТЭЗҮ-д туссан дунд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), Гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг), "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү), Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал) нарт тус тус даалгав" гэснийг;

VI. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Гэрээ байгуулах тухай" 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолд "... "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 31 дүгээр тогтоолд заасан санхүүжилтээр "Богдхан төмөр зам" төслийн доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ"-г гүйцэтгэгч компанийтай байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д зөвшөөрсүгэй" гэснийг;

VII. Зэвсэгт хүчний Жанжин штаб, түүний эрх, үүрэг шилжүүлсэн байгууллага, харьяа ангиуд нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх эрх бүхий, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, холбогдох бусад хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд мөн болохыг;

VIII. Тагнуулын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1629 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг;

IX. Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйл болон 343-358 дугаар зүйл, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.11 дэх заалт болон 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Талууд дараах гол нөхцөлийг харилцан тохиролцов. Үүнд:

1. Гэрээний ерөнхий хэлэлцээрийн үг хэллэг нь Гэрээний нөхцөлийн үг, хэллэгтэй утга болон агуулгын хувьд нэг байна.

2. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь "Богдхан төмөр зам" төслийн доод бүтэц, ертөө, зөрлөгийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

3. Энэхүү Гэрээ нь Гэрээний ерөнхий хэлэлцээр, Гэрээний ерөнхий нөхцөл болох Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбооноос эрхлэн гаргасан "FIDIC Conditions of Contracts for Construction" (For Building and Engineering Works Designed By The Employer, Second Edition, 2017) баримт бичиг, Гэрээний ерөнхий нөхцөлд заасан зааварчилгааны дагуу Талуудын харилцан тохиролцсон Гэрээний тусгай нөхцөл, Гэрээний нөхцөлийн хавсралтуудаас бүрдэнэ.

4. Гэрээг бүрдүүлж буй баримт бичгүүд нэг нь нөгөөгөө тайлбарлах бөгөөд баримт бичгийн давуу байдлын хувьд дараах байдлаар эрэмбэлэгдэнэ. Үүнд:

- 4.1. Эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл;
- 4.2. Гэрээний ерөнхий хэлэлцээр;
- 4.3. Нууц хадгалах гэрээ;

ЗАХИАЛАГЧ

3ХЖШ 2200005

- 4.4. Гэрээний тусгай нөхцөл А хэсэг (Гэрээний өгөгдөл);
- 4.5. Гэрээний тусгай нөхцөл Б хэсэг (Тусгай заалтууд);
- 4.6. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН);
- 4.7. Гэрээний нөхцөлийн хавсралт 1 (Захиалагчийн шаардлага);
- 4.8. Гэрээний нөхцөлийн хавсралт 2 (Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээний хүснэгт);
- 4.9. Зураг төсөл;
- 4.10. Гэрээний нөхцөлийн хавсралт (Ажлын график төлөвлөгөө);
- 4.11. Дагалдах бусад баримт бичиг;

5. Гүйцэтгэгч нь:

5.1. Гэрээний нөхцөлийн хавсралт 2 (Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ)-т заасан тоо хэмжээ бүхий ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, Захиалагчийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ;

5.2. Ажлын график төлөвлөгөөнд заасан болон Гэрээнд заасан үндэслэлээр сунгасан хугацаанд бүрэн гүйцэд хийж гүйцэтгэн, зориулалтын дагуу хэвийн ашиглах боломжтой төмөр замын шугамын доод бүтэц, барилга байгууламжийг Захиалагч талд хүлээлгэн өгнө;

5.3. Энэ Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэл, хүчин зүйлд үндэслэн гаргасан Инженерийн “Ажил эхлүүлэх мэдэгдэл”-д заасан хугацаанд Ажлыг эхлүүлнэ.

6. Захиалагч нь “Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлын төлбөрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг өөрийн хөрөнгө, Санхүүжилтийн гэрээ болон Талуудын харилцан тохиролцсон санхүүгийн бусад эх үүсвэрээр Гүйцэтгэлд суурilan мөнгөн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

7. Гэрээний зөвшөөрөгдсөн үнийн дүн нь магадлагдсан ТЭЗҮ-д заасан 342,007,106.68 (гурван зуун дөчин хоёр сая долоон мянга нэг зуун зургаан ам.доллар жаран найман цент) ам.доллар байх ба түүнтэй тэнцэх мөнгөн дүн (“Эрдэнэс- Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК нарын хооронд байгуулах Санхүүжилтийн гэрээнд заасан ханш)-ээс ихгүй байна. Төлбөрийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоно. Энэхүү зөвшөөрөгдсөн дүн нь НӨАТ орсон дүн байна.

8. Гэрээний зарим хэсэг хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь энэхүү Гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

9. Гэрээний аливаа асуудалтай холбоотой, энэ Гэрээ болон гэрээний иж бүрдлийн харилцан хамаарал нь эдгээр гэрээний иж бүрдлийн бие даасан, тусдаа байдлыг аливаа хэлбэрээр хөндөхгүй.

10. Энэхүү хэлэлцээр нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

11. Гэрээг Монгол хэлээр 3 эх хувь үйлдэх бөгөөд Захиалагч тал 2 хувийг, Гүйцэтгэгч тал 1 хувийг тус тус хадгална.

ЗАХИАЛАГЧ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМ” ХУЧНИЙ ТӨЛӨӨЛЖ:



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАВАНТОЛГОЙ
ТӨМӨР ЗАМ

1119279488
2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.УДААНЖАРГАЛ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ “ЗЭВСЭГТ ХУЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ”-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХУЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200995

ИЛ БОЛСОН

МАШ ИҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий нөхцөл

2. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Энэхүү Гэрээний ерөнхий нөхцөл нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбооноос 2017 онд хэвлэн гаргасан “FIDIC Conditions of Contract for Construction” (Second Edition, 2017) баримт бичиг байна.

ЗАХИАЛАГЧ

Б.Морийн

FIDIC RED BOOK—SECOND EDITION 2017.

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Морийн


ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ



International Federation of
Consulting Engineers (FIDIC)

ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБОО

Барилга Угсралтын ажлын Гэрээний Ерөнхий Нөхцөл

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ 2017

АЛБАН БУС ОРЧУУЛГА

Улаанбаатар хот

1

ЗАХИАЛАГЧ

Бодорж

FIDIC RED BOOK—SECOND EDITION 2017.

ГҮЙЦЭТГЭГЧ

Г. Мартинов

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ТУСГАЙ НӨХЦӨЛ БОЛОН
ХАВСРАЛТ БЭЛТГЭХ
ЗААВАРЧИЛГАА: БАТАЛГААНЫ
МЯГТУУД

ФИДИК® Гэрээний Нөхцөлүүд БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

ТЕНДЕРИЙН ЗАХИДЛЫН
ЗАГВАР, ТЕНДЕРТ ШАЛГАРСАН
ТУХАЙ ЗАХИДЛЫН ЗАГВАР,
ГЭРЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭР,
МАРГААНААС ЗАЙЛСХИЙХ/
ЗОХИЦУУЛАХ ГЭРЭЭ

ЗАХИАЛАГЧИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ДАГУУ
ГҮЙЦЭТГЭХ БАРИЛГЫН УГСРАЛТ БОЛОН
ИНЖЕНЕРИНГИЙН АЖИЛД ЗОРИУЛАВ

Ерөнхий нөхцөл

2

ЗАХИАЛАГЧ

FIDIC RED BOOK—SECOND EDITION 2017.

ГҮЙЦЭТГЭГЧ

Ерөнхий нөхцөл

АГУУЛГА

1 ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

- 1.1 Нэр томьёоны тодорхойлолт
- 1.2 Үг хэллэгийн тайлбар
- 1.3 Мэдэгдэл болон Бусад харилцаа холбоо
- 1.4 Хэрэглэгдэх хууль болон Хэл
- 1.5 Баримт бичгийн давуу байдлын эрэмбэ
- 1.6 Гэрээний ерөнхий хэлэлцээр
- 1.7 Эрх шилжүүлэх
- 1.8 Баримт бичгийг хадгалах, хүлээлгэн өгөх
- 1.9 Зураг төсөл болон Зааварчилгаа удаашрах
- 1.10 Захиалагч Гүйцэтгэгчийн баримт бичгийг ашиглах
- 1.11 Гүйцэтгэгч Захиалагчийн баримт бичгийг ашиглах
- 1.12 Нууцпал
- 1.13 Хууль тогтоомжийг дагаж мөрдөх
- 1.14 Хамтран болон дангаар хүлээх хариуцлага
- 1.15 Хариуцлагыг хязгаарлах
- 1.16 Гэрээ цуцлалт

2 ЗАХИАЛАГЧ

- 2.1 Ажлын талбайд нэвтрэх эрх
- 2.2 Дэмжлэг, туслалцаа үзүүлэх
- 2.3 Захиалагчийн ажилтан болон түүний бусад Гүйцэтгэгчид
- 2.4 Захиалагчийн санхүүгийн зохицуулалт
- 2.5 Ажлын талбайн нөхцөл байдал болон холбогдох мэдээлэл
- 2.6 Захиалагчаас нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж

3 ИНЖЕНЕР

- 3.1 Инженер
- 3.2 Инженерийн эрх үүрэг
- 3.3 Инженерийн төлөөлөгч
- 3.4 Инженер эрх шилжүүлэх
- 3.5 Инженерийн зааварчилгаа
- 3.6 Инженерийг солих
- 3.7 Тохиролцох эсхүл шийдвэрлэх

3.8 Хурал, уулзалт

4 ГҮЙЦЭТГЭГЧ

4.1 Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг

4.2 Гүйцэтгэлийн баталгаа

4.3 Гүйцэтгэгчийн төлөөлөгч

4.4 Гүйцэтгэгчийн баримт бичиг

4.5 Сургалт

4.6 Хамтын ажиллагаа

4.7 Улаан шугам, тэг тэнхлэг байгуулах

4.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үүрэг хариуцлага

4.9 Чанарын удирдлага, Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо

4.10 Ажлын талбайн мэдээллийг ашиглах

4.11 Гэрээний батлагдсан дүнгийн хүрэлцээтэй байдал

4.12 Байгаль, газар зүйн урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал

4.13 Зорчих эрх болон туслах тоног, хэрэгсэл

4.14 Орчин тойронд сөргөөр нөлөөлөхөөс зайлсхийх

4.15 Ажлын талбайд нэвтрэх зам

4.16 Бараа, материалын тээвэрлэлт

4.17 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж

4.18 Байгаль орчныг хамгаалах

4.19 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай түр хангарт

4.20 Ажлын явцын тайлан

4.21 Ажлын талбайн хамгаалалт

4.22 Гүйцэтгэгчийн Ажлын талбай дахь үйл ажиллагаа

4.23 Археологийн болон Геологийн олдворууд

5 ТУСЛАН ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

5.1 Туслан гүйцэтгэгч

5.2 Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч

6 АЖИЛТНУУД

6.1 Ажилтнуудыг зохион байгуулах

6.2 Цалингийн үнэлгээ болон хөдөлмөрийн нөхцөл

6.3 Ажилтан урвуулан авах

6.4 Хөдөлмөрийн хууль тогтоомж

6.5 Ажлын цаг

6.6 Ажилтнуудад зориулсан байр

6.7 Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

6.8 Гүйцэтгэгчийн удирдлага хяналтын бүтэц

6.9 Гүйцэтгэгчийн ажилтнууд

6.10 Гүйцэтгэгчийн бүртгэл

6.11 Хэв журмыг зөрчих

6.12 Голлох ажилтнууд

7 БАРАА МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАР

7.1 Ажил гүйцэтгэх арга хэлбэр

7.2 Загвар, дээж

7.3 Үзлэг, шалгалт

7.4 Гүйцэтгэгчийн хийх туршилт

7.5 Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах

7.6 Доголдлыг засварлах

7.7 Бараа материал, тоног төхөөрөмжийг өмчлөх эрх

7.8 Нөөц ашигласны төлбөр

8 АЖИЛ ЭХЛЭХ, ХУГАЦАА ХОЙШЛОХ БОЛОН АЖЛЫГ ТҮР ЗОГСООХ

8.1 Ажил эхлэх

8.2 Ажил дуусгах хугацаа

8.3 Ажлын хөтөлбөр

8.4 Урьдчилсан анхааруулга

8.5 Ажил дуусгах хугацааг сунгах

8.6 Эрх бүхий байгууллагаас шалтгаалж хугацаа хойшлох

8.7 Ажлын явцыг үнэлэх

8.8 Хугацаа хойшилсны алданги

8.9 Захиалагч Ажлыг түр зогсоох

8.10 Захиалагч Ажлыг түр зогсоосны үр дагавар

8.11 Захиалагч Ажлыг түр зогсоосны дараах бараа материал, тоног төхөөрөмжийн төлбөр

8.12 Түр зогсолт сунжрах

8.13 Ажлыг дахин үргэлжлүүлэх

9 АЖИЛ ДУУСМАГЦ ХИЙХ ТУРШИЛТ

9.1 Гүйцэтгэгчийн үүрэг

9.2 Хойшлогдсон туршилт

9.3 Давтан туршилт

9.4 Ажил дуусмагц хийх туршилт амжилтгүй болох

10 ЗАХИАЛАГЧ АЖЛЫГ ХҮЛЭЭН АВАХ

10.1 Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах

10.2 Ажлын бүрдлийг хүлээн авах

10.3 Ажил дуусмагц хийх туршилт саатах

10.4 Нөхөн сэргээх шаардлагатай гадаргуу

11 АЖИЛ ХҮЛЭЭН АВСНЫ ДАРААХ ДОГОЛДОЛ

11.1 Дутуу ажлыг гүйцээж, доголдлыг арилгах

11.2 Доголдлыг арилга зардал

11.3 Доголдол мэдэгдэх хугацааг сунгах

11.4 Доголдлыг арилгаж чадаагүй тохиолдол

11.5 Доголдлыг Ажлын талбайн гадна арилгах

11.6 Доголдлыг арилгасны дараах туршилтууд

11.7 Ажил хүлээн авсны дараах талбайд нэвтрэх эрх

11.8 Гүйцэтгэгч судалгаа хийх

11.9 Гүйцэтгэлийн гэрчилгээ

11.10 Гүйцэтгээгүй үүрэг

11.11 Ажлын талбайг чөлөөлөх

12 АЖЛЫН ХЭМЖИЛТ БА ӨРТГИЙГ ТОДОРХОЙЛОХ

12.1 Хэмжилт хийгдэх ажлууд

12.2 Хэмжилт хийх аргачлал

12.3 Гүйцэтгэсэн ажлын өртөг/үнэлгээг тодорхойлох

12.4 Гүйцэтгэх ажлаас хасалт хийх

13 ГЭРЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ БА ТОХИРУУЛГА

13.1 Өөрчлөлт оруулах эрх

13.2 Техникийн оновчтой шийдэл

13.3 Өөрчлөлт оруулах журам

13.4 Нөөц хөрөнгө

13.5 Өдрөөр тооцох ажил

13.6 Хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан тохируулга хийх

13.7 Өртөгт орсон өөрчлөлттэй холбогдуулан тохируулга хийх

14 ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

14.1 Гэрээний үнэ

14.2 Урьдчилгаа төлбөр

14.3 Явц дундын төлбөрийн хүсэлт

14.4 Төлбөрийн хуваарь

14.5 Ажилд зориулсан бараа материал, тоног төхөөрөмж

14.6 Явц дундын төлбөрийн гэрчилгээг (IPC) олгох

14.7 Төлбөр

- 14.8 Хойшилсон төлбөр
- 14.9 Суутган барих мөнгөн дүнг чөлөөлөх
- 14.10 Ажил дуусмагц өгөх тайлан
- 14.11 Эцсийн төлбөрийн хүсэлт
- 14.12 Үүргээс чөлөөлөх
- 14.13 Эцсийн төлбөрийн гэрчилгээг (FPC) олгох
- 14.14 Захиалагчийн хариуцлагын хугацаа дуусах
- 14.15 Төлбөрийн валют

15 ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 15.1 Алдааг засварлах тухай Мэдэгдэл
- 15.2 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцлах
- 15.3 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцалсны дараах төлбөрийн тооцоо
- 15.4 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцалсны дараах төлбөр
- 15.5 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцлах
- 15.6 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцалсны дараах төлбөрийн тооцоо
- 15.7 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцалсны дараах төлбөр

16 ГҮЙЦЭТГЭГЧ АЖЛЫГ ТҮР ЗОГСООХ БА ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 16.1 Гүйцэтгэгч ажлыг түр зогсоох
- 16.2 Гүйцэтгэгч гэрээг цуцлах
- 16.3 Гэрээ цуцалсны дараах Гүйцэтгэгчийн үүрэг
- 16.4 Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцалсны дараах төлбөр

17 ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫГ ХАМГААЛАХ БА НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛӨХ

- 17.1 Ажлыг арчилж, хамгаалах үүрэг
- 17.2 Ажлыг арчилж хамгаалахтай холбогдох хариуцлага
- 17.3 Оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх
- 17.4 Гүйцэтгэгчийн төлөх нөхөн төлбөр
- 17.5 Захиалагчийн төлөх нөхөн төлбөр
- 17.6 Хамтран төлөх нөхөн төлбөр

18 ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 18.1 Давагдашгүй хүчин зүйлс
- 18.2 Давагдашгүй хүчин зүйлийн тухай Мэдэгдэл
- 18.3 Ажил хойшлох хугацааг бууруулах үүрэг
- 18.4 Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар
- 18.5 Гэрээг цуцлах эрх
- 18.6 Хуулийн дагуу Гэрээний үүргээс чөлөөлөх

19 ДААТГАЛ

19.1 Ерөнхий шаардлага

19.2 Гүйцэтгэгчийн хариуцах даатгал

20 ЗАХИАЛАГЧ БОЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭХЭМЖЛЭЛ

20.1 Нэхэмжлэл

20.2 Төлбөр болон/эсхүл хугацаа сунгахтай холбоотой нэхэмжлэл

21. МАРГААН БА АРБИТРЫН АЖИЛЛАГАА

21.1 МЗШЗ байгуулах

21.2 МЗШЗ-ийн гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох

21.3 Маргаанаас зайлсхийх

21.4 МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах/хүлээн авах

21.5 Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх

21.6 Арбитрын ажиллагаа

21.7 МЗШЗ-ийн шийдвэрийг үл биелүүлэх

21.8 МЗШЗ байхгүй/бүрдээгүй тохиолдол

ИЛ БОЛСОН**МАШ НҮҮЦ****ХАВСРАЛТ**

МАРГААНААС ЗАЙЛСХИЙХ /ЗОХИЦУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
ХЭСГИЙН ИНДЕКС

*Бодорж**Б.Маржанов*

1. Ерөнхий зүйл

1.1. Нэр томъёоны тодорхойлолт

Тухайн үг хэллэгийн хам утга өөр байхаас бусад тохиолдолд дор дурдсан үг хэллэгүүд нь Гэрээнд дараах тогтоосон утсыг илэрхийлнэ.

1.1.1 “Гэрээний батлагдсан дүн” гэж “Тендерт шалгарсан тухай захидал”-д заасан, Гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнийн дүнг хэлнэ.

(ажил гүйцэтгэх захиалгын гэрээний дагуу зөвшөөрөгдсөн дүнг хэлнэ.)

1.1.2 “Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээ” гэж гэрээний 14.2.2 [Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээ]-т заасны дагуу Инженерийн гаргасан урьдчилгаа Төлбөрийн гэрчилгээг хэлнэ.

1.1.3 “Урьдчилсан төлбөрийн баталгаа” гэж гэрээний 14.2.1 [Урьдчилгаа төлбөрийн баталгаа]-т заасан баталгааг хэлнэ.

1.1.4 “Суурь огноо” гэж Тендериин санал хүргүүлэх сүүлийн өдрөөс 28 хоногийн өмнөх огноог хэлнэ.

1.1.5 “Тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл” гэж Ажлын график төлөвлөгөөнд тусгагдсан тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл (хэрэв байгаа бол) гэж заасан баримт бичгийг хэлнэ.

1.1.6 “Нэхэмжлэл” гэж Гэрээнд заасан эсхүл Гэрээ болон ажил гүйцэтгэхтэй холбоотой бий болж буй нэг талаас нөгөө талдаа хүргүүлэх эрх олгох эсхүл үүргээс чөлөөлөх тухай хүсэлт эсхүл шаардлагыг хэлнэ.

1.1.7 “Ажил эхлэх огноо” гэж гэрээний 8.1 [Ажил эхлэх]-т заасны дагуу Инженерийн гаргасан мэдэгдэлд заасан огноог хэлнэ.

1.1.8 “Ажлын уялдаа, холбооны нийцлийг хянах тогтолцоо” гэж гэрээний 4.9.2 [Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо]-т заасны дагуу ажлыг гүйцэтгэхэд зориулж Гүйцэтгэгчийн боловсруулж, хэрэгжүүлэх ажлын уялдаа, холбооны нийцлийг хянах тогтолцоог хэлнэ.

1.1.9 “Гэрээний нөхцөл” эсхүл “Энэхүү Гэрээний нөхцөл” гэж Гэрээний тусгай нөхцлийн дагуу өөрчлөлт оруулсан Гэрээний Ерөнхий Нөхцөлийг хэлнэ.

1.1.10 “Гэрээ” (гэж Гэрээний хэлэлцээр, Тендерт шалгарсан тухай захидал, Тендерт шалгарсан тухай захидал, Тендерт хүргүүлэх санал, Ажил гүйцэтгэх гэрээнд хамаарах аливаа хавсралтууд, энэхүү гэрээний нөхцөлүүд, Захиалагчийн шаардлага, Зураг, Ажлын график төлөвлөгөө, Гүйцэтгэгчийн төсөл, төлөвлөгөө, Гүйцэтгэгчийн ирүүлсэн Санал, Түншлэлийн (хэрэв хэрэглэгдэх бол) мэдүүлэг болон Ажил гүйцэтгэх гэрээнд, эсхүл Тендерт шалгарсан тухай захидалд Тендерт шалгарсан тухай захидалтусгасан нэмэлт баримт бичгүүдийг (хэрэв байгаа бол) хэлнэ.

1.1.11 “Гэрээний хэлэлцээр” гэж гэрээний 1.6 [Гэрээний хэлэлцээр]-д заасны дагуу талуудад хүлээн зөвшөөрөгдсөн гэрээг хэлнэ.

1.1.12 “Гэрээний мэдээлэл” гэж Гэрээний тусгай нөхцлийн А хэсэгт заасан гэрээний мэдээллүүдийг хэлнэ.

1.1.13 “Гэрээний үнэ” гэж гэрээний 14.1[Гэрээний үнэ] дэх хэсэгт тодорхойлсон үнийг хэлнэ.

1.1.14 “Гүйцэтгэгч” гэж Захиалагчийн сонгосон, Тендерт шалгарсан тухай захидалд нэрлэсэн этгээд (үүд) болон түүний хууль ёсны эрх залгамжлагч (нар)-ийг хэлнэ.

1.1.15 “Гүйцэтгэгчийн баримт бичиг” гэж Гүйцэтгэгчийн боловсруулсан тооцооны тайлан, цахим файлууд, компьютерийн программ болон бусад программ хангамж, зураг төсөл, гарын авлага, загварууд, Захиалагчийн шаардлага болон бусад техникийн баримт бичгүүд гэх мэт гэрээний 4.4 [Гүйцэтгэгчийн баримт бичиг]-тодорхойлсон баримт бичгүүдийг хэлнэ.

1.1.16 “Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж” гэж Ажил гүйцэтгэхэд шаардагдах Гүйцэтгэгчийн бүх төрлийн багаж, тоног төхөөрөмж, машин механизм, барилгын материалын үйлдвэр, тээврийн хэрэгсэл болон бусад хэрэгслийг хэлнэ. Түр ажилд зориулсан тоног төхөөрөмж, барилгын үндсэн ажлыг бүрдүүлэх буюу барилгын бүрдэлд орж сууринлагдах үндсэн тоног төхөөрөмж, материал болон бусад хэрэгслүүд нь Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжид хамаарахгүй.

1.1.17 “Гүйцэтгэгчийн ажилтан” гэж Гүйцэтгэгчийн төлөөлөгч, мөн Ажлын талбайд болон Ажил явагдах бусад газруудад ажиллаж буй Гүйцэтгэгчийн болон Туслан Гүйцэтгэгч тус бүрийн мэргэжлийн болон туслах ажилчид, бусад ажилтан, мөн Ажил гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх аливаа бусад ажилтнууд багтана.

1.1.18 “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд Гүйцэтгэгчээс нэр заан оруулсан, эсхүл гэрээний 4.3[Гүйцэтгэгчийн төлөөлөгч]-т заасны дагуу Гүйцэтгэгчийн томилсон, Гүйцэтгэгчийг төлөөлж ажиллах хувь хүнийг хэлнэ.

1.1.19 “Өртөг” гэж Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын талбайд болон талбайн гадна Гүйцэтгэгчийн бодитоор зарцуулсан (зарцуулахаар тооцсон), татвар, нэмэлт зардал болон бусад төлбөр хураамж орсон, гэхдээ ашиг ороогүй бүх зардлыг хэлнэ. Гүйцэтгэгч нь гэрээний нөхцлийн холбогдох хэсгийн дагуу өртгийг төлбөрт тооцуулах эрхтэй тохиолдолд тухайн өртгийг Гэрээний үнэ дээр нэмж тооцно.

1.1.20 “Зардал болон ашиг” гэж өртөг дээр, Гэрээний мэдээлэлд заасан, (хэрэв заагаагүй бол таван (5%)) хувиар тооцсон, ашгийг нэмсэн дүнг хэлнэ. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний нөхцлийн холбогдох хэсгийн дагуу өртөг болон ашгийг төлбөрт тооцуулах эрхтэй тохиолдолд энд дурдсан ашгийн хувийг зөвхөн Зардал дээр нэмэх ба Зардал болон ашгийг Гэрээний үнэ дээр нэмж тооцно.

1.1.21 “Тухайн Улс” гэж Ажлын үндсэн ажлыг гүйцэтгэх Ажлын Ажлын талбай (эсхүл түүний ихэнхи хэсэг) байрлах улсыг хэлнэ.

1.1.22 “М3Ш3” буюу “Маргаанаас зайлсхийх/шийдвэрлэх зөвлөл” гэж Гэрээнд ийнхүү нэрлэсэн, эсхүл гэрээний 21.1[М3Ш3 байгуулах], эсхүл 21.2[М3Ш3-н гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох]-т заасны дагуу томилогдсон нэг гишүүн эсхүл гурван гишүүн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) бүхий зөвлөлийг хэлнэ.

1.1.23 “М3Ш3-тэй байгуулах гэрээ” гэж Гэрээний ерөнхий нөхцлийн Хавсралт дахь “Маргаанаас зайлсхийх/шийдвэрлэх зөвлөлтэй байгуулах гэрээний ерөнхий нөхцөл”-г удирдамж болгон, харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулсан, Талууд болон (гэрээний 21.1 [М3Ш3 байгуулах], эсхүл 21.2 [М3Ш3-н гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох] –т заасны дагуу байгуулсан) М3Ш3-н нэг эсхүл гурван (тухайн нөхцөл байдлаас хамаарч) гишүүний гарын үсэг зурсан эсхүл зурахаар тохиролцсон хэлэлцээрийг хэлнэ.

1.1.24 “Ажил дуусах огноо” гэж Инженерийн гаргасан “Ажил хүлээн авах гэрчилгээ”-нд заасан огноог; эсхүл гэрээний 10.1 [Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах] дэх хэсгийн суулийн өгүүлбэрт заасан нөхцөл хангагдсан тохиолдолд Ажил эсхүл Хэсэг ажил нь Гэрээний дагуу дууссан гэж тооцсон огноог; эсхүл гэрээний 10.2 [Ажлын бурдлийг хүлээн авах], нэг бол 10.3 [Ажил дуусмагц хийх туршилт саатах]-т заасан нөхцөл бурдсэн тохиолдолд Ажлыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл ажлын бурдэл хэсгийг Захиалагч хүлээн авсан гэж тооцсон огноог хэлнэ.

1.1.25 “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.

1.1.26 “Өдрөөр тооцох ажлын хуваарь” гэж гэрээний 13.5 [Өдрөөр тооцох ажил] дахь хэсгийн дагуу тус ажилд зарцуулсан ажиллах хүчиний зардал, материал болон машин, механизмын зардалтай холбоотой Гүйцэтгэгчид олгох төлбөрийн дүнг болон тооцох аргачлалыг харуулсан, гэрээнд “Өдрөөр тооцох ажлын хуваарь (хэрэв байвал)” хэмээн нэрлэж оруулсан баримт бичгийг хэлнэ.

1.1.27 “Доголдол мэдэгдэх хугацаа” буюу “ДМХ” гэж Гэрээний мэдээлэлд заасан (хэрвээ заагаагүй бол 1 жилээр тооцох) бөгөөд гэрээний 11.3 [Доголдол мэдэгдэх хугацааг сунгах]-т заасны дагуу сунгагдаж болох; 11.1 [Дутуу ажлыг гүйцээж, Доголдлыг засах]-т заасны дагуу Ажил, хэсэг ажил эсхүл Ажлын бурдэл хэсэгт гарсан доголдолдоголдол болон эвдрэл гэмтлийн талаар мэдэгдэл хүргүүлэх хугацааг хэлнэ. Энэ хугацааг Ажил эсхүл бурдэл хэсэг эсхүл хэсэгчилсэн ажлын “Ажил дуусах огноо”-с эхлэн тоолно.

1.1.28 “Хугацаа хойшилсны алданги” гэж гэрээний 8.2 [Ажил дуусах хугацаа]-т заасан шаардлагыг хангаагүйн улмаас, мөн гэрээний 8.8 [Хугацаа хойшилсны алданги]-д заасны дагуу Гүйцэтгэгчийн хариуцах алдангийг хэлнэ.

1.1.29 “Маргаан” гэж дор дурдсан нөхцөл байдлыг хэлнэ.

а) аль Нэг (Нэхэмжлэгч) тал нь нөгөө (Хариуцагч) талын эсрэг нэхэмжлэл гаргасан (үүнд: энэхүү Гэрээний нөхцөлд тодорхойлсон нэхэмжлэл гаргах, эсхүл гэрээний нөхцөлийн дагуу Инженер дүгнэлт гаргах шаардлагатай асуудал үүсэх гэх мэт) бөгөөд,

б) Хариуцагч тал нь (эсхүл Инженер нь гэрээний 3.7.2 [Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх]-д заасны дагуу) нэхэмжлэлийг бүхэлд нь эсхүл түүний зарим хэсгийг хүлээн зөвшөөрөөгүй, мөн

с) Нэхэмжлэгч тал нь буулт хийхгүй байх (гэрээний 3.7.5 [Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх]-д заасны дагуу үл зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх замаар]).

Хэрэв Хариуцагч тал нь (эсхүл Инженер нь) нэхэмжлэлийг няцааж чадаагүй эсхүл шаардлагатай хариуг өгч чадаагүй байсан хэдий ч, МЗШЗ эсхүл арбитр (үүд) нь Хариуцагч талын байр суурийг үндэслэлтэй гэж үзсэн бол нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл түүний зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох тохиолдол байж болно.

1.1.30 “Зураг төсөл” гэж Гэрээнд орсон ажлын зураг төсөл, мөн Захиалагчийн (эсхүл түүний нэрийн өмнөөс) гаргасан аливаа нэмэлт болон өөрчлөлтийн зураг төслийг хэлнэ.

1.1.31 “Захиалагч” гэж Гэрээний мэдээлэлд захиалагч хэмээн заасан этгээд болон түүний хууль ёсны эрх залгамжлагч нарыг хэлнэ.

1.1.32 “Захиалагчийн тоног төхөөрөмж” гэж гэрээний 2.6 [Захиалагчаас нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж]-д заасан Захиалагчаас

Гүйцэтгэгчид хэрэглүүлэх боломжтой багаж, тоног төхөөрөмж, машин механизм, барилгын материалын үйлдвэр, тээврийн хэрэгслийг (хэрэв байгаа бол) хэлэх ба үүнд 10 [Захиалагч ажлыг хулээн авах]-д заасны дагуу хулээлгэж өгөөгүй байгаа үндсэн тоног төхөөрөмж орохгүй.

1.1.33 “**Захиалагчийн ажилтан**” гэж Инженер, Инженерийн төлөөлөгч, гэрээний 3.4 [Инженер эрх шилжүүлэх]-т заасан туслах ажилтнууд, Гэрээний дагуу Захиалагч үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ажиллах Инженер болон Захиалагчийн бусад бүх ажилчин, ажилтан, ажиллагсдыг, мөн Захиалагч эсхүл Инженерээс Гүйцэтгэгчид хүргүүлсэн Мэдэгдэлд “Захиалагчийн ажилтан” хэмээн тодорхойлсон аливаа ажилтныг хэлнэ.

1.1.34 “**Захиалагчийн нийлүүлэх материал**” гэж гэрээний 2.6 [Захиалагчаас нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж]-д заасан Захиалагчаас Гүйцэтгэгчид нийлүүлэх (хэрэв байгаа бол) материалыг хэлнэ.

1.1.35 “**Инженер**” гэж Гэрээний мэдээлэлд заасан, Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор Захиалагчийн томилсон, эсхүл гэрээний 3.6 [Инженерийг солих]-д заасны дагуу шинээр томилогдсон этгээдийг хэлнэ.

1.1.36 “**Инженерийн Төлөөлөгч**” гэж гэрээний 3.3 [Инженерийн Төлөөлөгч]-т заасны дагуу Инженерийн томилсон хувь хүн этгээдийг хэлнэ.

1.1.37 “**Давагдашгүй хүчин зүйл**” гэж гэрээний 18.1 [Давагдашгүй хүчин зүйл] дэх хэсэгт тодорхойлсон үйл явдал эсхүл нөхцөл байдлыг хэлнэ.

1.1.38 “**Ажил дуусах хугацааг сунгах**” гэж гэрээний 8.5 [Ажил дуусах хугацааг сунгах]-д заасны дагуу Ажил дуусах хугацааг сунгах утгыг агуулна.

1.1.39 “**FIDIC**” гэж Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоог (ФИДИК) хэлнэ.

1.1.40 “**Эцсийн төлбөрийн гэрчилгээ**” гэж гэрээний 14.13 [Эцсийн төлбөрийн гэрчилгээг олгох]-т заасны дагуу Инженерээс олгох төлбөрийн гэрчилгээг хэлнэ.

1.1.41 “**Эцсийн төлбөрийн хүсэлт**” гэж гэрээний 14.11 [Эцсийн төлбөрийн хүсэлт]-т тодорхойлсон Мэдэгдлийг хэлнэ.

1.1.42 “**Гадаад валют**” гэж Гэрээний үнийн нийт дүнг эсхүл хэсэгчилсэн дүнг төлөх мөнгөн тэмдэгтийг хэлэх ба энэ нь тухайн улсын дотоодын мөнгөн тэмдэгт биш болно.

1.1.43 “**Гэрээний ерөнхий нөхцөл**” гэж ФИДИК-ээс гаргасан “Захиалагчийн зураг төслийн дагуу гүйцэтгэх Барилга угсралт болон Инженерийн ажлын гэрээний нөхцөл”-ийг тодорхойлсон баримт бичгийг хэлнэ.

1.1.44 “**Бараа**” гэж Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, материал, үндсэн тоног төхөөрөмж болон түр ажил болон тэдгээрийн аль тохирохыг хэлнэ.

1.1.45 “**Явц дундын төлбөрийн гэрчилгээ**” буюу “**ЯДТГ**” гэж гэрээний 14.6 [Явц дундын төлбөрийн гэрчилгээ олгох] дахь хэсгийн дагуу, явц дундын төлбөрт зориулж Инженерээс гаргасан Төлбөрийн гэрчилгээг хэлнэ.

1.1.46 “**Түншлэл**” гэж түншлэл, ассоциаци, консорциум болон/эсхүл хоёр болон түүнээс дээш хувь хүний нөхөрлөл эсвэл бусад төрлийн нэгдлийг хэлнэ.

1.1.47 “**Түншлэлийн мэдүүлэг**” гэж Төнөрөйн нэг хэсэг болгон Захиалагчид ирүүлсэн, түншлэлээр оролцож буй Гүйцэтгэгчийн хоёр эсхүл түүнээс дээш хуулийн этгээдийн хуул эрх зүйн хариуцлагыг мэдүүлсэн захидалыг хэлнэ. Энэхүү захидалыг

түншлэлийн гишүүн тус бүр гарын үсэг зурж баталгаажуулсан байх ёстой ба Захиалагчид хаягласан байх ёстой, мөн түүнд зүйлсийг тусгасан байх ёстой Үүнд:

а) Түншлэлийн гишүүн тус бүр нь Гүйцэтгэгчийн Гэрээгээр хүлээсэн үүргийг биелэлттэй холбоотойгоор Захиалагчийн өмнө хамтын болон дангаараа хариуцлага хүлээнэ;

б) Түншлэлийн удирдлагчийг тогтоож түүний бүрэн эрхийг баталгаажуулна;

с) Түншлэлийн гишүүн тус бүрийн хийж гүйцэтгэх ажлын болон хэсэгчилсэн ажлын цар хүрээг (хэрвээ байвал) тогтооно.

1.1.48 “**Голлох ажилтнууд**” гэж Захиалагчийн шаардлагад дурдагдсан Гүйцэтгэгчийн төлөөлөгчөөс бусад Гүйцэтгэгчийн албан тушаалтан-ажилтнуудыг (хэрвээ байвал) хэлнэ.

1.1.49 “**Хууль**” гэж улс орны (эсхүл бүс нутгийн) бүх хууль тогтоомжууд, дүрмүүд, хууль эрхийн актууд, зарлиг, тушаал, захирамжууд, гэрээ хэлэлцээр, олон улсын хууль тогтоомжууд болон бусад хууль, гэрээ, аливаа төр, захиргааны байгууллага, агентлагууд болон төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагуудын дүрэм, журмыг хэлнэ.

1.1.50 “**Тендерт шалгарсан тухай захидал**” гэж Захиалагчийн гарын үсэг зурж баталгаажуулан “шалгарсан” болохыг албан ёсоор илэрхийлсэн Тендерийн захидалыг хэлэх бөгөөд уг захидалд Талууд харилцан зөвшилцэж гарын үсэг зурсан аливаа меморандум/санамж бичиг/гэрээ багтана. Хэрвээ шалгарсан тухай албан ёсоор илэрхийлсэн захидал байхгүй тохиолдолд “Тендерт шалгарсан тухай захидал” гэдгийг Гэрээний хэлэлцээр гэж ойлгох бөгөөд Тендерт шалгарсан тухай захидалын хүргүүлсэн эсхүл хүлээн авсан огноог Гэрээний хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажуулсан огноог хэлнэ.

1.1.51 “**Тендерийн саналаын захидал**” гэж Гүйцэтгэгчээс Ажил гүйцэтгэх саналаа Захиалагчид илэрхийлсэнээ дурдсан бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулсан тендерийн захидалыг хэлнэ.

1.1.52 “**Дотоод валют**” гэж тухайн улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ.

1.1.53 “**Материал**” гэж Гэрээний дагуу Ажлын талбайд эсхүл бусад газар байршуулсан, барилгын үндсэн ажлыг бүрдүүлэх эсхүл тухайлсан ажилд хэрэглэгдэх бүх төрлийн эд зүйлсийг (Үндсэн тоног төхөөрөмжжөөс бусад) хэлэх ба үүнд Гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчээс ханган нийлүүлэхээр үүрэг хүлээсэн материалууд (хэрвээ байвал) багтана.

1.1.54 “**cap**” гэж Грекорийн тооллын хуанлийн сарыг хэлнэ.

1.1.55 “**Зөвшөөрсөн мэдэгдэл**” гэж Гүйцэтгэгчийн баримт бичгүүд эсхүл энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Гүйцэтгэгчээс батлуулахаар хүргүүлэх бусад баримт бичгүүд болон ажлыг гүйцэтгэхэд ашиглагдаж болох аливаа бусад баримт бичгүүдэд Инженерийн өгсөн татгалзах зүйлгүй гэсэн хариуг хэлнэ.

1.1.56 “**Мэдэгдэл**” гэж гэрээний 1.3 [Мэдэгдэл болон Бусад харилцаа]-д заасны дагуу гарсан, мэдэгдэл гэж тодорхойлсон аливаа бичгэн харилцааг хэлнэ.

1.1.57 “**Татгалзсан мэдэгдэл**” гэж хэрвээ аль нэг тал нь, гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасан Инженерийн дүгнэлт, эсхүл гэрээний 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах]-т заасан МЗШЗ-ийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд нөгөө Талдаа хүргүүлж болох мэдэгдлийг хэлнэ.

1.1.58 “Бүрдэл ажил” гэж гэрээний 10.2 [Ажлын бүрдлийг хүлээн авах]-т заасны дагуу хүлээн авч, ашигласан ажил эсхүл хэсэгчилсэн ажлын бүрдлийг (тухайн тохиолдоос хамаарна) хэлнэ.

1.1.59 “Гэрээний тусгай нөхцөл” гэж Гэрээнд орсон, гэрээний тусгай нөхцөл хэмээн нэрлэгдсэн баримт бичгийг хэлэх бөгөөд тус нөхцөл нь Гэрээний тусгай нөхцлийн А Бүлэг гэрээний мэдээлэл, гэрээний тусгай нөхцлийн Б Бүлэг – Тусгай заалтууд гэсэн хэсгээс бүрдэнэ.

1.1.60 “Тал” гэж тухайн хам утгаас хамаарч Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийг хэлнэ. Талууд гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь хэлнэ.

1.1.61 “Төлбөрийн гэрчилгээ” гэж гэрээний 14 [Гэрээний үнэ болон төлбөрийн нөхцөл]-т заасны дагуу Инженерээс олгох төлбөрийн гэрчилгээг хэлнэ.

1.1.62 “Гүйцэтгэлийн гэрчилгээ” гэж гэрээний 11.9 [Гүйцэтгэлийн гэрчилгээ]-т заасны дагуу Инженерийн гаргасан (эсхүл гаргасан гэж тооцох) гэрчилгээг хэлнэ.

1.1.63 “Гүйцэтгэлийн баталгаа” гэж гэрээний 4.2 [Гүйцэтгэлийн баталгаа]-т заасан баталгааг хэлнэ.

1.1.64 “Байнгын ажил” гэж Гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэснээр байнгын ашиглалтанд оруулах, барилгын үндсэн ажлуудыг хэлнэ.

1.1.65 “Үндсэн тоног төхөөрөмж” гэж Гэрээний дагуу Ажлын талбай эсхүл бусад газар байршуулсан Барилгын үндсэн ажлыг бүрдүүлэх, эсхүл тухайлсан ажилд орох бүх төрлийн багаж, тоног төхөөрөмж, машин механизм болон тээврийн хэрэгслийг (бүрдэл хэсгийн хамт) хэлнэ.

1.1.66 “Ажлын хөтөлбөр” гэж гэрээний 8.3 [Ажлын хөтөлбөр]-т заасны дагуу Гүйцэтгэгч боловсруулж батлуулахаар хургуулсэн бөгөөд Инженерээс зөвшөөрсөн мэдэгдэл өгсөн (эсхүл өгөгдсөн гэж үзэх), нарийвчилсан төлөвлөгөөг хэлнэ.

1.1.67 “Нөөц хөрөнгө” гэж гэрээний 13.4 [Нөөц хөрөнгө]-т заасны дагуу ажлын аливаа бүрдэл хэсгийг гүйцэтгэхтэй холбоотой, эсхүл үндсэн тоног төхөөрөмж, материал эсхүл ажил, үйлчилгээг ханган нийлүүлэхэд зориулан Захиалагчаас тогтоож Гэрээнд тусгасан дүнг хэлнэ.

1.1.68 “Чанарын удирдлагын тогтолцоо” гэж гэрээний 4.9.1 [Чанарын удирдлагын тогтолцоо]-т заасны дагуу боловсруулж бэлтгэсэн Гүйцэтгэгчийн чанарын удирдлагын тогтолцоог (нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл тодорхой хугацаанд шинэчилж болно) хэлнэ.

1.1.69 “Суутган барих мөнгөн дүн” гэж гэрээний 14.3 [Явц дундын төлбөрийн хүсэлт]-т заасны дагуу Захиалагч авч үлдэх бөгөөд мөн гэрээний 14.9 [Суутган барих мөнгөн дүнг чөлөөлөх]-т заасны дагуу буцаан төлөгдөх суутган барих мөнгөний хуримтлагдсан дүнг хэлнэ.

1.1.70 “Ажлыг нягтлах” гэж Гүйцэтгэгчийн зүгээс хянуулж батлуулахаар хургуулсэн материалыг, Гэрээ болон Гүйцэтгэгчийн Гэрээний үүрэг, эсхүл гэрээтэй холбоотой үүрэгт нийцсэн эсэхэд үнэлгээ өгөх зорилгоор, Инженер магадлан шалгахыг хэлнэ.

1.1.71 “Ажлын график төлөвлөгөө” гэж Захиалагч боловсруулж Гүйцэтгэгч гүйцээн бөглөж тендерийн захидалд хавсаргасан бөгөөд Гэрээнд орсон, хуваарь хэмээн нэрлэсэн баримт бичиг(үүд)-ийг хэлнэ. Энэхүү баримт бичигт өгөгдөл, төлбөрийн төрөл болон хуваарь, болон/эсхүл нэгж үнэ, үнэ болон баталгааны баримт бичгүүд орсон байж болно.

1.1.72 “Төлбөрийн хуваарь” гэж төлбөрийн хуваарь (хэрэв байгаа бол) хэмээн нэрлэж хуваарийн иж бүрдэлд орсон, Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн дүн болон аргачлалыг харуулсан, баримт бичиг(үүд) –ийг хэлнэ.

1.1.73 “Хэсэг ажил” гэж Гэрээний мэдээлэлд Хэсэг ажил(хэрвээ байвал) хэмээн тодорхойлсон ажлыг хэлнэ.

1.1.74 “Ажлын талбай” гэж үндсэн ажил явагдах, мөн үндсэн тоног төхөөрөмж болон материалыг байрлуулах, мөн ажлын талбайг бүрдүүлэх хэсэг хэмээн гэрээнд заасан бусад газруудыг хэлнэ.

1.1.75 “Тусгай заалт” гэж Гэрээний тусгай нөхцлийн Б хэсгийг бүрдүүлэн тусгай заалт хэмээн нэрлэсэн баримт бичгийг (хэрвээ байгаа бол) хэлнэ.

1.1.76 “Захиалагчийн шаардлага” гэж Гэрээний иж бүрдэлд орсон, Захиалагчийн шаардлага хэмээн нэрлэсэн баримт бичиг, мөн Гэрээний заалтын дагуу Захиалагчийн шаардлагад оруулсан аливаа өөрчлөлт болон тохируулгын баримт бичгийг хэлнэ. Энэхүү баримт бичиг нь Ажлын шаардлагыг тодорхойлно.

1.1.77 “Төлбөрийн хүсэлт” гэж гэрээний 14.3 [Явц дундын төлбөрийн хүсэлт], 14.10 [Ажлыг бүрэн хийж дуусмагц өгөх төлбөрийн хүсэлт], эсхүл 14.11 [Эцсийн төлбөрийн хүсэлт]-т тус тус заасны дагуу төлбөрийн гэрчилгээний бүрдэл хэсэг болгон Гүйцэтгэгчээс батлуулахаар хүргүүлсэн хүсэлтийг хэлнэ.

1.1.78 “Туслан гүйцэтгэгч” гэж Гэрээнд туслан гүйцэтгэгч хэмээн нэрлэсэн аливаа этгээд, эсхүл Ажлын бүрдэл хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн томилсон туслан гүйцэтгэгч эсхүл зураг төсөл зохиогч этгээд, мөн тэдгээрийн хууль ёсны эрх залгамжлагч нарыг хэлнэ.

1.1.79 “Ажил хүлээн авсан гэрчилгээ” гэж гэрээний 10 [Захиалагч ажлыг хүлээн авах]-т заасны дагуу Инженерийн гаргасан (эсхүл гаргасан гэж үзэх) гэрчилгээг хэлнэ.

1.1.80 “Түр ажил” гэж Ажлын талбайд ажил гүйцэтгэхэд шаардагдах аливаа бүх төрлийн түр ажлыг (Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжжээс бусад) хэлнэ.

1.1.81 “Тендер” гэж Гүйцэтгэгчээс тендерийн саналын захидалтай хамт хүргүүлсэн бөгөөд Гэрээнд багтсан тендерийн саналын захидал, Гүйцэтгэгчийн санал, түншлэлийн (хэрэв байгаа бол) мэдүүлэг болон бусад баримт бичгүүдийг хэлнэ.

1.1.82 “Ажил дууссаны дараах туршилтууд” гэж Захиалагчийн шаардлагад тусгасан бөгөөд гэрээний 10 [Захиалагч ажлыг хүлээн авах]-т заасны дагуу Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийг (тухайн нөхцөл байдлаас хамаарч) хүлээн авсны дараа, тусгай заалтын шаардлагын дагуу хийгдэх туршилтуудыг (хэрвээ байвал) хэлнэ.

1.1.83 “Ажил дуусмагц хийх туршилтууд” гэж Гэрээнд тодорхойлсон, эсхүл Талууд харилцан зөвшөөрсөн, эсхүл Гэрээний өөрчлөлтийн даалгавраар өгөгдсөн бөгөөд, 10 [Захиалагч ажлыг хүлээн авах]-т заасны дагуу Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийг хүлээн авахаас өмнө (нөхцөл байдлаас хамаарч), мөн гэрээний 9 [Ажил дуусмагц хийх туршилтууд]-т заасны дагуу гүйцэтгэх туршилтуудыг хэлнэ.

1.1.84 “Ажил дуусах хугацаа” гэж гэрээний 8.2 [Ажил дуусах хугацаа]-т заасны дагуу Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) ажлыг дуусгахад зарцуулах, магадгүй гэрээний 8.5 [Ажил дуусгах хугацааг сунгах]-т заасны дагуу сунгагдаж болох, Ажил эхлэх өдрөөс тооцсон хугацааг хэлнэ.

1.1.85 “**Магадалшгүй**” гэж аливаа туршлагатай гүйцэтгэгч суурь огнооноос өмнө урьдчилан таамаглаагүй байх үндэслэлтэй гэж үзэхийг хэлнэ.

1.1.86 “**Өөрчлөлт**” гэж гэрээний 13[Өөрчлөлт ба тохируулга]-д заасан, гэрээний өөрчлөлт хэмээн даалгавар өгсөн, Ажилд оруулах аливаа өөрчлөлтийг хэлнэ.

1.1.87 “**Ажил**” гэж байнгын болон түр ажил эсхүл аль тохирохыг хэлнэ.

1.1.88 “**жил**” гэж 365 хоногийг хэлнэ.

1.2.Үг хэллэгийн тайлбар

Үг хэллэгийн хам утга өөр бахаас бусад тохиолдолд Гэрээний үг хэллэг нь дараах утгыг ирэхийлнэ.

Нэг хүсийг илэрхийлсэн биеийн төлөөний үг нь бүх хүсийн биеийн Төлөөллийг

(a) Нэг хүсийг илэрхийлсэн биеийн төлөөний үг нь бүх хүсийн биеийн төлөөний үе илэрхийлж болно.

(b) Ганц тоон дээр байгаа үгс нь олон тоог, олон тоон дээр байгаа үгс нь ганц тоог илэрхийлж болно.

(c) “Зөвшөөрөх”, “зөвшөөрсөн” эсхүл “зөвшилцөл” гэсэн үгс бүхий үгсийг агуулсан заалтууд нь тухайн тохиролцоо нь бичгээр үйлдэгдэж Талуудын гарын үсгээр баталгаажсан байх ёстой гэсэн утгыг агуулна.

(d) “Бичмэл” эсхүл “бичгээр” гэдэг нь гараар бичсэн, бичгийн машинаар үйлдсэн, хэвлэсэн эсхүл цахим хэлбэрээр боловсруулсан, улмаар дахин засварлах боломжгүй гэсэн утгыг илэрхийлнэ

(e) “болно” гэж аль Нэг тал эсхүл этгээд нь түүнд хандсан асуудал дээр ажиллах эсхүл ажиллахгүй байх сонголттой гэсэн утгыг илэрхийлнэ.

(f) “ёстой” гэж аль нэг Тал, эсхүл этгээд нь Гэрээний дагуу ажил үүргээ биелүүлэх үүрэгтэй гэсэн утгыг илэрхийлнэ.

(g) “зөвшилцөл” гэж аливаа холбогдох асуудлыг Захиалагч, Гүйцэтгэгч, эсхүл Инженер нь зөвшөөрсөн, эсхүл түүнд зөвшөөрөл өгсөн гэсэн утгыг илэрхийлнэ.

(h) “оролцуулан”, “багтана”, “багтсан” гэж үүгээр хязгаарлагдахгүй, эсхүл багтаасан, эсхүл дор дурдсан/дараах зүйлсийг багтаана” гэсэн утгыг илэрхийлнэ.

(i) Этгээд, эсхүл талууд гэсэн үгс нь эрх бүхий хувь хүн, хуулийн этгээдийг (хамтрагч нар болон түүний хууль ёсны эрх залгамжлагчийг оролцуулан) илэрхийлнэ.

(j) “Ажлыг гүйцэтгэх” эсхүл “Ажлын гүйцэтгэл” гэдэг нь Барилгын ажлыг гүйцэтгэх, дуусгах, аливаа гологдолтыг засах ажил гэсэн утгыг илэрхийлнэ. (хэрвээ Гэрээнд заасан бол холбогдох зураг төслийн ажлыг орсон гэж үзнэ)

Хэрвээ энэхүү гэрээний Нөхцөлд үг хэллэгийг жагсааж бичсэн бөгөөд түүний хоёрдугаар үг хэллэгээс сүүлийн үг хэллэг хооронд “ба”, “эсхүл”, “мөн”, “болон/эсхүл”, гэсэн үгс орсон бол жагсаалтын бүх зүйлс нь түүний өмнөх зүйлтэй эдгээр үгсээр болбогdon хамт үншигдах ётой.

Тодруулсан үгс болон бусад гарчгуудыг энэхүү гэрээний нөхцөлийн үг хэллэгийн тайлбарт анхаарч үзэх шаардлагагүй.

1.3.Мэдэгдэл болон Бусад харилцаа

Гэрээний нөхцлүүдэд заасан Мэдэгдэл хийх (Үл зөвшөөрөх мэдэгдэл мөн багтана) болон зөвшөөрөл өгөх, баталгаа өгөх, батлах, баталгаажуулах, зөвлөлдөх, гэрчилгээ олгох, хэлцэл хийх, нэхэмжлэх, шийдвэр гаргах, тодорхойлох, зааварчилгаа өгөх, үл татгалзах, хурал зарлах, хурлын тэмдэглэл, хүсэлт илгээх, хариулт өгөх, бүртгэд тайлан гэх мэт аливаа харилцаа нь бичгээр болон:

(a) Дараах шаардлагыг хангасан байх

i. хэвлэмэл бичиг баримт – биечлэн хүргэх ба илгээж байгаа цаасны эх хувьд илгээж буй талын (Гүйцэтгэгчийн төлөөлөгч, Инженер, эсхүл Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч) гарын үсгээр заавал баталгаажсан байна;

ii. гэрээний мэдээлэлд заасан цахим баримт бичгийг дамжуулах системийг ашиглах ба баталгаажсан хаягаас баталгаажсан хаяг руу илгээгдсэн байна.

(b) Хэрвээ мэдэгдэл хүргүүлж байгаа бол “Мэдэгдэл” гэж заавал тодорхойлсон байна. Хэрвээ энэ нь харилцаа холбооны өөр хэлбэр бол энэ талаар тодорхой дурьдаж, мөн Гэрээний аль заалт(үүд)-д хамаарах талаар тусгана.

(c) Биечлэн хүргэж өгөх, эсхүл шуудангаар илгээх, эсхүл электрон системийн аль нэгийг ашиглан хүргүүлэхдээ энэ хэсгийн (a)(ii) хэсэгт заасныг баримтлана;

(d) Гэрээний мэдээлэлд заасан хүлээн авагчийн хаягаар биечлэн хүргэж өгсөн, шуудангаар илгээсэн эсхүл дамжуулсан байна. Хэдийгээр хүлээн авагч нь хүлээн авах хаягаа өөрчилсөн тухай Хэрэв хүлээн авагч хүлээн авах өөр хаягаар авах тухай Мэдэгдэл ирүүлсэн бол түүнээс хойш илгээх баримт бичгийг Мэдэгдлээр ирүүлсэн шинэчилсэн хаягаар хүргүүлнэ.

Хэрвээ энэхүү Гэрээний нөхцөлд мэдэгдэл эсхүл үл зөвшөөрөх мэдэгдэл эсхүл бусад харилцааны баримт бичгийг хүргүүлсэн, өгсөн, хангасан, илгээсэн, дамжуулсан, мэдээлсэн байхыг тусгайлан зааж үүрэгжүүлсэн бол дээрх (d) заалтад заасны дагуу тухайн хүлээн авагчийн хаягаар хүлээлгэн өгснөөр уг баримт бичгийг албан ёсоор хүлээн авсан эсхүл хүлээлгэн өгснөөр тооцно. Цахимаар дамжуулсан мэдэгдэл эсхүл бусад харилцаа холбоог илгээгчийн хүлээн аваагүй тохиолдолд дамжуулсны дараах өдөр хүлээн авсанд тооцно.

Дээр дурдсан бүх мэдэгдэл болон бусад бүх төрлийн харилцаа холбоог үндэслэлгүйгээр саатуулж, хойшлуулж болохгүй.

Хэрвээ нэг Тал нь эсхүл Инженерээс мэдэгдэл эсхүл үл зөвшөөрөх тухай мэдэгдэл эсхүл гэрчилгээг гаргаж буй бол хүлээн авагч талд цаасан болон/эсхүл цахимаар эх хувийг илгээх бөгөөд хуулбарыг нь Инженерт эсхүл тухайн нөхцөл байдлаас хамаарч нөгөө Талд хүргүүлэх үүрэгтэй. Гэрээний нөхцөлд эсхүл гэрээнд заасны дагуу бусад бүх мэдэгдэл, харилцааг Талуудын аль нэгт болон/эсхүл Инженерт заавал хүргүүлнэ. Холбогдох бусад бүх харилцааны баримт бичгүүдийн хуулбар хувийг эдгээр Нөхцөл болон Гэрээний бусад хэсэгт заасны дагуу Талууд болон/эсхүл Инженер бүрдүүлсэн байх үүрэгтэй

1.4. Хэрэглэгдэх Хууль ба Хэл

Гэрээ нь гэрээний мэдээлэлд заасан улсын хуулиар (эсхүл хууль тогтоомж) (дурдаагүй бол тухайн Улсын хууль тогтоомжийн дагуу) зохицуулагдах бөгөөд аливаа зөрчилдсөн хууль тогтоомжийг эс тооцно.

Гэрээний баримтлах хэлийг гэрээний мэдээлэлд заана (заагаагүй бол энэхүү гэрээнд заасан Нөхцөлийн хэлийг сонгоно). Хэрэв гэрээний зарим хэсэгт нэгээс олон төрлийн хэлээр бичигдсэн тохиолдолд эрх баригч хэл дээрх хувилбарыг баримтална.

Харилцаанд хэрэглэгдэх хэлийг мөн Гэрээний мэдээлэлд заавал заасан байна. Хэрэв харилцааны хэлийг тодорхойлоогүй тохиолдолд Гэрээнд хэрэглэгдэж буй хэлийг харилцаандаа ашиглана

1.5. Баримт бичгийн эрэмбэ

Гэрээг бүрдүүлэх баримт бичгүүд нь гэрээний салшгүй нэгэн хэсэг байх бөгөөд хэрвээ ямар нэгэн зөрчилтэй, хоёрдмол утга бүхий, зөрүүтэй мэдээлэл агуулсан зэрэг байвал дор заасан дарааллын дагуу зэрэглэлийг тогтооно. Үүнд:

- (a) Гэрээний хэлэлцээр;
- (b) Тендерт шалгарсан тухай захидал;
- (c) Тендерийн саналын захидал;
- (d) Гэрээний тусгай нөхцөл Хэсэг А – Гэрээний мэдээлэл;
- (e) Гэрээний тусгай нөхцөл Хэсэг Б – Тусгай заалтууд;
- (f) Гэрээний ерөнхий нөхцөл;
- (g) Захиалагчийн шаардлага;
- (h) Зураг төсөл;
- (i) Хуваарь;
- (j) Түншлэлийн мэдүүлэг (хэрэв Гүйцэтгэгч нь Түншлэл бол);
- (k) Гэрээг бүрдүүлж байгаа бусад баримт бичгүүд.

1.6. Гэрээний ерөнхий хэлэлцээр

Хэрэв талууд Баримт бичигт тодорхой бус, хоёрдмол утга бүхий, эсхүл зөрөөтэй мэдээлэл гарсан тохиолдолд талууд инженерт гарсан асуудлыг тодоруулан мэдэгдэх ба мэдэгдэгдэсний дараагаар Инженер шаардлагатай баримт бичиг дээр тодруулга хийж зааварчилгааг өгнө.

Талууд өөрөөр тохиролцоогүй бол Гүйцэтгэгч Тендерт шалгарсан тухай захидал хүлээн авснаас хойш 35 хоногийн дотор Гэрээний ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажуулна.

Гэрээний ерөнхий хэлэлцээр нь Гэрээний тусгай нөхцөлд заасан маягтын дагуу хийгдсэн байна.

Хуульд заасан Гэрээний хэлэлцээр байгуулахтай холбоотой тэмдэгтийн хураамж болон бусад ижил төрлийн хураамжуудыг (хэрэв байгаа бол) Захиалагч хариуцна. Хэрэв Гүйцэтгэгч нь хамтарсан компанийтай бол хамтын нийгэмлэгийн гишүүн бүрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээнд гарын үсэг зурна.

1.7. Эрх шилжүүлэх

Талууд Гэрээний иж бүрдлийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь, гэрээний хүсэл зориг, үр ашгийг бусдад шилжүүлэхгүй. Гэхдээ Талууд нь:

- а) Нөгөө Талтайгаа урьдчилан харилцан тохиролцсоны үндсэн дээр, зөвхөн уг Талын санал болгосны дагуу Гэрээний иж бүрдлийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь шилжүүлж болно;
- б) Банк, санхүүгийн байгууллагад баталгаа болгох зорилгоор Гэрээнд заасны дагуу аливаа төлбөртэй холбоотой эрхээ шилжүүлж болох бөгөөд нөгөө Талтай урьдчилан харилцан тохиролцох шаардлагагүй.

1.8. Баримт бичгийг хадгалах, хүлээлгэн өгөх

Захиалагч Захиалагчийн шаардлага болон зураг төслийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Захиалагч Гэрээ болон зураг төслийн хуулбарыг тус тус 2 хувь үйлдэж Гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахин хуулбарлах, эсхүл хуулбар хийлгэх хүсэлтээ тавьж болно.

Инженер хүлээн авах хүртэл, Гүйцэтгэгчийн бүхий л баримт бичиг нь Гүйцэтгэгчийн өөрийн мэдэл, хадгалалт, хамгаалалтад байна. Гүйцэтгэгч нь Инженерт 1 хэвлэмэл эх хувь болон цахим хувийг (Захиалагчийн шаардлагад заасан маягтын дагуу, хэрэв заагаагүй бол Инженерийн зөвшөөрсөн маягтын дагуу), мөн шаардлагатай нэмэлт хуулбар хувийг хүргүүлнэ.

Гүйцэтгэгч дараах баримт бичгүүдийн хуулбар хувийг тухайн талбайд хадгална. Үүнд:

- (a) Гэрээ;
- (b) Гэрээний 6.10 [Гүйцэтгэгчийн бүртгэл, тайлан] болон 20.2.3 [Contemporary records]-т заасан бүртгэл, тайлан;
- (c) Захиалагчийн шаардлагад заасан хэвлэл, нийтлэл (хэрэв байгаа бол);
- (d) Гүйцэтгэгчийн баримт бичиг;;
- (e) Зураг төсөл;
- (f) Гэрээний дагуу хүргүүлсэн Гэрээний өөрчлөлт, мэдэгдэл болон бусад харилцааны баримт бичиг.

Захиалагчийн ажилтнууд нь эдгээр бүх баримт бичгүүдтэй ажлын цагаар эсхүл Гүйцэтгэгчтэй тохиолцсон хуваарийн дагуу танилцах эрхтэй.

Хэрвээ Ажил гүйцэтгэлд ашиглахаар боловсруулан гаргасан баримт бичигт алдаа, зөрчил байгааг аль нэг Тал (эсхүл Инженер) илрүүлсэн тохиолдолд уг Тал (эсхүл Инженер) нь нөгөө Талдаа тухайн алдаа, зөрчилтэй холбоотой мэдэгдлийг нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

1.9. Зураг төсөл болон зааварчилгааны хугацаа хожимдуулах

Тодорхой хугацаанд Гүйцэтгэгч шаардлагатай зураг төсөл авч чадаагүй мөн заавар тасалдсан эсхүл ажил саатах шинжтэй (Энэ нь үндэслэлтэй байх ёстой) болж ирвэл Гүйцэтгэгч энэ талаар Инженерт мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл шаардлагатай байгаа зураг төсөл болон даалгаврын тухай, мөн хэдий хугацаанд багтаан өгөх ёстой байсан талаар, үүнээс болж ажил удаашрах эсхүл саатах тохиолдолд ямар нөхцөл байдал үүсэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна.

Хэрэв Инженерээс заасан хугацаанд болон мэдэгдэл дурдсан нотлох баримтын хамтаар шаардлагатай зураг төсөл эсхүл даалгаврыг өгөөгүйн улмаас Гүйцэтгэгчид ажлын хоцролт үүссэн эсхүл ямар нэг зардал гарсан бол Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу тухайн асуудлаар хугацаа сунгуулах болон/эсхүл зардал болон ашгийн төлбөрийг нэхэмжлэх эрхтэй.

Гэхдээ, Инженерийн алдаа нь Гүйцэтгэгчийн баримт бичгийн алдаа, эсхүл хоцролтой хүргүүлсэн зэрэг Гүйцэтгэгчийн аливаа алдаа, хоцролтоос шалтгаалсан

бол Гүйцэтгэгч нь хугацаа сунгуулах болон/эсхүл зардал болон ашгийг нөхөн төлүүлэх эрхийг эдлэхгүй.

1.10. Захиалагч Гүйцэтгэгчийн баримт бичгийг ашиглах

Талуудын хооронд, Гүйцэтгэгчийн баримт бичгүүд болон Гүйцэтгэгч (түүний өмнөөс) боловсруулсан зураг төслийн зохиогчийн болон оюуны өмчийн эрхийг Гүйцэтгэгч эдэлнэ.

Гүйцэтгэгч нь Захиалагчид хугацаагүй, шилжүүлэх эрхтэй, онцгой бус, зохиогчийн эрхийн шимтгэлгүй эрхийн дагуу Гүйцэтгэгчийн баримт бичгийг (болон хэрвээ зураг төсөл байвал зураг төсөл, түүнтэй холбоотой баримт бичгүүд) боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг хуулбарлах, ашиглах, шилжүүлэх эрхийг өгсөн гэж үзнэ.

Энэхүү эрх нь:

(а) тухайн харьялагдах ажлын дуусах бодит эсхүл төлөвлөсөн хугацаа хүртэл хамаарна;

(б) Ажлыг дуусгах, ажиллуулах, засаж арчлах, өөрчлөх, тохируулах, засварлах болон нураах, буулгах зорилгоор Гүйцэтгэгчийн баримт бичгүүдийг (зураг төслийн баримт бичиг, хэрэв байгаа бол) хуулбарлах, ашиглах болон бусдад мэдээллэх эрхийг ажил дээр тодорхой хэмжээний албан тушаал эрхэлдэг хэн нэгэн этгээдэд өгөх;

(с) Цахим эсхүл компьютерийн програм хэлбэрээр байгаа Гүйцэтгэгчийн баримт бичгүүдийг ажлын талбайд эсхүл Гэрээнд заасан газарт ямар нэг компьютер дээр ашиглахыг зөвшөөрөх;

(д) Гэрээг цуцлах тохиолдолд:

(i) Гэрээний 15.2 [Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлах]-т заасны дагуу Гүйцэтгэгчийн баримт бичгийг (Гүйцэтгэгчийн боловсруулсан зураг төслийн баримт бичиг, хэрэв байгаа бол) хуулбарлах, ашиглах болон шилжүүлэх эрхийг Захиалагчид олгоно; эсхүл

(ii) Гэрээний 15.5 [Захиалагчид зохимжтой байдлын үүднээс гэрээ цуцлах], 16.2 [Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцлах] эсхүл 18.5 [Аль нэг талын саналаар цуцлах санал]-т тус тус заасны дагуу Гүйцэтгэгч нь өөрөө болон/эсхүл бусад этгээдэд зохицуулалт хийн Ажил дуусгах зорилгоор авсан төлбөртэй холбоотой Гүйцэтгэгчийн баримт бичгийг хуулбарлах, ашиглах болон шилжүүлэх эрхийг Захиалагч нь эдэлнэ.

Гүйцэтгэгчийн баримт бичиг (Гүйцэтгэгчийн зураг төслийн баримт бичиг, хэрэв байгаа бол) болон Гүйцэтгэгчийн (юмуу түүний өмнөөс) боловсруулсан зураг төслийг, түүний зөвшөөрөлгүйгээр Захиалагч (юмуу түүний өмнөөс) энэхүү хэсэгт зааснаас өөр зорилгоор ашиглах, хувилах, гуравдагч этгээдэд мэдээллэх ёсгүй.

1.11. Гүйцэтгэгч Захиалагчийн баримт бичгийг ашиглах

Талуудын хувьд Захиалагчийн шаардлага, Зураг төсөл болон Захиалагчийн (эсхүл түүнийг төлөөний этгээдийн) боловсруулсан бусад баримт бичгийн зохиогчийн болон оюуны өмчийн эрхийг Захиалагч эдэлнэ. Гүйцэтгэгч Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор эдгээр баримт бичгүүдийг өөрийн зардлаар хувилах, ашиглах, мэдээлж болно.

Эдгээр баримт бичгийг (бүтэн эсвэл хэсэгчлэн) Гэрээний зорилгод шаардагдааас бусад тохиолдолд захиалагчийн урьдчилан зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

1.12. Нууцлал

Гүйцэтгэгч Гэрээний үүргээ хэрхэн биелүүлж буй шалгах зорилгоор Инженерээс үндэслэлтэйгээр шаардсан үед Гүйцэтгэгч нь уг шаардсан нууцлалын зэрэглэлтэй болон бусад мэдээллийг задлах боломжтой.

Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан Гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичгүүдээс бусад Гэрээний бүхий л баримт бичгийг нууцад хамааруулна. Гүйцэтгэгч нь Захиалагчийн урьдчилан зөвшөөрөлгүйгээр Гэрээний аливаа мэдээллийг салбарын хэвлэмэл мэдээ, мэдээлэлд болон техникийн баримт бичигт тусгах эсхүл бусад байдлаар (хаа нэгтээ) хэвлэн нийтлэх, хэвлэн нийтлэхийг зөвшөөрөх, эсхүл задруулах эрхгүй.

Гүйцэтгэгчийн гаргасан бүхий л баримт бичгийг "НУҮЦ" гэсэн дардастайгаар мэдээллийг аван нууцлалын зэрэгтэйд тооцно.

Уг баримт бичиг, мэдээллийг гэрээний 15.2 [Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлах]-т зааснаас бусад тохиолдолд Захиалагч нь задруулах, эсхүл гуравдагч этгээдэд задруулахыг зөвшөөрөх эрхгүй.

Энэхүү хэсэгт заасны дагуу Талуудын нууцлалын талаар хүлээх үүрэг хариуцлага нь дараах тохиолдлуудад үйлчлэхгүй:

- аль нэг Талаас мэдээллийг хүлээн авахаас өмнө уг мэдээлэл нь нууцлалын зэрэглэлд хамааралгүйгээр нөгөө Талын мэдэлд хэдийн байсан тохиолдолд;
- эдгээр нөхцөлүүдийг зөрчилгүйгээр тухайн мэдээлэл нь олон нийтэд ерөнхийдөө ил тод болсон тохиолдолд; эсхүл
- нууцлалтын Гуравдагч этгээдээс хуулийн дагуу хүлээн авсан нууцлалын зэрэглэлд хамаarahгүй мэдээлэл

1.13. Хуульд нийцүүлэх

Захиалагч болон Гүйцэтгэгч нар Гэрээг хэрэгжүүлэх явцдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллана. Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол:

(a) Захиалагч нь Барилгын үндсэн ажилтай холбогдолтой төлөвлөлтийн, бүсчлэлийн болон барилгын зөвшөөрөл, түүнтэй төстэй бусад зөвшөөрлүүд, мөн Захиалагчийн шаардлагад заасан бусад зөвшөөрлийг заавал авсан (авна) байна. Захиалагч дээр дурдсан зөвшөөрлүүдийг аваагүйгээс гарах аливаа сөрөг үр дагавар, хохирлоос Гүйцэтгэгчийг хамгаалах бөгөөд үүнд доорх (c) заалтад тусгасан Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан нөхцөл байдалд хамаarahгүй.

(b) Гүйцэтгэгч Ажил гүйцэтгэхтэй холбогдон гарах бүхий л зөвшөөрлүүдийг авч, мэдэгдлийг өгч, татвар хураамжуудыг хуулийн дагуу бүрэн төлсөн байна. Ингээгүйн улмаас гарах аливаа сөрөг үр дагавар, хохирлоос Захиалагчийг хамгаална, гэхдээ гэрээний 2.2 [Дэмжлэг, туслалцаа үзүүлэх]-т заасан Захиалагчийн буруугаас шалтгаалсан нөхцөл байдалд хамаarahгүй.

(c) Энэхүү хэсгийн (a) заалтын дагуу Инженерийг аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, холбогдох бусад зөвшөөрлүүдийг авахад нь дэмжлэг үзүүлэн Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасан болон Захиалагчаас үндэслэлтэйгээр шаардсан бүхий л баримт бичгийг Захиалагчийн шаардлагад заасан хугацаанд

багтаан хүргүүлэх үүрэгтэй.

(d) Гүйцэтгэгч нь дээр дурдсан (a)-д дурдсан Инженерийн бүхий л зөвшөөрлүүд, лиценз, тусгай зөвшөөрлүүдийн шаардлагыг бүрэн хангаж нийцүүлэн ажиллана.

Дээрх (c)-д заасан үүргийг Гүйцэтгэгч биелүүлсэн бөгөөд Инженер нь (a)-д дурдсан холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрлүүдийг аваагүй эсхүл хугацаандаа аваагүйн улмаас Гүйцэтгэгчид хугацааны хоцролт үүссэн болон/эсхүл Зардал гарсан тохиолдолд Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу хугацааг сунгах нэхэмжлэл гаргах болон/эсхүл Зардал болон Ашгийн төлбөрийг авах эрхтэй.

Хэрэв Гүйцэтгэгч дараах заалтуудыг биелүүлээгүйн улмаас Захиалагчаас нэмэлт зардал гарсан бол Захиалагч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу Гүйцэтгэгчээс уг нэмэлт зардлуудаа төлүүлэх эрхтэй. Үүнд:

i. Дээр дурдсан С хэсэг; эсхүл

ii. Дээр дурдсан (b) болон (d) заалт бөгөөд Захиалагч нь 2.2 [Захиалагч дэмжлэг үзүүлэх] хэсгийн заалтуудыг биелүүлсэн байх үүрэг

1.14. Хамтран болон дангаар хүлээх хариуцлага

Хэрэв Гүйцэтгэгч нь (хамтарсан) бол:

a) Түншлэлийн гишүүд нь Захиалагчийн өмнө Гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хамтдаа болон тус тусдаа хүлээнэ.

b) Түншлэлийн удирдагч/удирдлага нь Гүйцэтгэгч болон Түншлэлийн гишүүн тус бүрийн хоорондын уялдаа холбоог хангах бүрэн эрхтэй.

c) Түншлэлийн аль ч гишүүн, гишүүн тус бүрийн гүйцэтгэх бүрдэл хэсэг болон түүний цар хүрээ болон Түншлэлийн хуулиар олгогдсон статусыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх эрхгүй (гэхдээ энэхүү Түншлэлийн статус өөрчилсөн зөвшөөрөл олгох нь дээр (a) заалтад заасан аливаа үүргээс чөлөөлөхгүй.)

1.15. Хариуцлагын хязгаар

Аль нэг Тал нь нөгөө Талдаа доор дурдсан заалтуудад зааснаас бусад тохиолдолд аливаа Ажлыг ашигласнаас үүссэн алдагдал хохирол, орлого ашгийн алдагдал, аливаа гэрээгээ алдах эсхүл гэрээтэй холбоотойгоор нөгөө талаас учруулсан шууд болон шууд бус хохирлыг барагдуулах үүрэг хариуцлагыг хүлээхгүй:

- (a) 8.8 [Хугацаа хойшилсны алданги] хэсэг;
- (b) 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] хэсгийн (c) дэх заалт;
- (c) 15.7 [Захиалагчид зохимжтой байдлын үүднээс гэрээ цуцалснаас хойши төлбөр] хэсэг;
- (d) 16.4 [Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцалсны дараах төлбөр] хэсэг;
- (e) 17.3 [Оюуны болон үйлдвэрийн өмчийн эрх] хэсэг;
- (f) 17.4 [Гүйцэтгэгч нөхөн төлбөр төлөх] хэсгийн эхний дэд хэсэг;
- (g) 17.5 [Захиалагч нөхөн төлбөр төлөх] хэсэг.

Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу болон түүнтэй холбоотойгоор дор дурдсанаас бусад тохиолдолд Захиалагчид төлөх нийт өр төлбөрийн хэмжээ нь Гэрээний мэдээлэлд заасан үнийн дүнгээс эсхүл (хэрвээ дүнг тусгаагүй бол) Гэрээний зөвшөөрөгдсөн дүнгээс хэтэрч болохгүй:

- (i) 2.6 [Захиалагчаас нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж] хэсгийн дагуу;
- (ii) 4.19 [Түр инженерийн шугам сүлжээ] хэсгийн дагуу;
- (iii) 17.3 [Оюуны болон үйлдвэрийн өмчийн эрх] хэсгийн дагуу;
- (iv) 17.4 [Гүйцэтгэгч нөхөн төлбөр төлөх] хэсгийн эхний заалтын дагуу.

Энэхүү хэсэг нь үүргээ биелүүлээгүй Талын аливаа авилгал, худал мэдээлэл, хууран мэхлэх үйлдэлтэй холбоотой үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

1.16. Гэрээ цуцлах

Зайлшгүй шаардлагын улмаас хуульд зааснаар Гэрээг цуцлах тохиолдолд талууд гэрээнд зааснаас бусад үйлдэл хийх шаардлагагүй.

2. Захиалагч

2.1 Ажлын талбайд нэвтрэх эрх олгох

Захиалагч нь Ажлын талбайн бүх хэсэгт нэвтрэх эрх болон үүний зарим хэсгийг эзэмших эрхийг Гэрээний мэдээлэлд заасан хугацаанд Гүйцэтгэгчид олгоно. Энэхүү Гүйцэтгэгчид олгогдох нэвтрэх болон эзэмших эрх нь үүгээр хязгаарлагдахгүй. Гэрээнд захиалагч нь аливаа суурь эзэмшил, заавар, нэвтрэх эрх, хэрэгтэй хэрэгсэл зэргийг Гүйцэтгэгчид олгоно гэж заасан бол энэхүү үүргийг Захиалагчийн шаардлагад заасны дагуу болон заасан хугацаанд биелүүлнэ.

Гэхдээ Захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүлээн авах хуртлээ уг нэвтрэх эсхүл эзэмших эрхийг өгөхөөс түтгэлзэх эсхүл татгалзах эрхтэй.

Хэрэв Гэрээний мэдээлэлд дээрхи эрх олгох хугацааг заагаагүй бол Захиалагч нь Гүйцэтгэгчид ажлын графикийн дагуу ажил үүргээ саадгүй гүйцэтгэх боломжит хугацаанд олгох ёстой ба Ажлын графикийн дагуу Гүйцэтгэгчид Ажлын талбайд нэвтрэх болон эзэмших эрхтэй болно. Хэрэв Ажлын график байхгүй бол гэрээний 8.3 [Ажлын график]-т зааснаар хүргүүлсэн суурь ажлын графикийн дагуу олгоно.

Хэрэв дээрх хугацаанд Захиалагчаас Ажлын талбайд нэвтрэх эсхүл эзэмших эрхийг олгох үүргээ биелүүлээгүйн улмаас Гүйцэтгэгчид хугацааны хоцролт үүссээн болон/эсхүл зардал гарсан бол Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу хугацаа сунгах нэхэмжлэл гаргах болон/эсхүл тухайн зардал болон ашгийг төлүүлэх эрхтэй.

Гэхдээ, хэрэв Гүйцэтгэгч нь холбогдох Гүйцэтгэгчийн баримт бичгийг хугацаандаа хүргүүлээгүй эсхүл алдаатай байх зэрэг байдлаар Гүйцэтгэгчийн алдаа эсхүл хоцролтоос шалтгаалан Захиалагч нь дээрх үүргээ биелүүлэх боломжгүй байсан бол Гүйцэтгэгч хугацааг сунгах нэхэмжлэл гаргах болон/эсхүл Зардал болон ашгийг төлүүлэх эрхгүй.

2.2. Дэмжлэг, туслалцаа үзүүлэх

Гүйцэтгэгч хэрэв хүсэлт гаргасан тохиолдотд Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу дараах ажлуудад нэн даруй хөлбогдох боломжит туслалцаа дэмжлэгийг Гүйцэтгэгчид үзүүлнэ.

(а) Гэрээнд хамааралтай боловч тухайн үед бэлэн бус байгаа тухайн Улсын хууль тогтоомжуудын хуулбарыг олох тал дээр, (ашиглах боломжгүй байгаа ч гэрээнд хамааралтай тус улсын хууль тогтоомж).

(б) Тухайн Улсын хууль тогтоомжоор шаардсан аливаа зөвшөөрөл, лицензүүд, тусгай зөвшөөрлүүд (мөн эдгээр зөвшөөрөл, лицензүүд, тусгай зөвшөөрлүүдийг авахад Гүйцэтгэгчээс шаардах мэдээлэл) ба үүнд:

(i) Гүйцэтгэгч нь 1.13 [Хуулийг дагаж мөрдөх]-т заасны дагуу авах шаардлагатай;

(ii) бараа хүргэлт мөн гаалийн бүрдүүлэлт;

(iii) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг Ажлын талбайгаас гарган экспортлох зөвшөөрөл зэрэг зөвшөөрөл, тусгай зөвшөөрлүүд, лицензүүд багтана.

2.3. Захиалагчийн ажилтнууд болон бусад Гүйцэтгэгч нар

Захиалагчийн ажилтнууд болон Захиалагчийн бусад Гүйцэтгэгч нар ажлын талбайд болон ойролцоо байршилд дор дурдсан үүргийг биелүүлэхийг Захиалагч хариуцна. Үүнд:

(а) Гэрээний 4.6 [Хамтын ажиллагаа]-д заасны дагуу Гүйцэтгэгчийн идэвх чармайлтыг дэмжиж хамтран ажиллана;

(б) Гэрээний 4.8 [Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг]-ийн (а) ба (е) заалт болон мөн гэрээний 4.18 [Байгаль орчныг хамгаалах]-д заасны дагуу Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг хариуцлагатай адил үүргийг хангаж ажиллана.

Захиалагчийн ажилтан эсхүл Захиалагчийн бусад Гүйцэтгэгч (хэрэв байгаа бол) нь авилга, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх үйл ажиллагаанд оролцсон болохыг баримтаар нотлон Гүйцэтгэгчээс тэдгээр этгээдийг Захиалагчаас халах болон татан буулгахыг шаардах (эсхүл халах болон татан буулгах шалтгааныг санал болгох) эрхтэй.

2.4 Захиалагчийн санхүүгийн зохицуулалт

Захиалагчийн Гэрээгээр хүлээсэн санхүүгийн зохицуулалтын талаар хүлээх үүргийг Гэрээний мэдээлэлд дэлгэрэнгүй тусгана.

Хэрвээ Захиалагч нь Санхүүгийн зохицуулалтдаа томоохон өөрчлөлт (Инженерээс тогтоосон хугацаанд төлж барагдуулах ёстой Гэрээний үнийн үлдсэн хэсгийг төлөх Захиалагчийн төлбөрийн чадварт нөлөөлөх) оруулах эсхүл Захиалагчийн санхүүгийн байдал өөрчлөгдсөний улмаас Санхүүгийн зохицуулалтдаа өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн бол тэр тухай дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлэх үүрэгтэй. Хэрэв Гүйцэтгэгч нь:

(а) Гэрээний зөвшөөрөгдсөн дүнгийн арван хувиас (10%) илүү дүн бүхий гэрээний өөрчлөлтийн ажил хийх зааварчилгаа авсан эсхүл Гэрээний өөрчлөлтийн хуримтлагдсан нийт дүн нь зөвшөөрөгдсөн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байвал;

(б) 14.7 [Төлбөрийн нөхцөл]-т заасны дагуу төлбөрөө хүлээн аваагүй бол;

(с) Энэхүү хэсэгт заасны дагуу Захиалагчаас санхүүгийн зохицуулалтдаа томоохон өөрчлөлт оруулах тухай Мэдэгдэл хүлээн аваагүй бол;

Гүйцэтгэгч нь тодруулга хүсэлтийг Захиалагчид илгээх эрхтэй ба Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор санхүүгийн

зохицуулалтад өөрчлөлт оруулсан тухай болон түүнийг баримталж буй тухай үндэслэл бүхий нотолгоог хүргүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь Инженерээс тогтоосон хугацаанд төлөгдөх шаардлагатай Гэрээний үнийн холбогдох төлбөрийг төлөх үүргийг Захиалагчид хүлээлгэнэ.

2.5 Ажлын талбайн нөхцөл байдал болон холбогдох мэдээлэл

Захиалагч нь ажлын талбайн байр зүй, геологи, гедрогеологи, цаг уурын болон байгаль орчны нөхцлийн талаарх өөртөө байгаа мэдээлэл өгөгдлийг суурь огнооноос өмнө гүйцэтгэгчид шилжүүлэх үүрэгтэй. Захиалагч нь суурь огнооноос хойш өөрийн эзэмшилд ирсэн дээрхтэй холбоотой бүх мэдээллийг гүйцэтгэгчид шуурхай өгнө.

Анхан шатны хэмжилтийн хяналтын цэгүүд, чиг, түвшинг Захиалагчийн шаардлагад тодорхой тусгах эсхүл Инженерийн мэдэгдлээр Гүйцэтгэгчид өгсөн байх шаардлагатай.

2.6 Захиалагчаас нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж

Захиалагчийн нийлүүлэх материал болон/эсхүл Захиалагчийн тоног төхөөрөмжийг ажил гүйцэтгэх тодорхойлолтод бүртгэнэ. Захиалагч ажил гүйцэтгэх тодорхойлолтод заагдсан дэлгэрэнгүй мэдээлэл/тодорхойлолт, хугацаа, үнэ зэргийг харгалzan боломжит тоног төхөөрөмж болон материалыаар гүйцэтгэгчийг хангах үүрэг хүлээнэ.

Гүйцэтгэгчийн ажилтан Захиалагчийн тоног төхөөрөмжийг ашиглах, хэрэглэх, жолоодох, удирдах эсхүл мэдэл, хяналтандаа байлгах хугацаанд тухайн тоног төхөөрөмжийн ашиглалт болон бүрэн бүтэн байдалд Гүйцэтгэгч хариуцлага хүлээнэ.

3. Инженер

3.1 Инженер

Захиалагч нь Гэрээнд заасан ажлыг гүйцэтгүүлэхээр Инженерийг томилно.

Инженер нь Гэрээнд заасан Инженерийн үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай бүхий л эрх мэдлийг эдэлнэ.

Инженер нь өөрөө хуулийн этгээд байгууллага бол Инженерийн нэрийн өмнөөс ажиллах Инженерийн төлөөний хүнийг Гэрээний дагуу томилон эрхийг олгоно.

Уг Инженер нь (хэрвээ хуулийн этгээд бол албан ёсоор томилогдон эрх олгогдсон Инженерийн төлөөлөгч):

(a) Инженерийг төлөөлөн ажиллах мэргэжилтэн нь Гэрээний дагуу мэргэжлийн ур чадвар, туршлага, мэдлэг шаардлагад нийцсэн мэргэжлийн инженер байна.

(b) гэрээний 1.4 [Хууль болон Хэл]-т заасан хэлийг бүрэн эзэмшсэн байна.

Хэрэв Инженер нь хуулийн этгээд байгууллага бол Инженер нь түүнийг төлөөлөх хүний томилон эрх олгосон (эсхүл өөрчилж томилсон) тухай мэдэгдлийг Талуудад хүргүүлэх үүрэгтэй. Уг мэдэгдлийг хоёр Тал хүлээн авснаар Инженерийн төлөөлөгчийн томилгоо нь хүчин төгөлдөр үйлчилнэ. Мөн үүнтэй ижил байдлаар Инженер нь аливаа томилгоо болон эрх мэдлийг цуцалсан мэдэгдлийг хүргүүлэх үүрэгтэй.

3.2 Инженерийн эрх үүрэг

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

Гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй бол энэхүү нөхцөлт инженер нь гэрээний дагуу хийгдэж буй үүрэг даалгаврыг явуулах эрхээ хэрэгжүүлэхдээ гэрээнд заасан шууд болон далд хэлбэрээр захиалагчийн ашиг сонирхлыг илэрхийлэн мэргэжлийн түвшинд оролцох үүрэгтэй юм.

Инженер нь Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй бол аль нэг Талыг гэрээнд заасан болон түүнтэй холбоотой аливаа ажил, үүрэг хариуцлагаас чөлөөлөх эрхгүй.

Инженер нь гэрээнд заасан эсхүл түүнд шууд бусаар илэрхийлсэн гэж үзэх Инженертэй холбогдох эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхтэй. Хэрвээ Инженер нь тодорхой эрх мэдлийг хэрэгжүүлэхээс өмнө Захиалагчаас зөвшөөрөл авах шаардлагатай бол энэ тухай шаардлагуудыг Гэрээний тусгай нөхцөлд зайлшгүй тусгана. Инженер нь гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасан эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ Захиалагчаас зөвшөөрөл авах шаардлагагүй. Инженер олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ Захиалагчийн зүгээс аливаа хязгаарлалт тавихгүй.

Гэхдээ Инженер нь эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ Захиалагчаас зөвшөөрөл авах шаардлагатай бол (Гэрээнд дагуу) уг эрх мэдлийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгосон гэж үзнэ.

Инженер болон Инженерийн төлөөлөгч эсхүл өгсөн түүний аливаа зөвлөхөөс хүргүүлсэн аливаа зөвшөөрөл, хэлэлцээр, чек, сертификат/гэрчилгээ, санал, хүсэлт, үл зөвшөөрөл, хяналт, үзлэг шалгалт, зааварчилгаа, мэдэгдэл, татгалзах зүйлгүй мэдэгдэл, хурлын тэмдэглэл/бичлэг, бүртгэл, хариу мэдэгдэл, тайлан, дүгнэлт, тест, үнэлгээ болон бусад ижил төстэй ажиллагаа (тухайн ажиллагаа хийгдсэн эсэхээс үл хамааран) Гүйцэтгэгчийг гэрээний дагуу болон гэрээтэй холбогдсон хүлээсэн аливаа ажил, үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.

3.3 Инженерийн төлөөлөгч

Инженер нь Инженерийн төлөөлөгчийг томилох эрхтэй бөгөөд гэрээний 3.4 [Инженер эрх шилжүүлэх]-т заасны дагуу түүнд төлөөлөгдсөн Инженерт төлөөлөгчийг өөрчилж томилохоос бусад Ажлын талбайд Инженерийг төлөөлөн ажиллахад шаардлагатай бүхий л эрх мэдлийг олгоно.

Инженерийн төлөөлөгч (хэрэв томилогдсон бол) нь 3.1 [Инженер] хэсгийн (a) болон (b)-д заасан заалтуудыг хангах бөгөөд Ажил гүйцэтгэх бүхий л хугацаанд Ажлын талбайд байрлаж байх үүрэгтэй. Хэрвээ Инженерийн төлөөлөгч ажлын талбайд түр эзгүй байх тохиолдолд түүнийг орлож ажиллах мэдлэг, чадвар туршлага бүхий төлөөлөгчийг Инженер томилон ажиллуулах үүрэгтэй бөгөөд энэ тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

3.4 Инженер эрх шилжүүлэх

Инженер нь шаардлагатай тохиолдолд өөрийн эрх мэдлийг болон үүрэг даалгаврыг зөвлөхүүдэд шилжүүлж, мөн тухайн төлөөлөл болон ажил үүргийн цуцлах эсхүл эргүүлэн татаж болох бөгөөд зөвлөхүүд тус бурийн эрх мэдэл, үүрэг даалгаврыг тодорхойлсон мэдэгдлийг Талуудад хүргүүлнэ. Хэрэв уг мэдэгдлийг Талууд хүлээн авах хүртэл тухайн үүрэг даалгавар өгөх, эрх мэдэл олгох эсхүл цуцлах, эгүүлэн татах нь хүчин төгөлдөр үйлчлэхгүй. Гэхдээ Инженер дараах ажил, эрх мэдлүүдийг шилжүүлэх эрхгүй:

(а) гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасан үйл ажиллагааг явуулах болон/ эсхүл

Б. Доржжин

Б. Чорлогийн
Чорлогийн

(b) гэрээний 15.1 [Алдааг засах тухай Мэдэгдэл]-д заасны дагуу Алдааг засах тухай мэдэгдэл хүргүүлэх.

Зөвлөхүүд нь эдгээр эрх мэдэл, үүрэг даалгаврыг гүйцэтгэх ур чадвар, туршлага, мэдлэгийг зохих ёсоор хангасан байх бөгөөд гэрээний 1.4 [Хууль болон Хэл]-т заасан хэлийг бүрэн эзэмшсэн байна.

Инженерээс үүрэг даалгавар авсан эсхүл эрх мэдэл олгогдсон зөвлөх нь гагцхүү энэхүү хэсэгт заасны дагуу хүргүүлсэн Инженерийн мэдэгдэлд тогтоосон эрх мэдэл, ажил үүргийн хүрээнд Гүйцэтгэгчид зааварчилгаа, даалгаврыг өгөх эрхтэй. Төлөөний Инженерийн мэдэгдэлд заасан олгогдсон эрх мэдлийн хүрээнд нийцсэн зөвлөхийн үйл ажиллагаа, арга хэмжээ нь үндсэн Инженерийн үйл ажиллагаа, арга хэмжээтэй адил тэгш хүчинтэй үйлчилнэ. Гэхдээ, Гүйцэтгэгч нь зөвлөхийн хүргүүлсэн аливаа зааварчилгаа, мэдэгдлийн талаар асуулга, тодруулга хийхийг хүсвэл уг асуулга, тодруулгатай холбогдох мэдэгдлийг Инженерт хүргүүлэх эрхтэй. Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан Захиалагчаас хариу ирүүлээгүй эсхүл зөвлөхийн зааварчилгаа, даалгавар эсхүл мэдэгдлийг аливаа өөрчлөлт оруулсан эсхүл буцаах шийдвэр гаргаагүй бол (тухайн нөхцөл байдлаас хамаарч) зөвлөхийн мэдэгдэл эсхүл гүйцэтгэгчийн мэдэгдлийг Инженерийн зүгээс хүлээн авч зөвшөөрсөн гэж үзнэ.

3.5 Инженерийн Зааварчилгаа

Инженер нь Гэрээний дагуу Гүйцэтгэгчид ажлаа гүйцэтгэхэд шаардагдах зааварчилгааг хүргүүлж (хэээд ч) болно.

Гүйцэтгэгч нь зөвхөн Инженерээс, эсхүл Инженерийн төлөөлөгчөөс (хэрэв томилогдсон бол), эсхүл гэрээний 3.4 [Инженер эрх шилжүүлэх]-т заасны дагуу зааварчилгаа өгөх зохих эрх мэдэл олгогдсон зөвлөхөөс зааварчилгааг авна.

Гүйцэтгэгч нь энэхүү хэсгийн доорхи заалтуудыг биелүүлэхийн зэрэгцээ Гэрээнд холбогдолтой аливаа асуудлаар Инженерийн эсхүл Инженерийн төлөөлөгчийн (хэрэв томилогдсон бол) эсхүл эрх бүхий зөвлөхийн зааварчилгааг дагаж мөрдөж биелүүлэх үүрэгтэй.

Хэрэв зааварчилгаа нь Гэрээнд өөрчлөлт оруулах тухай заасан бол гэрээний 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] дэх заалтыг дагаж мөрднө.

Хэрэв зааварчилгаа нь Гэрээнд өөрчлөлт оруулах тухай заагаагүй бол Гүйцэтгэгч уг зааварчилгааг:

(a) Гэрээнд өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн (эсхүл өмнө нь оруулсан Гэрээний өөрчлөлттэй холбоотой Тухайлсан ажилд хамаарах), эсхүл

(b) холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл ажилд холбогдох ХАБЭА-н санал (ХАБЭА-н шаардлагыг өөрчлөх), эсхүл технологийн хувьд боломжгүй гэж тооцох бөгөөд Гүйцэтгэгч нь зааварчилгаатай холбоотой аливаа ажлыг эхлүүлэхээсээ өмнө холбогдох учир шалтгааныг дурдсан мэдэгдлийг нэн даруй Инженерт хүргүүлнэ. Хэрвээ уг мэдэгдлийг Инженер хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор уг зааварчилгааг баталгаажуулссан эсхүл аливаа өөрчлөлт хийсэн тухай хариу Мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд уг Инженерийн зүгээс уг зааварчилгааг хүчингүй болгосонд тооцно. Өөр тохиолдолд буюу Инженерээс хариу өгсөн тохиолдолд Гүйцэтгэгч нь Инженерийн хариуд тусгагдсан үүрэг даалгаврыг заавал биелүүлэх, зааварчилгааг дагаж мөрдөх үүрэгтэй.

3.6 Инженерийг солих

Хэрэв Захиалагч нь Инженерийг өөрчлөх бол түүнийг солих/өөрчлөхөөр төлөвлөсөн хугацаанаас 42-оос багагүй хоногийн өмнө томилохоор төлөвлөж буй Инженерийн нэр, хаяг болон холбогдох туршлага, ур чадварын тухай мэдээллийг Гүйцэтгэгчид мэдэгдлээр хүргүүлэх үүрэгтэй.

Хэрэв Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор уг томилгоог үл зөвшөөрч буй тухайгаа учир шалтгааны хамтаар дурдан Мэдэгдлээр хариу ирүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэгчийг уг томилгоог хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Энэхүү хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгчээс Инженерийн оронд солихоор төлөвлөж буй хүнийг (хуулийн этгээд эсхүл бие хүн) тохиромжгүй гэж үзэн учир шалтгааны хамтаар үл зөвшөөрөх мэдэгдлийг Захиалагчид хүргүүлсэн тохиолдолд Захиалагч уг этгээдийг Инженерээр томилох эрхгүй.

Хэрэв Инженер нь нас барсан, өвчтэй, тахир дутуу болсон, ажлаасаа чөлөөлөгдсөн (эсхүл Инженер нь Захиалагчаас хамааралгүйгээр аливаа ажил үүргийг гүйцэтгэхээс татгалзах эсхүл боломжгүй болсон бол) зэрэг учир шалтгааны улмаас Ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд Захиалагч түүнийг нэн даруй солих эрхтэй бөгөөд томилогдож буй хүний (хуулийн этгээд эсхүл бие хүн) нэр, хаяг, ур чадвар, ажлын туршлагын талаар мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлэх үүрэгтэй. Энэхүү хэсэгт заас ан томилгоог гүйцэтгэгч батлах эсхүл мэдэгдэлийн дагуу шинэ хүн томилогдон батлагдах хүртэл энэхүү томилгоог түр томилгоо гэж үзнэ.

3.7 Тохиролцох эсхүл шийдвэрлэх

Энэ хэсэгт заасны дагуу ажил үүргийг гүйцэтгэхдээ Инженер нь төвийг сахисан байр сууринаас Талуудтай ажиллах бөгөөд зөвхөн Захиалагчийг төлөөлөх үйл ажиллагааг явуулах эрхгүй.

Инженер нь эдгээр Гэрээний нөхцөлүүдийн дагуу аливаа асуудал болон Нэхэмжлэлийг шийдвэрлэх эсхүл тохиролцох тохиолдолд энэ хэсэгт заасны дагуу дараах арга хэмжээнүүдийг авна:

3.7.1 Зөвшилцөлд хүрэхэд зөвлөгөө өгөх

Инженер Талуудтай хамтад нь болон/эсхүл тус тусад нь ганцаарчлан зөвлөлцөх үүрэгтэй бөгөөд Талууд харилцан зөвшилцөлд (хүргэх талаар) хүрэх талаас хүчин чармайлт гарган ажиллана. Инженер нь гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-д заасан ажил гүйцэтгэх шаардлагатай хугацааг хангалттай олгох үүднээс тухайн зөвлөлцөх ажиллагааг нэн даруй эхлүүлэх үүрэгтэй.

Хэрэв Инженерээс өөрөөр санал болгоогүй бөгөөд хоёр Тал харилцан тохиролцсон бол Инженер нь 2 талын (зөвлөлдсөн зөвлөлдөөний) бүртгэл-тэмдэглэл хангаж өгнө.

Хэрэв гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-д заасан гэрээний хугацааны хязгаарт багтаан Талууд тохиролцоонд хүрч чадсан бол Инженерээс зөвшилцөлтэй холбоотой мэдэгдлийг хоёр Талд хүргүүлэх ба уг зөвшилцлийн хэлэлцээрт талууд гарын үсгээ зурж баталгаажуулна. Уг мэдэгдлийг “Талуудын хэлэлцээрийн мэдэгдэл” гэсэн тэргүүтэй байх бөгөөд хэлэлцээрийн хуулбарыг багтаасан байна.

Хэрэв:

(а) гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-д заасан гэрээний хугацааны хязгаарт хугацаанд багтан талууд тохиролцоонд хүрч хэлцэл байгуулж чадаагүй бол; эсхүл

(b) Талууд (хоёр) хоорондоо заасан хугацаанд багтан тохиролцож хэлцэл байгуулах боломжгүй бол түүнийгээ Инженерт зөвлөн мэдээллэх.

Дээрх Тохиолдолд Инженер нь Талуудад (хоёр) холбогдох Мэдэгдлийг аль болох урьчилан хүргүүлэх бөгөөд гэрээний 3.7.2 [Инженерийн дүгнэлт]-д заасан арга хэмжээнүүдийг нэн даруй авна.

3.7.2 Инженерийн дүгнэлт

Инженер нь аливаа асуудал эсхүл Нэхэмжлэлийн талаар холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан үзэж Гэрээнд нийцүүлэн бодит дүгнэлт гаргах үүрэгтэй.

Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-т заасан дүгнэлт хийх хугацааны хязгаарт багтаан Инженер нь өөрийн дүгнэлтийн тухай мэдэгдлийг Талуудад хүргүүлнэ. Уг мэдэгдэлд “Инженерийн дүгнэлтийн тухай мэдэгдэл” хэмээн тэргүүтэй байх бөгөөд дүгнэлтийн учир шалтгаан, холбогдох тайлбар мэдээллүүдийн тусгана.

3.7.3 Хугацааны хязгаар

Хэрэв хэлцэл нь 42 хоногийн дотор эсхүл тохирсон цагийн хязгаар дотор инженер санал болгосон эсхүл талууд зөвшөөрсөн хэлцэл хийгдсэн тохиолдолд инженер хэлцлийн эсхүл дүгнэлтийн тухай мэдэгдлийг хүргүүлнэ:

а) харилцан зөвшилцөх (Нэхэмжлэлээс бусад) тохиолдолд эдгээр Нэхэмжлэлийн холбогдох хэсэгт заасан хэлцлийн хугацааны хязгаарыг эхлэх өдөр;

(b) гэрээний 20.1 [Нэхэмжлэл]-ийн (c)-д заасан Нэхэмжлэлтэй холбоотой тохиолдолд Инженер гэрээний 20.1-т заасны дагуу нэхэмжлэгч Талын мэдэгдлийг хүлээн авсан өдөр; эсхүл

(c) гэрээний 20.1 [Нэхэмжлэл]-ийн (a) эсхүл (b) заалтад заасан Нэхэмжлэлтэй холбоотой бол Инженер нь:

i. гэрээний 20.2.4 [Иж бүрдэл нэхэмжлэл]-т заасны дагуу иж бүрдэл Нэхэмжлэлийг хүлээн авсан өдөр; эсхүл

ii. гэрээний 20.2.4 [Үргэлжлэх нөлөөллийн нэхэмжлэл]-т заасан Нэхэмжлэлтэй холбоотой тохиолдолд дундын эсхүл эцсийн иж бүрдэл Нэхэмжлэлийг (тухайн нөхцөл байдаас хамаарч) хүлээн авсан өдөр.

Инженер нь гэрээний 3.7.1 [Зөвшилцэлд хүрэхэд зөвлөгөө өгөх] дэх заалтын хамгийн сүүлийн дэд заалтад заасны дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой өдрөөс хойш 42 хоногт багтаан эсхүл Инженерээс санал болгосон бөгөөд Талуудаас зөвшөөрсөн хугацааны хязгаар (эдгээр Гэрээний нөхцөлд “хэлцлийн хугацааны хязгаар” гэж тодорхойлсон) гэж тогтоосон өөр бусад хугацаанд багтаан Инженерийн хэлцлийн эсхүл дүгнэлтийн тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

Хэрвээ Инженер нь хэлцлийн эсхүл дүгнэлтийн тухай мэдэгдлийг холбогдох тогтоосон хугацааны хязгаарт багтаан хүргүүлээгүй тохиолдолд:

(i) Нэхэмжлэлтэй холбоотой үед Инженерийг нэхэмжлэлийг үл зөвшөөрсөн гэж үзнэ. эсхүл

(ii) Хэлцэл эсхүл дүгнэлтэй холбоотой үед асуудлыг аливаа Талаац гэрээний 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах]-т заасны дагуу СШСЗ-д шийдвэр гаруулахаар хүргүүлсэн Маргаан гэж үзэх бөгөөд үүнд Үл зөвшөөрөх мэдэгдэл шаардлагагүй (гэрээний 3.7.5 [Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх] болон 21.4.1 [МЗШЗ-д Маргаан гаргах]-ийн (a) дэд заалт үйлчлэхгүй).

3.7.4 Тохиролцох эсхүл шийдвэрийн үр дүн

Аливаа хэлцэл эсхүл дүгнэлтийг энэхүү хэсэгт заасны дагуу залруулах эсхүл шийдвэрлэж дуусах хүртэл Талууд заавал дагаж мөрдөх, биелүүлэх үүрэгтэй (Инженерээс хянагдаж зөвшөөрөгдсөн байна) ба хэрвээ дүгнэлт бол түүнийг гэрээний 21 [Маргаан ба Арбитрын ажиллагаа]-т заасны дагуу хянагдсан байх шаардлагатай.

Хэрэв хэлцэл эсхүл дүгнэлт нь аль нэг Тал нь нөгөө Талдаа төлөх төлбөрийн дүнтэй холбоотой бол Гүйцэтгэгч уг дүнг удаах Төлбөрийн мэдэгдэлдээ тусгах үүрэгтэй бөгөөд Инженер нь уг Төлбөрийн мэдэгдлийн дагуу гаргах Төлбөрийн гэрчилгээнд уг мөнгөн дүнг тусгах үүрэгтэй.

Хэрэв Инженерээс Тохиролцох эсхүл шийдвэрлэх талаарх мэдэгдлийг хүлээн авсан эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногт уг мэдэгдэл шивэлтийн алдаа эсхүл, хэвлэлтийн алдаа эсхүл, арифметик/тооцооллын алдаа илэрсэн тохиолдолд:

(a) Инженер илрүүлсэн бол энэ тухай мэдээллийг Талуудад нэн даруй мэдэгдэнэ; эсхүл

(b) Аль нэг Тал нь илрүүлсэн бол уг илрүүлсэн Тал нь энэ тухай мэдэгдлийг Инженерт хүргүүлэх бөгөөд а энэхүү гэрээний 3.7.4-т заасны дагуу хүргүүлж байгааг заавал дурдах ба алдааг тодорхой тайлбарлана. Хэрэв уг алдааг Инженер нь алдаа гэж хүлээн зөвшөөрөхгүй бол энэ тухай холбогдох мэдээллийг Талуудад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

Алдааг илрүүлснээс хойш эсхүл дээрхи (b) заалтад заасны дагуу мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Инженер нь Талуудад залруулан шинэчилсэн Тохиролцох эсхүл шийдвэрлэх мэдэгдлийг хүргүүлнэ. Үүнээс хойш шинэчилсэн тохиролцох эсхүл шийдвэрлэх мэдэгдлийг эдгээр Нөхцөлүүдийг хангах хэлцэл эсхүл дүгнэлт гэж үзэж дагаж мөрдөнө.

3.7.5 Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх

Аль нэг Тал нь Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх тохиолдолд:

(a) Үл зөвшөөрч буй Тал нөгөө Талдаа үл зөвшөөрөх мэдэгдэл (ҮЗМ) хүргүүлэх бөгөөд хуулбар хувийг Инженерт хүргүүлнэ.

(b) Уг ҮЗМ нь “Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх тухай мэдэгдэл” тэргүүтэй байх бөгөөд үл зөвшөөрч байгаа шалтгаануудыг дурдсан байна.

(c) Уг ҮЗМ-ийг гэрээний 3.7.2 [Инженерийн дүгнэлт]-т заасны дагуу Инженерийн дүгнэлтийн мэдэгдлийг эсхүл шаардлагатай тохиолдолд гэрээний 3.7.4 [Тохиролцох эсхүл шийдвэрлэхийн үр дүн]-т заасны дагуу Дүгнэлтийн дагуу засч залруулсан тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор хүргүүлэх үүрэгтэй (эсхүл Нэхэмжлэлийг үгүйсгэсэн дүгнэлттэй холбоотой үед гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-т заасны дагуу дүгнэлтийн хугацаа дуусгавар болсноос хойш 28 хоногийн дотор).

(d) Үүний дараа аль нэг Тал нь гэрээний 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах]-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж болно.

Хэрэв дээрхи (c)-д заасан 28 хоногийн дотор аль нэг Талаас ҮЗМ хүргүүлээгүй бол Инженерийн дүгнэлтийг Талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэх бөгөөд үүнийг эцсийн дүгнэлт буюу заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

Хэрэв үл зөвшөөрч буй Тал нь Инженерийн дүгнэлтийн аль нэг хэсгийг (хэсгүүдийг) үл зөвшөөрч байгаа тохиолдолд:

(i) тухайн Уг хэсгийг (хэсгүүдийг) ҮЗМ-д дэлгэрэнгүй тайлбарлана;

(ii) Уг хэсгийг (хэсгүүдийг) болон уг дүгнүүлтийн хэсэгт хамаарал бүхий эсхүл түүнийг бүрдэл бүхий аливаа бусад хэсгүүдийг дүгнэлтийн бусад хэсгүүдээс тусад нь авч үзнэ.

(iii) ҮЗМ хүргүүлээгүй тохиолдолд Дүгнэлтийн үлдсэн хэсгүүд ойлголт нь Талууд заавал биелүүлэх эцсийн дүгнэлт байна.

Хэрвээ Тал нь энэхүү гэрээний 3.7-д заасны дагуу Талуудын хэлцэлийг эсхүл Инженерийн эцсийн бөгөөд заавал биелүүлэх дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд нөгөө Тал нь гэрээний 21.6 [Арбитрын ажиллагаа]-д заасны дагуу арбитрт үүргээ биелүүлээгүй болох талаар шууд хандах эрхтэй үүнд аливаа бусад эрх, үүргийг хөндөхгүй. Энэ тохиолдолд 21.7 [МЗШЗ-н шийдвэрийг үл биелүүлэх] дахь хэсгийн нэгдүгээр болон гуравдах заалтуудад үйлчилж эхлэх ба эдгээр заалтууд нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх МЗШЗ-ийн шийдвэрт үйлчилдэгтэй адилаар үйлчилнэ.

3.8 Хурал, уулзалт

Инженер болон гүйцэтгэгчийн төлөөлөгч нь ажил гүйцэтгэлийг биелүүлэх зорилтын хүрээнд мөн цаашдын ажлын төлөвлөгөөг хэлэлцэх тохиолдолд бусад талуудыг хурал, уулзалтад оролцохыг шаардах эрхтэй.

Хэрэв Инженер эсхүл Гүйцэтгэгчийн төлөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд Захиалагчийн бусад Гүйцэтгэгчид болон төрийн байгууллага, хувийн аж ахуйн нэгж, болон/эсхүл Туслан гүйцэтгэгч нар уг хурал, уулзалтад оролцож болно.

Инженер нь менежментийн хурлын тэмдэглэлийг хөтлөх бөгөөд тэмдэглэлийн хуулбарыг хурал уулзалтанд оролцсон талууд болон Захиалагчид хүргүүлэх үүрэгтэй. Аливаа хурал, уулзалт болон хурлын тэмдэглэл дэх аливаа ажил, үүрэг хариуцлага нь Гэрээний шаардлагад нийцсэн байх ёстой.

4. Гүйцэтгэгч

4.1 Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг

Гүйцэтгэгч нь Гэрээнд заасны дагуу ажлыг гүйцэтгэнэ. Ажлын гүйцэтгэл болон бүрэн дууссан ажил нь Гэрээний бүрдэл баримт бичгийн дагуу, мөн аливаа Гэрээний өөрчлөлтийн дагуу өөрчлөлтийг тусгасан байх үүргийг Гүйцэтгэгч хүлээнэ.

Гүйцэтгэгч нь Гэрээнд тусгагдсан үндсэн тоног төхөөрөмж (сэлбэг хэрэгсэл байвал тэдгээрийн хамт) болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн ажиллах хүчин /ажилтнууд/ болон бараа, бүтээгдэхүүн, мөн Гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхэд шаардагдах түр болон байнгын/үндсэн бусад зүйлс, ажил үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн бүхий л үйл ажиллагаа ба ажил, барилга урсгалтын аргачлал, мөн бүхий л түр ажлын үнэн зөв, бодит, зохистой, тогтвортой, аюулгүй байдлыг хариуцна. Энэхүү тодорхойлсон Гэрээнд зааснаас гадна гүйцэтгэгч нь:

(i) Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, түр ажил болон Гэрээнд заасны дагуу шаардагдах үндсэн тоног төхөөрөмж ба материалын эд зүйлс тус бүрийн зураг төслийг хариуцна.

(ii) Барилгын үндсэн ажлын зураг төсөл эсхүл техникийн шаардлагуудыг үүрэг хариуцлага хүлээхгүй.

Инженерээс шаардсан тохиолдолд Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх аргачлал болон арга хэмжээний тухай Гүйцэтгэгчийн дэлгэрэнгүй санал, мэдээллийг

Инженерт хүргүүлэх үүрэгтэй. Эдгээр аргачлал болон арга хэмжээнд Инженерийн зөвшөөрөлгүйгээр аливаа /томоохон/ өөрчлөлтийг оруулахыг хориглоно.

Хэрвээ Гүйцэтгэгч Гэрээнд заасны дагуу барилгын үндсэн ажлын аливаа хэсгийн зураг төслийг гүйцэтгэхээр болсон тохиолдолд Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол:

(a) Гүйцэтгэгч нь энэхүү хэсэгт зориулсан инженерт баримт бичгүүдийг бэлдэж өгөх, мөн илгээх үүрэгтэй. Энэхүү бичиг баримтад ажлыг гүйцэтгэх үед шаардагдах зураг төслийг гүйцэтгэх, зураг төслийн дагуу хэрэгжилтийг хангахад шаардагдах болон Гүйцэтгэгчийн ажилтнуудад зориулагдсан гарын авлага, зааварчилгаа зэрэг аливаа бусад баримт бичгүүд бэлтгэн боловсруулж хүргүүлснээр инженерт хяналт шалгалт явуулна.

(b) Эдгээр Гүйцэтгэгчийн баримт бичгүүд нь Захиалагчийн шаардлага болон Зураг төсөлд нийцсэн байх бөгөөд Зураг төсөлд нэмж өөрчлөлт оруулахад инженерт хэрэг болох талуудын гүйцэтгэсэн зураг төслийн нэмэлт мэдээллийг тусгах шаардлагатай.

(c) Хэрвээ Инженерийн зүгээс Гүйцэтгэгчийн зураг төсөл гэрээнд нийцэж байгааг баримт бичигт тусган харуулахыг шаардан үндэслэлтэй даалгавар өгөгдсөн тохиолдолд Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар боловсруулан Инженерт нэн даруй хүргүүлэх үүрэгтэй;

(c) Тухайн зураг төсөлтэй холбоотой бүхий л Гүйцэтгэгчийн баримт бичигт гэрээний 4.4.1 [Баримт бичиг боловсруулах болон Нягтлах] заалтын (i) дэд заалтад заасны дагуу татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг Инженерээс ирүүлэх (эсхүл ирүүлсэн гэж үзэх) хүртэл уг зураг төсөлтэй холбоотой хэсгийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхгүй ба Гүйцэтгэгчийн баримт бичигт туссаны дагуу тухайн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх шаардлагатай;

(d) Инженерт хянан шалгуулахаар өмнө нь өгөгдсөн мэдэгдэл болох зураг төсөл эсхүл баримт бичигт Гүйцэтгэгч нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Хэрэв дээр дурьдсан зураг төсөл эсхүл баримт бичигтэй хамаарал бүхий Ажлын зарим хэсгийн барилга угсралтын ажлыг Гүйцэтгэгч эхлүүлсэн тохиолдолд тухайн барилга угсралтын ажлыг түр зогсоо ба хэрвээ гэрээний 4.4.1.(ii) дэд заалтын дагуу Инженерээс Гүйцэтгэгчийн баримт бичигтэй холбоотой мэдэгдэл ирүүлсэн тохиолдолд 4.4.1 дэх заалтад заасан дэд заалтууд үйлчилж эхлэх бөгөөд (хянуулахаар хүргүүлсэн)/(нэмэлт өөрчлөлт оруулсан) баримт бичигтэй холбоотой Татгалзах зүйлгүй тухай Мэдэгдлийг Инженерээс ирүүлэх (эсхүл ирүүлсэн гэж үзэх) хүртэл уг ажлыг дахин эхлүүлэхгүй.

(e) Гүйцэтгэгч нь тухайн хэсгийн үүрэг хариуцлагыг бүрэн хариуцах бөгөөд Ажил дууссаны дараа тухайн хэсэг нь Гэрээнд заагдсан шаардлага, зорилгод (эсхүл, хэрвээ шаардлага/зорилго нь тодорхойлогдоогүй, тусгагдаагүй бол тэдгээрийн үндсэн зориулалттай нийцсэн) нийцсэн байх ёстой;

(f) Гүйцэтгэгч нь дээр дурдсан үүрэг хариуцлагуудаас гадна энэхүү хэсэгт хамаарал бүхий зураг төсөл болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүд нь Захиалагчийн шаардлага болон Хуульд тусгагдсан техникийн стандарт, шаардлагуудад хангасан байх ба мөн Гэрээний бүрдэл хэсгүүд, Гэрээний өөрчлөлт болон тохицуулгын баримт бичгүүдтэй нийцтэй байлгах зэрэг үүрэг хариуцлагыг хүлээн;

(g) Хэрвээ гэрээний 4.4.2 [Ажлын явцын тэмдэглэл] болон/эсхүл 4.4.3 [Ашиглалт болон Засвар үйлчилгээний гарын авлага]-ийн дэд заалтууд хамаарах бол заалтын дагуу Гүйцэтгэгч нь Инженерт тухайн хэсэгтэй холбоотой Гүйцэтгэгчийн

баримт бичгүүдийг нийцүүлэн хүргүүлэх ба үүндээ Инженерээс тухайн хэсгийг ажиллуулах, ашиглах, үйлчилгээ үзүүлэх, задаргаа хийх, угсралт хийх, тохируулах, засварлах зэргийг хийхтэй холбоотой мэдээллийг хангалттай тусгасан байна;

(h) Хэрвээ гэрээний 4.5 [Сургалт]-д хамаарах бол Гүйцэтгэгч нь энэхүү хэсэгтэй холбогдох ашиглалт болон засвар үйлчилгээтэй холбоотой Инженерийн ажиллагдын сургалтыг хариуцан явуулна.

4.2 Гүйцэтгэлийн баталгаа

Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүргийг зүй ёсоор биелүүлэхийн баталгаа болгон Гэрээний мэдээлэлд дурдсан мөнгөн тэмдэгт болон дүнгээр Гүйцэтгэлийн баталгааг (Гүйцэтгэгчийн зардлаар) гаргасан байх үүрэгтэй. Хэрвээ Гэрээний мэдээлэлд баталгааны дүнг тусгаагүй бол энэхүү хэсэг үйлчлэхгүй.

4.2.1 Гүйцэтгэгчийн үүрэг

Гүйцэтгэгч нь тендерт шалгарсан тухай захидлыг хүлээн авснаас хойш 28 өдөрт багтаан Гүйцэтгэлийн баталгааг Захиалагчид хүргүүлэх ба, уг баталгааны хуулбарыг нь Инженерт хүргүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн зөвшөөрсөн тухайн улс оронд (эсхүл хуульд заасан бусад улс оронд), хууль ёсны этгээдээс олгох бөгөөд Гэрээний тусгай нөхцөлд хавсаргасан маягтын дагуу эсхүл Захиалагчаас зөвшөөрсөн (гэвч энэхүү зөвшөөрөл болон/эсхүл гэрээ хэлцэл нь Гүйцэтгэгчийг энэхүү хэсэгт заасан аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй) маягтын дагуу гаргана.

Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох болон гэрээний 11.11 [Ажлын талбайг чөлөөлөх] дэх хэсгийн заалтуудыг Гүйцэтгэгч биелүүлж дуусах хүртэл хугацаанд Гүйцэтгэлийн баталгааг хүчин төгөлдөр мөрдөх, хангах үүргийг Гүйцэтгэгч хүлээнэ. Хэрвээ Гүйцэтгэлийн баталгаанд дуусгавар болох огноог тусгасан бөгөөд дуусгавар болох огнооноос 28 хоногийн өмнө Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн баталгааг авах эрхийг хангаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн баталгааны дуусгавар болох хугацааг Гүйцэтгэлийн баталгааг олгох хүртэл болон 11.11 [Ажлын талбайг чөлөөлөх] хэсгийн заалтуудыг Гүйцэтгэгч бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаагаар сунгах ёстой.

Хэрвээ гэрээний 13 [Гэрээний өөрчлөлт болон Тохируулга]-т заасны дагуу аливаа Гэрээний өөрчлөлт болон/эсхүл тохируулга хийгдсэний улмаас Гэрээний зөвшөөрөгдсөнгийн хорин хувиас (20%) илүү Гэрээний үнийн хуримтлагдсан өсөлт эсхүл бууралт гарсан тохиолдолд:

(a) энэхүү өсөлт гарсан тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн хүсэлтээр Гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн валютаар /мөнгөний нэгжээр/ хуримтлагдсан өсөлттэй тэнцэх хувиар нэн даруй нэмэгдүүлнэ; эсхүл

(b) энэхүү бууралт гарсан тохиолдолд Захиалагчтай урьдчилан зөвшилцсөний дагуу Гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн валютаар /мөнгөний нэгжээр/ хуримтлагдсан бууралттай тэнцэх хувиар бууруулах боломжтой.

4.2.2 Гүйцэтгэлийн баталгааны дагуу Нэхэмжлэл гаргах

Захиалагч нь гагчхүү дараах тохиолдуудад Гэрээнд заагдсан дүнгээр Гүйцэтгэлийн баталгааны нэхэмжлэл гаргах ба бусад тохиолдолд Гүйцэтгэлийн баталгааны дагуу нэхэмжлэл гаргах эрхгүй:

(a) Энэ хэсэгт заасны дагуу Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацааг Гүйцэтгэгч сунгаагүй бол Захиалагч гэрээний бүх дүнг (эсхүл өмнө бууруулсан бол үлдсэн дүнгээр) бүрэн хэмжээгээр нэхэмжилж болно.

(b) Гүйцэтгэгч нь гэрээний 3.7 [Хэлцэл болон Дүгнэлт]-д зааснаар харилцан зөвшөөрсөн эсхүл тогтоосон эсхүл гэрээний 21 [Маргаан болон Арбитрын ажиллагаа]-т заасны дагуу харилцан зөвшөөрсөн эсхүл тогтоосон дүнг гэрээ хийгдсэн эсхүл тогтоосон эсхүл шийдвэрлэсэн эсхүл арбитрын шийдвэр гарсан (тухайн нөхцөл байдлаас хамаарч) өдрөөс хойш 42 хоногийн дотор Захиалагчид төлж барагдуулаагүй бол;

(c) Гүйцэтгэгч нь гэрээний 15.1 [Алдааг засах тухай Мэдэгдэл]-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдэл дурдсан үүрэг даалгаврыг 42 хоногт багтаан эсхүл бусад хугацаанд мэдэгдэлд тусган (хэрвээ байвал) биелүүлээгүй бол;

(d) Гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлсэн эсэхээс үл хамааран гэрээний 15.2 [Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлах]-т заасны дагуу Захиалагчийн зүгээс Гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн бол; эсхүл

(e) Хэрэв гэрээний 11.5 [Гологдлыг ажлын талбайн гадна засварлах]-д заасны дагуу Гүйцэтгэгч нь аливаа доголдол эсхүл гэмтэж эвдэрсэн аж үйлдвэрийн нэгжийг Ажлын талбайгаас гаргах ёстой бөгөөд Гүйцэтгэгчийн Мэдэгдэлд тусгасан холбогдох хугацааг (эсхүл Захиалагчтай зөвшилцсөн бусад хугацаанд) дусахаас өмнө уг үндсэн тоног төхөөрөмжийг засварлаагүй, Ажлын талбайд буцаан авчраагүй, дахин суурилуулаагүй, дахин шалгаж тестлээгүй бол.

Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааны нэхэмжлэлээс үүсэх бүхий л хохирол, алдагдал, төлбөрөөс (шүүхийн хураамж болон зардлыг багтаана) Гүйцэтгэгчийг хамгаалах, хохиролгүй болгох үүрэгтэй ба энэхүү үүргийг Захиалагч нь нэхэмжлэл гаргах эрхгүй байсан ч биелүүлнэ.

Захиалагчийн хүлээн авсан гүйцэтгэлийн баталгаа холбоотой аливаа дүнг:

i. Гэрээний 14.13[Сүүлийн төлбөрийн гэрчилгээ]-т заасан Сүүлийн төлбөрийн гэрчилгээнд тусгана (төлбөрийн дүнд багтаана); эсхүл

ii. Хэрвээ Гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээний 15.4 [Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцалснаас хойши хөлбөр], 15.7 [Захиалагчид зохимжтой байдлын үүднээс гэрээ цуцалснаас хойши хөлбөр], 16.4 [Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцалсны дараах төлбөр], 18.5 [Аль нэг Талын саналаар цуцлах санал], эсхүл 18.6 [Хуулийн дагуу Гэрээний үүргээс чөлөөлөх]-д (нөхцөл байдлаас хамаарна) тус тус заасны дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрт оруулан тооцно.

4.2.3 Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгох

Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааг дор дурьдсан нөхцөлийн дагуу Гүйцэтгэгчид буцаан олгоно:

(a) Гүйцэтгэлийн гэрчилгээг хүргүүлснээс хойш 21 өдөрт багтаан буцаан олгох ба Гүйцэтгэгч нь гэрээний 11.11 [Ажлын талбайг чөлөөлөх]-т заасныг биелүүлсэн бол; эсхүл

(b) Хэрвээ гэрээний 15.5 [Захиалагчид зохимжтой байдлын үүднээс гэрээ цуцлах], 16.2 [Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцлах], 18.5 [Аль нэг Талын саналаар цуцлах санал] эсхүл 18.6 [Хуулийн дагуу Гэрээний үүргээс чөлөөлөх] хэсгүүдэд тус тус заасны дагуу Гэрээ цуцлагдсан бол Гэрээ цуцлагдсаны дараа нэн даруй Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгоно.

4.3 Гүйцэтгэгчийн төлөөлөгч

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилох бөгөөд тухайн төлөөлөгчид Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг сольж томилохоос бусад Гэрээний дагуу Гүйцэтгэгчийг төлөөлж ажил гүйцэтгэхэд шаардагдах бүхий л эрхийг олгоно.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Ажилд хамаарах үндсэн инженеринийн чиглэлээр мэргэшсэн, туршлага, ур чадвартай байх бөгөөд гэрээний 1.4 [Хууль болон Хэл]-т заасан харилцааны хэлийг бүрэн эзэмшсэн байна.

Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг нэр заан гэрээнд дурдаагүй бол Гүйцэтгэгч нь Ажил эхлэх огноогоос өмнө Гүйцэтгэгчийн төлөөлөгчөөр томилохоор санал болгож буй хүний нэр болон тодорхойлолт/дэлгэрэнгүй мэдээллийг зөвшилцөхөөр Инженерт хүргүүлнэ. Хэрвээ зөвшилцөлд хүрээгүй бөгөөд улмаар эгүүлэн татсан бол, эсхүл томилогдсон этгээд нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн ажил үүргээ биелүүлээгүй бол Гүйцэтгэгч нь тухайн томилгоон дээр өөр тохиорох хүний нэр, холбогдох мэдээллийг санал болгон мөн адил хүргүүлнэ. Хэрвээ энэхүү саналыг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Инженер нь тухайн санал болгож буй хүнээс татгалзсан эсхүл солих тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлэх байдлаар хариу мэдэгдээгүй бол Инженерийг тухайн төлөөлөгчийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Инженерийн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч нь томилогдсон Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг эгүүлэн татах эсхүл сэлгээний томилгоог хийх (Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь нас барах, өвчин эмгэг, тахир дутуу болох шалтгаанаар эсхүл ажлаас халагдсанаар ажил үүргээ биелүүлэх чадамжгүй болохоос бусад тохиолдлыг оруулна. Эдгээр тохиолдолд тухайн төлөөлөгчийг эгүүлэн татсан шийдвэрийг шууд хүчин төгөлдөр үйлчилнэ хэмээн үзэн үүрэг гүйцэтгэгч төлөөлөгчийн томилгоог хийх бөгөөд энэхүү төлөөлөгчийг Инженерийн зүгээс хүлээн зөвшөөрөл эсхүл энэхүү хэсэгт заасны дагуу сэлгээний төлөөлөгч томилогдох хүртэл хугацаанд үүрэг гүйцэтгэгч төлөөлөгч гэж үзнэ) эрхгүй.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг удирдан чиглүүлэх үүрэг хариуцлагыг үргэлжид хүлээнэ. Гэрээний дагуу ажил гүйцэтгэх бүхий л хугацаанд Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Гүйцэтгэгчийн төлөө болон түүнийг төлөөлөн ажиллах ба үүнд гэрээний 1.3 [Мэдэгдэл болон Бусад харилцаа]-т заасны дагуу бүхий л мэдэгдэл болон бусад харилцааг хүлээн авах, илгээх; 3.5 [Инженерийн даалгавар]-д заасны дагуу аливаа даалгаврыг хүлээн авах зэрэг үүрэгт ажлуудыг багтаана.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Ажлын талбайд Ажил гүйцэтгэх явцын бүхий л хугацаанд Ажлын талбайд байх шаардлагатай. Хэрвээ Гүйцэтгэгчийн төлөөлөгч Ажил гүйцэтгэх явцад Ажлын талбайд түр хугацаагаар эзэнгүй байх бол Инженерээс урьдчилан зөвшөөрөл авч зохих шаардлагуудыг хангах төлөөлөгчийг түр хугацаагаар томилон ажиллуулах ёстай.

Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь доор дурдагдах эрх мэдэл, үүрэг хариуцлагуудаас бусад аливаа эрх мэдэл, үүргийг зохих ур чадвар бүхий туршлагатай хүнд/этгээдэд шилжүүлэх эрхтэй ба ямар ч үед цуцлах/буцаан татах эрхтэй:

(a) гэрээний 1.3 [Мэдэгдэл болон Бусад харилцаа]-т заасны дагуу Мэдэгдэл болон бусад харилцаатай холбоотой хүлээн авах, илгээх эрх;

(b) гэрээний 3.5 [Инженерийн даалгавар]-т заасны дагуу даалгавар хүлээн авах эрх үүрэг.

Аливаа эрх шилжүүлэх эсхүл цуцлах/буцаан татах шийдвэр нь Инженер нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчөөс тухайн шилжүүлж буй хүний нэр, шилжүүлж буй болон цуцалж буй эрх мэдэл, үүрэг хариуцлага, удирдлагын эрх мэдлийг эрхийг шилжүүлж буй болон цуцалж буй цаг хугацааны хамтаар нарийвчилан тусгасан Мэдэгдэл авах хүртэл хүчин төгөлдөр бус байна.

Эдгээрт хамаарал бүхий этгээдүүд/хүмүүс нь гэрээний 1.4 [Хууль болон Хэл]-т заасан харилцааны хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай.

4.4 Гүйцэтгэгчийн баримт бичиг

4.4.1 Баримт бичиг боловсруулах болон нягтлах

Гүйцэтгэгчийн баримт бичиг нь дараах баримт бичгүүдийг багтаана. Үүнд:

- (a) Захиалагчийн шаардлагад дурдсан баримт бичгүүд;
- (b) гэрээний 1.13 [Хуулийг дагаж мөрдөх]-т заасны дагуу Гүйцэтгэгчид шаардлагатай зөвшөөрлүүд, тусгай зөвшөөрлүүд, лиценз болон хууль дүрэм, норм нормативд заасан бусад зөвшөөрлүүд;
- (c) Шаардлагатай тохиолдолд гэрээний 4.4.2 [Ажлын явцын тэмдэглэл] болон 4.4.3 [Ашиглалт болон Засвар үйлчилгээний гарын авлагы]-т заасан баримт бичгүүд;
- (d) Шаардлагатай тохиолдолд гэрээний 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг]-ийн (a) заалтад заасан бичиг баримтууд.

Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичгийг гэрээний 4.1 [Хууль болон Хэл]-т дурьдсан харилцааны хэлээр үйлдэнэ.

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн бүх баримт бичгийг бэлтгэх ёстой бөгөөд захиалагчийн ажилтнууд эдгээр бүх баримт бичгийг бэлтгэгдсэн байгаа газар нөхцөлөөс үл хамааран шалгах эрхтэй.

Хэрвээ Захиалагчийн шаардлага эсхүл эдгээр Ерөнхий нөхцөлүүдэд Гүйцэтгэгчийн баримт бичгийг Инженерийн хяналтаар оруулах тухай тусгайлан заагаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичгийг мэдэгдлийн хамтаар хүргэх бөгөөд уг мэдэгдэлд Гүйцэтгэгчийн баримт бичиг нь гэрээнд нийцсэн болон хяналтад бэлэн болсныг дурдана.

Инженер нь Гүйцэтгэгчийн баримт бичгийг болон дээрх мэдэгдлийг Гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 21 хоногт багтаан Гүйцэтгэгчид дараах мэдэгдлийг хүргүүлэх үүрэгтэй:

(i) Татгалзах зүйлгүй болох тухай мэдэгдэл (үүнд Ажилд онцгой нөлөө үзүүлэхээргүй бага зэргийн асуудлуудтай холбоотой санал шүүмжийг (комментүүдийг) тусгаж болно); эсхүл

(ii) Гүйцэтгэгчийн баримт бичиг нь гэрээнд нийцэхгүй (ирүүлсэн баримт бичгийн хувьд) байгааг учир шалтгааныг дурдана.

Хэрвээ Инженер нь энэхүү 21 хоногийн дотор мэдэгдэл хүргүүлээгүй бол Инженерийг Гүйцэтгэгчийн баримт бичигтэй холбоотой татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг хүргүүлсэн гэж үзнэ.

Дээрх (ii) дэд заалтын мэдэгдлийг хүлээн авсны дараа Гүйцэтгэгч нь гүйцэтгэгчийн баримт бичгийг хянан засварлаж, энэ хэсэгт заасны дагуу хянан шалгуулахаар инженерт дахин өгөх бөгөөд хянуулах 21 хоногийн хугацааг тухайн өдрөөс эхлэн тооцно.

4.4.2 Ажлын явцын тэмдэглэл

Хэрвээ Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгчийг Гүйцэтгэлийн тайланг бэлтгэж боловсруулах үүргээс чөлөөлсөн бол энэхүү хэсэг үйлчлэхгүй.

Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлынхаа хэмжээ, нарийвчилсан байршил, дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг тодорхой тусгасан Ажил гүйцэтгэлийн багц тайланг бэлтгэх, шинэчилэх үүргийг хүлээнэ. Гүйцэтгэлийн тайлангийн маят загвар, лавлагааны систем, цахим систем (хадгалах зэрэг) болон бусад нарийвчилсан мэдээллийг Захиалагчийн шаардлагад тусгана (тусгаагүй бол Инженерээс зөвшөөрөгдсөн байна). Эдгээр гүйцэтгэлийн тайланг ажлын талбайд хадгалах бөгөөд энэхүү хэсэгт заасан зорилгоор гагчхүү ашиглана.

Гүйцэтгэлийн тайлангуудыг Инженерээр нягтлуулж, хянуулахаар хүргүүлэх ба Инженерээс гэрээний 4.4.1 [Баримт бичиг боловсруулах болон Нягталж, хянах]-ийн хэсгийн (i) дэд заалтад заасны дагуу татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг хүргүүлэх (эсхүл хүргүүлсэн гэж үзэх) хүртэл гэрээний 10.1 [Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах]-т заасны дагуу Ажлыг дууссан гэж үзэхгүй.

Энэхүү хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгчийн хүргүүлэх Гүйцэтгэлийн тайлангийн хуулбар хувийн тоо нь гэрээний 1.8 [Баримт бичгийг хадгалах, хүлээлгэн өгөх]-д заасны дагуу байх ёстой.

4.4.3 Ашиглалт болон Засвар үйлчилгээний гарын авлага

Хэрвээ Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгч нь ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлагыг хариуцахгүй гэж тусгайлан заасан бол энэхүү хэсгийн заалтууд үйлчлэхгүй.

Гүйцэтгэгч нь ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлагыг Захиалагчийн шаардлагад заасан маят болон бусад зохих мэдээллүүдийг тусган бэлтгэх бөгөөд тогтмол шинэчилж хүчин төгөлдөр хүчинтэй байлгана.

Ашиглалт болон засвар үйлчилгээний гарын авлагыг Инженерт хянуулахаар хүргүүлэх ёстой бөгөөд хэрвээ Инженерээс гэрээний 4.4.1 [Баримт бичиг боловсруулах болон Нягталж, хянах]-ийн (i) дэд заалтад заасны дагуу Татгалзах зүйлгүй тухай Мэдэгдлийг ирүүлэх (эсхүл ирүүлсэн гэж үзэх) хүртэл гэрээний 10.1 [Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах]-т заасны дагуу ажлыг хүлээн зөвшөөрч Ажил гүйцэтгэсэн гэж үзэхгүй болно.

4.5 Сургалт

Хэрвээ Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгч нь Захиалагчийн (болон/эсхүл бусад ажиллах хүчиний) ажиллагсдын сургалтыг хариуцахгүй гэж тусгайлан заасан бол энэхүү хэсгийн заалтууд үйлчлэхгүй.

Инженерийн ажиллагсдын (болон/эсхүл Захиалагчийн шаардлагад заагдсан бусад ажиллагсдын) ажлын ашиглалтын болон засвар үйлчилгээ, ажилтай холбоотой бусад чиглэлийн сургалтуудыг Захиалагчийн шаардлагад тусгагдсан сургалтуудтай хамтад нь Гүйцэтгэгч хариуцан явуулна. Сургалтын хуваарийг Захиалагчийн шаардлагад тусгасан (тусгаагүй бол Захиалагчийн зөвшөөрөлтэйгээр хийгдэнэ) байх ёстой. Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад тусгасан болон/эсхүл шаардлагатай эрх бүхий туршлагатай сургалтын багш ажилтнууд, сургалтын байр болон сургалтын материалын хариуцан хангах үүрэгтэй.

Хэрвээ Захиалагчийн шаардлагад Захиалагч ажлыг хүлээн авахаас өмнө сургалт нь дууссан байх ёстой хэмээн заасан бол Захиалагчийн шаардлагад заасны дагуу энэ сургалтыг явуулж дуустал гэрээний 10.1 [Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах]-т заасны дагуу ажлыг дууссан гэж үзэхгүй.

4.6 Хамтын ажиллагаа

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заагдсан эсхүл Инженерийн даалгаврын дагуу Гэрээнд тусгаагүй аливаа ажлыг ажлын талбайд болон гадна гүйцэтгэхдээ дараах этгээдүүдтэй хамтран ажиллаж зохих боломжуудаар хангах үүрэгтэй:

- (a) Захиалагчийн ажилтан;
- (b) Захиалагчийн бусад гүйцэтгэгч нар;
- (c) Хуулиар эрх мэдэл олгогдсон төрийн өмчийн байгууллагууд болон дэд бүтцийн хувийн компаниудын ажилтан.

Гэрээнд тусгаагүй аливаа ажлыг тухайн талбай дээр эсхүл түүний ойролцоо гүйцэтгэх ажилд хүн томилон ажиллуулж болно. Ийм тохиолдолд Гүйцэтгэгчийн гэрээнд заагдсан тоног төхөөрөмжийг ашиглах, түр ажил хийх, нэвтрэх зохицуулалт болон/эсхүл ажлын талбай дээрх бусад гүйцэтгэгчийн байгууламжийн эрхийг эдэлж болно.

Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлыг хариуцах ба Захиалагчийн шаардлагад заагдсан эсхүл Инженерийн даалгаврын дагуу өөрийн үйл ажиллагааг бусад гүйцэтгэгчдийн (хэрвээ байгаа бол) үйл ажиллагаатай уялдан зохицож хамтран ажиллах тал дээр бүхий л бололцоотой арга хэмжээг авч ажиллана.

Хэрэв энэ хэсэгт заасан даалгаврын үр дүнд Гүйцэтгэгчид хоцролт үүсэх болон/эсхүл Зардал учирсан бол Захиалагчийн шаардлагад заасан хамтын ажиллагаа, зохицуулалт, боломжууд нь Магадалшгүй хүчин зүйл хэмээн үзэж Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу Хугацаа сунгах болон эсхүл уг Зардал болон ашгийн төлбөрийг төлүүлэх эрхтэй.

4.7 Улаан шугам, тэг тэнхлэг татах

Гүйцэтгэгч нь 2.5 [Ажлын талбайн өгөгдөл болон геодезийн тулгуур цэгүүд]-д заасны дагуу Ажлын Улаан шугам, тэг тэнхлэг байгуулна.

4.7.1 Нарийвчлал

Гүйцэтгэгч нь:

- (a) холбогдох бүх геодезийн тулгуур цэгүүдийг Ажил эхлэхээс өмнө баталгаажуулна.
- (b) Баталгаажуулалт тус бүрийн үр дүнг Инженерт цаг тухайд нь хүргүүлнэ.
- (c) Ажлын байрлал, түвшин, хэмжээс, эсхүл тохируулга зэрэгт гарсан аливаа алдааг засч запруулна.
- (d) Ажлын бүх хэсгүүдийн байршлын үнэн зөв байдлыг хариуцна.

4.7.2 Алдаа

Хэрвээ Гүйцэтгэгч нь геодезийн тулгуур цэгүүдэд алдаа илрүүлсэн тохиолдолд уг алдааг тайлбарласан мэдэгдлийг Инженерт хүргүүлэх үүрэгтэй бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

(a) хэрвээ энэ геодезийн тулгуур цэгүүд нь зураг төсөл болон/эсхүл Захиалагчийн шаардлагад тусгагдсан бол Ажил эхлэх огнооноос тооцсон Гэрээний мэдээлэлд заасан (заагаагүй бол 28 өдрөөр тооцно) хугацаанд багтаан хүргүүлнэ; эсхүл

(b) хэрвээ гэрээний 2.5 [Ажлын талбайн өгөгдөл болон геодезийн тупгуур цэгүүд]-д заасны дагуу Инженерээс геодезийн тулгуур цэгүүдийг ирүүлсэн бол тэдгээрийг хүлээн авснаас хойш аль болох богино хугацаанд багтаан хүргүүлнэ.

4.7.3 Засварлах арга хэмжээ, хугацаа хоцролт болон зардалтай холбоотой хэлцэл ба шийдвэр

Инженер нь гэрээний 4.7.2 [Алдаа]-т заасны дагуу Гүйцэтгэгчээс Мэдэгдэл хүлээн авсны дараа 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д зааснаар дараах зүйлүүдийг хүлээн зөвшөөрөх эсхүл тогтоох үйл ажиллагааг эхлүүлнэ. Үүнд:

(a) холбогдох мэдээлэлд алдаа байгаа эсэх;

(b) туршлага бүхий гүйцэтгэгч тухайн алдаануудыг өмнө нь илрүүлэх (хугацаа болон зардлыг тооцно) боломжтой байсан эсэх:

- Тендерийн материалыг хүргүүлэхээс өмнө ажлын талбай, зураг төсөл болон Захиалагчийн шаардлагыг хянаж байхдаа; эсхүл

- Хэрвээ холбогдох мэдээллийд нь зураг төсөл болон/эсхүл Захиалагчийн шаардлагад тусгагдсан байсан бөгөөд гэрээний 4.7.2-ийн (a) дэд заалтад заагдсан хугацаанаас өмнө Гүйцэтгэгчийн мэдэгдэл ирүүлэх үед.

(c) Алдааг засахын тулд Гүйцэтгэгч нь ямар арга хэмжээг (хэрвээ байвал) авах шаардлагатай. (ба гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар] дахь заалтуудыг хангах үүднээс Инженер нь 4.7.2 [Алдаа]-т заасны дагуу Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авах өдрийг гэрээний 3.7.3-т заасны дагуу хэлцлийн хугацааны хязгаарыг тогтоох хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөр тооцно.)

Хэрвээ дээрх (b) заалтад зааснаар туршлага бүхий гүйцэтгэгч нь алдааг илрүүлж/тогтоож чадаагүй бол:

(i) Гэрээний 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх]-т заасны дагуу Гүйцэтгэгч нь холбогдох арга хэмжээг үүргийг хүлээх (хэрвээ байвал); ба

(ii) Хэрвээ алдааны улмаас Гүйцэтгэгчид хоцролт үүсэх болон/эсхүл Зардалтай холбоотой хохирол учирсан бол Гүйцэтгэгч нь 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу ХС нэхэмжлэл гаргах болон/эсхүл зардал болон ашгийн төлбөрийн эрхийг эдэлнэ.

4.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг хариуцлага

Гүйцэтгэгч нь:

(a) ХАБЭА-н (Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн) холбогдох бүхий л хууль, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөнө;

(b) Гэрээнд заасан ХАБЭА-н бүхий л шаардлага, үүргийг биелүүлнэ;

(c) Гүйцэтгэгчийн ХАБЭА-н ажилтнаас (6.7 [Ажилтан, ажилчдын ХАБЭА]-д заасны дагуу томилогдсон) өгөгдсөн бүхий л зааварчилгаа, даалгаврыг биелүүлж дагаж мөрдөнө;

(d) Ажлын талбайд болон ажил гүйцэтгэж буй бусад байршилд (хэрвээ байвал) эрх бүхий бүх хүмүүсийн ХАБЭА-г хангана;

(e) Дээр дурдагдсан хүмүүсийг аливаа эрсдлээс хамгаалан Ажлын талбай болон Ажлыг (болон Ажил гүйцэтгэж буй бусад байршилуудад) шаардлагагүй эд зүйлс, саад тогороос ангид байлгана;

(f) Хашаа, гэрэлтүүлэг, аюулгүйн нэвтрэх хэсэг, харуул хамгаалалт, үзлэг хяналт зэргийг:

i. гэрээний 10 [Захиалагч ажлыг хүлээн авах]-д заасны дагуу Ажлыг бүрэн хүлээн авч дуусах хүртэл хугацаанд Ажилд зориулан;

ii. Дуусаагүй ажил эсхүл ДМХ-нд хийж гүйцэтгэж буй засч запруулах Ажлын аливаа бүрдэл хэдэд тус тус хангах үүргийг хүлээнэ. Мөн

(g) Ажил гүйцэтгэхэд шаардагдах болон олон нийт, орчны газар нутаг, өмчлөгч, түрээслүүлэгч нарын ашиглалт, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор аливаа Түр ажлыг хийж хангах үүргийг хүлээнэ.

Ажил эхлэх огнооноос эхлэн 21 хоногт болон Ажлын талбайд барилга угсралтын ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байгаа Ажлын талбай болон бусад байршилд гүйцэтгэх Ажилд зориулан бэлтгэсэн ХАБЭА-н гарын авлагыг Инженерт зааварлах зорилгоор хүргүүлнэ. Энэхүү гарын авлагыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шаардагдах ХАБЭА-н бусад баримт бичгүүд дээр нэмэлтээр хүргүүлнэ.

ХАБЭА-н гарын авлага нь дараах ХАБЭА-н багц шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

(i) Захиалагчийн шаардлагад тусгасан шаардлагууд;

(ii) Гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн ХАБЭА-н үүрэгтэй нийцсэн байх;

(iii) Ажил гүйцэтгэлийн Ажлын талбай болон бусад гадна талбайд (хэрвээ байвал) байх эрх бүхий хүмүүст зориулагдсан ХАБЭА-н зүй зохистой орчинг бүрдүүлэх, улмаар түүнийгээ хадгалах чиглэгдсэн шаардлагууд.

Энэхүү гарын авлагыг Гүйцэтгэгч эсхүл Гүйцэтгэгчийн ХАБЭА-н ажилтан эсхүл шаардлагатай болон үндэслэлтэй хүсэлт дагуу Инженерийн зүгээс хянагдсан байх шаардлагатай. Хяналт хийгдсэн гарын авлагуудыг Гүйцэтгэгч нь Инженерт нэн даруу хүргүүлнэ.

Гэрээний 4.20 [Явцын тайлан]-ийн (g) заалтад заасан тайланд тавигдах шаардлагууд дээр нэмэлтээр Гүйцэтгэгч нь аливаа осол гарсан тохиолдолд уг ослын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Инженерт аль болохоор богино хугацаанд хүргүүлэх үүрэгтэй бөгөөд ноцтой гэмтэл, амь нас алдсан ослын үед Инженерт шуурхай мэдээлнэ.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасны дагуу болон Инженерийн шаардсаны дагуу хүний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай ба эд хөрөнгөд учирсан аливаа хохиролтой холбоотой бүртгэл, тайланг (ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, журмын дагуу) хөтлөх үүрэгтэй.

4.9. Чанарын удирдлагын болон Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо

4.9.1 Чанарын удирдлагын тогтолцоо

Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа Гэрээний шаардлагад нийцэж буйг нотлох зорилгоор Гүйцэтгэгчийн Чанарын удирдлагын тогтолцоог (ЧУТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү ЧУТ нь Ажилд тусгайлан зориулагдан боловсруулагдах ба Ажил эхлэх огнооноос хойш 28 хоногийн дотор Инженерт хүргүүлсэн байна. Үүний дараа, ЧУТ нь шинэчлэгдэх эсхүл нэмэлт, өөрчлөлт орох бүрт хуулбарыг нь Инженерт нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

ЧУТ нь Захиалагчийн шаардлагын заалтуудтай (хэрвээ байгаа бол) нийцтэй байх бөгөөд Гүйцэтгэгчийн журмуудыг багтаана. Үүнд:

(а) гэрээний 1.3 [Мэдэгдэл болон бусад харилцаа холбоо]-т заасан бүхий л мэдэгдлүүд болон бусад харилцааны мэдээллүүд, Гүйцэтгэгчийн баримт бичиг, Гүйцэтгэлийн тайлан (хэрэв заасан бол), үйл ажиллагаа болон ашиглалтын зааварчилгаа (хэрэв заасан бол), ажил, бараа, гүйцэтгэл, ур чадвар эсхүл үзлэг шалгалт болон тэдгээрт хамаарал бүхий үнэн зөв, бодит, цаг хугацааны бүртгэл мэдээллээр хангах;

(б) Ажил гүйцэтгэх үе шатууд болон Туслан гүйцэтгэгчийг зөв зохистой зохицуулалт, удирдлагаар хангах;

(с) Гүйцэтгэгчийн баримт бичгийг Инженерийн хяналт шалгалтанд хүргүүлэх

Инженер нь ЧУТ-г хяналт шалгалт явуулах эрхтэй ба мөн ЧУТ нь Гэрээнд нийцэхгүй зүйл гарч ирсэн тохиолдолд энэхүү талаарх мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлэх эрхтэй. Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Гүйцэтгэгч нь ЧУТ үл нийцлийг залруулах үүрэгтэй. Хэрвээ ЧУТ-г өргөн барьснаас хойш 21 хоногийн дотор Инженерээс уг мэдэгдлийг хүргүүлээгүй бол Инженерийг Татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг хүргүүлсэн гэж үзнэ.

Инженер нь гүйцэтгэгчээс гаргасан ЧУТ-г зөв хэрэглэж чадахгүй байгаа тохиолдолд ямар ч үед гүйцэтгэгчид энэхүү мэдэгдлийг хүргүүлэх боломжтой. Энэхүү мэдэгдлийг Гүйцэтгэгч хүлээн авангутаа учруулсан алдаа дутагдлыг нэн даруй залруулах үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь ЧУТ-ний дотоод аудитыг тогтмол хийх бөгөөд хамгийн багадаа 6 сар тутам 1 удаа хийх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь дотоод аудит дууссанаас хойш 7 хоногийн дотор тайланг үр дүнгийн хамтаар Инженерт танилцуулах ёстай. Тайлан бүрт шаардлагатай тохиолдолд нь сайжруулахаар санал болгож буй арга хэмжээ болон/эсхүл ЧУТ болон/эсхүл түүний хэрэгжүүлэлтийг боловсронгуй болгох саналуудыг тусгана.

Хэрвээ Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн чанарын баталгаажуулалтын гэрчилгээнд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагатай бол Гүйцэтгэгч нь хөндлөнгийн аудитаар тогтоогдсон аливаа үл тохирл(ууд)-ыг тайлбарласан мэдэгдлийг Инженерт нэн даруй хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь түншлэл бол энэхүү үүрэг нь тухайн түншлэлийн гишүүн бүрт хамаарна.

4.9.2 Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо

Гүйцэтгэгч нь зураг төсөл (хэрвээ байвал), материал, Захиалагчийн ханган нийлүүлсэн материалууд (хэрвээ байвал), үндсэн тоног төхөөрөмж, ажил болон ажиллах ур чадвар зэрэг нь Гэрээний бүх заалтуудад бүрэн нийцэж буйг батлах Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй.

Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо нь Захиалагчийн шаардлагад нарийвчлан заасан нөхцөл шаардлагуудыг бүрэн хангасан байх ёстой бөгөөд Гүйцэтгэгчийн хийсэн бүхий л үзлэг, хяналт шалгалтын үр дүнг тайлаглах аргудыг багтаасан байна. Хэрвээ үзлэг болон эсхүл хяналт шалгалтаар Гэрээний зөрчил, үл тохирол илэрсэн тохиолдолд 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах] дэд заалтыг дагаж мөрдөнө.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасан байдлаар, хэрвээ тодорхой заагаагүй бол Инженерээс хүлээн зөвшөөрсөн загвар, зааврын дагуу ажлын эсхүл

бүрдэл хэсэгт (тухайн нөхцөл байдлаас хамаарч) зориулсан тохирлын хяналтын иж багц баримт бичгийг бүрэн, цэгтэй боловсруулан Инженерт хүргүүлэх үүрэгтэй.

4.9.3 Ерөнхий хариуцлага

Чанарын удирдлагын тогтолцоо болон/эсхүл Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоог дагаж мөрдөх нь Гэрээлэгчийг Гэрээний дагуу болон түүнтэй холбоотойгоор хүлээсэн аливаа үүрэг, хариуцлагаас үл чөлөөлнө.

4.10 Ажлын талбайн мэдээллийг ашиглах

Гүйцэтгэгч нь гэрээний 2.5 [Ажлын талбайн өгөгдөл болон геодезийн тулгуур цэгүүд]-д заагдсан бүхий л өгөгдлийг судалж ойлгосон байх хариуцлагыг хүлээнэ.

Үүний нэгэн адил Гүйцэтгэгч ажил дээр байгаа тохиолдолд ажлын газрыг шалгаж, түүнд нэвтрэх, түүний эргэн тойрон дахь байдал, дээр дурьдсан мэдээлэл болон бусад байгаа мэдээллийг шалгаж, тендерт оролцооос өмнө уг ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүх асуудлыг хангасан байна, Үүнд:

- (a) Ажлын талбайн байгалийн тогтоц болон хэлбэр, инженер геологийн нөхцлийг багтаасан;
- (b) Цаг уур болон гидрогеологийн нөхцөл болон ажлын талбайд нөлөөлөх цаг уурын нөлөөлөл;
- (c) Ажлын гүйцэтгэлд шаардлагатай бараа болон ажлын тоо хэмжээ ба цар хүрээ;
- (d) Улсын ажиллах хүчиний дадлага туршлага, дүрэм, журам болон хуулиуд;
- (e) Нэвтрэх орц гарц, байр, барилга байгууламж, ажилтан, эрчим хүч, тээвэр, ус болон бусад хэрэгцээ эсхүл үйлчилгээнүүдэд зориулагдсан гүйцэтгэгчийн шаардлагууд.

4.11 Гэрээний батлагдсан дүнгийн хүрэлцээтэй байдал

Гүйцэтгэгчийг:

- (a) Гэрээний зөвшөөрөгдсөнгийн үнэ зөв болон хүрэлцээтэй байдлыг хүлээн зөвшөөрсөн;
- (b) Гэрээний зөвшөөрөгдсөнгийн өгөгдлүүд, тайлбар, шаардлагатай мэдээллүүд, үзлэг, шалгалт зэрэгт үндэслэн гэрээний 4.10 [Ажлын талбайн өгөгдлийг ашиглах]-т заасан холбогдох бүх асуудлуудыг хүлээн зөвшөөрсөн хэмээн тус тус үзнэ.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Гэрээний зөвшөөрөгдсөн нь Гүйцэтгэгчийн Гэрээгээр хүлээсэн бүхий л үүрэг хариуцлагыг болон Гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бүхий л зүйлийг тус тус багтаасан гэж үзнэ.

4.12 Байгаль газар зүйн урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал

Энэхүү хэсэгт “магадалшгүй нөхцөл байдал” гэдэг нь Ажлын талбайд ажил гүйцэтгэх үеэр Гүйцэтгэгчид учирч болох байгалийн хүчин зүйлс болон саад бэрхшээлүүд (байгалийн эсхүл хүний нөлөөтэй), хорт бодис гэсэн утгатай бөгөөд үүнд инженер геологийн болон гидрологийн нөхцөл байдлууд багтах боловч Ажлын талбайн цаг уурын нөхцөл байдал болон түүний нөлөөллүүд хамаарахгүй.

Хэрвээ ажил гүйцэтгэлийн үеэр ямар нэгэн хүчин зүйлийн нөлөөгөөр Гүйцэтгэгчийн ажлын явцад хүндрэл учирсан эсхүл зардал өссөн нөхцөл үүссэн бол

Гүйцэтгэгч нь нөлөөлсөн хүчин зүйлийг магадалшгүй хүчин зүйл хэмээн үзсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна:

4.12.1 Гүйцэтгэгч Мэдэгдэл хүргүүлэх

Ийнхүү магадалшгүй нөхцөл байдал (хүчин зүйлийн нөлөө) үүссэн үед Гүйцэтгэгч нь Инженерт мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэл нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- (a) магадалшгүй нөхцөл байдлын цаашдын нөлөөг бууруулах, хязгаарлах, шийдвэрлэх зорилгоор нэн даруй шалгах, судлах боломжийг Инженерт олгоно;
- (b) Инженерийн зүгээс магадалшгүй нөхцөл байдлыг нэн даруй шалгах болон/эсхүл судлах боломжийг олгох зорилгоор магадалшгүй нөхцөл байдлыг тайлбарлан тусгана;
- (c) Гүйцэтгэгчийн зүгээс магадалшгүй нөхцөл байдлыг яагаад урьдчилан таамаглах боломжгүй гэж үзэж байгаа шалтгаануудыг дурьдсан байна.
- (d) Магадалшгүй нөхцөл байдал нь ажлын гүйцэтгэх ажлын явцад болон/эсхүл зардал өсөхөд хэрхэн, яаж нөлөө үзүүлж болохыг тодорхойлон тусгана.

4.12.2 Инженерийн шалгалт, судалгаа

Инженер нь Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор эсхүл Гүйцэтгэгчтэй харилцан зөвшилцөх хугацаанд магадалшгүй нөхцөл байдлыг шалгах, судалгааг хийх үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь магадалшгүй нөхцөл байдалд тохирсон болон Инженерт шалгаж, судлах боломжийг олгосон зохих, үндэслэл бүхий арга хэмжээнүүдийг авч Ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

4.12.3 Инженерийн зааварчилгаа

Инженер нь магадалшгүй нөхцөл байдалтай холбоотой зааварчилгаа өгсөн тохиолдолд гүйцэтгэгч өгсөн зааварчилгааг дагаж мөрдөн хэрэв энэхүү зааварчилгаа нь өөрчлөлттэй хамаарах бол гэрээний 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] үйлчилнэ.

4.12.4 Хугацаа хоцролт болон/эсхүл Зардал

Хэрвээ эдгээр 4.12.1, 4.12.2, 4.12.3 заалтуудыг хангах магадалшгүй нөхцөл байдлын улмаас Гүйцэтгэгчид хугацаа хоцролт үүссэн болон/эсхүл Зардал гарсан байвал Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу тухайн Зардлыг нөхөн төлүүлэх болон/эсхүл ХС Нэхэмжлэл гаргах эрхтэй.

4.12.5 Хугацаа хоцролт болон/эсхүл Зардалтай холбоотой тохиролцох эсхүл шийдвэрлэх

Гэрээний 4.12.4 [Хугацаа хоцролт болон/эсхүл Зардал]-т заагдсан аливаа Нэхэмжлэлийн 20.2.5 [Нэхэмжлэлийн хэлцэл ба шийдэл] хэсэгт заасны дагуу гаргасан хэлцэл болон дүгнэлт нь Магадалшгүй хүчин зүйл байсан эсэх, байсан бол түүний ямар түвшинд байсныг тусгасан байна.

Инженер нь Ажлын ижил төстэй хэсгүүдэд (хэрвээ байвал) тохиосон бусад хүчин зүйлийг/physical conditions Суурь огнооноос өмнө урьдчилан харах/тооцох тааламжтай нөхцөл байдал эсэхийг судлах эрхтэй.

Хэрвээ урьдчилан харах тааламжтай нөхцөл байдал байсан нь тогтоогдвол Инженер нь эдгээр нөхцөл байдлаас хамаарсан энэхүү 4.12.5-т заасны дагуу

зөвшилцөх эсхүл тогтоох нэмэлт Зардлын тооцоонд хасалт хийх/бууруулах эрхтэй. Гэхдээ, энэхүү гэрээний 4.12.5-т заасны дагуу хийгдсэн бүхий л нэмэгдэл болон хасалтын цэвэр дүн нь Гэрээний үнийг хасах үндэслэл болохгүй.

Инженер нь Гүйцэтгэгчийн гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-т заасны дагуу гаргасан Нэхэмжлэлдээ нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл байдлаар тусгасан байж болох суурь огнооноос өмнөх Гүйцэтгэгчийн урьдчилан тооцсон хүчин зүйлсийн магадалшгүй нөхцөл байдал аливаа баримт, нотолгоог харгалзан үзэж болох боловч тэдгээр баримт нотолгоогоор хязгаарлагдахгүй.

4.13 Зам ашиглах зөвшөөрөл болон түр байгууламжийн зардал

Ажлын талбайд нэвтрэх зэрэг Ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор зам ашиглах тусгай болон/эсхүл түр зөвшөөрлүүдийн бүхий л төлбөр, хураамжийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Ажил гүйцэтгэхэд шаардагдах Ажлын талбайн гадна байрлах аливаа түр байгууламжийн зардал болон холбогдох эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

4.14 Орчин тойронд сэргөөр нөлөөлөхөөс зайлсхийх

Гүйцэтгэгч нь зохисгүй байдлаар эсхүл шаардлагагүй тохиолдолд:

(a) олон нийтийн тав тух, амар амгалан байдалд, эсхүл;

(b) нийтийн болон Захиалагчийн эсхүл бусад талуудын эзэмшлийн байх эсэхээс үл хамааран бүх зам талбай, явган хүний замыг ашиглахдаа тус тус сэргөөр нөлөөлөхийг хориглоно.

Гүйцэтгэгч нь шаардлагагүй болон зүй зохисгүй байдлаар гадны оролцоноос үүсч болзошгүй аливаа хохирол, алдагдал, зардал төлбөрөөс (тэмдэгтийн хураамж болон бусад хууль эрх зүйн зардал багтана) Захиалагчийг хамгаалах, баталгаагаар хангах үүргийг хүлээнэ.

4.15 Ажлын талбайд нэвтрэх зам

Суурь огнооны өдөрт Гүйцэтгэгчийг ажлын талбайд нэвтрэх замын нөхцөл байдлыг (боловжит болон хүртээмжтэй байдлыг) хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Гүйцэтгэгч нь аливаа зам эсхүл гүүрийг Гүйцэтгэгчийн зам ашиглалт эсхүл ажиллагсдын нөлөөгөөр эвдрэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд тээврийн хэрэгсэл (хууль дүрэмд заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн даац болон өргөн (хэрвээ байвал), бусад хязгаарлалтууд) болон замын урсгалын зүй зохистой ашиглалт багтана.

Эдгээр нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол:

(a) Гүйцэтгэгч нь (Талууд хоорондоо) Гүйцэтгэгчийн нөлөөтэй үүссэн аливаа замын эвдрэлийг засах болон Гүйцэтгэгчийн ашиглалтын үеийн замын засвар үйлчилгээг хариуцна;

(b) Гүйцэтгэгч нь нэвтрэх зам, ашиглагдах маршрутын дагуух шаардлагатай бүх тэмдэг, тэмдэглэгээг хариуцах бөгөөд Гүйцэтгэгчийн ашиглах зам, тэмдэг, тэмдэглэгээ, чиглэлийн талаарх холбогдох байгууллагаас шаардаж болох аливаа аман болон бичгэн зөвшөөрлүүдийг авах үүрэгтэй;

(c) Гүйцэтгэгчийн ашиглалт болон бусад нэвтрэх замтай холбоотойгоор гаргасан гуравдагч этгээдийн аливаа нэхэмжлэлийг Захиалагч хариуцахгүй;

(d) Захиалагч нь нэвтрэх зам, маршрутын нөхцөл байдлын талаар баталгааг гаргахгүй;

(e) Гүйцэтгэгчийн ашиглах зам, маршрутын нөхцөл байдал хангалтгүй байх эсхүл хангагдаагүйтэй холбоотой бүхий л Зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Нэвтрэх зам, маршрутын хүртээмжгүй байдал эсхүл байхгүйгээс шалтгаалан Инженерийн зүгээс эсхүл гуравдагч этгээдээс зам маршрутад Суурь огнооноос хойш өөрчлөлт оруулсны улмаас Гүйцэтгэгч нь хугацаа хоцролт үүсэх эсхүл Зардал гарсан бол Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу Хугацааг сунгах нэхэмжлэл гаргах болон/эсхүл тухайн Зардлыг төлүүлэх эрхтэй.

4.16 Бараа, материалын тээвэрлэлт

Гүйцэтгэгч нь дараах үүргүүдийг хүлээнэ:

(a) Аливаа үндсэн тоног төхөөрөмж эсхүл бусад барааны үндсэн зүйлсийг (Захиалагчийн шаардлагад заасны дагуу) Ажлын талбайд хүргэгдэх өдрөөс 21-нээс багагүй хоногийн өмнө Инженерт мэдэгдэл хүргүүлнэ;

(b) Ажилд шаардагдах бүх бараа болон бусад зүйлсийг савлаж баглах, ачих, зөөж тээвэрлэх, хүлээн авах, буулгах, хадгалах, арчилж хамгаалах үүрэг хариуцлагыг хүлээнэ;

(c) Бүх барааг импортлох, тээвэрлэхтэй холбоотой бүхий л гаалийн бүрдүүлэлт, зөвшөөрлүүд, татвар хураамж, төлбөр зэргийг хариуцах бөгөөд тэдгээрийг Ажлын талбайд хүргүүлэхтэй холбоотой бүхий л үүрэг хариуцлагыг хүлээнэ;

(d) Бүх барааны импорт, тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотойгоор үүсч болох аливаа хохирол, алдагдал, зардал төлбөр (хууль ёсны төлбөр, зардлыг багтаана) зэрэг эрсдлүүдээс Инженерийг хамгаалах бөгөөд тэдгээрийн импорт, тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотойгоор гуравдагч этгээдээс үүсэх бүхий нэхэмжлэл болон төлбөрийг асуудлаар хэлэлцээр хийх, төлбөрийг барагдуулах үүргийг хүлээнэ.

4.17 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн бүх тоног төхөөрөмжийг бүрэн хариуцна. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжүүд Ажлын талбайд орж ирснээс хойш эдгээр тоног төхөөрөмжийг гагцхүү Ажил гүйцэтгэх зорилгоор ашиглана. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр Ажлын талбайгаас гаргахыг хориглоно. Гэхдээ энэхүү зөвшөөрөл нь Ажлын талбайгаас бараа болон Гүйцэтгэгчийн ажилтнуудыг /ажиллах хүчинийг/ тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд үл хамаарна.

Гэрээний 4.16 [Барааг тээвэрлэх]-д заасны дагуу хүргүүлсэн аливаа мэдэгдлээс гадна Гүйцэтгэгч нь аливаа Гүйцэтгэгчийн үндсэн тоног төхөөрөмжийг ажлын талбайд оруулсан өдрийг мэдээлсэн мэдэгдлийг Инженерт хүргүүлэх үүрэгтэй. Энэхүү мэдэгдлийг Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг ажлын талбайд оруулах хугацаанаас 7 хоногийн дотор хүргүүлэх бөгөөд тоног төхөөрөмжийн өмчлөгч нь Гүйцэтгэгч эсхүл Туслан гүйцэтгэгч эсэх, эсхүл бусад этгээдийн өмчлөлд буй эсэх, түрээслэсэн эсхүл зээлдсэн эсэх, хэрвээ зээлдсэн эсхүл түрээслэсэн бол тухайн түрээслэгч эсхүл зээлдүүлэгч этгээдийн албан ёсны мэдээллийг тусгасан байна.

4.18 Байгаль орчныг хамгаалах

Гүйцэтгэгч нь дараах нөхцөлүүдийг хангахад чиглэгдсэн шаардлагатай бүх арга хэмжээнүүдийг авах үүрэгтэй. Үүнд:

- (а) байгаль орчныг хамгаалах (Ажлын талбайд болон талбайн гадна орчинд);
- (б) Ажил гүйцэтгэхтэй холбоотой аливаа байгаль орчны үнэлгээ болон нөлөөлөх байдлын тайланда тусгасан шаардлагуудыг (хэрвээ байвал) хангах;
- (с) Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа болон/эсхүл ажлаас хамаарал бүхий бохирдол, дуу чимээ болон бусад байдлаар иргэдэд болон эд хөрөнгөд учруулах хохирол, тав тухыг алдуулах үр дагавар, хохирлыг хязгаарлах.

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүсч болох хаягдал бохирдол, гадаргууд хаягдах хаягдлууд, бохир ус, бусад хорт бодис нь Захиалагчийн шаардлагад болон холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээ, утгаас хэтрэхгүй байх байх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4.19 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай түр хангарт

Гүйцэтгэгч нь дор дурдсанаас бусад тохиолдолд Гүйцэтгэгчид ажлыг гүйцэтгэхэд шаардагдах цахилгаан, хий, харилцаа холбоо, усан хангамж зэрэг түр хэрэглэгдэхүүнүүд болон бусад холбогдох ажил үйлчилгээг хариуцна.

Энэ хэсгийн бусад заалтууд нь хэрвээ Захиалагчийн шаардлагад “Захиалагч нь Гүйцэтгэгчийн ашиглах хэрэглэгдэхүүн хариуцна” гэж заасан тохиолдолд гагцхүү хүчин төгөлдөр үйлчилнэ. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлтод дэлгэрэнгүй мэдээлэл ба тусгагдсан үнэ нь Ажлын талбайн Түр хэрэглэгдэхүүнүүд Ажил гүйцэтгэх зорилгоор ашиглах эрхтэй. тэдгээр ажил үйлчилгээг явуулахад Гүйцэтгэгчид шаардагдах аливаа аппарат, багаж хэрэгслээр хангах болон ашиглалтын тоо хэмжээг гаргах ажлын эрсдэл болон зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Гүйцэтгэгч нь ашиглалтын тоо хэмжээг гаргах/тооцоолох аппарат/багаж хэрэгсэлд Инженерийн зөвшөөрлийг авна. Гэрээний мэдээлэлд тусгагдсан (хэрвээ тусгаагүй бол сар бүр) төлбөрийн хуваарь тус бүр дэх ашиглалтын тоо хэмжээг (хэрвээ байвал) Гүйцэтгэгч тооцоолох бөгөөд уг тоо хэмжээнд хамаарах Гүйцэтгэгчийн төлөх үнийн дүнг холбогдох мэдэгдэлд тусгасан байх ёстай.

4.20 Ажлын явцын тайлан

Гүйцэтгэгч нь Сар тутмын явцын тайланг Захиалагчийн шаардлагад заасан маягтын (хэрвээ маягт байхгүй бол Инженерээс хүлээн зөвшөөрсөн маягтын) дагуу гүйцэтгэж Инженерт хүргүүлнэ. Сар тутмын явцын тайлан бүрийг цаасан хэвлэмэл 1 эх хувь, цахимаар 1 хувь болон Гэрээний мэдээлэлд заасны дагуу нэмэлт хэвлэмэл хувийг (хэрвээ байвал) хүргүүлнэ. Анхны тайлангийн хугацаа нь Ажил эхлэх огнооноос хойш нэг сарын хугацааг бүтэн хамрана. Үүний дараа сар бүрийн явцын тайланг сар бүрийн сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор хүргүүлж тайлاغнах үүрэгтэй.

Явцын тайланг ажил дуусах огноог хүртэл эсхүл хэрвээ ажил хүлээн авсан гэрчилгээнд дутуу ажил бүртгэгдсэн байвал тэдгээр ажлыг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд үргэлжлүүлэх ёстай. Захиалагчийн шаардлагад өөрөөр дурдаагүй бол Явцын тайлан бүрт дараах зүйлсийг багтаасан байх ёстай. Үнд:

- (а) Гүйцэтгэгчийн баримт бичгүүд (Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн зураг төсөл байвал түүнийг багтаана), худалдан авалт/ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, ажлын талбайд хүргэлт, барилга угсралт, угсралтын ажлууд, тест/туршилт зэргийн үе шат бүрийг багтаасан явцын график, диаграмм, дэлгэрэнгүй мэдээллүүд;
- (б) Ажлын талбайд болон талбайн бус байршилд гүйцэтгэсэн үйлдвэрлэл болон ажлын явц, төлөв байдлыг харуулсан гэрэл зурагнууд болон/эсхүл видео бичлэгүүд

(c) Үндсэн тоног төхөөрөмж болон материалын үндсэн зүйл тус бүрийн үйлдвэрлэлийн мэдээлэл буюу үйлдвэрийн байршил, явцын хувь болон дараах хугацаануудын бодит болон төлөвлөсөн хугацаанууд:

- (i) Үйлдвэрлэж эхлэх хугацаа
- (ii) Гүйцэтгэгчийн хяналт шалгалтын хугацаа
- (iii) Тест/туршилтын хугацаа
- (iv) Тээврлэлтийн болон Ажлын талбайд ирүүлэх хугацаа

(d) 6.10 [Гүйцэтгэгчийн бүртгэл, тайлан]-т заасан дэлгэрэнгүй мэдээллүүд

(e) Чанартай холбоотой баримт бичгүүдийн хуулбар, хяналт, шалгалтын тайлангууд, туршилтын үр дүнгүүд, тохирлын гэрчилгээ болон бусад баталгаажилтын баримт бичгүүд (материалын гэрчилгээнүүд багтана);

(f) Гэрээний өөрчлөлтүүдийн жагсаалт болон 20.2.1 [Нэхэмжлэлийн мэдэгдэл]-т заасны дагуу хүргүүлсэн аливаа мэдэгдлүүд (Тал тус бүрээс хүргүүлсэн);

(g) Эрүүл ахуй болон аюулгүй ажиллагаатай холбоотой тоон мэдээллүүд, үүнд хүрээлэн буй байгаль орчин болон олон нийтийн харилцаатай холбоотой гарсан аливаа аюултай осол ба авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл багтана.

(h) Явцын бодит гүйцэтгэл болон төлөвлөлтийн харьцуулалт, үүнд Ажлын график болон Ажил дуусах хугацааны дагуу Ажлыг гүйцэтгэж дуусахад сөргөөр нөлөөлж болохуйц аливаа үйл явдал эсхүл нөхцөл байдлыг дэлгэрэнгүйгээр тусгах ба хугацаа хоцролтыг шийдвэрлэхээр авч хэрэгжүүлсэн (эсхүл авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн) арга хэмжээнүүдийг мөн адил тусгана.

Гэхдээ, явцын тайланд тусгасан аливаа мэдээллийг нь эдгээр нөхцөлүүдийн хэсэгт дурдсан мэдэгдэл гэж үзэхгүй.

4.21 Ажлын талбайн хамгаалалт

Гүйцэтгэгч нь Ажлын талбайн хамгаалалтыг хариуцах бөгөөд дараах үүргүүдийг хүлээнэ:

(a) Ажлын талбайд хөндлөнгийн хүнийг оруулахгүй байх

(b) Ажлын талбайд нэвтрэх, ажиллах хүний бүрэлдэхүүн нь Гүйцэтгэгчийн ажилтнууд, Захиалагчийн ажилтнууд болон Гүйцэтгэгчид Захиалагч эсхүл Инженерээс Мэдэгдэл болгон хүргүүлэн эрх олгосон бусад ажилтнуудаар (Ажлын талбайд ажиллах Захиалагчийн бусад туслан гүйцэтгэгчид) хязгаарлагдана.

4.22 Гүйцэтгэгчийн ажлын талбай дахь үйл ажиллагаа

Гүйцэтгэгч нь үйл ажиллагаагаа гагцхүү Ажлын талбайн дотор явуулах үүрэгтэй бөгөөд хэрвээ Гүйцэтгэгчийн зүгээс нэмэлт талбай шаардагдах бол Инженерийн зүгээс тухайн нэмэлт талбайг ажлын талбай гэж зөвшөөрч батласан байх шаардлагатай. Гүйцэтгэгч нь Ажлын талбайн дотор болон нэмэлт талбайд Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж байршуулах болон Гүйцэтгэгчийн ажилтнууд үйл ажиллагааг явуулах, тэдгээрийг талбайн хязгаарыг давахгүй байх зэрэг тал дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Гүйцэтгэгч нь бүхий л хугацаанд Ажлын талбайг аливаа шаардлагагүй эд зүйлс, материалын ангид байлгах ба аливаа Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг болон илүүдэл материалыг Ажлын талбайд зүй ёсоор хадгалах эсхүл талбайг

чөлөөлөх үүргийг хүлээнэ. Мөн Гүйцэтгэгч нь цаашид шаардлагагүй Түр ажил болон аливаа эвдэрч хаягдсан эд зүйлс, аюултай бодис, хог хаяглуудыг талбайгаас чөлөөлж цэвэрлэх үүрэгтэй.

Ажил хүлээн авсан гэрчилгээ олгогдсоны дараа Гүйцэтгэгч нь нэн даруй Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжүүд, илүүдэл материал, эвдэрч хаягдсан эд зүйлс, аюултай бодис, хог хаяглууд, Түр ажил болон Ажил хүлээн авсан гэрчилгээнд дурдагдсан Ажил болон Ажлын талбайн хэсгийг чөлөөлж цэвэрлэнэ. Гүйцэтгэгч нь Ажлын талбайн болон Ажлын бүрдэл хэсгийг чөлөөлж цэвэр, аюулгүй нөхцөл байдлыг ханган хүлээлгэн өгнө.

Гэхдээ Гүйцэтгэгч нь Инженертэй харилцан зөвшилцсөний дагуу Ажлын талбайн хэсгийг Гэрээний үүргээ бүрэн биелүүлэх үүднээс Гүйцэтгэгчид ашиглагдах барааг байршуулах зориулалтаар барилгын чанарын баталгаат хугацаа (ДМХ)-нд өөртөө хадгалж болно.

4.23 Археологийн болон Геологийн олдворууд

Ажлын талбайд олдсон аливаа олдворууд, зоос, үнэт болон эртний эд зүйлс, археологийн болон геологийн байгууламж, бүтээц, бусад эд зүйлсийг Захиалагчийн эрх мэдэл болон хадгалалт, хамгаалалтад шилжүүлж байршуулна. Эдгээр олдворуудаас аливаа эд зүйлсийг Гүйцэтгэгчийн ажилтнууд болон бусад хүн гэмтээх эсхүл авч явахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохимжтой бүхий л арга хэмжэээг Гүйцэтгэгч авна.

Аливаа олдвор, эд зүйлс олдсон даруй Гүйцэтгэгч нь аль болох богино хугацаанд тэдгээр олдвор эд зүйлсийг хурдан хугацаанд шалгах болон/эсхүл судлах боломжийг олгосон мэдэгдлийг Инженерт хүргүүлнэ. Энэхүү Гүйцэтгэгчийн мэдэгдэл нь олдворын тухай тодорхойлолт мэдээллийг агуулах бөгөөд Инженерийн зүгээс тэрхүү олдвортой хэрхэн харьцаж хандах талаар даалгавар, зааварчилгааг хүргүүлэх ёстой.

Хэрвээ Гүйцэтгэгч нь Инженерийн даалгавар, зааварчилгааг дагаж биелүүлээгүйн улмаас Зардал гарсан эсхүл хугацааны хоцролт үүссэн бол гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу Гүйцэтгэгч нь тухайн зардлыг барагдуулах эсхүл ХС нэхэмжлэл гаргах үүрэгтэй.

5. Туслан гүйцэтгэх гэрээ

5.1 Туслан гүйцэтгэгч

Гүйцэтгэгч дараах тохиолдолд Туслан гүйцэтгэгч авах боломжгүй:

(a) Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа ажлын нэмж нэгтгэсэн дүн нь гэрээний үнэ хэсгийн Гэрээний мэдээлэлд заагдсан (хэрэв заагаагүй бол бүх ажлын хувьд) хувиас их байгаа бол;

(b) Гэрээний мэдээлэлд заасан Туслан гүйцэтгэгч авахыг зөвшөөрөөгүй аливаа ажилд;

Гүйцэтгэгч нь Туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн бүхий л ажлын хариуцлагыг хүлээж, Туслан гүйцэтгэгчдийг удирдан зохион байгуулах, зохицуулах ба Туслан гүйцэтгэгч болон түүний төлөөлөгч эсхүл ажилчдын үйлдэл эсхүл буруутай үйл ажиллагааны хариуцлагыг өөрийн буруутай үйлдэл хэмээн үзэж хариуцлага хүлээнэ.

Гүйцэтгэгч нь доор дурдсанаас бусад, санал болгож буй бүх Туслан гүйцэтгэгчдэд Инженерийн урьдчилсан зөвшөөрлийг авна:

1. Материал нийлүүлэгчид; эсхүл

2. Гэрээнд заагдсан Туслан Гүйцэтгэгчийн гэрээ.

Гүйцэтгэгч нь Туслан гүйцэтгэгч санал болгож байгаа тохиолдолд Инженерийн зөвшөөрлийг авах шаардлагатай ба Туслан гүйцэтгэгчийн нэр, хаяг, дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох туршлага, туслан гүйцэтгэх гэрээ байгуулахаар төлөвлөж буй ажлын талаар болон Инженерээс зохих ёсоор шаардаж болох нэмэлт мэдээллүүдийг Инженерт хүргүүлнэ. Хэрэв Инженер нь үүнийг (эсхүл нэмэлт мэдээлэл өгөхийг хүссэн бол түүнийг) хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор санал болгож буй Туслан гүйцэтгэгчээс татгалзсан тухай мэдэгдэл илгээгээгүй, хариу өгөөгүй тохиолдолд Инженерийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Гүйцэтгэгч нь сонгогдсон Туслан гүйцэтгэгч тус бүрийн ажил эхлэхээр төлөвлөгджэх буй өдрөөс болон ажлын талбай дээр ажил эхлэх огнооноос 28 хоногийн өмнө Инженерт мэдэгдэл хүргүүлнэ.

5.2 Нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгч

5.2.1 “Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч” -ийн тодорхойлолт

Энэхүү гэрээнд заасан “Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч” гэдэг нь Захиалагчийн шаардлагад ийнхүү нэр заагдсан Туслан гүйцэтгэгч, эсхүл гэрээний 13.4 [Нөөц хөрөнгө]-д заасны дагуу Инженерээс Туслан гүйцэтгэгчээр ажиллуулахаар Гүйцэтгэгчид зааварчилсан этгээдийг хэлнэ.

5.2.2 Нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгчээс татгалзах

Гүйцэтгэгч нь үндэслэл бүхий татгалзал байвал Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгчийн талаарх холбогдох үндэслэл бүхий дэлгэрэнгүй тайлбар мэдэгдлийг Инженерт түүний зааврыг хүлээн авснаас хойш 14-өөс илүүгүй хоногийн дотор илгээнээр тухайн нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгчийг ажилд авах үүрэг хүлээхгүй. Дараах асуудлуудын аль нэгнээс (бусад асуудлуудын хамтаар) үүдэлтэй бөгөөд Захиалагч нь үүнээс үүссэн үр дагавраас Гүйцэтгэгчийг ангид байлгах үүрэг хүлээнээс бусад тохиолдолд татгалзлыг үндэслэлтэй хэмээн үзнэ.

(а) Туслан гүйцэтгэгчийн мэргэжлийн ур чадвар, хөрөнгийн эх үүсвэр болон санхүүгийн чадавх хангалтгүй гэж үзэх шалтгаан байсан

(б) нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгч, мөн түүний төлөөлөгч болон ажиллагсад нь Бараа, материалыг зориулалтын бусаар ашиглах буюу тэдгээрт хайнга, тоомжиргүй хандах явдлаас Гүйцэтгэгчийг ангид байлгах талаар туслан гүйцэтгэх гэрээнд заагаагүй байсан; эсхүл

(с) Туслан гүйцэтгэх гэрээндээ гэрээний дагуу ажил (хэрэв зураг төслийн ажил байгаа бол түүнийг багтаан) гүйцэтгэх зорилгоор Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч нь дараах нөхцөлийг тусгаагүй тохиолдолд:

(1) Гүйцэтгэгчийг түүний Гэрээний дагуу хүлээсэнтэй ижил үүрэг, хариуцлагаас чөлөөлөх хэмжээний хэмжээний тийм үүрэг, хариуцлагыг Гүйцэтгэгчийн өмнө хүлээхийг, ба

(2) Гүйцэтгэгчийг Гэрээнд заасан эсхүл түүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үүрэг хариуцлагаас болон эдгээр үүрэг хариуцлагыг Туслан гүйцэтгэгч биелүүлээгүйн улмаас үүсэх аливаа үр дагавраас ангид байлгах үүрэгтэй.

5.2.3 Нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгчид төлөх төлбөр

Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэх гэрээний дагуу төлөгдвэл зохих мөнгөн дүнг Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгчид төлнө. Гэрээний 5.2.4 [Төлбөр төлснийг нотлох баримт]-д зааснаас бусад тохиолдолд, энэхүү дүн болон үүн дээр нэмэгдсэн

бусад төлбөрийг Гэрээний 13.4 [Нөөц хөрөнгө]-ийн (b)-д заасны дагуу Гэрээний үнэд багтсан байх ёстой.

5.2.4 Төлбөр төлснийг нотлох баримт

Инженер нь нэр дэвшиүүлсэн Туслан гүйцэтгэгчид төлбөл зохих дүнг тусгасан Төлбөрийн гэрчилгээг олгохоос өмнө, түрүүчийн Төлбөрийн гэрчилгээний дагуу авбал зохих, суутган барих мөнгөний дүнгээр, эсхүл өөр байдлаар хийгдсэн суутгалыг хассан бүх дүнг Нэр дэвшиүүлсэн Туслан гүйцэтгэгч хүлээн авсан тухай зохих нотлох баримтыг ирүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардаж болно. Хэрэв Гүйцэтгэгч нь:

- (a) Энэхүү зохих ёсны нотлох баримтыг Инженерт хүргүүлээгүй, эсхүл
- (b) (1) эдгээр дүнг төлөхгүй байх, эсхүл төлөхөөс татгалзах зохих ёсны эрхтэй гэж Инженерт бичгээр мэдэгдээгүй, ба

(2) Гүйцэтгэгчийн энэхүү эрхийн талаар Нэр дэвшиүүлсэн Туслан гүйцэтгэгчид мэдэгдсэн тухай зохих нотлох баримтыг Инженерт өгөөгүй бол, томилогдсон Туслан гүйцэтгэгчид төлөгдөхөөр урьд нь баталгаажсан бөгөөд дээр дурдсан (a) ба (b) заалтад дурдсан нотлох баримтыг Гүйцэтгэгч танилцуулаагүй бүх дүнг, эсхүл (зохих суутгалыг хассан) түүний хэсгийг Захиалагч (дан ганц өөрийн үзэмжээрээ) Нэр дэвшиүүлсэн Туслан гүйцэтгэгчид шууд төлж болно.

Үүний дараа Нэр дэвшиүүлсэн Туслан гүйцэтгэгчид Захиалагчаас шууд төлсөн дүнг тусгасан мэдэгдлийг Инженер Гүйцэтгэгчид өгөх ба энэхүү дүнг тухайн мэдэгдлийн дараах явц дундын төлбөрийн гэрчилгээнд гэрээний 14.6.1 [Явц дундын төлбөрийн гэрчилгээ]-ийн (b) дэд заалтын дагуу суутгал хэлбэрээр оруулна.

6. Ажилтнууд

6.1 Ажилтнуудыг зохион байгуулах

Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч өөрийн бүх ажилтнууд, тэдгээрийн цалин хөлс, хоол хүнс, унаа тээвэр болон байрлах байр, нийгмийн халамжийн асуудлуудыг хариуцаж, зохион байгуулж ажиллана.

6.2 Цалингийн үнэлгээ ба хөдөлмөрийн нөхцөл

Гүйцэтгэгч нь ажил явагдаж буй газарт, мөрдөж буй бүх хуульд нийцсэн бөгөөд тухайн төрлийн ажилд буюу салбарт тогтоосноос доошгүй цалин хөлсийг төлөх ба хөдөлмөрийн орчин нөхцөлийг хангаж мөрдөнө.

Хэрэв хэрэглэж болохоор цалингийн хэмжээ болон орчин нөхцөл тогтоогдоогүй бол, Гүйцэтгэгч нь ижил төстэй үйл ажиллагаатай ажил олгогчдын тогтоон мөрдөж буй цалингийн хэмжээ болон хөдөлмөрийн нөхцөлийн тухайн орон нутгийн дундаж түвшингээс доошгүй ажлын хөлсийг төлөх ба хөдөлмөрийн нөхцөлийг хангана.

6.3 Ажилтан урвуулан авах

Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилтнууд дундаас албан хаагчид болон ажилчдыг шинээр ажилд авах буюу авахыг оролдохгүй.

Захиалагч болон Инженерийн аль ч Гүйцэтгэгчийн ажилтнууд дундаас албан хаагчид болон ажилчдыг ажилд авах буюу авахыг оролдохгүй.

6.4 Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж

Гүйцэтгэгч нь түүний ажилчдын ажил эрхлэлтийн (цалин хөлс ба ажлын цагийг оролцуулсан), эрүүл мэндийн, аюулгүй байдлын, нийгмийн хамгааллын,

цагаачлалын ба гадаад руу цагаачлах тухай хууль зэргийг хамруулсан, Гүйцэтгэгчийн ажилчдад хамааралтай, хөдөлмөрийн холбогдох бүх хуулийг дагаж мөрдөх ба тэднийг хууль ёсны бүх эрхээ эдлэх боломжоор хангана.

Гүйцэтгэгч нь ажлын байранд дахь аюулгүй байдалтай холбоотой хуулийг багтаан холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөхийг өөрийн нийт ажилчдаас шаардах ёстай.

6.5 Ажлын цаг

Дор дурдсанаас бусад тохиолдолд, Гэрээний мэдээлэлд заасан, орон нутгийн хэмжээнд зөвшөөрөгдсөн амралтын өдрүүдэд, эсхүл ажлын өдрийн хэвийн цагаас гадуур ажлын Талбай дээр ажил гүйцэтгэхийг хориглоно:

- (a) Гэрээнд өөрөөр заасан;
- (b) Инженер зөвшөөрөл өгсөн; эсхүл
- (c) амь нас, эд хөрөнгийг хамгаалахад, эсхүл ажлын аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд ажлыг хийхээс өөргүй болсон, эсхүл хийх шаардлагатай болсон тохиолдолд Гүйцэтгэгч нь хийх шаардлагатай ажлыг болон түүний шалтгааныг тодорхой дурдсан мэдэгдлийг Инженерт яаралтай өгнө.

6.6 Ажилтнуудад зориулсан байр

Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь өөрийн ажилчдад зориулан шаардлагатай бүх байр, сууц, ахуйн хангамжийн барилга байгууламжаар хангах ба тэдгээрийг засварлаж арчилна.

Хэрэв эдгээр байр, сууц ба барилга байгууламж нь Захиалагчаас Гүйцэтгэгчид урьдчилан өгсөн зөвшөөрөлтэйгээс бусад тохиолдолд ажлын талбай дээр байрлах бол, тэдгээр нь гэрээнд заасан талбайн дотор байршина. Хэрэв эдгээр байр, сууц ба барилга байгууламж нь ажлын талбайн бусад хэсэгт баригдсан байвал Гүйцэтгэгч тэдгээрийг өөрийн зардлаар нэн даруй зайлзуулах ба эрсдлийг өөрөө хариуцна. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилчдыг Захиалагчийн шаардлагад заасны дагуу байр, сууцаар мөн хангана.

6.7 Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Гүйцэтгэгч нь Гэрээний 4.8 [Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг]-д заасан шаардлагууд дээр нэмээд, өөрийн ажилчдын эрүүл мэндийг хамгаалах ба аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх бүх шаардлагатай арга хэмжээг цаг ямагт авна. Гүйцэтгэгч нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран:

(a) бүх хугацааны туршид Ажлын талбай дээр, мөн Гүйцэтгэгчийн болон Захиалагчийн ажилчдад зориулсан байранд, Захиалагчийн шаардлагад заасны дагуу эмнэлгийн ажилтныг ажиллуулах, анхны тусlamжийн хэрэгслүүдийг бэлэн байлгах, эмнэлгийн булан байгуулах, түргэн тусlamжийн болон эмнэлгийн аливаа бусад үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрүүлэх; ба

(b) шаардлагатай ахуйн нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг мөрдүүлэх болон тахал, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохион байгуулалтын тохиромжтой бүх арга хэмжээг авсан байна.

Гүйцэтгэгч нь осол аваараас урьдчилан сэргийлэх, мөн эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрмийг сахиулах ажлыг хариуцан ажиллах эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны албан тушаалтныг Ажлын талбай дээр томилсон байна. Тухайн ажилтан нь:

(1) энэ чиглэлээр мэргэшсэн, туршлагатай бөгөөд энэхүү үүргийг биелүүлэх чадвартай байх; ба

(2) Ажлын талбайд нэвтрэх эрх бүхий ба/эсхүл тэнд ажиллаж байгаа бүх хүний эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хангах болон осол аваараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар удирдамж, зааварчилгаа өгөх эрхтэй байна.

Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэх нийт хугацааны туршид энэхүү ажилтанд, хариуцсан үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай бүх зүйл болон эрх мэдлээр хангах үүрэгтэй.

6.8 Гүйцэтгэгчийн удирдлага, хяналт

Эхлэх өдрөөс Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл Гүйцэтгэгч нь ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах, удирдах, чиглүүлэх, үзэж шалгах, турших ба хянах шаардлагатай бүх удирдлагаар хангана.

Удирдлага хяналт нь хангалттай тооны хүнээс бүрдсэн байна:

(а) харилцаж буй хэлээр чөлөөтэй ярьж, бичдэг, эсхүл тухайн хэлний зохих мэдлэгтэй (Гэрээний 1.4 [Хууль ба Хэл]-т заасан); ба

(б) Ажлыг аюулгүй бөгөөд чанартай гүйцэтгэхэд хийгдэх бүх төрлийн ажлын (тулгарч болзошгүй эрсдэлийн шаардлагатай арга техник, түүнчлэн осол аваараас урьдчилан сэргийлэх аргыг хамруулсан)

6.9 Гүйцэтгэгчийн ажилтнууд

Гүйцэтгэгчийн ажилчид нь (хэрэв байгаа бол Голлох ажилтнуудыг оролцуулан) тус тусын эрхэлсэн ажил, эсхүл мэргэжлээрээ зохих хэмжээнд мэргэшсэн, ур чадвартай ба туршлагажсан хүмүүс байна.

Инженер нь, Ажилд буюу ажлын талбай дээр ажиллуулж буй, (хэрэв байгаа бол), Гүйцэтгэгчийн төлөөлөгч болон Голлох мэргэжилтнүүдийг оролцуулан, доорх дутагдал гаргасан аливаа хүнийг халахыг (эсхүл халах нөхцөлийг хангахыг) Гүйцэтгэгчээс шаардаж болно:

- (а) сахилга батыг байнга зөрчдөг, анхаарал хянамж муутай;
- (б) албан үүргээ гүйцэтгэхдээ чадвар муутай, хайхрамжгүй ханддаг;
- (с) Гэрээний аливаа заалтыг мөрддөггүй;
- (д) аюулгүй байдал, эрүүл мэнд, эсхүл байгаль орчныг хамгаалахад сөргөөр нөлөөлөх аливаа үйлдлийг байнга хийдэг;
- (е) зохих нотлох баримтын үндсэн дээр авлига, залilan, үгсэн хуйвалдсан, эсхүл хүч хэрэглэсэн үйл явдалд оролцсон нь илэрхий болсон; эсхүл
- (f) Гэрээний 6.3 [Хүмүүсийг элсүүлэх]-ыг зөрчин Захиалагчийн ажилтнуудаас ажилд авсан.

Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгч нь солиход тохиromжтой орны хүнийг томилно (эсхүл томилох нөхцөлийг хангана). Гүйцэтгэгчийн Төлөөлөгчийг солих тохиолдолд, Гэрээний 4.3 [Гүйцэтгэгчийн Төлөөлөгч]-ыг хэрэглэнэ. Тэргүүлэх мэргэжилтнүүдийг (хэрэв байгаа бол) солих тохиолдолд, Гэрээний 6.12 [Тэргүүлэх мэргэжилтнүүд]-ыг хэрэглэнэ.

6.10 Гүйцэтгэгчийн бүртгэл

Гүйцэтгэгч санал болгож, Инженер зөвшөөрснөөс бусад тохиолдолд, Гүйцэтгэгч нь Гэрээний 4.20 [Ажлын явцын тайлан]-д заасны дагуу гаргах сар

тутмын явцын тайландаа дор дурдсан зүйлсийн бүртгэлийг, Ажлын хөтөлбөрт заасан ажил тус бүр дээр, ажил явагдаж байгаа байршил тус бүр дээр, мөн ажлын өдөр тус бүрээр гаргаж тусгана:

- (а) Гүйцэтгэгчийн ажилчдын ажилласан бодит цаг;
- (б) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн нэр төрөл тус бүрийн ба тэдгээрийн ажилласан бодит цаг;
- (с) ашиглаж буй Түр ажлын нэр төрөл;
- (д) Байнгын ажилд зориулан суурилуулсан Үндсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл; ба
- (е) Хэрэглэсэн Материалын нэр төрлийн ба тэдгээрийн тоо хэмжээ.

6.11 Хэв журмыг зөрчих

Гүйцэтгэгчийн ажилчдын зүгээс болон тэдний дунд хууль бус, үймж танхайрсан үйлдэл гаргах буюу нийгмийн хэв журам зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг Гүйцэтгэгч бүх хугацааны туршид авч хэрэгжүүлэх ба Ажлын талбай дээр болон түүний ойролцоо байгаа хүмүүсийн амар тайван байдал болон өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаална.

6.12 Голлох ажилтнууд

Хэрэв Захиалагчийн шаардлагад Голлох ажилтнуудын талаар тусгаагүй бол энэхүү хэсгийг хэрэглэхгүй.

Гүйцэтгэгч нь тендерт голлох ажилтны албан тушаалд нэр заагдсан хүмүүсийг томилох ёстай. Хэрэв тэгж нэр заагдаагүй, эсхүл томилогдсон хүн нь холбогдох Голлох ажилтны албан тушаалд ажиллаж чадахгүй байгаа бол Гүйцэтгэгч нь түүний оронд энэхүү албан тушаалд томилохоор төлөвлөж буй өөр хүний нэр ба дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрөл авахаар Инженерт хүргүүлнэ. Хэрэв зөвшөөрөл өгөхөөс татгалзсан, эсхүл зөвшөөрлөө дараа нь хүчингүй болгосон бол, Гүйцэтгэгч нь энэхүү албан тушаалд оронд нь ажиллах тохиромжтой хүний нэр ба дэлгэрэнгүй мэдээллийг мөн адилаар хүргүүлнэ.

Хэрэв Инженер нь аливаа ийм мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, энэхүү албан тушаалд тухайн хүнийг томилохоос (эсхүл оронд нь сольж ажиллуулахаас) татгалзсан тухайгаа дурдсан мэдэгдэл илгээн хариу өгөөгүй бол, Инженерийг зөвшөөрлөө өгсөн гэж үзнэ.

Гүйцэтгэгч нь Инженерийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аливаа Голлох ажилтны томилгоог хүчингүй болгохгүй, мөн түүнийг өөр хүнээр солихгүй (хэрэв тухайн хүн нас барах, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, эсхүл огцрох зэргээс шалтгаалан үүргээ биелүүлэх чадамжгүй болсон бол, энэ тохиолдолд түүний томилгоог шууд хүчингүй болсонд тооцох ба оронд нь хийх томилгоог Инженерээс зөвшөөрөл өгөх хүртэл, эсхүл энэхүү Гэрээний дагуу орны өөр хүнийг томилох хүртэл түр томилгоо гэж үзнэ).

Ажил хийгдэх нийт хугацааны туршид бүх голлох ажилтнууд нь талбайд (эсхүл, ажлууд талбайн гадна хийгдэж байвал тухайн ажлын байршилд) суурин байрлаж ажиллана. Хэрэв Ажлыг гүйцэтгэх явцад аль нэг голлох ажилтан түр хугацаагаар явах бол, тохирох хүнийг түүний оронд Инженерийн урьдчилсан зөвшөөрөлтэйгөөр түр томилно.

Бүх Голлох ажилтнууд нь гэрээний 1.4 [Хууль ба Хэл]-т заасан харилцааны хэлээр чөлөөтэй ярьж, бичдэг байна.

7. Бараа материал, тоног төхөөрөмж болон гүйцэтгэлийн чанар

7.1 Ажил гүйцэтгэх арга хэлбэр

Гүйцэтгэгч нь үйлдвэрлэл, нийлүүлэлт, угсралт, туршилт болон ашиглалтанд өгөх үедээ мөн/эсхүл Үндсэн тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, нийлүүлэлт, материалын туршилт болон бусад бүх үйл ажиллагааг өөрчилж засварлах явцдаа:

a) Гэрээний иж бүрдэлд заасан арга барилаар (хэрэв байвал)

b) Хүлээн зөвшөөрөгдсөн бодит туршлагад үндэслэн үнэн зөв, хянамгай байдлаар

c) Гэрээний иж бүрдэлд өөрөөр заагаагүй бол шаардлага хангахуйц байдлаар тоноглогдсон барилга байгууламж, хоргүй бараа материалыг ашиглан гүйцэтгэх ёстой.

7.2 Загвар, дээж

Гүйцэтгэгч нь аливаа материалыг ажилд ашиглахын өмнө дор дурдсан материалын дээж түүнтэй хамааралтай мэдээллийг Инженер рүү зөвшөөрөл авах зорилгоор илгээх ёстой. Үүнд:

a) Гүйцэтгэгчийн зардлаар үйлдвэрлэгчийн жишиг материалын дээж болон гэрээний иж бүрдэлд заасан загвар дээжийг

b) Нэмэлт зардлаар авах Инженерийн шаардсан нэмэлт загвар дээжийг

Загвар дээж бүр нь гарал үүслийн хаяг тэмдэглэгээтэй байх бөгөөд ажилд ашиглахаас зориулагдсан байна.

7.3 Үзлэг, шалгалт

Захиалагчийн ажилтан нь Гэрээний мэдээлэлд заасан ажлын ердийн цагийн хуваарийн ажлын үеэр болон бусад тогтоосон цаг хугацааны үед:

a) Ажлын талбайн бүх хэсэгт болон мөн байгалийн гаралтай материалыг олборлож буй хэсэгт нэвтрэх эрхтэй.

b) бэлтгэл, үйлдвэрлэл болон барилга угсралтын (ажлын талбайд болон бусад газруудад) ажлын үед:

i. Материал, Үндсэн тоног төхөөрөмж, ажлын гүйцэтгэлийг шалгах, хянах, хэмжилт хийх болон турших (Захиалагчийн шаардлагад заасны дагуу)


ii. Үндсэн тоног төхөөрөмж болон Материал, Үндсэн тоног төхөөрөмжийн ажлын явцыг шалгах, үзлэг хэмжилт хийх,

iii. Бүртгэл, тайланг бэлтгэх боловсруулах (зураг авах болон/эсхүл бичлэг хийх зэрэг багтана).

c) Гэрээний нөхцөл болон Захиалагчийн шаардлагад заасны дагуу бусад ажил болон шалгалтуудыг хийж гүйцэтгэх үед.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажиллагсдад ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

Гүйцэтгэгч нь аливаа материал, үндсэн тоног төхөөрөмж эсхүл тухайн ажлыг шалгуулахад бэлэн болсон тухай Мэдэгдлийг тэдгээрийг далдлагдах, ил харагдахгүй болох эсхүл хадгалалт тээвэрлэлтэд зориулж боож багцлахаас нь өмнө Инженерт хүргүүлнэ. Үүний дараа Захиалагчийн төлөөлөгч хяналт, шалгалт, хэмжилт мөн туршилтыг шалтгаангүй хоцроохгүйгээр хийж гүйцэтгэнэ эсхүл Захиалагчийн төлөөлөгчийг тухайн шалгалтыг хийх шаардлагагүй болох



Мэдэгдлийг Инженерээс Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Хэрэв Инженер энэхүү мэдэгдлийг хүргүүлээгүй болон/эсхүл Захиалагчийн төлөөлөгч Гүйцэтгэгчийн мэдэгдэл заасан хугацаанд ирж оролцоогүй тохиолдолд (эсхүл энэхүү хугацааг Гүйцэтгэгчтэй харилцан тохиролцож болно) Гүйцэтгэгч нь ажлаа үргэлжлүүлж далдлах, ил харагдахгүй болгох эсхүл хадгалалт тээвэрлэлтэд зориулж боож багцлах ажлыг гүйцэтгэх эрхтэй.

Хэрвээ Гүйцэтгэгч нь энэхүү хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол Инженер тухайн хийгдээгүй ажлыг тогтоон засч запруулах, сайжруулан дуусгах ажлыг хийлгэх шаардлагатай үед хийлгэх/хийх бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь зардал болон эрсдлийг бүрэн хариуцна.

7.4 Гүйцэтгэгчийн хийх туршилт

Энэхүү хэсэг нь Гэрээнд тусгагдсан бүх туршилт шинжилгээний ажил мөн Ажил дууссаны дараах (хэрэв байвал) туршилтад ашиглагдана.

Гүйцэтгэгч нь шаардлагатай туршилт, шинжилгээний ажлыг үр дүнтэй, үнэн зөв хийж гүйцэтгэхийн тулд бүх аппарат хэрэгсэл, туслалцаа, баримт бичгүүд, бусад мэдээллүүд, түр цахилгаан болон усны хангамж, тоног төхөөрөмж, түлш, дагалдах жижиг материалыуд, багаж хэрэгсэл, хүн хүч, материал, болон мэргэшсэн дадлага туршилгатай, чадварлаг ажилчдаар хангах ёстой. Бүх аппарат хэрэгсэл, тоног төхөөрөмж болон багаж хэрэгслүүд нь Захиалагчийн шаардлагад заасан стандартын дагуу туршигдаж баталгаажсан эсхүл хүчин төгөлдөр хууль дүрэмд заагдсан байх ёстой бөгөөд хэрэв Инженер хүсэлт гаргавал Гүйцэтгэгч багаж туршиж баталгаажуулсан гэрчилгээг туршилтын шинжилгээний ажил эхлэхийн өмнө илгээх ёстой.

Гүйцэтгэгч нь үндсэн тоног төхөөрөмж, материал болон тухайн ажлын туршилт шинжилгээг хийхдээ Инженерт албан бичгээр хугацаа болон байршлыг нь тусгаж мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү мэдэгдэл нь Захиалагчийн төлөөлөгчийг туршилтын ажилд оролцох боломжит байршилд хийгдэхийг бодолцох бөгөөд хугацааны хувьд тохиромжтой байх ёстой.

Инженер нь 13 [Гэрээний өөрчлөлт болон тохируулга] зүйлийн дагуу хийгдэх шаардлагатай туршилт шинжилгээний ажлын байршил, хугацаа, ажилбаруудыг нь өөрчлөх эсхүл Гүйцэтгэгчид нэмэлт туршилт хийх зааварчилгаа өгч болно. Хэрэв өөрчлөгдсөн эсхүл нэмэлтээр хийгдсэн үндсэн тоног төхөөрөмж, материал, ажлын гүйцэтгэлийн туршилт шинжилгээ гэрээний шаардлагыг хангахгүй бол тухайн ажлыг хийхэд гарсан энэхүү нэмэлт зардал болон хугацааны хоцрогдлыг Гүйцэтгэгч хариуцна.

Инженер 72 цагаас хэтрэхгүйгээр Гүйцэтгэгчид тухайн туршилтын ажилд оролцох эсэхээ албан бичгээр мэдэгдэл илгээнэ. Хэрэв Инженер Гүйцэтгэгчийн энэхүү дэд заалтын дагуу өгсөн мэдэгдэлд тусгасан хугацаа болон тухайн байршилд хийгдэх туршилтын ажилд оролцохгүй бөгөөд өөрөөр зааварчилгаа өгөөгүй бол Гүйцэтгэгч туршилтын ажлыг эхлүүлж болно. Эдгээр туршилт нь Инженерийг байлцуулан хийгдсэн гэж үзнэ. Хэрэв Гүйцэтгэгчид энэхүү зааварчилгааг дагаж мөрдсөнөөс эсхүл Захиалагчийн хариуцлагаас үүдэн ямар нэг саатал гарч хугацааны хоцрогдол мөн/эсхүл нэмэлт зардал үүссэн бол Гүйцэтгэгч 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу хугацааны сунгалт болон/эсхүл зардлаа төлүүлэх эрхтэй.

Хэрэв Гүйцэтгэгчээс шалтгаалж хийгдэх шаардлагатай туршилтын ажил (өөрчилсөн болон нэмэлтээр хийгдсэн туршилтын ажлыг мөн оролцуулна) хоцрох, энэ хоцрогдоос шалтгаалж Захиалагчид нэмэлт зардал гарсан бол Захиалагч 20.2

[Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

Гүйцэтгэч нь зохих ёсоор туршилтын баталгаажсан тайланг нэн даруй Инженерт илгээх ёстай. Хийгдэх шаардлагатай туршилтын ажил амжилттай болсон тохиолдолд Инженер энэхүү үр дүнд тулгуурлан Гүйцэтгэгчийн туршилтын/чанарын гэрчилгээг баталгаажуулах эсхүл Гүйцэтгэгчид гэрчилгээ олгоно. Хэрэв Инженер туршилтын ажилд оролцоогүй бол түүнийг шинжилгээний хариуг үнэн зөв гэдгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Үндсэн тоног төхөөрөмж, материал болон тухайн ажил хийгдэх шаардлагатай туршилтанд тэнцээгүй тохиолдолд хэсэг 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах]-г ашиглана.

7.5 Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах

Хэрэв хяналт, шалгалт, хэмжилт эсхүл туршилтын үр дүнд Үндсэн тоног төхөөрөмж, Материал, Гүйцэтгэгчийн зураг төсөв (хэрэв байвал), ажил гүйцэтгэлд доголдол илэрсэн эсхүл гэрээний шаардлагыг хангахгүй бол Инженер Үндсэн тоног төхөөрөмж, Материал, зураг төсөв эсхүл ажлын гүйцэтгэлд илэрсэн доголдлыг тодорхойлж албан бичгээр мэдэгдэл Гүйцэтгэгчид илгээх ёстай. Үүний дараа Гүйцэтгэгч нэн даруй тухайн доголдлыг засварлах шийдэл боловсруулан хүргүүлнэ.

Инженер уг шийдлийг шалгаад хэрэв энэхүү шийдлээр хийж гүйцэтгэвэл тухайн Үндсэн тоног төхөөрөмж, Материал, Гүйцэтгэгчийн зураг төсөвт (хэрэв байвал), үр дүн үзүүлэхгүй эсхүл ажлын гүйцэтгэл нь гэрээний шаардлага хангахгүй гэж үзвэл албан бичгээр түүнийгээ тодорхойлж Гүйцэтгэгчид мэдэгдэл илгээж болно. Энэхүү мэдэгдлийг авсны дараа Гүйцэтгэгч нэн даруй шийдлээ шинэчилж Инженерт илгээх ёстай. Хэрэв Инженер Гүйцэтгэгчийн санал болгосон шийдэлд (эсхүл шинэчилж өгсөн шийдэл) 14 хоногийн дотор албан бичгээр хариу өгөхгүй бол Инженер зөвшөөрсөн мэдэгдэл илгээсэн гэж үзнэ.

Хэрэв Гүйцэтгэгч доголдлыг засварлах шийдлээ (эсхүл шинэчилсэн шийдэл) нэн даруй өгч чадаагүй эсхүл доголдлыг засахаар шийдэл боловсруулж Инженерээр батлуулсан ажлаа гүйцэтгэж чадаагүй бол Инженер:

а) Гэрээний 7.6 [Доголдлыг засварлах]-ийн (а) заалт болон/эсхүл (b)-н дагуу Гүйцэтгэгчид шаардлага хүргүүлэх, эсхүл

б) гэрээний 11.4 [Доголдлыг засах ажлыг үл гүйцэтгэх]-ийн (а) заалтыг ашиглан үндсэн тоног төхөөрөмж, материал, Гүйцэтгэгчийн зураг төсөв (хэрэв байвал), ажлын гүйцэтгэлийг албан бичгээр тухайн нөхцөл байдалд үүссэн шалтгааныг нь дурдаж, батлахгүй байж болно.

Үндсэн тоног төхөөрөмж, материал, зураг төсөв (хэрэв байвал), эсхүл ажлын гүйцэтгэлийн доголдлыг засварласны дараа хэрэв Инженер зарим ажлуудад дахин туршилт хийхийг шаардвал туршилтын ажил нь Гүйцэтгэгчийн зардлаар гэрээний 7.4 [Гүйцэтгэгчийн хийх туршилт шинжилгээ]-ийн дагуу дахин хийгдэнэ. Хэрэв батлагдаагүйгээс болон дахин туршилтын ажил хийснээр Захиалагчид нэмэлт зардал гарвал 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу зардлаа Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

7.6 Доголдлыг засварлах

Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө Инженер хэдийд ч хамаагүй өмнө нь хийгдсэн хяналт, шалгалт, хэмжилт, туршилт, туршилтын/чанарын гэрчилгээ, Инженерийн зөвшөөрөл олгосон албан бичигт нэмэлтээр дараах зааварчилгааг өгч болно.

- a) Засварлах, доголдлыг арилгах (шаардлагатай тохиолдолд ажлын талбайгаас өөр газар), эсхүл гэрээний шаардлага хангахгүй Үндсэн тоног төхөөрөмж материалыг талбайгаас зайлуулах эсхүл солих
- b) Гэрээний шаардлага хангагүй ажлыг засварлах, доголдлыг арилгах эсхүл талбайгаас зайлуулах, дахин гүйцэтгэх
- c) Осол, урьдчилан таамаглашгүй нөхцөл байдал болон бусад зүйлээс шалтгаалж аливаа ажлын аюулгүй байдалд нөлөөлсөн бөгөөд нэн яаралтай засч сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх

Гүйцэтгэгч шаардлагыг аль болох боломжит хугацаанд биелүүлэх бөгөөд шаардлагад заасан хугацаанаас (хэрэв байвал) хэтрүүлэхгүй байх эсхүл дээрх дэд заалт (c)-н дагуу хойшлуулж болшгүй нөхцөлд нэн даруй арга хэмжээ авна.

(i) Захиалагч эсхүл Захиалагчийн төлөөлөгчийн үйлдлээс шалтгаалж Гүйцэтгэгчид энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд хугацааны хоцрогдол болон/эсхүл зардал гарсан бол Гүйцэтгэгч 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу хугацааны сунгалт болон/эсхүл зардлаа нэхэмлэх эрхтэй.

(ii) Давагдашгүй хүчин зүйл үүссэн бол гэрээний 18.4 [Онц байдын үр дагавар]-ийг ашиглана.

Хэрэв Гүйцэтгэгч Инженерийн өгсөн шаардлагыг биелүүлж чадаагүй бол, Захиалагч өөр хуулийн этгээдийг хөлслөн авч тухайн ажлыг гүйцэтгүүлж болно. Энэхүү хэсэгт заасан Гүйцэтгэгч тухайн ажлын төлбөрийг төлөхөөс бусад тохиолдолд гэрээний 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-ийн дагуу Захиалагч нь Гүйцэтгэгчийн алдаанаас шалтгаалж үүссэн бүх зардлыг төлүүлэх эрхтэй. Энэхүү эрхийн хүрээнд Захиалагч гэрээний дагуу бусад эрхэд халдахгүй байх ёстой.

7.7 Бараа материал, тоног төхөөрөмжийг өмчлөх эрх

Үндсэн тоног төхөөрөмж болон Материалын аливаа зүйл тус бүр нь тухайн Улсын Хууль тогтоомжид заасан үндсэн шаардлагуудыг бүрэн хангах ёстой бөгөөд доорх дэд хэсгүүдийн заалтуудыг хангасан тохиолдолд ямар нэг барьцаа, саадгүйгээр Захиалагчийн өмч болно. Үүнд:

- a) Ажлын талбайд хүргэгдсэн бол;
- b) Гүйцэтгэгч нь гэрээний 8.11 [Захиалагч Ажлыг түр зогсоосны дараах Үндсэн тоног төхөөрөмж болон Материалын төлбөр]-т заасны дагуу Үндсэн тоног төхөөрөмж болон Материалын үнийг төлсөн бол;
- c) Гүйцэтгэгч нь гэрээний 14.5 [Ажилд зориулж татан авсан Үндсэн тоног төхөөрөмж ба Материал]-т заасны дагуу тогтоосон үндсэн тоног төхөөрөмж болон Материалын үнийг төлсөн бол.

7.8 Нөөц ашигласны төлбөр

Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч бүх нөөц ашигласны төлбөр, түрээс мөн дараах зүйлтэй хамаарал бүхий бусад төлбөрүүдийг төлөх үүргийг хүлээнэ. Үүнд:

- a) Ажлын талбайн гаднаас байгалийн эх үүсвэр бүхий Материал авч ашигласны төлбөр;
- b) Захиалагчийн шаардлагад заасан Ажлын талбай доторх хог хаях цэгээс бусад, газар шороо, ухмал, нураалтын ажлаас гарсан материалын хог хаягдал

болов бусад хаягдал материалыг (байгалийн эсхүл хүний бүтээсэн) зайлцуулах/хаях төлбөр.

8. Ажил эхлэх, хугацаа хойшлох болон ажлыг түр зогсоох

8.1 Ажил эхлэх

Инженер ажил эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн дотор ажил эхлэх огноог заасан мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч тендерт шалгарсан баримт бичгийг хүлээн авснаас хойш 42 хоногийн дотор ажлыг эхлүүлнэ.

Гүйцэтгэгч ажил эхэлсэн өдрөөс хойш Ажлыг аль болох хурдан эхлүүлж, түргэн шуурхай, сааталгүй үргэлжлүүлнэ.

8.2 Ажил дуусах хугацаа

Гүйцэтгэгч нь ажлыг бүхэлд нь эсхүл хэсэг ажил тус бүрийг (хэрвээ байвал) ажил дуусах хугацаанд заагдсан (тухайн нөхцөл байдлаас хамаарч) хугацаанд дуусгах бөгөөд үүнд гэрээний 10.1 [Ажлыг бүхэлд нь болон Багц ажлыг хүлээн авах]-т нийцүүлсэн байдлаар Гэрээнд заасан бүхий л ажлыг хийж дуусгана.

8.3 Ажлын хөтөлбөр

Гүйцэтгэгч нь гэрээний 8.1 [Ажил эхлүүлэх]-ийн дагуу мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор ажил гүйцэтгэх анхны ажлын хөтөлбөрийг инженерт хүргүүлнэ. Энэхүү ажлын хөтөлбөрийг Захиалагчийн шаардлагад заасан программ хангамжийг (хэрэв заагаагүй бол инженерийн зөвшөөрсөн программ хангамж) ашиглан бэлтгэнэ. Мөн аливаа ажлын хөтөлбөр нь бодит гүйцэтгэлийг илтгээгүй эсвэл Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэгт нийцэхгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч нь ажлын бодит гүйцэтэлийг үнэн зөв тусгасан шинэчилсэн ажлын хөтөлбөрийг хүргүүлнэ.

Анхны хөтөлбөр болон шинэчилсэн хөтөлбөр бүрийг гэрээний мэдээлэлд заасны дагуу нэг цаасан хувь, нэг цахим хувь, нэмэлт цаасан хуулбар (хэрэв байгаа бол)-аар инженерт ирүүлэх бөгөөд үүнд:

- а) Ажил болон ажлын бүрдэл хэсгийн ажлуудын (хэрвээ байвал) ажил эхлэх огноо болон ажил дуусах хугацаа;
- б) Гэрээний мэдээлэлд заасан Гүйцэтгэгчийг ажлын талбайд нэвтрэх, бүхэлд нь болон хэсэгчилэн эзэмших (хэсэг тус бүрээр) эрхийг олгосон өдөр. Хэрэв Гэрээний мэдээлэлд заагаагүй бол Гүйцэтгэгч Захиалагчид хүсэлт гарган ажлын талбайд нэвтрэх, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эзэмших (хэсэг тус бүрээр) эрхийг олгохыг хүссэн өдрүүд;
- с) Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх төлөвлөлтийн дараалал ба үүнд зураг төслийг ажлын (хэрвээ байвал) үе шат бүрийн төлөвлөлт, Гүйцэтгэгчийн баримт бичгийг бэлтгэн боловсруулах болон хүргүүлэх, ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, тест, Ажлын талбай хүртэл тээвэрлэлт, хүргэлт, барилга угсралт, угсралт, суурилуулалт болон аливаа нэрлэсэн Туслан гүйцэтгэгчийн (5.2 [Нэрлэсэн туслан гүйцэтгэгч]-т заасны дагуу нэрлэсэн) гүйцэтгэх ажил болон тест, туршилт зэргийн төлөвлөсөн хугацааг багтаана.
- (д) Захиалагчийн шаардлагад заасан эсхүл Гэрээний нөхцөлөөр шаардсан аливаа хүргүүлсэн/ирүүлсэн мэдээлэл, баримт бичгийг хянаж, шалгаххугацаанууд;
- (е) Гэрээнд заасан эсхүл шаардсан шалгалт, туршилт, шинжилгээ хийх дараалал болон хугацаанууд;

(f) Шинэчилсэн ажлын хөтөлбөрт зориулж: Инженерээс өгсөн 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах]-т заасны дагуу татгалзах зүйлгүй мэдэгдэл өгсөн болон/эсхүл 7.6 [Гологдлыг засварлах]-т заасны дагуу гологдлыг засварлах даалгавар (хэрвээ байвал) өгсний дагуу хийгдэх засварлах (хэрвээ байвал) ажлуудын дараалал болон хугацаа

(g) Үйл ажиллагааны бүх ажилбарууд (Захиалагчийн шаардлагад заагдсан байдлаар), логик байдлаар харилцан хамааралтай, ажилбар тус бүрийн эхлэх болон дуусгах хугацааны хамгийн эхний болон сүүлийн боломжит хувилбарууд, хоцролт (хэрвээ байвал), онцгой анхаарах үе шатууд;

(h) Тухайн бүс, нутгийн албан ёсны амралтын болон баяр ёслолын өдрүүд (хэрвээ байвал);

(i) Үндсэн тоног төхөөрөмж болон Материалын хүргэлт/татан авалттай холбоотой үндсэн хугацаанууд;

(j) Шинэчилсэн ажлын хөтөлбөр тус бүр болон бүх ажилбарт: тухайн өдрийн байдлаар бодит ажлын гүйцэтгэл, тухайн ажлын гүйцэтгэлд хамаарах аливаа хоцролт, энэхүү аливаа хоцролтын бусад ажилбаруудад үзүүлэх нөлөөллүүд (хэрвээ байвал);

(k) Дараах зүйлсийг багтаасан нотлох тэмдэглэл, тайлангууд:

(i) Ажлын гүйцэтгэх голлох/тomoохон үе шатуудын тодорхойлолт

(ii) Гүйцэтгэгчээс санал болгож буй Ажлыг гүйцэтгэх аргачлалын ерөнхий тайлбар

(iii) Ажлын талбайд шаардлагатай Гүйцэтгэгчийн ажиллагсдын ангилал тус бүр дэх ажиллах хүчний тоо болон Гүйцэтгэгчийн машин, тоног төхөөрөмж, мөн Ажлыг гүйцэтгэх үндсэн үе шат бүрийн тайлбар мэдээлэл

(iv) шинэчилсэн ажлын хөтөлбөрт өмнө Гүйцэтгэгчээс хүргүүлсэн Ажлын хөтөлбөр томоохон өөрчлөлтийг тусган оруулсан бол тэр тухай тайлбар мэдээлэл

(v) Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан аливаа хоцролтын нөлөөллийг багасгахаар ирүүлсэн Гүйцэтгэгчийн саналууд.

Инженер нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн анхны хөтөлбөр болон шинэчилсэн хөтөлбөр бүрийг хянан үзэж, энэ нь Гэрээг хэр зэрэг биелүүлээгүй, бодит ахиц дэвшлийг тусгахаа больсон, эсвэл Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагатай зөрчилдэж байгаа талаар Гүйцэтгэгчид мэдэгдэл өгч болно. Хэрэв инженер ийм мэдэгдэл өгөөгүй бол:

- анхны хөтөлбөрийг хүлээн авснаас хойш 21 хоногт багтаан; эсхүл
- шинэчилсэн хөтөлбөрийг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хүргүүлээгүй бол Инженерийг үл татгалзах мэдэгдлийг хүргүүлсэн гэж үзэх бөгөөд Гүйцэтгэгчээс хүргүүлсэн анхны эсхүл шинэчилсэн хөтөлбөр (тухайн нөхцөл байдлаас хамаарч) нь ажлын хөтөлбөрөөр тооцно. Үүнд:

Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хүлээсэн бусад үүргийг харгалzan хөтөлбөрийн дагуу ажиллана. Захиалагчийн ажилтнууд ажлын хөтөлбөрт тулгуурлан цаашдын үйл ажиллагааг төлөвлөх эрхтэй.

Аливаа хөтөлбөрт тусгасан асуудлууд болон Ажлын хөтөлбөр эсхүл аливаа нэмэлт тайлан мэдээллийг Гэрээгээр заасан мэдэгдэл гэж авч үзэхгүй бөгөөд эдгээр нь Гүйцэтгэгчийг аливаа үүрэг хариуцлагаас үл чөлөөлнө.

Ажлын хөтөлбөр нь гэрээг биелүүпэхгүй (тодорхой хэмжээгээр) эсвэл бодит ахиц дэвшлийг тусгахаа больсон эсвэл Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагатай зөрчилдэж байгаа тухай инженер ямар ч үед Гүйцэтгэгчид мэдэгдвэл,

Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хэсэгт заасны дагуу шинэчилсэн хөтөлбөрийг инженерт ирүүлнэ.

8.4 Урьдчилсан анхааруулага

Талууд нь нэг нэгэндээ болон Инженерт зөвлөгөө өгөх бөгөөд инженер нь ирээдүйд болох аливаа мэдэгдэж байгаа эсвэл болзошгүй үйл явдал, нөхцөл байдлын талаар талуудад урьдчилан зөвлөнө.

- (a) Гүйцэтгэгчийн ажиллагсдын ажилд сөргөөр нөлөөлөх
- (b) Ажил дууссаны дараа Ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх
- (c) Гэрээний үнийг өсгөх
- (d) Ажил болон түүний Бүрдэл хэсгийн ажлыг (хэрэв байгаа бол) хойшлуулах

Инженер нь тухайн нөхцөл байдлын болон үйл явдлын нөлөөллөөс зайлсхийх эсхүл нөлөөллийг бууруулах зорилгоор Гүйцэтгэгчийг 13.3.2 [Санал ирүүлэх хүсэлтээр оруулах өөрчлөлт] хэсгийн дагуу саналаа ирүүлэхийг шаардаж болно.

8.5 Ажил дуусах хугацааг сунгах

Гүйцэтгэгч нь дор дурдсан аль нэг шалтгааны улмаас 10.1 [Ажлыг бүхэлд нь болон Багц ажлыг хүлээн авах] хэсгийг биелүүлэхэд хамаарал бүхий Ажил дуусах хугацаа хойшлогдсон эсхүл хойшлогдохоор байгаа бол 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл] хэсэгт заасны дагуу Ажил дуусах хугацааг сунгах эрхтэй. Үүнд:

- (a) Гэрээний өөрчлөлт; (20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл] хэсгийг дагаж мөрдөх шаардлага тусгагдаагүй Гэрээний өөрчлөлтүүдээс бусад)
- (b) Хугацаа хоцорсон шалтгаан нь эдгээр Гэрээний нөхцөлийн хэсэгт заасны дагуу Хугацааг сунгах нэхэмжлэл (ХСН) гаргах үндэслэл болж байвал;
- (c) Эдгээр Гэрээний нөхцөлд Магадалшгүй нөхцөл байдалд багтан "Ажлын талбай дахь цаг уурын таагүй нөхцөл байдал" гэж тодорхойлогдсон цаг уурын нэн таагүй нөхцөл байдал үүсч гэрээний 2.5 [Ажлын талбайн өгөгдөл болон геодезийн тулгуур цэгүүд]-т заасны дагуу Инженерээс гаргасан цаг уурын өгөгдөл мэдээлэл болон/эсхүл Улсын цаг уурын орчны газраас тухайн ажлын талбайн газарзүйн байршил дахь цаг уурын албан ёсны мэдээлэл байгаа бол;
- (d) Гоц халдварт өвчин, тахал эсхүл Төр засгийн шийдвэрээс шалтгаалан ажиллах хүчин эсхүл бараа материалын (эсхүл Захиалагчийн нийлүүлэх бараа материал) хангалт дутагдах, хомсдох зэрэг урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүссэн бол
- (e) Захиалагч, Захиалагчийн ажилтан, эсхүл ажлын талбайд ажиллаж буй Захиалагчийн бусад гүйцэтгэгч нараас аливаа хоцролт, түр зогсолт эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ шалтгаалсан бол.

Хэрвээ 12 дугаар зүйлд заасны дагуу аливаа ажилбарын хэмжсэн тоо хэмжээ нь Тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл эсхүл бусад Хуваарьт заасан энэхүү ажилбарын хэмжсэн тоо хэмжээнээс арван хувиас (10%) илүү гарсан бөгөөд энэхүү өсөлт нь 10.1 [Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах]-т заасан ажил дуусгах хугацаанд хоцролт үүсэх шалтгаан болсон бол Гүйцэтгэгч нь 20.2 [Төлбөрийн

болов/эсвэл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу ХС нэхэмжлэл гаргах эрхтэй 20.2.5 [Нэхэмжлэлийн хэлцэл ба шийдэл]-т заасны дагуу гаргах энэхүү аливаа Нэхэмжлэлийн хэлцэл эсхүл шийдэлд Тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл эсхүл бусад Хуваарын тооцоолсон тоо хэмжээнээс харьцангуй бага (10 хувиас их) аливаа бусад ажилбарын хэмжилтүүдэд хийгдсэн Инженерийн нягталж, хянсан дүгнэлтийг тусгаж болно. Инженер нь энэхүү бага гарсан хэмжилтийн тоо хэмжээний дагуу Ажлын графикийн чухал хэсгүүдэд нөлөөлөх аливаа боломжит нөлөөллийг тооцож үзэж болно. Гэхдээ энэхүү тооцох үзсэн цэвэр нөлөөлөл нь Ажил дуусах хугацаанд цэвэр бууралт байдлаар нөлөөлөхгүй байх хэрэгтэй.

Инженер нь 20.2 [Төлбөрийн болон/эсвэл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу ХС тус бүрийг тогтоохдоо 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-т заасны дагуу өмнө хийгдсэн хэлцэл болон дүгнэлтүүдийг хянах бөгөөд үүнд нийт ХС нь багасч болохгүй ба харин өсч болно.

Хэрвээ Захиалагчийн хариуцсан асуудлаас шалтгаалан үүссэн хоцролт нь Гүйцэтгэгчийн хариуцсан асуудлаас шалтгаалан үүссэн хоцролттой давхцаж байвал Гүйцэтгэгчийн ХС-ыг хийхдээ Тусгай заалтуудад тусгагдсан журам болон аргачлалд нийцүүлэн тооцно (хэрвээ тусгагдаагүй бол холбогдох бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзсэн зохих байдлаар шийдвэрлэнэ).

8.6 Эрх бүхий байгууллагаас шалтгаалж хугацаа хойшлох

Хэрэв:

(а) Гүйцэтгэгч нь тухайн Улсын төр засгийн эсхүл эрх бүхий хувийн хэвшлийн инженерийн шугам сүлжээний аж ахуйн нэгжүүдийн гаргасан шийдвэрийг дагаж мөрдсөн;

(б) Эдгээр төр, засгийн болон эрх бүхий хуулийн этгээд нь Гүйцэтгэгчийн ажлыг саатулсан эсхүл тасалдуулсан;

(с) Хоцролт эсхүл saatlyig Урьдчилан таамаглах боломжгүй байсан;

бол эдгээр шалтгаанаас үүссэн аливаа хоцролт болон saatlyig 8.5 [Ажил дуусах хугацааг сунгах]-ийн (b) заалтад заасан хугацаа хоцролтын шалтгаан гэж үзнэ.

8.7 Ажлын явцыг үнэлэх

Хэрвээ 8.5 [Ажил дуусах хугацааг сунгах]-т заасан аль нэг шалтгаанаар биш бөгөөд аливаа хугацааны үед:

(а) Бодит ажлын явц хэт удаан бөгөөд ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийн ажлыг зохих ажил дуусах хугацаанд нь багтаан дуусгах явц байдал удаашралтай байгаа бол; болон/эсхүл;

(б) 8.3 [Ажлын хөтөлбөр]-т заасны дагуу ажлын явц нь Ажлын хөтөлбөр төлөвлөгөөнөөс хоцорсон эсхүл хоцрох төлөвтэй бол

Инженер нь 8.3 [Ажлын хөтөлбөр]-т заасны дагуу Ажил эсхүл бүрдэл хэсгийн ажлын явцыг хурдасгах болон ажил дуусах хугацаанд багтаан дуусгах зорилготойгоор дэвшиүүлж буй аргачлал, дэлгэрэнгүй саналыг тусгасан шинэчилсэн хөтөлбөрийг ирүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

Хэрвээ Инженер нь өөрөөр заасан мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлээгүй бол эдгээр шинэчилсэн аргачиллал, төлөвлөгөөг Гүйцэтгэгч дагаж мөрдөн ажиллах үүрэгтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор ажлын цагийг нэмэгдүүлэх болон/эсхүл Гүйцэтгэгчийн ажиллагдын тоог нэмэх болон/эсхүл Бараа материалыг нэмэгдүүлэх

шаардлага гарч болзошгүй ба эдгээрийн зардал болон эрсдэлийг Гүйцэтгэгч хариуцна. Энэхүү шинэчилсэн аргачлал, төлөвлөгөө нь Захиалагчаас илүү зардал гарсан бол 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу эдгэр төлбөрийг болон мөн хугацаа хойшилсны алдангийг (хэрвээ байвал) Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

8.5 [Ажил дуусах хугацааг сунгах]-т дурдсан шалтгаануудаас үүдэлтэй ажлын саатлыг багасгахын тулд Инженерээс өгөгдсөн даалгавар, арга хэмжээнүүдийг багтаасан шинэчилсэн аргачлал 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] дахь заалт үйлчилнэ.

8.8 Хугацаа хойшилсны алданги

Гүйцэтгэгч 8.2 [Ажил дуусах хугацаа]-ийн заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Захиалагч нь 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл] хэсгийн дагуу Хугацаа хойшилсны алдангийг Гүйцэтгэгчээс нэхэмжлэх эрхтэй. Хугацаа хойшилсны алданги гэдэг нь Гэрээний мэдээлэлд тусгагдсан дүн бөгөөд холбогдох Ажлыг эсхүл Бүрдэл хэсэг дуусах огноо болон холбогдох Ажил дуусах хугацаанд хамаарах өдөр бүр төлөгдөх ёстой дүн юм. Энэхүү хэсгийн дагуу төлөгдөх Хугацаа хойшилсны алдангийн нийт мөнгөн дүн нь Гэрээний мэдээлэлд заасан Хугацаа хойшилсны алдангийн хамгийн их дүнгээс (хэрвээ байвал) хэтрэхгүй.

Эдгээр Хугацаа хойшилсны алданги нь гагцхүү Гүйцэтгэгч 8.2 [Ажил дуусах хугацаа] хэсгийн заалтуудыг биелүүлээгүйтэй холбоотой үүссэн алданги байх бөгөөд үүнд Ажил дуусахаас өмнө 15.2 [Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүйн улмаас гэрээ цуцлах] хэсгийн дагуу гэрээг цуцлах тохиолдол хамаарахгүй. Эдгээр Хугацаа хойшилсны алданги нь Гүйцэтгэгчийг Ажил бүрэн дуусгах эсхүл Гэрээгээр болон түүнтэй холбоотой хүлээсэн аливаа бусад үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Энэхүү хэсгийн заалтууд нь Гүйцэтгэгчийн Хугацаа хойшилсны алданги төлөх болон Гүйцэтгэгчийн үйлдсэн аливаа хууран мэхлэлт, залилан, хариуцлагаагүй байдал, санаатай болон санамсаргүйгээр гаргасан алдаа, зөрчилд үүсэх хариуцлагаас чөлөөлөхгүй.

8.9 Захиалагч Ажлыг түр зогсоох

Инженер нь Гүйцэтгэгчийн ажлын явцыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зогсоох даалгаврыг хэзээ ч өгөх эрхтэй бөгөөд уг даалгаварт түр зогсоох болсон шалтгаан болон хугацааг тодорхой дурдсан байна.

Түр зогсолтын хугацаанд Гүйцэтгэгч нь тухайн ажлыг бүхэлд нь (тухайн нөхцөл байдлаас хамааран) эсхүл тухайн хэсгийн эвдрэл гэмтэл, элэгдэл хорогдол зэргээс хамгаалах, хадгалах, найдвартай байдлыг хангах үүргийг хүлээнэ.

Тухайн түр зогсолтын хариуцлага нь Гүйцэтгэгчээс хамааралтай бол 8.10 [Захиалагч Ажлын түр зогсоосны үр дагавар], 8.11 [Захиалагч Ажлыг түр зогсоосны дараах Үндсэн тоног төхөөрөмж болон Материалын төлбөр] болон 8.12 [Түр зогсолт удаашрах] тус тус үйлчлэхгүй.

8.10 Захиалагч Ажлыг түр зогсоосны үр дагавар

Гэрээний 8.9 [Захиалагч ажлыг түр зогсоох]-т дагуу Инженерийн өгсөн даалгаврыг гүйцэтгэхэд болон/эсхүл 8.13 [Ажлыг дахин эхлүүлэх]-т заасны дагуу Ажлыг дахин эхлүүлснээс болж Гүйцэтгэгчид хоцролт үүссэн болон/эсхүл зардал гарсан бол Гүйцэтгэгч 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу ХС нэхэмжлэл гаргах болон/эсхүл ашиг болон зардлын төлбөрийг гаргуулах эрхтэй байна.

Дараах тохиолдлуудад Гүйцэтгэгч нь хугацаа сунгах нэхэмжлэл гаргах эсхүл зардлын төлбөрийг нэхэмжлэх эрхгүй:

(а) Гүйцэтгэгчийн буруутай эсхүл алдаатай үйл ажиллагаанаас шалтгаалсан гүйцэтгэл (зураг төсөл, хэрэв байгаа бол), үндсэн тоног төхөөрөмж болон материалыг засч запруулах үйл ажиллагааны зардал;

(б) гэрээний 8.9 [Захиалагч ажлыг түр зогсоох]-т заасны дагуу хамгаалах, хадгалах эсхүл найдвартай байдлыг хангах үүргийг Гүйцэтгэгч биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа элэгдэл хорогдол, хохирол гэмтэл эсхүл эвдрэлийг запруулах үйл ажиллагааны зардал

8.11 Захиалагч Ажлыг түр зогсоосны дараах бараа, материал, тоног төхөөрөмжийн төлбөр

Үндсэн тоног төхөөрөмж болон Материалыг дор дурдсан шалтгаануудын улмаас Ажлын талбайд хүргүүлээгүй бол Гүйцэтгэгч тэдгээрийн үнийг төлүүлэх (8.9 [Захиалагч ажлыг түр зогсоох] хэсгийн дагуу ажлыг түр зогсоосон өдрөөс тооцно) эрхтэй:

(а) Үндсэн тоног төхөөрөмж дээр хийгдэх ажил, эсхүл Үндсэн тоног төхөөрөмж эсхүл/болон Материал ханганд нийлүүлэлтийг 28 хоногоос дээш хугацаагаар түр зогсоосон бөгөөд

i. Ажлын графикийн дагуу төлөвлөсөн Үндсэн тоног төхөөрөмж болон Материал нь түр зогсолтын хугацаанд Ажлын талбайд хүргэгдэхэд бэлэн байсан бол; ман

ii. Гүйцэтгэгч нь Үндсэн тоног төхөөрөмж болон Материал нь Гэрээнд нийцэж буй тухай хангалттай нотолгоог Инженерт хүргүүлсэн бол;

(б) Гүйцэтгэгч нь Инженерийн зааварчилгааны дагуу Үндсэн тоног төхөөрөмж болон/эсхүл Материалыг Захиалгчийн өмч гэж тэмдэглэсэн бол.

8.12 Түр зогсолт сунжрах

Хэрэв, 8.9 [Захиалагч ажлыг түр зогсоох]-т заасны дагуу хийгдсэн түр зогсолт нь 84 хоногоос хэтэрсэн бол Гүйцэтгэгч нь ажлаа үргэлжлүүлэн хийх зөвшөөрөл хүссэн мэдэгдлийг Инженерт хүргүүлэх эрхтэй.

Хэрэв Инженер дээр дурдсан Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор 8.13 [Ажлыг дахин үргэлжлүүлэх] хэсгийн дагуу хариу Мэдэгдэл хүргүүлээгүй бол Гүйцэтгэгч нь:

(а) түр зогсолтыг цаашид үргэлжлүүлэхийг харилцан зөвшөөрч болох бөгөөд үүнд түр зогсолт үргэлжлэх хугацаанд гарсан ХС болон/эсхүл зардал болон ашгийн (хэрвээ Гүйцэтгэгчээс Зардал гарсан бол) асуудлаар болон/эсхүл түр зогсолтод хамрагдсан үндсэн тоног төхөөрөмж болон/эсхүл Материалын төлбөрийн асуудлаар харилцан зөвшилцэх эрхтэй;

эсхүл (хэрвээ Талууд дээрхи (а) хэсгийн дагуу тохиролцоонд хүрч чадаагүй бол)

(б) Инженерт хоёр дахь мэдэгдэл хүргүүлсний дараа түр зогсолтод холбоотой Ажлын хэсгийг (хэрвээ 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх]-т заасны дагуу өгөдсөн даалгавар хэмээн үзэж) Гэрээний хасалт хийгдсэн хэмээн нэн даруй үзэх ба мөн 8.9 [Захиалагчаас Ажлыг түр зогсоох]-т заасны дагуу хамгаалах, хадгалах, найдвартай байдлыг хангах цаашдын үүрэг хариуцлагаас чөлөөлнө.

Хэрэв түр зогсолт нь Ажилд бүхэлд нь нөлөөлсөн бол Гүйцэтгэгч 16.2 [Гүйцэтгэгчийн саналаар гэрээ цуцлах] хэсийн дагуу Гэрээ цуцлах тухай Мэдэгдэл хүргүүлж болно.

8.13 Ажлыг дахин үргэлжлүүлэх

Гүйцэтгэгч инженерээс түр зогсоосон ажлыг үргэлжлүүлэх тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа аль болох богино хугацаанд түр зогссон ажлыг дахин үргэлжлүүлнэ.

Энэхүү мэдэгдэл заасан хугацаанд (хэрэв заагаагүй бол Гүйцэтгэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа шууд) Гүйцэтгэгч болон Инженер нь түдгэлзүүлэхэд нөлөөлсөн ажил, үйлдвэр, материалын шалтгааныг хамтран шалгана. Инженер нь түр зогсолтын хугацаанд ажил, үндсэн тоног төхөөрөмж болон материалын эвдрэл, гэмтэл, элэгдэл, хорогдлыг шалган бүртгэж энэ тухай тайлан мэдээллийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. Гүйцэтгэгч тэдгээр эвдрэл, гэмтэл, элэгдэл хорогдолыг ажил дууссаны дараа Гэрээнд нийцтэй байхаар даруй засч запруулах үүрэгтэй.

9. Ажил дуусмагц хийх туршилт

9.1 Гүйцэтгэгчийн үүрэг

Гүйцэтгэгч нь 4.4.2 [Ажлын явцын тэмдэглэл] заалт (хэрвээ байвал) болон 4.4.3 [Ашиглалт болон Засвар үйлчилгээний гарын авлага] заалтад (хэрвээ байвал) заасан баримт бичгүүд хүргүүлсний дараа энэхүү хэсэг болон 7.4 [Гүйцэтгэгчийн хийх туршилт шинжилгээ] хэсгийн дагуу Ажил дуусмагц хийх туршилтуудыг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн туршилтуудыг эхлүүлэхээр төлөвлөж буй өдрөөс 42-оос доошгүй хоногийн өмнө эдгээр туршилтуудад шаардагдах хугацаа, нөөцийг харуулсан нарийвчилсан туршилтын хөтөлбөрийг инженерт ирүүлнэ.

Инженер нь санал болгож буй туршилтын хөтөлбөрийг хянан үзэж болох бөгөөд хэрвээ туршилтын төлөвлөгөөнд Гэрээнд нийцэхгүй заалтууд байвал уг асуудлын хүрээнд Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх эрхтэй. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор туршилтын төлөвлөгөөний гарсан асуудлыг тохирлыг засч запруулах үүрэгтэй. Хэрэв Инженер туршилтын төлөвлөгөөг (эсхүл шинэчилсэн туршилтын хөтөлбөр) хүлээн авснаас хойш 14 өдрийн дотор хариу мэдэгдлийг хүргүүлээгүй бол Инженерийн зүгээс татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг хүргүүлэн гэж үзнэ. Гүйцэтгэгч нь Инженерээс татгалзах зүйлгүй мэдэгдэл хүлээн авах (эсхүл өгсөн гэж үзэх) хүртэл Ажил дуусмагц хийх туршилтуудыг эхлэх эрхгүй.

Туршилтын хөтөлбөрт заасан огнооноос гадна Гүйцэтгэгч 21-ээс доошгүй хоногийн дараа Гүйцэтгэгч туршилт бүрийг гүйцэтгэхэд бэлэн байх хугацааг Инженерт хүргүүлнэ. Гүйцэтгэгч энэхүү хугацаанаас хойш 14 өдөрт багтаан эсхүл Инженерээс даалгавраар өгөгдсөн өдөр эсхүл өдрүүдэд Ажил дуусмагц хийх туршилтуудыг эхлүүлэх бөгөөд Инженерийн татгалзах зүйлгүй мэдэгдэлд заан баталгаажуулсан (эсхүл өгсөн гэж үзэх) туршилтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэл эсхүл ажлын зарим бүрдэл хэсэг нь Ажил дуусмагц хийх туршилтуудыг давсан гэж Гүйцэтгэгчээс үзсэн тохиолдолд аль болох хурдан хугацаанд Гүйцэтгэгч нь энэхүү туршилтуудын үр дүнгийн баталгаажсан тайланг Инженерт хүргүүлнэ. Инженер нь тухайн тайланд хянаж үзсэний дараа Гэрээд нийцээгүй туршилтуудын үр дүнгийн талаарх мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлэх эрхтэй. Хэрвээ Инженер туршилтуудын үр дүнгийн тайланг хүлээн авснаас хойш 14

өдрийн дотор хариу мэдэгдэл хүргүүлээгүй бол Инженерээс татгалзах зүйлгүй мэдэгдлийг хүргүүлсэн гэж үзнэ.

Ажил дуусмагц хийх туршилтуудын үр дүнг дүгнэхдээ Инженер нь бүтээмжид нөлөөлөх Ажлын (аливаа хэсгийн) аливаа Захиалагчийн ашиглалтын нөлөөлөл, үр дагаврыг болон Ажлын бусад шинж чанаруудыг харгалzan үзэх шаардлагатай.

9.2 Хойшлогдсон туршилт

Хэрэв Гүйцэтгэгч нь ажил эсхүл бүрдэл хэсэг (нөхцөл байдлаас хамаарч) ажил дуусмагц хийх туршилтуудад бэлэн тухай 9.1 [Гүйцэтгэгчийн үүрэг] хэсгийн дагуу мэдэгдэл хүргүүлсэн боловч энэхүү туршилтуудыг захиалагчийн ажилтнууд үндэслэлгүйгээр хойшлуулсан бол 10.3 [Ажил дуусмагц хийх туршилт саатах] хэсгийг мөрдөнө.

Хэрэв ажил дуусмагц хийх туршилтууд Гүйцэтгэгчээс шалтгаалан хойшилсон бол Инженерийн зүгээс Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Гүйцэтгэгчийг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 21 өдрийн дотор туршилтуудыг гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

Гүйцэтгэгч нь туршилтыг Гүйцэтгэгчийн тогтоосон 21 хоногийн дотор тогтоосон тухайн өдөр буюу өдрүүдэд хийх бөгөөд энэ тухай Гүйцэтгэгч инженерт 7-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь Ажил дуусмагц хийх туршилтуудыг 21 өдрийн дотор хийгээгүй тохиолдолд:

- (a) Захиалагчийн ажилтан туршилтуудыг баталгаажуулсны дараа Инженер хоёр дох Мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлэх;
- (b) Гүйцэтгэгч энэхүү туршилтуудыг
- (c) Туршилтыг хийж дууссаны дараа 28 өдрийн дотор Инженер нь туршилтын тайлангийн хуулбарыг Гүйцэтгэгчид илгээх;
- (d) Хэрэв Захиалагч туршилтын үр дүнгийн нэмэлт зардал хүлээн авсан тохиолдолд Захиалагч 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС нэхэмжлэл]-т заасны дагуу үндэслэлтэй төлбөрийг Гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

Гүйцэтгэгч оролцсон эсэхээс үл хамааран эдгээр гүйцэтгэлийн туршилтыг гүйцэтгэгчийг байлцуулан хийсэн гэж үзэх бөгөөд эдгээр туршилтын үр дүнг үнэн зөв гэж хүлээн зөвшөөрнө.

9.3 Давтан хийх туршилт

Хэрэв тухайн Ажил эсхүл ажлын зарим Бүрдэл хэсэг нь Ажил дуусмагц хийх туршилтуудад тэнцээгүй бол 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах]-ийг мөрдөнө Инженер эсвэл гүйцэтгэгч эдгээр амжилтгүй болсон туршилтууд болон холбогдох аливаа ажлын гүйцэтгэлийн туршилтыг ижил нөхцөл, нөхцлийн дагуу давтан хийхийг шаардаж болно. Энэхүү давтан туршилтыг энэ зүйл заалтын зорилгын дагуу тайлбарлагдана.

9.4 Ажил дуусмагц хийх туршилт амжилтгүй болох

Хэрэв ажил эсхүл бүрдэл хэсэг нь 9.3 [Давтан хийх туршилт]-ийн дагуу давтан хийгдсэн ажил дуусмагц хийх туршилтуудад тэнцээгүй бол Инженер дараах арга хэмжээг авах эрхтэй.

(a) 9.3 [Давтан хийх туршилт]-т заасны дагуу ажил дуусмагц хийх туршилтыг дахин хийх даалгаврыг өгөх;

(b) Хэрвээ Гүйцэтгэгчийн ажлын туршилтад тэнцээгүй шалтгаан нь Захиалагчийг уг ажлаас хүртэх ашгийг хүртэх боломжгүй болгохоор байгаа бол 11.4 [Гологдлыг засах ажлыг үл гүйцэтгэх]-ийн (d) зүйлд заасан эрхийг эдэлнэ;

(c) Хэрвээ ажлын Бүрдэл хэсгийн туршилтанд тэнцээгүй шалтгаан нь тухайн бүрдэл хэсгийг Гэрээнд заасны дагуу ашиглах боломжгүй байхаар нөлөөлэх бол Ажлын бүрдэл хэсгийн хүлээн авахаас татгалзах бөгөөд Захиалагч нь 11.4 [Гологдлыг засах ажлыг үл гүйцэтгэх]-ийн (c) зүйлд заасан эрхийг эдэлнэ.

(d) Хэрвээ Захиалагч хүссэн тохиолдолд уг хүсэлтийн дагуу Ажил хүлээн авсан гэрчилгээг олгох;

Дээр дурдсан (d) дэд хэсгийн заалт хэрэгжих тохиолдолд Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу хүлээсэн бусад бүх үргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх бөгөөд Захиалагч нь 20.2 [Төлбөрийн болон/эсхүл ХС Нэхэмжлэл] хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн төлбөрийг төлөх эсхүл 11.4 [Гологдлыг засах ажлыг үл гүйцэтгэх] хэсгийн (b) дэд хэсэгт заасны дагуу Гэрээний үнийг бууруулах эрхийг эдэлнэ. Энэхүү эрх нь Захиалагчийн Гэрээний дагуу болон бусад байдлаар хүлээсэн бусад эрхийг үл хөндөнө.

10. Захиалагч ажлыг хүлээн авах

10.1 Ажлыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн авах

9.4, 10.2, 10.3 дугаар зүйлүүдэд зааснаас бусад тохиолдолд Захиалагч ажлыг дараах тохиолдолд хүлээн авна. Үүнд:

а) Энэ зүйлийн (i) хэсэгт зааснаас бусдаар Ажил дуусмагц хийх туршилт амжилттай болж Гэрээнд заасны дагуу Ажил дууссан тохиолдолд;

б) 4.4.2 дугаар зүйлийн дагуу ирүүлсэн Ажлын явцын тэмдэглэлд Инженер Татгалзах Мэдэгдэл ирүүлээгүй тохиолдолд;

с) 4.4.3 дугаар зүйлийн дагуу ирүүлсэн ашиглалт болон засвар үйлчилгээний гарын авлагад Инженер татгалзах мэдэгдэл ирүүлээгүй тохиолдолд;

д) 4.5 дугаар зүйлийн дагуу Гүйцэтгэгч сургалтыг зохион байгуулсан тохиолдолд;

е) Энэ зүйлийн дагуу ажлыг хүлээн авах гэрчилгээ олгогдсон эсхүл олгогдсон гэж үзсэн тохиолдолд;

Гүйцэтгэгч ажил дуусаад хүлээн авахад бэлэн болохоос 14 хоногийн өмнө Ажлыг хүлээн авах гэрчилгээ олгохыг хүссэн мэдэгдлийг Инженерт өгч болно. Хэрэв Ажил нь Ажлын хэсгүүдэд хуваагдсан бол Гүйцэтгэгч нь ажлын хэсэг тус бүрт Ажлыг хүлээн авах гэрчилгээ олгохыг хүсэж болно.

Гэрээний 10.2-т заасны дагуу хэсэг ажлыг хүлээн авсан бол (а) - (е) хүртэлх хэсгүүдэд заасан нөхцөлүүд биелээгүй тохиолдолд Ажлын үлдсэн Хэсгүүдийг хүлээн авах боломжгүй.

Инженер Гүйцэтгэгчийн Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор:

(i) Ажил болон тухайн Хэсгийг Үндсэн зориулалтаар нь ашиглахад ноцтой нөлөө үзүүлэхээргүй дутуу үлдсэн бага хэмжээний ажил, доголдолтой Ажил эсхүл Ажлын хэсгийн Гэрээнд заасны дагуу дууссан огноог зааж Ажлыг хүлээн авсан Гэрчилгээг Гүйцэтгэгчид олгоно; эсхүл

(ii) Шалтгааныг дурдан Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтэд татгалзсан Мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү Мэдэгдэлд Ажлыг хүлээн авсан Гэрчилгээг олгохын

тулд гүйцэтгэж дуусгах ажлууд, засвар хийх шаардлагатай гэмтэл доголдол эсхүл Гүйцэтгэгчээс ирүүлэх шаардлагатай баримт бичгүүдийг тодорхой заана. Ийнхүү Гүйцэтгэгч дутагдлыг арилгах, баримт бичгийг бүрдүүлэх эсхүл энэхүү заалтын дагуу нэмэлт мэдэгдэл өгөхөөс өмнө ажлыг гүйцэтгэж дуусгана.

Хэрэв Инженер Гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Ажлыг хүлээн авах гэрчилгээг олгох эсхүл няцаасан хариу өгөөгүй ба дээрх (a), (b) хэсгүүдэд дурдсан нөхцөлүүдийг биелүүлсэн тохиолдолд Инженер Гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш Гэрээнд заасны дагуу ажил эсхүл Ажлын хэсгийг 14 дэх өдөрт дууссан гэж үзэж ажлыг хүлээн авах гэрчилгээг олгохыг зөвшөөрсөн гэж үзнэ.

10.2 Ажлын бүрдлийг хүлээн авах

Инженер байнгын ажлын аль нэг хэсэгт зөвхөн Захиалагчийн зөвшөөрлөөр хүлээн авах Гэрчилгээ олгож болно.

Захиалагч Ажлын аль ч хэсгийг (Гэрээнд заасан түр арга хэмжээ авах эсхүл талууд тохиролцсон, Захиалагчийн шаардлагад зааснаас бусад тохиолдолд) тухайн хэсэгт Инженер ажил хүлээн авах гэрчилгээ олгохоос нааш ашиглахгүй. Хэрэв ажил хүлээн авах гэрчилгээ олгохоос өмнө Захиалагч ажлын аль нэг хэсгийг ашиглавал Гүйцэтгэгч энэ талаар тодорхойлсон мэдэгдлийг хүргүүлэх ба:

(a) тухайн Хэсгийг ашигласан өдрөөс эхлэн Захиалагч тухайлсан ажлыг хүлээн авсан гэж үзнэ;

(b) Гүйцэтгэгч тухайн хэсгийн ажлыг Захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн хариуцлага хүлээхгүй бөгөөд эрсдэл Захиалагчид шилжинэ; мөн

(c) Инженер нэн даруй ажлыг хүлээн авах Гэрчилгээг олгож гэрчилгээнд дутуу ажлууд (ажил дуусмагц хийх туршилтыг багтаана) эсхүл засварлах шаардлагатай гэмтэл доголдлыг тусгасан байна.

Инженер ажлын бүрдлийг хүлээн авах гэрчилгээг олгомогц Гүйцэтгэгч нэн даруй гэрчилгээнд тусгасан дутуу ажлууд (Ажил дуусмагц хийх туршилтыг багтаан) болон гэмтэл доголдлыг засварлана. Гүйцэтгэгч эдгээр ажлуудыг доголдол мэдэгдэх хугацаанаас өмнө аль болох бодино хугацаанд хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

Хэрэв Захиалагч ажлын бүрдлийг хүлээн авах эсхүл ашигласнаас болж Гүйцэтгэгчид нэмэлт зардал гаргасан бол 20.2-т заасны дагуу эдгээр зардлаа ашгийн хамт төлүүлэх эрхтэй.

Хэрэв Инженер Ажлын бүрдлийг хүлээн авах Гэрчилгээг олгосон эсхүл энэхүү зүйлийн (a) хэсэгт заасны дагуу Захиалагч тухайлсан ажлыг хүлээн авсан ба дээрх (a) хэсгийн дагуу Захиалагч ажлыг хүлээн авснаас хойших үлдсэн ажлыг дуусгах хугацаанд тооцогдсон хугацаа хойшилсны алдангийг бууруулна.

Үүний адил үлдсэн Хэсгийн хугацаа хойшилсны алдангийн хэмжээг мөн бууруулна.

Ажлыг дуусгаад хүлээж авсан актад дурдсан өдрөөс хойшхи хоцорсон хугацаанд, батлагдсан хэсгийн ёртгийн нийт ажил буюу хэсэгт эзлэх харьцаагаар алдангийг багасгаж тооцно. Инженер энэхүү алдангийн бууралтыг 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу шийдвэрлэнэ. (Мөн 3.7.3 [Хугацааны хязгаар] Инженер энэхүү хэсгийн дагуу Гүйцэтгэгчээс Мэдэгдэл хүлээн авсан өдрийг 3.7.3 хэсгийн дагуу Хугацааны хязгаар эхлэх өдөр гэж тооцох зорилгоор) Энэхүү хэсгийн

заалт нь зөвхөн өдөр тутмын Хугацаа хойшилсны алдангид хамаарах бөгөөд алдангийн хамгийн дээд хэмжээнд нөлөөлөхгүй.

10.3 Ажил дуусмагц хийх туршилт саатах

Хэрэв Захиалагчийн ажилтан эсхүл Захиалагчаас шалтгаалан Ажил дуусмагц хийх туршилт 14-с дээш хоногоор саатсан (тасралтгүй үргэлжилсэн хугацаа эсхүл хэд хэдэн удаагийн тохиолдлоор нийт 14-с дээш хоног) тохиолдолд:

(a) Гүйцэтгэгч нь уг тохиолдлоос хугацаа хойшлолтын талаарх Мэдэгдлийг Инженерт хүргүүлнэ;

(b) Ажил дуусмагц хийх туршилт дуусах өдрөөр Захиалагч Ажлыг бүхэлд нь эсхүл Ажлын хэсгийг (тухайн нөхцөл байдлаас хамааран) хүлээн авсан гэж үзнэ;

(c) Инженер (тухайн нөхцөл байдлаас хамааран) Ажил эсхүл Ажлын хэсгийг хүлээн авах Гэрчилгээг нэн даруй олгоно.

Гүйцэтгэгч нь Инженер ажлыг хүлээн авах гэрчилгээг олгосны дараа ажил дуусмагц хийх туршилтыг Доголдол мэдэгдэх хугацаанаас өмнө боломжит бодино хугацаанд хийнэ. Инженер Гүйцэтгэгчид 14-өөс доошгүй хоногийн өмнө ажил дуусмагц хийх туршилтыг явуулах талаарх мэдэгдлийг хүргүүлнэ. Тус тохиолдолд 9.1 дэх хэсгийг дагаж мөрдөнө.

Гүйцэтгэгч ямар нэгэн хугацаа хойшлох эсхүл санхүүгийн асуудлаас үүдэн Ажил дуусмагц хийх туршилтыг хугацаанд нь хийж чадаагүй тохиолдолд түүнтэй холбогдон гарсан зардлыг 20.2-т заасны дагуу нөхөн төлүүлэх эрхтэй.

10.4 Нөхөн сэргээх шаардлагатай гадаргуу

Ажил хүлээн авах гэрчилгээнд өөрөөр заагаагүй бол тухайн ажил болон ажлын хэсэгт олгосон гэрчилгээ нь байгалийн нөхөн сэргээлтийн болон бусад газрын гадаргуугийн ажил дууссан гэж үзэх үндэслэл болохгүй.

11. Ажил хүлээн авсны дараах доголдол

11.1 Дутуу ажлыг гүйцээж, доголдлыг арилгах

Ажил, Гүйцэтгэгчийн баримт бичгүүд болон Хэсэг ажил ба/буую Ажлын бүрдэл хэсгийг Гэрээнд заасан шаардлага хангасан нөхцөлд (хэвийн элэгдэл хорогдлыг тооцно) байлгахын тулд Гүйцэтгэгч нь холбогдох Доголдол мэдэгдэх хугацаанд багтаан эсхүл аль болох боломжит хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

(a) Аливаа ажил нь холбогдох ажил дуусах огноондоо багтаж дуусаагүй тохиолдолд тухайн ажлыг ажил хүлээн авсан гэрчилгээнд заагдсан хугацаанд, эсхүл Инженерээс зааварчилсан үндэслэл бүхий хугацаанд багтаан гүйцэтгэж дуусгах, ба

(b) Захиалагчаас (эсхүл түүний нэрийн өмнөөс) Гүйцэтгэгчид хүргүүлсэн мэдэгдэлд дурдсан аливаа доголдол эсхүл эвдрэл гэмтлийг засаж запруулах бүхий л ажлыг тухайн Ажил эсхүл Хэсэг ажил, Ажлын бүрдэл хэсэгт (тухайн нөхцөл байдлаас хамааран) хамаарах Доголдол мэдэгдэх хугацаа дуусахад эсхүл дуусахаас өмнө хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Хэрвээ холбогдох Доголдол мэдэгдэх хугацаанд доголдол илрэвэл (үүнд хэрэв ажил дууссаны дараах туршилт байгаа бөгөөд аливаа ажил нь тухайн туршилтад тэнцээгүй нөхцөл байдал багтана) Захиалагч нь Гүйцэтгэгчид (эсхүл түүний нэрийн өмнөөс) зохих мэдэгдлийг хүргүүлнэ. Үүний дараагаар:

- (i) Гүйцэтгэгч болон Захиалагчийн ажилчид нь хамтран доголдол эсхүл эвдрэл гэмтлийн үзлэг шалгалтыг хийнэ;
- (ii) дараа нь Гүйцэтгэгч шаардлагатай засварын ажлын саналаа бэлтгэж, хүргүүлэх; ба
- (iii) Гэрээний 7.5 [Доголдол ба Татгалзал]-ийн хоёр, гурав болон дөрөв дэх параграфыг хэрэглэнэ.

11.2 Доголдлыг арилгах зардал

Хэрэв тухайн ажил нь дараах зүйлүүдэд хамаарч буй тохиолдолд, Гэрээний 11.1 [Дутуу ажлыг гүйцээж, доголдлыг арилгах]-ийн (b) заалтад дурдсан бүх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэж, эрсдэлийг хүлээнэ:

- (a) Гүйцэтгэгч хариуцлагыг нь хүлээх Ажлын зураг төсөл (хэрэв байгаа бол);
- (b) Байгууламж, Бараа материал эсхүл Ажлын ур чадвар нь гэрээнд заасан шаардлагыг хангахгүй байгаа;
- (c) Гүйцэтгэгч (Гэрээний 4.4.2 [Ажлын явцын тэмдэглэл], Гэрээний 4.4.3 [Ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлага] ба/эсхүл Гэрээний 4.5 [Сургалт] (хэрэв шаардлагатай бол)-ын дагуу, эсхүл өөр байдлаар) хариуцлагыг нь хүлээх асуудлуудад хамааралтай алдаатай үйл ажиллагаа, эсхүл засвар үйлчилгээ; эсхүл
- (d) Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд.

Хэрвээ Гүйцэтгэгч нь өөр бусад шалтгаантай гэж үзсэн бол Инженерт нэн даруй мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Инженер нь үүнийг зөвшөөрөх эсхүл шийдвэрлэхдээ 3.7 [Зөвшилцөх, Шийдвэрлэх]-г дагаж мөрднө (мөн, Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-т нийцүүлэх үүднээс, тус Мэдэгдлийн огноо нь 3.7.3-т заасны дагуу хэлцлийн хугацааны хязгаарын эхлэх огноо байна.) Хэрэв дээр дурдсанаас өөр бусад шалтгаан ажилд хамааралтай болохыг харилцан зөвшөөрч, эсхүл тогтоосон бол тухайн ажлыг Инженерийн зааварчилгааны дагуу гүйцэтгэх ёстой байсан хэмээн үзэж Гэрээний 13.3.1 [Зааварчилгааны дагуу өөрчлөлт оруулах]-ыг дагаж мөрднө.

11.3 Доголдол мэдэгдэх хугацааг сунгах

Захиалагч нь дараах тохиолдолд ажил, хэсэг ажил эсхүл ажлын бүрдэл хэсгийн доголдол мэдэгдэх хугацааг сунгах эрхтэй. Үүнд:

(a) Хэрэв ажил, хэсэг ажил, ажлын бүрдэл хэсэг эсхүл Байгууламжийн тоног төхөөрөмжийн гол нэр төрөл нь (ажил хүлээн авсны дараа болон нөхцөл байдлаас хамааран) гэрээний 11.2 [Доголдлыг арилгах зардал]-ын (a)-аас (d) дэх заалтуудын дагуух аливаа асуудалд хамааралтай доголдол эсхүл эвдрэл гэмтлээс шалтгаалан зориулалтаараа ашиглагдах боломжгүй болсон тохиолдолд

(b) 20.2 [Төлбөрийн болон/эсхүл Хугацаа сунгах Нэхэмжлэл] дахь хэсэг хамааралтай бол.

Гэсэн хэдий ч Доголдол мэдэгдэх хугацааг гэрээний мэдээлэлд заасан доголдол мэдэгдэх хугацаа дууссанаас хойш 2 жилээс илүүгээр сунгахгүй.

Хэрэв байгууламжийн тоног төхөөрөмж ба/эсхүл материалыг хүлээлгэн өгөх ба/эсхүл угсралт ажиллагаа нь Гэрээний 8.9 [Захиалагч ажлыг түр зогсоох]-т заасны дагуу (Ажлын түр зогсолт нь Гүйцэтгэгчээс шалтгаалснаас бусад тохиолдолд) эсхүл

Гэрээний 16.1 [Гүйцэтгэгч ажлыг түр зогсоох]-д зааснаар түр зогссон тохиолдолд Ажлын догоилдол мэдэгдэх хугацаанаас хойш 2 жил өнгөрсний дараа үүссэн аливаа эвдрэл, гэмтэл, догоилдолд энэ зүйлд заасан Гүйцэтгэгчийн үүрэг хамаарахгүй ба үндсэн тоног төхөөрөмж ба/эсхүл материалын баталгаат хугацаа дууссан гэж үзнэ.

11.4 Догоиллыг арилгаж чадаагүй тохиолдол

Хэрэв аливаа догоилдол эсхүл эвдрэл, гэмтлийг Гэрээний 11.1 [Дутуу ажлыг гүйцээж, догоиллыг арилгах]-т заасны дагуу арилгах ажлыг Гүйцэтгэгч хэтэрхий удааж, саатуулсан бол Захиалагч (эсхүл түүний нэрийн өмнөөс) тухайн догоиллыг арилгах хугацааг буюу хэдий хугацаанд арилгасан байх ёстойг тогтоож болно. Энэхүү тогтоосон хугацааны талаарх мэдэгдлийг Захиалагч нь (эсхүл түүний нэрийн өмнөөс) Гүйцэтгэгчид хүргүүлэх бөгөөд эвдрэл, гэмтэл, догоиллыг арилгахад шаардлагатай хэмээн үзсэн үндэслэл бүхий хугацааг (холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан үзнэ) уг мэдэгдлээр Гүйцэтгэгчид олгоно.

Хэрвээ Гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд догоилдол эсхүл эвдрэл, гэмтлийг арилгаж чадаагүй ба гэрээний 11.2 [Догоиллыг арилгах зардал]-ийн дагуу Гүйцэтгэгч өөрийн зардлаар догоиллыг засах ажлыг хийж гүйцэтгэх байсан бол Захиалагч нь (Захиалагч өөрийн үзэмжээр):

(a) Гэрээнд заасан шаардагдах арга хэлбэрийн дагуу, Гүйцэтгэгчийн зардлаар тухайн ажлыг өөрөө үргэлжлүүлэн гүйцэтгэх эсхүл бусдаар гүйцэтгүүлэх (аливаа туршилтыг хамруулан) бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь тухайн ажилд хариуцлага хүлээхгүй. Догоилдол эсхүл эвдрэл, гэмтлийг арилгах ажилтай холбоотой Захиалагчид үүссэн үндэслэл бүхий зардлыг Захиалагч нь Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

(b) Эвдрэл, гэмтэлтэй эсхүл догоилдолтой ажлыг хүлээн авах тохиолдолд Захиалагч нь Гэрээний 20.2 [Төлбөр ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу Гэрээний үнээс хасалт хийлгэх эрхтэй. Энэхүү хасалт нь гагцхүү тухайн догоилдол, эвдрэл, гэмтлийг арилгахаар байх ба тус алдаанаас үүдэн бий болсон үнийн бууралтыг Захиалагчид нөхөхөд хүрэлцэх хэмжээний дүнтэй байх ёстой.

(c) Ажлын аливаа хэсгийг Гэрээнд заагдсан зориулалтын дагуу ашиглах боломжгүй болж, тэр нь хэрвээ 13.3.1 [Инженерийн зааварчилгааны дагуу өөрчлөлт оруулах]-т заасан хасалттай холбоотой бол тэрхүү хасалтыг хийлгэхийг Инженерээс шаардах эрхтэй; эсхүл

(d) Хэрэв догоилдол, эсхүл эвдрэл, гэмтэл нь Захиалагчийг тухайн ажлаас бодит ашиг хүртэх боломжгүй болгосон бол Гэрээг бүхэлд нь нэн даруй цуцална (ба гэрээний 15.2 [Гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг цуцлах]-ыг хэрэглэхгүй). Үүний дараа Захиалагч нь гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу ажилд зарцуулсан нийт төлбөр, нэмэлт санхүүжилтийн зардал болон задалж, буулгах зардал, Талбайг чөлөөлөх зардал мөн үндсэн тоног төхөөрөмж, материалыг Гүйцэтгэгчид эргүүлэн өгөх зардлуудыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх эрхтэй.

(e) Дээрх (c) эсхүл (d) дэд заалтын дагуу Захиалагч өөрийн үзэмжээрээ хандах үйл ажиллагаа нь Захиалагчид Гэрээгээр болон өөрөөр олгогдсон аливаа эрхийг хөндөхөөргүй байна.

11.5 Догоиллыг ажлын талбайн гадна арилгах

Хэрэв Гүйцэтгэгч нь догоилдол мэдэгдэх хугацаанд үндсэн тоног төхөөрөмжийн догоилдол эсхүл эвдрэл гэмтэл нь ажлын талбай дээр шуурхай

засагдаж чадахгүй хэмээн үзэж байгаа бол тухайн шалтгааныг дурдсан мэдэгдлийг Захиалагчид хүргүүлэн үндсэн тоног төхөөрөмжийн доголдол эсхүл эвдрэл гэмтлийг ажлын талбайгаас гаргаж засварлах зөвшөөрлийг хүснэ. Тухайн мэдэгдэлд доголдолтой эсхүл эвдрэл гэмтэлтэй үндсэн тоног төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн дурдах ба дараах дэлгэрэнгүй тайлбарыг тусгана:

- (a) засах шаардлагатай доголдол эсхүл эвдрэл, гэмтэл;
- (b) доголдолтой эсхүл эвдрэл, гэмтэлтэй үндсэн тоног төхөөрөмжийг засварлахаар аваачих газар;
- (c) тухайн тоног төхөөрөмжийг зөөвөрлөх тээврийн хэрэгсэл (болон тухайн тээврийн хэрэгслийн даатгал);
- (d) талбайн гадна хийхээр төлөвлөсөн хяналт шалгалт ба туршилт;
- (e) засварлагдсан үндсэн тоног төхөөрөмжийг ажлын талбайд буцаан авч ирэхээс өмнө шаардагдах төлөвлөгөөт хугацаа; ба
- (f) засварлагдсан үндсэн тоног төхөөрөмжийг дахин суурилуулах болон давтан туршихад шаардагдах төлөвлөсөн хугацаа (Гэрээний 7.4 [Гүйцэтгэгчийн хийх туршилт] ба/эсхүл гэрээний 9 [Ажлын төгсгөлд хийх туршилт]-ийн (хэрэв шаардлагатай бол) дагуу);

Гүйцэтгэгч нь Захиалагчаас зохих журмаар нэмэлтээр шаардаж болох аливаа нарийвчилсан мэдээллээр хангах үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь Захиалагч зөвшөөрөл өгмөгц (энэхүү зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийн энэ зүйлд заасан аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй) доголдолтой эсхүл эвдрэл, гэмтэлтэй Үндсэн тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргаж болно. Энэхүү зөвшөөрлийн нөхцөл болгон Захиалагч нь Гүйцэтгэгчийг доголдол эсхүл эвдрэл, гэмтэлтэй үндсэн тоног төхөөрөмжийг бүрэн солих хэмжээний үнийн дүнгээр Гүйцэтгэлийн баталгааг нэмэгдүүлэхийг шаардаж болно.

11.6 Доголдлыг арилгасны дараах туршилтууд

Аливаа ажлын доголдол эсхүл эвдрэл, гэмтлийг арилгаснаас хойш 7 хоногийн дотор Гүйцэтгэгч нь ажил, хэсэг ажил, ажлын бүрдэл ба/эсхүл үндсэн тоног төхөөрөмжийн засварлагдсан байдлын тухай болон санал болгож буй давтан туршилтын талаарх (9-р зүйл [Ажил дуусмагц хийх туршилт]-ийн дагуу) мэдэгдлийг Инженерт хүргүүлнэ. Инженер нь тус мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Гүйцэтгэгчид дараах хариу мэдэгдлийг хүргүүлнэ:

- (a) санал болгосон туршилтыг хийхийг зөвшөөрсөн; эсхүл
- (b) засварлагдсан ажил, хэсэг ажил ба/эсхүл үндсэн тоног төхөөрөмж нь Гэрээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд зайлшгүй хийгдэх ёстой давтан туршилт явуулахыг зааварчилна.

Хэрэв Гүйцэтгэгч 7 хоногийн дотор мэдэгдэл хүргүүлээгүй бол Инженер нь доголдол эсхүл эвдрэл, гэмтэл засварлагдсанаас хойш 14 хоногийн дараа засварлагдсан ажил, хэсэг ажил, ажлын бүрдэл ба/эсхүл үндсэн тоног төхөөрөмж нь Гэрээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд зайлшгүй хийгдэх ёстой давтан туршилт явуулахыг зааварчилсан Мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

Гэрээний 11.2 [Доголдлыг арилгах зардал]-т заасны дагуу засварын ажлын зардлыг хариуцах тал нь эрсдэл болон зардлыг хариуцахаас бусдаар энэхүү

Гэрээнийээр явуулж буй бүх давтан туршилт нь өмнөх туршилтад хэрэглэгдэж байсан нөхцөлөөр хийгдэнэ.

11.7 Ажил хүлээн авсны дараа талбайд нэвтрэх эрх

Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш 28 хоногийн хугацаанд Захиалагчаас аюулгүй байдлыг хангах зорилготой хязгаарлалт тавьснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь шаардлагатай тохиолдолд энэхүү Зүйлийн заалтад нийцүүлэн ажлын талбайд нэвтрэх эрхтэй байна.

Холбогдох доголдол мэдэгдэх хугацаанд Гүйцэтгэгч нь ажлын талбайн аль нэг хэсэгт нэвтрэх үедээ:

(а) Гүйцэтгэгч нь Захиалагчид ажлын талбайн нэвтрэн орох гэж буй хэсэг, ийнхүү нэвтрэх шалтгаан ба Гүйцэтгэгчийн санал болгож буй нэвтрэх огноо зэргийг дурдсан Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлэн, нэвтрэх хүсэлт гаргана. Энэхүү Мэдэгдлийг Захиалагчаас тавьсан аюулгүй байдлыг хангах зорилготой хязгаарлалт зэрэг холбогдох бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэж ажлын талбайд нэвтрэхээр санал болгосон өдрөөс өмнө, тохиромжтой хугацаанд өгсөн байх ёстой.

(б) Захиалагч нь Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор, Гүйцэтгэгчид дараах хариу мэдэгдлийг хүргүүлнэ:

(1) Гүйцэтгэгчийн хүсэлтийг зөвшөөрсөн тухай Захиалагчийн зөвшөөрлийг; эсхүл

(2) Үндэслэл бүхий өөр өдөр (өдруудийг) санал болгон, холбогдох шалтгаанаа дурдана. Хэрэв Захиалагч нь 7 хоногийн дотор энэхүү мэдэгдлээ хүргүүлээгүй бол түүнийг Гүйцэтгэгчийн мэдэгдэлд тусгасан нэвтрэхээр санал болгосон огноонд нэвтрэх эрхийг Гүйцэтгэгчид олгосон хэмээн үзнэ.

Хэрэв, ажилд Гүйцэтгэгч нэвтрэн орохыг зөвшөөрөхдөө Захиалагчаас гаргасан аливаа үндэслэлгүй saatlaas шалтгаалан Гүйцэтгэгч нь нэмэлт зардал гаргасан бол Гэрээний 20.2 [Төлбөр ба/эсхүл Хугацаа сунгахтай холбоотой нэхэмжлэл]-т заасны дагуу аливаа ийм өртөг болон ашгаа төлүүлэх эрхтэй.

11.8 Гүйцэтгэгч судалгаа хийх

Гүйцэтгэгч нь Инженерийн заавраар доголдол үүссэн шалтгааныг түүний удирдлага доор судална. Гүйцэтгэгч нь судалгаагаа Инженерийн заавар болгосон өдөр (өдруүд)-д эсхүл Инженертэй тохиролцсон өдөр (өдруүд)-д хийнэ.

Гэрээний 11.2 [Доголдол арилгах зардал]-т заасны дагуу Гүйцэтгэгч нь зардлыг хариуцахааргүй бол Гэрээний 20.2 [Төлбөр ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-д заасны дагуу судалгаатай холбоотой үүсэх Өртөг болон ашгийн төлбөрийг авах эрхтэй.

Хэрэв Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнийийн дагуу судалгааг хийгээгүй бол Захиалагчийн ажилтан уг судалгааг хийж болно. Ийнхүү судалгаа хийгдэх бол Гүйцэтгэгчид судалгаа хийгдэх өдрийн талаар Мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Гүйцэтгэгч өөрийн зардлаараа тус судалгаанд оролцож болно. Хэрвээ Гэрээний 11.2 [Доголдол арилгах зардал]-ийн дагуу доголдол нь Гүйцэтгэгчийн зардлаар засварлагдсан бол Захиалагч нь Гэрээний 20.2 [Төлбөр ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийн дагуу Захиалагчаас судалгаатай холбоотой үндэслэлтэйгээр гарсан зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

11.9 Гүйцэтгэлийн гэрчилгээ

Инженер нь Гүйцэтгэгчид Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дууссан өдрийг заасан Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулан өгөх хүртэл Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзэхгүй.

Инженер нь Гүйцэтгэгчид Доголдол мэдэгдэх хугацаа дууссанаас хойш 28 хоногийн дараа эсхүл Гүйцэтгэгч нь дараах нөхцөлүүдийг хангамагц аль болох хурдан хугацаанд Гүйцэтгэлийн гэрчилгээг олгоно (Захиалагч болон Маргаанаас Зайлсхийх, Шийдвэрлэх Зөвлөлд илгээх хуулбар хувийн хамт):

(a) Гүйцэтгэгчийн бүх баримт бичгийг хүргүүлсэн; ба

(b) Гэрээнд заасны дагуу бүх ажлыг дуусгаж, туршилт явуулсан (илэрсэн аливаа доголдлыг засссанг хамааруулна)

Хэрэв Инженер нь 28 хоногийн дотор Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулаагүй бол энэхүү гэрээнийийн дагуу Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулах ёстой байсан өдрөөс хойш 28 дахь хоногт Гүйцэтгэлийн гэрчилгээг олгогдсон хэмээн үзнэ.

Ажил хүлээн авсан гэдгийг зөвхөн Гүйцэтгэлийн гэрчилгээгээр нотолно.

11.10 Гүйцэтгээгүй үүрэг

Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосны дараа тухайн үед биелэгдээгүй үлдсэн аливаа үүргээ биелүүлэх талууд тус бүрийн үүрэг хариуцлага хэвээр үлдэнэ. Биелэгдээгүй ажил үүргийн хэмжээ болон нөхцөл байдлыг тодорхойлохын тулд Гэрээг хүчинтэй хэвээр хэмээн үзнэ.

Гэсэн хэдий ч Үндсэн тоног төхөөрөмжийн хувьд хуулиар хориглосон, залилан үйлдсэн, хайхрамжгүй хандсан, санаатайгаар алдаа гаргах, эсхүл зүй бус үйлдлээс бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь Үндсэн тоног төхөөрөмжийн Доголдол мэдэгдэх хугацаа дуусгавар болсноос хойш 2 жилээс дээш хугацааны дараа үүссэн аливаа доголдол, эсхүл эвдрэл, гэмтэлд хариуцлага хүлээхгүй.

11.11 Ажлын талбайг чөлөөлөх

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээг хүлээн авсан даруйдаа:

(a) Гүйцэтгэгчийн үлдсэн тоног төхөөрөмж, илүүдэл материал, эvdэрхий сэг, хог, ажлын талбай дээр түр хийгдсэн ажлуудыг цэвэрлэн;

(b) ажил гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд өртсөн ба Байнгын ажил явагдаагүй ажлын талбайн бүх хэсгийг нөхөн сэргээж;

(c) ажлын талбайг Захиалагчийн шаардлагад заасан (хэрэв заагаагүй бол аюулгүй, цэвэрхэн) нөхцөлтэй болгон үлдээнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээгээг хүргүүлснээс хойш 28 хоногийн дотор дээрх (a), (b) ба/эсхүл (c) заалтуудыг хэрэгжүүлээгүй бол Захиалагч нь ажлын талбай дээр үлдсэн аливаа зүйлийг худалдаж (холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн хэмжээгээр), эсхүл өөр байдлаар арилгаж болох ба/эсхүл Ажлын талбайг (шаардлагатай бол) Гүйцэтгэгчийн зардлаар цэвэрлэж эсхүл нөхөн сэргээж болно.

Захиалагч нь дээрх зүйлсийг худалдах, эсхүл өөр байдлаар ашиглах, эсхүл ажлын талбайг цэвэрлэх, нөхөн сэргээхтэй холбогдон, эсхүл тэдгээрт хамааралтайгаар, үндэслэлтэйгээр гаргасан зардлаас тэдгээрийг худалдсанаас олон мөнгөтэй тэнцүү дүнг хассан (хэрэв худалдсан бол) зардлыг Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.

12. Ажлын хэмжилт ба өртгийг тодорхойлох

12.1 Хэмжилт хийгдэх ажлууд

Ажлын тоо хэмжээг болон төлбөрийн дүнг тооцоолоход энэхүү зүйлийн дагаж мөрднө.

Ажлын талбайд гүйцэтгэсэн Ажлын аливаа бурдэл хэсгийн тоо хэмжээг тооцох шаардлага Инженерт гарсан тохиолдолд тэрээр 7-оос багагүй өдрийн хугацаанд Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлдээ хэмжилт хийгдэх ажлын хэсгүүд, огноо, ажлын талбай дахь байршил зэргийг тодорхойлон тусгана. Гүйцэтгэгчтэй өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд ажлын талбай дээрх хэмжилтийг тухайн өдөр хийх ба Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь:

(a) Инженерт туслалцаа дэмжлэгийг үзүүлэх зорилготойгоор ур чадвар бүхий туршлагатай шаардлага хангасан төлөөлөгчийг илгээх эсхүл өөрөө оролцох ба хэмжилтийн талаар харилцан зөвшилцэлд хүрч ажиллахыг эрмэлзэнэ.

(b) Инженерээс хүссэн/шаардсан аливаа тайлан, баримт бичиг, мэдээллээр хангана.

Хэрэв Инженерийн мэдэгдэлд (эсхүл Гүйцэтгэгчтэй өөрөөр харилцан тохиролцсоны дагуу) дурдсан байршил болон хугацаанд Гүйцэтгэгч өөрөө оролцох үүргээ биелүүлээгүй эсхүл төлөөлөгчөө илгээгээгүй бол Инженерийн (эсхүл Инженерийн өмнөөс) гүйцэтгэсэн хэмжилтийн үед Гүйцэтгэгчийг байлцсан гэж үзэх бөгөөд мөн хэмжилтийн үнэн зөв, бодит байдлыг Гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Бүртгэл тайлангаас ажлын үндсэн ажлын аливаа хэсгийг тоо хэмжээг тооцох бол Захиалагчийн шаардлагад тусгасан байх ба Гэрээнд өөрөөр заагаагүй бол уг бүртгэл тайланг Инженер боловсруулна.

Уг ажлын хэсгийн бүртгэл тайланг Инженер боловсруулсан бол тэрээр 7-оос багагүй өдрийн хугацаанд Гүйцэтгэгчид Мэдэгдэл хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлдээ Инженерээс хэмжилтийг хийхэд байлцах, бүртгэл тайланг харилцан зөвшилцэх Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн очих ажлын талбай дахь байршил болон огноог тодорхойлон тусгана.

Хэрэв Инженерийн мэдэгдэлд (эсхүл Гүйцэтгэгчтэй өөрөөр харилцан тохиролцсоны дагуу) дурдсан байршил болон хугацаанд Гүйцэтгэгч өөрөө оролцох үүргээ биелүүлээгүй эсхүл төлөөлөгчөө илгээгээгүй бол хэмжилтийн үнэн зөв, бодит байдлыг Гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Хэрвээ ажлын аливаа хэсгийн тоо хэмжээг хэмжих ажлын хүрээнд Гүйцэтгэгч нь ажлын талбай дахь хэмжилтэд байлцсан эсхүл хэмжилтийн бүртгэл тайлантай танилцаж судалсан боловч хэмжилтийн талаар Инженер болон Гүйцэтгэгч нар харилцан зөвшилцэж чадаагүй бол Гүйцэтгэгч нь ажлын талбайд хийгдсэн хэмжилт эсхүл хэмжилтийн бүртгэл тайланг буруу гэж үзэж байгаа шалтгаануудыг дурдсан мэдэгдлийг Инженерт хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь уг мэдэгдлийг ажлын талбайд хэмжилт хийхэд байлцсан эсхүл хэмжилтийн бүртгэл тайлан хийгдсэн өдрөөс хойш 14 хоногт багтаан Инженерт хүргүүлээгүй бол уг хэмжилтийг үнэн зөв, бодит хэмээн Гүйцэтгэгчийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Энэхүү хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авсаны дараа, хэрвээ уг хэмжилт нь 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] хэсгийн сүүлийн хэсэгт хамааралгүй бол Инженер нь:

- хэмжилтийг харилцан зөвшилцөх эсхүл тогтоох зорилготойгоор 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-г баримтлан ажиллах; мөн
 - 3.7.3 [Хугацааны хязгаар] хэсгийн заалтыг хангах үүднээс Гүйцэтгэгчийн Мэдэгдлийг Инженер хүлээн авсан огноо нь 3.7.3-т заасан хэлцлийн хугацааны хязгаар эхлэх огноо байна.

Энэхүү хэмжилтийг харилцан зөвшилцөх эсхүл тогтоох хүртэл хугацаанд Инженер нь дундын төлбрийн гэрчилгээнүүдэд ашиглах зорилготойгоор урьдчилсан хэмжилтийг тогтоосон байх шаардлагатай.

12.2 Хэмжилт хийх аргачлал

Хэмжилт хийх аргачлал нь Гэрээний мэдээлэлд тусгагдсаны дагуу байх шаардлагатай бөгөөд хэрвээ тусгаагдаагүй бол Тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад холбогдох Хуваарыт (Хуваариудад) нийтэй байхаар шаардлагатай.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэмжилтийг ажлын үндсэн ажлын ажилбар тус бүрийн цэвэр бодит тоо хэмжээгээр бодох бөгөөд тоо хэмжээг тоймлох буюу ерөнхийгөөр авах, хорогдуулах буюу буулгаж тооцох, үр ашиггүй байдал буюу зохисгүйгээр ашиглахыг хориглоно.

12.3 Гүйцэтгэсэн ажлын өртөг/үнэлгээг тодорхойлох

Гэрээнд өөрөөр заагаагүй бол Инженер нь 12.1 [Гүйцэтгэсэн Ажлын тоог хэмжих] ба 12.2 [Хэмжилт хийх аргачлал]-т тус тус заасны дагуу зөвшилцөж эсхүл тогтоосон аргачлал болон ажилбар тус бүрийн харгалзах нэгж үнэ эсхүл үнэлгээг ашиглан ажилбар зүйл тус бүрийн үнийг тооцоолно.

Ажилбар тус бүрийн зохих нэгж үнэ эсхүл үнэлгээ нь Тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад хуваарыт ажилбар тус бүр дээр тусгагдсан нэгж үнэ эсхүл үнэлгээ байх ба хэрвээ энэхүү ажилбар нь тусгагдаагүй бол ижил төстэй ажлын ажилбарын харгалзах үнэ эсхүл үнэлгээг ашиглана.

Тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад хуваарыт ажилбарыг дурдсан боловч харгалзах нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтоогоогүй бол тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад хуваарыт тусгагдсан бусад нэгж үнэ эсхүл үнэлгээнд багтсан гэж үзнэ.

Дор дурдсан тохиолдлуудад ажилбарт харгалзах шинэ нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтооно:

(a) Ажилбар нь тодорхойлогоогүй бөгөөд энэхүү ажилбарын нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтоогдоогүй, мөн Тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл эсхүл бусад Хуваарыт ижил төстэй ажилбар байхгүйн улмаас нэгж үнэ эсхүл үнэлгээ тусгагдаагүй, эсхүл Гэрээнд заагдсан аливаа бусад ажилбартай ижил төстэй нөхцөл байдалд гүйцэтгэгдээгүй бол;

(b) (i) ажилбарын тоо хэмжээ нь тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад хуваарыт заасан тухайн ажилбарын тоо хэмжээнээс 10%-иас илүү хувиар өссөн бол;

(ii) уг ажилбарын энэхүү өөрчлөлтийг Тоо хэмжээнд сууринсан үнэ бүрдэл болон бусад Хуваарыт заасан нэгж үнэ эсхүл үнэлгээгээр үржүүлэхэд Гэрээний зөвшөөрөгдсөнгийн 0,01%-аас хэтэрч байвал;

(iii) энэхүү өөрчлөлт нь уг ажилбарын нэгжид ногдох зардлыг шууд хамааралтайгаар 1%-аас илүү хувиар өсгөсөн бол;

(iv) уг ажилбарын хувьд Тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл болон бусад Хуваарьт “тогтмол үнэ бүхий”, “тогтмол хураамж” эсхүл үүнтэй ижил төстэй байдлаар тоо хэмжээний хувьд өөрчлөгдхөд үнэ болон үнэлгээг өөрчлөгдхөгүй байхаар тусгайлан заагаагүй бол; болон/эсхүл

(c) 13 [Гэрээний өөрчлөлт болон Тохируулга] зүйлд болон дээр дурдсан (a) эсхүл (b) заалтад заасны дагуу даалгавраар уг ажил нь өгөгдсөн бол.

Аливаа шинэ нэгж үнэ эсхүл үнэлгээг дээр дурдсан (a), (b), (c) дэд хэсгүүдийн хамаарал бүхий хэсэгт заасан нөхцөл байдлуудад нийцүүлэн холбогдох Тоо хэмжээнд суурилсан үнэ бүрдэл болон бусад Хуваарьт заасан харгалзах нэгж үнэ эсхүл үнэлгээд үндэслэн тооцож гаргана.

Хэрвээ шинэ нэгж үнэ эсхүл үнэлгээг тооцоход шаардлагатай харгалзах үнэ эсхүл үнэлгээ байхгүй бол түүнийг тооцохдоо ажлыг/ажилбарыг гүйцэтгэхэд Зардал болон Гэрээний мэдээлэлд заасан холбогдох ашгийн хувь (хэрвээ заагаагүй бол 5%-иар тооцно) болон аливаа бусад холбогдох асуудлыг харгалзан үзнэ.

Хэрвээ аливаа ажилбарын нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтоохдоо Инженер болон Гүйцэтгэгч нар харилцан зөвшилцэж чадахгүй бол Гүйцэтгэгч нь хүлээн зөвшөөрөхгүй шалтгаанаа тайлбарлан тусгасан Мэдэгдлийг Инженерт хүргүүлнэ. Энэхүү хэсэгт заасны дагуу уг Гүйцэтгэгчийн Мэдэгдлийг хүлээн авсаны дараа хэрвээ 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх] дэх заалтын хамгийн сүүлийн дэд заалтад заасны дагуу уг нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтоогоогүй байвал Инженер нь:

- холбогдох нэгж үнэ эсхүл үнэлгээг харилцан зөвшилцэх эсхүл тогтоох зорилготойгоор 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-г баримтлан ажиллана.
- Гүйцэтгэгчийн мэдэгдлийг Инженер хүлээн авсан огноо нь 3.7.3 [Хугацааны хязгаар] дахь заалтыг хангах үүднээс 3.7.3-т заасан хэлцлийн хугацааны хязгаар эхлэх огноо байна.

Нэгж үнэ эсхүл үнэлгээг харилцан зөвшилцэж тогтоох хүртэл хугацаанд Инженер нь дундын төлбөрийн гэрчилгээнүүдэд ашиглах зорилготойгоор урьдчилсан нэгж үнэ эсхүл үнэлгээг тогтоосон байх шаардлагатай.

12.4 Гүйцэтгэх ажлаас хасалт хийх

Хэрвээ аливаа ажлын хасалт нь Гэрээний өөрчлөлтийн хэсэг (эсхүл бүхлээрээ) болсон бөгөөд:

- (a) үнийн дүнг өөрөөр тохироогүй бол;
- (b) хэрвээ уг ажлын хасалт хийгээгүй бол уг ажлын зардал нь Гэрээний зөвшөөрөгдсөнгийн бүрдэл хэсэгт багтах байсан боловч хасалт хийснээр холбогдох зардал Гүйцэтгэгчээс гарсан (эсхүл гарч буй) бол;
- (c) уг ажлын хасалт хийснээр уг дүн нь Гэрээний үнийн бүрдэл хэсэгт багтаагүй (эсхүл багтахааргүй байгаа) бол;
- (d) энэхүү зардал нь аливаа орлуулсан ажлын үнийн дунд багтаагүй гэж үзсэн бол;

Гүйцэтгэгч нь холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг нотлох баримтууд, тайлангийн хамтаар 13.3.1 [Инженерийн даалгаврын дагуу Гэрээний өөрчлөлт хийх]-ийн (c) дэд заалтад заасны дагуу гаргах Гүйцэтгэгчийн саналдаа тусган Инженерт хүргүүлнэ.

13. Гэрээний Өөрчлөлт ба Тохируулга

13.1 Өөрчлөлт оруулах эрх

Инженер нь Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө, хэдийд ч Гэрээний 13.3 [Өөрчлөлт хийх журам]-ийн дагуу Өөрчлөлт оруулахыг санаачилж болно.

Гэрээний 11.4 [Доголдлыг арилгаж чадахгүй байх]-д зааснаас бусад тохиолдолд Өөрчлөлт нь, Захиалагчийн, эсхүл Талууд өөрөөр тохиролцоогүй бол бусад этгээдийн гүйцэтгэх аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

Гүйцэтгэгч нь доорх зүйлсийг (нарийвчилсан нэмэлт мэдээллийн хамт) тусгасан мэдэгдлийг Инженерт цаг тухайд нь өгөөгүйгээс бусад тохиолдолд, Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн дагуу зааварчлагдсан аливаа өөрчлөлтийг оруулах үүрэгтэй ба өөрчлөлтийг сааталгүй бөгөөд зохих хэмжээнд шуурхай оруулна:

(а) захиалагчийн шаардлагад тодорхойлсон ажлын цар хэмжээ ба шинж чанарыг харгалзан үзэхэд, өөрчлөгдсөн ажил нь Урьдчилан таамаглах боломжгүй байсан;

(б) Гүйцэтгэгч нь Өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Бараа, материалыг шуурхай олж бэлтгэх боломжгүй; эсхүл

(с) энэ нь Гэрээний 4.8 [Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг] ба/эсхүл Гэрээний 4.18 [Байгаль орчныг хамгаалах]-ыг даган биелүүлэх Гүйцэтгэгчийн боломж нөхцөлд сөргөөр нөлөөлөх байсан.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа Инженер нь зааварчилгаагаа цуцалсан, баталгаажуулсан, эсхүл өөрчилсөн тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хариу илгээнэ. Ийнхүү баталгаажуулсан, эсхүл өөрчилсөн талаарх аливаа зааварчилгааг Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн дагуу өгсөн зааварчилгаа гэж үзнэ.

Аливаа Өөрчлөлт тус бүр нь дараах зүйлсийг багтаасан байж болно:

(1) Гэрээнд тусгагдсан аливаа нэр төрлийн ажлын тоо хэмжээний өөрчлөлтүүд (гэхдээ ийм өөрчлөлт нь заавал Өөрчлөлт хэмээн тооцогдох албагүй);

(2) аливаа нэр төрлийн ажлын чанарын болон бусад шинж байдлын өөрчлөлт;

(3) Ажлын аливаа бүрдэх хэсгийн түвшин, байршил ба/эсхүл хэмжээсийн өөрчлөлт;

(4) Талуудын тохиролцоогүйгээр бусдын хийж гүйцэтгэхээс бусад, аливаа ажлын орхигдуулалт;

(5) Ажлын төгсгөлд явуулах холбогдох туршилт, хяналтын өрөмдлөг, сорилт ба хайгуулын ажлыг багтаасан, Байнгын ажилд шаардлагатай аливаа нэмэлт ажил, үндсэн тоног төхөөрөмж, Материал, эсхүл ажил үйлчилгээ; эсхүл

(6) Ажлыг гүйцэтгэх хугацааны эсхүл дэс дарааллын өөрчлөлтүүд.

Инженерээс Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн дагуу өөрчлөлт оруулах зааварчилгааг өгөөгүй байхад, Гүйцэтгэгч нь байнгын ажилд ямар нэгэн нэмэлт ба/эсхүл өөрчлөлт оруулах ёсгүй.

13.2 Техникийн оновчтой шийдэл

Гүйцэтгэгч нь хэдийд ч Инженерт бичгээр үйлдсэн саналыг (гүйцэтгэгчийн бодлоор) хүргүүлэх эрхтэй, хэрэв батлагдвал:

- (a) ажлыг дуусгах явцыг хурдасгах;
- (b) Ажлыг гүйцэтгэх, ашиглах болон засвар арчлалтыг хийх Захиалагчийн зардлыг бууруулах;
- (c) хийгдэж дууссан ажлын үр ашиг эсхүл үнэ цэнийг Захиалагчийн талд нэмэгдүүлэх; эсхүл
- (d) өөр байдлаар Захиалагчид үр ашиг өгөх.

Саналыг Гүйцэтгэгчийн зардлаар бэлтгэх ба тус санал нь Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн (a)-аас (c) заалтад тусгасан зүйлсийг багтаасан байна.

Инженер нь ийм саналыг хүлээн авсны дараа, өөрийн зөвшөөрлийг олгосон мэдэгдлийг аль болох боломжит хурдан хугацаанд Гүйцэтгэгчид илгээн, эсхүл өөр байдлаар хариу өгнө. Инженерийн зөвшөөрөл, эсхүл бусад шийдвэрээр өгөх хариу нь дан ганц Захиалагчийн үзэмжээр шийдэгдэнэ. Гүйцэтгэгч нь хариу хүлээж байхдаа ямар ч ажлыг saatуулах ёсгүй.

Хэрэв Инженер нь тухайн саналд өөрийн зөвшөөрлийг тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр өгсөн бол, дараа нь өөрчлөлт оруулах зааварчилгааг Инженер өгнө. Үүний дараа Гүйцэтгэгч нь Инженерээс үндэслэлтэйгээр шаардаж болох нэмэлт дэлгэрэнгүй мэдээллүүдийг хүргүүлэх ба Тусгай нөхцөлд тусгагдсан Талуудын хооронд үр ашиг, зардал ба/эсхүл saatlyg хуваарилах (хэрэв байгаа бол) асуудлыг Инженер авч үзэхийг багтаасан Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар хийгдэх өөрчлөлт]-ийн сүүлийн догол мөртийг хэрэглэнэ.

Хэрэв энэхүү заалтын дагуу гаргасан Инженерээс зөвшөөрсөн саналд Байнгын ажлын хэсгийн зураг төслийн өөрчлөлт орсон бол, Талууд тохиролцсоноос бусад тохиолдолд:

- (1) Гүйцэтгэгч нь энэ хэсгийн зураг төслийг өөрийн зардлаар боловсруулах; ба
- (2) Гэрээний 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг]-ийн (a)-аас (h) заалтуудыг хэрэглэнэ.

13.3 Өөрчлөлт оруулах журам

Инженер нь Гэрээний 13.1 [Өөрчлөлт оруулах эрх]-тэй уялдуулан, доорх заалтуудын аль нэгийн дагуу Өөрчлөлтийг гаргана:

13.3.1 Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт

Инженер нь (оруулах шаардлагатай өөрчлөлт болон Зардлыг бүртгэхэд тавигдах аливаа шаардлагуудыг тусгасан) Мэдэгдлийг Гэрээний 3.5 [Инженерийн зааварчилгаа]-ийн дагуу Гүйцэтгэгчид хүргүүлэн, Өөрчлөлт оруулахыг зааварчилж болно.

Гүйцэтгэгч нь Өөрчлөлтийг оруулж эхлэх ба Инженерийн зааварчилгааг хүлээн авснаас хойш 28 хоногийн (эсхүл Гүйцэтгэгч санал болгож, Инженер зөвшөөрсөн өөр хугацаанд) дотор доорх зүйлсийг хамруулсан нарийвчилсан мэдээллийг Инженерт хүргүүлнэ:

- (а) Гүйцэтгэгчийн хэрэглэж буй, эсхүл хэрэглэх нөөц болон ажлын аргачлалыг багтаасан гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэх гэж буй өөрчлөгдсөн ажлын нэр төрөл;

(b) ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө ба 8.3 [Ажлын хөтөлбөр]-т заасны дагуу ажлын хөтөлбөрт болон ажил дуусгах хугацаанд оруулах аливаа шаардлагатай өөрчлөлтүүдийн (хэрэв байгаа бол) талаарх Гүйцэтгэгчийн санал; ба

(c) Гэрээний 12 [Ажлын хэмжилт ба өртгийг тодорхойлох]-д заасны дагуу дагуу Гэрээний өөрчлөлтэд үнэлгээ, тооцоог хийх байдлаар Гэрээний үнэд тохируулга хийх Гүйцэтгэгчийн саналыг холбогдох мэдээллийн хамт (үүнд аливаа тооцоолсон тоо хэмжээний холбогдох мэдээллүүд болон хэрвээ Ажил дуусах огноонд аливаа шаардлагатай өөрчлөлтийг хийсний улмаас Гүйцэтгэгчээс Зардал гарсан эсхүл гарах бол Гүйцэтгэгчийн зүгээс Гүйцэтгэгч нь авах эрхтэй гэж үзсэн нэмэлт төлбөрийн дүнг (хэрвээ байвал) тусган харуулна). Хэрэв Талууд нь бусад этгээдийн гүйцэтгэх аливаа ажлын орхигдуулалтыг тохиролцсон бол, орхигдуулалтаас шалтгаалан Гүйцэтгэгчид учирсан (эсхүл учирч болох) аливаа ашгийн алдагдал болон бусад алдагдал ба хохирлын дүнг Гүйцэтгэгчийн саналд мөн оруулж болно.

Үүний дараа Гүйцэтгэгч нь Инженерээс үндэслэлтэйгээр шаардаж болох аливаа нэмэлт мэдээллийг хүргүүлнэ.

Инженер дараа нь доорх зүйлсийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр Гэрээний 3.7 [Тохиролцох, эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллана:

(1) Хугацаа сунгах нэхэмжлэл, хэрэв байгаа бол; ба/эсхүл

(2) Гэрээний үнийн тохируулга (өөрчлөгдсөн ажлыг хэмжсэн тоо хэмжээг ашиглан, Зүйл 12 [Ажлын хэмжилт ба өртгийг тодорхойлох]-ийн дагуу Өөрчлөлтийг үнэлж, өртгийг тодорхойлсныг оролцуулсан)

(ба Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийн хангах зорилгоор, Гүйцэтгэгчийн танилцуулгыг (шаардсан аливаа нэмэлт мэдээллийг оролцуулан) Инженер хүлээн авсан огноо нь Гэрээний 3.7.3-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарын эхлэх огноо болно.) Гүйцэтгэгч нь Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийг дагаж мөрдөх ямар нэгэн шаардлагагүйгээр, энэхүү Хугацаа сунгалтын ба/эсхүл Гэрээний үнийн тохируулгын эрхтэй байна.

13.3.2 Санал ирүүлэх хүсэлтийн дагуу гэрээнд өөрчлөлт оруулах

Инженер нь (төлөвлөж буй өөрчлөлтийг тодорхой тусгасан) мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө, Өөрчлөлт оруулахыг зааварчлахаас өмнө, түүнээс саналаа ирүүлэх хүсэлт тавьж болно.

Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш аль болох түргэн хугацаанд, доор дурдсаны аль нэгээр нь хариу өгнө:

(a) Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн (a)-аас (c) заалтад заасан асуудлуудыг тусгасан саналаа хүргүүлэх; эсхүл

(b) Гэрээний 13.1 [Өөрчлөлт оруулах эрх]-ийн (a)-аас (c) заалтад заасан асуудлуудыг үндэслэн, яагаад Гүйцэтгэгч дагаж мөрдөх боломжгүй талаарх шалтгаануудаа (хэрэв үнэхээр тийм бол) хүргүүлэх.

Инженер нь ийм саналыг хүлээн авсны дараа, өөрийн зөвшөөрлийг олгосон Мэдэгдлийг аль болох боломжит хурдан хугацаанд Гүйцэтгэгчид илгээн, эсхүл өөр байдлаар хариу өгнө. Гүйцэтгэгч нь хариу хүлээж байхдаа ямар ч ажлыг саатуулах ёсгүй.

Хэрэв Инженер нь тухайн саналд өөрийн зөвшөөрлийг тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр өгсөн бол, дараа нь өөрчлөлт оруулах зааварчилгааг Инженер өгнө. Үүний дараа Гүйцэтгэгч нь Инженерээс үндэслэлтэйгээр шаардаж болох нэмэлт

дэлгэрэнгүй мэдээллүүдийг хүргүүлэх ба Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар хийгдэх өөрчлөлт]-ийн сүүлийн догол мөртийг хэрэглэнэ.

Хэрэв Инженер нь тухайн саналд тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр зөвшөөрөл өгөөгүй ба, хэрэв Гүйцэтгэгч нь саналаа хүргүүлснээс шалтгаалан Зардал гаргасан бол, Гүйцэтгэгч нь Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийн дагуу энэ зардлаа төлүүлэх эрхтэй.

13.4 Нөөц хөрөнгө

Нөөц хөрөнгө тус бүрийг зөвхөн Инженерийн зааварчилгааны дагуу бүхлээр нь буюу хэсэгчилсэн байдлаар хэрэглэх ба Гэрээний үнэд зохих байдлаар тохируулга хийгдэнэ. Гүйцэтгэгчид төлөгдсөн нийт үнийн дунд гагцхүү Инженерээс зааварчилсан Нөөц хөрөнгийн дүнтэй холбоотой ханган нийлүүлэлт эсхүл ажил үйлчилгээний дүнг хамруулан тооцно.

Нөөц хөрөнгө тус бүрд Инженер дараах зүйлсийг зааварчилж болно:

(а) Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажил (Үндсэн тоног төхөөрөмж, Материал эсхүл үзүүлэх үйлчилгээг оролцуулан) ба Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар хийгдсэн өөрчлөлт]-ийн дагуу тохиролцох эсхүл шийдвэрлэх ёстой Гэрээний үнийн өөрчлөлт; ба/эсхүл

(б) Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгчээс (5.2 [Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч]-т заасны дагуу болон бусад байдлаар) нийлүүлсэн, Гүйцэтгэгч худалдаж авах үндсэн тоног төхөөрөмж, материал, ажил эсхүл үзүүлэх үйлчилгээнүүд; болон эдгээрийн үнийн дүнг Гэрээний үнэд дараах байдлаар тусгаж оруулна:

(1) Гүйцэтгэгчийн төлсөн (эсхүл төлөх ёстой) бодит дүн; ба

(2) холбогдох Төлбөрийн хуваарь тусгагдсан зохих хувь хэмжээг (хэрэв байгаа бол) ашиглан, эдгээр бодит дүнгээс хувилан тооцож гаргасан, нэмэгдэл зардал болон ашгийн дүн. Хэрэв ийм хувь байхгүй бол Гэрээний мэдээлэлд заасан хувийг ашиглана.

Хэрэв Инженер нь дээрх (а) ба/эсхүл (б) заалтын дагуу Гүйцэтгэгчид зааварчилсан бол энэхүү зааварчилгаанд, хийгдэх ажлын, эсхүл худалдан авах үндсэн тоног төхөөрөмж, материал, ажил болон үйлчилгээний бүх (эсхүл зарим) нэр төрөлд өгөх Гүйцэтгэгчийн ханган нийлүүлэгчдийн ба/эсхүл Туслан гүйцэтгэгчдийн үнийн саналыг хүргүүлэхтэй холбогдсон Гүйцэтгэгчийн шаардлагыг оруулж болно. Дараа нь, Инженер нэг бол, эдгээр үнийн саналын нэгийг зөвшөөрөхийг (гэхдээ, энэхүү зааварчилгааг гэрээний 5.2 [Нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгч]-ийн дагуу зааварчилгаа гэж үзэхгүй) Гүйцэтгэгчид зааварчилсан, эсхүл зааварчилгаа хүчингүй болгосон Мэдэгдлийг илгээн, хариу өгч болно. Хэрэв Инженер нь үнийн саналыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хариу өгөөгүй бол, Гүйцэтгэгч нь эдгээр үнийн саналын алийт нь ч өөрийн үзэмжээр сонгох эрхтэй.

Нөөц хөрөнгөтэй холбоотой тайлан бүрд холбогдох нэхэмжлэл, ваучер, дансны болон төлбөрийн баримт зэргийг Нөөц хөрөнгийн нотолгоо болгон хавсаргана.

13.5 Өдрөөр тооцох ажил

Хэрэв Гэрээнд Өдрөөр тооцох ажлын хуваарь тусгагдаагүй бол, энэхүү хэсгийг хэрэглэхгүй.

Бага хэмжээний буюу туслах чанарын ажлын хувьд өөрчлөлтийг өдрөөр тооцох ажил дээр үндэслэн гүйцэтгэхийг Инженер зааварчилж болно. Ийм

тохиолдолд ажлыг, өдрөөр тооцох ажлын хуваарийн дагуу үнэлж, өргтгийг тодорхойлох ба дараах журмыг баримтална.

Гүйцэтгэгч нь энэхүү ажилд хэрэглэх бараа, материалыг (өдрөөр тооцох ажлын хуваарийн үнэ нь тусгагдсан аливаа бараа, материалыас бусад) захиалахаасаа өмнө, Гүйцэтгэгчийн ханган нийлүүлэгчдийн ба/эсхүл Туслан гүйцэтгэгчдийн нэг, эсхүл түүнээс дээш үнийн саналыг Инженерт хүргүүлнэ. Үүний дараа Инженер эдгээр үнийн саналын нэгийг зөвшөөрөхийг (гэхдээ, энэхүү зааварчилгааг Гэрээний 5.2 [Нэр дэвшигэлсэн Туслан гүйцэтгэгч]-ийн дагуу зааварчилгаа гэж үзэхгүй) Гүйцэтгэгчид зааварчилж болно. Хэрэв Инженер нь үнийн саналыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ийнхүү зааварчлаагүй бол, Гүйцэтгэгч нь эдгээр үнийн саналын алийг нь ч өөрийн үзэмжээр хүлээн зөвшөөрөх эрхтэй.

Гүйцэтгэгч нь, өдрөөр тооцох ажлын хуваариар төлбөр нь хийгдэх болоогүй аливаа зүйлээс бусад, өмнөх өдрийн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн нөөцийн бүртгэлийг (Гэрээний 6.10 [Гүйцэтгэгчийн бүртгэл]-д тодорхойлсны дагуух) дотроо багтаасан, үнэн зөв гаргасан тайлангийн хуулбар хувийг (ба нэг цахим хувийг) өдөр бүр Инженерт хүргүүлнэ.

Хэрэв тайлан нь үнэн зөв бөгөөд түүнийг зөвшөөрсөн бол, Инженер гарын үсэг зурж, тайлан тус бүрийн нэг хувийг Гүйцэтгэгчид нэн даруй буцаана. Хэрэв тайлан нь алдаа мадагтай, эсхүл түүнийг зөвшөөрөөгүй бол, Инженер дараа нь ашигласан нөөцийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр Гэрээний 3.7 [Тохиролцох, эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу үргэлжлүүлэн ажиллах (ба Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийн зорилгоор, энэхүү заалтын дагуух Өөрчлөлтөд хамаарах ажлыг Гүйцэтгэгч хийж дуусгасан огноо нь 3.7.3-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарын эхлэх огноо болно).

Дараагийнхаа тайланд Гүйцэтгэгч нь тохиролцсон эсхүл шийдвэрлэсэн нөөцийг үнэлж, өргтгийг тодорхойлсон тооцоог, Өдрөөр тооцох ажилд ашиглагдсан аливаа бараа, материалын (Өдрөөр тооцох ажлын хуваарьт үнэ нь тусгагдсан аливаа бараа, материалыас бусад) нотолгоо болгосон бүх холбогдох нэхэмжлэх, ваучер, дансны болон төлбөрийн баримтуудын хамт тусган Инженерт хүргүүлнэ.

Өдрөөр тооцох ажлын жагсаалтад өөрөөр заагаагүй бол, өдрөөр тооцох ажлын хуваарьт байгаа үнэ ба тариф нь үнэлгээнд татвар хураамж, нэмэгдэл зардал ба ашгийг шингээсэн гэж үзнэ.

13.6 Хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан тохируулга хийх

Энэхүү хэсгийн дараах заалтуудыг баримтлан, Суурь огнооны дараа хийгдсэн ба/эсхүл Суурь огнооны дараа албан ёсоор хэвлэгдсэн бөгөөд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Гүйцэтгэгчид нөлөөлсөн, доор дурдсан зүйлүүдэд орсон өөрчлөлтийн үр дүнд үүссэн Зардлын аливаа өсөлт, эсхүл бууралтыг харгалзан Гэрээний үнэд тохируулга хийнэ:

- (a) Тухайн Улсын Хууль, (хууль тогтоомжийг шинээр батлах болон хуулийг шинэчлэн найруулах, хуульд өөрчлөлт оруулах зэрэг багтана) тогтоомжид;
- (b) Дээрх (a) дэд хэсэгт заасантай холбоотойгоор гарсан шүүхийн эсхүл төр захиргааны албан ёсны тайлбар эсхүл хэрэгжүүлэлтэд;
- (c) Гэрээний 1.13 [Хуульд нийцүүлэх]-ийн (a) эсхүл (b) заалтуудад тус бүр харгалзан Захиалагчийн, эсхүл Гүйцэтгэгчийн олж авсан аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лиценз болон бусад албан ёсны эрх олгосон баримт бичгүүд; эсхүл

(d) Гэрээний 1.13 [Хуульд нийцүүлэх]-ийн (b) заалтын дагуу Гүйцэтгэгчийн олж авах аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лицензэд тавигдах шаардлагууд ба/эсхүл бусад албан ёсны эрх олгосон баримт бичгүүд;

Энэхүү Гэрээний "Хууль, тогтоомжид орсон өөрчлөлт" гэж дээрх (a), (b), (c) ба (d) заалтын дагуух аливаа өөрчлөлтийг хэлнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь Хууль, тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан сааталтай тулгарсан ба/эсхүл нэмэгдэл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу энэ Зардлаа төлүүлэх эрхтэй.

Хэрэв Хууль, тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан зардлын бууралт бий болсон бол, Захиалагч нь 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-т заасны дагуу Гэрээний үнийг бууруулах эрхтэй.

Хэрэв Хууль тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан ажлыг гүйцэтгэхэд ямар нэгэн тохируулга хийх шаардлагатай болвол (дагалдах нарийвчилсан мэдээлэл бүхий):

- (1) Гүйцэтгэгч нь Инженерт мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ, эсхүл
- (2) Инженер нь Гүйцэтгэгчид мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ.

Үүний дараа Инженер нь нэг бол Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн дагуу Өөрчлөлт оруулах зааварчилгааг өгнө, эсхүл Гэрээний 13.3.2 [Санал ирүүлэх хүсэлтээр оруулах Өөрчлөлт]-т заасны дагуу санал ирүүлэх хүсэлтийг илгээнэ.

13.7 Өртөгт орсон өөрчлөлттэй холбогдуулан тохируулга хийх

Хэрэв Гэрээнд зардлын индексжүүлэлтийн жагсаалт тусгагдаагүй бол энэ хэсгийг хэрэглэхгүй.

Хөдөлмөрийн хөлс, бараа болон ажлын бусад бүрдлийн зардлын өсөлт ба бууралтыг тооцон, Зардлын индексжүүлэлтийн жагсаалтын дагуу гарсан дүнг нэмэх, эсхүл хасах замаар Гүйцэтгэгчид төлвөл зохих төлбөрийн дүнг тохируулна.

Энэхүү хэсгийн эсхүл эдгээр нөхцөлийн бусад зүйлд тусгагдаагүй зардлын аливаа өсөлт эсхүл бууралтын бүрэн нөхөн олговрын тухайд уг зардлын өсөлт болон бууралттай холбоотой магадалшгүй зардлын үнийн дүнг Гэрээний зөвшөөрөгдсөн дүнд багтаасан гэж үзнэ.

Төлбөрийн гэрчилгээгээр баталгаажуулснаас өөр байдлаар Гүйцэтгэгчид төлөх дүнд хэрэглэх тохируулгыг Гэрээний үнийн төлбөрийг хийх мөнгөн тэмдэгт тус бүрээр тооцоолж гаргана. Зардал, эсхүл өнөөгийн үнийг үндэслэж үнэлсэн ажилд ямар ч тохируулга хийхгүй.

Өнөөгийн үнийн индекс тус бүрийг тодорхой болох хүртэл, Явц дундын төлбөрийн гэрчилгээг олгохын тулд Инженер нь түр хугацааны индексийг хэрэглэнэ. Өнөөгийн үнийн индекс тодорхой болмогц тохируулгыг зохих ёсоор дахин тооцоолно.

Хэрэв Гүйцэтгэгч нь ажлыг дуусгах хугацааны дотор дуусгаагүй бол, үнийн тохируулгыг доор дурдсанаас Захиалагчид илүү тохиромжтой аль нэгийг нь сонгон хийнэ:

- (a) Ажлыг дуусгах хугацааг дуусгавар болохоос 49 хоногийн өмнөх өдрийн индекс, эсхүл үнэ тус бүрийг; эсхүл

(b) өнөөгийн индекс, эсхүл үнийг.

14. Гэрээний үнэ болон Төлбөрийн нөхцөл

14.1 Гэрээний үнэ

Гэрээний тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол:

(a) Гэрээний үнэ гэдэг нь 12.3 [Гүйцэтгэсэн ажлын төлбөрийн тооцоо]-т заасны дагуу Ажил гүйцэтгэх үнэ байх ба Гэрээнд заасны дагуу аливаа тохируулга (өөрчлөлт), нэмэлт (эдгээр Гэрээний нөхцлийн дагуу Гүйцэтгэгчийн авах эрх бүхий Зардал эсхүл Зардал болон ашиг зэргийг багтаана) эсхүл/болон хасалт зэргийг хийж болно.

(b) Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу Гүйцэтгэгч төлөхөөр үүрэг хүлээсэн бүхий л татвар, хураамж, төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд Гэрээний үнэд 13.6 [Хуульд өөрчлөлт орсонд холбоотой тохируулга хийх] хэсэгт зааснаас бусад тохиолдолд ямар нэгэн тохируулга хийгдэхгүй.

(c) Тoo хэмжээнд сууринсан үнэ бүрдэл эсхүл бусад Хуваарыт туссан аливаа тоо хэмжээ нь урьдчилан тооцоолсон тоо хэмжээ бөгөөд дор дурдсан тохиолдуудад тэрхүү тоо хэмжээг бодит болон зөв тоо хэмжээгээр тооцохгүй.

i. Гүйцэтгэгч гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн ажлын тоо хэмжээ, эсхүл

ii. 12 [Гүйцэтгэсэн ажлын тоог хэмжих ба Төлбөрийн тооцоо гаргах]-т заасны дагуу хэрэглэгдэх тоо хэмжээ.

(d) Гүйцэтгэгч нь санал болгож буй Нийт үнийн дүнгийн (хэрвээ байвал) задаргааг Хуваарыт тусган Ажил эхэлсэн өдрөөс хойш 28 хоногийн дотор Инженерт хүргүүлнэ. Инженер нь Төлбөрийн гэрчилгээг боловсруулахдаа задаргааг харгалзан үзэх эрхтэй боловч түүнийг заавал мөрдөх үүргийг хүлээхгүй.

14.2 Урьдчилгаа төлбөр

Хэрвээ Гэрээний мэдээлэлд урьдчилгаа төлбөрийн дүн тусаагүй бол энэ хэсгийн заалт хамаарахгүй.

Захиалагч нь Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээг хүлээн авсны дараа ажлыг (зураг төсөл хэрвээ байвал) эхлүүлэхэд зориулан хүүгүй зээл байдлаар урьдчилгаа төлбөрийг төлөх үүрэгтэй. Төлөхөөр заагдсан урьдчилгаа төлбөрийн дүн болон валюут зэргийг Гэрээний мэдээлэлд заавал тусгана.

14.2.1 Урьдчилгаа төлбөрийн баталгаа

Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцэх мөнгөн дүнгээр болон валютаар Урьдчилгаа төлбөрийн баталгааг (өөрийн зардлаар) гаргуулах бөгөөд эх хувийг Захиалагчид, хуулбарыг нь Инженерт тус тус хүргүүлэх үүргийг хүлээнэ. Энэхүү баталгааг тухайн улс орны (эсхүл өөр улсын) Захиалагчийн зөвшөөрсөн хуулийн этгээдээр гаргуулах бөгөөд тендерийн баримт бичгээр өгөгдсөн маягт эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн маягтыг ашиглана (гэхдээ энэхүү зөвшөөрөл болон/эсхүл хэлцэл нь Гүйцэтгэгчийг энэ хэсгийн дагуу хүлээх аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй).

Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөр эргэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд Урьдчилгаа төлбөрийн баталгааг хүчин төгөлдөр байлгах үүрэгтэй бөгөөд түүний дүн Төлбөрийн гэрчилгээнд заасны дагуу Гүйцэтгэгчээс эргэн төлөгдсөн төлбөрийн хэмжээгээр үе шаттайгаар буурч болно.

Хэрэв Урьдчилгаа төлбөрийн баталгаанд хүчин төгөлдөр байх хугацаа заагдсан бөгөөд тухайн хүчин төгөлдөр байх эцсийн хугацаанаас өмнө 28 хоногт багтаан урьдчилгаа төлбөрийг төлж барагдуулаагүй бол:

(а) Гүйцэтгэгч нь энэхүү баталгааны хугацааг урьдчилгаа төлбөр төлөгдөж дуустал сунгах үүрэгтэй.

(б) Гүйцэтгэгч нь уг сунгалтын нотлох баримтыг Захиалагчид нэн даруй хүргүүлэх ба түүний хуулбарыг Инженерт хүргүүлнэ.

(с) Хэрэв уг сунгалтын нотлох баримтыг Урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчин төгөлдөр байх эцсийн хугацаанаас 7 хоногийн өмнө Захиалагч хүлээж аваагүй бол Захиалагч нь урьдчилгаа төлбөрөөс төлөгдөөгүй дүнг нэхэмжлэх эрхтэй.

Урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргахдаа Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг барагдуулах хүсэлтийг (Мэдэгдэл хэлбэрээр) хавсаргасан байх үүрэгтэй.

14.2.2 Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээ

Инженер нь Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээг дараах дэд хэсгүүдэд заасан хугацаанаас хойш 14 хоногт багтаан гаргаж өгөх үүргийг хүлээнэ:

(а) Захиалагч нь 4.2.1 [Гүйцэтгэгчийн үүрэг] болон 14.2.1 [Урьдчилгаа төлбөрийн баталгаа]-т тус тус заасны дагуу маягт болон холбогдох хуулийн этгээдээс олгогдсон Гүйцэтгэлийн баталгаа болон Урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авсан өдөр;

(б) Инженер нь 14.2.1 [Урьдчилгаа төлбөрийн баталгаа] хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн Урьдчилгаа төлбөр авах хүсэлтийн хуулбарыг хүлээн авсан өдөр.

14.2.3 Урьдчилгаа төлбөрийг чөлөөлөх

Урьдчилгаа төлбөрийн чөлөөлөлтийг Төлбөрийн гэрчилгээнүүдэд заасан төлбөрийн хувиар тооцон хийнэ. Хэрэв Гэрээний мэдээлэлд бусад төлбөрийн хувийг өөрөөр заагаагүй бол:

(а) Урьдчилгаа төлбөрийн валюттай ижил валют бүхий баталгаажсан дундын төлбөрийн нийт дүн нь (урьдчилгаа төлбөр, хасалтууд/суутгал, барьцааны чөлөөлсөн мөнгөний дүн орохгүй) мөн валют бүхий Болзолт мөнгөн дүнг хасч тооцсон Гэрээний зөвшөөрөгдсөнгийн ногдох хэсгээс 10%-иас хэтэрсэн тохиолдолд ДТГ-нээс хасалтыг хийж эхэлнэ;

(б) Урьдчилгаа төлбөр төлөгдөж дуустал, ДТГ тус бүрийн дүнгийн (урьдчилгаа төлбөр, хасалтууд/суутгал, барьцааны чөлөөлсөн мөнгөний дүн орохгүй) дөрөвний нэг буюу 25%-тай тэнцэх барагдуулах хувиар урьдчилгаа төлбөрийн валют болон харьцаагаар хасалт/суутгалыг хийнэ.

Хэрвээ урьдчилгаа төлбөрийг ажил хүлээн авсан гэрчилгээ олгохоос өмнө эсхүл 15 [Захиалагчийн саналаар гэрээ цуцлах], 16 [Гүйцэтгэгч ажил түр зогсоо ба түүний саналаар гэрээ цуцлах] болон 18 [Онц байдал] зүйлүүдэд заасны дагуу гэрээг цуцлахаас өмнө тус тус буцаан төлөлтийг барагдуулаагүй бол Гүйцэтгэгч нь үлдэгдэл нийт төлбөрийг Захиалагчид нэн даруй буцаан төлөх үүрэгтэй.

14.3 Явц дундын төлбөрийн хүсэлт

Гүйцэтгэгч нь Гэрээний мэдээлэлд заасан төлбөрийн хугацаа дууссаны дараах өдөрт (хугацаа заагаагүй бол сар бүрийн эцэст) мэдэгдлийн Инженерт хүргүүлнэ. Уг Төлбөрийн мэдэгдлийг:

(а) Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу хүргүүлнэ;

(b) Гэрээний мэдээлэлд заасны дагуу 1 хэвлэмэл эх хувь, 1 цахим хувь болон нэмэлт хэвлэмэл хуулбарууд (хэрэв заагдсан бол) байдлаар хүргүүлнэ;

(c) Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчээс төлүүлэх эрхтэй үзэж байгаа үнийн дүнгийн холбогдох задаргааг холбогдох нэмэлт мэдээлэл, нотлох баримтын хамтаар хүргүүлэх бөгөөд эдгээр нэмэлт мэдээлэл, нотлох баримт нь Инженерийн зүгээс Гүйцэтгэгчийн ирүүлсэн төлбөрийн үнийн дүнг 4.20 [Явцын тайлан]-т заасны дагуу ирүүлсэн холбогдох явцын тайлантай харьцуулан хянан шалгах боломжийг Инженерт олгох хангалттай мэдээлэл байх шаардлагатай.

Төлбөрийн мэдэгдэл нь дор дурдсан жагсаалтын дагуу холбогдох зүйлсийг агуулсан байх бөгөөд тэдгээр нь Гэрээний үнэд заасан валютаар илэрхийлэгдсэн байна. Үүнд:

(i) Төлбөрийн хугацааны сүүлийн өдөр хүртэл Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг (гэрээний үнээр тооцоолсон) болон хийж гүйцэтгэсэн Гүйцэтгэгчийн бичиг баримтууд (Гэрээний өөрчлөлтүүдийг тусгах бөгөөд доорхи (ii) – (x) дэд хэсгүүдэд заасан зүйлсийг тусгахгүй);

(ii) 13.6 [Хуульд өөрчлөлт орсонтой холбоотой тохируулга хийх] болон 13.7 [Зардлын тарифийн өөрчлөлттэй холбоотой тохируулга хийх]-д заасны дагуу хийгдсэн Хуулийн өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа нэмэлт болон/эсхүл хасалт;

(iii) Барьцааны дүнгээс хасагдах аливаа дүнг тусгах бөгөөд уг дүнг тооцоходоо энэхүү хэсгийн (ii) болон (vi) дэд хэсэгт заасан дүнгүүдийн нийлбэрийг Гэрээний мэдээлэлд заасан Суутган барих мөнгөн дүнгийн хувиар бодож, Захиалагчид үлдсэн барьцааны мөнгөн дүнгийн хэмжээ нь Гэрээний мэдээлэлд заасан Барьцааны мөнгөн дүнгийн хязгаарт (хэрвээ байвал) хүрэх хүртэл тооцно.

(iv) 14.2 [Урьдчилгаа төлбөр]-т заасны дагуу урьдчилгаа төлбөр болон буцаан төлөлтөнд нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн;

(v) 14.5 [Ажилд зориулж татан авсан Үндсэн тоног төхөөрөмж ба материал]-т заасны дагуу Үндсэн тоног төхөөрөмж болон Материалд нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн;

(vi) Гэрээнд зааснаар болон өөр бусад байдлаар заасны дагуу, мөн 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн;

(vii) 13.4 [Болзолт мөнгөн дүн]-д заасны дагуу болзолт мөнгөн дүнд нэмэгдэх дүн;

(viii) 14.9 [Барьцааны мөнгийг чөлөөлөх]-д заасны дагуу барьцаа мөнгийг чөлөөлөх дүнд нэмэгдэх аливаа дүн;

(ix) 4.19 [Түр инженерийн шугам сүлжээ]-д заасны дагуу Захиалагчаас нийлүүлсэн инженерийн шугам сүлжээг Гүйцэтгэгч ашигласантайгаар холбоотой хасагдах аливаа дүн;

(x) Өмнө хүргүүлсэн бүх төлбөрийн гэрчилгээнүүдээр баталгаажигдсан хасалтын дүн

14.4 Төлбөрийн хуваарль

Хэрвээ Гэрээнд Гэрээний үнийн төлбөрийн хэсэгчилэн төлөх хуваарийг тогтоосон Төлбөрийн хуваарийг тусгасан бөгөөд уг Хуваарын өөрөөр заагаагүй бол:

(a) 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-ийн (i) заалтад заасныг хангах зорилгоор Төлбөрийн хуваарьт заасан хэсэгчилэн төлөх төлбөрийн дүнг гэрээний үнийн тооцоолох утгаар авна.

(b) 14.5 [Ажилд зориулж татан авсан Үндсэн тоног төхөөрөмж ба материал]-ийн заалт үйлчлэхгүй;

(c) Хэрвээ:

(i) тэдгээр хэсэгчилэн төлөх төлбөрийн дүнг ажлыг гүйцэтгэх явцын бодит гүйцэтгэлээс тогтоох боломжгүй бол.

(ii) Инженерийн тогтоосон ажлын бодит гүйцэтгэл нь төлбөрийн хуваарьт тусгагдсан гүйцэтгэлээс зөрүүтэй тохиолдолд

Инженер нь 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-т заасны дагуу хэсэгчилэн төлөх төлбөрийн шинэчилсэн хувилбарыг зөвшөөрөх эсхүл дүгнэлт (мөн 3.7.3 [Хугацааны хязгаар] хэсэгт заасны дагуу дээр дурдсан (ii) дэд заалтын дагуу тогтоосон зөрүүний огноо нь 3.7.3 заалтын дагуу гэрээний хугацааны хязгаарын эхэлсэн огноо байна) гаргана.

Энэхүү шинэчилсэн хэсэгчилэн төлөх төлбөрийн хэмжээг төлбөрийн хуваарьт тусгасан гүйцэтгэлийн төлөвлөлттэй харьцуулан шийдвэрлэнэ.

Хэрвээ Гэрээнд төлбөрийн хуваарь тусгагдаагүй бол Гүйцэтгэгч нь 3 сар тутамд төлбөр хүлээн авах хүлээлтийг илэрхийлсэн төлбөрийн албан бус (non-binding estimates) тооцоог хүргүүлнэ. Анхны тооцоог ажил эхлэх огноогоос хойш 42 хоногт багтаан хүргүүлнэ. Шинэчилсэн буюу хянагдсан тооцоог 3 сарын давтамжтайгаар илгээх бөгөөд ажил хүлээн авсан гэрчилгээг олгох хүртэл энэхүү тооцоог илгээнэ.

14.5 Ажилд зориулсан бараа материал, тоног төхөөрөмж

Хэрвээ Гэрээний мэдээлэлд Үндсэн тоног төхөөрөмж болон/эсхүл Материалын жагсаалттай тээвэрлэлтийн үеийн төлбөр болон/эсхүл хүргэлтийн үеийн төлбөр зэрэг тусгагдаагүй бол энэхүү хэсгийн заалтууд үйлчлэхгүй.

Гүйцэтгэгч нь 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-ийн (v) заалтад заасны дагуу дараах дүнг тусгана:

- Ажлын үндсэн ажилд холбоотойгоор ажлын талбайд хүргүүлж буй эсхүл хүргүүлсэн (тухайн тохиолдлоос хамааран) үндсэн тоног төхөөрөмж болон материалын нэмэгдэх дүн

- 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-ийн (i) заалтад заасны дагуу тухайн үндсэн тоног төхөөрөмж болон материалын гэрээний үнэ нь ажлын үндсэн ажлын хэсэгт тусгагдсан учраас хасагдах дүн.

Хэрвээ дараах нөхцөлүүд хангагдсан (мөн 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийг хангах үүднээс эдгээр нөхцөлүүдийг хангах хугацааг 3.7.3-т заасны дагуу хэлцлийн хугацааны хязгаарын эхлэх өдрөөр тооцно) бол Инженер нь үндсэн тоног төхөөрөмж болон материалтай холбоотой нэмэгдэх дүн тус бүрийг хүлээн зөвшөөрөх эсхүл тогтоох зорилготойгоор 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-г дагаж мөрдөнө:

(a) Гүйцэтгэгч нь:

(i) Инженерийн зүгээс үзлэг шалгалтыг хийх боломжийг ханган хангалттай бүртгэл, тайланг (мөн захиалгын хуудас, орлого зарлагын баримтууд, зардал болон үндсэн тоног төхөөрөмж болон материалуудын ашиглалтын бүртгэл зэргийг үүнд багтаана) бүрдүүлж хөтөлсөн.

(ii) Үндсэн тоног төхөөрөмж болон материалууд нь Гэрээнд бүрэн нийцэж буй тухай нотлох баримтуудыг (үүнд 7.4 [Гүйцэтгэгчийн хийх туршилт шинжилгээ]-т заагдсан туршилт/чанарын гэрчилгээ, болон/эсхүл 4.9.2 [Ажлын уялдаа холбооны нийцлийг хянах тогтолцоо]-т заасан тохиирлын баримт бичгүүдийг оруулах боломжтой) Инженерт хүргүүлсэн;

(iii) Ажлын талбайд хүргүүлж буй эсхүл хүргүүлсэн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) үндсэн тоног төхөөрөмж болон материалыг худалдан авах/турээслэх, тээвэрлэлтийн эсхүл хүргэлтийн зэрэг зардлуудыг тусгасан зардлын мэдэгдлийг хангалттай нотлох баримтуудын хамтаар хүргүүлсэн; эсхүл:

(b) Холбогдох Үндсэн тоног төхөөрөмж болон Материалтай нь:

(i) Тээвэрлэлт хийх үед Гэрээний өгөгдлийн төлбөр хийгдэх жагсаалтанд орсон;

(ii) Гэрээнд заасан Улсын бөгөөд тогтоосон ажлын талбайд хүргэгдэхээр тээвэрлэлтэд ачигдсан;

(iii) Тээврийн үйлчилгээ үзүүлэгч этгээд нь тоног төхөөрөмж болон материалыг зориулалтын баглаа боодолтойгоор бүрэн бүтэн хүлээн авсан тухай болон тээвэрлэлтийн талаарх бусад нотлох баримтуудыг доор дурдсан баримт бичгүүдийн хамтаар Инженерт хүргүүлсэн бол:

- Ачаа тээврийн болон даатгалын төлбөрийн баримтууд;
- Инженерээс шаардсан аливаа бусад баримт бичгүүд;
- Гүйцэтгэгч нь Захиалагчаас зөвшөөрсөн (гэхдээ энэ зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийг энэ дэд хэсгээс хойшх дэд хэсгүүдэд заасан аливаа үүрэг хариуцлагаас үл чөлөөлнө) загвар болон хуулийн этгээдээс энэхүү хэсэгт заасан төлбөрийн хэмжээтэй тэнцэх дүн болон валютаар гаргасан банкны баталгааг Захиалагчид хүргүүлэх (дараагийн Мэдэгдлийг хүргүүлэхээс өмнө) тухай Гүйцэтгэгчийн бичгэн даалгавар. Мөн энэхүү баталгаа нь 14.2.1 [Урьдчилгаа төлбөрийн баталгаа] хэсэгт тодорхойлсон маягттай ижил маягттай байх ба Үндсэн тоног төхөөрөмж болон Материалууд нь Ажлын талбайд зохистойгоор хадгалагдсан бөгөөд ба аливаа гэмтэл, эвдрэл, элэгдлээс хамгаалагдах хүртэл хүчин төгөлдөр байх шаардлагатай,

эсхүл

(c) дараах дэд хэсэгт заасан нөхцөлүүдийг хангаж буй үндсэн тоног төхөөрөмж болон Материалууд:

(i) Ажлын талбайд хүргэгдсэний дараа хийгдэх төлбөр нь хийгдэх бөгөөд Гэрээний мэдээлэлд тусгагдсан;

(ii) Ажлын талбайд хүргэгдэн зүй зохистой хадгалагдаж, аливаа эвдрэл, гэмтэл, элэгдэл хорогдол зэргээс хамгаалагдсан бөгөөд Гэрээнд нийцэж буй гэсэн дүгнэх байдлаар харагдаж буй бол.

Хүлээн зөвшөөрөх эсхүл тодорхойлох дүнгийн хэмжээг тогтооходоо энэхүү хэсэгээр шаардсан баримт бичгүүд болон нотлох баримтууд, үндсэн тоног төхөөрөмж болон материалын гэрээний үнийн дүн зэргийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Хэрвээ дээрх (b) заалт хүчинтэй үйлчилсэн тохиолдолд дээрх (b)(iii) дэд заалтад заасны дагуу банкны баталгааг Захиалагч хүлээн авах хүртэл Инженер нь энэ зүйлд заагдсан аливаа төлбөрийг баталгаажуулах үргийг хүлээхгүй. Инженерээс баталгаажуулах ДТГ-ийн нийлбэр дүн нь харилцан зөвшилцсөн эсхүл тогтоосон үнийн дүнгийн наян (80%) хувьтай тэнцүү хэмжээтэй байна. Энэхүү

87

ЗАХИАЛАГЧ

FIDIC RED BOOK-SECOND EDITION 2017.

ГҮЙЦЭТГЭГЧ

харилцан зөвшилцсөн эсхүл тогтоосон дүнгийн валют нь 14.3 [Дундын толбөрийн хүсэлт]-ийн (i)-д заасан гэрээний үнэ тусгасан төлбөрийг барагдуулах валюттай адил байх ёстой. Түүнчлэн Төлбөрийн гэрчилгээнд хасалт хийгдэх тодорхой дүнг тусгах бөгөөд энэ нь холбогдох үндсэн тоног төхөөрөмж болон материалтай холбоотой уг нэмэгдэл дүнтэй тэнцүү, мөн хувь хэмжээ болон валют адил байна.

14.6 Явц дундын төлбөрийн гэрчилгээг (IPC) олгох

Дараах дэд хэсгүүдэд заасан нөхцөл бүрдэх хүртэл аливаа төлбөрийн дүнг баталгаажаагүй эсхүл Гүйцэтгэгчид төлөх эрх үүсээгүй гэж үзнэ. Үүнд:

(a) Захиалагч нь 4.2.1 [Гүйцэтгэгчийн үүрэг]-т дагуу маягтын дагуу холбогдох хуулийн этгээдээс олгосон Гүйцэтгэлийн баталгааг хүлээн авсан;

(b) Гүйцэтгэгч нь 4.3 [Гүйцэтгэгчийн төлөөлөгч]-т заасны дагуу Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилсон.

14.6.1 Явц дундын төлбөрийн гэрчилгээ

Инженер нь мэдэгдлийг болон холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан ЯДТГ-г Захиалагчид, хуулбарыг Гүйцэтгэгчид тус тус хүргүүлнэ. Энэхүү ЯДТГ-д:

(a) Инженерийн зүгээс бодитой гэж үзсэн төлбөрийн дүнг, болон

(b) Гэрээ болон бусад байдлаар эсхүл 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу төлөх шаардлагатай аливаа нэмэлт болон/эсхүл суутгал/хасалтыг тусгана.

Мөн холбогдох дэлгэрэнгүй баримт бичгүүдийг (эдгээр нь баталгаажсан дүн болон Мэдэгдэлд туссан холбогдох дүнгийн хоорондын аливаа ялгааг эсхүл зөрүүг тодорхойлох болон уг ялгаа эсхүл зөрүүний учир шалтгааныг тайлбарласан байх шаардлагатай) хавсаргана.

14.6.2 Явц дундын төлбөрийн гэрчилгээ (түүний тодорхой дүнг) тур хойшлуулах

Ажил хүлээн авах тухай гэрчилгээг олгохоос өмнө Инженер нь хэрвээ IPC-гийн тодорхой дүн (барьцааны чөлөөлөх дүн боло бусад хасалт/суутгалуудыг хасаж тооцсоны дараа) Гэрээний мэдээлэлд заасан IPC-ийн хамгийн бага дүнгээс бага бол тэрхүү дүнг тур хойшлуулах эрхтэй. Энэ тохиолдолд Инженер нь холбогдох мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ.

IPC-ийг аливаа бусад шалтгаанаар хойшлуулах эрхгүй боловч:

(a) Хэрвээ Гүйцэтгэгчийн нийлүүлсэн аливаа зүйл эсхүл хийж гүйцэтгэсэн ажил нь Гэрээнд нийцэхгүй байгаа бол тухайн алдааг засах эсхүл солих зардлын дүнтэй тэнцэх хэмжээний дүнг уг алдааг засч залруулах эсхүл солих ажлыг бүрэн хийж дуусах хүртэл хугацаагаар хойшлуулах эрхтэй.

(b) Хэрвээ Гүйцэтгэгч нь аливаа ажил үйлчилгээг гүйцэтгэх үүргээ биелүүлэхгүй байх эсхүл биелүүлж чадахгүй бол уг ажил үйлчилгээ эсхүл үүрэг хариуцлагатай холбогдох дүнг тухайн ажил үйлчилгээ, үүрэг хариуцлагыг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хойшлуулах эрхтэй. Энэ тохиолдолд Инженер нь тур хойшлуулж буй дүнтэй холбоотой алдаа дутагдал, үүрэг хариуцлагыг тайлбарласан нэмэлт мэдээлэл бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлэх үүрэгтэй. болон/эсхүл

(c) Хэрвээ Инженер нь Гүйцэтгэгчийн мэдэгдэл /Тайлан/ болон бусад холбогдох баримт бичгүүдэд аливаа үл тохирол эсхүл ноцтой алдааг илрүүлсэн бол

уг алдаа болон үл тохирлыг засч залруулах эсхүл үрдчилан сэргийлэхтэй холбоотой дүн бүхий ЯДТГ-г түүнийг засч залруулах хүртэл хойшлуулна.

Инженер нь хойшлуулсан дүнг тус бүрийн IPC-д холбогдох мэдээлэлд дүнгийн нарийвчилсан тооцоолол болон учир шалтгааныг дэлгэрэнгүй дурдах үүрэгтэй.

14.6.3 Засварлах, өөрчлөлт хийх

Төлбөрийн гэрчилгээнд өмнө нь зохих ёсоор хийгдсэн залруулга эсхүл өөрчлөлттэй холбоотойгоор Инженер нь аливаа Төлбөрийн гэрчилгээг засварлах, өөрчлөлт хийх эрхтэй. Төлбөрийн гэрчилгээ нь Инженерийн зүгээс аливаа Гүйцэтгэгчийн баримт бичиг эсхүл ажлыг (аливаа бурдэл хэсгийг) хүлээн зөвшөөрсөн, баталгаажуулсан, зөвшөөрөл өгсөн эсхүл Татгалзсан тухай мэдэгдлийн илэрхийлэл болохгүй.

Хэрэв Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн авах эрхтэй аливаа дүнгүүдийг ДТГ-д тусгаагүй байна гэж үзсэн тохиолдолд эдгээр дүнг (энэ хэсэгт зааснаар "тодорхойлсон дүнгүүд") дараагийн Тайлан/Мэдэгдэлд тусгана. Дараа нь Инженер Төлбөрийн гэрчилгээнд хийгдэх шаардлагатай зохих засвар, өөрчлөлтийг хийнэ. Түүний дараа:

(a) Гүйцэтгэгч дараагийн Төлбөрийн гэрчилгээнд тусган оруулсан дүнд сэтгэл хангалаун бус байвал тэрхүү дүнг тусгасан; мөн

(b) Тодорхойлсон дүнгүүд нь Инженер нь 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасан өөрийн үүрэг хариуцлагыг биелүүлж буйн илрэл болж чадахгүй бол

Гүйцэтгэгч нь дээрхтэй холбоотой асуудлаар Инженерт Мэдэгдэл хүргүүлэх эрхтэй бөгөөд 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх] хэсгийн заалтууд үйлчилнэ (3.7.3 [Хугацааны хязгаар] хэсгийн заалтуудыг хангах үүднээс энэхүү мэдэгдлийг Инженер хүлээн авах огноо нь 3.7.3-д заасны дагуу хугацааны хязгаарыг тооцож эхлэх өдрөөр тооцно).

14.7 Төлбөр

Захиалагч нь дараах төлбөрүүдийг Гүйцэтгэгчид төлөх үүргийг хүлээнэ. Үүнд:

(a) Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээ тус бурд тусган баталгаажсан төлбөрийн дүнг Захиалагч Урьдчилгаа төлбөрийн гэрчилгээг хүлээн авснаас хойш Гэрээний мэдээлэлд заагдсан (хэрвээ заагдаагүй бол 21 хоногт багтаан) хугацаанд багтаан;

(b) Дараах дэд заалтад заасны дагуу хүргүүлсэн ДТГ тус бүрээр баталгаажсан дүнг:

(i) 14.6 [ДТГ олгох]-т заасны дагуу Захиалагч Мэдэгдэл болон холбогдох баримт бичгүүдийг хүлээн авснаас хойш Гэрээний мэдээлэлд заагдсан (хэрвээ заагаагүй бол 56 хоногт багтаан) хугацаанд багтаан; эсхүл

(ii) 14.13 [Сүүлийн төлбөрийн гэрчилгээ]-т заасны дагуу Захиалагч ДТГ-г хүлээн авснаас хойш Гэрээний мэдээлэлд заагдсан (хэрвээ заагаагүй бол 28 хоногт багтаан) хугацаанд багтаан;

(c) Сүүлийн төлбөрийн гэрчилгээнд тусгасан дүнг Захиалагч Сүүлийн төлбөрийн гэрчилгээг хүлээн авснаас хойш Гэрээний мэдээлэлд заагдсан (хэрвээ заагаагүй бол 56 хоногт багтаан) хугацаанд багтаан;

Төлбөл зохих төлбөрийн дүн тус бүрийг холбогдох валютаар Гэрээнд заагдсан улсын (тухайн валютын хувьд) бөгөөд Гүйцэтгэгчийн нэрлэсэн банкны дансанд шилжүүлнэ.

14.8 Хойшилсон төлбөр

Хэрвээ Гүйцэтгэгч 14.7 [Төлбөрийн нөхцөл]-д заасны дагуу төлбөрийг хүлээн аваагүй бол Гүйцэтгэгч нь тухайн хойшлуулсан хугацааны үеийн төлөгдөөгүй дүнгээс тооцсон нэмэлт төлбөрийг сар бүр авах эрхтэй. Энэхүү хойшлуулсан үеийн хугацааг 14.7 [Төлбөрийн нөхцөл]-д заасан төлбөрийн хугацаа дуусгавар болох өдрөөр тооцож эхлэх бөгөөд аливаа ДТГ олгосон өдөр үл хамаарна (14.7 хэсгийн (b) заалтад тохиолдолд).

Гэрээний мэдээлэлд өөрөөр дурдаагүй бол эдгээр төлбөрийн алданги/нэмэлт төлбөрийг доор дурдсан жилийн хүүгийн (3%)-аар тооцно:

- (a) Төлбөр төлөгдөх газрын бөгөөд төлбөрийн валютаар тооцох бөгөөд үндсэн зээлдэгч нарт олгодог банкны богино хугацааны зээлийн дундаж хүү; эсхүл
- (b) тухайн газарт уг хүү тодорхой бус бол төлбөрийн валют бүхий улсын зохих хүү, эсхүл
- (c) хэрвээ аль аль газарт уг хүү тодорхойгүй бол төлбөрийн валют бүхий улсын хуулийн дагуу тогтоосон хүү.

Гүйцэтгэгч нь:

(i) Захиалагчид албан ёсны мэдэгдэл эсхүл Тайлан (үүнд 20.2 [Төлбөрийн болон/эсвэл ХС Нэхэмжлэл]-т заасан аливаа шаардлагууд) эсхүл гэрчилгээ гаргахгүйгээр; мөн

(ii) аливаа бусад эрх болон эрх зүйн эрхийг хөндөхгүйгээр хүсэлт гарган төлбөрийн алдангийг/нэмэлт төлбөрийг Захиалагчаар төлүүлэх эрхтэй.

14.9 Суутган барих мөнгөн дүнг чөлөөлөх

Ажил хүлээн авсан гэрчилгээг олгогдсоны дараа:

- (a) хэрвээ уг гэрчилгээ нь нийт Ажилд олгогдсон бол Гүйцэтгэгч нь Барьцаа мөнгөний эхний хагасыг Мэдэгдэл/Тайланд тусгана; эсхүл
- (b) хэрвээ уг гэрчилгээ нь бүрдэл хэсэгт олгогдсон бол Гүйцэтгэгч нь Барьцаа мөнгөний эхний хагасын уг бүрдэл хэсэгт холбоотой хувийг Мэдэгдэл/Тайланд тусгана.

Ажлын чанарын баталгаат хугацаа (ДМХ) дуусах өдрүүдийн хамгийн сүүлчийн хугацаа дууссаны дараа Гүйцэтгэгч нь Барьцаа мөнгөний хоёрдах хагасыг Мэдэгдэл/Тайланд тухайн сүүлчийн өдрийн дараа нэн даруй тусгана. Хэрвээ Ажил хүлээн авсан гэрчилгээ нь Бүрдэл хэсэгт олгогдсон (эсхүл олгогдсон гэж үзсэн тохиолдолд) бол Гүйцэтгэгч нь Барьцаа мөнгөний хоёрдахь хагасын холбогдох хувийг тухайн Бүрдэл хэсэгт зориулсан ДМХ-ны дуусгавар болох хугацааны дараа нэн даруй тусгана.

Ижил төстэй аливаа Мэдэгдэл/Тайланг Инженер хүлээн авсны дараа гаргасан ДТГ-нд Инженер нь Барьцаа мөнгөний зохих хэмжээг чөлөөлснийг баталгаажуулна. Гэхдээ 14.6 [ЯДТГ олгох]-д заасны дагуу Барьцааны мөнгийг чөлөөлөх үед хэрвээ 11 [Ажлыг хүлээн авсны дараах доголдол]-д заасны дагуу гүйцэтгэж дуусаагүй ямар нэгэн ажил үлдсэн бол энэхүү дутуу ажлыг гүйцэтгэж дуустал Инженер нь тэрхүү ажилд хамаарах зардлын баталгаажуулалтыг түр тутгэлзүүлэх эрхтэй.

Бүрдэл хэсэг тус бүрт холбогдох хувь нь Гэрээний мэдээлэлд заасан Бүрдэл хэсэг бүрийн утгатай адил байх шаардлагатай. Хэрвээ Гэрээний мэдээлэлд Бүрдэл хэсэг тус бүрийн утга буюу хувийг тусгаагүй бол энэхүү хэсэгт заасны дагуу уг Бүрдэл хэсэгтэй холбоотой Барьцаа мөнгийн аливаа хагасын хувь чөлөөлөх тухай асуудал хамаarahгүй болно.

14.10 Ажил дуусмагц өгөх тайлан

Гүйцэтгэгч нь Ажил дуусах огнооноос хойш 84 өдөрт багтаан 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-т заасны дагуу ажил дууссан тухай мэдэгдлийг холбогдох баримт бичгүүдийн хамтаар Инженерт хүргүүлэх бөгөөд үүндээ доор дурдсан мэдээллүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

- (a) Ажил дуусах огноо хүртэл Гэрээний дагуу гүйцэтгэсэн нийт ажлын дүн;
- (b) Ажил дуусах огноо хүртэл хугацаанд Гүйцэтгэгчээс авах эрхтэй гэж үзэж буй аливаа бусад дүнгүүд;
- (c) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу Ажил дуусах огнооноос хойш Гүйцэтгэгчээс авахаар тооцсон эсхүл авах эрх бүхий гэж үзэж буй аливаа бусад тооцсон дүнгүүд; Эдгээр тооцсон дүнгүүдийн тус бүрээр нь (дээр дурдсан (a) ба (b) дэд хэсгүүдэд заасан) харуулах бөгөөд мөн дараах тооцсон дүнгүүдийг багтаана. Үүнд:
 - (i) Гүйцэтгэгчээс 20.2 [Төлбөрийн болон/эсвэл ХС Нэхэмжлэл]-т заасны дагуу мэдэгдлээр хүргүүлсэн Нэхэмжлэлүүдийн дүнгүүд;
 - (ii) 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах]-т заасны дагуу МЗШЗ-д хүргүүлсэн аливаа асуудлуудтай холбоотой дүнгүүд;
 - (iii) 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах] хэсэгт заасны дагуу хүргүүлсэн Үл зөвшөөрөх мэдэгдэлд (ҮЗМ) тусгагдсан аливаа асуудлын дүн зэрэг орно.

Дараа нь Инженер нь 14.6 [ДТГ олгох]-д заасны дагуу ДТГ-г олгоно.

14.11 Эцсийн төлбөрийн хүсэлт

Энэхүү хэсгийн дараах заалтуудын дагуу Гүйцэтгэгчээс хүргүүлэх аливаа Мэдэгдлийг 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах] эсхүл 21.6 [Арбитрын ажиллагаа]-д холбоотой аливаа шалтгаанаар хойшилуулж/түтгэлзүүлж үл болно.

14.11.1 Эцсийн төлбөрийн мэдэгдлийн төсөв

Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш 56 өдөрт багтаан Гүйцэтгэгч нь Инженерт Эцсийн төлбөрийн мэдэгдлийн төсвийг хүргүүлнэ.

Энэхүү Эцсийн төлбөрийн хүсэлт нь доорх шаардлагуудыг хангах үүрэгтэй:

- (a) 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-т заасны дагуу өмнө хүргүүлсэн Мэдэгдэл/Тайлантай ижил маягтаар хийнэ;
- (b) нэг хэвлэмэл эх хувь, нэг цахим хуулбар болон Гэрээний мэдээлэлд заасны дагуу нэмэлт хэвлэмэл хуулбаруудын (хэрвээ байвал) хамтаар хүргүүлнэ;
- (c) нотлох баримт, тайлан бүхий дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) Гэрээний дагуу гүйцэтгэсэн нийт ажлын дүн;
 - (ii) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу, Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосон өдрийг хүртэл Гүйцэтгэгч нь авах эрхтэй гэж үзэж буй аливаа бусад дүнгүүд;
 - (iii) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш авах ёстой эсхүл авахаар төлөвлөсөн гэж

үзэж буй аливаа бусад тооцсон дүнгүүд бөгөөд үүндээ 14.10 [Ажил дууссан тухай мэдэгдэл]-ийн (c) заалтын (i)-аас (ii)-д заасны дагуу тооцсон үнийн дүнгүүдийг багтаанаа. Эдгээр тооцсон дүнгүүдийг (дээр дурдсан (i) ба (ii) дэд заалтуудад заасан) тус бүрээр нь харуулна.

Дээрх (iii) дэд заалт зааснаас бусад тохиолдолд, хэрвээ Инженер нь Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсвийн аливаа хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй эсхүл баталгаажуулж/нотолж чадаагүй бол энэ тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Дараа нь Гүйцэтгэгч Инженерээс бодитойгоор шаардсаны дагуу холбогдох нэмэлт мэдээллийг уг Мэдэгдэлд заасан хугацаанд хүргүүлэх ба Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөвт Талууд харилцан хүлээн зөвшөөрөх боломжтой өөрчлөлтүүдийг тусганаа.

14.11.2 Батлагдсан эцсийн төлбөрийн хүсэлт

Хэрвээ 14.11.1 [Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөв]-ийн (iii) дэд заалт хамаарал бүхий дүн байхгүй бол Гүйцэтгэгч нь Сүүлийн төлбөрийн мэдэгдлийг (эдгээр Гэрээний нөхцөлд “Сүүлийн төлбөрийн мэдэгдэл” гэх) харилцан зөвшилцсөнийхөө дагуу бэлтгэн боловсруулж Инженерт хүргүүлнэ.

Гэхдээ хэрвээ:

- (a) 14.11.1 [Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөв]-ийн (iii) дэд заалт хамаарал бүхий дүн байхгүй; болон/эсхүл
- (b) Инженер болон Гүйцэтгэгч нь Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөвт тусгагдсан аливаа дүнгийн талаар харилцан зөвшилцөлд хүрэх боломжгүй бөгөөд энэ нь тэдгээрийн хэлэлцээрээс тогтоогдвол

Гүйцэтгэгч нь харилцан зөвшилцсөн дүнгүүд, тооцсон дүнгүүд, үл зөвшилцсөн дүнгүүд зэргийг тус бүрээр тусгасан мэдэгдлийг (энэхүү Гэрээний нөхцөлд “Хэсэгчлэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдэл” гэх) бэлтгэн Инженерт хүргүүлнэ.

14.12 Үүргээс чөлөөлөх

Гүйцэтгэгч нь Сүүлийн төлбөрийн мэдэгдэл эсхүл хэсэгчилэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдлийг (тухайн нөхцөл байдлаас хамаарч) хүргүүлэхдээ уг мэдэгдлийн нийт дүн нь Гэрээнд заасан болон түүнтэй холбоотойгоор Гүйцэтгэгчийн олгогдох нийт мөнгөн дүнг бүрэн багтаасан бөгөөд эцэслэсэн төлбөрийн тооцоо болохыг баталгаажуулсан Төлбөрийн тооцоог эцэслэх эцэслэсэн тухай мэдүүлгийг мөн хүргүүлнэ. Энэхүү Төлбөрийн тооцоог эцэслэсэн тухай мэдүүлэгтээ дараах агуулгыг нэмж тусгаж болно. Уг Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн нийт дүн нь МЗШ-ийн хүрээнд хэлэлцэж буй аливаа Маргаан болон 21.6 [Арбитрын ажиллагаа]-д заасны дагуу явагдаж буй аливаа арбитрын үйл ажиллагаатай холбоотой гарч болзошгүй аливаа төлбөрөөс шалтгаалан өөрчлөгдөх болон/эсхүл мэдүүлэг нь Гүйцэтгэгч:

- (a) Сүүлийн төлбөрийн гэрчилгээгээр баталгаажуулсан нийт дүнгийн төлбөрийг бүрэн хүлээн авсан бөгөөд
- (b) Гүйцэтгэлийн баталгааг хүлээн авсны дараа хүчинтэй болно.

Хэрвээ Гүйцэтгэгч нь Төлбөрийн тооцоог эцэслэсэн тухай мэдүүлгийг хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол уг мэдүүлгийг хүргүүлсэн гэж үзэх бөгөөд энэхүү хэсгийн (a) болон (b) дэд хэсгүүдэд заасан нөхцөлүүд хангагдсаны дараа хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Энэхүү хэсгийн дагуу гаргасан Төлбөрийн тооцоог эцэслэсэн тухай мэдүүлэг нь МЗШЗ-ийн хүрээнд хэлэлцэж буй аливаа Маргаан болон 21-т заасны дагуу явагдаж буй аливаа арбитрын үйл ажилагаанд хамаарах болон холбоотой Талуудын аливаа хариуцлага болон эрхийг хөндөхгүй.

14.13 Эцсийн төлбөрийн гэрчилгээг (FPC) олгох

Сүүлийн төлбөрийн мэдэгдэл эсхүл Хэсэгчилэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдэл (тухайн нөхцөл байдлаас хамаарч) болон 14.12 [Төлбөрийн тооцоог эцэслэх эцэслэсэн тухай мэдүүлэг]-т заасан мэдүүлгийг тус тус хүлээн авсанас хойш 28 өдөрт багтаан Инженер нь Сүүлийн төлбөрийн гэрчилгээг Захиалагчид хүргүүлэх бөгөөд уг гэрчилгээнд дараах мэдээллүүдийг тусгана:

(a) Инженерийн зүгээс зохих ёсны гэж тооцож буй сүүлийн төлбөрийн дүн ба энэ дүнд Гэрээнд болон бусад байдлаар заасан эсхүл 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасан аливаа нэмэлт болон/эсхүл суутгал/хасалтыг тусгасан байна;

(b) Захиалагчаас өмнө нь төлөгдсөн нийт дүн болон Захиалагчийн эрх бүхий нийт дүн зэргийг баталгаажуулсны/нотолсны дараа, мөн Гүйцэтгэгчээс өмнө төлсөн болон/эсхүл Гүйцэтгэлийн баталгааны дагуу Захиалагч хүлээн авсан нийт дүнг (хэрвээ байвал) баталгаажуулсны/нотолсны дараа тус тус Захиалагчаас Гүйцэтгэгчид төлөх үлдэгдэл төлбөр (хэрвээ байвал) эсхүл тухайн нөхцөл байдлаас хамааран Гүйцэтгэгчээс Захиалагчид төлөх нийт үлдэгдэл төлбөрийн дүн;

Хэрвээ Гүйцэтгэгч нь 14.11.1-т заагдсан хугацаанд Сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөв/төслийг хүргүүлээгүй бол Инженер энэхүү үүргээ биелүүлэхийг шаардсан хүсэлтийг илгээнэ. Хэрвээ үүний дараа 28 өдөрт багтаан Гүйцэтгэгч нь сүүлийн төлбөрийн мэдэгдлийг төсөв/төслийг хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол Инженер нь өөрийн зүгээс тооцсон төлбөрийн дүн бүхий сүүлийн төлбөрийн гэрчилгээг хүргүүлнэ.

Хэрвээ:

(i) Гүйцэтгэгч 14.11.2 [Батлагдсан сүүлийн төлбөрийн мэдэгдэл]-т заасны дагуу Хэсэгчилэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдлийг хүргүүлсэн бол; эсхүл

(ii) Гүйцэтгэгч Хэсэгчилэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдлийг хүргүүлээгүй боловч Гүйцэтгэгчээс хүргүүлсэн сүүлийн төлбөрийн мэдэгдлийн төсөв/төсөлд дурдсан төлбөрийг Инженер нь хэсэгчлэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдэл хэмээн адилтган үзсэн тохиолдолд

Инженер нь 14.6 [ДТГ олгох]-д заасныг баримтлан ДТГ олгох ажиллагааг явуулна.

14.14 Захиалагчийн хариуцлагын хугацаа дуусах

Захиалагч нь дараах дэд хэсгүүдэд заасан мэдэгдлүүдэд Гүйцэтгэгч тодорхой мөнгөн дүнгийн хэмжээг тусган зааснаас бусад тохиолдолд Гэрээтэй эсхүл Ажлын Гүйцэтгэлтэй холбоотой эсхүл түүний дагуу аливаа асуудлаар эсхүл зүйлээр Гүйцэтгэгчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

(a) Сүүлийн төлбөрийн мэдэгдэл эсхүл хэсэгчлэн зөвшилцсөн сүүлийн төлбөрийн мэдэгдэл;

(b) 14.10 [Ажил дууссан тухай мэдэгдэл]-т заасан мэдэгдэл (Ажил хүлээн авсан тухай мэдэгдлийг хүргүүлсний дараа үүссэн аливаа асуудал эсхүл зүйл хамаарахгүй).

Гүйцэтгэгч нь сүүлийн төлбөрийн гэрчилгээний хуулбарыг хүлээн авснаас хойш 56 хоногийн дотор сүүлийн төлбөрийн гэрчилгээнд тусгагдсан аливаа төлбөрийн дүнтэй холбоотой 20.2 [Төлбөрийн болон/эсвэл ХС Нэхэмжлэл]-т заасан нэхэмжлэл гаргаагүй эсхүл үйлдээгүй бол Гүйцэтгэгчийг уг гэрчилгээнд баталгаажсан мөнгөн дүнг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Энэ тохиолдолд Захиалагч нь сүүлийн төлбөрийн гэрчилгээнд тусгасан мөнгөн дүнг төлж барагдуулах болон Гүйцэтгэгчид гүйцэтгэлийн баталгааг буцаан олгохоос аливаа бусад үүрэг хариуцлагыг Гүйцэтгэгчийн өмнө хүлээхгүй.

Гэхдээ энэхүү хэсгийн заалтууд нь Захиалагчийн алданги төлөх үүрэг хариуцлагыг хязгаарлахгүй бөгөөд аливаа Захиалагчийн үйлдсэн хуран мэхлэлт, залилан, хариуцлагагүй байдал, санаатай болон санамсаргүйгээр гаргасан алдаа, зөрчилд үүсэх харууцлагаас чөлөөлөхгүй.

14.15 Төлбөрийн валют

Гэрээний үнийг Гэрээний мэдээлэлд заасан валютаар эсхүл валютуудаар төлнэ. Хэрэв Гэрээний мэдээлэлд хоёр болон түүнээс их валют заагдсан бол дараах дэд хэсгүүдийн заалтуудыг баримтлана. Үүнд:

(a) Хэрэв Гэрээний зөвшөөрөгдсөнг зөвхөн тухайн Улс орны валютаар, эсхүл зөвхөн Гадаад валютаар илэрхийлсэн бол:

(i) Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол төлбөр хийх Дотоодын болон Гадаадын валютын харьцаа/хувь хэмжээг эсхүл дүн, төлбөрийн тооцооны валютын тогтсон ханш зэргийг Гэрээний мэдээлэлд зааснаар авна.

(ii) 13.4 [Болзолт мөнгөн дүн] хэсэг болон 13.6 [Хуульд өөрчлөлт орсонтой холбоотой тохируулга хийх] хэсгийн дагуу хийгдэх төлбөр ба суутгал/хасалтыг холбогдох валют ба харьцаа/хувь хэмжээгээр хийнэ.

(iii) 14.3 [Дундын төлбөрийн хүсэлт]-ийн (i) - (iv) заалтад заасны дагуу хийгдэх бусад төлбөр болон хасалт/суутгал нь дээр (i) дэд заалтад заасан валют ба харьцаа/хувь хэмжээгээр хийнэ.

(b) 13.2 [Техникийн оновчтой шийдэл] хэсэг эсхүл 13.3 [Гэрээний өөрчлөлт хийх үйл явц] хэсгийн дагуу Талууд тохируулгыг зөвшилцсөн эсхүл шийдвэрлэсэн тохиолдол тус бүрд холбогдох валют тус бүрээр төлөх дүнг зааж тусгана. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд энэхүү хэсгийн дээр дурдсан (a)(i) дэд заалтад заасан төрөл бүрийн ажлын зардлын бодит эсхүл хүлээгдэж буй валютын харьцаа болон төрөл бүрийн валютын харьцаа/хувь хэмжээг тодорхойлсон заавар/жишигийг тогтоосон байх шаардлагатай.

(c) Хугацаа хойшилсоны алдангийн төлбөрийг Гэрээний мэдээлэлд заасан валют болон хувь хэмжээгээр төлнэ.

(d) Гүйцэтгэгчийн Захиалагчид төлөх бусад төлбөрийг Захиалагчийн зарцуулсан валютаар эсхүл Талууд харилцан тохиролцсон валютаар төлнэ.

(e) Хэрвээ тухайн валютаар Гүйцэтгэгчээс Захиалагчид төлбөл зохих аливаа төлбөрийн хэмжээ нь уг валютаар Захиалагчаас Гүйцэтгэгчид төлвөл зохих нийт дүнгээс их гарсан бол Захиалагч нь энэхүү дүнгийн зөрүүг өөр валютаар Гүйцэтгэгчид төлөх эрхтэй.

(f) Хэрэв валютын ханшийг Гэрээний мэдээлэлд заагаагүй бол суурь огнооны өдөр тухайн улсын Төв банкнаас зарласан албан ёсны валютын ханшаар тооцно.

15. Захиалагч Гэрээг цуцлах

15.1 Алдааг засварлах тухай Мэдэгдэл

Хэрвээ Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн аливаа үүргээ биелүүлээгүй тохиолдолд Инженерийн зүгээс Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Гүйцэтгэгчийг тодорхой хугацаанд (энэхүү Нөхцөлийн “Алдааг засах тухай мэдэгдэл”-д тусгасан) алдаа, доголдолыг засч залруулахыг шаардана.

Алдааг засах тухай Мэдэгдэл нь дараах шаардлагуудыг заавал хангасан байна. Үүнд:

- (a) Гүйцэтгэгчийн алдааг тодорхойлно;
- (b) Гүйцэтгэгчийн ажил үүргийг тогтоосон Гэрээний холбогдох зүйл, хэсэг, заалтуудыг дурьдсан байх;
- (c) Гүйцэтгэгчид алдаагаа засч залруулах хугацааг тогтоон тусгаж өгөх бөгөөд энэ хугацаа нь алдаа болон ажлын мөн чанар, тухайн алдааг засч залруулахад авах шаардлагатай арга хэмжээнүүдийг харгалзаж үзсэн үндэслэл бүхий боломжит хугацаа байна.

Гүйцэтгэгч нь алдааг засах тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа тухайн алдаа, доголдолыг засч залруулах арга хэмжээ болон мэдэгдэлд дурьдсан цаг хугацаатай нийцсэн алдаа, доголдолыг засч залруулах арга хэмжээг авч эхлэх хугацааг тусгасан хариуг Инженерт түргэн шуурхай хүргүүлнэ.

Алдааг засах тухай мэдэгдэлд заасан хугацаа нь хугацаа сунгах үндэслэл болохгүй.

15.2 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцлах

Энэхүү заалтын дагуу Гэрээг цуцлах нь Гэрээний дагуу болон бусад байдлаар Захиалагчийн бусад эрхийг үл хөндөнө.

15.2.1 Гэрээг цуцлах тухай Мэдэгдэл

Захиалагч нь өөрийн санаачлагаар Гэрээг цуцлах тохиолдолд Гүйцэтгэгчид гэрээг цуцлах хүсэл зоригоо илэрхийлсэн мэдэгдлийг (15.2.1 дэх хэсгийн дагуу хүргүүлж буй болохыг дурьдах) хүргүүлнэ. Мөн Гэрээг цуцлах тухай мэдэгдлийн (f), (g), (h) дэд заалтад заасны дагуу Захиалагч нь мэдэгдэл хүргүүлэх эрхтэй. Үүнд:

- (a) доорх нөхцлүүдэд:
 - (i) Алдааг засах мэдэгдлийг биелүүлээгүй;
 - (ii) 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу заавал биелэгдэх шинжтэй шийдвэр, дүгнэлт, зөвшилцэлийг биелүүлээгүй бол;
 - (iii) 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах] дэх хэсгийн дагуу гарсан МЗШЗ-ийн заавал биелүүлэх шинжтэй шийдвэр болон Гүйцэтгэгч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд
- (b) Ажлыг гүйцэтгэхгүй байх эсхүл Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхээс татгалзаж буйгаа аливаа нэгэн хэлбэрээр илэрхийлсэн бол;
- (c) Хүндэтгэх шалтгаангүйгээр 8 [Ажил эхлэх, хугацаа хойшлох болон гүйцэтгэлийн чанар] дугаар зүйлд заасны дагуу Ажлыг гүйцэтгэж чадахгүй, эсхүл Гэрээний мэдээлэлд заасан Хугацаа хойшилсоны алдангийн дээд хязгаарыг заасан бөгөөд 8.2 [Ажил дуусах хугацаа]-т заасаны дагуу төлөх хугацаа хойшилсны төлбөр нь уг дээд хэмжээнээс хэтэрсэн бол;

(d) Хүндэтгэх шалтгаангүйгээр 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзах]-д заасны дагуу Инженерээс ирүүлсэн татгалзах тухай мэдэгдлийг эсхүл 7.6 [Доголдлыг засварлах]-д хэсэгт заасан Инженерийн даалгаврыг хүлээн авснаас хойш 28 өдөрт багтаан гүйцэтгэж чадаагүй бол;

(e) 4.2 [Гүйцэтгэлийн баталгаа] хэсгийг зөрчсөн бол;

(f) 5.1 [Туслан гүйцэтгэгч]-д заасныг зөрчиж Ажлыг бүхэлд нь эсхүл ажлын хэсгийг гүйцэтгэсэн эсхүл 1.7 [Эрх шилжүүлэх] дахь хэсгийн дагуу авах шаардлагатай зөвшөөрлийг авалгүйгээр Гэрээний эрхийг шилжүүлсэн бол;

(g) дампуурсан эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол; татан буугдсан, зохион байгуулалт өөрчлөгдсөн, үйл ажиллагааг нь зогсоосон, татан буугдсан, үйл ажиллагааг цуцалсан бол; хуулийн дагуу төлөөлөгч, менежер эсхүл итгэмжлэгч зэргийг томилох шаардлагатай хариуцагч болсон бол: Гүйцэтгэгчийн зээлдүүлэгч настай төлбөрийн чадварын талаар хэлэлцээрт орсон эсхүл гэрээ байгуулсан бол; эсхүл холбогдох Хууль тогтоомжийн дагуу өмнө дурьдсантай адил төстэй эсхүл ижил төстэй үйлчлэл бүхий аливаа үйлдэл хийгдсэн, эсхүл аливаа үйл явдал болсон бол;

эсхүл Гүйцэтгэгч нь хамтарсан хэлбэртэй тохиолдолд:

(i) Түншлэлийн аль нэг гишүүнд өмнө дурьдагдсан үйл явдлуудын аль нэг бий болсон,

(ii) Энэ тухай бусад гишүүн(гишүүд) нь 1.14 (a) [Түншлэл болон түүний гишүүдийн үүрэг хариуцлага]-д заасны дагуу Захиалагчид тухайн гишүүний Гэрээгээр хүлээсэн үүргийг Гэрээнд нийцүүлж биелүүлэх талаар мэдэгдээгүй бол;

(h) Гэрээний болон ажлын бүхий л үе шатанд ямарваа нэгэн авилга, залилан, хуйвалдаан, албадлагын чанартай үйл ажиллагаанд холбогдсон болох нь хангалттай үндэслэл бүхий нотлох баримтаар нотлогдож байвал.

15.2.2 Гэрээг цуцлах

Гүйцэтгэгч нь 15.2.1 [Гэрээг цуцлах тухай мэдэгдэл] дэх заалтын дагуу мэдэгдэл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн мэдэгдэлд дурьдсан алдаа, доголдлыг залруулж чадаагүй бол Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээ цуцлах талаарх хоёр дахь мэдэгдлийг хүргүүлсэнээр Гэрээг нэн даруй цуцлах эрхтэй. Гүйцэтгэгч уг хоёр дахь мэдэгдлийг хүлээн авсан өдрөөр Гэрээг дуусгавар болсонд тооцно.

Гэвч, 15.2.1 [Гэрээг цуцлах тухай мэдэгдэл]-ийн (f), (g), (h) дэд заалтуудад заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Захиалагчаас 15.2.1 дэх заалтын дагуу Гэрээг нэн даруй цуцлахаар мэдэгдлийг хүргүүлэх эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөр Гэрээ цуцлагдсанд тооцно.

15.2.3 Гэрээг цуцалсны дараах үйл ажиллагаа

15.2.2 [Гэрээг цуцлах]-т зааснаар Гэрээ цуцлагдсан тохиолдолд Гүйцэтгэгч нь дараах үүргийг хүлээнэ:

(a) Энэхүү заалтад заасны дагуу Захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд тусгагдсан аливаа үндэслэл бүхий даалгаврыг нэн даруй биелүүлэх бөгөөд энэ дараах нөхцөлүүдийг бүрдүүлнэ:

(i) аливаа туслан гүйцэтгэгчийг томилох гэрээг байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ;

(ii) амь нас, эд хөрөнгийг хамгаалах болон Ажлын аюулгүй байдлыг хангана;

(b) Захиалагчид дор дурьдсан зүйлсийг Инженерт хүлээлгэж өгөх үүргийг хүлээнэ:

(i) Захиалагчаас шаардсан аливаа Бараа,

(ii) бүхий л Гүйцэтгэгчийн баримт бичиг,

(iii) 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг хариуцлага] дэх хэсгийн дагуу ажлын хэсгийн зураг, төслийг Гүйцэтгэгч хариуцсан бол Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн болон бусад холбогдох бүхий л зураг төсөл, баримт бичгүүд,

(c) Ажлын талбайг суллах бөгөөд, хэрвээ Гүйцэтгэгч энэхүү үүргийг үл биелүүлвэл Захиалагч нь ажлын талбайг албадан чөлөөлөх эрхтэй.

15.2.4 Гэрээг цуцлагдсаны дараа Ажлыг дуусгах

Энэхүү хэсэгт заасны дагуу Гэрээ цуцлагдсаны дараа Захиалагч нь ажлыг өөрөө гүйцэтгэж дуусгах эсхүл гуравдагч этгээдтэй харилцан зөвшилцэж ажлыг дуусгуулахаар тохиролцох эрхтэй. Ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгч болон түүний нэрийн өмнөөс хүлээлгэн өгсөн бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүдийг (мөн зураг төсөл, холбогдох баримт бичгүүд) Захиалагч болон гуравдагч этгээд ашиглах эрхтэй байна.

Дээр дурьдсан байдлаар Ажлыг гүйцэтгэж дууссан тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлд Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж болон Тур ажлыг Гүйцэтгэгчид ажлын талбайд эсхүл ажлын талбайн ойролцоо байршилд шилжүүлэн хүлээлгэн өгөх талаар мэдээлнэ. Гүйцэтгэгч нь холбогдох зардал болон эрсдэлийг хариуцан тэдгээрийг ажлын талбайг чөлөөлөх ажлыг шуурхай зохион байгуулах үүрэгтэй. Хэрэв Гүйцэтгэгч нь Захиалагчид төлөх аливаа төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүй тохиолдолд Захиалагч нь төлбөрийг барагдуулах зорилгоор тэдгээр тоног төхөөрөмж, эд зүйлсийг (холбогдох Хууль тогтоомжийн дагуу) худалдах эрхтэй. Худалдан борлуулж төлбөр бүрэн төлөгдсөний дараа үлдсэн аливаа үлдэгдэл орлогийг Захиалагчаас Гүйцэтгэгчид буцаан олгоно.

15.3 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцалсны дараах төлбөр тооцоо

15.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр Гэрээ цуцлагдсаны дараа Инженер нь 3.7 дугаар зүйлд заасны дагуу Ажлын үндсэн ажил, Бараа, Гүйцэтгэгчийн баримт бичгийн гүйцэтгэлийн үнэлгээ, Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын төлбөрийн аливаа үлдэгдэл нийт дүн зэргийг тогтоох буюу хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг явуулна. (3.7.3 [Хугацааны хязгаар] Хэсгийн дагуу цуцлах өдрийг 3.7.3 Хэсэгт заасан хэлцлийн хугацааны хязгаарыг тогтоох хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөр авна)

Энэхүү үнэлгээнд/үнийн дүнд аливаа нэмэгдсэн болон хасагдсан дүн, үлдэгдэл байгаа эсэх, мөн 14.13 дугаар зүйлийн (a) болон (b) хүсгүүдэд заасны дагуу нөхцөл байдал үүссэн эсэх талаар заавал тусгана.

Энэхүү үнэлгээнд/үнийн дүнд Гэрээнд нийцээгүй аливаа Гүйцэтгэгчийн баримт бичиг, Материал, Үндсэн тоног төхөөрөмж, машин, тоног төхөөрөмж, Ажлын үндсэн ажил зэргийн дүнг тусгахгүй.

15.4 Гүйцэтгэгчийн буруугаас гэрээг цуцалсны дараах төлбөр

Захиалагч нь 15.3 дахь заалтын дагуу харилцан зөвшөөрч тогтоосон төлбөрийг энэхүү зүйлд заасан аливаа заалтуудаар тодорхойлогдсон зардал, алдагдал, хохирол зэргийг (хэрвээ байвал) бүрэн барагдуулаагүй эсхүл запруулаагүй тохиолдолд барагдуулах хүртэл Гүйцэтгэгчид төлөхөөс татгалзах эрхтэй.

15.2 дугаар зүйлийн дагуу Гэрээ цуцлагдсан тохиолдолд Захиалагч нь 20.2-т зааснаар Гүйцэтгэгчид дараах төлбөрийг барагдуулах үүргийг хүлээнэ:

(a) 15.3-д заасны дагуу Гүйцэтгэгчид төлөх үлдэгдэл дүнг тооцсоны дараа Ажил гүйцэтгэхэд гарсан нэмэлт зардлууд болон Захиалагчаас хамаарсан нотолгоо бүхий бусад зардлууд (11.11-д заасан Ажлын талбайг чөлөөлөх, цэвэрлэх, нөхөн сэргээхтэй холбоотой гарсан зардлуудыг багтаана);

(b) Ажил гүйцэтгэх явцад Захиалагчид учруулсан аливаа алдагдал болон хохирол;

(c) Хэрвээ Ажлыг болон Ажлын хэсгийг 10.1-д заасны дагуу хүлээлгэн өгөөгүй бөгөөд 15.2-д заасан гэрээ цуцлах өдөр нь ажлыг болон Ажлын хэсгийг Ажил дуусах хугацаанд заасан хугацаанаас хойш байвал Хугацаа хойшилсны төлбөрийг төлнэ. Энэхүү Хугацаа хойшилсны төлбөрийг дээрх хоёр хугацааны хоорондын өдөр тус бүрээр тооцож төлөх үүрэгтэй.

15.5 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцлах

Захиалагч гэрээ цуцлах эрхийнхээ хүрээнд гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэхдээ Гүйцэтгэгчид гэрээг цуцлах тухай Мэдэгдлийг илгээснэ. (Тэрхүү Мэдэгдэлдээ 15.5-д заасны дагуу хүргүүлж байгаагаа дурьдаж бичнэ).

Энэхүү зүйлд заасны дагуу гэрээ цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлсний дараа Захиалагч нь:

(a) Гүйцэтгэгч нь төлбөр хүлээн авсан болон төлбөр авахаар нэхэмжилсэнээс бусад Гүйцэтгэгчийн баримт бичгүүдийг Гүйцэтгэгчид буцаан олгох шаардлагатай ба Захиалагч нь тухайн баримт бичгүүдийг цаашид ашиглах эрхгүй болно.

(b) Хэрвээ 4.6 дугаар зүйл хэрэгжих тохиолдолд Захиалагч нь аливаа Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, Түр ажил, Гүйцэтгэгчийн байгууламж, ажил, үйлчилгээ зэргийг ашиглах эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эрхгүй болно.

(c) Гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгчид буцаах арга хэмжээг авна.

Энэхүү зүйлд заасан гэрээ цуцлалт нь Гүйцэтгэгч нь Мэдэгдэл хүлээн авснаас хойш эсхүл Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааг буцаан өгснөөс хойш 28 өдрийн дараагаас хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

15.6-д заасны дагуу Гүйцэтгэгч нь үлдэгдэл төлбөрийг хүлээн аваагүй бол төлбөрийг хүлээн автال Захиалагч нь ажлыг (аливаа ажлын хэсгийг) гүйцэтгэхгүй бөгөөд бусад гуравдагч этгээдээр ажил (ажлын хэсгийг) гүйцэтгүүлэхийг хориглоно.

Гэрээ цуцлагдсаны дараа Захиалагч нь 16.3 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

15.6 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцалсны дараах төлбөрийн тооцоо

15.5 дугаар зүйлд заасны дагуу гэрээ цуцлагдсаны дараа Гүйцэтгэгч нь аль болох шуурхай доор дурьдсан холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл, баримт бичгүүдийг (Инженерийн шаардлагатай гэж үзсэн) заавал мэдүүлнэ:

(а) Хийж гүйцэтгэсэн ажлын дүн ба үүнд дараах дүнгүүдийг заавал багтаасан байна:

(i) 18.5-ийн (а)-(е) заалтуудад тогтоосон дүнгүүд, болон

(ii) 14.13-ийн (а) болон (б) заалтуудад тогтоосон аливаа нэмэгдсэн болон хасагдсан дүн, мөн төлбөрийн үлдэгдэл дүн (хэрвээ байвал);

(б) Ийнхүү гэрээг цуцалсны улмаас Гүйцэтгэгчид учирсан аливаа алдагдал болон хохирлын дүн.

Улмаар Инженер нь дээрхи (а) болон (б) хэсгүүдэд тодорхойлсон төлбөрийн дүнг зөвшөөрөх эсхүл тогтооходоо 3.7-г мөрдлөг болгоно (мөн 3.7.3-г хангах үүднээс энэхүү 15.6 дугаар зүйлийн дагуу Инженер нь Гүйцэтгэгчээс холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл, нэхэмжлэл, баримт бичгүүдийг авсан өдрийг 3.7.3-т заасан хэлцлийн хугацааны хязгаарын хүчинтай эхлэх өдрөөр тооцно).

Гүйцэтгэгчийн зүгээс Төлбөрийн нэхэмжлэл гаргах шаардлагагүйгээр Инженер нь хүлээн зөвшөөрсөн эсхүл тогтоосон үнийн дүнг тусгасан Төлбөрийн гэрчилгээг олгоно.

15.7 Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс гэрээг цуцалсны дараах төлбөр

Захиалагч нь 15.6-д заасны дагуу Төлбөрийн гэрчилгээнд тусгасан нийт дүнгээр төлбөрийг хийх бөгөөд уг зүйлд заасны дагуу Гүйцэтгэгчээс илгээсэн холбогдох баримт бичгийг Инженер хүлээн авснаас өдрөөс хойш 112 өдөрт багтаан төлбөрийг төлнө.

16. Гүйцэтгэгч ажлыг түр зогсоох ба гэрээг цуцлах

16.1 Гүйцэтгэгч ажлыг түр зогсоох

Хэрвээ:

(а) Инженер нь 14.6-д заасны дагуу IPC баталгаажуулалтыг хийж чадаагүй бол;

(б) Захиалагч нь 2.4-д заасан үндэслэл бүхий нотолгоогоор хангаж чадахгүй бол;

(с) Захиалагч нь 14.7 дугаар зүйлийг зөрчсөн бол; эсхүл

(д) Захиалагч нь дараах нөхцөлүүдийг биелүүлээгүй бол:

i. 3.7 дугаар зүйлийн дагуу заавал биелэгдэх зөвшилцэл, тохиролцоог биелүүлээгүй бол, эсхүл

ii. 21.4-д заасан МЗШЗ-ийн шийдвэрийг биелүүлээгүй бол энэ нь Захиалагчийг Гэрээний дагуу биелүүлэх үүрэг, хариуцлагаа биелүүлээгүй гэж үзэх үндэслэл болно,

Гүйцэтгэгч нь мэдэгдэл хүргүүлсэнээс хойш дээрх дэд хэсгүүдэд заасан үүрэг даалгавруудыг Захиалагч биелүүлж дуустал буюу шийдвэрлэтэл ажлыг түтгэлзүүлэх (ажлын хувь хэмжээг бууруулах) эрхтэй.

Энэхүү арга хэмжээ нь 14.8-д заасан санхүүжилтийн төлбөр болон 16.2-д заасны дагуу гэрээг цуцлах зэрэг Гүйцэтгэгчийн эрхийг хөндөхгүй.

Хэрвээ Захиалагч нь 16.2-д заасны дагуу Гүйцэтгэгчээс гэрээг цуцлах тухай мэдэгдэл ирүүлэхээс өмнө энэ зүйлд дурьдсан мэдэгдэлд тодорхойлсон үүрэг

хариуцлагатай холбоотой асуудлуудыг гүйцэтгэж шийдвэрлэсэн бол Гүйцэтгэгч нь аль болох шуурхай хэвийн үйл ажиллагааг сэргээж үргэлжлүүлэх үүрэгтэй.

Хэрвээ энэ зүйлд заасны дагуу ажлыг түр зогсоосны (ажлын хувь хэмжээг бууруулах) үр дүнд Гүйцэтгэгчид хугацаа хоцролт үүсэх эсхүл зардал гарсан тохиолдолд Гүйцэтгэгч нь 20.2-д заасны дагуу хугацаа сунгах эсхүл зардал болон Ашгийн дүнг төлүүлэх эрхийг эдэлнэ.

16.2 Гүйцэтгэгч гэрээг цуцлах

Энэ зүйлд заасны дагуу гэрээг цуцлах нь Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн болон бусад аливаа эрхийг хөндөхгүй.

16.2.1 Мэдэгдэл

Гүйцэтгэгч нь өөрийн саналаар Гэрээг цуцлах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн Мэдэгдлийг (энэхүү 16.2.1-т заасны дагуу хүргүүлж байгаагаа уг Мэдэгдэлд дурьдсан байна) Захиалагчид хүргүүлэх, эсхүл доорх дурьдсан (g) хэсгийн (ii) дахь дэд заалт, (h), (i), (j) дэд заалтуудад заасан нөхцөл байдлууд үссэн бол гэрээг цуцлах мэдэгдлийг хүргүүлэх эрхтэй. Үүнд:

(a) 2.4 дэх хэсэг зөрчигдсөний дагуу 16.1-т зааснаар мэдэгдэл хүргүүлснээс хойш 42 өдөрт багтаан Гүйцэтгэгч нь үндэслэл бүхий нотолгоог авч чадаагүй тохиолдолд;

(b) Инженер нь Төлбөрийн мэдэгдэл болон бусад холбогдох баримт бичгүүдийг хүлээн авснаас хойш 56 өдөрт багтаан Төлбөрийн гэрчилгээг гаргаж өгөөгүй тохиолдолд;

(c) Гүйцэтгэгч нь 14.7-д заасан дуусгавар болох хугацаанаас хойш 42 өдөрт багтаан Төлбөрийн гэрчилгээнд тогтоосон төлбөрийг хүлээн аваагүй тохиолдолд;

(d) Захиалагч нь дараах зөрчлүүдийг гаргасан бол:

- (i) 3.7-д заасан заавал биелүүлэх шийдвэрийг зөрчсөн; эсхүл
- (iii) 21.4-д заасны дагуу гаргасан МЗШЗ-ийн шийдвэрийг зөрчсөн

бөгөөд энэ нь Гэрээнд заагдсан Захиалагчийн үүргээ ноцтойгоор зөрчсөн тохиолдолд;

(e) Захиалагч нь өөрийн ажил үүргээ ноцтойгоор биелүүлээгүй бөгөөд энэ нь Захиалагч Гэрээгээр олгосон үүргийг ноцтой зөрчилд тооцогдсон тохиолдолд;

(f) Захиалагч нь Тендерт шалгарсан тухай захильтыг хүлээн авснаас хойш 84 өдөрт багтаан 8.1-д заасны дагуу Ажил эхлэх мэдэгдлийг хүлээн аваагүй тохиолдолд;

(g) Захиалагч нь:

- i. 1.6-д заасныг зөрчих; эсхүл
- ii. 1.7-д заасныг зөрчиж Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ шилжүүлсэн тохиолдолд;

(h) 8.12-ийн (b) заалтад тодорхойлсоны дагуу түр зогсолт нь ажилд бүхэлд нь нөлөөлсөн тохиолдолд;

(i) Захиалагч нь дампуурсан эсхүл төлбөрийн чадваргүй болсон; татан буугдсан, хуулийн дагуу арга хэмжээ авагдсан, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтөнд орсон, үйл ажиллагааг нь зогсоосон, татан буугдсан, хуулийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон;

(j) Захиалагч нь Гэрээний болон ажлын бүхий л үе шатанд ямарваа нэгэн авилга, залилан, хуйвалдаан, албадлагын чанартай үйл ажиллагаанд холбогдсон болох нь хангальтай үндэслэл бүхий нотлох баримтаар тогтоогдсон бол.

16.2.2 Гэрээг цуцлах

Хэрвээ Захиалагч нь 16.2.1-т заасны дагуу хүргүүлсэн Мэдэгдэлд дурьдсан зөрчил, догондлыг уг Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 өдрийн дотор шийдвэрлэж, засч залруулж чадаагүй бол Гүйцэтгэгчээс Гэрээг цуцлах талаар мэдэгдсэн хоёр дахь мэдэгдлийг хүргүүлсэнээр гэрээг нэн даруй цуцлах эрхтэй. Энэ тохиолдолд хоёр дахь мэдэгдлийг Захиалагч хүлээн авсан өдрийг Гэрээг цуцлах өдрөөр тооцно.

Хэрвээ 16.2.1-ийн (g) заалтын (ii) дэд заалт, (h), (i) эсхүл (j) дэд заалтуудад заасан нөхцөл байдал үүссэн бол Гүйцэтгэгч нь 16.2.1-д заасны дагуу мэдэгдлийг хүргүүлсэнээр Гэрээг нэн даруй цуцлах эрхтэй бөгөөд Гэрээг цуцлах өдрийг Захиалагч уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөр тооцно.

Хэрвээ дээр дурьдсан 14 хоногийн хугацаанд Гүйцэтгэгчид хоцролт болон Зардалтай холбоотой хохирол учирсан тохиолдолд 20.2-д заасны дагуу Хугацааг сунгах болон учирсан зардал болон ашиг зэрэг төлбөрийг гаргуулах эрхтэй.

16.3 Гэрээ цуцалсны дараах Гүйцэтгэгчийн үүрэг

Гэрээг 15.5, 16.2, 18.5 дугаар зүйлүүдэд заасны дагуу цуцласны дараа Гүйцэтгэгч нь дараах үүргүүдийг нэн даруй хүлээнэ:

(a) Ажлын аюулгүй байдал, хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах үүднээс Инженерээс өгөгдсөн чиглэл зааварт хамаарах ажлаас бусад цаашдын бүхий үйл ажиллагааг зогсоно. Хэрвээ Инженерийн өгсөн чиглэл зааврын дагуу ажил гүйцэтгэсний улмаас Гүйцэтгэгчид Зардал гарсан тохиолдолд 20.2-д заасны дагуу Гүйцэтгэгч нь хугацаа сунгуулах ба зардал болон ашиг зэрэг төлбөрийг гаргуулах эрхтэй.

(b) Бүхий л Гүйцэтгэгчийн баримт бичиг, үндсэн тоног төхөөрөмж, материал болон бусад хэрэгслийд болон Гүйцэтгэгч төлбөр авч гүйцэтгэсэн бусад ажлуудыг Инженерт хүлээлгэн өгнө.

(c) Ажлын талбайн аюулгүй ажиллагаанд хамаарахаас бусад бүх барааг Ажлын талбайгаас гаргаж, чөлөөлнө.

16.4 Гүйцэтгэгчийн санаалаар гэрээ цуцалсны дараах төлбөр

16.2-д заасны дагуу Гэрээг цуцласан тохиолдолд Захиалагч нь дараах үүргийг хүлээнэ:

(a) 18.5-д заасны дагуу Гүйцэтгэгчид төлбөрийг төлнө.

(b) Гүйцэтгэгч нь 20.2-д заасныг биелүүлсэн бол гэрээг цуцалсны улмаас Гүйцэтгэгчид учирсан аливаа ашгийн алдагдал эсхүл бусад алдагдал, хохирлыг төлж

17. Гүйцэтгэсэн ажлыг хамгаалах ба нөхөн төлбөр

17.1 Ажлыг арчилж, хамгаалах

Хэрэв эдгээр нөхцөлийн дагуу, эсхүл өөр байдлаар Гэрээ цуцлагдаагүй бол Гүйцэтгэгч нь, ажил, бараа материал болон Гүйцэтгэгчийн баримт бичгийг аричилж, хамгаалах үүргийг Гэрээний 17.2 [Ажлыг арчилж, хамгаалахтай холбогдох хариуцлага]-ийн дагуу ажлыг Эхлэх өдрөөс, ажил дуусах огноо хүртэл буюу дээрх

үүрэг Захиалагчид шилжих хүртэл бүрэн хүлээнэ. Хэрэв, ажлыг хүлээн авсан гэрчилгээ нь хэсэг ажил, эсхүл ажлын бүрдэл хэсэгт олгогдсон (эсхүл олгосон гэж үзсэн) бол, энэхүү хэсэг ажил, эсхүл ажлын бүрдлийг арчилж хамгаалах үүрэг. Захиалагчид шилжинэ.

Хэрэв Гэрээ нь эдгээр нөхцөлийн дагуу, эсхүл өөр байдлаар цуцлагдсан бол Гүйцэтгэгч нь гэрээ цуцлагдсан өдрөөс ажлыг арчилж, хамгаалах үүрэг хүлээхээ болино.

Уг үүрэг зохих ёсоор Захиалагчид шилжсэний дараа, Гүйцэтгэгч нь ажил дууссан огноогоор таслагдсан дуусаагүй үлдсэн ажлыг арчилж хамгаалах үргийг, эдгээр дуусаагүй ажил дуустал хүлээнэ.

Хэрэв Ажил, бараа, материал болон Гүйцэтгэгчийн баримт бичгийг арчилж, хамгаалах үүрэг хүлээсэн хугацаанд нь тэдгээрт, Гэрээний 17.2 [Ажлыг арчилж хамгаалахтай холбогдох хариуцлага]-т тусгагдсанаас бусад аливаа шалтгаанаас ямар нэгэн эвдрэл, эсхүл хохирол үүссэн бол, Гүйцэтгэгч нь эдгээр эвдрэл, хохирлыг өөрийн эрсдэл ба зардлаар, тухайн ажил, бараа, материал болон Гүйцэтгэгчийн баримт бичиг нь (нөхцөл байдлаас хамаарч) Гэрээний шаардлагад нийцсэн байх хэмжээнд засварлаж, арилгана.

17.2 Ажлыг арчилж, хамгаалахтай холбогдох хариуцлага

Гүйцэтгэгч нь Ажил хүлээн авсан гэрчилгээг олгосноос хойш Гүйцэтгэгчээс шалтгаалан Ажил, бараа материал болон Гүйцэтгэгчийн баримт бичигт үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохирлыг хариуцна. Гүйцэтгэгч нь ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө нь түүний хариуцлага хүлээж байсан үйл явдлаас үүдэлтэй бөгөөд ажил хүлээн авсан гэрчилгээг олгосноос хойш ил болсон аливаа эвдрэл, эсхүл хохирлын хариуцлагыг мөн хүлээнэ.

Ажил, бараа материал, болон Гүйцэтгэгчийн баримт бичигт доор дурдсан үйл явдлын аль нэг (эдгээр Ажил, Бараа материал, болон Гүйцэтгэгчийн баримт бичгээс Инженер нь доор дурдсан үйл явдлуудын аль нэг нь үүсэхээс өмнө, Гэрээний 7.5 [Доголдол ба түүнийг хүлээн авахаас татгалзал]-ийн дагуу татгалzsанаас бусад тохиолдолд) шалтгаанаас үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохиролд, нөхөн төлбөрөөр эсхүл өөр байдлаар Гүйцэтгэгч ямар нэг хариуцлага хүлээхгүй:

(a) Ажлыг Гэрээний дагуу гүйцэтгэсний зайлшгүй үр дүн болсон (Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлын аргачлалаас үүдэлтэйгээс бусад) дурын нэвтрэх эрх, гэрэл, агаар, ус, эсхүл бусад ашиглах эрх бүхий түр, эсхүл байнгын нөхцөл байдал;

(b) Байнгын ажлын, Гэрээнд тусгагдсан байж болохоос бусад аливаа хэсгийг Захиалагч ашигласан, эсхүл эзэмшсэн;

(c) Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Гүйцэтгэгч боловсруулсан зураг төслөөс бусад, Захиалагчийн болосвруулсан ажлын зураг төслийн ямар нэгэн бүрэлдэхүүн хэсэгт гарсан, эсхүл Захиалагчийн шаардлага болон Зурагт байж болох (ба туршлагатай гүйцэтгэгч Үнийн саналаа танилцуулахаас өмнө Талбай, Захиалагчийн шаардлага болон Зураг төслийг шалгаж танилцан, судлахдаа зохих байдлаар арчилж, хамгаалсан ч олж илрүүлэхгүй байсан) алдаа, дутагдал, доголдол, эсхүл орхигдсон зүйл;

(d) Урьдчилсан таамаглах боломжгүй, эсхүл түүний эсрэг авах хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээг туршлагатай гүйцэтгэгчээс ч зохих байдлаар хүлээх боломжгүй байсан байгалийн хүчиний (Гүйцэтгэгчид зориулан Гэрээний мэдээлэлд тусгаснаас бусад) аливаа үйлчлэл;

(e) Гэрээний 18.1 [Давагдашгүй хүчин зүйл]-ийн (a)-аас (f) заалтад жагсаасан үйл явдал, эсхүл нөхцөл байдлын аль нэг;

(f) Захиалагчийн ажилчид, эсхүл Захиалагчийн бусад гүйцэтгэгчдийн аливаа үйлдэл, эсхүл зөрчил.

Хэрэв Ажил, бараа материал, болон Гүйцэтгэгчийн баримт бичигт дээрх (a)-аас (f) заалтад тодорхойлсон үйл явдлаас аль нэг нь тохиолдсон ба эвдрэл, хохиролд хүргэсэн тохиолдолд, Гүйцэтгэгч нь Гэрээний 18.4 [Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар]-д хамааруулан, Инженерт яаралтай Мэдэгдэл өгнө. Үүний дараа Гүйцэтгэгч нь, Инженерийн зааварчилсан хэмжээнд үүсэж болох аливаа тийм эвдрэл ба/эсхүл хохирлыг засаж, арилгана. Ийм зааварчилгааг Гэрээний 13.3.1 [Зааварчилгаагаар оруулах Өөрчлөлт]-ийн дагуу өгөгдсөн гэж үзнэ.

Хэрэв Ажил, бараа материал болон Гүйцэтгэгчийн баримт бичгийн эвдрэл, эсхүл хохирол нь доорх зүйлсийн нэгдлээс үүдэлтэй бол:

- (1) дээрх гэрээниййн (a)-аас (f) заалтад дурдсан ямар нэгэн үйл явдал, ба
- (2) Гүйцэтгэгч хариуцлага хүлээх шалтгаанаас,

ба Гүйцэтгэгч энэхүү эвдрэл, хохирлыг засаж, арилгаснаас болж хугацаа хоцорсон ба/эсхүл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь, дээр дурдсан аливаа үйл явдал нь энэхүү саатал ба/эсхүл Зардалд нөлөөлсөн тийм хэмжээгээр Хугацаа сунгах ба/эсхүл Өртөг болон ашгийн хувь хэмжээг, Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийн дагуу нэхэмжлэх эрхтэй.

17.3 Оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх

Энэхүү гэрээний “зөрчил” гэдэг нь Ажилтай холбогдолтой аливаа зохиогчийн эрхийн гэрчилгээний, бүртгэгдсэн зураг төслийн, зохиогчийн эрхийн, худалдааны тэмдгийн, худалдааны нэрийн, худалдааны нууцын, эсхүл бусад оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрхийн зөрчил (эсхүл сэжигтэй зөрчил) гэсэн утгыг илэрхийлнэ; түүнчлэн “нэхэмжлэл” гэж дээр дурдсан эрхийг зөрчсөн гэж үзсэн гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг (эсхүл гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг) хэлнэ.

Хэрэв нэг Тал нь нэхэмжлэл хүлээн авсан боловч түүнээс хойш 28 хоногийн дотор Нөгөө талдаа ямар нэгэн нэхэмжлэлийн мэдэгдэл өгөөгүй бол, Тухайн нэхэмжлэл хүлээн авсан Талыг энэхүү Гэрээниййн дагуух хохирлыг нөхөн төлүүлэх аливаа эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

Захиалагч нь зөрчсөн гэж үзсэн бөгөөд доор дурдсан үр дагавар болж байгаа, эсхүл болсон аливаа нэхэмжлэлийн хариуцлагаас (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) Гүйцэтгэгчийг ангид байлгаж, хохиролгүй болгох үүрэгтэй:

(a) Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлага, зураг ба/эсхүл аливаа Өөрчлөлтийг дагаж мөрдсөний гарцаагүй үр дагавар; эсхүл

(b) Захиалагчаас ямар нэгэн ажлыг дараах байдлаар ашигласны үр дагавар:

(1) Гэрээнд зааснаас, эсхүл Гэрээнээс үндэслэлтэйгээр үүсэж болохоос өөр зорилгоор, эсхүл

(2) хэрэв тухайн ашиглалтын талаар Суурь огнооноос өмнө Гүйцэтгэгчид мэдэгдээгүй, эсхүл Гэрээнд энэ талаар тусгаагүй бол, Гүйцэтгэгчийн ханган нийлүүлээгүй аливаа зүйлтэй холбоотойгоор.

Гүйцэтгэгч нь зөрчсөн гэж үзсэн бөгөөд доор дурдсан зүйлээс, эсхүл түүнтэй холбоотойгоор гарсан аливаа бусад нэхэмжлэлийн хариуцлагаас (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) Захиалагчийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэгтэй:

- (1) Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэл; эсхүл
- (2) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг ашигласан.

Хэрэв нэг Тал нь энэхүү Гэрээнийийн дагуу нөхөн төлбөр авах эрхтэй бол, нөхөн төлбөр барагдуулах Тал нь (нөхөн төлбөрийг барагдуулж буй Талын өөрийн зардлаар) нэхэмжлэлийг шийдэх хэлэлцээрийг хийх, ба/эсхүл үүнээс үүсэж болох аливаа маргаан таслах болон арбитрын үйл ажиллагааг зохицуулах бүх хариуцлагыг өөртөө авна. Нөгөө Тал нь нөхөн төлбөрийг барагдуулж буй Талын хүсэлтийг харгалзан, түүний зардлаар, нэхэмжлэлийн маргаанд туслалцаа үзүүлнэ. Хэрэв нөхөн төлбөрийг барагдуулж буй Тал нь нөгөө Талаас ингэх хүсэлт гаргасны дараа, ямар нэгэн хэлэлцээр хийх, маргаан таслах болон арбитрын үйл ажиллагааг зохицуулах бүх хариуцлагыг өөртөө шуурхай аваагүй бол, энэхүү нөгөө Тал (ба нөхцөл байдлаас хамааран, Гүйцэтгэгчийн ажилчид эсхүл Захиалагчийн ажилчид) нь нөхөн төлбөрийг барагдуулах Талд хор хохирол учруулж болох ямар нэгэн үйлдлийг гаргахгүй байх үүрэгтэй.

17.4 Гүйцэтгэгчийн төлөх нөхөн төлбөр

Гүйцэтгэгч нь доорх асуудлуудтай холбогдолтойгоор гарсан гуравдагч этгээдийн бүх нэхэмжлэл, хохирол, алдагдал, зардал (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан)-ын хариуцлагаас Захиалагч, Захиалагчийн ажилчид, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийг ангид байлгаж ба хохиролгүй болгох үүрэг хүлээнэ:

(a) Захиалагч, Захиалагчийн ажилчид, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, дур зоргоороо буюу санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнтэй хамааралтайгаас бусад, Гүйцэтгэгчийн ажлыг гүйцэтгэлээс, эсхүл ажлыг гүйцэтгэх үед, эсхүл Гүйцэтгэгч ажлыг гүйцэтэсэн шалтгаанаар тохиолдсоны аль нь ч байсан, хэн нэгэн гэмтэж бэртэх, өвчлөх, нас барах; ба

(b) дараах нөхцөлөөс үүдэлтэй бөгөөд тийм хэмжээний аливаа хөдлөх болон үл хөдлөх (Ажлаас бусад) өмч, хөрөнгөд гарсан эвдрэл, учирсан хохирол:

(1) Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэлээс, эсхүл Ажлыг гүйцэтгэх үед, эсхүл Гүйцэтгэгч Ажлыг гүйцэтгэсэн шалтгаанаар, ба

(2) Гүйцэтгэгч, Гүйцэтгэгчийн ажилчид, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн, эсхүл энд дурдагдсан этгээдүүдийн шууд ба шууд бусаар хөлсөлсөн хэн нэгний аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнд хамааруулж болох.

Гүйцэтгэгч нь Байнгын ажлын бүрдэл хэсгийн зураг төслийн хариуцлагыг Гэрээний 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг]-ийн дагуу ба/эсхүл, аливаа бусад зураг төслийнхийг Гэрээний дагуу хүлээх тохиолдолд, хэрэв байгаа бол, ажил (эсхүл хэсэг ажил, эсхүл ажлын бүрдэл хэсэг, эсхүл үндсэн тоног төхөөрөмжийн томоохон хэсэг) нь хийгдэж дууссаныхаа дараа Гэрээний 4.1 [Гүйцэтгэлийн ерөнхий үүрэг]-ийн дагуу төлөвлөгдсөн зорилгод тохирохгүй байхад хүргэсэн, зураг төслийн үүргээ биелүүлэхдээ Гүйцэтгэгчийн гаргасан бүх үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас Захиалагчийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэг хүлээнэ.

17.5 Захиалагчийн төлөх нөхөн төлбөр

104

Захиалагч нь доорх асуудлуудтай холбогдолтойгоор гарсан гуравдагч этгээдийн бүх нэхэмжлэл, хохирол, алдагдал, зардал (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан)-ын хариуцлагаас, Гүйцэтгэгч, Гүйцэтгэгчийн ажиллагсад, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэгтэй:

(а) Захиалагч, Захиалагчийн ажилчид, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, дур зоргоороо буюу санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнтэй хамааралтай хэн нэгний гэмтэл бэртэл, өвчин, нас баралт, эсхүл Ажлаас бусад өмч, хөрөнгөд гарсан эвдрэл, учирсан хохирол; ба

(б) 17.2 [Ажлыг арчилж, хамгаалах хариуцлага] Гэрээний (а)-аас (f) дэд хэсэгт тодорхойлсон аливаа нөхцөл байдал, үйл явдлаас үүдэн гарсан аливаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөд (Ажилд хамааралгүй бусад) гарсан эвдрэл, хохирол.

17.6 Хамтран төлөх нөхөн төлбөр

Гэрээний 17.4 [Гүйцэтгэгчийн нөхөн төлбөр]-ийн ба/эсхүл Гэрээний 17.3 [Оюуны ба аж үйлдвэрийн өмчийн эрх]-ийн дагуу Захиалагчид нөхөн төлбөр төлөх Гүйцэтгэгчийн үүргийг, Гэрээний 17.2 [Ажлыг арчилж, хамгаалахтай холбогдох хариуцлага]-ын (а)-аас (f) заалтуудад тодорхойлсон аливаа үйл явдалтай холбоотой аливаа эвдрэл, хохирол, эсхүл гэмтлийн нөхөн төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн бууруулна.

Үүнтэй нэгэн адилаар, Гэрээний 17.5 [Захиалагчийн нөхөн төлбөр]-ийн дагуу Гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлөх Захиалагчийн үүргийг, Гэрээний 17.1 [Ажлыг арчилж, хамгаалах үүрэг]-ийн ба/эсхүл Гэрээний 17.3 [Оюуны ба аж үйлдвэрийн өмчийн эрх]-ын дагуу Гүйцэтгэгч хариуцлага хүлээх аливаа үйл явдлаас дээрх эвдрэл, хохирол, эсхүл гэмтэлд нөлөөлсөн байж болох хэмжээгээр хувь тэнцүүлэн бууруулна.

18. Давагдашгүй хүчин зүйл

18.1 Давагдашгүй хүчин зүйл

Давагдашгүй хүчин зүйл гэж:

- (1) аль нэг талын хяналтаас давсан;
 - (2) тухайн Тал Гэрээнд гарын үсэг зурахаас өмнө, зогсоох боломжит арга хэмжээ авах боломжгүй байсан;
 - (3) үүссэн үед нь тухайн Тал зайлсхийх, эсхүл даван туулж чадахгүй; ба
 - (4) нөгөө Талд хамааралгүй
- үйл явдал, эсхүл нөхцөл байдлыг хэлнэ.

Дээрх (1)-ээс (4)-д дурдсан заалтууд хангагдаж байгаа нөхцөлд, Давагдашгүй хүчин зүйл нь дараах үйл явдал, эсхүл нөхцөл байдлын алинаас ч бүрдэж болох ба гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) дайн, байлдааны үйл ажиллагаа (дайн гэж зарлагдсан эсэхээс үл хамааран), халдлага, гадны дайсны аливаа үйлдэл;

(б) бослого, алан хядах үйл ажиллагаа, хувьсгал, үймээн самуун, цэргийн болон булаан эзлэгчдийн эргэлт, иргэний дайн;

(с) гүйцэтгэгчийн ажилчид, өмнө Гүйцэтгэгчийн болон түүний Туслан гүйцэтгэгчдийн ажиллуулж буй бусад ажилчдаас өөр этгээдийн гаргасан нийгмийн хэв журмын зэрчил, үймээн самуун, эмх замбараагүй байдал;

(д) Гүйцэтгэгчийн ажилчид, мөн Гүйцэтгэгчийн болон түүний Туслан гүйцэтгэгчдийн ажиллуулж буй бусад ажилчдыг зөвхөн хамруулаагүй ажил хаялт, эсхүл ажилчдыг олноор нь халах ажиллагаа;

(е) Гүйцэтгэгчийн хэрэгцээнд хамааруулж болох зэр зэвсэг, тэсрэх материал, цацраг туяа, эсхүл цацраг идэвхт бодисоос бусад дайн байлдааны зэр зэвсэг, тэсрэх материал, ионжсон цацраг туяа буюу цацраг идэвхт бодисоор бохирдох тохиолдолд;

(f) газар хөдлөлт, далайн шуурга, хуй салхи, галт уулын дэлбэрэлт гэх мэт байгалийн сүйрэл, гамшиг.

18.2 Давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдэл

Хэрэв нэг Тал нь (энэхүү Гэрээний “нөлөөлөлд өртсөн Тал” гэх) давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээний дагуу хүлээсэн ямар нэгэн үүргээ биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүйд хүрэхээр байгаа бол, нөлөөлөлд өртсөн Тал нь нөгөө Талдаа энэхүү давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдэл өгөн, биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүйд хүрэхээр байгаа үүргийг (энэхүү Гэрээний “саатсан үүрэг” гэх) тодорхой дурдсан байна.

Нөлөөлөлд өртсөн Тал нь давагдашгүй хүчин зүйлийг олж мэдсэнээс, эсхүл олж мэдэх ёстой байснаас хойш 14 хоногийн дотор энэхүү Мэдэгдлийг өгсөн байх ба нөлөөлөлд өртсөн Тал дараа нь давагдашгүй хүчин зүйлээс болж энэхүү үүрэг saatсан огнооноос эхлэн, saatсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно. Хэрэв энэ Мэдэгдлийг нөгөө Тал нь дээрх 14 хоногийн хугацаа өнгөрсний дараа хүлээн авсан бол, нөлөөлөлд өртсөн Тал нь нөгөө Талын энэхүү Мэдэгдлийг хүлээн авсан огнооноос эхлэн, saatсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно.

Үүнээс дараа, энэхүү давагдашгүй хүчин зүйл нь нөлөөлөлд өртсөн Талын үүргээ биелүүлэхэд нь саад болсон хугацаагаар, нөлөөлөлд өртсөн Тал нь saatсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно. Нөлөөлөлд өртсөн Тал нь saatсан үүргийг биелүүлэхээс бусад, Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхээс чөлөөлөгдөхгүй.

Гэсэн хэдий ч, нөгөө Талдаа Гэрээний дагуу зохих төлбөр хийх аль ч Талын үүргийг давагдашгүй хүчин зүйлээр чөлөөлөхгүй.

18.3 Ажлын хойшлох хугацааг бууруулах үүрэг

Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавраас шалтгаалан Гэрээний биелэлтэд үүсэх аливаа saatлыг хамгийн бага хэмжээнд байлгах бүхий л боломжит хүчин чармайлтыг Тал тус бүр, ажлын нийт хугацааны туршид гаргаж ажиллах ёстой.

Хэрэв давагдашгүй хүчин зүйл нь үргэлжилсэн нөлөөтэй байвал, нөлөөлөлд өртсөн Тал нь Гэрээний 18.2 [Давагдашгүй хүчин зүйлийн талаарх Мэдэгдэл]-ийн дагуу эхний Мэдэгдэл өгснөөс хойш 28 хоног тутамд, тухайн нөлөөллийг тодорхой дурдсан нэмэлт Мэдэгдлийг өгч байна.

Нөлөөлөлд өртсөн Тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл зогссон үед нөгөө Талдаа яаралтай мэдэгдэл өгнө. Хэрэв нөлөөлөлд өртсөн Тал нь яаралтай мэдэгдээгүй бол, нөлөөлөлд өртсөн Талын үүргийн биелэлт нь цаашид давагдашгүй хүчин зүйлээр дахин саатахгүй гэж нөгөө Тал үзэж буйгаа, шалтгааны хамт тодорхой дурдсан мэдэгдлийг нөгөө Тал нь нөлөөлөлд өртсөн Талд өгнө.

18.4 Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар

Хэрэв Гүйцэтгэгч нь нөлөөлөлд өртсөн Тал бөгөөд, Гэрээний 18.2 [Давагдашгүй хүчин зүйлийн талаарх Мэдэгдэл]-ийн дагуу тэрээр Мэдэгдэл өгсөн давагдашгүй хүчин зүйлээс үүдсэн шалтгаанаар, сааталтай тулгарсан ба/эсхүл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийн дагуу:

(a) Хугацаа сунгах ба/эсхүл

(b) хэрэв Давагдашгүй хүчин зүйл нь Гэрээний 18.1 [Давагдашгүй хүчин зүйл]-ийн (a)-(e) заалтад тодорхойлсон төрлийнх ба, мөн тус Гэрээний (b)-ээс (e) заалтад тодорхойлсон төрлийнх ба, тухайн Улсад болсон тохиолдолд, энэхүү Зардлаа төлүүлэх эрхтэй.

18.5 Гэрээ цуцлах эрх

Хэрэв явагдаж байсан бүх ажлын ихэнх хэсгийн гүйцэтгэл нь, Гэрээний 18.2 [Давагдашгүй хүчин зүйлийн талаарх Мэдэгдэл]-ийн дагуу Мэдэгдэл өгөгдсөн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан 84 хоногийн хугацаанд үргэлжлэн зогссон, эсхүл мөн дээрх мэдэгдсэн давагдашгүй хүчин зүйлээс болж, хэсэгчилсэн хугацаагаар хэд хэдэн удаа давтагдан, нийтдээ 140 хоногоос илүү хугацаанд зогссон бол, аль ч Тал нь нөгөө Талдаа Гэрээг цуцлах мэдэгдэл өгч болно.

Энэ тохиолдолд, Гэрээг цуцлах огноо нь нөгөө Тал Мэдэгдэл хүлээн авснаас хойших 7 хоногийн дараах огноо байх ба Гүйцэтгэгч нь Гэрээний 16.3 [Гэрээг цуцалсны дараа Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг]-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллана.

Гүйцэтгэгч нь гэрээ цуцлагдсан өдрөөс хойш, гүйцэтгэсэн ажлын өртгийн, доорх зардлуудыг хамруулсан нарийвчилсан нэмэлт мэдээллүүдийг (Инженерээс үндэслэлтэйгээр шаардсаны дагуу) аль болох боломжтой богино хугацаанд хүргүүлнэ:

(a) Хийж гүйцэтгэсэн аливаа ажлын Гэрээнд заасан дүнгээр тооцсон төлвөл зохих дүн;

(b) Гүйцэтгэгчид хүргүүлсэн, эсхүл өөр дээрээ хүлээн авах хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээх, ажилд зориулан захиалсан үндсэн тоног төхөөрөмж болон материалын Зардал. Захиалагч төлбөрийг нь хийснээр эдгээр үндсэн тоног төхөөрөмж болон материал нь Захиалагчийн (эрсдэлийг өөрөө хүлээнэ) өмч болох ба Гүйцэтгэгч нь тэдгээрийг Захиалагчийн мэдэлд байршуулна;

(c) Ажил дуусахыг хүлээх хооронд, үүссэн нөхцөл, байдалд Гүйцэтгэгчээс үндэслэлтэйгээр гаргасан бусад зардал, эсхүл хүлээсэн өр төлбөр;

(d) Түр ажил болон Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг Талбайгаас нүүлгэж тэдгээр зүйлсийг Гүйцэтгэгчийн улсад байгаа түүний ажил руу (эсхүл өөр бусад байршил руу, илүү зардал гаргахгүйгээр) буцаах Зардал; ба

(e) Гэрээ цуцлагдсан өдөр хүртэл ажилтай холбогдуулан хөлслөн ажиллуулж байсан Гүйцэтгэгчийн ажилчдыг бүгдэнг нь эх оронд нь буцаахтай холбоотой зардал.

Дараа нь Инженер хийсэн ажлын өртгийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр Гэрээний 3.7 [Тохиролцох, эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллах (ба Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ын зорилгоор, энэхүү гэрээнийийн дагуу хүргүүлсэн Гүйцэтгэгчийн нарийвчилсан нэмэлт мэдээллийг Инженер хүлээн авсан огноо нь Гэрээний 3.7.3-ын дагуух тохиролцох хугацааны хязгаарын эхлэх огноо болно.)

Инженер нь, ийнхүү тохиролцсон, эсхүл шийдвэрлэсэн мөнгөн дүнд Гүйцэтгэгчээс Тайлан шаардахгүйгээр, Төлбөрийн гэрчилгээг Гэрээний 14.6 [Явц дундын төлбөрийн гэрчилгээг олгох]-ийн дагуу олгоно.

18.6 Хуулийн дагуу гэрээний үүргээс чөлөөлөх

Энэхүү Зүйлийн аливаа бусад заалт дээр нэмээд, хэрэв Талуудын хяналтаас давсан ямар нэгэн тохиолдол буюу нөхцөл байдал (давагдашгүй хүчин зүйлийг оролцуулан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) үүссэн бөгөөд тэр нь:

(а) аль нэг Талыг, эсхүл хоёр Талыг хоёуланг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй, эсхүл хууль бус болгож байгаа; эсхүл

(б) Гэрээг цаашид биелүүлэхээс чөлөөлөгдөх эрхийг, Гэрээг зохицуулах хуулиар Талуудад олгож байгаа,

ба хэрэв Талууд нь Гэрээг үргэлжлүүлэн биелүүлэх боломж олгох байсан гэрээний нэмэлт өөрчлөлтийг тохиролцож чадаагүй бол, ийм тохиолдол буюу нөхцөл байдлын талаарх Мэдэгдлийг аль нэг Тал нь нөгөө Талдаа өгсний дараа:

(1) урьд нь Гэрээг зөрчсөн аливаа зөрчилтэй холбоотой аль нэг Талын эрхийг хөндөхгүйгээр, Талууд цаашид үүргээ биелүүлэхээс чөлөөлөгднө; түүнчлэн

(2) Захиалагчаас Гүйцэтгэгчид төлвэл зохих дүн нь Гэрээний 18.5 [Гэрээг цуцлах эрх]-ын дагуу төлөгдөх байсан дүнтэй ижил байх ба Инженер нь энэхүү дүнг, Гэрээ тухайн Гэрээний дагуу цуцлагдсан хэмээн үзэж баталгаажуулна.

19. Даатгал

19.1 Ерөнхий шаардлагууд

Гүйцэтгэгч нь аль ч Талын Гэрээгээр хүлээсэн үүрэг эсхүл хариуцлагыг хязгаарлахгүйгээр, Гүйцэтгэгч хариуцлага хүлээх бүх даатгалыг Инженерийн зөвшөөрсөн даатгагч болон нөхцөлөөр хийлгэж, түүний хүчинтэй байдлыг хариуцна. Эдгээр нөхцөлүүд нь Тендерт шалгарсан тухай захидал хүргүүлэх өдрөөс өмнө хоёр Тал тохиролцсон аливаа нөхцөлүүдтэй (хэрэв байгаа бол) тохирч байх ёстой.

Энэхүү Зүйлийн дагуу заавал хамрагдах шаардлагатай даатгалууд нь Захиалагчаас шаардах хамгийн энгийн даатгалууд бөгөөд Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар Гүйцэтгэгчид шаардлагдах бусад даатгалуудад нэмж даатгуулж болно.

Захиалагчаас шаардсан үед Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу заавал хийлгэх шаардлагатай гэрээний нөхцөлийг боловсруулна.

Даатгалын хураамж төлөгдсөн тохиолдолд бүрд Гүйцэтгэгч нь даатгалын төлбөрийн баримтын хуулбарыг эсхүл тухайн хураамж төлөгдсөн тухай даатгагчаас баталгаажуулсан баримтыг Захиалагчид (хуулбарыг Инженерт) нэн даруй хүргүүлнэ.

Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээний 19.2 [Гүйцэтгэгчийн хийлгэх даатгал]-ийн дагуу шаардагдах аливаа даатгалыг хийлгэж, хүчинтэй байлгах үүргээ биелүүлээгүй бол, ийм аливаа тохиолдолд, Захиалагч нь эдгээр даатгалыг хийлгэн, хүчинтэй байлгах, мөн шаардлагатай байж болох даатгалын хураамжийг төлөх бөгөөд Гүйцэтгэгчид төлбөл зохих аливаа мөнгөнөөс ийнхүү төлсөн дүнг үе үе суутгах замаар түүнийгээ Гүйцэтгэгчээс нөхөж авах, эсхүл Гүйцэтгэгчийн өр төлбөр хэлбэрээр өөр байдлаар эргэн төлүүлэх эрхтэй. Энэхүү Гэрээний Зүйл 20 [Захиалагчийн ба Гүйцэтгэгчийн нэхэмжлэл]-ийн заалтуудыг хэрэглэхгүй.

Хэрэв Гэрээний дагуу хийгдсэн даатгалын аливаа нөхцөлийг Гүйцэтгэгч, эсхүл Захиалагчийн аль нэг дагаж мөрдөөгүй бол, ийнхүү дагаж мөрдөөгүй Тал нь

тухайн зөрчлөөс үүссэн бүх шууд хохирол ба нэхэмжлэлийг (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) нөгөө Талдаа нөхөн төлнө.

Мөн Гүйцэтгэгч нь дараах үүрэг, хариуцлагыг хүлээнэ:

(а) Ажлын шинж байдал, цар хэмжээнд, эсхүл түүнийг гүйцэтгэх төлөвлөгөөнд орсон аливаа өөрчлөлтийг даатгалын байгууллагад мэдээлэх; ба

(б) Гэрээг гүйцэтгэх бүхий л хугацааны туршид Гэрээний дагуу даатгалын хүрэлцээтэй болон хүчин төгөлдөр байдлыг тогтмол хангах.

Аливаа гэрээнд зөвшөөрсөн хасаж тооцож болох зөвшөөрөгдсөн хязгаар нь Гэрээний мэдээлэлд заасан дүнгээс (хэрэв заагаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүн байна) хэтрэх ёсгүй.

Хэрвээ Гүйцэтгэгч эсхүл Захиалагч нь энэхүү зүйлийг зөрчсөнөөс үүсгэгдээгүй ба даатгалын байгууллагаас нөхөн төлбөр хийгдэхгүй, хуваагдмал хариуцлага байгаа үед хохирлыг Талуудын хүлээх хариуцлагын дагуу хувааж барагдуулна. Даатгалын байгууллагаас нөхөн төлбөр хийгдэхгүй нь дээрх зөрчлөөс шалтгаалсан бол, үүссэн хохирлыг тухайн зөрчил гаргасан Тал нь хариуцна.

19.2 Гүйцэтгэгчийн хариуцах даатгал

Гүйцэтгэгч нь дараах даатгалыг хийлгэнэ:

19.2.1 Ажлын даатгал

Гүйцэтгэгч нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хамтарсан нэр дээр Ажил эхлэх огноонд заагдсан өдрөөс Ажил хүлээн авсан гэрчилгээг олгох өдөр хүртэл хугацаанд дараах нөхцөлүүдийг ханган даатгуулах ба даатгалтай байлгана:

(а) Ажлыг ба Гүйцэтгэгчийн баримт бичгийг, Ажилд нийлүүлсэн үндсэн тоног төхөөрөмж ба материалын хамт, тэдгээрийг бүрэн солих үнийн дүнгээр. Зураг төсөл нь алдаатай хийгдсэн, эсхүл доголдолтой материалыар, хийц муутай хийгдсэний улмаас элементүүдийн ажиллагаа доголдсоноос үүссэн Ажлын ямар нэгэн бүрдэл хэсгийн эвдрэл ба хохирлыг хамруулахын тулд даатгалын хэмжээг нэмэгдүүлэх ёстой; ба

(б) эвдэрсэн зүйлийг нурааж буулгах болон барилгын хог хаягдлыг зөөж зайлзуулах зардал, мэргэжилтнүүдийн зардлыг багтаасан, эвдрэл, эсхүл хохирлыг засаж арилгахад зориулах аливаа дагалдах нэмэлт зардлыг нөхөхөд шаардлагатай, дээрх бүрэн солих үнээс арван таван (15%) хувиар тооцсон нэмэгдэл дүн (эсхүл, Гэрээний мэдээлэлд тусгагдсан байж болох бусад ийм дүн).

Даатгалын нөхөн төлбөр нь аливаа шалтгаанаар үүссэн бүх эвдрэл, эсхүл хохирлоос Захиалагч болон Гүйцэтгэгчийг, Ажил хүлээн авсан гэрчилгээг олгоо огноо хүртэл хамгаална. Үүнээс хойш, Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө бий болсон аливаа шалтгаанаар үүссэн эвдрэл, эсхүл хохиролтой, мөн түүнчлэн Гүйцэтгэгчээс Зүйл 11 [Ажил хүлээд авсны дараах доголдол] ба “Ажил дууссаны дараах туршилт”-ыг дагаж мөрдөх зорилгоор хийсэн аливаа үйлдлийн явцад түүний буруугаас үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохиролтой холбогдолтой аливаа дусаагүй ажлын хувьд даатгал нь Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл үргэлжилнэ.

Гэсэн хэдий ч, Ажилд Гүйцэтгэгчийн хийлгэсэн даатгалын нөхцөл төлбөрт дараах зүйлсийн аль нэгийг хамруулахгүй байж болно:

(1) тухайн зардал ба үл нийцэлд хамаарах Ажлын аливаа бусад бүрдэл хэсэгт, эвдрэл эсхүл хохирлыг засаж арилгах зардлыг хасаж тооцоогүй тохиолдолд, доголдолтой (хангалтгүй хийц эсхүл чанарын доголдолтой материалыг

оролцуулан), эсхүл өөр байдлаар Гэрээний шаардлагад нийцэхгүй байгаа Ажлын ямар нэгэн бүрдэл хэсгийг засаж сайжруулах зардал:

(2) Гэрээний үнэд хийгдсэн saatlaas үүдэлтэй аливаа хасалтыг оролцуулсан шууд буюу хөндлөнгийн эвдрэл, эсхүл хохирол;

(3) элэгдэл хорогдол, дутагдал ба хулгай; болон

(4) Гэрээний мэдээлэлд өөрөөр заагаагүй бол, давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй эрсдэлүүд.

19.2.2 Бараа, материалын даатгал

Гүйцэтгэгч нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хамтарсан нэр дээр Гэрээний мэдээлэлд тусгасан дүнгээр ба/эсхүл заасан дүнгээр (хэрвээ тогтоогоогүй эсхүл заагаагүй бол Ажлын талбайд хүргэх зардлыг багтааж тооцсон тэдгээрийг бүрэн солих үнийн дүнгээр) Гүйцэтгэгчээс Ажлын талбайд оруулсан Бараа болон бусад эд зүйлсийг даатгалд хамруулах үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь энэхүү даатгалыг, Бараа материалыг Ажлын талбай дээр авчирсан огнооноос тэдгээр нь Ажилд цаашид шаардлагагүй болох хүртэл хүчинтэй байлгана.

19.2.3 Мэргэжлийн үүргээ зөрчсөний хариуцлагын даатгал

Гүйцэтгэгч нь Байнгын ажлын бүрдэл хэсгийн зураг төслийн хариуцлагыг гэрээний 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг]-т заасны дагуу ба/эсхүл, аливаа бусад зураг төслийнхийг гэрээний дагуу хүлээх ба Зүйл 17 [Ажилд Ажлыг арчилж, хамгаалах ба нөхөн төлбөр]-д тодорхойлсон баталгаанд нийцүүлж байгаа тохиолдолд, хэрэв байгаа бол:

(a) Гүйцэтгэгч нь зураг төслийн үүргээ биелүүлэхдээ түүний гаргасан аливаа үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас үүссэн хариуцлагаас хамгаалах мэргэжлийн хариуцлагын даатгалыг, Гэрээний мэдээлэлд зааснаас багагүй дүнгээр (хэрэв тусгаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүнгээр) хийлгэх ба хүчинтэй байлгана;

(b) хэрэв Гэрээний мэдээлэлд заасан бол мэргэжлийн хариуцлагын ийм даатгал нь Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хүлээсэн зураг төслийн үүргээ биелүүлэхдээ гаргасан аливаа үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас үүдэн Ажил нь (эсхүл Хэсэг ажил, эсхүл ажлын бүрдэл хэсэг, эсхүл үндсэн тоног төхөөрөмжийн томоохон хэсэг, хэрэв байгаа бол) хийгдэж дууссаныхаа дараа Гэрээний 4.1 [Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг]-ийн дагуу төлөвлөгдсөн зорилгодоо тохирохгүй байгаагаас үүдэх хариуцлагаас мөн хамгаална.

Гүйцэтгэгч нь энэхүү даатгалыг Гэрээний мэдээлэлд заасан хугацааны туршид хүчинтэй байлгана.

19.2.4 Хүмүүсийн бэртэл, гэмтэл ба эд хөрөнгийн эвдрэл, хохирлын даатгал

Гүйцэтгэгч нь давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэл, эсхүл хохирлоос бусад Гүйцэтгэлийн гэрчилгээг олгохоос өмнө, Гэрээг гүйцэтгэх явцад тохиолдсон аливаа хүний амь нас эрсдэх, бэртэл, гэмтэл, эсхүл үүссэн аливаа эд хөрөнгийн (Ажлаас бусад) эвдрэл, эсхүл хохиролд хүлээх хариуцлагыг Гүйцэтгэгч ба Захиалагчийн хамтарсан нэр дээр даатгуулна.

Гүйцэтгэгч ба Захиалагчийг тус тусад нь даатгуулагч гэж үзэн даатгалыг хэрэглэх тийм харилцан хариуцлагын заалтыг даатгалын гэрээнд оруулсан байна.

Гүйцэтгэгч Ажлын талбай дээр ямар нэгэн ажил эхлэхээс өмнө энэхүү даатгалыг хийлгэсэн байх ба Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл хүчинтэй байх ёстой бөгөөд Гэрээний мэдээлэлд зааснаас багагүй дүнтэй (хэрэв дүн заагаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүнтэй) байна.

19.2.5 Ажилчдын бэртэл, гэмтлийн даатгал

Ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэлтэй, Гүйцэтгэгчийн хөлслөн ажиллуулж буй хүмүүс, эсхүл Гүйцэтгэгчийн бусад аливаа ажилчдын бэртэл, гэмтэл, өвчин, амь нас эрсдэх, хохирол, нэхэмжлэл ба зардлыг (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) нөхөн төлөх хариуцлагын даатгалыг Гүйцэтгэгч хийлгэх ба хүчинтэй байлгана.

Захиалагчийн өөрийн, эсхүл Захиалагчийн ажилчдын аливаа үйлдэл, эсхүл хайнга хандлагаас үссэн хохирол ба нэхэмжлэлийг энэхүү даатгалд хамруулахгүйгээс бусад тохиолдолд, Захиалагч ба Инженер нь даатгалын гэрээний дагуу мөн нөхөн төлбөр авна.

Ажлыг гүйцэтгэхэд Гүйцэтгэгчийн ажилчид оролцох бүхий л хугацааны туршид даатгалыг хүчинтэй хэвээр байлгана. Туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн аливаа ажилчид Туслан гүйцэтгэгч өөрөө даатгалыг хийлгэж болох боловч, энэхүү Гэрээний Туслан гүйцэтгэгч дагаж мөрдөх асуудалд Гүйцэтгэгч хариуцлага хүлээнэ.

19.2.6 Хуулиар болон орон нутгийн эрх зүйгээр шаардагдах бусад даатгал

Ажил (түүний ямар нэгэн бүрдэл хэсэг) хийгдэж байгаа улсын Хууль, тогтоомжоор шаардагдах бусад бүх даатгалыг Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар хийлгэнэ.

Орон нутгийн эрх зүйгээр шаардагдах бусад даатгалыг (хэрэв байгаа бол) гэрээний мэдээлэлд нарийвчлан зааж тусгах ба Гүйцэтгэгч нь даатгалыг нарийвчилсан заалтад нийцүүлэн өөрийн зардлаар хийлгэнэ.

20. Захиалагчийн болон Гүйцэтгэгчийн нэхэмжлэл

20.1 Нэхэмжлэл

Доор дурдсан нөхцөлд Нэхэмжлэл гаргаж болно:

(a) хэрэв Захиалагч нь Гүйцэтгэгчээс ямар нэгэн нэмэлт төлбөр авах, (эсхүл Гэрээний үнийг бууруулах) ба/эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах эрхтэй гэж үзэж байгаа бол;

(b) хэрэв Гүйцэтгэгч нь Захиалагчаас ямар нэгэн нэмэлт төлбөр авах ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмэлжлэлийн эрхтэй гэж үзэж байгаа бол; эсхүл

(c) хэрэв аль нэг Тал нь нөгөө Талаасаа өөр бусад эрх, эсхүл хөнгөлөлт эдлэх эрхтэй гэж үзэж байгаа бол. Ийм өөр эрх, эсхүл хөнгөлөлт нь дээрх (a) ба/эсхүл (b) дэд хэсгүүдэд заасан эрхэд хамааралтайгаас бусад тохиолдолд, ямар ч төрлийнх (Инженерийн аливаа санал, эсхүл үнэлгээ, Мэдэгдэл, гэрчилгээ, тодорхойлолт, зааварчилгаатай холбогдолтой) байж болно.

Нэхэмжлэлийг дээр дурдсан (a) эсхүл (b) заалтын дагуу гаргасан тохиолдолд, Гэрээний 20.2 [Төлбөрийн ба/ эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл]-ийг хэрэглэнэ.

Нэхэмжлэлийг дээр дурдсан (c) заалтын дагуу гаргасан тохиолдолд, нөгөө Тал эсхүл Инженер нь хүссэн эрх, эсхүл хөнгөлөлтийг зөвшөөрөөгүй (эсхүл, хэрэв тэдгээр нь зохих хугацааны дотор хариу өгөөгүй тул үл зөвшөөрсөн гэж үзсэн) бол Маргаан үссэн гэж үзэхгүй, гэвч нэхэмжлэгч Тал нь Инженерт Мэдэгдэл өгөн,

Нэхэмжлэлээ шийдүүлэхээр хандаж болох ба Гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-г хэрэглэнэ. Үл зөвшөөрлийг (эсхүл санал зөрсөн гэж үзсэнийг) нэхэмжлэгч Тал мэдсэн дариудаа энэхүү Мэдэгдлийг өгөх бөгөөд түүнд нэхэмжлэгч Талын нэхэмжлэл ба нөгөө Тал, эсхүл Инженерийн үл зөвшөөрлийн (эсхүл санал зөрсөн гэж үзсэн) талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

20.2 Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэл

Хэрэв аль нэг Тал нь Гэрээтэй холбогдуулан эдгээр Нөхцөлийн аливаа Зүйлийн дагуу, эсхүл Гэрээтэй хамааралтай өөр байдлаар нөгөө Талаасаа ямар нэгэн нэмэлт төлбөр авах (эсхүл, Захиалагч байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах) ба/эсхүл Хугацаа сунгах нэхэмжлэлийн (Гүйцэтгэгч байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах (Захиалагч байх тохиолдолд) эрхтэй гэж үзэж байгаа бол, Нэхэмжлэлийн талаар дараах журмыг баримтална:

20.2.1 Нэхэмжлэлийн тухай Мэдэгдэл

Нэхэмжлэгч Тал нь аль болох боломжит богино хугацаанд Нэхэмжлэл гаргасан зардал, хохирол, saat ал, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг бий болгож буй үйл явдал буюу нөхцөл байдлыг тодорхой дурдсан Мэдэгдлийг (эдгээр Нөхцөлд “Нэхэмжлэлийн тухай Мэдэгдэл” гэх), тухайн үйл явдал буюу нөхцөл байдал нэхэмжлэгч Тал мэдсэн, эсхүл мэдэж ёстой байснаас хойш 28 хоногийн дотор Инженерт өгнө.

Хэрэв нэхэмжлэгч Тал нь энэ 28 хоногийн энэ хугацаанд Нэхэмжлэлийн тухай Мэдэгдлийг өгөөгүй тохиолдолд, нэхэмжлэгч Тал нь нэмэлт төлбөр авах, Гэрээний үнийг бууруулах (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) эрхгүй, Ажил дуусах хугацааг (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) сунгуулах эрхгүй, эсхүл Доголдол Мэдэгдэх хугацааг (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) сунгахгүй ба нөгөө Тал нь Нэхэмжлэл шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдалтай холбогдолтой аливаа хариуцлагаас чөлөөлөгднө.

20.2.2 Инженерийн эхний хариу

Хэрэв, нэхэмжлэгч Тал Нэхэмжлэлийн тухай Мэдэгдлийг Гэрээний 20.2.1 [Нэхэмжлэлийн тухай Мэдэгдэл]-ийн дагуу 28 хоногийн хугацаанд багтаж өгөөгүй гэж Инженер үзвэл, тэрээр Нэхэмжлэлийн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, (шалтгааныг дурдсан) мэдэгдлийг нэхэмжлэгч Талд зохих ёсоор өгнө.

Хэрэв Инженер ийм Мэдэгдлийг 14 хоногийн дотор өгөөгүй бол Нэхэмжлэлийн тухай мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзнэ. Хэрэв нөгөө Тал нь энэхүү хүчин төгөлдөр гэж үзсэн Мэдэгдэлтэй санал нийлэхгүй байвал, үл зөвшөөрсөн тухайгаа дэлгэрэнгүй дурдсан Мэдэгдлийг Инженерт өгнө. Үүний дараа, Гэрээний 20.2.5 [Нэхэмжлэлийг тохиролцох эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу хийгдсэн Нэхэмжлэлийн тохиролцоо эсхүл гаргасан шийдвэрт энэхүү үл зөвшөөрлийг Инженерээс нягталсан байдлыг тусгаж өгнө.

Хэрэв нэхэмжлэгч Тал нь Инженерээс энэхүү Гэрээнийийн дагуу Мэдэгдэл хүлээн авсан бөгөөд Инженертэй санал нийлэхгүй байгаа, эсхүл Нэхэмжлэлийн тухай Мэдэгдлийг оройтуулж хүргүүлснийг зөвтгөх тодорхой нөхцөл байдал байгаа гэж үзэж байгаа бол, Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу гаргасан өөрийн Дэлгэрэнгүй нэхэмжлэлдээ энэхүү үл зөвшөөрсөнтэй холбогдолтой, эсхүл оройтуулж хүргүүлснээ зөвтгөх тодорхой нөхцөл байдлынхаа тухай нарийвчилсан мэдээллийг(нөхцөл байдлаас хамааруулан) тусгасан байна.

20.2.3 Зэрэгцээ гаргасан бүртгэл

Энэхүү Гэрээний 20.2-т “Зэрэгцээ гаргасан бүртгэл” гэж Нэхэмжлэл гаргахад хүргэсэн үйл явдал, эсхүл нөхцөл байдалтай нэгэн зэрэг, эсхүл түүний дөнгөж дараа нь бэлтгэгдсэн, эсхүл бий болсон бүртгэлийг хэлнэ.

Нэхэмжлэгч Тал нь ийм зэрэгцээ гаргасан бүртгэлийг Нэхэмжлэлийг нотлоход шаардлагатай байж магадгүй хэмээн бүртгэлийг хөтөлнө.

Инженер нь Захиалагчийн хариуцлагыг оруулахгүйгээр, Гүйцэтгэгчийн зэрэгцээ гаргасан бүртгэл хөтлөлтийг үзэж шалгах ба/ эсхүл нэмэлт бүртгэлийг хөтлөх зааварчилгааг Гүйцэтгэгчид өгч болно. Гүйцэтгэгч нь эдгээр бүх бүртгэлийг ажлын ердийн цагаар (эсхүл, Гүйцэтгэгчтэй тохиролцсон бусад цагт) үзэж шалгахыг Инженерт зөвшөөрөх ба хэрэв зааварчилсан бол, тэдгээрийн хувийг Инженерт өгнө. Инженерээс ийнхүү үзэж шалгах, хянах, эсхүл зааварчлах (хэрэв байгаа бол) нь Гүйцэтгэгчийн зэрэгцээ гаргасан бүртгэлийн үнэн зөвийг эсхүл бүрэн бүтэн гэдгийг зөвшөөрсний илэрхийлэл биш болно.

20.2.4 Дэлгэрэнгүй нэхэмжлэл

Энэхүү Гэрээний 20.2-т “Дэлгэрэнгүй нэхэмжлэл” гэж доорх зүйлсийг хамруулсан Нэхэмжлэлийг хэлнэ:

- (a) Нэхэмжлэлийг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын дэлгэрэнгүй тайлбар;
- (b) Нэхэмжлэлийн гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэл бүхий мэдэгдэл;
- (c) нэхэмжлэгч Талын гаргасан бүх зэрэгцээ гаргасан бүртгэлүүд; ба
- (d) нэхэмжилж буй нэмэлт төлбөрийн (эсхүл Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүн) дүнтэй ба/эсхүл Ажил дуусгах хугацааны (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) сунгалттай, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) сунгалттай холбогдолтой дэлгэрэнгүй нэмэлт мэдээллийг.

Доор заасан хугацаанд:

- (1) Нэхэмжлэл гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаар нэхэмжлэгч Тал мэдсэн (эсхүл мэдэх ёстой байснаас) хойш 84 хоногийн дотор, эсхүл
- (2) нэхэмжлэгч Тал санал болгож, Инженер зөвшөөрсөн тодорхой өөр хугацааны дотор (хэрэв байгаа бол)

нэхэмжлэгч Тал нь Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг Инженерт хүргүүлнэ.

Хэрэв нэхэмжлэгч Тал нь дээр дурдсан (b) заалтын дагуух мэдэгдлийг энэхүү хугацааны хязгаарт багтаан хүргүүлээгүй бол, Нэхэмжлэлийн тухай мэдэгдлийг хугацаа дууссан бөгөөд цаашид хүчин төгөлдөр бус Мэдэгдэл гэж үзэх ба Инженер нь энэхүү хугацааны хязгаар дууссанаас хойш 14 хоногийн дотор нэхэмжлэгч Талд зохих ёсоор мэдэгдэл өгнө.

Хэрэв Инженер ийм мэдэгдлийг 14 хоногийн дотор өгөөгүй бол, Нэхэмжлэлийн тухай мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзнэ. Хэрэв негеө Тал нь энэхүү хүчин төгөлдөр гэж үзсэн мэдэгдэлтэй санал нийлэхгүй байвал, үл зөвшөөрсөн тухайгаа дэлгэрэнгүй дурдсан мэдэгдлийг Инженерт өгнө. Үүний дараа, Гэрээний 20.2.5 [Нэхэмжлэлийн тохиролцох эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу хийгдсэн Нэхэмжлэлийн тохиролцоо, эсхүл гаргасан шийдвэрт энэхүү үл зөвшөөрлийг Инженерээс нягталсан байдлыг тусгаж өгнө.

Хэрэв нэхэмжлэгч Тал нь Инженерээс энэхүү Гэрээний 20.2.4-ийн дагуу Мэдэгдэл хүлээн авсан ба хэрэв тухайн Тал энэхүү Мэдэгдэлтэй санал нийлэхгүй байгаа, эсхүл дээрх (b) заалтын дагуух мэдэгдлийг оройтуулж хүргүүлснээ зөвтгөх нөхцөл байдал байна гэж үзэж байгаа бол, Дэлгэрэнгүй нэхэмжлэлдээ энэхүү үл зөвшөөрсөнтэй холбогдолтой нарийвчилсан мэдээллийг, эсхүл оройтуулж хүргүүлснээ яагаад зөвтгөж байгаа тухайгаа (нөхцөл байдлаас хамааруулан) тусгасан байна.

Хэрэв Нэхэмжлэлийг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдал нь үргэлжилсэн үр нөлөөтэй байвал, Гэрээний 20.2.6 [Үргэлжилсэн нөлөөллийн нэхэмжлэл]-ийг хэрэглэнэ.

20.2.5 Нэхэмжлэлийг тохиролцох эсхүл шийдвэрлэх

Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу, эсхүл явц дундын болон эцсийн Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг Гэрээний 20.2.6 [Үргэлжилсэн нөлөөллийн нэхэмжлэл]-ийн аль нэгнийх нь дагуу хүлээн авсны дараа Инженер нь Гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллаж, нэхэмжлэгч Тал нь Гэрээний дагуу эдлэх эрхтэй доорх зүйлсийг тохиролцож, эсхүл шийдвэрлэнэ:

(a) нэхэмжлэгч Тал авах эрхтэй нэмэлт төлбөрийг (хэрэв байгаа бол), эсхүл Гэрээний үнийн бууруулалтыг (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд); ба/эсхүл

(b) Ажил дуусгах хугацааны (түүний хүчинтэй байх огнооноос өмнө, эсхүл хойно) сунгалтыг (хэрэв байгаа бол) (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд), гэрээний 8.5 [Ажил дуусгах хугацааг сунгах]-ийн дагуу, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны (түүний хүчинтэй хугацаа дуусах огнооноос өмнө) сунгалтыг (хэрэв байгаа бол) (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд), Гэрээний 11.3 [Доголдол мэдэгдэх хугацааны сунгалт]-ийн дагуу.

Хэрэв Инженер нь Гэрээний 20.2.2 [Инженерийн эхний хариу] ба/эсхүл Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу Мэдэгдэл өгсөн хэдий ч Нэхэмжлэлийг энэхүү Гэрээний 20.2.5 -ийн дагуу тохиролцож, эсхүл шийдвэрлэнэ. Дэлгэрэнгүй нэхэмжлэлд ийм Мэдэгдлээр тусгасан нэхэмжлэгч Талын үл зөвшөөрсөнтэй холбоотой (хэрэв байгаа бол) эсхүл оройтуулж хүргүүлснээ яагаад зөвтгөж байгаа талаарх (нөхцөл байдлаас хамааруулан) нарийвчилсан мэдээллийг харгалзан, Нэхэмжлэлийн тухай Мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзэх эсэхийг Нэхэмжлэлийг тохиролцох эсхүл шийдвэрлэхдээ тусгана. Анхааран үзэж болох (гэхдээ заавал дагах албагүй) нөхцөл байдалд дараах зүйлсийг хамруулж болно:

- Оройтуулж хүргүүлснийг хүлээн зөвшөөрсөн нь нөгөө Талд хохирол учруулах эсэх, эсхүл ямар хэмжээнд хохирол учруулах
- Гэрээний 20.2.1 [Нэхэмжлэлийн тухай Мэдэгдэл]-ийн дагуу хугацааны хязгаартай тохиолдолд, нэхэмжлэгч Тал нь өөрийн нэмэлт мэдээлэлдээ хамруулж болох, Нэхэмжлэлийг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаарх нөгөө Талын урьд нь мэдэж байсан аливаа нотолгоо; ба/эсхүл
- Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу хугацааны хязгаартай тохиолдолд, нэхэмжлэгч Тал нь өөрийн нэмэлт мэдээлэлдээ хамруулж болох, Нэхэмжлэлийн гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлийн талаарх нөгөө Талын урьд нь мэдэж байсан аливаа нотолгоо.

Хэрэв, Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу, эсхүл явц дундын болон эцсийн Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг Гэрээний 20.2.6 [Үргэлжилсэн нөлөөллийн нэхэмжлэл]-ийн дагуу хүлээн аваад Инженерт нэмэлт мэдээлэл шаардлагатай болвол Инженер нь:

(1) нэмэлт мэдээллүүд болон тэдгээрийг шаардах болсон шалтгаанаа тодорхой дурдсан Мэдэгдлийг нэхэмжлэгч Талд яаралтай өгнө;

(2) бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарт багтаан нэхэмжлэгч Талд Мэдэгдэл өгөн, Нэхэмжлэлийн гэрээний ба/ эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлд өөрийн хариугаа өгнө;

(3) нэхэмжлэгч Тал нь дээрх (1)-р заалтын дагуу Мэдэгдэл хүлээн авснаасаа хойш аль болох боломжит богино хугацаанд нэмэлт мэдээллүүдийг хүргүүлнэ;

(4) Дараа нь Инженер дээрх (a) ба/ эсхүл (b) заалтад тусгасан зүйлсийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр Гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллах (ба Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийн зорилгоор, нэхэмжлэгч Талаас нарийвчилсан нэмэлт мэдээллийг Инженер хүлээн авсан огноо нь Гэрээний 3.7.3-ын дагуух тохиролцох хугацааны хязгаарын эхлэх огноо болно.)

20.2.6 Үргэлжилсэн нөлөөллийн нэхэмжлэл

Хэрэв энэхүү Гэрээний 20.2-ын дагуу Нэхэмжлэл гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдал нь үргэлжилсэн нөлөөлөлтэй байвал:

(a) Гэрээний 20.2.4 [Дэлгэрэнгүй нэхэмжлэл]-ийн дагуу хүргүүлсэн Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг явц дундын нэхэмжлэл гэж үзнэ;

(b) энэхүү анхны явц дундын Дэлгэрэнгүй нэхэмжлэлтэй холбогдуулан, Инженер нь Гэрээний 3.7.3 [Хугацааны хязгаар]-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарт багтаан нэхэмжлэгч Талд Мэдэгдэл өгөн, Нэхэмжлэлийн гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлд өөрийн хариугаа өгнө;

(c) анхны явц дундын Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг танилцуулсны дараагаас нэхэмжлэгч Тал нь нэхэмжилсэн нэмэлт төлбөрийн хуримтлагдсан дүнг (эсхүл Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүнг) ба/ эсхүл нэхэмжилсэн хугацааны сунгалтыг (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) илэрхийлсэн цаашдын явц дундын Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг сарын зайдайгаар хүргүүлнэ.

(d) нэхэмжлэгч Тал нь үйл явдал эсхүл нөхцөл байдлаас шалтгаалсан нөлөөлөл дууссанаас хойш 28 хоногийн дотор, эсхүл нэхэмжлэгч Тал санал болгож, Инженер зөвшөөрч болох тийм өөр хугацааны дотор эцсийн Дэлгэрэнгүй нэхэмжлэлийг хүргүүлнэ. Энэхүү эцсийн дэлгэрэнгүй нэхэмжлэл нь нэхэмжилсэн нэмэлт төлбөрийн нийт дүнг (эсхүл Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүнг) ба/эсхүл нэхэмжилсэн хугацааны сунгалтыг (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) илэрхийлнэ.

20.2.7 Ерөнхий шаардлага

Инженер нь Нэхэмжлэлийн тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа, Нэхэмжлэлийг Гэрээний 20.2.5 [Нэхэмжлэлийг тохиролцох, эсхүл шийдвэрлэх]-ийн

дагуу тохиролцох, эсхүл шийдвэрлэх хүртэл, Гэрээний холбогдох заалтын дагуу нэхэмжлэгч Талд төлөгдхөөр аливаа Нэхэмжлэлд зохих ёсоор батлагдсан тийм дүнг Төлбөрийн гэрчилгээ бүрд оруулж өгнө.

Захиалагч нь энэхүү Гэрээний 20.2-ыг даган биелүүлэхдээ зөвхөн, Гүйцэтгэгчээс ямар нэгэн төлбөр нэхэмжлэх ба/эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах, эсхүл Гүйцэтгэгчид төлбөл зохих аливаа дүнгээс тооцоо хийж авах, эсхүл ямар нэгэн суутгал хийх эрхтэй.

Энэхүү Гэрээний 20.2-ийн шаардлагууд нь Нэхэмжлэлд хэрэглэгдэж болох бусад аливаа Гэрээнийийн шаардлага дээр нэмэлт болж өгнө. Хэрэв нэхэмжлэгч Тал нь Нэхэмжлэлтэй холбоотой энэ болон өөр аливаа бусад Гэрээнийийг зөрчсөн бол, аливаа нэмэлт төлбөрт ба/эсхүл аливаа Хугацаа сунгах-д (Гүйцэтгэгч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтад (Захиалагч нь нэхэмжлэгч Тал байх тохиолдолд) уг зөрчил нь Нэхэмжлэлийг Инженерээс сайтар судалж шалгахад саад учруулсан, эсхүл нөлөөлсөн хир хэмжээг (хэрэв байгаа бол) харгалзан үзнэ.

21. Маргаан ба Арбитрын ажиллагаа

21.1 МЗШЗ байгуулах

Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах] заалтын дагуу МЗШЗ-өөр шийдвэрлүүлнэ.

Тендерт шалгарсан тухай мэдэгдлийг Гүйцэтгэгч хүлээн авсан өдрөөс хойш Гэрээний мэдээлэлд заагдсан хугацааны (заагаагүй бол 28 өдрийн) дотор Талууд хамтран МЗШЗ-ийн гишүүн(д)-ийг томилно.

Гэрээний мэдээлэлд заагдсаны дагуу МЗШЗ нь шаардлага хангасан нэг (цаашид “нэг гишүүн” гэх) эсхүл гурван гишүүн (цаашид “гишүүд” гэх)-ий бүрэлдэхүүнтэй байна. Хэрвээ гишүүнийг тоог урьдчилан тогтоогоогүй бөгөөд Талууд татгалзаагүй бол МЗШЗ нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Гишүүн эсхүл гишүүдийг (тухайн нөхцөл байдлаас хамаарч) Гэрээний мэдээлэлд дурьдсан нэрсийн жагсаалтаас МЗШЗ-ийн гишүүнээр томилогооос татгалзсан эсхүл боломжгүй этгээдээс бусад этгээдийг сонгож, томилно.

Хэрвээ МЗШЗ нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй бол Талууд нөгөө Талтайгаа харилцан зөвшилцэж тус бүр нэг гишүүнийг сонгоно. Тэдгээр сонгогдсон гишүүдтэй Талууд харилцан зөвшилцэж гурав дахь гишүүнийг сонгох бөгөөд энэхүү гурав дахь гишүүн нь МЗШЗ-ийн даргаар томилгоно. /Даргын үүргийг гүйцэтгэнэ.

Талууд болон МЗШЗ-ийн нэг гишүүн эсхүл гурван гишүүн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) тус бүр МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсанаар МЗШЗ байгуулагдсанд тооцно.

МЗШЗ-ийн нэг гишүүн эсхүл гурван гишүүний цалин хөлсний дүн дээр аливаа МЗШЗ-ийн экспертийн цалин хөлсийг багтаан Талууд МЗШЗ байгуулах гэрээг батлах үедээ харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ. Энэхүү цалин хөлсийг Талууд тэнцүү байдлаар хувааж төлөх үүргийг хүлээнэ.

Хэрвээ МЗШЗ-ийн нэг эсхүл түүнээс олон гишүүдийг өөрчилж томилох талаар Талууд харилцан зөвшилцсөн тохиолдолд зохих шаардлага хангасан хүн эсхүл хүмүүсийг Талууд хэдийд ч нэр дэвшиүүлж томилох эрхтэй. Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд гишүүн нь ажил үүргээ биелүүлэхээс татгалзах, нас барах, өвчний улмаас, хөгжлийн бэрхшээлийн асуудал, огцрох, томилгооны хугацаа дуусгавар болсон зэрэг нөхцөл байдал бий болсон бол МЗШЗ-ийн

гишүүнийг өөрчлөх томилгоог хийнэ. Шинээр томилогдох гишүүн нь Энэхүү заалтад заасны дагуу сонгогдож, зөвшөөрөгдсөн байвал зохино.

МЗШЗ-ийн гишүүний томилгоог аль нэг тал нь дангаараа цуцлах шийдвэр гаргах эрхгүй бөгөөд уг асуудлаар Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Талууд өөрөөр тохироогүй бол, МЗШЗ-ийн (гышүүн тус бүрийн томилгооны хугацаа) хугацаа нь дараах тохиолдолдуудын аль сүүлд бий болсон тохиолдолд дуусгавар болно:

(a) ажлаас халах шийдвэр нь хүчин төгөлдөр үйлчлэх өдөр эсхүл 14.12 [Төлбөрийн тооцоог эцэслэх]-т заасан өдөр хүчин төгөлдөр үйлчилнэ, эсхүл

(b) Энэхүү томилолт дуусгавар болох хугацаа хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах]-т заасны дагуу холбогдох бүх маргааныг МЗШЗ шийдвэрлэж, шийдвэрээ талуудад хүргүүлсэнээс хойш 28 өдрийн дараа,

Хэрвээ дараах нөхцөлүүдийн аль нэг заалтын дагуу болон бусад байдлаар Гэрээ цуцлагдсан бол МЗШЗ (гышүүдийн томилгоо) дараах хэсгүүдэд тогтоосон өдрийн аль түрүүлж тохиолдсоноос хойш 28 өдрийн дараа дуусгавар болно:

(i) МЗШЗ нь гэрээний хүрээн дэх бүхий л маргааныг шийдвэрлэн 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах]-т заасны дагуу гэрээ цуцлагдсан өдрөөс хойш 224 өдрийн дотор хүргүүлсэн бол, эсхүл

(ii) Талууд Гэрээг цуцлахтай холбоотой бүхий л асуудлаар (Гэрээний төлбөр, тооцоотой холбоотой асуудал үүнд хамаарна) харилцан зөвшилцэж эцсийн тохиролцоонд хүрсэн өдөр;

21.2 МЗШЗ-ийн гишүүний (гышүүдийн) томилгоо амжилтгүй болох

Дор дурьдсан нөхцлүүдэд:

(a) МЗШЗ нь нэг гишүүнээс бүрдэх бөгөөд 21.1 [МЗШЗ байгуулах] хэсгийн эхний цогцолборт заасан хугацаанд багтан Талууд нь харилцан зөвшилцэж томилж чадаагүй бол; эсхүл

(b) МЗШЗ нь гурван гишүүнээс бүрдэх бөгөөд 21.1 [МЗШЗ байгуулах]-ийн эхний цогцолборт заасан хугацаанд багтан:

(i) Аль нэг Тал нь гишүүнийг сонгож чадаагүй бол;

(ii) Аль нэг Тал нь нөгөө Талын сонгосон гишүүнийг зөвшөөрөөгүй бол;

(iii) Талууд нь МЗШЗ-ийн (даргаар ажиллах) гуравдагч гишүүний томилгоог тохиролцож чадаагүй бол;

(c) МЗШЗ-ийн гишүүн нас барсан, өвчтэй, хөдөлмөрийн чадварыг алдсан, халагдсан, эсхүл томилолтыг цуцалсан зэрэг шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон эсхүл ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзсан өдрөөс хойш 42 өдөрт багтаан гишүүнийг нөхөн томилох тал дээр Талууд нь харилцан зөвшилцэж чадаагүй бол;

(d) Хэрвээ Талууд МЗШЗ-ийн гишүүнийг (гышүүдийг) томилох эсхүл нөхөн томилох талаар харилцан зөвшилцсөн боловч уг гишүүнийг томилох эсхүл нөхөн томилох талаар аль нэг Талаас саналаа ирүүлснээс хойш 14 өдөрт багтаан нөгөө Тал нь МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурахаас татгалзах эсхүл гарын үсэг зурах үүргээ биелүүлээгүйн улмаас тухайн томилолт хүчин төгөлдөр болж үйлчлэхгүй нөхцөл байдал үүссэн бол

Гэрээний мэдээлэлд нэр заасан хуулийн этгээд эсхүл эрх бүхий этгээд нь аль нэг эсхүл хоёр Талын хүсэлтээр Талуудтай харилцан зөвшилцэн МЗШЗ-ийн гишүүн (гишүүд)-ийг (энэхүү 21.2 дахь хэсгийн (d) заалтад дурьдсан нөхцөл байдлын хувьд талуудын харилцан зөвшилцсөн гишүүн (гишүүд)-ийг) томилно. Энэхүү томилгоо нь эцсийн шийдвэр бөгөөд заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

Үүний дараа, Талууд болон томилогдсон гишүүн (гишүүд) нь МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурсанд тооцох ба МЗШЗ байгуулах гэрээний дагуу дараах үүргүүдийг хүлээнэ:

(i) сар бүрийн болон өдөр тутмын ажил үйлчилгээний цалин хөлсийг МЗШЗ-ийг томилсон шийдвэрт зааснаар олгоно,

(ii) МЗШЗ-ийн хэрэглэх хууль тогтоомж нь Гэрээний 1.4 [Хууль болон Хэл]-т заасан хууль, тогтоомжууд байна.

Талууд МЗШЗ-ийн зардлыг тэнцүү төлөх үүрэгтэй. Хэрвээ Гүйцэтгэгч нь тухайн зардлыг бүрэн гаргасан бол зардлын нийт дүнгийн тал хувийг Мэдэгдэлд эргэн төлөгдөхөөр тусгах бөгөөд дараа нь уг төлбөрийг Захиалагч Гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлж барагдуулна.

Хэрвээ Захиалагч нь уг зардлыг бүрэн гаргасан бол Инженер нь тухайн төлбөрийн дүнгийн тал хувийг 14.6.1 [IPC] заалтын (b)-д заасны дагуу хасалт хийж тооцно.

21.3 Маргаанаас зайлсхийх

Хэрэв Талууд харилцан зөвшөөрсөн тохиолдолд Гэрээний явцад тэдний хооронд үүссэн үл ойлголцол эсхүл санал зөрөлдөөнийг шийдвэрлэх зорилгоор туслалцаа, дэмжлэг авах болон/эсхүл албан бусаар хэлэлцэхийг хүсч МЗШЗ-д хамтарсан хүсэлт (бичгээр хүсэлт гаргах бөгөөд хуулбарыг Инженерт хүргүүлнэ) гаргах эрхтэй. Хэрэв МЗШЗ нь талуудын хооронд ямар нэгэн байдлаар үл ойлголцол эсхүл санал зөрөлдөөн бий болсон талаар мэдсэн тохиолдолд талуудыг уг хүсэлтийг гаргахыг санал болгож болно.

Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Талуудын хооронд үүссэн аливаа маргаан эсхүл санал зөрөлдөөнтэй асуудлаар Инженер нь гэрээний 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу асуудал шийдвэрлэх үүргээ гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд Талууд дээр дурьдсан хамтарсан хүсэлтийг гаргах эрхтэй.

Энэ албан бус дэмжлэг туслалцаа, хэлэлцээрийг аливаа уулзалтын үеэр, Ажлын талбайд ажиллах болон бусад байдлаар хэрэгжүүлж болно. Хэрвээ Талууд өөрөөр тохиролцоогүй бол Талууд тэрхүү албан бус хэлэлцээрт /уулзалт, зөвлөлгөөн, үйл ажиллагаанд/ заавал байлцах үүрэгтэй. Энэхүү албан бус хэлэлцээрийн /уулзалт, зөвлөлгөөн, үйл ажиллагаанд/ үед гаргасан аливаа зөвлөмж, зөвлөлгөөг Талууд заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй ба мөн МЗШЗ нь албан бус хэлэлцээрийн үед гаргасан аливаа үзэл бодол эсхүл зөвлөмж зөвлөлгөөг амаар болон бичгээр гаргасан эсэхээс үл хамааран цаашдын Маргааныг шийдвэрлэх процесс болон шийдвэрт тусгах үүргийг мөн адил хүлээхгүй болно.

21.4 МЗШЗ-н шийдвэр гаргуулах/хүлээн авах

Хэрвээ Талуудын хооронд Маргаан үүссэн тохиолдолд МЗШЗ-д аль ч Тал хандаж болох бөгөөд (21.3 дахь хэсэг [Маргаанаас зайлсхийх]-т заасан албан бус яриа, хэлэлцээр өрнөсөн эсэхээс үл хамаарна) үүнд дараах заалтуудыг баримтлана.

21.4.1 МЗШЗ-д хандах

Талууд МЗШЗ-д хандаж маргааныг шийдвэрлүүлэхдээ дараах заалтуудыг дагаж мөрдөнө:

- (а) Хэрвээ Маргааны агуулга нь 3.7 [Тохиролцох эсхүл шийдвэрлэх]-д заасны дагуу , 3.7.5 [Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх]-д заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдлийг 42 өдөрт багтаан хүргүүлсэн эсхүл мэдэгдлийг хүлээн авсан бол МЗШЗ-д хандах эрхтэй байна. Хэрвээ энэхүү 42 өдөрт багтааж Маргааныг МЗШЗ-д гаргаж чадаагүй бол тэрхүү Үл зөвшөөрөх мэдэгдлийн хугацааг дууссан гэж үзэх бөгөөд цаашид хүчингүйд тооцно.
- (б) Энэхүү хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн болохыг тодорхойлж дурьдана.
- (с) Маргаантай холбоотой асуудлаар өөрийн нөхцөл байдлыг тодорхойлж тусгана.
- (д) Бичгээр үйлдэх бөгөөд гэрээний нөгөө Тал болон Инженерт хуулбарыг хүргүүлнэ.
- (е) Гурван гишүүнтэй МЗШЗ-ийн хувьд албан ёсоор ирүүлсэн бүртгэлийн огноог МЗШЗ-ийн даргын хүлээн авсан өдрөөр бүртгэнэ.

Хуулиар хориглоогүй бол энэхүү хэсэгт заасны дагуу МЗШЗ-д Маргаан гарах нь тоологдож буй аливаа хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох үндэслэл болно.

21.4.2 Маргаан үүссэнээр Талуудын хүлээх үүрэг

Талууд МЗШЗ-аас уг Маргааныг (21.4.1 дэх заалтын дагуу) шийдвэрлэхэд шаардагдах бүхий л мэдээлэл, Ажлын талбай болон зохих байгууламжуудад нэвтрэх эрхийг МЗШЗ-д олгоно.

Гэрээ цуцлагдсан эсхүл Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс бусад тохиолдлуудад Талууд нь Гэрээнд заасан ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэгтэй.

21.4.3 МЗШЗ-ийн шийдвэр

МЗШЗ нь доор заасан хугацаанд багтаан шийдвэрээ гаргаж, хүргүүлнэ:

- а) холбогдох баримт бичиг, мэдээллүүдийг хүлээн авснаас хойш 84 өдөрт багтаан; эсхүл
- (б) Шийдвэрлэх хугацааг МЗШЗ-ийн зүгээс санал болгож болох бөгөөд Талууд зөвшөөрсөн байх шаардлагатай.

Дээр заасан хугацаа дуусгавар болох үед, хэрвээ аль нэг МЗШЗ-ийн гишүүний төлбөр/цалин олгох хугацаа дуусгавар болсон бөгөөд тэрхүү төлбөр төлөгдөөгүй үлдэгдэлтэй байвал МЗШЗ нь тухайн төлбөрийн үлдэгдэл төлөгдөж дуустал МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээлгэн өгөх үүргийг хүлээхгүй. Үлдэгдэл төлбөр төлөгдсөний дараа МЗШЗ шийдвэрээ аль болох шуурхай хүлээлгэн өгнө.

МЗШЗ нь МЗШЗ-ийн шийдвэрийг Талуудад бичгээр ба мөн Инженерт хуулбарыг тус тус хүргүүлэх бөгөөд уг шийдвэр нь үндэслэлтэй байх ба энэхүү Хэсэгт заасны дагуу хүргүүлж буйг дурьдах ёстай.

Энэхүү Хэсэгт заасны дагуу шийдвэрийг гаргасантай холбогдуулан аль нэг Тал нь Үл зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлсэн эсэхээс үл хамааран Талууд уг шийдвэрийг нэн даруй дагаж мөрдөх, заавал биелүүлэх үүргийг хүлээнэ. МЗШЗ-ийн

шийдвэрийг хэрэгжүүлэх Инженерийн биелэлтэнд хяналт тавих үүрэг хариуцлагыг Захиалагч хүлээнэ.

Хэрвээ нэг Тал нь нөгөө Талд аливаа төлбөрийг барагдуулахаар МЗШЗ-ийн шийдвэрт тусгагдсан бол:

(i) Доорх (ii) дэд хэсэгт заасныг харгалзан, уг төлбөрийг нэн даруй төлж барагдуулах үүрэгтэй бөгөөд аливаа баталгаа эсхүл Мэдэгдэл шаардахгүй.

(ii) Тал нь хүсэлт гаргасан бөгөөд Төлбөрийн хүлээн авагч тал нь 21.6 [Арбитрын ажиллагаа]-д заасны дагуу шийдвэр цуцлагдсан тохиолдолд тухайн төлбөрийн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг буцаан төлөх боломжгүй гэх үндэслэл бүхий шалтгаантай гэж МЗШЗ-ийн зүгээс гагцхүү үзсэн тохиолдолд МЗШЗ нь төлбөрийн дүнтэй тэнцэх хэмжээний зохих төлбөрийн баталгааг (МЗШЗ өөрийн үзэмжээр шийднэ) гаргахыг төлбөрийг хүлээн авагч талаас хүсэх (шийдвэрийн нэг хэсэг байдлаар) эрхтэй.

МЗШЗ-ын ажиллагааг арбитрын ажиллагаа гэж үзэхгүй бөгөөд МЗШЗ нь арбитр(арбитрууд)ын ажил үүргийг гүйцэтггэх эрхгүй ба тэдний эрхийг эдлэхгүй.

21.4.4 МЗШЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрөх

Хэрвээ МЗШЗ-ийн шийдвэрийг аль нэг Тал нь үл зөвшөөрвөл:

(a) Үл зөвшөөрсөн Тал нь нөгөө Талдаа Үл зөвшөөрөх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд МЗШЗ болон Инженерт хуулбарыг хүргүүлнэ;

(b) Уг мэдэгдлийн тэргүү нь “МЗШЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрөх тухай” байх бөгөөд Маргаан бүхий асуудлууд болон үл зөвшөөрөх болсон шалтгаан(үүд)-ыг тодорхой дурьдана;

(c) Энэхүү мэдэгдлийг МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 28 өдрийн дотор хүргүүлнэ.

Хэрвээ МЗШЗ нь 21.4.3 [МЗШЗ-ийн шийдвэр] хэсэгт заасан хугацаанд багтаж шийдвэрээ хүргүүлээгүй бол аль нэг Тал нь энэхүү хугацаа дууссан өдрөөс хойш 28-н өдрийн дотор нөгөө Талдаа Үл зөвшөөрөх мэдэгдлийг дээр дурьдсан (a) болон (b) заалтуудад заасны дагуу хүргүүлнэ.

3.7.5 дахь хэсгийн сүүлийн цогцолбор, 21.7 болон 21.8 дугаар хэсгүүдэд тус тус зааснаас бусад тохиолдолд, тухайн Маргаантай холбоотойгоор 21.4.4-т заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдлийг гаргалгүйгээр гэрээний аль нэг Талаас Маргааныг шийдвэрлүүлэхээр арбитрт хандах эрхгүй.

Хэрвээ МЗШЗ нь Маргаантай холбоотой шийдвэрээ Талуудад хүргүүлсэн бөгөөд Талууд МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 28-н өдрийн дотор энэхүү 21.4.4-т заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдэл (Y3M)-ийг ирүүлээгүй бол уг шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрсөнд тооцож, Талууд заавал биелүүлэх эцсийн шийдвэр болно.

Хэрвээ үл зөвшөөрсөн мэдэгдэл гаргасан Тал нь МЗШЗ-ийн шийдвэрийн зөвхөн зарим хэсгийг үл зөвшөөрсөн бол:

(i) уг үл зөвшөөрч буй хэсгийг Үл зөвшөөрөх мэдэгдэлд тодорхой тусгана;

(ii) энэхүү үл зөвшөөрч буй хэсэг(хэсгүүд), мөн хамаарал бүхий эсхүл хөндөгдөх бусад хэсгүүдийг уг шийдвэрийн бусад хэсгүүдээс тусад нь тусгайлан авч үзнэ;

*С. Сагдул**Б. Чиратжин*

(iii) үл зөвшөөрөх Мэдэгдэлд хамааралгүй Шийдвэрийн хэсгүүд нь Үл зөвшөөрөх мэдэгдэл (Y3M) ирүүлсэн эсэхээс үл хамааран Талууд заавал биелүүлэх эцсийг шийдвэр байна.

21.5 Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх

21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах] дүгээр хэсэгт заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдлийг хүргүүлснээс хойш Талууд Арбитрийн ажиллагааг эхлүүлэхээс өмнө Маргааныг эвээр зохицуулахыг зорьж ажиллах үүрэгтэй. Гэвч, Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Маргааныг эвээр зохицуулах оролдлого хийсэн эсэхээс үл хамааран Үл зөвшөөрөх мэдэгдлийг (Y3M) хүргүүлснээс хойш 28 дахь өдөрт эсхүл түүнээс хойш арбитрын ажиллагааг эхлүүлж болно.

21.6 Арбитрын ажиллагаа

3.7.5 [Инженерийн дүгнэлтийг үл зөвшөөрөх] Хэсэгт, 21.4.4 [МЗШЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрөх] Хэсэгт, 21.7 [МЗШЗ-н шийдвэрийг үл биелүүлэх] Хэсэгт, 21.8 [МЗШЗ оролцоогүй тохиолдолд]-д тус тус заасны дагуу эсхүл талууд эвээр шийдвэрлэнээс бусад тохиолдолд эцсийн шийдвэр болж албажаагүй МЗШЗ-ийн шийдвэртэй холбоотой аливаа Маргаан нь олон улсын арбитраар эцэслэгдэн шийдвэрлэнэ. Талууд өөрөөр тохиролцоогүй бол:

(a) Олон Улсын Худалдааны Танхимын Арбитрын ажиллагааны дүрмийн дагуу Маргааныг эцэслэн шийдвэрлэнэ;

(b) Тус Дүрмийн дагуу томилогдсон нэг эсхүл гурван арбитрийн бүрэлдэхүүнтэйгээр Маргааныг эцэслэн шийдвэрлэнэ;

(c) Арбитрын ажиллагааг 1.4 [Хууль болон Хэл]-т заасан хэлээр явуулна;

Арбитрч(ид) нь аливаа гэрчилгээ, дүгнэлт (заавал болон эцсийн дүгнэлтээс бусад), заавар, Инженерийн санал эсхүл үнэлгээ /тодорхойлолт/ зэргийг болон Маргаантай холбоотой аливаа МЗШЗ-ийн шийдвэрийг (хүчин төгөлдөр эцсийн шийдвэрүүдээс бусад) хянах, өөрчлөх бүрэн эрхийг эдэлнэ. Инженер нь Маргаантай холбоотой аливаа асуудлаар арбитрт гэрчээр дуудагдах болон баримт нотолгоо гаргах бүрэн эрхтэй.

Арбитрын ажиллагааны зардлыг хувиарлахдаа арбитрын зүгээс 21.1 [МЗШЗ байгуулах] болон/эсхүл 21.2 [МЗШЗ-ийн гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох] хэсгүүдэд заасны дагуу аль МЗШЗ-ийг томилоход аль Тал нь үүргээ биелүүлээгүй болохыг (хэрвээ байвал) харгалзан үзнэ.

Арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаа нь МЗШЗ-ийн шийдвэрийг гарагаас өмнөх Талуудын гаргасан баримт болон нотолгоонууд, эсхүл 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах] хэсэгт заасны дагуу Талуудын Үл зөвшөөрөх мэдэгдэл (Y3M)-д дурьдагдсан үл зөвшөөрсөн тухай шалтгаануудаар үл хязгаарлагдана. МЗШЗ-ийн аливаа шийдвэр нь арбитрын ажиллагаанд нотлох баримт болно.

Арбитрын ажиллагааг Ажлыг гүйцэтгэж дуусгахаас өмнө эсхүл дууссаны дараа эхлүүлж болно. Ажлын гүйцэтгэх явцад хийгдсэн аливаа арбитрын ажиллагаа нь Талууд, Инженер, МЗШЗ-ийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага өөрчлөгдхөх үндэслэл болохгүй.

Хэрвээ нэг Тал нь нөгөө Талдаа төлбөр төлөх шийдвэр гарсан бол уг төлбөрийг дахин нэмэлт гэрчилгээ эсхүл Мэдэгдэл шаардалгүйгээр нэн даруй төлж барагдуулна.

21.7 МЗШЗ-н шийдвэрийг үл биелүүлэх

Гэрээний аль нэг Тал нь МЗШЗ-ийн заавал биелүүлэх аливаа шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд нөгөө Тал нь 21.6 [Арбитрын ажиллагаа] хэсэгт заасны дагуу гомдолоо арбитрт шууд гаргах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд 21.4 [МЗШЗ-ийн шийдвэрийг гаргуулах] болон 21.5 [Эвээр зохицуулах] дахь хэсгүүд хамаарахгүй. Арбитрын хурлаас (21.6 [Арбитрын ажиллагаа] хэсэгт заасны дагуу) тодорхой заасан болон түр хугацаагаар дүгнэлт болон бусад шуурхай арга хэмжээг авах, тушаал шийдвэр гаргах (холбогдох хууль тогтоомжийн дагуу), улмаар тэрхүү шийдвэрээ даган мөрдүүлэх эрхтэй.

Эцсийн бус байдлаар гаргасан МЗШЗ-ийн заавал даган биелүүлэх шийдвэр нь тодорхой болон түр хугацааны арга хэмжээ, шийдвэр нь Маргааныг бүрэн шийдвэрлэсэн шийдвэр гаргал

МЗШЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг тогтоосон аливаа тодорхой эсхүл түр хугацааны шийдвэр буюу дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэр, дүгнэлтийн заавал биелүүлэх эсхүл эцсийн эсэх байдлаас үл хамааран тухайн шийдвэр, дүгнэлтийг хохирлыг барагдуулах эсхүл нөхөн төлбөрийн шийдвэр, дүгнэлтэд тусгах эрхтэй.

21.8 МЗШЗ байгуулагдаагүй тохиолдол

Хэрвээ Талуудын хооронд Гэрээтэй холбоотой эсхүл Ажлыг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар Маргаан өрнөсөн буюу үүссэн үед МЗШЗ бүрдээгүй (эсхүл байгуулагдаагүй) тохиолдолд, МЗШЗ-ийг томилох хугацааг дууссан гэж үзэх бөгөөд:

(a) 21.4 [МЗШЗ-н шийдвэр гаргуулах] болон 21.5 [Эвээр зохицуулах] дахь хэсгүүд үйлчлэхгүй; бөгөөд

(b) Талууд 21.6 [Арбитрын ажиллагаа]-д заасны дагуу арбитрт шууд хандан Маргаан үүсгэх эрхтэй.

---000---

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтцийн газар
шороо, өртөө, зэрлэгийн барилга угсралтын
ажил гүйцэтгэх Гэрээний тусгай нөхцөл

2. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200022

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Мурзаков

ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ


Зүйл, заалт	Нөхөн мэдээлэл	Мэдээлэл
1.1.14	Гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл	<p>Нэр: "Зэвсэгт хүчний Жанжин штаб"</p> <p>Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө-51.</p> <p>Утас: (+976) 7015-2661</p> <p>Цахим шуудан: bbdg_demjleg@mil.gov.mn</p>
1.1.27	Доголдол мэдэгдэх хугацаа	48 сар
1.1.31	Захиалагчийн мэдээлэл	<p>Нэр: "Тавантолгой төмөр зам" ХХК</p> <p>Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнион бюлдинг, Б блок, 11 давхар</p> <p>Утас: (+976) 7777-7727</p> <p>Цахим шуудан: info@ttz.mn</p>
1.1.35	Инженерийн талаарх мэдээлэл	"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Захиалагчийн хяналтын хэлтэс эсхүл Захиалагчийн томилсон этгээд
1.1.84	Ажил дуусах хугацаа	2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр
1.3 (a)(ii)	Цахим баримт бичиг илгээх арга	Гэрээний мэдээлэлд заасан албаны цахим шуудан
1.3 (d)	Захиалагчийн холбоо барих хаяг	Гэрээний мэдээллийн 1.1.31-т заасан албан ёсны хаяг
	Инженерийн холбоо барих хаяг	Тусгай зохицуулалтын 1.1.35-т заасан албан ёсны хаяг
	Гүйцэтгэгчийн холбоо барих хаяг	Гэрээний мэдээллийн 1.1.14-т заасан албан ёсны хаяг
1.4	Хэрэглэгдэх хууль тогтоомж	Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдж буй хууль тогтоомж
	Гэрээний хэл	Монгол хэл
	Талуудын харилцах хэл	Монгол хэл
1.8	Гүйцэтгэгчийн баримт бичгийг үйлдэх тоо	Цаасан 3 хувь, цахим 1 хувь
2.1	Гүйцэтгэгчид ажлын талбайд нэвтрэх эрх олгох өдөр	Гэрээнд талууд гарын үсэг зурсанаар
2.4	Захиалагчийн санхүүгийн зохицуулалт	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл болон Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн мн/01, мн/03, мн/28 дугаар хамтарсан тушаалд заасны дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Тавантолгой төмөр зам" ХХК нарын хооронд 2022 оны 06 дугаар сарын 27-

ЗАХИАЛАГЧ

		ны өдөр байгуулсан Санхүүжилтийн гэрээгээр зохицуулагдана.
4.2	Гүйцэтгэлийн баталгаа (Барилга угсралтын ажлын дүнгээс) Хувь:	5%
8.8	Хугацаа хэтрүүлсний хохирол хоногт тооцох хэмжээ: Дээд хязгаар:	Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01% болон Захиалагчид учирсан хохирлын нийт дүн Алданги нь Гэрээний нөхцөлийн хавсралт 2[Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-ын Хүснэгт 1.2-т заасан нийт үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй
14.2	Урьдчилгаа төлбөрийн дүн	Санхүүжилтэд суурилсан Ажлын даалгавар тус бүрийн үнийн дүнгийн 50 хуртэлх хувь
14.3	Хүсэлт хүргүүлэх хувь	Цаасан 3 хувь, цахим 1 хувь
14.11. (b)	Эцсийн төлбөрийн хүсэлтийн төсөл хүргүүлэх хувь	Цаасан 3 хувь, цахим 1 хувь
21.1	МЗШЗ-ийн бүрэлдэхүүн	3 гишүүнтэй байна.
21.2	МЗШЗ-ийн гишүүнийг томилох эрх бүхий этгээд	MYXAYT-аас томилогдсон этгээд

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200024



2.(Б). ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1.1.1.

Гэрээний батлагдсан дүн
/өөрчлөх/

1.1.1. “Гэрээний батлагдсан дүн” гэж Талуудын хооронд байгуулсан Ерөнхий хэлэлцээрийн 7-д заасан дүн байна.

1.1.2 болон 1.1.3

Гэрээний ерөнхий нөхцлийн энэ заалтыг хэрэглэхгүй.

1.1.4.

Суурь огноо
/өөрчлөх/

“Суурь огноо” гэж гэрээнд гарын зурсан өдрийг ойлгоно.

1.1.10.

Гэрээ
/өөрчлөх/

1.1.10 “Гэрээ” гэж Гэрээний хэлэлцээрт тусгасан баримт бичиг, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, Захиалагчийн шаардлага, зураг төсөл, ажлын график төлөвлөгөө болон бусад баримт бичгүүдийг хэлнэ.

1.1.14.

Гүйцэтгэгч
/өөрчлөх/

“Гүйцэтгэгч” гэдэгт “Богдхан төмөр зам” төслийн доод, бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэх этгээдийг ойлгоно.

Нэр: “Зэвсэгт хүчний Жанжин штаб”

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө-51.

Утас: (+976) 7015-2661

Цахим шуудан: bbdg_demjleg@mil.gov.mn

1.1.20.

Өртөг болон ашиг

Гэрээний энэхүү заалтыг хэрэглэхгүй.

1.1.21.

Тухайн улс
/өөрчлөх/

“Тухайн улс” гэж Монгол Улсыг ойлгоно.

1.1.22 болон 1.1.23

Маргаан шийдвэрлэх
зөвлөл
/өөрчлөх/

Маргаан шийдвэрлэх зөвлөл буюу МШЗ нь Гэрээний тусгай нөхцөлд заасан эсхүл 21 дүгээр зүйлийн дагуу томилогдсон гурван гишүүнийг хэлнэ.

Энэхүү гэрээнийн ерөнхий нөхцөлд МЗШЗ гэж заасныг МШЗ хэмээн ойлгоно.


1.1.31.

Захиалагч
/өөрчлөх/

“Захиалагч” гэдэгт Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 230 дугаар тогтоолоор Богдхан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийг ойлгоно.

Нэр: “Тавантолгой төмөр зам” ХХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар



ЗАХИАЛАГЧ

дүүрэг, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг
Б блок, 11 давхар.

Утас: (976)-77777877

Факс: (976)-77771777

Цахим шуудан: info@ttz.mn

1.1.42.

Гадаад валют
/өөрчлөх/

“Гадаад валют” гэж Америк долларыг ойлгоно.

1.1.43.

Гэрээний ерөнхий
нөхцөл
/өөрчлөх/

“Гэрээний ерөнхий нөхцөл” гэж ФИДИК-ээс гаргасан “Захиалагчийн зураг төслийн дагуу гүйцэтгэх Барилга угсралт болон Инженерийн ажлын гэрээний ерөнхий нөхцөл буюу Redbook /2017/ баримт бичгийг ойлгоно.

1.1.46. болон 1.1.47.

Хууль
/өөрчлөх/

Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ заалтыг хэрэглэхгүй.

1.1.49.

Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.1.50. болон 1.1.51

Дотоод валют
/өөрчлөх/

Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ заалтыг хэрэглэхгүй.

1.1.52.

“Дотоод валют” гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийг ойлгоно.

1.1.64

Байнгын ажил
/өөрчлөх/

“Байнгын ажил” гэж Гэрээний ерөнхий хэлэлцээрт заасан “Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлыг ойлгоно.

1.1.67.

Нөөц хөрөнгө
/өөрчлөх/

“Нөөц хөрөнгө” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хэрэглэгдэх Магадалшгүй ажлын зардлыг ойлгоно.

1.1.74

Ажлын талбай
/Өөрчлөх/

1.1.74 “Ажлын талбай” гэж төмөр замын нийт трассын дагуу байрлах төслийн ажлыг гүйцэтгэх барилга угсралт, үйлдвэрлэлийн талбайг хэлнэ.

1.1.76.

Захиалагчийн шаардлага
/Өөрчлөх/

“Захиалагчийн шаардлага” гэж Гэрээний хавсралт 1. [Захиалагчийн шаардлага]-д заасан Ерөнхий шаардлага болон Техникийн шаардлагыг хамтад нь ойлгоно.

1.1.78.

“Туслан гүйцэтгэгч” гэж ажлын бүрдэл эсхүл хэсгийг гүйцэтгүүлэхээр томилогдсон туслан гүйцэтгэгчийг ойлгоно.

ЗАХИАЛАГЧ

3ХЖШ 2200026

Туслан гүйцэтгэгч

/өөрчлөх/

1.1.81.

Тендер

Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ заалтыг хэрэглэхгүй.

1.1.89.

Төсөл

/нэмэх/

“Төсөл” гэж “Богдхан” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг технологийн иж бүрдлийн хамт шинээр барьж байгуулах цогц бүтээн байгуулалтын ажлыг ойлгоно.

1.1.90.

Эрх бүхий этгээд

/нэмэх/

“Эрх бүхий этгээд” гэж Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан Захиргааны байгууллага болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан Нутгийн өөрөө удирдах байгууллага, мөн Захиалагч, Гүйцэтгэгчийн удирдах дээд байгууллагыг хамааруулан ойлгоно.

1.1.91.

Захиалагчийн
хяналтыг
хэрэгжүүлэгч

/Нэмэх/

Захиалагчийн хяналтыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төслийн удирдлагын газар эсхүл Захиалагчийн зүгээс шинээр өөрчлөн томилсон этгээд хэрэгжүүлнэ.

1.1.92.

Ажлын хэсэг

/нэмэх/

Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн мн/01, мн/03, мн/28 дугаар хамтарсан тушаалд заасны дагуу худалдан авах ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах үүрэг бүхий “Дэд ажлын хэсэг”-ийг ойлгоно.

1.1.93.

Санхүүжүүлэгч

/Нэмэх/

“Санхүүжүүлэгч” гэж “Богдхан төмөр зам” төслийг санхүүжүүлж буй “Эрдэнэс тавантолгой” ХК болон бусад санхүүжүүлж буй этгээдийг ойлгоно.

1.5.

Баримт бичгийн давуу
байдлын эрэмбэ

/өөрчлөх/

Гэрээг бүрдүүлж буй баримт бичгүүдийн давуу байдлын эрэмбэ дарааллыг Гэрээний ерөнхий хэлэлцээрт зааснаар ойлгоно.

1.6.

Гэрээний ерөнхий
хэлэлцээр

/Өөрчлөх/

Энэ хэсгийг дараах агуулгаар өөрчлөх:

Гэрээний ерөнхий хэлэлцээр нь Талуудын хооронд 2022 оны ... дугаар сарын-ны өдөр байгуулсан “Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлын гэрээний ерөнхий хэлэлцээр байна.

1.8.

Баримт бичгийг
хадгалах, шилжүүлэх

Энэ хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах нэмэлтийг оруулах:

Гүйцэтгэгч нь энэхүү хэсэгт дурдсан баримт бичгүүдээр хязгаарлагдахгүйгээр Гэрээний дагуу хүлээсэн үүрэгтэйгээ

ЗАХИАЛАГЧ

холбоотойгоор олж авсан, өөрөө бий болгосон, эсхүл өөрийн нэрийн өмнөөс хийлгэсэн бичгээр үйлдсэн бүх баримт бичиг, зураг, Техникийн шаардлагууд, график материал, гэрэл зураг, загвар (3D бодит загварыг оруулаад) болон бусад бүх мэдээллүүдэд нэвтрэх боломжоор Захиалагч болон Санхүүжүүлэгчийг хангана.

Захиалагч болон Санхүүжүүлэгч нь ажлын талбай дээр хадгалагдаж буй баримт бичигтэй танилцахын тулд шаардлагатай үед, эсхүл ажлын цагаар нэвтрэх эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч нь цахим хэлбэрээр хагдалагдсан барим бичигтэй танилцах үед компьютер, программ хангамж болон шаардлагатай бусад хэрэгслээр хангах үүрэгтэй.

1.10.

Захиалагч Гүйцэтгэгчийн баримт бичгийг ашиглах

Энэ хэсэгт дараах зохицуулалтыг нэмэх:

Гэрээ болон ажил гүйцэтгэхтэй холбоотой Гүйцэтгэгчийн боловсруулсан баримт бичгийг Захиалагч шаардан авах эрхтэй.

1.12

Нууцлал
/өөрчлөх/

Гэрээний энэхүү хэсгийг дараах байдлаар өөрчлөх:

Энэхүү Гэрээгээр гүйцэтгэх ажил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4 дэх хэсэгт заасны дагуу хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бараа, ажил үйлчилгээний худалдан авалтад хамаарч байгаа тохиолдолд Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хууль тогтоомжид заасан нийтлэг шаардлагыг хангаж ажиллах, мэдээллийг нууцлах, хамгаалахад шаардагдах арга хэмжээг Талууд авч хэрэгжүүлэхдээ Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.11-д заасан мэргэжил арга зүйн удирдлагыг үндэслэл болгоно.

Талууд дээрх үйл ажиллагааг Гүйцэтгэгчийн Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд саад учруулахгүй байдлаар зохион байгуулах үүрэгтэй ба холбогдох харилцааг тусдаа гэрээгээр зохицуулна.

Талууд харилцан бичгээр зөвшөөрөл олгосон, эсхүл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд Гэрээ, Ажил, түүнд холбогдох аливаа баримт бичиг (цаасан болон цахим хэлбэрийн), мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах, нийтэд ил болгох, гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ Гэрээний бус зорилгоор ашиглахыг хориглоно.

Энэхүү хэсэг нь Гэрээ эсвэл түүний дагуу Гүйцэтгэгчийн оролцоо ямар нэгэн байдлаар цуцлагдаж дуусгавар болсон ч “Төрийн нууц” ангиллаас холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр гартаал цаг хугацааны хязгааргүйгээр хүчинтэй хэвээр хадгалагдан үлдэх болно.

Талууд Гэрээ байгуулагдмагц нууцпалтай холбоотой асуудлаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200028

- a) Захиалагч эрх бүхий этгээдтэй хамтран Төслийн баримт бичгийн нууцалбал зохих хэсгийг тодорхойлж Гүйцэтгэгчийг мэдээллээр хангана;
- b) Төслийн баримт материалтай Талуудын зөвхөн нууцын материалтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтан танилцана. Талууд нууцын материалтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтны жагсаалтыг харилцан албан бичгээр мэдэгдэнэ. Уг жагсаалтад өөрчлөлт орсон дариу нөгөө Талд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар Талууд гуравдагч этгээдтэй гэрээ, хэлэлцээр байгуулахдаа тухайн гэрээний оролцогч талуудад энэхүү хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллах үүргийг гэрээний нөхцөл болгон заавал тусгана.

Барилгын ажилд хамааралтай бусад Гүйцэтгэгч нарт тухайн ажлыг нь уг барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хүрээ, хязгаар дотор мэдээллийг өгч болно. Мэдээлэл задруулж буй Тал нь нууц хадгалах гэрээ, эсхүл нууцын баталгааг тухайн этгээдтэй заавал байгуулна.

Гүйцэтгэгч задруулах гэж буй мэдээллийн тухай мэдэгдлийг нөгөө Талд, шаардлагатай бол Тагнуулын ерөнхий газарт урьдчилан хүргүүлж, задруулах мэдээллийн хэмжээг аль болох бага байлгах, нууцлалыг хамгаалах талаах бүх талын арга хэмжээг авна.

Мэдээлэл задруулагч Талын хүлээх үүрэгт дараах баримт бичиг хамаарахгүй:

- i. Энэхүү гэрээ байгуулахаас өмнө нийтэд аль хэдийн ил тод болсон мэдээлэл, баримт бичиг;

Гэрээнд заасан Ажлын хүрээнд гаргасан Тагнуулын ерөнхий газрын зөвлөмжийн дагуу Захиалагчаас Гүйцэтгэгчид шилжүүлэх нууц мэдээллийг энэхүү гэрээ дуусгавар болсны дараа хууль тогтоомжид заасны дагуу буцаан шилжүүлнэ.

Захиалагч нь Гэрээг дагаж мөрдөж буй эсэхэд үе үе шалгалт хийх эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч Захиалагчийн шаардсан мэдээллийг цаг тухайд нь түргэн шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

1.14. болон 1.15

Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ хэсгийг хэрэглэхгүй.

1.17

Төслийн бусад ажил
/нэмэх/

“Төслийн бусад ажил” гэдэгт “Богдхан төмөр зам”-ын төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын ажлаас бусад ажил буюу дээд бүтэц, эстакадан гүүр, туннель, дохиолол холбоо гэх мэт төмөр замын суурь бүтцийг технологийн иж бурдлийн хамт шинээр барьж байгуулахад шаардлагатай бусад бүхий л ажлыг ойлгоно.

Гүйцэтгэгч нь “Богдхан төмөр зам” төслийн бусад ажлыг хийж гүйцэтгэж буй гүйцэтгэгч нартай харилцан мэдээлэл солилцож, уялдаа холбоог хангаж ажиллана.

ЗАХИАЛАГЧ

1.18 Төсөл төлөвлөгөө /нэмэх/	хэрэгжүүлэх	Гүйцэтгэгч нь Ажил эхлүүлэх мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Гэрээний Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага]-ын 1.1 дэх хэсэг “Ерөнхий шаардлага”-ын 3.1-д заасан төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан Инженерт хүргүүлэн батлуулна. Аливаа төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, уг төлөвлөгөөний шаардлагуудыг мөрдөх Гүйцэтгэгчийн аливаа үүрэг, эсхүл Захиалагчийн төлөвлөгөөг зөвшөөрөн батлахтай холбоотой гаргасан санал дүгнэлт, удирдамж чиглэл зэргийг үл харгалзан Захиалагчид аливаа үүрэг хариуцлага ногдуулахгүй бөгөөд гэрээ болон дүрэм, журам, стандарт, хууль тогтоомжийг даган мөрдөх ба энэхүү асуудалтай холбоотой аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
2.2. Дэмжлэг, үзүүлэх	туслалцаа	Энэхүү хэсгийн “а” заалтыг хасах.
2.3. Захиалагчийн ажилтнууд болон бусад Гүйцэтгэгч нар		Энэ хэсэгт дараах зохицуулалтыг нэмэх: Гүйцэтгэгч нь бусад Гүйцэтгэгч нартай ажлын уялдаа холбоотой ажиллана.
3.5. Инженерийн Зааварчилгаа /өөрчлөх/		Энэхүү хэсгийн 5 дахь догол мөрнөөс хойшхи хэсгийг дараах байдлаар өөрчлөх: Ямар ч тохиолдолд Зааварчилгаа бичгээр өгөгдсөн байна. Хэрэв Инженер, эсхүл Инженерийн төлөөлөгч нь: a) Амаар зааварчилгаа өгсөн бол ийнхүү өгснөөс хойш ажлын 1 хоногт багтаан Гүйцэтгэгчээс зааварчилгааг хүлээн авсныг бичгээр баталгаажуулан авна; b) Ийнхүү баталгаажуулсан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1 хоногт зааварчилгаа авсан, эсхүл татгалзсан тухайгаа бичгээр хариу өгөхгүй бол Баталгаажсан албан бичиг нь Инженер, эсхүл Инженерийн төлөөлөгчөөс өгсөн бичгэн зааварчилгааны үндэслэл болно.
3.8. Хурал, уулзалт /өөрчлөх/		Энэхүү хэсгийн эхний өгүүлбэрийг дараах байдлаар өөрчлөх: Талууд ажлын явц, гүйцэтгэл, тулгарч буй асуудлыг шийдвэрлэн цаашдын төлөвлөгөөг хэлэлцэх зорилтын хүрээнд уулзалт, хурлыг 7 хоног тутамд зохион байгуулна.
4.2.1 Гүйцэтгэлийн баталгаа /өөрчлөх/		4.2.1 дэх хэсгийн эхний цогцолборыг дараах байдлаар өөрчлөх: Гүйцэтгэлийн баталгаа нь Доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга угсралтын үнийн дүнгийн 5%-тай тэнцүү хэмжээний мөнгөн дүн байх ба явц дундын төлбөрөөс сутган тооцно.

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200030

4.6.

Хамтын ажиллагаа
/нэмэх/

Энэхүү хэсгийн сүүлийн цогцолборын хойно дараах агуулгыг нэмэлтээр оруулах.

Гүйцэтгэгч нь:

- a) Ажил нь төслийн бусад ажлуудтай уялдаа холбоотой ажиллах шаардлагатайг;
- b) Ажил гүйцэтгэх явцдаа Ажлын талбайн шаардлагатай хэсгүүдэд, эсхүл Ажлын талбайн зэргэлдээ төслийн бусад ажил нэгэн зэрэг явагдахыг;
- c) Гүйцэтгэгч нь Ажлын зураг төслийг төслийн бусад ажлуудтай зохицуулах үүднээс төслийн бусад ажлын гүйцэтгэгчид болон эрх бүхий байгууллагуудаас зураг төслийн мэдээлэл авах шаардлагатай болохыг;
- d) Захиалагч, төслийн бусад ажлын гүйцэтгэгч болон эрх бүхий этгээдүүд нь Ажлын зураг төсөлтэй холбоотой мэдээллийг шаардах бөгөөд үүнийг цаг хугацаанд нь өгч байх ёстойг;
- e) Ажлын гүйцэтгэл, Гүйцэтгэгчийн зураг төслийн мэдээлэл, эсхүл төслийн бусад ажлын гүйцэтгэгчид болон эрх бүхий этгээдтэй хамтран ажиллахад гаргасан аливаа саатал нь төслийн ажилд сөргөөр нөлөөлж, цаг хугацааны хоцрогдол үүсгэсэн тохиолдолд, үүнтэй хамааралтай нэмэлт зардал, алдагдал хохирлыг төлөхийг хүлээн зөвшөөрч байна.

Гүйцэтгэгч нь төслийн бусад ажилтай хамааралтайгаар үүссэн эсхүл, үүсч буолох аливаа асуудал, эрсдэлийг Захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэн, өөрийн үүргүүдийг хангахад шаардлагатай байгаа арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах ба төслийн бусад гүйцэтгэгч нартай харилцан зөвшилцөх замаар төслийн ажлыг саадгүй явуулах үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь төслийн бусад ажлын гүйцэтгэгч болон аливаа гуравдагч тал Ажилд гэмтэл учруулахаас хамгаална.

4.7.3.

Засварлах арга хэмжээ,
хугацаа хоцролт болон
Зардалтай холбоотой
Хэлцэл ба шийдвэр

/өөрчлөх/

Энэхүү хэсгийн (b) заалтад заасан эхний догол мөрийг хасах.

4.10.

Ажлын талбайн мэдээллийг ашиглах

Гэрээний ерөнхий нөхцлийн энэхүү хэсгийн "d" заалтыг хасах.

4.19.

Ажил гүйцэтгэхэд
шаардлагатай түр
хангарт

Энэхүү хэсгийн эхний догол мөрийн араас дараах агуулгыг нэмэх:

Захиалагч нь Ажил гүйцэтгэх, Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах ус ашиглалтын зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авах, холбогдох гэрээг байгуулах асуудлыг хариуцах бөгөөд

ЗАХИАЛАГЧ

		худгийн техникийн гэрчилгээ Захиалагчийн нэр дээр байна. Гүйцэтгэгч нь худгийн арчлалт, хамгаалалтыг хариуцна.
4.20.	Ажлын явцын тайлан	Энэхүү хэсэгт дараах зохицуулалтыг сүүлийн догол мөрийн араас дараах агуултыг нэмэх: Дээр дурдсан тайлангуудаас гадна Гүйцэтгэгч нь Гэрээний Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага]-д дурдсан тайлангуудыг, түүнд заасан хугацаанд боловсруулан Инженерт хүргүүлнэ.
4.24.	Захиалагчийн техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглах /нэмэх/	Захиалагч өөрийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Гүйцэтгэгчид түрээсээр ашиглуулж болно. Түрээслүүлэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, үнэ болон нөхцөлийг Талууд холбогдох гэрээг тусад нь байгуулах замаар харилцан тохиролцох бөгөөд түрээсийн төлбөрийн тооцоог сар бүр тулган, тооцоо нийлсэн акт үйлдсэн үндсэн дээр Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган барагдуулна.
5.2.1	Нэр дэвшүүлсэн туслан гүйцэтгэгч	Гэрээний ерөнхий нөхцлийн энэхүү хэсгийн “13.4 дэх хэсгийн дагуу” гэснийг хасах.
5.3.	Туслан гүйцэтгэгчтэй холбоотой төлбөр тооцоо /нэмэх/	Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсан туслан гүйцэтгэгчид түүний хийж гүйцэтгэсэн ажлыг хянан баталгаажуулсны үндсэн дээр төлбөрийг төлнө. Инженер нь гэрээ байгуулагдсан туслан гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой Төлбөрийн гэрчилгээг олгоходоо өмнөх төлбөрийн гэрчилгээний дагуу авсан төлбөрөөс туслан Гүйцэтгэгчид төлөх төлбөрийг төлсөнг нотлох баримтыг шаардаж болно. Гүйцэтгэгч нотлох баримтыг хүргүүлээгүй тохиолдолд, Захиалагч туслан гүйцэтгэгчид шууд төлбөрийг төлж болно. Доор дурдсан нөхцөл хангагдсан тохиолдолд туслан гүйцэтгэгчид шууд төлбөрийг төлж болно. Үүнд: <ol style="list-style-type: none">Ерөнхий Гүйцэтгэгч туслан гүйцэтгэгчүү шууд төлбөр төлөхийг хүлээн зөвшөөрсөн;Ерөнхий Гүйцэтгэгч тухайн Туслан гүйцэтгэгчийн хийсэн ажлыг хянаж, баталгаажуулсан.
5.4.	Ажлын хэсэг /Нэмэх/	Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 5 сарын 17-ны өдрийн мн/01, мн/03, мн/28 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь Туслан гүйцэтгэгчтэй холбоотой асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулна.
6.5.	Ажлыг цаг /өөрчлөх/	Гүйцэтгэгч нь ажилтны ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн зохион байгуулна.

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200032

6.7.	Энэ хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах зохицуулалтыг нэмэх: Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал	Гэрээний хавсралт 1 [Захиалагчийн шаардлага] ба Хавсралт 5 [Байгаль орчин, нийгмийн удирдлага], Хавсралт 6[Хөдөлмөрийн аюулгүй байда, эрүүл ахуй]-д заасан Ажлын талбайд мөрдөх журмуудыг Талууд боловсруулан, дагаж мөрдүүлнэ. Гүйцэтгэгч эдгээр журмуудыг туслан гүйцэтгэгч болон Ажлын талбайд ажиллаж буй бусад этгээдүүдэд хуулбарлан өгч, дагаж мөрдүүлэх ажлыг хариуцан ажиллана. Эдгээр журмуудад дараах асуудлуудтай холбоотой журмууд багтсан байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: a. Ажлын талбайн харуул хамгаалалт; b. Эрүүл мэнд, аюулгүй байдал; c. Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх.
6.8. болон 6.9.		Гэрээний ерөнхий нөхцөлийн энэхүү заалтыг хэрэглэхгүй.
7.3.	Энэхүү хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах агуулгыг нэмэх: Үзлэг, шалгалт	Энэхүү хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах агуулгыг нэмэх: Ажилтнуудаас бусад Захиалагчийн Ажилтнууд нь Гүйцэтгэгчид нэгээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.
7.4.	Туршилт	Энэ хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах зохицуулалтыг нэмэх: Энэ Гэрээний дагуу хийгдэх Ажлын хэсэг бүрт туршилт хийгдсэн байх ёстой ба туршилт хийгдэлгүй орхигдсон Ажлын хэсэг байвал, Ажил гүйцэтгэх хугацааг сунгалгүйгээр Гүйцэтгэгчийн зардлаар туршилтыг хийхийг Захиалагч шаардаж болно.
7.7.	Бараа материал, тоног төхөөмөржмийг өмчлөх эрх	Энэхүү хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах зохицуулалтыг нэмэх. Гэрээний энэхүү хэсэгт гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, машин механизм хамаарахгүй.
7.8.	Нөөц ашиглалтын төлбөр /өөрчлөх/	Энэ хэсгийн b заалтыг дараах байдлаар өөрчлөв. b) Захиалагч нь Гэрээнд заасан Ажлыг гүйцэтгэхэд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах, барилга байгууламж, зам, талбай барих, тоног төхөөрөмж угсарч суурилуулах газрын ашиглалтын зөвшөөрлийг авч, холбогдох эрх бүхий байгууллагатай гэрээг байгуулах бөгөөд эдгээр Гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмыг баримтлан Гүйцэтгэгчид ашиглуулна. Гүйцэтгэгч түгээмэл тархацтай ашигт малтмал хайх буюу ашигласны төлбөрийг холбогдох журмын дагуу хариуцан төлнө.

ЗАХИАЛАГЧ

		Хог хаягдлын зөвшөөрөл, гэрээ, холбогдон гарах төлбөр, Ажлын талбай, талбайн орчныг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг Гүйцэтгэгч дангаар хариуцна.
7.9. Ажлын хэсэг /Нэмэх/		Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын 2022 оны 5 сарын 17-ны өдрийн мн/01, мн/03, мн/28 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь төсөлд шаардлагатай бараа, материалын худалдан авах ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуула.
8.1. Ажил эхлэх өдөр /өөрчлөх/		Энэ хэсгийг дараах байдлаар өөрчлөх: Гэрээний Ерөнхий хэлэлцээрийн 5.3-т заасны дагуу Инженерийн мэдэгдлийн дагуу ажлыг эхлүүлнэ.
9.1. Гүйцэтгэгчийн үүрэг		Энэ хэсэгт дараах зохицуулалтыг нэмэх: Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт Гэрээний нөхцөлийн Хавсралт 1 [Захиалагчийн шаардлагаг]-т заасны дагуу Ажил болон Багц ажлын туршилтыг гүйцэтгэнэ.
9.3. Давтан хийх туршилт /Нэмэх/		Энэ хэсэгт дараах зохицуулалтыг сүүлийн догол мөрийн араас дараах агуулыг нэмэх: Гүйцэтгэгч нь давтан туршилт хийхийн өмнө Ажлын доголдолыг хэрхэн засаж, сайжруулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид ирүүлэх ба уг сайжруулалтыг өөрийн зардлаар, боломжит богино хугацаанд хийж гүйцэтгэнэ.
10.1. Ажил буюу хэсэг ажлыг хүлээн авах /нэмэх/		Энэ хэсэгт дараах агуулгыг сүүлийн догол мөрийн араас нэмэх: Захиалагч Ажлыг хэсэгчлэн хүлээн авч болно.
10.2. Ажлын бүрдэлийг хүлээн авах		Энэ хэсэгт дараах агуулгыг сүүлийн догол мөрийн араас нэмэх: Ажил болон хэсэг ажлын бүрдэлийг талууд тохиролцсон тохиолдолд хүлээн авч болно.
10.5. Хүлээн авах ажлын хэсэг /Нэмэх/		“Богдхан төмөр зам” төсөл нь хоорондоо уялдаа холбоотой төмөр замын цогцолбор төсөл бөгөөд доод бүтцийн ажлаас шалтгаалж дээд бүтцийн ажил хийгдэх учраас доод бүтцийн ажлыг хүлээж авахдаа дээд бүтцийн ажлыг гүйцэтгэгчийг байлцуулж нэгдсэн акт үйлдэж, ажлыг хүлээн авна.
11.1. Дутуу ажлыг гүйцээж, доголдолыг арилгах		Энэ хэсэгт дараах агуулгыг сүүлийн догол мөрий араас нэмэх: “Богдхан төмөр зам” төсөл нь хоорондоо уялдаа холбоотой төмөр замын цогцолбор төсөл бөгөөд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд үндэслэж дараагийн гүйцэтгэгчийн ажил хийгдэх учраас ажил доголдолгүй байна.

ЗАХИАЛАГЧ

		Хэрэв дараагийн гүйцэтгэгч болон Захиалагч гүйцэтгэсэн ажилд доголдол илрүүлсэн тохиолдолд тэр даруй доголдлыг арилгаж, дараагийн гүйцэтгэгчийг ажил хийх боломжоор хангана.
13.4. Нөөц хөрөнгө /өөрчлөх/		Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, "Богдхан төмөр зам" төслийн ТЭЗҮ болон Гэрээний Хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-д заасан "Магадалшгүй ажлын зардал"-ыг зарцуулах зориулалт, журам энэхүү хэсэгт үйлчилнэ.
13.7. Өртөгт орсон үнийн өөрчлөлтийн тохируулга /Өөрчлөх/		Энэ хэсэгт заасан үнийн өөрчлөлтийн тохируулгыг Гэрээний нөхцөлийн Хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-т заасны дагуу зохицуулж, тохируулна.
14.1. Гэрээний үнэ		Дараах агуулгыг нэмэх: Энэхүү гэрээний ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар зүйл болон Гэрээний Хавсралт 2-т заасан үнэ эцсийн үнэ биш бөгөөд Ажлын даалгаварт туссан нэгж үнийн нийлбэр дүн нь гэрээний дүн байна
14.2 Урьдчилгаа төлбөр /өөрчлөх/		Санхүүжилтэд сууринсан Ажлын даалгавар тус бүрийн үнийн дүнгийн 50 /тавь/ хүртэлх хувьтай тэнцүү хэмжээний мөнгөн дүн байна.
14.2.1 Урьдчилгаа төлбөрийн баталгаа		Гэрээний ерөнхий нөхцлийн энэхүү заалтыг хэрэглэхгүй.
14.2.3 Урьдчилгаа төлбөрийн эргэн төлөлт		Гэрээний ерөнхий нөхцлийн энэхүү заалтыг дараах байдлаар өөрчлөх: Урьдчилгаа төлбөрийг явц дундын төлбөрөөс хувь тэнцүүлэн хасаж тооцно.
14.6. Явц дундын төлбөр (IPC)		Эхний догол мөрөнд дурдсан нөхцөлд дараах зохицуулалтыг нэмэх: (с) Энэхүү Гэрээний ерөнхий нөхцлийн 4.20 [Ажлын явцын тайлан]-д заасны дагуу гүйцэтгэлийн тайлан болон, энэхүү Гэрээний Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага], Хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-т тус тус заасан тайлан, баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлэх.
14.9 Суутган барих мөнгөн дүнг суллах		Гэрээний ерөнхий нөхцлийн энэхүү заалтыг хэрэглэхгүй.
14.15.		Энэхүү хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах агуулгыг нэмэх:

ЗАХИАЛАГЧ

Төлбөрийн мөнгөн тэмдэгт	Ажлын даалгаварт заасныг баримтлана.
19.1 болон 19.2. Даатгал /өөрчлөх/	<p>Талууд Барилгын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заавал хамрагдахаар заасан (гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал г.м) даатгалд өөрсдийн зардлаар хамрагдах үүрэг хүлээх бөгөөд ийнхүү даатгуулах үүргээ биелүүлээгүйгээс учирсан аливаа эрсдэлийн үр дагаварыг бие дааж хариуцна.</p> <p>Барилгын үйл ажиллагаанд оролцогч аль нэг талын даатгалд хамрагдахтай холбоотойгоор үүссэн зардал, хариуцлагыг бусад талууд хамтран хариуцахгүй.</p>
21.1. ¹ Маргааныг урьдчилан шийдвэрлэх /нэмэх/	<p>Талуудын хооронд Маргаан үүссэн тохиолдолд Талууд энэ талаар нөгөө Талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлж, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ.</p> <p>Дээр дурдсаны дагуу Маргаан үүссэн тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш 14 хоногт багтаан тухайн Маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж чадаагүй бол, аль нэг Тал тухайн Маргааныг Тал тус бүрийн гүйцэтгэх удирдлага, түүнээс дээш түвшний удирдлагыг хэрэгжүүлэгч нараас ус тус тэнцүү тоогоор бүрдсэн удирдлагын хороогоор шийдвэрлүүлэх хүсэлтийг нөгөө Талдаа бичгээр гаргана. Үүний дагуу тухайн хүсэлтийг бичгээр хүргүүлснээс хойш 21 хоногийн дотор үүссэн Маргааны талаар бичгээр шийдвэр гаргахаар Талуудын тохиролцож тогтоосон газарт цуглан хуралдана. Удирдлагын хороо Маргааныг дүгнэсэн шийдвэр гаргах хугацааг харилцан тохиролцож сунгаж болно.</p> <p>Удирдлагын хороо уг 21 хоног эсхүл харилцан тохиролцож сунгасан хугацаандаа багтаан Маргаантай асуудлаар санал нэгдэж чадвал энэ тухай шийдвэрээ бичгээр гаргаж, тус хорооны нийт гишүүд маргааныг шийдвэрлэсэн болохоо илэрхийлж гарын үсэг зурж баталгаажуулна.</p> <p>Удирдлагын хороо Маргааныг ийнхүү шийдвэрлэж чадаагүй эсхүл хорооны шийдвэрийн талаар талууд маргасан тохиолдолд, маргааныг ГЕН-ийн 21.1 дэх хэсэгт заасан журмыг баримтлан шийдвэрлүүлэх ажиллагааг явуулах бөгөөд уг урьдчилсан шийдвэрлэх ажиллагааг Маргаан шийдвэрлэх зөвлөл ажиллуулахаас өмнө явуулсан байна.</p>
21.1. МШЗ-ийг томилох /өөрчлөх/	<p>Маргаан шийдвэрлэх зөвлөл 3 (гурван) гишүүнтэй байна.</p> <p>Талууд Маргаан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнийг МУХАУТЫН дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын Арбитрч нараас сонгох бөгөөд ийнхүү сонгоходоо Талууд тус бүр нөгөө Талтайгаа харилцан зөвшилцэж тус бүр нэг гишүүнийг санал болгоно. Тэдгээр сонгогдсон гишүүдтэй Талууд зөвшилцсөний үндсэн дээр гурав дахь гишүүнийг сонгох бөгөөд энэхүү гурав дахь гишүүн нь МШЗ-ийн даргаар томилогдоно.</p> <p>Маргаан үүсгэж буй тал МШЗ-ийн зардалыг хариуцна.</p>

ЗАХИАЛАГЧ

21.2.

МШЗ-ийн гишүүдийг томилон ажиллуулахтай холбоотойгоор санал зөрөх
/өөрчлөх/

Энэ хэсгийг дараах агуулгаар өөрчлөх:

Маргаан шийдвэрлэх зөвлөлийг Талууд харилцан зөвшилцэж томилж чадаагүй тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (MYXAYT)-аас эрх олгосон этгээдээр МШЗ-ийн гишүүнийг сонгуулж томилно.

21.3.

Маргаанаас зайлсхийх

Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ заалтыг хэрэглэхгүй.

21.4.

МШЗ-ийн шийдвэрийг гардан авах

Тус зүйлийн эхний догол мэрийн "Хэрэв талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд" гэсний араас "МШЗ томилогдоны дараагаар" хэмээн нэмэх;

"(21.3 дахь хэсэг [Маргаанаас зайлсхийх]-т заасан албан бус яриа, хэлэлцээр өрнөсөн эсэхээс үл хамаарна)" гэснийг хасах

21.4.1 дүгээр зүйлийн "а" хэсгийг хасах

21.6.

Арбитр

/өөрчлөх/

Энэ хэсгийг дараах агуулгаар өөрчлөх:

Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимиын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

Арбитр нь аливаа гэрчилгээ, дүгнэлт, заавар, Инженерийн санал эсхүл үнэлгээ /тодорхойлолт/ болон Маргаантай холбоотой аливаа МШЗ-ийн шийдвэрийг хянах, өөрчлөх бүрэн эрхийг эдэлнэ. Инженер нь Маргаантай холбоотой аливаа асуудлаар арбитрт гэрчээр дуудагдах болон баримт нотолгоо гаргах бүрэн эрхтэй.

Арбитрын ажиллагааны зардлыг хувиарлахдаа арбитрын зүгээс 21.1 [МШЗ байгуулах] эсхүл 21.2 [МШЗ-ийн гишүүний томилгоо амжилтгүй болох] хэсгүүдэд заасны дагуу аль МЗШЗ-ийг томилоход аль Тал нь үүргээ биелүүлээгүй болохыг харгалзан узна.

ЗАХИАЛАГЧ

Б.Нямжав

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМ ХӨСКИМ" ТӨЛӨӨЛЖ:
6375405 СБА2198



ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр
ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСОГТ" ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА ДОСЛОГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200038

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө,
зөрлөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх
Гэрээний нөхцөлийн Хавсралт 1 –
Захиалагчийн шаардлага

ХАВСРАЛТ 1

ЗАХИАЛАГЧИЙН ШААРДЛАГА

“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Зэвсэгт Хүчний Жанжин Штаб” нарын хооронд
2022 оны ... дугаар сарын ...-ний өдөр байгуулав.

1. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

ЗАХИАЛАГЧ

С. Сүрүүн

ГҮЙЦЭТГЭГЧ

Б. Маржанин

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ХАВСРАЛТ №1-1 ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. ЕРӨНХИЙ

Захиалгчийн энэхүү шаардлагууд нь дараах 4 хэсэгт хуваагдана. Үүнд:

1. Нийтлэг: энэ хэсэг нь Гэрээнд бүхэлд нь үйлчилнэ.
2. Үйл ажиллагаанд тавигдах шаардлага. Үүнд: Ажлын батлагдсан зураг төсөл, барилга, гүйцэтгэл, үйл ажиллагаа болон Ажлын цар хүрээний ерөнхий шаардлага орно.
3. Барилга: энэ хэсэг нь Ажлын барилга байгууламжтай холбоотой шаардлагуудад холбогдон үйлчилнэ.
4. Хяналт, туршилт ба ашиглалтад хүлээн авах: энэ хэсэг нь үйлдвэр, тоног, төхөөрөмж, үйлдвэрлэсэн эд зүйлийн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт ба хүлээлгэн өгөх шаардлагуудад үйлчлэх ба туршилт, ашиглалтад хүлээлгэн өгөх шаардлага мөн орно.

1.2. ТӨСЛИЙН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БА ЗОРИЛГО

1.2.1. Танилцуулга

Богдхан төмөр зам нь ОХУ, Монгол Улсын төр засгийн удирдлагын түвшинд хөрш улсуудыг дамжсан эдийн засгийн кооридорын дэд бүтцийг шинэчлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал Богдхан төмөр зам нь ашиглалтад орсны үр дүнд Улаанбаатар төмөр замын хүндрэлтэй хэсгүүдийг арилгах, тээвэрлэлтийн хурд нэмэгдэж, аялах зай 22 км-ээр багасч, түлшний зарцуулалт буурах, Улаанбаатар хотын өртөөдөд саатах арилах зэрэг олон чиглэлээр төмөр замын төслийн ашиглалтын зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгоно.

Уг төмөр замын төсөл мөн Улаанбаатар хотын хүн ам, нийгэм эдийн засгийн төвлөрлийг задлах, нийслэлийн бүс нутаг болон түүний ойр орчны нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогын хүрээнд бий болох Шинэ зуунмод, Зуунмод, Майдар болон Сэргэлэн хотуудын хөгжлийг хангах дэд бүтцийн гол урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Богдхан төмөр зам нь төмөр замын цогцолбор төсөл бөгөөд бүтээн байгуулалтыг турван хуулийн этгээдээр тухайлан барьж гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл, Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн МН/01, МН/03, МН/28 дугаар тушаалуудаар Төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг “Зэвсэгт хүчний Жанжин штаб”-аар, дээд бүтцийн барилгын ажлыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээр, эстакадан гүүр, туннелийн барилгын ажлыг “Бодь интернэшнл” ХХК-аар гүйцэтгүүлэхээр тооцож, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг талуудад тус тус даалгасан байна.

1.2.2. Хэрэгжүүлэлт

Гүйцэтгэгчийн шинээр баригдах Богдхан төмөр замын бүтээн байгуулалтын ажилд дараах багц ажлууд багтана. Үүнд:

Багц 1: Рашаант өртөөнөөс 1 дүгээр зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 2: 1 дүгээр зөрлөгөөс Хайрхан-Уул өртөө хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 3: Хайрхан-уул өртөөнөөс 2 дугаар зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 4: 2 дугаар зөрлөгөөс Хөшигт өртөө хүртэлх доод бүтцийн

ажил;

Багц 5: Хөшигт өртөөнөөс 3 дугаар зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 6: 3 дугаар зөрлөгөөс 4 дүгээр зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 7: 4 дүгээр зөрлөгөөс 5 дугаар зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 8: 5 дугаар зөрлөгөөс 6 дугаар зөрлөг хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 9: 6 дугаар зөрлөгөөс Мааньт өртөө хүртэлх доод бүтцийн ажил;

Багц 10: Барилга байгууламжийн ажил.

- 1, 2, 3, 5, 6 дугаар зөрлөг
- 4 дүгээр зөрлөг
- Хайрхан-Үул өртөө
- Хөшигт өртөө
- Хөшигтийн өртөөний суурьшлын бүс

Богдхан төмөр зам нь Рашаантын өртөөний 2 замыг үргэлжлүүлэн эхэлж, Мааньтын өртөө хүртэл үргэлжлэх бөгөөд Эмээлт уул, Дойт уулыг туннелдэж, Туул гол, Бөхөг голын хэсэгт эстакадан гүүрээр гарахаар тооцож байгаа болно.

Тус чиглэлийн төмөр замыг ойролцоогоор 144.894 км урт замтай, 6 зөрлөг, 4 өртөө, 1 суурьшлын бүс, нийт 4770 м урттай 2 эстакад, 551 м бүхий 14 дамнуурут гүүр, 80 м бүхий 3 жаазан гүүр, нийт 14600 м бүхий 2 туннел, 135 ш хоолойтой байх бөгөөд үүний 4 нь авто замын гарц, 7 нь мал амьтны гарц байна гэж төлөвлөсөн.

Төмөр замын галт тэрэгний дундаж хурд 90 км/ц, жилд тээвэрлэх ачааны хэмжээ 30 сая тонн хүртэл бөгөөд MNS 6229:2021 стандартын шаардлагын дагуу III зэрэглэлийн төмөр зам байхаар тооцоолсон.

Жилд тээвэрлэх ачааны хэмжээ үе шаттайгаар өсөж, 2046 онд дээд хэмжээнд хүрч 30 сая тонноос хэтрэхээр байх тул цаашид төмөр замын төхөөрөмж байгууламжийг хүчинтгэх, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчилж галт тэрэгний жин нэмэгдүүлэн тээх чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллахаар байна. Тухайлбал хоорондын замыг хос замтай болгох, галт тэрэгний жинг нэмэгдүүлэх, нэгтгэсэн галт тэрэг аялуулах зэрэг арга хэмжээг үе шаттайгаар авах хэрэгтэй.

1.2.4. Төслийн төмөр зам

Богдхан төмөр зам нь Рашаантын өртөөнөөс эхэлж, Мааньт өртөө хүртэл ойролцоогоор 144.894 км урт зам юм.

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. ЕРӨНХИЙ

Богдхан төмөр замын доод бүтцийн ажил болон өртөө, зөрлөгийн барилга байгууламжийн ажлын худалдан авалт, барилгын болон тоног төхөөрөмж угсарч суурилуулах, ханган нийлүүлэлт, гүйцэтгэл, туршилт ба ашиглалтад хүлээлгэн өгөх зэрэг иж бүрэн ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, жилд 30 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий төмөр замын доод бүтцийн ажил болон өртөө зөрлөгийн барилга байгууламжийн ажлыг Захиалагчид хүлээлгэн өгөхөд Гүйцэтгэгчид тавих “Захиалагчийн шаардлага”-ыг энэхүү хавсралтаар тодорхойлно.

Энэхүү зорилгыг бүрэн ухамсарлаж, бий болох үүрэг хариуцлага, эрсдэлийг хүлээн зөвшөөрөн Гүйцэтгэгч нь дараах үүргийг хүлээж байна. Үүнд:

- Гэрээний нөхцөлийн Хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-т заасан тоо хэмжээнд үндэслэн;

- Гэрээний нөхцөлийн Хавсралт 3 [Ажлын график төлөвлөгөө]-д заасан хугацаанд төмөр замын доод бүтцийн буюу газар шорооны ажил (далан, сэтэрхий, ухмал), гүүр, хоолой, ертөө зөрлөгийн барилга байгууламжийн ажлын худалдан авалт, барилга угсралт, үйлдвэрлэл, нийлүүлэлт, сууринуулалт, туршилтыг гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөх (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй);

- Гүйцэтгэгч нь дээрх гүйцэтгэсэн ажлыг Захиалагчид хүлээлгэн өгөх, зүгшруулэх;

- Худалдан авалт, барилга угсралтын ажлын төлөвлөгөөний биелэлт, чанарын дагалдах баримт бичиг болон ашиглалт, засвар үйлчилгээний заавар, гарын авлагаар Захиалагчийг хангах;

- Гүйцэтгэгч нь өөрсдийн хариуцсан ажлыг гүйцэтгэхдээ төмөр замын барилга байгууламжийн бусад гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажилтай уялдуулах асуудал дээр онцгой анхаарч ажиллана. Төмөр замын ажил нь хоорондоо уялдаа холбоо бүхий багц ажил учраас доод бүтцийн ажлаас шалтгаалж бусад ажил уялдах ба бусад Гүйцэтгэгчид нь тохиролцсон хугацаандаа ажлаа эхлэх, сааталгүйгээр үйл ажиллагаагаа явуулахад өөрсдийн зүгээс шалтгаалах бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллана.

Гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг худалдан авах, барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхдээ дарааллын хувьд (i) Магадлагдсан зураг төсөл, (ii) Гэрээний нөхцөлийн Хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-т заасан тоо хэмжээг тус тус баримтална.

Барилга угсралт, сууринуулалт, туршилт ба хүлээлгэн өгөх ажлыг Гүйцэтгэгч нь Монгол Улсын хууль, дүрэм, журам, холбогдох стандарт, техникийн шаардлага, Захиалагчийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь Гэрээний нөхцөлийн Хавсралт 4 [Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах зөвшөөрөл авахтай холбоотой үүргийн матриц]-т өөрөөр заагаагүй бол бүхий л шаардлагатай зөвшөөрлийг холбогдох орон нутгийн ба төрийн эрх бүхий байгууллагаас авна. Үүнд: барилга угсралт, сууринуулалтын ажлын бусад зөвшөөрөл бүгд багтана.

2.2. ГЭРЭЭНИЙ ШААРДЛАГУУД

Ажлын зураг төсөл, гүйцэтгэл нь Гэрээнд заасан тусгай шаардлагад нийцсэн байна. Захиалагч зураг төслийг Гэрээний нөхцөлийн Хавсралт 1-2 хэсэг [Техникийн шаардлага]-т заасан журам, стандартын дагуу боловсруулж, эрх бүхий этгээдээр магадлуулна. Захиалагч нь зураг төслийг Гүйцэтгэгчид өгөөгүйгээс Ажил удаашрах эсхүл саатах шинжтэй байвал Гүйцэтгэгч нь энэ тухай Инженерт мэдэгдэл хүргүүлэх боломжтой. Гүйцэтгэгч нь холбогдох баталгаажуулалтын болон гүйцэтгэлийн зураг, ажлын аргачлалыг боловсруулна. Ийнхүү боловсруулсан зураг төсөл, ажлын аргачлалыг Инженерт хүргүүлэх ба Инженер энэхүү Хавсралт 1-1 хэсгийн 3.2.3-т заасан журмыг баримтлан хариуг бичгээр өгнө. Инженер “зөвшөөрсөн” болон “санал бүхий зөвшөөрсөн” хариу мэдэгдэл өгсөн бол Гүйцэтгэгч зураг төсөл, барилгын дараагийн үе шатны ажлыг эхлүүлнэ. Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэлд тусгасан Инженерийн үндэслэл бүхий саналыг Гүйцэтгэгч хүлээн авч өөрчлөлт оруулна. Хэрэв уг санал нь техник, технологийн хувьд оновчтой бус, эсхүл ажлын хугацаа, зардалд нөлөөлөхөөр бол тэр талаар тодорхой дурдсан хариу тайлбарыг Инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь дараах баримт бичгийг Гэрээний нөхцөл, энэхүү гэрээний нөхцөлийн Хавсралт 1-2 хэсэг [Техникийн шаардлага]-т нийцүүлэн тухай бүр боловсруулж Инженерт хүргэнэ. Үүнд:

- Ажлын нарийвчилсан төлөвлөгөө;

ЗАХИАЛАГЧ

Б.М.Г.

- Чанарын хяналтын төлөвлөгөө;
- Барилгын угсралтын ажил гүйцэтгэх аргачлал;
- Баталгаажуулалтын болон гүйцэтгэлийн зураг;
- Талбайн туршилтын журам;
- Ажлын журам;
- Ашиглалт, засвар үйлчилгээний заавар, гарын авлага;
- Туршилт ба ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөө;

Хэрэв боловсруулсан ТЭЗҮ-д тусгагдсан бараа, ажил үйлчилгээ, техникийн шаардлагад нэмэлт, өөрчлөлт орсон бол Гүйцэтгэгч нь уг нэмэлт, өөрчлөлтийг Захиалагчаас албан бичгээр өгсөн мэдэгдэл, Инженерийн даалгавар, зааварчилгааны дагуу дагаж мөрдөнө. Үүнтэй холбоотой нэмэлт зардал, ажил гүйцэтгэх хугацааг Гэрээний нөхцөлийн Хавсралт №2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ]-т заасны дагуу зохицуулна.

2.3. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

2.3.1. Нийтлэг зүйл

Гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын цар хүрээ нь (цаашид “Ажлын цар хүрээ” гэх) газар шорооны ажил, далан, сэтэрий, гүүр, хоолой гэх мэт доод бүтцийн ажил, өртөө, зөрлөг, суурьшлын бүсийн барилга байгууламж болон түүний инженерийн байгууламжийн барилга угсралтын ажил, туршилт, ашиглалтад хүлээлгэн өгөх ажлаас бүрдэнэ.

Гүйцэтгэгч нь барилгын ажлыг Гэрээний нөхцөлийн Хавсралт 1-2 хэсэгт [Техникийн шаардлага]-т нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. Гэрээний дагуу зүгшрүүлэлт, ашиглалт болон засвар үйлчилгээ нь Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд багтана.

Гүйцэтгэгч нь уг ажлын цар хүрээнд хамаарах барилга байгууламж болон бусад ажлыг Гэрээний нөхцөлийн Хавсралт 6 [Ажлын график төлөвлөгөө]-д заасан хугацаанд гүйцэтгэх Захиалагчид хүлээлгэн өгнө. Гэрээний дагуу зүгшрүүлэлт, баталгаат хугацаан дахь засвар үйлчилгээ зэрэг нь Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд орно.

2.3.2. Гүйцэтгэгчийн нэмэлт судалгаа

Гүйцэтгэгч Байнгын ажлын зураг төсөл ба барилгад шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт судалгааг өөрийн зардлаар гүйцэтгэж болно.

2.3.3. Холбогдох ажил гүйцэтгэгчидтэй уялдуулах

Гүйцэтгэгч нь холбогдох ажил гүйцэтгэгчид болон бусад холбогдох талуудтай уялдаа холбоотой байх үүрэг хүлээнэ. Тухайлбал Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн төмөр замын доод бүтцийн ажлын гүйцэтгэл, явц нь хугацаа хожимдуулах болон бусад байдлаар төмөр замын дээд бүтэц, эстакад, туннель, эрчим хүч, дохиолол холбооны ажилтай уялдуулан ажиллана.

2.3.4. Холбогдох зөвшөөрөл /бүрдүүлэлт

Гэрээний нөхцөлийн хавсралт 4-т [Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах зөвшөөрөл авахтай холбоотой үргийн матриц]-т өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь холбогдох гэрчилгээ, орон нутгийн удирдлагаас авах зөвшөөрөл, гүйцэтгэлийн гэрчилгээ, гол түймрээс сэргийлэхэд шаардлагатай бүхий л зөвшөөрлийг авна. Захиалагч нь байгаль орчин, олон нийттэй харилцах асуудлаар шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.

ЗАХИАЛАГЧ

2.3.5. Төмөр замыг барихад шаардлагатай газар шорооны ажил

Төмөр замын дээд бүтцийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай далан босгох, сэтлэлтийн ажил, зөрлөг ба гарцын хэсэг дэх газар шорооны ажилд дараах ажилбарууд багтана (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй). Үүнд:

- а) Цэвэрлэгээ, газрын хөрсний цэвэрлэгээ ба хуулалт;
- б) Тэсэлгээтэй болон тэсэлгээгүй ухмал;
- с) Далан босгох, үүнд хучлага давхарга, замын суурь хөрс, энгийн дүүргэлт орно. (хэрвээ шаардлагатай бол нягтаршилтын харьцааны өөрчлөлт)
- д) Налуу хэсгийн хамгаалалт, элэгдлийн хяналт;
- е) Шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л ажлууд.

2.3.6. Газар шорооны ажлыг хамгаалах байгууламж

Хэрвээ шаардлагатай бол төмөр замын (гол төмөр зам, өртөө, зөрлөг, салбар зам)-ын дагуух болон буудлууд дахь газар шороог тогтоох бүтэээцийн барилгын ажил.

2.3.7. Зам төмрийн ажил гүйцэтгэхэд шаардлагатайгаас бусад газар шорооны ажил

Шаардлагатай бол өртөө, зөрлөг, мал амьтны гарц, гарцын буудлуудын хэсэг дэх бүхий л газар шорооны ажлын (дээр дурдсан зам төмрийн ажилд шаардлагатайгаас бусад) барилгын ажил. Үүнд: цэвэрлэгээ, газрын хөрсний цэвэрлэгээ ба хуулалт, тэсэлгээтэй болон тэсэлгээгүй ухмал, далан, налуу хэсгийн хамгаалалт, элэгдлийн хяналт ба шаардлагатай бусад бүхий л ажлууд хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй.

2.3.8. Жаазан болон дам нуруут гүүр, хоолойн ажил

Авто замын гарц, ус өнгөрүүлэх зэрэг жааз, дам нуруут гүүрийн ажил, хоолойн ажлын зураг төсөл, барилга угсралт, худалдан авалтын ажлууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

2.3.9. Өртөө, зөрлөгийн барилга байгууламжийн ажил

Дараах өртөө, зөрлөгийн барилга байгууламжийн болон түүний инженерийн байгууламжийн барилга угсралт, худалдан авалт, ашиглалтад хүлээлгэн өгөх ажил хамаарна. Үүнд:

- а) 1, 2, 3, 5, 6 дугаар зөрлөг
- б) 4 дүгээр зөрлөг
- с) Хайрхан-Уул өртөө
- д) Хөшигт өртөө
- е) Хөшигтийн өртөөний суурьшлын бүс

2.3.10. Түр зуурын ажил

Байнгын Ажилтай холбоотой бүхий л Түр зуурын ажилд дараахыг оруулах ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- а) Инженерийн зөвшөөрөл урьдчилан авсны үндсэн дээр Байнгын Ажлыг гүйцэтгэх зорилгоор барьж байгуулсан байгууламжийн хэсгийг задлах (шаардлагатай хэсэгт, тухайн хэмжээгээр);
- б) Байнгын Ажлыг аюулгүй гүйцэтгэхэд Гүйцэтгэгчид шаардлагатай Түр зуурын барилга байгууламж, Түр зуурын хэрэглээний үйлчилгээний хэрэгсэл;

ЗАХИАЛАГЧ

с) Олон нийт болон барилгын тоног төхөөрөмжийг аюулгүй шилжүүлэхэд шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээ;

д) Байнгын Ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бөгөөд Ажлыг дуусгавар болгосноор тэдгээрийг зайлцуулах шаардлагатай бусад аливаа Түр зуурын ажлууд.

2.4 ҮНДСЭН ШААРДЛАГУУД

Гүйцэтгэгч нь доод бутэц, өртөө, зөрлөгийн барилга байгууламжийн ажлын Үзүүлэлтүүдийн нөхцөл ба заалтууд, Үндсэн Зураг Төслийн ажиллагааны шаардлагын тайлбар, Захиалагчийн шаардлага дахь бусад мэдээллийг Захиалагч болон Захиалагчийн зураг төсөл гүйцэтгэгчээс тодруулна.

Баталгаажуулалт ба гүйцэтгэлийн зураг төсөл, Ажлын талбай дээр хүлээн авах туршилтын үе шатуудын турш Гүйцэтгэгч нь систем, тусгай техникийн бүрэлдэхүүнүүд, үйл ажиллагааны шаардлагууд, мөн гүйцэтгэгчийн мэдээлэлд заасан шаардлагуудад нийцсэн гэдгийг нотлох баримтыг Инженерт хүлээн зөвшөөрөхүйц байдлаар гаргаж өгнө.

Гүйцэтгэгч нь баталгаажуулалтын болон гүйцэтгэлийн зураг төсөл, ажил хүлээлгэн өгөх болон туршилт ба ажлын гүйцэтгэлийг Хавсралт 6-д заасны дагуу гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь үйл ажиллагаа бүрийн хугацаа, огноо ба нийт төслийн хугацааг дурдаж, Төслийн Гүйцэтгэлийн Төлөвлөгөөний өөрийн хэсэгт хамаарах Төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан хөтөлбөрийг хүргүүлнэ.

Гүйцэтгэгч ажлыг Инженерийн хяналт дор явуулах ба энэхүү Инженер нь Захиалагчийн нэрийн өмнөөс Гэрээний баримт бичгийн дагуу Ажлыг хянаж, баталгаажуулна.

3. БАРИЛГЫН АЖИЛТАЙ ХОЛБООТОЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Ажлын талбайд ашиглах шаардлагатай төслийн менежментийн төлөвлөгөө, ажлын аргачлал, дараалал, журам, хуваарь, төлөвлөгөө, аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын систем зэргийг тусгасан “Төсөл Хэрэгжүүлэх Төлөвлөгөө” (TXT) боловсруулж, Инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь хэрэглэгдэх бодит арга барил, арга зам, техник, дараалал, журам, хуваарь, төлөвлөгөөг зохих ёсоор тусгасан одоо хүчин төгөлдөр байгаа баримт бичигт шаардлагатай нөхцөлөөр TXT-г шинэчилнэ. Гүйцэтгэгч нь шаардлагатай шинэчлэлтийг тухай бүр нэн даруй хийх ба шинэчлэлтийг хиймэгц Инженерээр хянуулж, зөвшөөрөл авахаар нэн даруй Инженерт өгнө. Инженер уг төлөвлөгөөнд хяналт тавьж, баталгаажуулах бөгөөд Захиалагчид тус төлөвлөгөөтэй холбоотой нэмэлт санал, мэдэгдэл байвал үүнийгээ Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

Хэрэв өөр эцсийн хугацаа заагаагүй бол, Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг Инженерийн хяналт шалгалтаар оруулах бөгөөд Ажил эхлүүлэх мэдэгдэл авсан өдрөөс хойш хуанлийн 28 (хорин найм) хоногийн дотор Инженерт хүргүүлнэ. Гүйцэтгэгчийн Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг Захиалагчийн Төслийн Менежментийн Төлөвлөгөөний баримт бичгийн дагуу боловсруулах ба үүнд дараах төлөвлөгөө хамаарна.

1. Ажлын Төлөвлөлт, Хуваарилалт
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон Байгаль орчны Төлөвлөгөө
3. Олон нийттэй Харилцах Төлөвлөгөө
4. Зөвшөөрлийн Төлөвлөгөө
5. Ханган нийлүүлэлтийн Төлөвлөгөө
6. Барилгын ажлын Аргачлалын Төлөвлөгөө

7. Төслийн ажилтай холбоотой худалдан авалтын Төлөвлөгөө
8. Гүйцэтгэгчийн Удирдлага болон Боловсон хүчний Төлөвлөгөө
9. Хөдөлмөрийн Харилцааны Төлөвлөгөө
10. Интерфэйс Төлөвлөгөө
11. Түр Байгууламжийн Төлөвлөгөө
12. Төслийн Үзүүлэлтийн Төлөвлөгөө
13. Чанарын Хяналтын Төлөвлөгөө
14. Туршилтын Төлөвлөгөө
15. Менежмент болон Харилцаа холбооны Төлөвлөгөө
16. Дуусгавар болгох, Ашиглалтад оруулах болон Хүлээлгэн өгөх Төлөвлөгөө
17. Хаах Төлөвлөгөө

3.2. БАРИМТ БИЧИГ ХЯНАХ, ХҮРГҮҮЛЭХ БОЛОН ХАРИУ ӨГӨХ ЖУРАМ

3.2.1. Баримт бичиг боловсруулах, хянах журам

Гүйцэтгэгч нь Ажил эхлүүлэх мэдэгдэл авсан өдрөөс хойш хуанлийн 28 хоногийн дотор “Төсөл хэрэгжүүлэх Менежментийн Төлөвлөгөө”-ний хамт баримт бичиг хянах төлөвлөгөөг хянаж, шалгуулж батлуулахаар Инженерт өгнө.

Гүйцэтгэгчийн Баримт бичиг Хянах Төлөвлөгөөнд дараах баримт бичиг багтах ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- a) Гүйцэтгэгчийн Чанарын Хяналтын журамд заасан шаардлагын дагуу Инженерт өгөхөөс өмнө бүх баримт бичгийг боловсруулах, батлах, хянах журам. Үүнд эрх мэдлийн түвшинг тодорхой заана;
- b) Баримт бичиг хүргүүлэх журам;
- c) Хамгийн сүүлийн байдлаар хянасан хувилбарыг Инженерт хүргүүлэх ба баримт бичиг өөрчлөх буюу дахин боловсруулах журам;
- d) Гэрээний дугаар;
- e) Эрэмбэ дараалал;
- f) Баримт бичгийн дугаар;
- g) Явцын үзүүлэлт.

Захиалагч нь барилгын ажил болон ирээдүйд үүсэх ажлын дагуу Гэрээг дуусгавар болгосны дараа Ажлыг зохион байгуулж, гүйцэтгэж, засвар үйлчилгээ хийхийн тулд төслийн баримт бичгийг ашиглана.

Гүйцэтгэгч нь Захиалагч, Инженерээс шаардсаны дагуу төслийн баримт бичгийг бүрэн байдлаар цаг тухайд нь хүргүүлнэ. Захиалагч нь төслийн баримт бичгийн бүрэн гүйцэд байдлыг тодорхойлж, нягтална.

Гүйцэтгэгч нь баримт бичгийг боловсруулахдаа баримт бичиг дээр огноо, дугаар, нэр болон бусад мэдээллийг тусгасан байх ба хүргүүлж буй баримт бичиг нь дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг урьдчилан хянаж, хангаж байгааг Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн гарын үсэг, тэмдэгээр баталгаажуулсан байна. Үүнд:

- Захиалагчийн шаардлагад нийцэж байгаа эсэх;

ЗАХИАЛАГЧ

Гагарин

- Хянах боломжтой бөгөөд нотлогдож, батлагдсан тооцоолол, эсхүл зураг төслийн дагуу байгаа, эсхүл түүнд үндэслэсэн эсэх;

- Баримт бичгийн бүрэн гүйцэд, үнэн зөв бөгөөд хүчин төгөлдөр байдлыг хангах зорилгоор Гүйцэтгэгч төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу боловсруулсан эсэх;

- Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг хангасан эсэх;

- Шаардлагатай нэмэлт тодорхойлолт, тайлбар, судалгаа орсон эсэх.

Инженер шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гүйцэтгэгч нь баримт бичгийг цахим болон эх хувиар хүргэх ба Талууд баримт бичгийг цахим байдлаар хадгална.

3.2.2. Баримт бичиг хүргүүлэх журам

Гэрээнд заасны дагуу бүх мэдэгдэл, баримт бичгийг Гүйцэтгэгч болон Инженерт хүргүүлсэн байх бөгөөд шаардлагатай тохиолдолд Захиалагчид хувийг илгээх үүрэгтэй.

Гүйцэтгэгч нь Гэрээ болон түүний бүрдэл хэсэгт өөрөөр заагаагүй бол бүхий л баримт бичгийг дараах заалтад дурдсан журмын дагуу хүргүүлж, хянуулна.

Хүргүүлж буй баримт бичиг, тухайн баримт бичигт хавсаргасан баримт бичгүүдийн жагсаалт, Захиалагчийн Шаардлагын бүхий л холбогдох шаардлагыг уг саналаар дамжуулан хэрхэн биелүүлж байгааг хураангуйлан тодорхойлж буй тухайн баримт бичигт хамаарах Ажлын нэг хэсэг буюу дэд системийг тайлбарласан товч танилцуулга дагалдана.

Шинэ бүтээгдэхүүн/технологи хэрэглэх тохиолдолд, ижил төрлийн уур амьсгалтай, үйл ажиллагааны нөхцөлтэй төмөр замын компани үйл ажиллагаандaa хэрэглэж, гэрчилгээжүүлсэн тухай нотолно.

3.2.3. Инженерээс хариу өгөх

Инженер нь Гүйцэтгэгчээс ирсэн хүсэлт (хариу өгөх шаардлагатай аливаа баримт бичиг)-ийг хүлээн авснаас хойш хуанлийн 14 хоногийн дотор хариу өгнө. Дээрх хугацаа нь Гүйцэтгэгчээс ирсэн хүсэлтэд хариу өгөх хугацааг зөвхөн нарийвчлан заагаагүй тохиолдолд үйлчилнэ.

Инженер нь дараах гурван төрлийн аль нэгээр хариу өгнө:

- зөвшөөрсөн мэдэгдэл
- санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл
- Татгалзсан мэдэгдэл (үндэслэл бүхий тайлбартай)

Инженерийн өгөх хариу мэдэгдлийн тодорхойлолт:

a. "Зөвшөөрсөн мэдэгдэл": Инженер нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа Гэрээний дагуу аливаа зөрчил илрүүлээгүй бол албан ёсны "Зөвшөөрсөн мэдэгдэл"-ийг Гүйцэтгэгчид өгнө. Инженерийн "Зөвшөөрсөн мэдэгдэл" нь Гүйцэтгэгчийн хүргүүлсэн баримт бичигтэй холбоотой Гэрээг дагаж биелүүлэхтэй холбоотой аливаа хариуцлагаас Гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй. "Зөвшөөрсөн мэдэгдэл" нь төлөвлөсөн ажлын дараагийн үе шатыг эхлүүлэх эрхийг Гүйцэтгэгчид олгоно.

b. "Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл": Инженер нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа, ноцтой биш гэж үзсэн зөрүү, эс үйлдэл, алдаа гэх мэтийг илрүүлбэл "Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл" өгнө. Гүйцэтгэгч нь "Барилгын ажил"-д холбогдох саналыг тусгахаас өмнө Инженертэй зөвшилцэж, оруулсан саналуудад хариу өгнө. Инженерийн зүгээс "Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл" гаргасны дараа, Гүйцэтгэгч нь саналыг хамруулж оруулсан шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд төлөвлөсөн ажлын дараагийн үе шатыг эхлүүлэх эрхтэй болно.

с. "Татгалзсан мэдэгдэл (үндэслэл бүхий тайлбартай)": Инженер нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа, ноцтой гэж үзсэн зөрүү, зөрчил, алдаа эсхүл эс үйлдэл гэх мэтийг илрүүлбэл "Татгалзсан мэдэгдэл" өгнө. Гүйцэтгэгч нь Инженерийн саналтай холбогдуулан хүргүүлэх баримт бичгийг засаж, дахин Инженерт өгнө. Гүйцэтгэгчээс дахин хариу хүргүүлсний дараа Инженер нь "Зөвшөөрсөн мэдэгдэл" эсхүл "Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл" өгөх хүртэл Гүйцэтгэгч нь холбогдох хэсгийн ажлын дараагийн үе шатыг эхлүүлэх эрхгүй. Харин Гүйцэтгэгч нь Инженерийн "Татгалзсан мэдэгдэл"-ийг үндэслэлгүй гэж үзсэн бол нотолгоо, тайлбарын хамт тухайн баримт бичгийг дахин хүргүүлнэ.

3.3. ЧАНАРЫН ЕРӨНХИЙ ХЯНАЛТ

3.3.1. Нийтлэг зүйл

Гүйцэтгэгч чанарын удирдлагын баг (ЧУБ)-тай байх бөгөөд уг баг нь Гүйцэтгэгчийн Төсөл Хэрэгжүүлэх Төлөвлөгөөг (3.1-р хэсэг) боловсруулж, хянах, баталгаажуулахад оролцно. Гүйцэтгэгч нь Захиалагч, Инженер ба бусад холбогдох аливаа гуравдагч этгээдтэй хамтран ажиллана. Гүйцэтгэгч нь Инженер, Захиалагчтай харилцахдаа байнга албан бичгээр болон шаардлагатай тохиолдолд бусад хэрэгслээр харилцах ба төслийн чанар, аюулгүй байдал, барилгын явц, өртөг ба гэрээний асуудлаар үнэн, зөв мэдээллийг дамжуулна.

Баталгаажуулалтын болон гүйцэтгэлийн зураг теслийг батлах үе шатанд Захиалагч ба Инженерт бүхий л чанарын баталгааны асуудлуудтай холбоотойгоор мэдээлэл авсаар байх бөгөөд Гүйцэтгэгч нь уг мэдээллүүдийг өгөх үүрэгтэй. Инженер нь шаардлагатай тохиолдолд хоорондын харилцан уялдаа ба хамтын ажиллагаатай холбоотойгоор Гүйцэтгэгчид зөвлөмж, зааварчилгаа өгнө. Зураг төсөл, үйлдвэрлэлийн хөтөлбөр ба хуваарыт зөрчилдөөн үүсэх нь нэхэмжлэл гаргахад хүргэж болох тул үүнээс зайлсхийх нь зүйтэй.

Зураг төсөл, Барилга, Үйлдвэрлэл, Ашиглалтад хүлээлгэх өгөх ажлыг батлагдсан Чанарын хяналтын журмын дагуу хянаж, гэрээний шаардлага болон тохиролцсон зураг төсөлд нийцсэн эсэхийг баталгаажуулна. Гүйцэтгэгч нь Чанарын Хяналтын Төлөвлөгөөг 3.1-р хэсэгт заасны дагуу боловсруулж, Инженерт хүргүүлэн хянаж, шалгуулна.

Чанарын Хяналтын Төлөвлөгөөний зорилго нь Ажлын талбайд гүйцэтгэж байгаа ажил нь дараах баримт бичгийн дагуу хийгдэж байгааг баталгаажуулахад оршино. Үүнд:

- Үндсэн зураг төсөл;
- Стандарт ба хууль тогтоомжийн шаардлагууд;
- Ажлын зураг;
- Өөрчлөлт ба гүйцэтгэлийн зураг;
- Аюулгүй ажиллагааны дүрэм;
- Байгаль орчныг хамгаалах шаардлагууд;

Гүйцэтгэгчийн чанарын хяналтын нэгж нь худалдан авах гэрээ хийгдсэн бараа материал, тоног төхөөрөмжийн чанарын баримт бичгийг Үйлдвэрийн танилцуулгын хамт Инженерт шаардлагатай тохиолдолд Захиалагчид хүргүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд Гүйцэтгэгч нь Инженертэй хамтран ажиллана. Үүнд:

i Зураг төсөл, боловсруулалт, үйлдвэрлэл ба туршилтыг хууль, дүрэм, журам, стандарт, Гэрээний бүрдэл баримт бичиг болон ТЭЗҮ-ийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянана;

ii Үйлдвэрлэлд ашиглаж байгаа түүхий эд материал ба тоног төхөөрөмжийг тэдгээрийн тоо хэмжээ, чанарт хяналт тавих бөгөөд холбогдох стандарт, Гэрээний

нөхцөлийн Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага]-д нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна;

iii Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийнэ;

iv Үйлдвэрлэлийн туршилт, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, угсралт нь магадлагдсан зураг төсөлтэй нийцэж байгаа эсэхийг шалгах ба үйлдвэрлэлийн шат дамжлагыг дагаж мөрдсөн эсэхэд хяналт тавина;

v Ажлын уялдаа холбоо, хяналт, туршилтын үр дүн ба ашиглагдах материалын үр дүнг тогтмол шалган хянаж, гэрээний баримт бичигт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна;

vi Гүйцэтгэгчийн лаборатори ба Ажлын талбайд явуулах туршилт, шалгалтад байлцана. Гүйцэтгэгчийн чанарын хяналтын төлөвлөгөө болон шаардлагатай тохиолдолд Захиалагч болон Инженерийн хяналт хийхийг шаардсан тохиолдолд туршилтад байлцана;

vii Туршилтын явц ба шалгалтын үр дүн нь стандарт, Гэрээний нөхцөлийн Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага]-д нийцсэн болохыг баталгаажуулна;

viii Байгууламжийн нэгдсэн систем ажиллаж байгааг шалгана;

ix Шаардлагатай буюу тодорхойлон заасан тохиолдолд Захиалагчийн зөвшөөрлийг авна.

x Суурилуулалтууд нь бусад дэг журмуутдай уялдаа холбоотой байдлыг зохицуулна;

xii Бүх механик ба цахилгаан тоног төхөөрөмжийг хүлээн авах туршилт, ашиглалтад хүлээлгэн өгөх журмын дагуу хянана;

xiii Аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажил гүйцэтгэх, хүлээлгэн өгөх хугацааны туршид батлагдсан аюулгүй ажиллагааны журам, стандартын хэрэгжилтийг баталгаажуулна;

xvii Бүхий л дуусгавар болсон ажил, нийлүүлсэн тоног төхөөрөмж нь магадлагдсан Зураг төсөл, стандартад нийцсэн эсэхэд хяналт тавина;

xiv Эдгээр бүх үйл ажиллагааны Ажлын явцын тайланг Захиалагчид Инженерээс, Гүйцэтгэгч Инженерт тогтмол тайлагнана.

xv Төслийн асуудалтай хэсэгт онцгой анхаарал хандуулна;

3.3.2. Материал, тоног төхөөрөмжийн чанар

Гүйцэтгэгч нь ханган нийлүүлэхээр зорьж байгаа, энэхүү Гэрээнд хамаарах үндсэн бараа материалын үйлдвэрлэлд ашиглах түүхий эд материал, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн нэрийг батлуулахаар Инженерт, шаардлагатай тохиолдолд Захиалагчид холбогдох баримт бичгийг өгнө.

Энэхүү Гэрээнд заасан эд ангид хамаарах бүх тоног төхөөрөмж, материал нь шинэ бөгөөд чанарын стандартын шаардлага хангасан, зохих ёсоор үйлдвэрлэсэн байна. Чанар стандартын шаардлагад үл нийцэх бараа материалыг хүлээн зөвшөөрөхгүй ба Гүйцэтгэгч нь бүх ажлыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримтлан мэргэжлийн өндер түвшинд хийж гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан сонгох бүх тоног төхөөрөмжийг талбай дээр зонхилдог орчны нөхцөл, техникийн шаардлагад тохируулан сонгоно.

Түүнчлэн, Гүйцэтгэгч нь олон улсын эрх бүхий байгууллагаас гаргадаг чанарын туршилтын тайлан болон үйлдвэрлэгчдийн бусад шаардлагатай мэдээллийг өгнө.

Захиалагчаар батлуулахаас өмнө ханган нийлүүлсэн тоног төхөөрөмж болон баталснаас өөр зорилгоор ашигласан тоног төхөөрөмж хэрэглэхээс татгалзана.

3.4. ТАЛБАЙН АШИГЛАЛТ

Ажлын хуваарь (Хавсралт 6)-т өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь Гэрээг хэрэгжүүлэх өдрөөс эхлэн Талбайд нэвтрэх ба ашиглах эрхтэй. Улмаар Гүйцэтгэгч нь Хавсралт 6-д заасан Ажлын хуваарьтай уялдуулан Ажлыг үргэлжлүүлэх ба Холбогдох Ажил Гүйцэтгэгчдээс шаардсаны дагуу талбайн боломжтой хэсгүүдэд чөлөөтэй нэвтрүүлнэ.

3.5. ТАЛБАЙН БАЙГУУЛАМЖ

Гүйцэтгэгч нь өөрийн боловсон хүчиний ажиллах, амьдрах орчин нэхцэлийг бүрдүүлэх ба үүнд талбайн оффис, байр, цайны газар, агуулах, угаалгын, эрчим хүчиний, усан хангамжийн болон хаягдал ус цэвэрлэх байгууламж орно. Ажлыг гүйцэтгэж дуусмагц, Гүйцэтгэгч нь түр байгууламжийг хурааж газрыг анх байсан байдалд оруулах ажлыг хариуцна.

Гүйцэтгэгч нь аюултай материал хадгалах, хянахад зориулсан байгууламжаар хангах ба томилсон туслан гүйцэтгэгчдийн ижил төрлийн байгууламжууд нь холбогдох стандарт, шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд Гүйцэтгэгч хяналт тавьж, хариуцна.

Төслийн талбайд байрлах Инженерийн байр, хоололт, бусад зардлын асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА

3.6.1 Нийтлэг зүйл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар Захиалагчаас Гүйцэтгэгчид тавих шаардлагыг дараах байдлаар харилцан тохиролцов. Уг шаардлагыг Гүйцэтгэгч нь өөрийн ажилтнууд, туслан гүйцэтгэгчид, тэдгээрийн ажиллагсад, бараа, материал, хийц ханган нийлүүлэгчдийг оролцуулан ажлыг гүйцэтгэхэд оролцож буй бүх талуудад дагаж мөрдүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах Монгол улсын хууль, дүрэм, журам, стандарт, норм ба норматив нь дор дурьдсан шаардлагаар хязгаарлагдахгүй болно.

3.6.2 Хөдөлмөрийн эрүүл мэнд

Гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бүтээн байгуулалтын төсөлд ажил гүйцэтгэгч бүх компани нийт ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах;
- Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр төслийн талбайд ажил гүйцэтгэх чадамжгүй, эрүүл мэндийн хувьд ноцтой шалтгаантай тохиолдолд ажилтанг ажиллуулахгүй;
- Эрүүл мэндийн хугацаат үзлэгийг тогтоосон хугацаанд зайлшгүй нийт ажилтнуудад хийлгэнэ;
- Анхан шатны тусlamж үзүүлэх сургалт явуулах;
- Байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжээнд өөрсдийн эрүүл мэндийн ажилтантай байх;
- Анхны тусlamжийн хайрцагтай байх; (Шаардлагтай ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд)

- Халдварт өвчнөөс сэргийлэх зааварчилгаа өгөх;
- БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх заавартай байх;
- Орон нутгийн эмнэлэгтэй хамтран ажиллах, уялдааг хангах.

Мөн Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартын норм, нормативын зөвшөөрөгдхөх хэмжээ алдагдсан, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлээс урьдчидлан сэргийлэх бүх арга хэмжээг авч ажиллах ба шаардлагатай тохиолдолд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгож ажиллах, нөхөн сэргээх арга хэмжээг авах, дасгал хөдөлгөөн хийлгэнэ.

Гүйцэтгэгч нь Үйлдвэрийн осол, хурц хорлогоос урьдчилан сэргийлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг удирдлага болгож ажиллана. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгч нь ҮОХХСБ орон тооны бус байнгын комиссыг байгуулсан байна.

Захиалагчаас “Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журам”-ыг батлах ба Гүйцэтгэгч үүнийг хэрэгжүүлж ажиллана.

3.6.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

Гүйцэтгэгч нь Галын аюулгүй байдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллана.

Гүйцэтгэгч нь галын сарай (иж бүрдлээр), объект бүрт галын хор, тамхи татах цэгийг байршуулах ба түүний хэвийн ажиллагааг тогтмол шалгаж хяналт тавина. Гүйцэтгэгч нь гэр сууцны зуухны битүүмж, шалны хамгаалалт, яндангийн амалгаа, шатахуун түгээгүүрийн аянга баригч, газардуулга зэргийг зөв байршуулах ба түлш, шатах тослох материалын галын аюулгүй байдлыг хангаж, хадгалалтын гормыг чанд мөрдөнө. Мөн цугларах цэг байршуулна. Гэр болон байр хоорондын цайг 5 метрээс багагүй зайд байрлуулна.

Гүйцэтгэгч нь газын баллон болон үйлдвэрлэлийн хийн баллон даралтат савны баталгаажуулалт хийсэн байх ба газын баллоныг хадгалахдаа нар шууд тусгалаас халхлагдсан, агаар нэвт сэлгэгдэхүйц сүүдэр газарт баллоныг мөр хүртэл нь далдлаж газарт байршуулж ашиглана. Үйлдвэрлэлийн хийн баллон даралтат савны аюулгүй байдлыг хангана. Мөн тэсэрч, дэлбэрэх бодисын аюулгүй байдлыг хангах ба холбогдох хууль, дүрэм, журмын шаардлагыг мөрдөж ажиллана.

Гүйцэтгэгч нь Химиин бодис, нэмэлтийн хадгалалт, хамгаалалт, химиин нэмэлт бодистой харьцаан ажиллах, хадгалах, тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангана.

Төмөр замын доод бүтцийн ажил болон өртөө, зөрлөгийн барилга байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэх хугацаанд дээр дурдснаас гадна дараах зүйлсийн аюулгүй байдлыг хангаж, холбогдох хуульд заасан шаардлагыг биелүүлж ажиллана. Үүнд:

- Талбайн хэвийн ажиллагаатай зохиомол гэрэлтүүлгийн байдал;
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн олголт, ашиглалт;
- Дам нуруу өргөж байршуулах үеийн аюулгүй байдал;
- Бетон зуурмаг талбайд авах үеийн аюулгүй байдал;
- Шон сууринд арматур байрлуулах үеийн аюулгүй байдал;
- Замын аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ;
- Барилгын шат угсралтын үеийн аюулгүй байдал;
- Өндөрт ажиллах, өндөрийн бүсний бэхлэгээний аюулгүй байдал;
- Дугуй хоолой буулгах, байршуулах үеийн аюулгүй байдал;

- Тоног төхөөрөмжийн удирдлага, ашиглалтын үеийн аюулгүй байдал;
- Гагнуурын үеийн аюулгүй байдал;
- Өрөмдлөгийн үеийн аюулгүй байдал;
- ХАБЭА-н инженерийн сургалт явуулсан байдал;
- Бетон зуурмагийн узелийн аюулгүй байдал;
- Эргэлтэд багаж, тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах үеийн аюулгүй байдал;
- Бэхэлгээний боолт, татуурга, трасс зэргийг баталгаажуулсан байдал;
- Хүчтгэлийн үеийн аюулгүй байдал;
- Шат, шатны хашлагын аюулгүй байдал;
- Техникийн бүрэн бүтэн байдал;
- Машин, механизмийн кабины бүрэн бүтэн байдал;
- Машин, механизмийн халуун, хүйтэн үлээгүүр, хэмжигчийн хэвийн байдал;
- Жолооч, операторуудын аюулгүй байдал;
- Өргөх зөөвөрлөх техникийн аюулгүй байдал;
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хяналт;
- Ажлын талбайн хаалт, хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээ;
- Ажлын талбайн орох, гарах гарцын тэмдэг тэмдэглэгээ;
- Карьер, талбайн гэрэлтүүлгийн байдал;
- Тоологч, дохиочны аюулгүй байдал;
- Аюулгүй зайд баримтлаж буй байдал;
- Халуун, хүйтэнд нөхцөлд ажиллах үеийн аюулгүй байдал;
- Засвар үйлчилгээний аюулгүй байдал;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал;
- Кемпийн аюулгүй байдал;
- Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал;
- Яаралтай үед холбогдох хүмүүсийн бүртгэл;
- Карьерын аюулгүй байдал;
- Замын аюулгүй байдал;
- Гүүрийн захын болон завсарын тулгуурын суурийн ухмалын тэмдэглэгээ, хаалт, хашилт, анхааруулсан байдал;
- Хэв, хашмал угсралт үеийн аюулгүй байдал, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. (үйлдвэрлэлийн нөхцөл байдалд тулгуурлан аюулгүй ажиллагааны заалт нэмэгдэж болно).

3.6.4 Эрүүл ахуй

Гүйцэтгэгчийн гал тогоо, оффис, амрах байр, нийтийн бие засах газар, кемп орчны хог хаягдлын цэг, хүнсний бүтээгдэхүүний агуулах, зоорь зэргийн ариун цэвэр, халдвартгүйжүүлэлт болон ундны ус, хоолны чанар, хоолны дээжийн бүртгэл, угаалтуур, шүршүүр, сууртуурын тоо зэрэг нь нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартад нийцсэн байна. Үйлдвэрийн нөхцөл байдалд тулгуурлан уг эрүүл ахуйн шаардлага нэмэгдэж болно.

3.6.5 Байгаль орчин олон нийтийн харилцаа

Гүйцэтгэгч нь орон нутгийн байгаль орчин ба олон нийтэд үзүүлэх барилгын ажлын болон холбогдох үйл ажиллагааны сөргөн нөлөөг бууруулахын тулд ямар ч үед хүчин чадлаа дайчлан ажиллана. Ургамал, амьтны аймгийг хамгаалах, тоосжилт, агаарын бохирдол, хийн ялгаруулалтыг бууруулах буюу багасгах, чимээ шуугиан болон дулаан ялгаруулалтыг багасгах, бохир ус, хог хаягдлыг цэвэрлэх, гадаргын ус урсацыг хянахтай холбоотой асуудлыг Гүйцэтгэгч өөрийн ажлын хүрээнд хамаарах хэсгийг хариуцах ба эдгээрийг Төслийн ажлын даалгаварт багтсанд тооцно. Гүйцэтгэгч нь зөрчил арилгуулах, эсхүл холбогдох стандарт, нийтлэг жишгийг сайжруулахтай холбоотой Захиалагч болон Инженерийн аливаа зааварчилгааг дагаж мөрдөнө. Гүйцэтгэгч нь Захиалагчийн баталсан байгаль орчны дүрэм, журам, нөхцөлийг баримталж ажиллана.

3.7. ТАЛБАЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ БОЛОН ТӨЛӨВЛӨЛТ

3.7.1. Хяналт ба Хүчинтэй байдал

Захиалагч нь өөрийн боловсруулсан Зураг төсөл (загвар зураг, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, инженер хайгуулын судалгаа, инженер, геологи, геодезийн зураглал зэрэг)-ийн үнэн зөв байдлыг хариуцна.

Гүйцэтгэгч нь зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлагатай, үүнтэй холбоотойгоор нэмэлт Гидрологийн Хяналт болон Геотехникийн шалгалтыг оруулах шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт хяналтыг өөрийн зардлаар хийнэ. Гүйцэтгэгч нь өөрчлөлтийн буюу гүйцэтгэлийн зураг төслийн үнэн зөв байдлыг хариуцна.

3.7.2. Геотехникийн Шалгалт

Захиалагч нь Гэрээний Баримт бичиг хүлээлгэн өгөх ажлын хүрээнд бэлэн байгаа төмөр замын чигийг геотехникийн үзүүлэлт (Геотехникийн профайл) болон техникийн бусад дэлгэрэнгүй мэдээлэл, зураг төслийг Гүйцэтгэгчид гаргаж өгнө. Захиалагч нь энэхүү гаргаж өгсөн баримт бичгийнхээ үнэн зөв байдлыг хариуцах ба Гүйцэтгэгч шаардлагатай гэж үзвэл өөрийн зардлаар тус мэдээлэл, баримт бичигтэй холбоотой баталгаажуулалт, нэмэлт хэмжилт, шалгалт хийж болно.

3.7.3. Төлөвлөлт

Гүйцэтгэгч нь төслийн бүх төлөвлөгөөг боловсруулна. Төлөвлөгөө болон түүний аливаа өөрчлөлтийг бэлтгэж Инженерээр баталгаажуулна. Төлөвлөгөөнд багц 1-2 хүрээнд хийх ажлуудад уялдуулсан байна.

Ажлыг эхлүүлэхээс өмнө, Захиалагч нь Ажлыг төлөвлөхөд ашиглагдах Төлөвлөгөөтэй холбоотой үндсэн мэдээллийг боломжтой тохиолдолд Гүйцэтгэгчид гаргаж өгнө. Гүйцэтгэгч нь дээрх мэдээ мэдээллийн бүрэн гүйцэд, үнэн зөв байдлыг хянан шалгах ба томилогдсон Ажлын туслан гүйцэтгэгчийн төлөвлөлтийг оруулан Ажилтай холбоотой бүхий л төлөвлөлтийн мэдээллийн үнэн зөв байдалд бүрэн хариуцлага хүлээнэ. Захиалагч, Инженер нь Гүйцэтгэгчийн мэдээлсэн аливаа зөрүүтэй мэдээг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж болох хэдий ч Гүйцэтгэгч нь төлөвлөгөөний үнэн зөв байдлыг дангаар хариуцна.

3.8. ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН АЖЛЫН ХУВААРЬ

Гүйцэтгэгч нь Төслийн ажилтай холбоотой шаардлагатай төлөвлөгөөг бэлтгэх ажлыг хариуцна. Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг хүлээн авснаас хойш хуанлийн 28 хоногийн дотор Инженерээс татгалзсан мэдэгдэл өгөөгүй бол Гүйцэтгэгч нь тус төлөвлөгөөний дагуу, энэхүү Гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэнэ. Захиалагчийн ажиллах хүчин нь өөрсдийн үйл ажиллагааг дээрх Төлөвлөгөөний дагуу явуулна. Инженерийн зөвшөөрсөн Ажлын хуваарийг хүлээн зөвшөөрсөн гэрээний төлөвлөгөө гэж үзнэ.

Ажил эхэлснээс хойш 28 хоногийн дотор Гүйцэтгэгч нь дараах мэдээллийг тусгасан Ажлын нарийвчилсан төлөвлөгөө болон Гэрээний нөхцөлийн Хавсралт б дахь Ажлын хуваарьт үндэслэн боловсруулсан дараах баримт бичгийг бэлтгэж, хүргүүлнэ. Үүнд:

1. Ханган нийлүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө. Үүнд: санал болгож буй туслан гүйцэтгэгчдийн бүрэн мэдээлэл, материалын бэлтгэн нийлүүлэлтийн төсөл, худалдан авахаас өмнөх үеийн туршилт, шалгалт, ажлын талбайгаас гадна шалгах, зөвшөөрөх болон санал болгож буй огноо зэргийг багтаана.

2. Их хэмжээний материалын бэлтгэн нийлүүлэлт болон нийлүүлэх хуваарь. Үүнд: Санал болгож буй бэлтгэн нийлүүлэгчдийн нэрс, материалын төрөл, тоо хэмжээ болон төлөвлөсөн хугацаа зэргийг оруулна.

3. Гэрээний бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан хуваарь буюу S-шугам. Үүнд: Гэрээний төлбөрийн нөхцөлүүд дээр үндэслэсэн цагийн “хоцрогдол”-ыг мөн тусгасан байна.

4. Барилгын Нэгдсэн Төлөвлөгөө (Ажлын хамгийн богино болон хамгийн сүүлд гүйцэтгэх хуваарь)

5. Дараагийн сард хийхээр төлөвлөсөн гол үйл ажиллагаануудыг оруулсан “Дараа сарын төлөвлөгөө”-г сар бүрийн сүүлийн 7 хоногт.

6. Гурван сар бүрийн эргэлтийн төлөвлөгөө.

7. Туршилт, тест болон хүлээлгэн авах төлөвлөгөө

Захиалагч эсхүл Инженер нь Гүйцэтгэгчид гэрээний дагуу Төлөвлөгөө нь биелээгүй (эсхүл дурдсан хүрээнд), бодит явц болон Гүйцэтгэгчийн дурдсан хүсэл зоригтой нийцээгүй тухай мэдэгдэл өгвэл Гүйцэтгэгч нь Төлөвлөгөөг шинэчилж, мэдэгдэл гаргасан талын зөвшөөрлийг авахаар Инженерт, шаардлагатай бол Захиалагчид хүргүүлнэ. Гэрээнд заагдсан хүчин зүйлс болон Захиалагч болон Гүйцэтгэгчээс хамаарахгүй үүссэн нөхцөлөөс шалгаалан Ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд өөрчлөлт орох шаардлага үүссэн үед тухай бүрд өөрчлөлт хийж Инженерээр баталгаажуулахаар хүргүүлнэ.

3.9. ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Гүйцэтгэгчийн үйлдсэн бүх бичиг баримт Инженерт цахим байдлаар хүргэгдэх ба аль ч талын баримт цахим байдлаар хадгалагдахаас гадна дараа хэрэгтэй үед цахим болон хэвлэмэл байдлаар сэргээгдэх боломжтой байх ёстой. Бичиг баримтууд стандартын шаардлага хангаж байх ёстой. Үүнд дизайн, зөвшөөрөл, барилга байгууламжийн тайлан, чанарын хяналт, материалын талаарх тооцоо, хангамж, хүний нөөц, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээ мэдээлэл багтана.

3.10. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад нийцүүлж, Ажлыг хийж гүйцэтгэх ба төсөл хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлагаар хангах удирдлагын нэгжийг томилон ажиллуулна.

Мөн Гүйцэтгэгч төслийн багийн зохион байгуулалтын болон ажил үүргийн уялдааг харуулсан схем боловсруулах ба уг схем нь ажлын шаардлагад нийцсэн байх бөгөөд үүний өөрчлөлтийг Сар тутмын тайланд тусгасан байдал.

Хяналтын өрөө нь 24 цагийн радио холбоотой, аюулгүй ажиллагааны бүх ажилтантай холбогддог утсан холбоо бүхий байхаас гадна дээрхээр хязгаарлагдахгүй, талбайн кемп, үйлдвэрүүд, Захиалагчийн оффис, карьер гэх мэт бусад шаардлагатай бүх хэсэг нэгжтэй радио давтамжаар холбогдох боломжтой байхаас гадна 24 цагийн харуул хамгаалалттай байна.

3.11. ӨДӨР ТУТМЫН АЖЛЫГ ХЯНАХ

Гүйцэтгэгч гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор ажлын гүйцэтгэл, биелэлтэд хяналт тавина. Тус ажлын хүрээнд ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж ажиллахаас гадна холбогдох тайлан боловсруулж, Инженерт (шаардлагатай бол Захиалагчид) хүргүүлэх ажил мөн багтана. Тайланд ажлын гүйцэтгэлийн явцыг харуулах шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг багтаасан байна.

Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн явцын талаар өдөр, долоо хоног, сар, улирлын явцын тайлан боловсруулж, Инженерт (шаардлагатай бол Захиалагчид) хүргүүлнэ.

3.12. САРЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЙЛАН

3.12.1 Ерөнхий

Гүйцэтгэгч Сар ажлын явцын тайланг Захиалагчийн баталсан маягтын дагуу боловсруулж дараа сарын 5-ны өдрийн дотор Гэрээнд заасан хувь хэмжээгээр Инженерт (шаардлагатай бол Захиалагчид)-хүргүүлнэ. Уг тайланд дараах агуулга багтсан байна. Үүнд:

3.12.2 Ажлын бодит гүйцэтгэл

Сарын ажлын явцын тайланд ажлын гүйцэтгэлийн хувь, дөрвүүтэй ахиц, үндсэн хэсгүүд, асуудалтай хэсгүүдэд засан сайжруулалт болон холбогдох бусад арга хэмжээ авах ажлын зардал, харилцан хамааралтай асуудлууд, тулгамдсан асуудал болон авах арга хэмжээ, гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээг төлөвлөсөн ажлын хувь хэмжээтэй харьцуулах зэрэг мэдээллүүд орсон байна. Тухайлбал дараах мэдээ багтаж болох ба үүгээр хязгаарлагдахгүй.

- Тухайн сард хийгдсэн газар шорооны ажил буюу төмөр замын доод бүтцийн ажил, өртөө, зөрлөгийн барилга угсралт, түүний засварын тоног төхөөрөмж, дээрх ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой үүссэн бусад ажлын хуваарь, гүйцэтгэлийн хувь болон бодит үйл явцыг харуулсан тоон өсөлтийн үзүүлэлт, баримтын хамт;
- Гүйцэтгэсэн ажил тус бүрийн хувь хэмжээ;
- Ажил гүйцэтгэх явцад үүссэн алдаа, гологдол, эс үйлдлийн талаарх тайлбар, баримт, үүнтэй холбоотой хоцорсон цаг хугацааг хэрхэн нөхөн эсхүл ирээдүйд учирч болох хугацааны хоцрогдлын хэм хэмжээ, авах арга хэмжээний төлөвлөгөө;
- Тухайн сард хийж гүйцэтгэсэн Ажилд ашигласан ажиллах хүч, тоног төхөөрөмжийн жагсаалт болон бусад мэдээлэл;

3.12.3. Зохицуулалт

Төмөр замын багц ажлыг хийж гүйцэтгэхэд шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлууд, мөн ажлын явцад нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийн жагсаалт, Туслан Гүйцэтгэгчид хамаарах асуудлуудын одоогийн нөхцөл байдлын мэдээг сар ажлын явцын тайланд тусгасан байна. Үүнд:

- Тайлант сард хамаарах зохицуулалтын болон тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;
- Хүлээгдэж байгаа зөвшөөрөл, шийдвэрүүд болон бүх өргөдөл, хүсэлтүүдийн жагсаалт, мөн түүнчлэн олгогдсон зөвшөөрөл, шийдвэрүүдийн жагсаалт.

3.12.4. Бараа ажил үйлчилгээний худалдан авалтын мэдээ

Ажил гүйцэтгэхэд шаардагдах бараа материал, тоног төхөөрөмж, газар шорооны ажилд шаардлагатай чигжээс, түгээмэл тархацтай ашигт малтмал, барилга байгууламжийн

материалын худалдан авалттай холбоотой ажлын гүйцэтгэл, явцыг тайланд тусгана. Тайланд ийнхүү тусгахдаа дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Тайлант сард хийж гүйцэтгэсэн бараа материалын худалдан авалтууд, холбогдох мэдээлэл, тулгамдаж буй болон шийдвэрлэх шаардлагатай асуудал, Гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн товч мэдээлэл;
- Худалдан авалт хийгдсэн бараа, материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, нарийвчилсан тодорхойлолтын хамт. Үүнд: Зөвшөөрөл, Үйлдвэрлэлийн гэрчилгээ, үйлдвэрлэлийн явц, гүйцэтгэл, гарал үүсэл, тээвэрлэлт болон барилгын талбайд хүлээн авах хуваарь (төлөвлөсөн болон бодит хугацаа)
- Худалдан авалтын үйл ажиллагаа хоцорсон эсэх, удаашралтай эсхүл хоцрогдолтой байгаа бол үндэслэл бүхий шалтгаан, удаашрал, хоцрогдлыг арилгах арга хэмжээ.

3.12.5. Ажлын хуваарь, гүйцэтгэлийн ахицын шинэчилсэн мэдээлэл

Төслийн үйл ажиллагаанд ашиглах Гүйцэтгэгчийн Ажлын хуваарь, гүйцэтгэлийн шинэчилсэн мэдээг Захиалагчтай тохиролцсоны дагуу нэг төрлийн төслийн хяналтын программ (Primavera байж болно) дээр боловсруулна.

Сар тутмын явцын тайланд тусгасан ажлын гүйцэтгэлийн өсөлтийн мэдээ нь бодит ажлын гүйцэтгэл, тухайн ажлыг дуусгахад цаашид хэдий хугацаа зарцуулах, явцын өсөлт, үүнд үндэслэн ирээдүйд ямар ажлууд хийж гүйцэтгэх талаарх тооцоолол, хийж гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээгээр Ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан харуулсан тайлан, тухайн сард хамаарах ажлын гүйцэтгэлийн график (хийж гүйцэтгэсэн ба үлдэгдэл ажил), суурь шугамтай харьцуулсан харьцуулалт; мөн бодит Өсөлтийн "S" муруй зэргийг багтаасан байна.

Гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайлан нь дараах тусгай шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

а. Ажлын төлөвлөгөө: үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг хэрхэн тодорхойлсон тухай тайлбар, Гэрээнд тодорхойлсон график төлөвлөгөөт ажлыг хийж дуусгахад Гүйцэтгэгчийн тодорхойлсон арга зам;

б. Шинэчилсэн Төлөвлөгөө: Төслийн Ажлын хуваарийн дагуу явж байгаа болон дуусгавар болсон ажлууд нь зөвшөөрөгдсөн хугацаанаас хэтэрсэн, эсхүл өмнө дууссан эсэхийг нарийвчилсан төлөвлөгөөнд тусгана.

Нарийвчилсан тайлан нь дараах тусгай шаардлагуудыг хангасан байна.

- Гүйцэтгэлийн эцсийн хугацаа, нэгж ажилбарын төлөвлөгөө ба бодит гүйцэтгэлийн хугацаа, ажлын төлөвлөгөөт хугацаа хожимдсон ба тус хоцрогдлын үндэслэл бүхий тайлбар;
- Хугацаа хоцорсны улмаас Ажлын хуваарыт нөлөө үзүүлэх эсэх, мөн нөлөө үзүүлж байгаа бол ажлын хоцрогдлыг багасгаж, алдааг засаж, запруулах, түүний нөлөөллийг багасгаж үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийн талаар тайлбар;
- Өмнөх сард үүссэн шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлуудын талаарх тайлбар, аливаа алдаа, дутагдлыг засаж запруулсан мэдээ;
- Зураг төслийн өөрчлөлт болон өөрчлөлтийн журам (хэрэв өөрчлөх бол)-аас хамаарсан цаг хугацааны зохицуулалт.
- Хэрэгжиж байгаа буюу төлөвлөгөөнд багтсан үйл ажиллагаануудын тодорхойлолт, тэдгээр үйл ажиллагаа бүрийг дугаарлаж, цэгтэй тодорхойлсон тодорхойлолт;

с) Төлөвлөгөөний Үйл явцыг дараах байдлаар илэрхийлнэ:

- Тухайн Тайлант Сарын ажлын үйл явцын нэгдсэн тайлан болон үлдсэн ажлуудын урьдчилсан мэдээ зэргийг тусгана.

д) Дагалдах үйл ажиллагааны анализ: Тайлант хугацааны өмнө болон тухайн хугацаанд хийгдэхээр төлөвлөгдсөн боловч сарын төгсгөлд эхлээгүй байгаа ажлуудад хийсэн анализ, мөн түүнчлэн Төлөвлөгөөгээс эхлүүлэхээс өмнө хэрэгжүүлж эхлэх эсхүл хэрэгжүүлж дуусгасан байх ажлуудад хийсэн анализыг үүнд тусгана.

4.12.6. Гурван сарын үргэлжилсэн төлөвлөгөө

Гурван сарын үргэлжилсэн төлөвлөгөө нь гол Төлөвлөгөөний үргэлжлэл (дагалдах арга хэмжээ) бөгөөд гурван сарын хугацааг хамаарна.

Гурван Сарын Үргэлжилсэн Төлөвлөгөө нь тухайн хугацаан дахь Гүйцэтгэгчийн төлөвлөгөө, зохион байгуулалт болон ажлын гүйцэтгэлийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.

Гурван Сарын Үргэлжилсэн Төлөвлөгөөг Талуудын тохиролцсон Ажлын хуваарь, төлөвлөгөө боловсруулах программ дээр боловсруулна. Төлөвлөгөөг шугаман диаграмм болон цагийн хэмжээс бүхий диаграммын загвараар хийнэ. Шугаман диаграммууд нь А3 хэмжээс дээр хийгдэх бөгөөд харин цагийн хэмжээс бүхий диаграммууд нь А1 хэмжээсийн аргаар хийгднэ. Уг төлөвлөгөөнд заасан зорилтууд нь зөвшөөрөгдсөн Төлөвлөгөөний зорилтуудтай уялдсан, шууд хамааралтай байна.

Гурван сарын үргэлжилсэн төлөвлөгөөг сар тутамд гаргах ба тус сарын тайлангийн бүрдэл хэсэг байна.

Хэрэв Гурван сарын үргэлжилсэн төлөвлөгөө нь Ажлын хуваарытай зөрчилдөж байвал Төлөвлөгөөнд хийсэн Анализийн тайланг нарийвчилсан тооцооллын хамт ирүүлэх бөгөөд дээрх тооцоололд гурван сарын хугацаанд хийгдэх ажлуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар Гүйцэтгэгчийн төлөвлөгөөг тусгасан байна. Гүйцэтгэгчийн тэрхүү төлөвлөгөөнд урьдчилсан таамаглал болон ажлыг цаг тухайд нь дуусгах зорилгоор авч хэрэгжүүлэх арга замуудыг тусгана.

Гурван сарын үргэлжилсэн төлөвлөгөө болон Гэрээний нөхцөлийн Хавсралт 6 [Ажлын хуваарь] хоорондын уялдааг хангах үүднээс Гэрээлэгч тал тэдгээрт хийгдэх шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ.

3.12.7. Чанарын удирдлагын тогтолцоо

Гүйцэтгэгчийн Чанарын Удирдлагын Тогтолцооны хэрэгжилт, хяналт, шалгалтын тайланг Сарын явцын тайланда хавсаргах бөгөөд дараах зүйлс багтсан байна. Үүнд:

- 1) Чанарын тогтолцооны баримт бичгүүдийн хяналт, хэрэгжилтийн явц;
- 2) Аудитын журам болон түүний хэрэгжилт;
- 3) Тайлант хугацааны туршид Инженер болон Гүйцэтгэгчээс тодорхойлсон бүхий л зөрүү, үл нийцэл болон тэдгээрийг арилгахтай холбоотой хийж гүйцэтгэсэн арга хэмжээ;
- 4) Чанарын удирдлагын тогтолцооны гүйцэтгэлийн талаар нарийвчилсан үнэлгээ. Үүнд: зөрүү, үл нийцлүүд, алдаа дутагдлын талаарх мэдээллийг багтаах бөгөөд тэдгээрийг залруулах, урьдчилан сэргийлэхэд авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийн талаар тусгана;
- 5) Захиалагч, Инженер болон Гүйцэтгэгчтэй холбоотой хүлээгдэж буй бүхий л асуудал, тайлбарууд, тэдгээртэй холбоотой төлөвлөж буй арга хэмжээнүүд.

ЗАХИАЛАГЧ

3.12.8. Санхүүгийн статус

Санхүүгийн статусын талаар дараах асуудлууд нь сарын ажлын тайланд тусгагдана.
Үүнд:

1. Санхүүгийн чухал асуудлууд, одоо тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхээр авч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийн талаар нарийвчилсан хяналтын тайлан;
2. Хийгдсэн болон цаашид төлөгдөх бүхий л төлбөрийн статусыг харуулсан санхүүгийн бүртгэлийн схем;
3. Гэрээгээр төлөвлөгдсөн болон сарын ажлын тайланг гаргах өдрийг хүртэл хийгдсэн бэлэн мөнгөний гүйлгээний "S" муруй;
4. Мөнгөн гүйлгээний тооцооллын шинэчилсэн хүснэгт;
5. Одоо байгаа бүхий л нэхэмжлэлүүдийн статусын тайлан;
6. Үргэлжилж байгаа нэхэмжлэлүүдийн статусын тайлан;
7. Үргэлжилж байгаа нэхэмжлэлүүдийн түр хугацааны, шинэчилсэн санхүүгийн тооцооллыг тайландаа тодорхой тусгасан тайлан;
8. Эцсийн үр дагавар, өсөлтийн үйл явц, зөвшөөрөгдсөн буюу мэдэгдсэн эсэх талаарх мэдээллийг тусгасан өөрчлөлтүүдийн (зөвшөөрөгдсөн болон урьдчилан таамаглаж байсан аль аль нь) жагсаалт;
9. Хүлээн авсан төлбөр тус бүрийн огноо, мөнгөн дүнгийн талаарх жагсаалт. Мөн хүргэгдсэн боловч хараахан төлөгдөөгүй байгаа сар тутмын төлбөрийн нэхэмжлэлийн жагсаалт.

3.12.9. Бусад

Сар тутмын явцын тайландаа мэдээллийг мөн тусгасан байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд ажлын талбай дээр ажилласан ажиллах хүчиний жагсаалт, ажил гүйцэтгэх цаг, ээлжийн зохион байгуулалт, тулгамдсан асуудлууд зэргийг агуулсан тайлбар, тодорхойлолт;
2. Тайлант хугацаанд ажилласан Гүйцэтгэгчийн төслийн удирдлагын болон хяналтын багийн ажилтнуудын жагсаалт;
3. Тайлант хугацаанд ажилласан техник, тоног төхөөрөмж, үйлдвэр, түүнд хоршин ажилласан техник, машин механизмын жагсаалт, шатахуун зарцуулалтын тооцоо нийлсэн акт, түр зогсолт хийсэн, эвдрэл гэмтэлтэй техникийн жагсаалт, эвдрэл гэмтлийг засварлахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ;
4. Ажлын гүйцэтгэлийн өсөлт талбайн болон гүйцэтгэлийн гэрэл зургууд /харьцуулсан байдлаар/;
5. Шаардлагатай бараа материалын чанарын шинжилгээний баримт бичиг, тестийн хариу, үр дүн (тогтсон тест болон шалгах тестүүд)-ийн талаар товч мэдээлэл.
6. Тайлант хугацааны цаг уур, хур тунадас болон температурын гэм мэт цаг уурын мэдээ;
7. Аюулгүй ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр нөлөө;
8. Ажлын талбайд үссэн үйлдвэрлэлийн болон зам тээврийн осол, гэмтэл, гэмт хэргийн шинжтэй зөрчлийн жагсаалт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр нөлөө;
9. Сарын хугацаанд гаргасан аливаа нэхэмжлэлийн (хэрэв байгаа бол) жагсаалт. Үүнд нэхэмжлэлийн хэмжээ болон цаг хугацааны хүрээг багтаасан байна;

10. Тайлант сард Захиалагчид эсхүл Инженерт хүргүүлсэн, тэдгээрээс хүлээн авсан баримт бичиг, албан тоотын жагсаалт;
11. Нөөц Ашиглалт: Барилгын талбайд байршсан нөөцийг илтгэх голлох барилга угсралтын материалууд, дараагийн гурван сарын нөөц ашиглалтын төлөвлөгөө;
12. Барилгын талбайд байгаа барилга угсралтын бүхий л машин механизмуудын жагсаалт. Нөгөөтэйгүүр зорилтот өсөлт/үйл явцад хүрэхийн тухайн сард шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт;
13. Машин механизмын хэсэг тус бүрийн өдөр тутмын ажиллагаа болон ажиллаж буй байдлын тэмдэглэл;
14. Ашиглалтаас гарсан машин механизмуудын жагсаалт, тэдгээрийг буцаан ажиллуулахад хийгдэх арга хэмжээний талаарх жагсаалт;
15. Дараагийн гурван сард Барилгын талбайд шаардагдах машин механизмуудын ашиглалтын төлөвлөгөө;
16. Түр хугацаанд хийгдэж буй Ажлуудын жагсаалт.
17. Гүйцэтгэгч Ажил гүйцэтгэхтэй холбоотой ашиглаж буй чижээс, түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, шатахууны хэрэглээ, тээвэрлэлтийн мэдээ;
18. Карьеруудын буюу тээвэрлэлтийн замын (Vogtow Area/карьер) зохицуулалтууд. Үүнд: туслах зам, барилгын талбайд нэвтрэх замууд болон нөхөн сэргээлтийн талаар тусгана;
19. Шийдвэрлэх шаардлагатай болон Захиалагчийн зүгээс дэмжлэг үзүүлэхийг хүссэн асуудлын жагсаалт.

3.13. ЦАГ АГААРЫН БОЛОН БУСАД ХҮНДРЭЛТЭЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гүйцэтгэгч нь барилгын талбайд ажилласан тодорхой туршлагатай байх буюу цаг агаарын байгалийн давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд ажлыг хэвийн үргэлжлүүлнэ. Цаг агаарын онцгой нөхцөлөөс үүдэн гарах багахан хэмжээний саатал, бэрхшээлийг үл харгалзан ажлын гүйцэтгэлийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.14. АЖИЛ-ӨДӨР

Ажил-өдөр нь Гэрээний тусгай нөхцөлд нийцэх ба холбогдох журмын дагуу зохион байгуулагдана.

Ажил-Өдрийг зөвхөн Захиалагчийн төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрөлд хийж гүйцэтгэх ба Ажил-Өдрийн тайлант хуудас дээр тухайн өдөр ажилласан Инженер /Гүйцэтгэгчийн/ гарын үсэг зурж Захиалагчид хүргүүлнэ.

Инженер нь Ажил-Өдрийн гүйцэтгэлийг хүлээн авсны дараа баталгаажуулах ба Захиалагч зохих журмын дагуу Гүйцэтгэгчид төлнэ.

3.15. ДАГАЛДАХ АЖЛУУД

Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны хүрээлэлд дараах ажлууд хамаарахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд эдгээрийг даалгах бөгөөд Дагалдах ажилдууд гэж тооцогдоно.

1. Мал амьтдын нүхэн гарц (зураг төсөлд дүрсэлсэн дээр нэмэгдэж хийгдэх мал амьтны гарц)
2. Төмөр замын нийт уртын дагуух хашлага (Төмөр замын зурvasын хашлага буюу төмөр замын дагуу хашлага нь Дагалдах ажилд тооцогдоно.)

4. ХЯНАЛТ, ТУРШИЛТ БА АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ

Зураг төслийн дагуу нийлүүлэгдэж байгаа түүхий эд, тоног төхөөрөмж болон бүрдэл хэсгүүд, бүхий л ажлуудын гүйцэтгэлийг Захиалагч болон Инженер шалгаж, судална.

Ажиллах хүч, бараа түүхий эд нь зохих хууль, тогтоомж, техникийн шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох туршилт, шалгалт нь үйлдвэрлэгчийн эсхүл Гүйцэтгэгчийн ажлын талбай дээр хийгдэнэ. Тэдгээр туршилт, шалгалтуудын нарийвчилсан мэдээлэл болон давтамжийг доор дурдсаны дагуу Гүйцэтгэгчийн зүгээс санаачлах бөгөөд Гүйцэтгэгчийн заавал дагаж мөрдөх, шаардлагыг хангаж байгаа эсэхэд Захиалагч болон Инженер хяналт тавина.

Зураг Төсөлд тодорхойлсон бусад хэсгүүдийн эсхүл патентлагдсан хэсгүүдэд хийх бүхий л туршилтыг тухайн асуудлаар эрх авсан байгууллага хийнэ.

4.1. ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлууд нь энэхүү Ажлын Зураг Төслийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг ажилд хэрэглэсэн түүхий эд, тоног төхөөрөмжийн хэсгүүд нь туршилтад хамрагдсан байна.

4.2. АНГИЛАЛ

Туршилт нь дараах таван (5) ангилалд хуваагдана:

- Төрөл, хэлбэрийн туршилт;
- Хэв загварын туршилт;
- Үйлдвэрийн туршилт (ҮТ)
- Талбайн туршилт (ТТ)
- Урьдчилсан туршилт (ҮТ)

Бүхий л төрлийн систем, тоног төхөөрөмжийн эд анги болон түүхий эд нь Төрөл, хэлбэрийн туршилтад хамрагдана. Дээрх туршилт нь үйлдвэрлэлийн шатанд хийгдэх бөгөөд Хэв загварын туршилт эхлэхээс өмнө хийгдэж дууссан байна. Хэрэв тухайн тоног төхөөрөмжийн төрөл, хэлбэр нь гэрчилгээ(зохих итгэмжлэлийн баримт бичиг)-тэй бол Гүйцэтгэгч түүнийг нотолсны үндсэн дээр туршилт хийхгүй байж болно. Төрөл, хэлбэрийн туршилтад хамруулах зүйлсийн саналыг Гүйцэтгэгч гаргаж, Инженер хянаж, зөвлөлдөх ба шаардлагатай тохиолдолд Захиалагчаар хянуулна.

Хэв загварын туршилтад ажилд хэрэглэгдэж байгаа бүхий л төрлийн систем, тоног төхөөрөмжийн эд анги болон түүхий эдийг хамруулна.

Хэв загварын туршилтыг хийж дууссаны Үйлдвэрийн шаардлага хангасан эсэхийг тодорхойлох Үйлдвэрийн туршилтыг тоног төхөөрөмж болон системд хийнэ.

Талбайн туршилтыг түүхий эд, тоног төхөөрөмж, эсхүл системийг тогтоосон Ажлын талбайд хүргэгдэн, суурилуулсны дараа хийнэ. Талбайн туршилт нь Урьдчилсан туршилт (үүнд холимог сорил, шинжилгээ, гүйцэтгэлийн туршилт, туршилтын явалт зэрэг багтана) болон Хүлээн авах туршилтаас бүрдэнэ.

Туршилт дуусах хүртэл аливаа хангалтгүй туршилтыг залруулах бүхий л арга хэмжээг Гүйцэтгэгч авч хэрэгжүүлнэ.

4.3. ТУРШИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.3.1. Ерөнхий зохицуулалт

Гүйцэтгэгч нь Туршилтын Төлөвлөгөөг бичгэн хэлбэрээр үйлдэж, Инженерээр хянуулж, батлуулахаар хүргүүлнэ. Туршилтын төлөвлөгөөнд Төрөл, хэлбэрийн туршилт,

Хэв загварын туршилт, Үйлдвэрийн туршилт, Талбайн туршилт зэргийн агуулгыг тусгасан байна. Агуулга бүр нь үргэлжилсэн хуудасны дугаарлалт, харьяалах хуудсанд хамаарах гарчигтай бичнэ.

Гүйцэтгэгчийн тодорхойлох бүлэг бүрээс хамааран агуулга бүр нь зүйлд холбогдоно. Сорилын Төлөвлөгөөний бүлэг бүр нь дагалдах хэсэгт тусгагдсан асуудлуудыг багтаасан байна.

Туршилтын үзүүлэлт, өгөгдлүүд болон туршилт тус бүрд нэг бүрчлэн тодорхойлсон журмыг Монгол хэл дээр бичгэн хэлбэрээр гаргах бөгөөд олон улсын холбогдох хэм хэмжээ, стандартуудыг багтаасан байна. (Тоног төхөөрөмжийн нэр, ангилал, төрөл, үйлдвэрлэгчид, шаардлагатай туршилтын байгууллага, тоног төхөөрөмжүүдийг тусгана.)

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа стандарт, шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлсон баримт, бичиг.

4.3.2. Төрөл, хэлбэрийн туршилт

Гүйцэтгэгч нь туршилт хийх шаардлагатай зүйлс, туршилт хийгдсэн зүйлс болон бие даасан гуравдагч этгээдээр туршилт хийлгэх шаардлагатай зүйлсийг ойлгомжтойгоор тодорхойлсон жагсаалтыг бэлтгэнэ.

Гүйцэтгэгчээс эд зүйлсэд хийх туршилтыг гүйцэтгэх алхам бүрийг тодорхойлсон журмыг гаргана. Туршилтыг хийхдээ анхаарч, нийцүүлэх олон улсын холбогдох стандартуудын хуулбарыг хавсаргасан байна. Туршилтыг гүйцэтгэх арга барилын талаар нарийн тайлбар болон хэрэглэгдэх багаж хэрэгслийн (нэр, төрөл, ангилал болон үйлдвэрлэгч зэргийг багтаасан) талаарх нарийн мэдээллийг оруулна.

Туршилт хийгдсэн зүйлсийн хувьд Гүйцэтгэгч нь холбогдох нотлох баримт бичгүүдийг ирүүлж, баталгаажуулна.

Гуравдагч бие даасан шинжээчээр хийлгэсэн туршилтын талаарх мэдээллийг, тэрхүү туршилтыг гүйцэтгэсэн байгууллагын туршлага, ур чадварын мэдээллийн хамт ирүүлнэ.

Туршилтын нарийвчилсан хуваарь/төлөвлөгөөг ирүүлнэ.

4.3.3. Хэв, загварын туршилт

Гүйцэтгэгчээс эд зүйлсэд хийх туршилтыг гүйцэтгэх алхам бүрийг тодорхойлсон журмыг гаргана. Туршилтыг хийхдээ анхаарч, нийцүүлэх олон улсын холбогдох стандартуудын хуулбарыг хавсаргасан байна.

Туршилтын багаж хэрэгслийн нэр, төрөл, ангилал болон үйлдвэрлэгч зэргийг тусгасан байна. Туршилтын нарийвчилсан хуваарь /төлөвлөгөөг ирүүлнэ.

4.3.4. Үйлдвэрийн туршилт

Ачилт хийхээс өмнө бүх тоног төхөөрөмж болон бараа материалууд энэхүү туршилтаар орсон байна. Уг туршилтыг Инженерт хүргүүлж, батлуулсан Гүйцэтгэгчийн тусгай нөхцөлийн дагуу хийнэ. Туршилт амжилттай хийгдсэн тохиолдолд эрх бүхий шинжилгээний байгууллага гарын үсэг зурж баталгаажуулсан гэрчилгээг олгох бөгөөд, хэрэв Захиалагч, Инженер туршилтын үйл явцад оролцсон бол Инженерийн гарын үсэг зурж баталгаажуулсан гэрчилгээг эрх бүхий шинжилгээний байгууллагаас олгоно.

Туршилтуудын бүхий л явцыг ердийн төмөр замын үйл ажиллагааг явуулж буй байдлаар гүйцэтгэнэ.

Тоног төхөөрөмж болон систем нь үйлдвэрийн туршилтыг хангасны дараа системийн бурдэл хэсэг бүрд бие даасан Хяналтын инженерээс олгосон албан ёсны

гэрчилгээг хянуулж, баталгаажуулахаар Инженер, шаардлагатай тохиолдолд Захиалагчид хүргүүлнэ.

Гүйцэтгэгчээс эд зүйлсэд хийх туршилтыг гүйцэтгэх алхам бүрийг тодорхойлсон журмыг гаргана. Туршилтыг хийхдээ анхаарч, нийцүүлэх олон улсын холбогдох стандартуудын хуулбарыг хавсаргасан байна.

Туршилтын багаж хэрэгслийн нэр, төрөл, ангилал болон үйлдвэрлэгч зэргийг тусгасан байна. Туршилтын нарийвчилсан хуваарь /төлөвлөгөөг ирүүлнэ.

4.3.5. Талбайн туршилт

Гүйцэтгэгч нь туршилт болон бусад өөрчлөлтүүдэд шаардлагатай бүхий л тоног төхөөрөмж, материал, ажиллах хүчийг хариуцна. Гүйцэтгэгч нь өөрчлөлт хийх шаардлагатай хэрэглэсэн бүхий л сэлбэг, эд ангийн Талбайн туршилтын үед солино.

Гүйцэтгэгч нь бүх эд ангийг туршилтын шаардлага хангах эсэхийг баталгаажуулсан байна. Бүх туршилтын явц болон дүнг Хөндлөнгийн хянагч инженерээр хянуулна. Захиалагч тоног төхөөрөмж, систем, түүний үйлдвэрлэлийн явцыг үйлдвэр дээр нь очиж зааварчилгаа өгч хянан ажиллах Хянагчийг томилно. Хянагч үйлдвэрлэлийн холбогдох бүх үе шатуудад хяналт тавих эрхтэй (үйлдвэрлэлийн явц, туршилтын явц, доголдлыг засах явц г.м). Хянагч нь үйлдвэрлэлийн хяналтыг хийх хугацаанд ажлын цагаар холбогдох бүх үйлдвэрүүдэд чөлөөтэй нэвтэрч, үйлдвэрлэлийг Захиалагчийн шаардлага болон Үндсэн зураг төсөлд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

Үйлдвэрлэгч Хянагчийн илрүүлсэн доголдолд хариу өгч, зохих арга хэмжээг авна. Хянагч мөн үйлдвэрлэлийн зарим нэг чухал үе шатуудын туршилтын үйл явцад биечлэн оролцож, туршилтын үр дүнд гарын үсэг зурж батлах эрхтэй.

Талбайн туршилтад гүйцэтгэсэн бүх Ажлыг хамруулж туршина. Талбайн туршилт нь урьдчилсан ба эцсийн хүлээн авах туршилтаас бүрдэнэ. Туршилтыг Захиалагч өөрийн Хяналтын ажилтан, Инженер болон Хөндлөнгийн хянагч инженерийн зааварчилгаагаар гүйцэтгэж явуулна. Туршилтын бүхий л үр дүнг Захиалагч, Инженер болон Хөндлөнгийн хянагч инженер гарын үсэг зурж баталгаажуулна.

4.3.6. Урьдчилсан туршилт

Урьдчилсан туршилт нь ашиглалтад оруулах Нэгдсэн шалгалт, гүйцэтгэлийг үзүүлэлтийн шалгалт болон туршилтын явалт гэсэн үе шатуудаас бүрдэнэ.

4.3.7. Туршилт ба ашиглалтад оруулах

Гүйцэтгэгч системийг суурилуулж, шалган Захиалагчийн Шаардлага болон холбогдох баримт бичгүүдийн шаардлагыг хангасан гэж үзсэн тохиолдолд Захиалагч, Инженер Ажлыг ашиглалтад оруулах хүсэлтийг гаргана. Захиалагч Талбайн эцсийн туршилтад зориулж ажлын бүрэлдэхүүн хэсгийг томилно. Талбайн эцсийн туршилт нь Инженерийн баталсан Гүйцэтгэгчийн бэлтгэсэн эцсийн туршилтын материалын дагуу явагдана.

4.3.8 Үйл ажиллагаа

Гүйцэтгэгч нь Ажил, эд анги, сэлбэгийн үйлдвэрлэл, Туслан гүйцэтгэгч нарын Ажлыг хүлээн авах болон Талбайн туршилтуудын үйл ажиллагааг тус тус бэлтгэн явуулна.

Ашиглалтад оруулах ажиллагаа нь Захиалагчийн ажилтан, төлөөлөл, Инженер эсхүл бусад албаны хүмүүс болон сургагч, танилцуулагч ажилтнуудын оролцох Туршилтын явалтын үе шат, түүний дараагаар Нэгдсэн системийн туршилтын үе шатнаас бүрдэнэ.

Ашиглалтад оруулсан өдрөөс хойш 6 сарын дотор, Гүйцэтгэгч нь Туршилтын багц хөтөлбөрийн нэг болох хяналт, үйл ажиллагаа, туршилтын хэлбэр байдлыг тодорхойлсон Туршилт болон Ашиглалтад оруулах багц хөтөлбөрийг бэлтгэж Инженерт шаардлагатай гэж үзвэл Захиалагчид явуулна.

Туршилтын хуваарь болон журмыг Инженерт танилцуулж зөвшөөрөл авах ба мөн туршилтын тоног төхөөрөмж, аргыг нарийвчлан тусгасан байна.

Бүх туршилтын журмыг Туршилт хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө танилцуулна. Туршилтын журам нь туршилтын бүх даалгаврын шалгуур үзүүлэлт, турших арга зүй болон холбогдох зураглал (эсхүл тодруулга) байршлыг хоёрдмол утга, санаагүйгээр ойлгомжтой тодорхой тусгасан байна.

Туршилтын журмыг Гүйцэтгэгч боловсруулан гаргах ба мөн гэрээний хугацаанд Төмөр замын ажлын зураг төсөл, харилцах системд өөрчлөлт орсон, эсхүл нэмэлт туршилт шаардлагатай болсон үед дахин өөрчлөлт оруулна.

Инженер болон Захиалагч бүх туршилтад хяналт тавих, туршилт, шалгалтын материалын танилцах эрхтэй.

4.3.9. Хөтөлбөр

Туршилт болон Ашиглалтад хүлээн авах хөтөлбөрт холбогдох тоног төхөөрөмж, туслах систем болон зураг төслийн өөрчлөлтийг хийх, дахин туршилт явуулахаас эхлээд эцсийн Ашиглалтад оруулах хүртэлх хугацааг хангальтай тооцоопно.

Тусгай хянаагч шинжээч, зэрэг тусгай мэргэжилтнүүдийн зардлаас бусад Туршилтуудын бүх зардлыг Гүйцэтгэгч хариуцан гаргана. Мөн догонд гол гэмтлээс, эсхүл тоног төхөөрөмж нь эхний удаагийн туршилтад тэнцээгүйгээс дахин туршилт явуулах, догондлыг засварлах зэргээс үүдэх зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Инженер, Захиалагчтай бичгээр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд, тоног төхөөрөмжийн Хянаагчар томилогдсон ажилтан нь тухайн тоног төхөөрөмжийн зураг төсөл, сууринуулалт хариуцсан ажилтнаас тусдаа бие даасан байна.

Туршилтаар орох бүх тоног төхөөрөмжүүд нь зохих ёсны хүчин төгөлдөр тохиуулга хийсэн шошготой байна. Мөн тодорхой хугацаанд тохиуулгын нарийвчлалыг шалгаж байна. Бүх туршилтын дунд Инженер, Захиалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. ЦАХИЛГААНЫ АЖЛЫН ҮНДСЭН ЗАРЧМЫН ҮЗЛЭГ ШАЛГАЛТ

Хянаагч байгууллага төрөл бүрийн эд ангийн үзлэг шалгалтыг Инженер эсхүл Захиалагчийн зөвшөөрлөөр дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.

1. Хүнд тоног төхөөрөмж - Гүйцэтгэгч хууль ёсны лабораторид тоног төхөөрөмжийн дээжийг шалгаж үзэх ба ерөнхий стандартын туршилтыг анхны эд ангийн үйлдвэрлэл дээр тус тус туршина.
2. Жижиг тоног төхөөрөмж/туслах угсралтууд-Талбай дээр эцсийн туршилтын үед болон ашиглалтад оруулах үед туршина.

Бүх Талбайн Туршилтад Захиалагч эсхүл Инженерийг оролцуулж, бичлэгээр баталгаажуулна. Гүйцэтгэгч товлогдсон өдрийн мэдээллийг урьдчилан мэдэгдлээр явуулна. Гүйцэтгэгч туршилтыг тусгайлан боловсруулсан загвараар гүйцэтгэнэ. Туршилтын загварыг Инженер урьдчилан хянан зөвшөөрсөн байна. Туршилтын бүх багаж, тоног төхөөрөмж хэрэгслийг Гүйцэтгэгчээс бэлтгэх ба Захиалагч, Инженерийн зүгээс тавигдсан шаардлагыг хангасан байна. Туршилтын дунг Гүйцэтгэгч, Захиалагч, Инженер хамт хянан, гарын үсэг зурж баталгаажуулна.

Эд ангийг ачиж явуулахаас өмнө, Инженер эсхүл Захиалагч үйлдвэр дээр нь очиж хяналт хийх ба Захиалагч эсхүл Инженерийн үйлдвэр дээр хийх хяналтыг аюулгүй боломжит нөхцөлөөр хангахыг Гүйцэтгэгчийн зүгээс хариуцна.

4.5. ТУРШИЛТЫН ГЭРЧИЛГЭЭ БОЛОН МЭДЭГДЭЛ

Гүйцэтгэгч эд анги, тоног төхөөрөмж бүрийн ерөнхий стандартын болон дээжийн туршилтын гэрчилгээ болон мэдэгдлийг явуулна. Туршилтын бүрэн хариу нь тодорхой хаягласан, эмхлэн үзсэн, эд ангийн нэр, хийгдсэн, загвар, төрөл, туршсан огноо, туршилтын төрөл, тайлбар, үйл явц зэргийг тусгасан байна. Туршилтын хариу нь Чанарын баталгааны гэрчилгээ, эд ангийн стандарт болон эд ангийг шалгасан стандартыг багтаасан байна.

4.5.1 Нэгдсэн туршилт

Төгсгөлийн туршилт нь Нэгдсэн туршилт бөгөөд иргэний барилга, барилга, замын доод бүтцийн ажил ба дээр дурдсан Туслан гүйцэтгэгч нарын хариуцсан Ажлуудыг хамрах ба үүгээр хязгаарлагдахгүй. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэж буй ажил, эд анги, тоног төхөөрөмж, туслах систем, үзүүлэлтийг Инженерийн чиглүүлсэн туршилтын үзүүлэлтийг хангаж, бусдын гүйцэтгэсэн ажил, эд анги, тоног төхөөрөмж, туслах систем эсхүл систем, үзүүлэлтийг давхар хянан баталгаажуулна. Нэгдсэн туршилт нь Гэрээний еренхий нөхцөлийн гүйцэтгэлд хийх туршилт бөгөөд энэхүү шаардлагад заасан туршилтууд, түүний үр дун, үр дагаврыг Гүйцэтгэгч өөрийн гүйцэтгэсэн багц ажлын хүрээнд хариуцна. Нэгдсэн туршилт нь бүх гүйцэтгэгчийн ажлыг дууссанаас хойш хийгдэх ба бүх хэсгийг хамруулсан байдлаар туршилт явагдах тул Гүйцэтгэгч уг туршилтаас зөвхөн өөрийн гүйцэтгэсэн ажилд хамаарах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Зэвсэгт хүчний Жанжин штабын гүйцэтгэсэн төмөр замын доод бүтцийн ажил нь батлагдсан ажлын зураг, нарийвчилсан зураг, бусад шаардлагад нийцсэн, төмөр замын дээд бүтцийн ажлыг хийхэд саадгүй хийгдсэн байна.

Гүйцэтгэгч нь нэгдсэн системийн туршилт болон Гэрээнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хангасан нэгдсэн системийг бүрэн ашиглахад гүйцэтгэх ажлын хүрээ болон Туслан гүйцэтгэгчийн хамтран гүйцэтгэх ажлын шаардлага, журмыг Инженер болон Захиалагчид гаргаж өгнө.

Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчийн хамтран явуулах Нэгдсэн системийн шалгалтад туршилтын явалтыг мөн оруулна.

4.5.2. Давтан туршилт

Хэрэв Ажил эсхүл түүний аль нэг хэсэг нь Нэгдсэн шалгалт болон Ашиглалтад оруулах шалгалтад тэнцээгүй бол Инженер ижил нөхцөлд, ижил журмаар дахин давтахыг шаардана. Хэрэв энэхүү доголдол, дахин шалгалт нь Гүйцэтгэгчийн зөрчлөөс үүдсэн, мөн Захиалагчаас нэмэгдэл зардал гаргах бол, Захиалагчаас Гүйцэтгэгчид төлөх бусад төлбөрөөс ижил үнийн дүнтэй зардлыг хасаж тооцно.

4.5.3. Туршилтын үр дунг хангах

Нэгдсэн шалгалт болон Ашиглалтад оруулах шалгалтын дүнг Инженер, Захиалагч болон Гүйцэтгэгч хамтран нэгтгэж дүгнэнэ.

4.5.4. Туршилтад тэнцэхгүй байх

Хэрэв Ажил, түүний хэсэг, механизмын аль нэг бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж эсхүл эд анги бүрдэл хэсэг, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь Нэгдсэн туршилт болон Ашиглалтад оруулах туршилтад тэнцээгүй, мөн ямар нэг шалтгаанаар уг Ажил, түүний аль нэг хэсэгт запруулга тохируулга хийгээгүй бол Инженер нь Захиалагчийн зөвшөөрлийн дагуу шаардагдах хугацааны дотор Нэгдсэн туршилт болон Ашиглалтад оруулах туршилтын үзүүлэлтийг хангахын тулд хийгдэвэл зохих өөрчлөлт тохируулгыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэх зааварчилгааг өгнө.

4.5.5. Залруулах бусад зүйлс

Гүйцэтгэгч нь Ажил олгогчийн зөвшөөрөлд зориулан залруулах бусад зүйлсийн жагсаалтыг гаргаж өгнө. Энэхүү жагсаалт нь залруулга хийх шаардлагатай доголдлыг тодорхойлон, зардал, гүйцэтгэж дуусгахаар төлөвлөгдсөн огноог тусгасан байна. Доголдлыг залруулах баталгаат хугацаа нь Инженер уг доголдлыг залруулсан тухай баталсан өдрийн дараа өдрөөс эхлэн тооцно.

4.5.6. Туршилтын мэдээлэл

Туршилтын бүх мэдэгдлүүд нь энэхүү баримт бичгийн бусад хэсэгт тодорхойлсон шаардлагын дагуу боловсруулагдаж Инженерт баталгаажуулахаар өгнө.

Гүйцэтгэгчид засвар үйлчилгээг даалгавал, Захиалагчийн хэвийн ашиг орлоготой, хэвийн үйл ажиллагаатай, үр дүнтэй засварын ажиллагаанд Ашиглалтын ажилтан албан хаагч хянагчийг бий болгоход дэмжлэг үзүүлж, зааварчилгаа өгнө.

4.5.7. Хууль зүйн шаардлага

Гүйцэтгэгч бусдын хамт Төмөр замын сүлжээг нээхэд хуулийн дагуу шаардлагатай үзлэг, туршилтыг Инженер, Захиалагчийн хяналтын дор хийлгэж, холбогдох эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авна.

Гүйцэтгэгч доорх Иргэний болон тээврийн тоног төхөөрөмж, системийн үзүүлэлтүүдийг зохих ёсоор хангасныг илэрхийлэх өргөн цар хүрээг хамарсан нэгдсэн шалгалтыг явуулж, үзүүлэлтийг хангана. Үүнд:

- Эрчим хүчиний нэгдсэн систем, нөөц эрчим хүчиний систем
- Барилгын систем

4.5.8 Гүйцэтгэлийг шалгах

Нэгдсэн туршилтыг амжилттай давсны дараа, Захиалагчийн шугамын системийн гүйцэтгэлийн туршилтыг Гүйцэтгэгчийн гаргасан цагийн хуваарийн дагуу зохион байгуулна. Гүйцэтгэгч бүхий л гүйцэтгэлийн туршилтад зөвшөөрөл бүхий инженерийн үйл ажиллагааны системд туслуулах ба, алдаатай оношилгоо болон алдааны залруулгад оролцуулна. Системийг удирдан, ашиглах зөвшөөрөл бүхий инженерүүдийг оролцуулна.

4.6. Туршилтын явалт

Нэгдсэн системийн туршилт болон хүлээлгэн өгөх туршилтад тавигдах шаардлагыг бүрэн хангасны дараа Захиалагч бүх техникийн системийн туршилтын явцад болон Инженер болон бусад албаны ажилтнуудын шаардлагыг хангах зорилгоор туршилтын явцад ажилчдыг сурган, техникийн системийн жигдруүлнэ. Туршилт явалтын үр дүнд Гүйцэтгэгч өөрийн гүйцэтгэсэн ажил (Төмөр замын доод бүтцийн ажил)-ын хүрээнд хамаарах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Өртөөний хязгаарын үнэлгээ 1- туршилтын үед 60% CFD байна. (энэ нь хамгийн багадаа замын 40% нь “ЗГИ”>115 байна.)

Өртөөний хязгаарын үнэлгээ 3-шалгалтын үед 10% CFD байна. (энэ нь хамгийн багадаа замын 90% нь “ЗГИ”>75 байна.)

Өөр өөр зүйл хэсгүүдээс шалтгаалан замын чанарын үзүүлэлт шаардлага хангагүй эсхүл “ЗГИ” үзүүлэлт заагдсан хязгаарт хүрэхгүй тохиолдолд туршилтын явалтын нэг сарын хугацаанд хойшлуулан дахин туршилтын явалтыг зохион байгуулна.

Энэхүү хугацаанд Гүйцэтгэгч өөрийн гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд үзлэг засвар хийх, цаашид техникийн ажилчдыг сургах зэргээр хамтран оролцено.

Туршилтын явалтаар системийн үзүүлэлт гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангасан бол Захиалагч болон Инженер Албан ёсоор хүлээн авсан гэрчилгээнд гарын үсэг зурна. Энэхүү гэрчилгээ нь тус төмөр замыг ашиглалтад оруулах бүрэн эрхийг олгоно.

4.7 Улсын комиссын гэрчилгээ

Барилга байгууламжийн ажлын хүрээнд Гүйцэтгэгч нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол болон Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмын стандартын дагуу Улсын комиссын хяналт шалгалтаар заавал орно. Гүйцэтгэгч, Захиалагч (дор тэмдэглэсний дагуу) Улсын хүлээлгэн авах комисст бүрдүүлэн өгөх материалыг доорх хүснэгтээс харна уу. Баримт бичгүүдийн жагсаалт нь эцсийн байдлаар биш бөгөөд гүйцэтгэлийн явцад өөрчлөгдөж болно. Гүйцэтгэгч тал бэлтгэх баримт бичгээс бусад Гүйцэтгэгч нартай тохиролцож, өөрийн гүйцэтгэсэн ажилд хамаарах, илүү дөхөм баримт бичгийг бүрдүүлнэ. Бүрдүүлэх баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд Инженер нь тухайн баримт бичгүүдийг бэлтгэх Гүйцэтгэгч бэлтгэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.

№	Баримт бичгийн жагсаалт	Бэлтгэх тал
1	Төслийн үндсэн мэдээлэл	Захиалагч
2	Зураг төсөл боловсруулах гэрээ	Захиалагч
3	Зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	Захиалагч
4	Архитектур төлөвлөлтийн даалгавар	Захиалагч
5	Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд	Захиалагч
6	Газар олголтын захирамж	Захиалагч
7	Геодезийн зураглалын ажлын тайлан	Захиалагч
8	Магадлалаар баталгаажуулсан инженер-геологийн судалгааны дүгнэлт	Захиалагч
9	Магадлалаар баталгаажуулсан ажлын зураг төсөл, төсөв	Захиалагч
10	Зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтын хамт	Захиалагч
11	Зохиогчийн хяналт хийх гэрээ	Захиалагч
12	Баталгаажуулалт болон гүйцэтгэлийн зураг	Гүйцэтгэгч
13	Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	Гүйцэтгэгч
14	Захиалагч, гүйцэтгэгчтэй хийсэн гэрээ	Захиалагч
15	Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	Гүйцэтгэгч
16	Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл	Гүйцэтгэгч
17	Барилгын ажлын ил, далд ажлын акт	Гүйцэтгэгч
18	Барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан дүгнэлт	Гүйцэтгэгч
19	Барилга угсралтын ажлын үе шат бүрт хяналт хийсэн тайлан, фото зураг	Гүйцэтгэгч

ЗАХИАЛАГЧ

Бүрд

20	Барилгын материалын гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, лабораторийн дүгнэлт	Гүйцэтгэгч
21	Инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн эсхүл өөрийн эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл	Гүйцэтгэгч
22	Тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан туршилтын баримт бичиг, зааврын дагуу суурилуулахад хийсэн туршилтын дүгнэлт	Гүйцэтгэгч
23	Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт	Захиалагч
24	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт	Захиалагч
25	Бусад холбогдох нэмэлт баримт бичгүүд	Захиалагч, Гүйцэтгэгч

4.8 Сэлбэг эд анги, онцгой багаж болон худалдааны дараах үйлчилгээ

Гүйцэтгэгч нь дараагийн гурван жилийн сэлбэг материал, багаж болон эд ангийн жагсаалтыг санал болгож, Инженерт өгч хянуулан батлуулна. Сэлбэг анги болон Онцгой багажийн жагсаалтад тухайн багаж тоног төхөөрөмжийн бүрэн мэдээллийг бичсэн байна. Мөн жагсаалтад талбайн заагдсан хэсэгт хүргэж өгөх хөлс зэрэг үнэ өртгийг Гүйцэтгэгч тодорхойлно. Сэлбэг эд анги, Онцгой багажийн жагсаалтыг хүлээн авсны дараа Захиалагч Сэлбэг эд анги, Онцгой багажийг хүргүүлэх талаар Гэрээнд өөрчлөлт оруулна.

Гүйцэтгэгч нь худалдааны дараах үйлчилгээнд хүлээх үүрэг нь эцсийн байрлалд /газарт/ суурилуулсан иж бүрдлийн хангарт, тэдгээрийн бүрэн бутэн байдал, сэлбэгийн шуурхай нөхөн сэргээлт, тэдгээрт тогтмол хэвийн үзлэг хийх юм. Энэхүү худалдааны дараах үйлчилгээ үзүүлэх үүрэг нь баталгаат хугацаа дууссан ба эцсийн байдлаар хүлээн авсны дараа бас гэрээнд заасны дагуу З жилийн хугацаанд үргэлжилнэ.

4.9 Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүд

Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүдэд ажлын зураг болон Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн зураг төсөл, барилгын ажилд зориулан боловсруулсан баримт бичгүүд багтана. Эдгээр нь гүйцэтгэлийн зураг төслийн үе шатуудад боловсруулагдсан Зураг төслийн тайлан, Техникийн тооцоо, Барилга угсралтын тайлан гэдэг нь Гүйцэтгэгчийн боловсруулж, үзэглэсэн түр ажлын барилгын үнэн зөв тэмдэглэл юм. Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүд нь Инженерийн "татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл"-ээр шийдвэрлэгдэж, баталгаажна.

Гүйцэтгэгч нь Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүдийг бэлтгэхэд шаардлагатай бүх тэмдэглэлийг хадгална. Захиалагчтай байгуулсан гэрээгээр Гүйцэтгэсэн ажлын зураг болон тэмдэглэлийг Гүйцэтгэгч боловсруулж, өгөх ба энэ нь Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүд болно.

Гүйцэтгэсэн ажлын зураг нь Гүйцэтгэсэн ажлын нөхцөлийг үнэн зөвөөр бүрэн гүйцэд тэмдэглэх зорилгоор шаардлагатай бүх өөрчлөлт шинэчлэлийг харуулсан зургуудыг багтаасан Барилга угсралтын техникийн зургийн эцсийн хувилбар бүрдэл юм. Гүйцэтгэсэн ажлын зураг нь Барилгын зураг төслийн өөрчлөлт, Барилгын зөрүү, мөн цаашдын төмөр зам болон түүний байгууламжийн засвар үйлчилгээ, түүний удирдлагад хамаарах бусад онцлогийг тусгасан байна.

Гүйцэтгэсэн ажлын тэмдэглэлд Захиалагчийн Шаардлага 1.1-ийн 3.12 [сарын тайлан] дахь хэсэгт заасантай нийцэхүйц гэрэл зураг, тэмдэглэлүүд багтана. Гүйцэтгэсэн ажлын тэмдэглэлд геотехникийн судалгаа, бүх үзлэг шалгалтын тайлан, Захиалагчийн

Шаардлагын зураг төсөл, барилга угсралтад хэрэглэгдэх бусад баримт бичиг баримтууд хамаарах ба Гүйцэтгэгч Ажлын барилга угсралтын үнэн зөв тэмдэглэлийг баталгаажуулна.

Гүйцэтгэсэн ажлын баримт бичгүүд нэг хэсэг болгон, Гүйцэтгэгч төслийн санхүүгийн бүрдүүлэлт болон ашиглалтад хүлээлгэн өгөхэд шаардлагатай бүх тэмдэглэлийг хэвээр хадгална. Эдгээр тэмдэглэлийг доорх байдлаар бүрдүүлэх ба, үүгээр хязгаарлагдахгүй:

- Хийгдсэн ажлыг үйл ажиллагаа, байршил, өргтгөөр нь;
- Хэрэглэсэн материалыг төрөл, үйлдвэрлэгчийн нэрийн барааны дугаарын хамт, байршил, үнээр нь;
- Бусад бүх тэмдэглэлийг шаардлагын дагуу Захиалагч /бие даасан хяналтын инженерээр нь.

Ерөнхий нөхцөлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэсэн баримт бичгүүдийн гурван (3) хэвлэмэл хувь, нэг (1) цахим хувийг Инженерт хүлээлгэн өгнө. Нэмэлт нэг ижил цахим хувийг зөвхөн уншиж болох хэлбэрээр CD/DVD-г тохиролцон, Инженерт нэмэлт өртөггүйгээр "Үл татгалзах тухай мэдэгдэл"-ээр олгоно. Гүйцэтгэгч мөн техникийн зураг төслийг бүрдүүлэх бүх эх зураг төслийн бүрэн хуулбарыг электрон байдлаар хүлээлгэн өгнө.

Бүх Гүйцэтгэсэн ажлын зураг болон тэмдэглэлүүд туршилтын ажил эхлэхээс өмнө хүлээлгэн өгөгдсөн байх ёстой. Бүх ашиглалт болон засвар үйлчилгээний заавруудыг Захиалагчийн Шаардлагад тусгагдсан хугацаанд өгөх ба Ажлын засвар, тохиргоо, задаргаа, угсраа болон удирдлага, арчилгааны талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Хүлээн авсан гэрчилгээ олгоход, эдгээр бичиг баримт болон заавруудыг хүлээлгэн өгч, Захиалагч хүлээн авах хүртэл энэхүү Ажлыг дуусгавар болсонд тооцохгүй.

Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн Гүйцэтгэсэн ажлын баримт бичиг, хууль журмын дагуу олгогдсон гэрчилгээ зэрэг Монгол улсын хуулийн дагуу шаардлагдах аливаа баримт бичгийн бүрдлийг Инженерт өгнө.

Ажил гүйцэтгэж дуусахад буюу Инженер болон Захиалагчийн шаардлагаар тохирсон хугацаанд Гүйцэтгэгч бэлэн зургууд болон эцсийн бичиг баримтуудыг бэлдсэн байна.

4.10. Ашиглах болон засварлах заавар

Гүйцэтгэгч бүх иргэний барилга болон төмөр замын ажлын тухай агуулга бүхий ашиглалт ба засвар үйлчилгээний (АБЗҮ) зааврыг боловсруулна. (АБЗҮ) заавар нь ашиглалтын үеийн үзлэг засварын горимыг тодорхойлсон байна. Хэрэглэгдэх (АБЗҮ) зааварт үр дүнтэй засварын ажлыг явуулахад шаардлагдах засварчдын тоо болон ур чадварыг заасан байх ёстой. (АБЗҮ) заавар нь Гүйцэтгэгчийн Гүйцэтгэсэн ажлын бичиг баримтад багтсан байна. (АБЗҮ) заавар нь Инженерт энэхүү гэрээгээр бий болсон бүх төрлийн биет хөрөнгөнд засвар үйлчилгээ явуулах, түүний удирдахад зөвлөмж болгон зохиогдсон байна. (АБЗҮ) заавар батламжлагдах ба, Инженер "Үл татгалзах тухай мэдэгдэл"-г олгоно.

Монголын төмөр замд ашиглагдаж буй хэрэглэж буй хэрэглэж болохуйц иргэний барилга, байгууламж ба замын дээд бүтцийн үйл ажиллагаа болон засварын Код, Зааварт нэмэлт болгон Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу бүтээгдэх төрөл бүрийн биет хөрөнгийн ашиглалт болон засварт зориулан Монголын төмөр замын Код, Заавруудад нэмэлт заалтуудыг тусгасан нэмэлт зааврыг боловсруулна. (хэрэв өөр бол).

Захиалагч үйлдвэрийг зүй ёсоор ашиглах, ээлжит засвар үйлчилгээг гүйцэтгэж байхын тулд Захиалагч болон Инженерт шаардлагатай дизайн ба техник ашиглалтын ойлголт өгөх зорилгоор Гүйцэтгэгч бүх нууцын зэрэглэлтэй мэдээллийг дэлгэх нэн шаардлагатай юм.

Гүйцэтгэгч үр ашигтай ашиглалт болон засвар үйлчилгээнд зориулан бүх нийлүүлэгдсэн байнгын Ажил, үйлдвэр, тоног төхөөрөмж, үйлдвэрлэгдсэн зүйл болон систем, дэд системд зориулан заавар боловсруулна. Үүнд дараах зүйлс орох ба үүгээр хязгаарлагдахгүй байж болно:

1. Систем /дэд системийн гарын авлага-Бүх системийн зарчмын дэлгэрэнгүй тайлбарыг орон зайн диаграммаар үзүүлсэн.
2. Ашиглалтын /хэрэглэгчийн гарын авлага-хэрэгцээт байдлаар аль болох олон дэд хэсгүүдэд хуваан, техникийн бус ажилтанд ойлгомжтойгоор бүх системийн байгууламжийн мэдээллийг хангалттайгаар багтаасан байна.
3. Засвар үйлчилгээ болон үзлэгийн гарын авлага -Урьдчилан төлөвлөгөөт засвар үйлчилгээний үзлэгийн интервал, аргачлал, шаардлагуудыг нарийвчлан тусгасан ба тоног төхөөрөмжийн ажиллах зарчим ба практикийн талаар хангалттай мэдээлэл оруулснаар техникийн ажилтан эвдрэлийг шуурхай оношилж алдааг засах боломжийг олгоно.

Ашиглалтын болон засвар үйлчилгээний заавар доод тал нь дараах зүйлүүдийг агуулсан байна. Үүнд:

- a. Суурилагдсан тоног төхөөрөмж болон систем бүрийн талаар техникийн зааварчилгаа оруулснаар Захиалагчийн ажилчид байгууламж болон цар хүрээний талаар бүрэн ойлголттой болж чадна;
- b. Бүх тоног төхөөрөмжийн эд анги болон системийн агуулга зарчмыг үзүүлсэн диаграммчлагдсан зураг;
- c. Тоног төхөөрөмжийн эд анги болгоны үйлдвэрлэгчийн нэр, хаяг, утас, имайл ба факсийн дугаар;
- d. Томоохон хэмжээний тоног төхөөрөмжид үйлдвэрлэгчийн үзлэг үйлчилгээний гарын авлага байх ба тусгайлан төсөлд зориулан бүрдүүлсэн нарийвчилсан зураг, тайлбар, зам төмрийн хэлхээний нарийвчлал, ашиглалт болон засварын заавар, ашиглалтын хэлбэр, удирдлагын нөөц, дараалал, холболтууд, урьдчилсан засварын программ орсон байна;
- e. Ашиглалтад өгөх үед суурилуулагдсан бүх байнгын ба байнгын бус тоног төхөөрөмжийн тохииргооны хуваарь;
- f. Алдааг олон арга техник, хэрэглэгдэх мэдээллийн сан буюу засвар үйлчилгээний арга зөвлөмж, засварын интервал, засварын багаж;
- g. Төслийн талбай дээр эсвэл үйлдвэрлэгчээс явуулсан холбогдох тоног төхөөрөмжийн бүх туршилтын хариу;
- h. Үйлдвэрлэгчээс санал болгосон амархан гэмтэх элэгдэх боломжтой тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн жагсаалт, хэвийн ажиллах тооцоот хугацаат ба урт хугацааны хүргэлт шаардсан тоног төхөөрөмжийг тусгайлан заана;
- i. Газар шорооны ажил, ус зайлцуулагч зэрэг рүү чиглэсэн байнгын замын тогтмол үзлэг шалгалтын шаардлага;
- j. Замын геометрийн үзлэгийн шаардлагууд;
- k. Үзлэгийн тэмдэглэлийн стандарт хүснэгт;
- l. Томоохон материалын баталгаат засварын гэрчилгээ.

Инженер гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд Ашиглалт болон засвар үйлчилгээний заавар /Хэрэглэгчийн заавар ба Засвар үйлчилгээ болон үзлэгийн зааврын

эмхэтгэл (Техникийн түвшинд ашиглагдахаар бол зохижтой) Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн байна.

Гүйцэтгэгч үйлдвэрийг хүлээн авах туршилтаас өмнө замын бүтцийн засвар үйлчилгээний заавар, Төмөр замын байгууламж, барилгын засвар ба ус зайлцуулах системийн заавраас бусад бүх заавруудыг хянуулахаар өгсөн байх ба харин эдгээр заавруудыг Захиалагчтай зөвшилцэн Зам ашиглах товлосон өдрөөс хойш 6 сараас хэтрэхгүй хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч бүх гарын авлагаас 6 цаасан хувь 1 цахим хувиар хангах ба, төслийн хугацаанд хэрэгтэй газар нь зааврыг шинэчлэн засварлаж байна. Цахим зааврыг агуулгын дижитал хайлт хийж болохоор бэлтгэсэн байна.

Гүйцэтгэгч Доголдол мэдээлэх хугацаанд ашиглалт болон засвар, үйлчилгээний зааврыг шинэчлэн засварлах, хэрэв шаардлагатай бол, ямар нэгэн нэмэлт зардалгүйгээр Инженерт хянуулахаар дахин танилцуулж болно.

ЗАХИАЛАГЧ

Б. Чиратжин

31

ГҮЙЦЭТГЭГЧ

Б. Чиратжин

ХАВСРАЛТ 1

ЗАХИАЛАГЧИЙН ШААРДЛАГА

“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Зэвсэгт Хүчний Жанжин Штаб” нарын хооронд 2022 оны ... дугаар сарын ...-ний өдөр байгуулав.

2. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

ЗАХИАЛАГЧ

Бодлж

32

ГҮЙЦЭТГЭГЧ

Д.Морийн

ГАРЧИГ

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ХАВСРАЛТ №1-2 ХЭСЭГ. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ
2. ТЕХНОЛОГИЙН ЗАМЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
3. ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
4. БУСАД

ЗАХИАЛАГЧ

Бодрум

33

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Доржжавын


1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Захиалагч нь магадлагдсан нарийвчилсан зураг төсөлд үндэслэн санхүүжилтэд суурилсан ажлын даалгавар хүргүүлэх үедээ техникийн шаардлагыг ажлын онцлог, аргачлал, технологи, эрх бүхий этгээдийн магадласан [хэсэгчилсэн болон бүтэн] зураг төсөл зэргээс хамаарч энэхүү техникийн шаардлагын дагуу эсхүл тухай бүр өөрчлөх эсхүл нэмэх байдлаар боловсруулан Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 1.2 Захиалагч нь Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил, ажилбар бүрт зориулсан техникийн шаардлагыг эрх бүхий этгээдийн магадласан зураг төслийн дараа тухай бүр боловсруулан Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 1.3. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх явцад ийнхүү захиалагчаас ирүүлсэн хамгийн сүүлийн техникийн шаардлагыг баримталж ажиллана.
- 1.4. Захиалагч санхүүжилтэд суурилсан ажлын даалгавар ирүүлэхдээ энэхүү гэрээнд заасан техникийн шаардлагыг өөрчилж эсхүл шинээр ирүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэгч нь Монгол улсын хууль тогтоомжид заасан байдлаар технологийн шаардлагыг мөрдөж ажиллана.
- 1.5. Гүйцэтгэгч нь Захиалагчаас ирүүлсэн техникийн шаардлагыг судлан үзээд тухайн техникийн шаардлагын дагуу ажил гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэж санал солилцно.
- 1.6. Захиалагчаас өөрчилж эсхүл нэмж ирүүлсэн техникийн шаардлага нь Гүйцэтгэгчийн өмнө нь гүйцэтгэсэн ажлын үр дүнд нөлөөлөхгүй

2. ТЕХНОЛОГИЙН ЗАМЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн шаардлага нь бүхэлдээ Гэрээний иж бүрдэлд байх бусад бүх баримт бичигтэй харилцан уялдаатайгаар ашиглагдана. Гэрээний иж бүрдэлд орсон баримт бичгүүдийн хооронд ямар нэгэн зөрүүтэй, мөн ойлгомжгүй буюу хоёрдмол утгатай зүйл гарвал тэдгээрийн байгаа дараалал, давуу байдлын эрэмбэтэй уялдуулан тайлбарлах ба хэрэглэнэ. Тухайлбал ажлын зураг ба ТШ-ын хооронд зөрүү байвал ТШ-д заасныг баримтална. Шаардлагатай гэж үзвэл энэ талаарх асуудлыг Гэрээний нөхцөлийн холбогдох заалтын дагуу Инженерт хандан тодруулж болно.

Гүйцэтгэгч нь манай улсад одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүл мэнд, аюулгүй байдал болон төрөл бүрийн татвар хураамж зэрэггэй холбогдолтой хууль, эрх зүйн актууд, орон нутгийн засаг захиргааны тогтоол шийдвэрүүдийг урьдчилан судалж мэдсэн байх ба тэдгээрийг дагаж мөрдөх үүрэгтэй, гэхдээ эдгээрээр хязгаарлагдах ёсгүй.

Гүйцэтгэгч нь ажил явагдах газар орон болон тухайн бүс нутгийн онцлог, цаг агаарын нөхцөл байдалтай сайтар танилцсан байх ба тэдгээрээс урьдчилан харж, анхааралтай авч үзэн тооцоолж болохуйц, технологийн замын ажилд шууд ба шууд бусаар нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, цаашлаад байгаль орчны хамгааллын асуудлыг өөрийн үйл ажиллагаандaa харгалзан ажиллах ёстой.

Энэхүү техникийн шаардлагад лабораторийн шинжилгээ, материалын сонголт түүний чанар, ажлын арга технологи, технологийн замын ажлын хяналтанд хэрэглэгдэх туршилт, шинжилгээнүүд, тэдгээрт тавигдах шаардлагуудыг багтаасан.

Намаг, шавартай газрыг чулуугаар дүүргэх зэрэгт ашиглах чулуун материалыудын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагад заасан аргаар ордыг ашиглахад бэлдэнэ. Технологийн зам барихад ашиглах материалын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагад зааснаар эдгээрийг авах шороон ордыг тогтооно.

Чулууны болон шороон ордуудын байршилаас хэд хэдэн дээжүүдийг экскаватор, геологийн өрмийн машин зэргийг ашиглан авна. Тэсэлгээний ажил эхлэхээс өмнө Инженерынн оролцоотойгоор дээжүүдийг авч битүүмжлэн Итгэмжлэгдсэн лабораторид илгээж, үр дүнг нь баталгаажуулна. Шинжилгээний үр дүнгээс хамааран тухайн чулууг ямар зориулалтаар хэрэглэхийг шийднэ.

Зураг төслийн материалын тайланда дурдсан ямар ч чулуун орд, шороон ордын аль ч материалын чанар болон тэдгээрийн тохиромжтой эсэх талаар Захиалагч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэ бүлэгт технологийн зам барих болон ухалтын ажил багтах ба эдгээр нь хажуугийн шуудуу, технологийн замд асгаасан чулуун дүүргэвчтэй материалыг асгах, тэгшлэх, нягтуулах ажлууд багтана.

ХАМААРАЛ

Энэхүү техникийн шаардлага нь “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлж буй 144,9км урттай Богдан төмөр замын трассын дагуу баригдах технологийн замын ажилд зөвхөн хамаарна. Технологийн замын трассын эхлэл, төгсгөлийн цэгүүд болон ерөнхий мэдээллүүд нь “Урбан девелопмент консалтинг групп” компаний боловсруулсан “Инженерын нарийвчилсан тайлан”-д дэлгэрэнгүй байдлаар тусгагдсан болно.

Энэхүү техникийн шаардлагад технологийн замын газар шорооны ажлын материалын ангилал, ерөнхий ажил болон талбайн цэвэрлэгээ, тохиromжгүй материал зайлцуулалт, тэдгээрийн ажлын гүйцэтгэлд тавигдах шаардлага, чанарын хяналтын шаардлагыг тус тус тусгав. Ажил эхлэхээс өмнө эдгээрийн талаар Инженерын нарийвчилсан зааварчилгааг авна.

Гэрээнд хамрагдах гол нэр төрлийн ажлууд:

- 1) Талбайн цэвэрлэгээ хийх
- 2) Замд хэрэглэх орон нутгийн материалын хайгуул, судалгаа хийх
- 3) Материал олборлолт явуулах, ордуудыг нөхөн сэргээх
- 4) Технологийн зам барих, арчлах
- 5) Замын тэмдэг суурилуулах
- 6) Мэдээлэх самбар байрлуулах
- 7) Төрөл бүрийн хамгаалах байгууламж хийх
- 8) Технологийн замын ажил дууссан үед эцсийн гүйцэтгэлийн зургийг боловсруулж батлуулах зэрэг бөгөөд гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй.

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

Тухайн объектын зураг төслийн баримт бичгүүдийг Захиалагчаас гэрээнд заасны дагуу Инженер ба Гүйцэтгэгчид хангана. Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, мөн тэдгээр зурганд хийсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу технологийн замын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Технологийн замын ажлыг зохих хэмжээнд гүйцэтгэхийн тулд Инженерын томилсон төлөөлөгчийн тухай бүрт өгөх зааврын дагуу зургуудыг өөрчлөх болон нэмэх байдлаар засварлаж болно. Гүйцэтгэгч нь тэдгээр зурганд орсон өөрчлөлт, нэмэлт зэргийг үндэслэн ажлын зургийг боловсруулан батлуулж, түүний дагуу барилгын ажлыг гүйцэтгэнэ. Ажлын зурагт орсон өөрчлөлт нь чанарыг муутгасан болон зураг төсөл зохиогч ба Инженерын зохих зөвшөөрлийг авалгүйгээр ажил гүйцэтгэж болохгүй.

БАРИМТ БИЧГИЙГ ХАДГАЛАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

Технологийн замын барилгын ажилтай холбогдолтой аливаа баримт бичгийг хадгалах үүргийг Гүйцэтгэгч хүлээх бөгөөд тухайн замын гэрээ, түүний иж бүрдэл баримт бичгүүд, зураг төсөл, техникийн баримт материал, стандарт зэргийн хувийг талбай дээр зохих тоогоор байлгаж байх ёстой. Гэрээ дууссаны дараа Гүйцэтгэгч нь эдгээр баримт бичгийг гэрээнд заасан тоогоор, тус туын чиглэлээр нь Инженер, Захиалагч, улсын архив болон бусад шаардлагатай газарт хүлээлгэн өгнө.

Хэрэв замын зураг төсөл, эсвэл түүнтэй холбогдолтой зааварчилгааг Инженерын зүгээс боломжийн хугацаанд өгөөгүйгээс болж барилгын ажил саатахад хүрэхээр байгаа, эсвэл saat албан ёсоор мэдэгдэнэ.

АЖЛЫН ДАРААЛАЛ

Ерөнхийдөө, гүйцэтгэгч нь замыг нэг төгсгөлөөс нь (Инженерээс зааварчилсан буюу тохиролцсон тохиолдолд замын хэсгийг) эхэлж, дунд нь тасархай хэсэг орхилгүйгээр нөгөө төгсгөл рүү чиглэсэн байдлаар үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгчээс танилцуулж, Инженерын баталсан ажлын төлөвлөгөөнд (шинэчилсэн ажлын төлөвлөгөөг оролцуулаад) хэсгийн урт ба ажлын бүрэлдэхүүн бүрээр харуулсан хийгдэх ажлын дарааллыг тусгасан байна.

ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

Талбайн цэвэрлэгээ гэдэг нь тохиромжгүй материалыг хуулж цэвэрлэх, хашлага хаалтыг буулгах зайлцуулах, бут, сөөг, үндэс, хожуул, зулзаган мод, бул чулуу зэргийг булгалах, сугалах, цэвэрлэж, зайлцуулах, тэдгээрийг булгалж сугалахад үссэн нүхнүүдийг буцаан дүүргэж, засах зэрэг ажлууд орно.

Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлцуулах явцад Гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ажиллана. Зурагт үзүүлсэн эсвэл Инженерын зааварласан газруудад талбайн цэвэрлэгээг хийнэ. Гүйцэтгэгч шороон ба чулууны орд газар, материал нөөцлөх талбай ба хаягдал зайлцуулах газар болон бусад ажлын талбайд Инженерын заавраар талбайн цэвэрлэгээг хийнэ. Дээр дурдсан газрууд нь төлбөрт хамарагдахгүй.

Инженер талбайн цэвэрлэгээний явцад буулгаж, зайлцуулж болохгүй тусгай мод, хожуул эсвэл обьектуудийн талаар зааварлана. Гүйцэтгэгч талбайн цэвэрлэгээний явцад нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй байх шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ба хэрэв өмч хөрөнгө, Инженерын шугам сүлжээнд ямар нэгэн гэмтэл учруулбал Гүйцэтгэгч нь гарсан хохирлыг бүрэн засах хариуцлагыг хүлээнэ.

Өнгөн хөрсийг зурагт заасан ба Инженерын зааварчилсан гүнд хуулж, зайлцуулах ажил талбайн цэвэрлэгээнд багтана. Талбайн цэвэрлэгээ хийгдэх хэсгүүдэд өнгөн хөрсийг зурагт заасан буюу Инженерын зааварчилсан гүнд Гүйцэтгэгч хуулж зайлцуулна. Хэрэв Гүйцэтгэгч заагдсан гүнээс илүү гүн хөрсийг хуулбал өөрийн өргөөр заагдсан хэмжээнд хүртэл дүүргэж нягтуулна.

Инженерын заавраар талбайн цэвэрлэгээг хийсэн бол цэвэрлэж зайлцуулсан бүх материал нь модноос бусад цэвэрлэгээнд хамаарна. Нийтийн болон хувийн өмчид хохирол учруулах буюу хүрээлэн буй орчинд хамаарах шаардлагыг зөрчихгүйгээр гүйцэтгэгч нь хаягдал материалыг зайлцуулах буюу хаяна. Техникийн шаардлагад заасны дагуу хаягдал

зайлуулах цэгийг тогтооно. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан талбайг цэвэрлэх ажлыг хийсний дараа гол ажил эхлэхээс өмнө зүлэг дахин ургавал нэмэлт талбайн цэвэрлэгээг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч зураг болон Инженерын зааварчилгааны дагуу барилга, байшин, суурь, хуучин төмөрбетон хоолой, хашаа болон хиймэл байгууламж болон хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн буулгах, нураан зайлуулах ажлыг хийнэ. Инженерын шийдвэрийн дагуу дахин ашиглах боломжгүй бүх төрлийн материалыг Гүйцэтгэгч талбайгаас зайлуулан энэхүү Техникийн шаардлагад заасны дагуу хаягдал зайлуулах цэгт аваачиж буулгана.

Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагад заасны дагуу одоогийн байгаа чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газрууд болон тэдэнд хүрэх туслах замуудыг цэвэрлэнэ.

Инженерын эвдлэлгүй орхихыг зааварласан ямар нэгэн жим зөрөг, хашаа, хана, хашилт, мод, бут, зүлэг ба бусад зүйл зэргийг ажил гүйцэтгэж байх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс болж ямар нэг хохирол учирвал сэргээн засварлах ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Инженер заавраар зайлуулж буюу хөдөлгөж үл болох хашилт, мод,

малын хашаа болон бусад зүйлсийг энэхүү техникийн шаардлагад заасан нөхцөлийн дагуу хамгаална. Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудын болон тэдэнд хүрэх түр замуудын өнгөн хөрсийг хуулах ба шаардлагатай үед чулуун болон шороон ордод тохиromжтой материалын үе гарч ирэх хүртэл хөрсний дээд хэсгийг ухаж авч зайлуулна. Өнгөн хөрсийг дангаар нь хуулж зайлуулах, эсвэл тохиromжтой материалын үе хүртэлх давхаргатай хамт хуулах эсэхийг Инженер зааварчилна. Түүнчлэн Инженер өнгөн хөрснөөс доош тохиromжтой материалын үе хүртэлх давхарга нь шаардлага хангана гэж үзсэн бол зам барилгын ажилд ашиглах талаар зөвлөж болно.

Технологийн замын ургамлын үе бүхий өнгөн хөрсийг замын захаас дотогш тэнхлэгруү нуруулдана. Нуруулсан хөрсийг /тохиromжгүй материал/ карьерын нөхөн сэргээлт хийх ажилд зориулан карьерын өнгөн хөрсний овоолгонд нөөцлөнө.

Хуулсан өнгөн хөрсийг 1 м-ээс илүүгүй өндөртэйгээр талбайд буулгана. Борооны усыг шингээн барих, гадаргын ус урсахаас хамгаалах зорилгоор өнгөн хөрсийг шатлан овоолно. Гүйцэтгэгч, салхинд өнгөн хөрсийг хийсгэж алдахгүйн тулд, мөн ургамалжилтыг сэргээх зорилгоор өнгөн хөрсний овоолгыг шаардлагатай бол усалж байна. Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар тус бүрт ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн өнгөн хөрс ба тохиromжтой материалын үе хүртэлх давхарга үеийн тухайн газруудад нь тарааж хаялгүй, ойролцоо хонхор хотгор газруудад зөөж аваачин тэгшилнэ. Өнгөн хөрсийг дангаар нь овоолсон тохиолдолд түүнийг нөөцөлж байгаад газраа зассаныхаа дараа тараана.

ИНЖЕНЕРТ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

Гүйцэтгэгч аливаа санал, асуудал, зураг, мэдээлэл, материал, шинжилгээний хариу, Гэрээний хэрэгжилттэй уялдан гарч буй бусад бичиг баримтуудыг Инженерт танилцуулах. Шаардлагатай болвол Инженер танилцуулсан зүйлсийг судалж үзэн, тохиромжтой бол, Гэрээний нөхцлүүдийн холбогдох заалтын дагуу Гүйцэтгэгчид хариуг өгнө. Инженерээс зөвшөөрөл авах шаардлагатай бичиг баримтуудыг, Гэрээний нөхцлүүдийн холбогдох зүйл, техникийн шаардлагын заалтууд, эсвэл Инженертэй харилцан зөвшилцөх шаардлагатай батлагдсан ажлын хөтөлбөрийг харгалзан, тэдгээр бичиг баримт бүрийг судалж үзэх боломжийн хугацааг Инженерт олгох зэрэг шалтгаанаар, хариу өгөх өдрөөс хангалттай хугацааны өмнө Инженерт танилцуулна.

BS 5775-д заасны дагуу бүх тооцоо, техникийн мэдээллүүд Си системийн нэгжээр илэрхийлэгдэнэ. Инженераас өөрөөр зааварласан буюу зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд бүх зурагны гадны хүрээ хүртэлх хэмжээ А3 хэмжээтэй байна. Зургийн тайлбарууд монгол хэл дээр хийгдсэн байна. Бүх хэмжээсүүд нь метр буюу миллиметрээр, бүх хүндийн жинг SI нэгжээр илэрхийлсэн байна.

Гүйцэтгэгч, зурагны хүрээ, дугаарлалт, нэр зэргийн талаар зөвшөөрөл авах зорилгоор ноорог зургийг Инженерт танилцуулна. Дараагийн бүх зургуудыг энэхүү зөвшөөрөгдсөн загварын дагуу Инженерт танилцуулна. Бүх зургийн доод талд гэрээний нэр ба зургийн тухайлсан нэрийг бичсэн байна. Бүх зургуудыг тус тусад нь дугаарлаж, хэрэглэсэн масштаб, танилцуулсан өдөр зэргийг тэмдэглэнэ. Мөн зурганд хийсэн нэмэлт өөрчлөлтүүдийг тэмдэглэж, өдрийг нь тавьсан байна. Аливаа танилцуулсан зүйлийг баталж, зөвшөөрөх нь Гүйцэтгэгчийг Гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Технологийн замын ажлыг гүйцэтгэхдээ гэрээний нөхцөлд заасан төмөр замын доод бүтцийн ажлын хөтөлбөр төлөвлөгөөтэй нягт уялдуулан, ажлын харилцан хамаарал, саад бэрхшээл зэргийг тооцон төлөвлөж захиалагчид танилцуулна. Технологийн замыг барих ажлын төлөвлөгөөний хугацааны нэгж нь 1 өдөр байна. Гүйцэтгэгч, технологийн замын ажлын төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд Инженерын заасан хугацаанд шинэчилнэ. Инженерын шаардлагад нийцэх хэмжээнд төлөвлөгөөгөө шинэчлэн засварлаж танилцуулна.

АЖЛЫН АРГАЧЛАЛ

Гүйцэтгэгч, гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авсанаас хойш хуанлын 7 хоногийн дотор төлөвлөж буй зохион байгуулалтын арга хэмжээ ба технологийн замын ажлыг хийж гүйцэтгэх аргачлалаа Инженерт танилцуулна. Аргачлал нь дараахи зүйлсийг агуулсан байх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Орд газрын ашиглалт
- Шороон ордын ашиглалт, усан хангамжийн ашиглалт, тэдгээрт хүрэх түр замууд.

- Түр замыг барих, байнгын усан арчлалт хийж, тоос шороо босохоор сэргийлэх
- Гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянах

Ажлыг гүйцэтгэх явцдаа Гүйцэтгэгч, дээр дурдсан зүйлсийн дагуу бэлтгэж танилцуулсан зохион байгуулалт, аргачлалдаа аливаа нэмэлт өөрчлөлт оруулахаар бол тэдгээрийг хэрэгжүүлэхээс өмнө Инженер /хяналтын Инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/-д дэлгэрэнгүй байдлаар нарийвчлантанилцуулна.

ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах эрхтэй бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг хангахад шаардлагатай бүх урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд Монгол улсад буюу тухайн орон нутагтмөрдөгддөг хууль тогтоомжийн шаардлагуудаас гадна, Инженерын бодлоор ажлын талбайд зөвшөөрөлгүй орсон гадны хүмүүс, мөн Гүйцэтгэгчийн хяналтын дор хийгдэж буй аливаа үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийг хамгаалах зэрэгт мөрдөх шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээнүүд орно.

a) Инженерын зөвшөөрлөөр, шөнийн ээлжинд хийж гүйцэтгэх ажлын аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс хангалттай хэмжээний гэрэлтүүлэг болон цахилгаан тасарсан үед ажиллуулах нөөц /аваарын/ гэрэлтүүлгийн төхөөрөмжөөр хангана.

a) Хяналтын Инженерүүд, талбайн ажилтан, ажиллагсад болон ямар нэг байдлаар ажилтай холбогдон ажлын талбайд орж ирж буй бүх хүмүүсийн ажлын талбайд ажиллах үеийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад шаардагдах хамгаалалтын хувцас, аюулгүй ажиллагааны багаж төхөөрөмжөөр хангаж, энэ талаар мэргэшсэн хүний ажиллуулан, үүнтэй холбоотой мэдээлэл, зааварчилгааг өгч, сургалт зохион байгуулах, хяналт тавих ажлуудыг Монгол улсад мөрдөгдж буй хууль тогтоомжийн дагуу хийнэ.

b) Эдгээр аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэлд дараах зүйлс багтах ба гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- малгай каск
- хамгаалалтын гутал
- нүдний хамгаалалтын шил, гагнуурын нүдний шил
- чихний хаалт
- хамгаалалтын тоноглол
- гэрэл ойлгогч хантааз
- аврах хэрэгсэл
- гал унтараах багаж хэрэгсэл гэх мэт
- c) Талбайд ажиллах бүх хүмүүс хамгаалалтын малгай гутал өмсөнө.

d) Талбайн бүх газрууд руу ямар нэг аюул, эрсдэл буюу бэртэл гэмтэлгүйгээр хүрч очих түр зам барьж тогтмол засвар арчлалт хийж байна.

e) Гэмтэж бэртсэн хүнийг хамгийн ойр эмнэлэгт хүргэж өгөх тохиromжтой тээврийн хэрэгсэлийг хангаж, байнгын бэлэн байдалд байлгана.

f) Гүйцэтгэгч, ажил дууссаны дараа өөрийн зардлаар Инженерын тавьсан шаардлагын хэмжээнд бүх түр байгууламжуудыг буулган, хог хаягдлыг шатаан, бохирын сав болон нүх, жалгыг буцааж булан, сайтар хааж, гаднах талбайг бүхэлд нь цэвэр цэмцгэр болгоно.

g) Ажил явагдаж буй газарт хангалттай тооны бие засах газар ба бусад ариун цэврийн байгууламжуудыг барьж байгуулан тэдгээрийг Инженерын болон тухайн орон нутгийн нийтийн эрүүл мэндийн эсуудал эрхлэх албаны тавьсан

شاардлагыг хангах хэмжээнд, эрүүл ахуйн нөхцлийн дагуу тогтмол цэвэрлэж, ариутгаж байна.

h) Олон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан удирдах хүмүүстэй харилцан зөвлөлдөж, ажлын талбай, ажилчдын байр, түр суурин доторхи шумуул, ялаа, хортон шавьж, амьтан зэргийг устгах шаардагатай арга хэмжээг авна.

i) Хүний амь хохирсон буюу хүнд гэмтсэн, улмаар үүнээс болж эмнэлэгт хүргэгдэж гурваас дээш хоногоор хэвтсэн тохиолдолд Инженерт яаралтай мэдэгдэнэ. Эхний үед ийм мэдээллийг амаар хүргэж болох ба болсон явдлын дараа 24 цагийн дотор Гүйцэтгэгч дэлгэрэнгүй тайланг бичгээр бэлтгэж танилцуулна. Иймэрхүү ноцтой аваар ослын талаар хуулийн байгууллагад мэдэгдэхтэй холбоотой аливаа шаардлагыг Гүйцэтгэгч дагаж мөрднө.

j) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал болон эд хөрөнгийн эвдрэл гэмтэлтэй холбоотой аливаа бусад аваар осол, үйл явдлыг Гүйцэтгэгч бүртгэх ба аваар осол гарсан даруйд зохих маягтын дагуу бэлтгэсэн мэдээллийг Инженер-т болон хуулийн байгууллагуудад танилцуулна.

Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газруудад хүрэх түр замууд болон барилгын явцад нийтийн хөдөлгөөнийг саадгүй явуулах замыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр барьж, засварлана. Түр шороон замаас бусад газраар дур мэдэн давхих, тээвэр хийх зэргээр байгаль орчин сүйтгэхийг хатуу хориглоно.

Төслийн замд ойр оршдог, хөдөлгөөн нэвтэрч буй түр замуудад (үүнд салаалсан замууд бас хамаарч болно) тээврийн хэрэгсэлүүд тэгш тал газарт 60 км/цаг, харин уулархаг газарт дор хаяж 40 км/цаг хурдтай явах нөхцөлийг хангаж, барилгын ажлын үргэлжлэх явцад ч байнга засварлаж арчилна. Барилгын ажлын явцад тухайн газар орны онцлогоос (өндөр уул, усаар хашигдсан, барилга байгууламж ойрхон гэх мэт) шалтгаалснаас хөдөлгөөнийг түр замаар өнгөрүүлэх боломжгүй тохиолдолд зайлшгүй байдлыг харгалzan, ажилд эвдрэл, хохирол учруулахгүй байх нөхцлийг хангаж, барилгын ажил явагдаж буй

талбай дундуур буюу дээгүүр замын хөдөлгөөнийг нэвтрүүлэн өнгөрүүлэхийг Инженерээс зөвшөөрч болно.

Ажил явагдаж буй газруудтай ойр байгаа замуудын дагуу түр тэмдэг, хаалт байрлуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах ба өөрийн тээврийн хэрэгслүүд болон хүнд механизмын хөдөлгөөний нөлөөллөөс хамгаална.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ

Барилгын ажлын үед замын дагуух гол, горхи зэрэг усны эх үүсвэрүүд зарим тохиолдолд хөндөгдж магадгүй. Баригдаж буй замын дагуу байгаа гол горхийг эргийн хамгаалалт хийх буюу бусад зөвшөөрөгдсөн аргыг ашиглан хамгаална. Гүйцэтгэгч нь Инженерын ба орон нутгийн удирдах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр гол горхи буюу, гүний худагнуудаас ус авч болно. Гүйцэтгэгч Монгол улсын гадаргын усны чанарын хяналтын стандартын дагуу шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд ингэснээр барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан усны чанарт өөрчлөлт гарахгүй байх боломжтой.

Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газарт үйл ажиллагаа явуулахдаа эрүүл мэнд, ахуйн болон аюулгүй байдлын талаарх орон нутгийн засаг захиргааны дүрэм журмыг мөрдөж ажиллана. Тийм дүрэм, журам байхгүй тохиолдолд, эсвэл тэдгээр дүрэм журмаас гадна дараах нөхцөлийг хангаж ажиллана:

- (а) Ажил явагдаж байгаа бүх газрын усыг байнга зайлцуулж хуурай байлгана. Хэрэв чулуун ба шороон ордын ухагдсан газарт ус гарч тэр нь өөрөө хатахааргүй байгаа бол ажил явагдаж байх хугацаанд усыг байнга соруулж зайлцуулж байна. Тиймэрхүү хонхор газрыг ажил дууссаны дараа Инженерын заавраар мал услах усан сан болгон үлдээж болно. Энэ тохиолдолд эргийн налууг 1:6-аас алгуур болгон засаж, мал ороход тохиромжтой болгоно.
- (б) Зам барилгын ажилд шаардагдах дээрх газрууд нь усны эх бүхий газар, хот, суурины дотор буюу тэдэнтэй ойр зэргэлдээ оршиж болохгүй.
- (в) Газрууд нь доор дурдсан хил хязгаарын дотор байж болохгүй.

Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар,
- Дархан цаазтай газар,
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар,
- Хамгаалалттай ойн бүс,
- Усны эх, усан хангамжийн бүс,

Хаягдал зайлцуулах газар нь гол горхи, суваг шуудуу, усны урсац, усны эх, нуур зэрэг усны нөөцийг боож, бохирдуулахгүй байх ёстой. Гүйцэтгэгч нь олгосон газарт ажлын

талбарынхаа хил хязгаарыг тогтоож, Инженерын зааврын дагуу хашаа хамгаалалт барьж тусгаарлан, үйл ажиллагаагаа зөвхөн тэр хил хязгаарын дотор бие даан явуулна.

(г) Мөргөцгийн өндөр 1м-ээс илүү болсон газарт, мөргөцөг рүү хүн, мөн мал орохоос хамгаалсан түр зуурын хайс, хашааг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж тавина.

(д) Ажил дуусахад бүх мөргөцгүүдийг нурааж, 1:6-аас багагүй налуу болгож сайтар тэгшлэн засна.

(е) Ажил дуусахад бүх хайс, хашаа болон түр хугацааны бусад байгууламжуудыг буулгаж, зөөн, жорлонгийн нүхийг булж, өнгөн хөрсийг тарааж тэгшлэн усалж, талбайг цэвэрхэн болгож үлдээнэ.

(ё) Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллана. Үүнд хөрсний болон гадаргын усанд тос, эрдэжксэн ус оруулахгүй байх ба гэхдээ энэ чиглэлийн арга хэмжээ нь зөвхөн эдгээрээр хязгаарлагдах ёсгүй бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг дагаж мөрдөнө.

(ж) Ажил дуусахад бүх чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудыг нөхөн сэргээж хүрээлэн буй орчны харагдах байдлыг сайжруулаад зогсохгүй хүн, малд саад болохооргүй байдлаар хуучин төрхийг сэргээнэ. Налуу жигд байх бөгөөд түүнийг өнгөн хөрсөөр хучиж, ургамалжилтыг тэтгэх зорилгоор байнга усалж байна. Газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай бүхий л зүйлийг хийж гүйцэтгэнэ.

СТАНДАРТ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Дор дурдсан стандартууд, норм болон бусад материалуудад хамгийн сүүлд оруулсан өөрчлөлт, шинэчилсэн хэвлэлүүд нь техникийн шаардлагын энэхүү хэсэгт дурдагдах ба эдгээртэй холбоотойгоор ашиглагдана. Үүнд:

Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорхи товчилсон үгсийг ашиглав:

MNS Монголын үндэсний стандарт

AASHTO Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)

ASTM Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг

BS Британы стандарт

ISO Олон улсын стандартчиллын байгууллага

Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагад дурдсан Стандарт техникийн шаардлагууд болон бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувь иж бүрэн багцыг Инженерын талбайн ажлын байранд хангаж өгнө. Мөн тэдгээр стандарт техникийн шаардлагууд болон тэдгээртэй адил төстэй бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувилж бүрэн багцыг Гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан талбай дахь ажлын байрандаа хадгалж ашиглана.

Энэ техникийн шаардлагын заасан Инженерын явуулах чанарын баталгааны туршилтын дагуу, бүх газар шорооны ажлууд нь барилгын чанарын туршилтанд хамрагдана. Гүйцэтгэгч ажлынхаа дэс дарааллын дагуу ийм хяналтын туршилтыг явуулах хугацааг ажлын төлөвлөгөө болон тендертээ тооцсон байх ёстай.

Гүйцэтгэгч нь технологийн замын ажлын хэсэг бүрийг барих ажлуудад Инженерын зөвшөөрлийг авах хүсэлтийг гаргана. Ийм хүсэлтэд Гүйцэтгэгчийн шинжилгээний дүнгийн хувиудыг хавсаргана. Үүний дараа Инженер тухайн хэсэгт нүдэнд ил ус тогтсон, давхраатсан, материал овойж гарсан /тэгшилсэн хэсэгт ил үзэгдэх/ эсэх, чулууны ялгарал, том хэмжээтэй материал байгаа эсэх, холилт ба нягтуулалт нь нэгэн жигд эсэхийг шалгана. Нүдээр үзэж шалгасан шалгалт нь хангалттай гэж үзсэн тохиолдолд Инженер баталгаа гаргах замын хэсгийг багаж, төхөөрөмжөөр шалгана. Эдгээр шалгалтын үр дүнг Инженер гүйцэтгэгчид бичгээр мэдээлэх ба үүний зэрэгцээ тухайн үе болон хэсгийг хүлээн авах буюу татгалзах шийдвэрээ гаргана.

Гүйцэтгэгч нь батлуулахаар мэдүүлсэн ажлын талбай, гадаргуугийн байдлыг хамгаалах, хадгалах хариуцлагыг бүрэн хүлээнэ. Хэрвээ Инженер шаардвал, энэ үе дээр хяналтын тэгшилгээ, барилгын хяналтын туршилт, зөвшөөрөгдөх алдааны шалгалтыг энэхүү техникийн шаардлагын дагуу явуулна. Технологийн замын аль нэг хэсгийг Инженер баталгаажуулсан боловч, Гүйцэтгэгч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хур тунадас болон бусад шалтгаанаар үүссэн эвдрэлийг засах хариуцлагыг бүрэн хүлээнэ.

Технологийн замын ажилд хэрэглэгдэх бүх материал нь энэ шаардлагуудад нийцсэн байх бөгөөд Инженерын шаардлагын дагуу байх ёстай. Ажилд хэрэглэхээр төлөвлөсөн бүх материалын дээжийг лабораторид өгч туршиж шинжлэн, шинжилгээний дүнг баталгаажуулнаар материалыг талбайд нийтэд нь татан авчрах зөвшөөрлийг Инженерээс авна. Хэрвээ энэ шаардлагын дагуу зарим материалыг гадны хараат бус лабораторид шинжлүүлэн баталгаажуулах шаардлагатай бол Гүйцэтгэгч нь үүнээс гарах бүх зардлыг хариуцах бөгөөд зардалд дараах зүйлүүд багтана /гэвч эдгээрээр хязгаарлагдахгүй/. Үүнд:

- Лабораторийн шинжилгээний хөлс
- Дээжээр хангах
- Дээжийг талбайгаас лаборатори руу, шаардлагатай бол буцааж талбай руу тээвэрлэх
- Лабораторийн ажилтнуудын хөлс

Хараат бус лабораторид хийгдэх шинжилгээний төлөвлөгөөг Инженертнэг долоо хоногийн өмнө мэдээлэх ба тэрээр шинжилгээ хийх цагт, газар дээр нь байлцах эрхтэй.

МАТЕРИАЛ БА ТЭДГЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Ажилд хэрэглэгдэх материалыуд нь энэхүү техникийн шаардлагын нөхцлүүдийг хангана. Хэрвээ Гүйцэтгэгч, өөр хувилбар техникийн шаардлагын дагуу ижил буюу илүү өндөр стандартын материал хангахыг илүүд үзвэл, санал болгож буй хувилбарыг техникийн шаардлагын хуулбар хувь болон санал болгосон материалын техникийн иж бүрэн шаардлагын хамт Инженерт хургуулна.

Эдгээр материалуудыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар Инженерын зөвшөөрсөн лабораторт шинжилж, баталгаажуулна. Энэхүү техникийн шаардлагын дагуу ажилд хэрэглэх материалыг олох, нөөцийг тогтоох, хангах, тээвэрлэх, хадгалах зэрэг ажлыг Гүйцэтгэгч дангаараа хариуцна.

Хэрвээ байнгын ажилд ашиглахаар төлөвлөсөн буюу эсвэл аль хэдийн ашиглагдаж буй бараа, материал нь холбогдох техникийн шаардлагыг хангахгүй байна гэж Инженер Инженер/ үзвэл, тэдгээр бараа материалыг хэрэглэхийг хэдийд ч хүчингүй болгох эрхтэй бөгөөд зөвшөөрөгдөх чанар бүхий бараа материалаар солих зааварчилгаа өгнө. Үүний үр дүнд гарах нэмэлт зардал болон чанаргүй хийгдсэн ажлын зардлыг, солих шаардлагатай бараа материал авах бүх зардлын хамт Гүйцэтгэгч гаргана.

Инженер нь олборлох материалын төрөл, талбай, гүн зэргийг Гүйцэтгэгчид зааварчилна. Зохистой ширхэглэлийг хангахын тулд Гүйцэтгэгч байгалиас олборлосон материалыудыг бульдозер, автогрейдер, ачиж ба экскаватор зэрэг тохиромжтой машин техникийг ашиглан холих шаардлага гарч болно. Эдгээр материалыг сайн хольж нэгэн жигд хольц болгоод ажилд ашиглахаас хамгийн багадаа 7 хоногийн өмнө нөөц материал хадгалах талбайд овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь том хэмжээтэй буюу шавар, хар шороон хөрс болон бусад чанар муутай, барилгын ажилд хор нөлөөтэй, тохиромжгүй материалыудыг ажилд ашиглах тохиромжтой материалыдаас тусгаарласан байх ёстой. Дээрх тохиромжгүй материалыудыг хаягдал зайлцуулах газар руу зөөж буулгана. Шороон орд бүрт материалыг төрөл, ширхэглэл тус бүрээр нь ялгаж нөөцөлнө.

Материал нөөцлөх газраас материалыг авахдаа уланд нь байгаа материалтай хольж болохгүй бөгөөд ёроолын үеийг 100мм орчим зузаантай үлдээнэ. Хэрэв нөөц материал нь шаардлагатай хэмжээнээс илүү гарсан бол Инженер өөрөөр зааварчлаагүй тохиолдолд Гүйцэтгэгч түүнийг чулуун болон шороон ордын дотор талбайд тараана.

Технологийн замын ажилд хэрэглэгдэх, шороон ордоос олборлосон материалд тавигдах шаардлага нь Гүйцэтгэгчийн бусад ажлуудад хамааралтай шаардлагаас давуу байдлаар ашиглагдана.

A. Лабораторийн шинжилгээ

Технологийн замын ажилд ашиглах байгалийн гаралтай ба боловсруулсан материалын лабораторийн туршилт шинжилгээг Гүйцэтгэгч нь Инженертэй зөвлөлдөж гүйцэтгэнэ. Материалын стандартад тодорхойлсон эцсийн бүтээгдэхүүнд тавих шаардлага болон барилгын ажилд хяналт тавих зорилгоор газар дээр нь хялбар тодорхойлж болох материалын шинж чанарын хоорондын харилцан уялдааг бий болгохын тулд ийм туршилтуудыг хийдэг.

Лабораторийн туршилтыг хольц ба байгалийн гаралтай материал дээр хийж гүйцэтгэх ба үүн дээр тулгуурлан Гүйцэтгэгчийн урьдчилан төлөвлөсөн материалыг газар дээр нь туршихаас хоёр долоо хоногийн өмнө урьдчилсан төлөвлөгөөгөө Инженерттанилцуулна.

(a) Материалын дээж авах

Багр

Б. Маргалт

□ Материалын дээжийг тухайн замын ажил гүйцэтгэгч байгууллагын материалын Инженер, байнгын техник технологийн хяналт гүйцэтгэж байгаа материалын Инженер хамтран авна.

□ Ажил гүйцэтгэгч байгууллагын материалын Инженер, байнгын техник технологийн хяналт гүйцэтгэж байгаа материалын Инженерууд нь хүндэтгэх шалтгаанаар ажиллаагүй тохиолдолд дээжийг гүйцэтгэгч байгууллагын ерөнхий Инженер болон хяналтын багийн ахлагч хамтран авна.

□ Дээжний дагалдах хуудсанд дээж авсан орд газрын нэр, дээжийг авсан хүний нэр албан тушаал мөн он сар өдрийг бичиж тэмдэглэсэн байна.

(б) Хөрсний шинжилгээнд хэрэглэгдэх стандарт аргууд

Дээж авах, бэлтгэх, савлах, тээвэрлэх, хадгалахдаа MNS 2305-94 стандартыг мөрдөнө. /AASHTO T87-2000 - Эвдэрсэн бүтэцтэй хөрс, хөрсний чулуулгийн дээжийг хуурайгаар бэлтгэх, шинжлэх, AASHTO T146-96 (2000) - Эвдэрсэн бүтэцтэй хөрсний дээжийг нойтон аргаар эсвэл Инженерын зааврын дагуу бэлтгэх/

- Хөрсийг 600C-аас хэтрэхгүй темпертурт хатаана.
- Элсэн хөрсийг 3 цаг, бусад хөрсийг 5 цаг, гөлтгөнөжсөн хөрсийг 8 цаг хатаана
- Хөрсний нягтыг пикнометрийн аргаар тодорхойлохдоо MNS 2143-2000 стандартыг мөрдлөг болгоно.
- Хөрсний нягтыг 0.01t/cm, зохистой чийгийн хэмжээг 0.1%-ийн нарийвчлалтай тодорхойлно

Хөрсний шинжилгээг дараах стандарт аргуудын дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 2-1: Хөрсний шинжилгээний аргууд

Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох MNS ASTM

D 2217:2002

Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох MNS AASHTO

T88-2004

Хөрсний урсалтын хязгаарыг тодорхойлох MNS ASTM

D 4318:2002

Хөрсний уян налархайн хязгаар ба уян налархайн индексийг тодорхойлох MNS ASTM

D 4318:2002

Сагдуулж

Хөрсний хувийн жин, нягтыг тодорхойлох MNS AASHTO

T100-2003

Стандарт хүчлэл /600кнм/м³ / -ээр хөрсний чийг-нягтын харьцааг 2.5 кг алхыг 457
мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан тодорхойлох MNS ASTM

D 698:2002

Стандарт бус хүчлэл /2700кнм/м³ / -ээр хөрсний чийг-нягтын харьцааг 5 кг алхыг 457
мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан тодо рхойлох MNS ASTM

D 1557:2002

Хөрсний нягтыг газар дээр нь элсэн конусын аргаар тодорхойлох MNS ASTM

D 1556:2002

Хөрсний ачаа даацын үзүүлэлт (CBR)-г тодорхойлох MNS ASTM

D 1883:2002

Хөрсний чийгийн агуулгыг лабораторид тодорхойлох AASHTO T265-93(2000)

Чийгийн агуулгыг тодорхойлох (талбайд) AASHTO T217-02

Динамик шигдэлтийн аргаар замын далан, суурийн даацыг хэмжих аргачлал
MNS 5678:2006

4.54 кг-ийн алхыг 457 мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан хөрсний нягт-чийгийн
харьцааг тодорхойлох MNS ASTM D 1557:2002-ийн стандарт аргын дагуу хийгдэх
лабораторид нягтыг тодорхойлно. Энэ шаардлагад MDD буюу MNS ASTM D 1557:2002
(хуурай үеийн хамгийн их нягтрал-ХҮХИН)-ийн үзүүлэлтийг мөн тодорхойлно.

Технологийн замд хэрэглэх материал

(A) Тавигдах шаардлага

- Технологийн замын дүүргэлтийн үед хэрэглэгдэх дээжний ачаалал даах
чадварын туршилтыг хийхдээ хөрсний тохиромжтой чийгээс ±0.5%-ийн чийгтэй болгоод
хэвлэж нягтуулна.
- Материалууд нь бохир ус, навч, ногоо, үндэс зэрэг органик хольц агуулаагүй
байна.
- Технологийн замын материалыг нэг үеэр дэвсэж нягтуулсаны дараах зузаан
300мм-ээс багагүй байна.
- Материалын зохистой чийгшилийн агуулгыг нягтуулалтын үед проктор
туршилтаар гарсан чийгийн агууламжаас 1%-иар их, 2%-иар бага байхыг зөвшөөрнө.

Бодл

(Б) Технологийн зам барихад мөрдөх шинжилгээний давтамж

- Чийг-нягтын харьцаа 5000м³-д нэг шинжилгээ эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.
- Ширхэглэлийн бүрэлдэхуүнийг тодорхойлох 5000м³-д нэг шинжилгээ эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.
- Уян напархайн индекс 5000м³-д нэг шинжилгээ эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.
- Урсалтын хязгаар 5000м³-д нэг шинжилгээ эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.
- Нягтруулалтын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг зөөвөр хийсэн өдөр тутамд нэг шинжилгээ
- Талбайн хуурай нягтшил 500м тутамд нэг шинжилгээ эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт нэг шинжилгээг хийнэ.
- Далан болон дэвсгэр үед хэрэглэх материалын удыг хамгийн их нягтралын 92%-иас багагүй, чийгийн зохиц агуулга 2%-иас ихгүй байхаар нягтруулна.

Захиалагчийн инженер нь материалын шинж чанарт өөрчлөлт ороогүй гэж үзвэл шинжилгээний давтамжийн тоонд өөрчлөлт оруулж болно.

a) Шинжилгээний стандарт шаардлагууд ба аргууд

Ажилд хэрэглэх бүх материал нь Монгол улсад батлагдсан “Тээвэрлэлт, материал, дээжлэх ба шинжилгээний аргуудын стандарт шаардлагууд”-д нийцэж байх ёстой. Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт шаардлагын дагуу хийгдэх ёстой боловч энэ шаардлагуудад хамрагдаагүй шинжилгээний аргууд буюу энэ шаардлагад өөрөөр заагдаагүй шинжилгээний хувьд AASHTO стандарт шаардлагуудын /эсвэл Инженерын заасан буюу зөвшөөрсөн бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ижил төстэй шаардлагууд/ заалтыг хэрэглэж болно. Энэ тохиолдолд хэрэглэгдэх Олон улсын стандартууд нь монгол хэлнээ орчуулагдсан байх бөгөөд Стандарт хэмжил зүйн төвөөс түр зөвшөөрөл авсан байна. Туршилт хийх лабораторид энэ стандартын албан ёсны орчуулга заавал байх ёстой.

Гүйцэтгэгчийн барилгын хяналтын шинжилгээний давтамж нь түүний төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу байх ба Инженертэй өөрөөр зөвшилцээгүй бол энэхүү шаардлагад заасан удирдамжийн дагуу байна. Гүйцэтгэгч нь ажилд хэрэглэх бүх материал болон хийгдэж буй нийт ажлуудад туршилт шинжилгээг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх шинжилгээг хийж, материал болон ажлын шинжилгээний үр дүнг Инженертэй танилцуулан шалгуулж нэг хувийг өгнө. Баталгаажуулах шаардлагатай шинжилгээг тохиромжтой байдлаар сайтар төхөөрөмжилсөн хараат бус шинжилгээний лабораторид явуулна.

Инженер нь Гүйцэтгэгчийн лабораторийн дээжлэх ажиллагаа, шинжилгээний байр, тоног төхөөрөмж, лабораторийн ажилтнуудын үйл ажиллагаа болон шинжилгээний үр дүнгийн бүртгэл зэргийг ямар ч үед чөлөөтэй хянаж шалгах эрхтэй.

Шимт хөрс болон “Сэтэрхийгээс”-с гарсан материал болон түгээмэл тархацтай ашигт малтмалын карьерыг орон нутгийн болон захиалагч, гүйцэтгэгчийн байгаль орчны мэргэжилтэн нарийн хяналтан дор буулгах, олборлох.

Гүйцэтгэгч нь нөөцлөх, тохиромжгүй материал, шимт хөрсийн буулгах газрыг уулын болон үерийн усны урсах чиглэлд нөлөөлөхөөргүй газар сонгосон байх ёстай. Төмөр замыг барих, ашиглах явцад байгаль орчны үзэгдэлээс үүдэн сул материал нь хийсэж төмөр зам дээр бууж дараахгүй зайдай газар байх шаардлагатай.

Мөн бороо, цасны усанд таран урсаж шимт хөрсийг бохирдуулахгүй, шуудуу хоолой уруу урсан бөглөх магадлалууд байгаа эсэхийг шалгасан байх ёстай. Бүтээн байгуулалтын шинээр барьж байгаа дэд бүтцэд ороогүй газруудыг тус тус судлан сонгох.

АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

Барилгын ажлын үед дараахи ерөнхий шаардлагууд тавигдана. Үүнд:

- a) Гүйцэтгэгч шөнийн цагаар ажил гүйцэтгэх тохиолдолд хангалттай гэрлээр хангах ба Инженерт ажлын явцыг ажиглах, хянах, материалын шинжилгээ, туршилт хийх нөхцлөөр хангах үүднээс нэмэлт гэрэлтүүлэг сууринуулж өгнө.
- b) Ажлын талбайд нөөцлөн бэлтгэсэн буюу шаардлага хангасан материалыг зөвхөн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ашиглана.
- c) Гүйцэтгэгч ажлын талбайн ойр орчмын барилга байгууламжид хүрэх замыг гэрээний нийт хугацааны туршид тогтмол арчилж аюулгүй байдлыг хангана.
- d) Гүйцэтгэгч, ажлын талбайд болон түүний ойр орчны газар, хөрс, зам болон бусад газруудыг бохирдуулахаас сэргийлэх ба ажлыг хэрэгжүүлж байх явцад үүсч болзошгүй аливаа хүндрэлтэй асуудал, саад бэрхшээл зэргийг багасгахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тэдгээр хүндрэлтэй асуудлыг нэгэнт үүссэний дараа багасгах биш, харин гарахаас нь өмнө хянаж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байна. Аливаа ажил ба бусад бүх холбогдох үйл ажиллагаануудыг Монгол улсад дагаж мөрдөгдаж буй бүх хууль тогтоомж, журмын (байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг оролцуулан) шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Зам барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гэж Инженер үзэж зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа мод, бут, бусад өвс ургамалыг огтолж, тайрч зайлцуулахгүй. Гүйцэтгэгч барилгын ажил гүйцэтгэж буй ажиллагсаддаа байгалийн нөөц баялаг, ан амьтдыг хайрлан хамгаалах талаар зааварчилгаа өгсөн байна. Ан хийх ба зөвшөөрөлгүй загасчлах явдалыг хориглох ба энэ талаар Гүйцэтгэгч нь баталгаа гаргана.
- f) Гүйцэтгэгч дараахи зүйлүүдтэй холбогдуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд:

Санжаров

С.Санжаров

- Гол горхи, усны урсац, нуур болон бусад адил төстэй зүйлсийг Инженерын зөвшөөрөлгүй гео-нэхмэл эдлэл буюу өөр бусад аргыг ашиглан лаг шаврын хаалт хийж, үерт автах, эрэг ёроол нь угаагдах, ус бохирдооос сэргийлэх,

- тэдгээрийн чанар, харагдах байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх, хүн, амьтан, ургамлыг гэмтээх, үхэлд хүргэхгүй байхтай холбогдуулсан арга хэмжээ,

- Усан хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс, мөн усны чанарт муугаар нөлөөлж, түүнийг бохирдуулахаас сэргийлэхийн тулд гүний усны нөөцтэй (шүүсэн усыг оролцуулан) холбогдуулсан арга хэмжээ.

- e) Ажлыг гүйцэтгэх явцад гарсан хаягдал материал буюу лаг шаврыг ойролцоо газарт зайлзуулах, шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийг зөвшөөрөгдсөн хаягдал материал зайлзуулах газарт зөөн хаяж, тухайн газрыг анхны байдалд нь оруулан нөхөн сэргээх ажлыг Инженерын тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

- f) Гүйцэтгэгч нь бүх бохир ус болон бусад хаягдал шингэнийг ямар нэг бохирдол үүсгэхгүй байдлаар зайлзуулна. Гүйцэтгэгч, ажлыг хэрэгжүүлэх үед гарсан аливаа хаягдал материалыг Инженер буюу эсвэл холбогдох байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гол, горхи, нуур, цөөрөмд хаяхгүй.

- g) Гүйцэтгэгч ажилдаа тоосжилт болон агаараар тархдаг хорт хийг багасгахад чиглэгдсэн арга ажиллагааг мөрдөж ажиллана. Тоосжилт үүсч болзошгүй тохиолдолд ус шүрших арга хэмжээг авна. Нөөц материал, хаягдал материалын овоолгыг өөр тийш нь ачиж зөөхөөс өмнө норгож чийглэх тухай зааврыг Инженер өгч болно.

- h) Гүйцэтгэгч буюу түүний туслан гүйцэтгэгчид, материал, үйлдвэр заводын ханган нийлүүлэгчдийн машин техникийн ашиглаж буй ажлын нэг хэсэг болох бүх хуучин замууд болон адил төстэй замууд дээрх тэдгээр машин техникийн явалтаас үүссэн тоос/шавар буюу бусад гадны биетийг тогтмол цэвэрлэнэ.

- i) Шатахууны агуулах ба машин техникийг цэвэрлэх газар нь ойр хавийн сайд, гол горхиноос хамгийн багадаа 300 м-ийн зайд байрласан байна.

- j) Гэрээний нөхцөлд дурдсан шаардлагуудаас гадна Гүйцэтгэгч, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх хууль, дүрэм, зарлиг, тогтоол, журам, шийдвэрүүд болон бусад хуулийн механизмуудын талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд эдгээр нь доорхи зүйлсээс бүрдэх боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд :

 - Техникийн шаардлагын нэмэлт,
 - байгаль орчин,
 - эрүүл мэнд, аюулгүй байдал,
 - ариун цэврийн байгууламж ба усан хангамж.

k) Хэрвээ өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх байгалийн гаралтай болон тохиromжтой материалын эх үүсвэрүүд нь ажлын талбайд байсан байгаагүйг үл харгалзан, тэдгээрийн байршлыг тогтоох, ашиглалтын зөвшөөрөл, орд газрын лиценз ба ус ашиглах эрх гэх мэт шаардлагатай бүх зөвшөөрлийг авах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.

l) Гүйцэтгэгч нь, ажлын талбайн эргэн тойронд шаардлагатай хаалт, хашаа хийж, засаж хамгаалан ажил дууссаны дараа буцааж буулгах ба Захиалагч, Инженер, бусад гүйцэтгэгчид болон ажлын талбай руу орох эрх бүхий бусад хүмүүсийн аюулгүй байдлыг зохих байдлаар хангах бөгөөд өөрийн хүлээсэн бусад үүрэг хариуцлагад ямар нэг хор хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх ёстой.

a) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас болон бусад шалтгаанаар тур зогсоовол талбайд байгаа бүх барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зогсолтын бүх хугацааны турш харж хамгаалан, түүнийг үйл ажиллагаагаа дахин эхлэх үед шууд ашиглахад бэлэн байлгах үүргийг хүлээнэ. Гэрээний нөхцлийндагуу, зогсолтын хугацааны турш ажлын талбайг харж хамгаалах үүрэг, хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.

b) Хэрвээ, барилгын ажлын явцад, археологийн чанартай малтмал, зоос, олдвор олдсон тохиолдолд Гүйцэтгэгч нь Монгол улсын засгийн газрын холбогдох байгууллагуудад яаралтай мэдэгдэх ба тэдгээр олдворуудыг Монгол улсын өмч болгож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь соёл, шашны холбогдолтой аливаа барилга байгууламжид нөлөөлөх серөг нөлөөллийг бууруулах явдлыг баталгаажуулна.

a) Технологийн замын барилгын ажил


- Тохиromжгүй гэж үзэхээс бусад тохиолдолд замын ухмалаас гарсан материалыг технологийн замд хэрэглэнэ. Нөөц газраас авах материалыг зөвхөн ухмалаас гарах материал хангалтгүй гэж Гүйцэтгэгчийн нотолж, Инженерын зөвшөөрсөн газарт хэрэглэнэ.
- Материалыг зөвхөн чийгтэйгээс болоод тохиromжгүй материал гэж үзэхгүй. Чийгтэй материалыг урсалтын хязгаар нь техникийн шаардлагад заасан чийгийн хэмжээнд нийцэх хүртэл нь борнойдож хатаана.

Зураг төсөлд өөрөөр үзүүлээгүй, эсвэл Инженер өөрөөр зааварчлаагүй бол Инженерын зөвшөөрсөн шороон орд, эсвэл ухмалаас гарсан тохиromжтой дүүргэгч материалыг технологийн зам барихад ашиглана. Өөрөөр тогтоогоогүй бол Гүйцэтгэгч нь газар шорооны ажилд шаардлагатай материал олборлох талбай, ашиглагдахгүй материалын талбайг сонгож, Инженерээс урьдчилан зөвшөөрөл авч, орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудтай зөвшилцнө. Гүйцэтгэгч нь материал олборлох талбай ба замын ухмалаас гарсан материалын тохирох эсэхийг шалгах бөгөөд материалын ашиглалтын асуудлыг Инженерын зөвшөөрлийг авсаны дараа баталгаажуулна. Материал олборлох талбай, ашиглагдахгүй материалын талбайг эзэмших болон дүүргэгч материал болон шороог тээвэрлэхтэй холбоотой төлбөрүүд тусгайлан хийгдэхгүй. Далангийн материал нь дараах шинж чанарыг хангасан байна.

Үүнд:

- Шигшүүрийн 0.075 мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 10%-иас бага;

Бодл



- Хөөлт нь 2%-иас бага;
- Урсалтын хязгаар нь 25%-иас бага;
- Уян налархайн индекс 9%-иас бага;
- Уян налархайн үржвэр нь 90-өөс бага;
- Хуурай үеийн хамгийн их нягт 1.85т/м3-иас багагүй;
- Хөрсний ачаа даацын үзүүлэлт нь 20%-иас багагүй байна.

Инженерын зааварчилснаас өөрөөр заагаагүй буюу зурагт үзүүлээгүй бол технологийн замд дээр дурдсан үзүүлэлт бүхий материалыг Инженерын зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ.

Инженер нь ажлын аргачлал, талбайн туршилтыг хянаж шалгаад өөрийн санал зөвлөмжийг уг аргачлалд оруулж болно. Технологийн замыг барих явцад материал нягтарч суух, доод үе рүүгээ шигдэх тохиолдол гарвал Гүйцэтгэгч өөрийн зардлаар үе бүрийн тогтоосон төвшин ба өргөнд хүртэл зөвшөөрөгдсөн дүүргэгч материалыг дахин дэвсэж нягтруулах ёстой. Хэрэв нягтруулсан шороон үе нь хэв гажилтад орох эсвэл тээврийн хэрэгсэл дээгүүр нь явж эвдсэн бол дараагийн үе шатны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн үеийг дахин засварлаж нягтруулна. Барьж байгаа буюу дууссан далан дээр дүүргэгч материалыг овоолж болохгүй, ийм хэлбэрээр зам хаах, хөдөлгөөн хязгаарлахыг хориглоно.

ЧУЛУУ БА ШОРООН ОРД

- a) Чулуун орд гэдэг нь зам барилгын ажилд ашиглах чулууг уулнаас өрөмдөж тэслэх буюу бусад арга хэрэгслүүдийг ашиглан олборлох газрыг хэлнэ.
- b) Шороон орд гэдэг нь зам барихад ашиглах чулуунаас бусад материалыудыг авч буй талбай юм.
- c) Материал нөөцлөх газар гэдэг нь дүүргэлтийн материал, өнгөн хөрс зэргийг зам барилгын ажилд ашиглахын өмнө түр хугацаагаар нөөцлөн овоолох талбайг хэлнэ.
- d) Хаягдал материал зайлуулах газар гэдэг нь зам барилгын ажлаас гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалыудыг тараан асгадаг талбайг хэлнэ. Инженерын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр илүүдэл болон шаардлага хангахгүй материалыг замын зурvas газарт асгаж болохгүй.

(4) Үл тохирох материал

- Намаг, намгархаг газраас гарсан материал
- Хүлэр, хожуул, модны тайрдас, амархан мууддаг материал холилдсон /AASHTO T267-86/, стандартын дагуу хөрсөнд агуулагдах органик нэгдлийн агууламж 2%-иас их шороон материал
- Галд авалцах материал
- Үеийн зузаанаас том ширхэглэлтэй ихтэй материал г.м

Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордыг тогтоох бөгөөд материалыг зөвхөн Инженерын зөвшөөрсөн шороон ордоос авна. Шороон ордын материал шинж чанараараа нэг төрлийн, ижилхэн байх шаардлагыг хангахын тулд шороон орд болон түүнд ойрхон газарт материалыг сайтар холих буюу овоолго хийж, дараа нь хэрэглэхээр бэлтгэнэ. Гүйцэтгэгч нь шороон ордод очих түр замыг барьж, өвс ургамал, хад чулуу, овор хэмжээ ихтэй үл тохирох материал, том чулууг зайлцуулна. Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордыг нөхөн сэргзэх үед ашиглах зорилгоор өнгөн хөрсийг хуулж, овоолон хадгална. Гүйцэтгэгч нь шороон ордод буй тохиромжтой материал нь үл тохирох материалтай холилдохгүй байх арга хэмжээг авна. Үл тохирох материалыг зайлцуулах, эсвэл техникийн шаардлагад заасны дагуу ухмалыг нөхөн сэргээхэд ашиглана.

Шороон ордыг тогтоосон өргөн ба хэлбэрээр ухах ажил дууссаны дараа цэвэрлэж, нөхөн сэргээнэ. Нөхөн сэргээсэн шороон ордын хажуу налуу нь хамгийн ихдээ хэвтээ байдлаар 6, босоо байдлаар 1 гэсэн харьцаатай байна. Техникийн шаардлагад заасны дагуу ордын хажуу налуу ба ойр орчим нь цэвэрхэн үзэмжтэй засагдсан байна. Шороон ордыг тойруулж, хашаа хийж, аюулгүй ажиллагааг хангана. Шороон ордыг ашиглахдаа техникийн шаардлагын холбогдох заалтуудын зэрэгцээ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зааврыг баримтална. Технологийн замын доорх ул хөрс, чулуун дүүргэлтийг доргиулагч индүү ба гөлгөр бултай индүүгээр нягтруулна.

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

Захиалагчаас зохион байгуулж, улмаар тухайн орон нутгаас газрын зөвшөөрөл олгосон даруйд ямар нэгэн ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь тухайн газарт хүрээлэн буй орчныг хамгаалахаас эхлүүлээд бусад бүх ажлыг эхлэх хууль эрх зүйн бүхий л нөхцөл бүрэлдсэн эсэхийг хянаж баталгаажуулсан байх ёстой. Газар шорооны болон зам барилгын үндсэн ажлуудыг эхлүүлэхдээ Инженерээс бичгээр зөвшөөрөл авч байж эхлүүлнэ. Технологийн замын ажлыг Гүйцэтгэгчийн ерөнхий Инженер болон орон нутагтай хийсэн зөвшилцэл дээр үндэслэн эхлүүлэх боломжтой бөгөөд ажил эхлүүлэх талаархи албан ёсны мэдэгдэлийг Инженерт бичгээр хүргүүлнэ.

Хажуугийн шуудууг барих ажлыг Техникийн шаардлагад заасны дагуу ухмалын нэг адил авч үзэх ба газар шорооны ажлын ангилалд хамаарна. Инженер барилгын ажлын явцад хажуугийн шуудууны гүн, налуу хэмжээнд өөрчлөлт оруулж болох ба энэхүү өөрчлөлтийн дагуу барина.

Гүйцэтгэгч нь нягтруулах ажлыг эхлүүлэхийн өмнө дүүргэгч материалын чийгийн хэмжээг тодорхойлох ёстой. Материалыг услах буюу хатаах замаар нягтруулах үеийн чийгийн хэмжээ нь (AASHTO T180) тохиромжтой чийгийн хэмжээнээс $\pm 2\%$ -ийн хооронд хэлбэлзэж байхаар тохируулна. Дүүргэгч материалыг тодорхой зузаантайгаар жигд тараагаад материалын чийгийн хэмжээ нь дээр дурдсан хязгаарт байхаар буюу хуурай үеийн нягт нь дор зааснаас багагүй байхаар нягтруулна. Үүнд:

A. Технологийн замын дүүргэгч материалыг хуурай үеийн хамгийн их нягтын 92%-иас багагүй байхаар нягтруулах ёстой.

Технологийн замын нягтруулалтыг Инженерын зөвшөөрлөөр Гүйцэтгэгчийн санал болгосон горимын дагуу хийж гүйцэтгэнэ. Нягтруулах явцад Гүйцэтгэгч нь шаардлагатай гэж үзвэл холимог материалын хөндий зайлгүй чигжиж өгөх үүднээс гадаргууг усална.

Гүйцэтгэгч нь нягтруулалтад зайлшгүй хэрэглэх усаа нөөцлөх ёстай. Нягтруулалтад зөвхөн давсгүй, элдэв хольцгүй цэвэр ус хэрэглэх ба Инженерын зөвшөөрсөн эх булгаас авна. Хэрвээ Инженер шаардсан бол Гүйцэтгэгч нь усанд шинжилгээ хийлгэж, шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана. Гүйцэтгэгч нь ус зөөвөрлөх болон тараах шаардлагатай бүхий л тоног төхөөрөмжөөр хангана. Шуршигч хошуу эсвэл ижил төстэй тоноглолтой усны нөөц сав ашиглан усыг технологийн замын гадаргуу дээр тогтмол хэмжээгээр жигд шуршинэ. Инженерээс зөвшөөрөгдсөн автогрейдер, анжис эсвэл ижил төрлийн холигч машин ашиглан нягтруулах гэж байгаа шороог устай жигд хольсон байх ёстай.

Намагтай болон бамбалзуур хөрстэй газрыг ухан Инженерын зааварласан хаягдал зайлцуулах газарт хаяж дараах байдлаар чулуун дүүргэлтийг дүүргэнэ.

- Инженерын заавраар намагтай газарт Гүйцэтгэгч зөвшөөрөгдсөн чулууг дэвсэнэ. Чулуун дүүргэлтийг зааварласан газарт нийтэд нь сайтар суух хүртэл жигд үеэр дэвсэж, индуудэн хөдөлгөөн явуулна. Тогтвортгуй ул суурь дээр чулуун дүүргэлтийг хийх бол материалыг ажлын талбайд ойрхон газарт буулгаж далангийн өндөр нь барилгын ажлын хүнд машин механизмын ачааллыг даах боломжтой болох хүртэл нь бульдозероор түрж тараах замаар хийнэ.

- Чулуун дүүргэлтийн хамгийн том нь 250 мм-ийн хэмжээтэй байна. Нягтарсан үеийн зузаан 500 мм буюу үүнээс бага байх ба чулуун дүүргэлтийг хийж байх явцад Инженер тавигдах шаардлагуудыг өөрчилж болно. Инженерын зааварласнаар нэмэлт үеүдийг дэвсэх буюу газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч чулуун үе бүрийг боломжийн хязгаарт нягтруулсан байна.

Замын ухмалаас /хөрс хуулалт, талбайн цэвэрлэгээ/ гарсан технологийн замд ашиглахад тохиромжгүй буюу хэрэглэх шаардлагагүй гэж Инженер тодорхойлсон бөгөөд хаягдал зайлцуулах талбайд зөөж буулгах заавар өгсөн материалыг хаягдал материал гэж тодорхойлно. Инженер тусгай зөвшөөрөл өгөхөөс бусад тохиолдолд ухмалын материалыг хаягдал зайлцуулах талбайд зайлцуулахгүй. Эхлээд хаягдал материал гэж ангилагдсан боловч дараа нь Инженерын зөвшөөрлөөр Гүйцэтгэгч технологийн зам болон түр замын нэг хэсэг болгож ямар нэгэн байдлаар хэрэглэсэн ухмалын материалыг хаягдал материал гэсэн ангиллыг нь өөрчилж, хаягдал материалын хэмжилтэд зохих өөрчлөлтийг хийж болно. Гүйцэтгэгч байршилыг нь тогтоож, Инженер урьдчилан баталж, орон нутгийн захиргааны зөвшөөрсөн хаягдал материал зайлцуулах талбайд Гүйцэтгэгч хаягдал материалыг зөөвөрлөж хаяна. Энэ техникийн шаардлагад заасны дагуу Гүйцэтгэгч хаягдал материалын талбайг олж тогтооно. Гүйцэтгэгч хаягдал материалыг зайлцуулах үйл ажиллагааг эхлэх тухай мэдэгдлийг хамгийн багадаа 24 цагийн өмнө Инженерт өгнө.

Газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерын зааврын дагуу талбайн цэвэрлэгээ, мод, хожуулыг булгалах, сугалах, намаг болон шаварлаг хөрсийг зайлцуулах, өнгөн хөрсийг хуулах зэрэг ажлыг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг Инженерын зааварчилснаар буюу зургийн дагуу гүйцэтгэнэ.

Газар шорооны ажлыг энэхүү шаардлагын дагуу хийж гүйцэтгэгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахиж гүйцэтгэнэ. Ухмалаас гарсан тохиромжтой материалыг технологийн зам ба түр замд хэрэглэж болно. Техникийн үзүүлэлтийн хувьд тохирохгүй материалыг технологийн болон түр замын дүүргэлтэд хэрэглэхгүй.

Тохиромжгүй материалд дараах зүйлс багтаж бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Өнгөн хөрс, намгархаг хөрс, хүлэртэй хөрс, хожуул, органик бодис 2%-иас их агуулсан шороо, амархан мууддаг материал холилдсон хөрс шороо;
- Шигшүүрийн 0.075мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 10 %-иас их;
- Хөөлт нь 3 %-иас их;
- Уян напархайн индекс 12 %-иас их;
- Урсалтын хязгаар 35 %-иас их материал;
- Бул чулуу, хад болон 75 мм-ээс том хэмжээтэй чулуу.

Тохирогчийн буюу эсвэл илүү гарсан тохирох материалыг Гүйцэтгэгч ашиглагдахгүй материалын талбай руу зөөж зайлцуулна. Гүйцэтгэгч нь дүүргэлтэд тохирох материалыг зөвхөн ухмал ба олборлох талбайгаас ашиглаж болно. Даланд шаардлагатай материалын хэмжээ нь ухмалаас гарсан тохиромжтой материалаас илүү байвал Гүйцэтгэгч Инженерын заавраар ухмалыг өргөтгөх эсвэл шинээр шороон орд нээж болно. Гүйцэтгэгч нь ухмалын болон дүүргэгч материал дэвссэн гадаргууг цаг агаарын нөлөөлөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас гэмтэж эвдрэхээс сэргийлж, хамгаалах үүрэгтэй. Хэрэв ямар нэг эвдрэл гарсан тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар тухайн ажлыг засаж хийнэ. Гүйцэтгэгч далангийн дүүргэлтэд тохиромжтой материалыг ашигласан эсэхийг баталгаажуулах үүднээс нэмэлт хяналт хийнэ. Хэрэв ямар нэг тохиромжгүй материал ашигласан бол түүнийг зайлцуулан оронд нь тохиромжтой материал дэвсэх ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх болно. Ухмал, далан, хажуугийн шуудуу, хөвөө зэргийг тогтоосон налууд хүртэл тэгшилж засах ажлуудыг газар шорооны ажил явагдаж буй байршил, төвшинд нэг зэрэг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг хийж гүйцэтгэхдээ Инженерын зааварчилгааг биелүүлэх ёстой.

ИНЖЕНЕРЫН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч, газар доор буюу дээр хийгдсэн аливаа Инженерын байгууламж, шугам сүлжээг (цаашид Инженерын байгууламж гэх) эvdэж гэмтээсэн тохиолдолд хариуцлагыг хүлээж, Захиалагчийн эсрэг гарсан аливаа зарга зардлаар хийж гүйцэтгэх хариуцлагыг хүлээнэ.

Хуучин Инженерын байгууламжийн ойр орчмын газарт ухалтын ажил эхлэхээс өмнө болон энэ ажил нь Инженерын байгууламжуудад нөлөөлөхүйц шинжтэй байвал, Гүйцэтгэгч, тэдгээр Инженерын байгууламжуудыг эзэмшигч буюу тэдгээрийг ажиллуулж буй холбогдох байгууллагуудад мэдэгдэж, Инженерын заавраар, ажлаа үргэлжлүүлэхээс өмнө, тэдгээр байгууламжийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлахаар төлөвлөсөн өөрийн ажлын төлөвлөгөөгөө холбогдох байгууллагуудад танилцуулж зөвшөөрөл авна.

Гүйцэтгэгч, дараахи бүх Инженерын байгууламжийн, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр, байршил болон холбогдох эд аngiудыг нарийвчлан тогтоох үүрэгтэй. Үүнд:

Согул
Согул

Б.Чиритин
Б.Чиритин

- Бохирын шугам,
- Гадаргын ус зайлцуулах байгууламж,
- Цахилгаан, холбоо, гэрэлтүүлгийн кабель шугам, шилэн кабель,
- Өндөр хүчдэлийн цамхагийн шон, кабелийн суваг хоолой,
- Ус дамжуулах шугам,
- Дулаан дамжуулах шугам.

Тэдгээр Инженерын байгууламжууд, шугам сүлжээг булж далдалсан байвал, Гүйцэтгэгч эзэмшигч байгууллагуудаас нь тэдгээрийн байршил, булсан гүн зэргийн талаарх мэдээллийг авна. Гүйцэтгэгч, цахилгаан ба цахилгаан соронзон багажийн аль тохирохыг ашиглан гараар туршилтын нух болон шуудуу ухах зэрэг аргаар цааш хайгуул хийнэ. Ил гарсан Инженерын байгууламж, шугам сүлжээг хэрхэх асуудлыг Инженер ба холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж, шийдвэрлэнэ. Эрсдэлтэй байж болох Инженерын байгууламжуудыг бүрэн ил гаргах ба гарсан ухмалыг нурахаас хамгаална. Ил гарсан шугам сүлжээг барилгын ажил эхлэхээс өмнө газар дээр нь сайтар хамгаална. Ажилтай залгаа суурилуулсан аливаа байгууламжийг ажлыг дусах хүртэл газар дээр нь аюулгүй байлгах ба дараа нь аюулгүй, тогтвортой байдалд нь буцааж суурилуулна.

Барилгын ажил дууссаны дараа шугам, хоолой, кабель шугамыг шороогоор булах, дүүргэлт хийх, нягтрнуулна. Ухмал, буцаан дүүргэлт, дахин суурилуулах (шаардлагатай үед) зэрэг ажлыг зохих дүрэм, журмын дагуу эзэмшигч байгууллагуудын зааварчлага, хяналтын дор хийж гүйцэтгэнэ. Ажлын шаардлагын дагуу хийсэн ухалтаас шалтгаалан замын гадаргуугийн эцсийн төвшинг өөрчлөх бол, тэдгээр хаалтын таг, худаг, үзлэгийн худагны тагуудын төвшин ба тэдгээрийн амсарыг Инженерын тавьсан шаардлагад нийцүүлэн тохирох байдлаар өөрчилнө.

Гүйцэтгэгч, зурагт үзүүлээгүй хэдий ч талбайгаас илрүүлсэн Инженерын байгууламж, шугам сүлжээний талаар Инженерт яаралтай мэдэгдэнэ. Хэрвээ, Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэн Инженерын байгууламжид хохирол учирч магадгүй байвал, Инженерын зүгээс эдгээр хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс засварлаж болох аливаа арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Өндөр хүчдэлийн цахилгааны шугам нь кран болон бусад овор ихтэй техник хэрэгслийн эд ангиар дамжин газарт богино холбоо үүсгэх аюултай тул Гүйцэтгэгч нь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын ойролцоо ажиллаж буй бүх хүмүүст аюулгүй зайн баримтлан ажиллах ёстойг таниулж зааварчлага өгсөн байна. Хүснэгт 1-1, 1-2-т өндөр хүчдэлийн дамжуулах шугам ба нам хүчдэлийн түгээх шугамнуудын хувьд баримтлах аюулгүй зайн санал болголоо. Эдгээр саналуудыг үл харгалзан, Гүйцэтгэгч, тэдгээрийн үйл ажиллагааг хариуцсан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөн, төрөл бүрийн хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамнаас гадагш баримтлах аюулгүй зайн өөртөө зориулан тогтооно. Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний болон цахилгааны шугамд ажил ойрхон байгаагаас шалтгаалан зайлшгүй хийгдэх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Хүснэгт 1-1: Өндөр хүчдэл дамжуулах

шугамнаас доошхи, санал болгож буй цэвэр зайд

Вольт кВ Зайд

138 7.8 м

230 8.4 м

345 9.4 м

500 10.0 м

Хүснэгт 1-2: Нам хүчдэлийн түгээх

шугамнаас доошхи, санал болгож буй зайд

Вольт кВ Зайд

0 - 750 1 м

750 - 38,000 1 м

38,000 - 86,000 1.5 м

Гүйцэтгэгч нь дээрхи шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхөө үүрэг хариуцлагыг бууруулахгүйгээр, аливаа ажил, Инженерын байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд, Инженерт яаралтай мэдэгдэнэ. Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа Инженерын байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

Гүйцэтгэгч нь дээрхи шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхээ үүрэг хариуцлагыг бууруулахгүйгээр, аливаа ажил, Инженерын байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд, Инженерт яаралтай мэдэгдэнэ. Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа Инженерын байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

ИНЖЕНЕРЫН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭГ

Зураг дээр үзүүлсэн Инженерын байгууламжийн байршил, эд ангиудыг үл харгалзан, өгсөн мэдээллийг баталгаажуулах, нарийвчлан тогтоохын тулд Гүйцэтгэгч, нэмэлт хайгуул судалгааг хийнэ.

Гэрээний нөхцөлд болон энэхүү техникийн шаардлагын зүйл 104-ийн шаардлагуудын дагуу ажлын хөтөлбөрөө боловсруулж байх явцдаа, Гүйцэтгэгч техникийн шаардлагын зүйл 120-д тодорхойлсоны дагуу ажлын талбайд ба эргэн тойронд байгаа Инженерын байгууламжийг илрүүлэх, байршлыг тогтоох, хамгаалах, шилжүүлэх болон холбогдох байгууллагаудад мэдэгдэх шаардлагатай хугацааг тооцож үзсэн байна. Гүйцэтгэгч, аливаа Инженерын байгууламжийг шилжүүлэх буюу өөрчлөх, шаардлага гарсан тохиолдолд холбогдох

байгууллагуудтай холбоо харилцаатай ажиллах хариуцлагыг хүлээнэ. Хэрвээ Гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг туслалцаа авах бол, энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Инженерт мэдэгдэнэ.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Гүйцэтгэгч зурагт үзүүлсэн, эсвэл Инженерын зааварласан ширхэг, дизайн, өнгө, хэмжээгээр замын мэдээллийн самбарыг хийж, суурилуулан, арчилж хамгаална. Инженерын зааварласан цэгүүдэд замын самбаруудыг суурилуулна.

Замын мэдээллийн самбаруудыг технологийн замын ажил дуусч, тээврийн хөдөлгөөн эхлэхээс өмнө суурилуулсан байна. Гүйцэтгэгч тэдгээр замын самбарыг баталгаат засварын хугацаа дуусах үед буцааж авна.

ГАДАРГУУГИЙН УСНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ

Барилгын ажлын үед замын зурваст орсон юм уу эсвэл түүний ойролцоо орших гол, горхи, рашаан булаг зэрэг усны эх үүсвэрүүд зарим тохиолдолд хөндөгдэж болзошгүй юм. Иймд зөвшөөрөгдсөн аргыг ашиглан хамгаалалтын арга хэмжээ авах замаар тунадас үүсэхээс хамгаалах ба Монгол улсын гадаргын усны чанарын хяналтын стандартын дагуу шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд ингэнээр барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан усны чанарт өөрчлөлт орохгүй байх нөхцөлийг хангаж ажиллах ёстай.

АЖЛЫГ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛОН ТЕХНИКИЙН ШААРДЛАГАТАЙ НИЙЦҮҮЛЭХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Инженер /хяналтын Инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/-ийн саналаар, замыг нээснээр тээврийн хөдөлгөөн аюулгүй байдлаар үргэлжлэн явагдах боломжтой, түүнээс гадна баталгаат засварын хугацаанд хийгдэж болох дараахи ажлуудаас бусад бүх ажил уг замын хэсэгт хийгдсэн гэж үзэхээс бусад тохиолдолд замын ямар ч хэсгийн ажлыг гүйцэтгэж дууссанд тооцож ажил хүлээн авах актыг олгохгүй. Үүнд:

1. Мэдээлэх тэмдэгнүүдийг байрлуулах
2. MNS 4596:2014 дугаартай Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу технологийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдгүүдийг байршуулах.
4. Тэмдгүүд нь MNS 4597:2014 дугаартай “Авто замын тэмдэг” техникийн ерөнхий шаардлага стандартад нийцсэн байна. .

Бүх материалыг цаг агаар, үер ус болон бусад гадны нөлөөнд өртөхөөргүй болон техникийн шаардлагад нийцэх байдлаар ажлын талбайд хадгалж, хамгаална.

ГЭРЭЛ ЗУРАГ

Энэхүү техникийн шаардлагын дагуу Гүйцэтгэгчийн Инженер төслийн нэр, хучин чадал, ажлын нэр, төрөл, байршил, огноог харуулсан технологийн замын ажлын явцын самбартай зургийг авч баримтжуулна.

БҮЛЭГ 1 - ЕРӨНХИЙ

1.1 БАЙРШИЛ БА ХАМРАГДАХ ГАЗРУУД

ТӨЛӨВЛӨЖ БУЙ ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА НЬ БҮХ ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ЕРӨНХИЙ АЖИЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛНО. ЭНЭ БАРИМТ БИЧИГ НЬ ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ЖИШИГ СТАНДАРТЫГ ТОГТООНО. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН ШААРДЛАГАД МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ, ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛЫН ТУРШИЛТЫН НЯГТРУУЛАЛТ, ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ТОХИРОМЖГҮЙ МАТЕРИАЛ ЗАЙЛУУЛАЛТ, ДАЛАН, ХУЧИЛТЫН ҮЕИЙН ДҮҮРГЭЛТ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШААРДЛАГЫГ ТУСГАВ.

Замын талаархи нарийвчилсан мэдээллийг Инженерийн нарийвчилсан зураг төсөлд үзүүлсэн болно. Трассын эхлэл, төгсгөлийн цэгүүдийг ажлын зурагт үзүүлсэн. Ажил эхлэхээс өмнө эдгээрийн талаар Захиалагчийн инженерийн нарийвчилсан зааварчилгааг авна. Ажлын талбайд дараах зүйлсийг Захиалагчийн инженерийн зөвшөөрөлтэйгээр гэрээнд тусгагдсаны дагуу байрлуулсан байна.

Үүнд:

- Замын зурvas газар,
- Шороон ордууд,
- Хаягдал зайлцуулах газар,
- Түр замууд,
- Гүйцэтгэгчийн түр байгууламжууд,
- Хадгалах, агуулах газрууд,
- Хээрийн лаборатори,
- Замын дагуу байгуулах үйлчилгээний цогцолбор
- Инженерийн ажлын байр ба оршин суух байрууд.

1.2 ГЭРЭЭНД ХАМРАГДАХ ЗҮЙЛҮҮД

ЕРӨНХИЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ӨГСӨН ГЭРЭЭНИЙ ЗУРГУУД БОЛОН ЦААШИД ӨГӨХ ЗУРГУУДЫГ БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨ ЛАВЛАГАА БОЛГОН АШИГЛАНА.

Гэрээнд хамрагдах ажил нь дараахи гол зүйлүүдээс бүрдэх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

- a) Хээрийн лаборатори эсвэл гэрээт лабораторийн байх;
- b) Талбайг цэвэрлэх, улаан шугам тавих, гадаслагаа хийх;
- c) Түр замыг барих, байнгын усан арчлалт хийж, тоос шороо босохоос сэргийлэх, арчлалтын талаархи мэдээллийг бүртгэх, тайлагнах;
- d) Хэмжих хэрэгсэл, лабораторийн тоног төхөөрөмжүүдийг Стандартчилал хэмжилзүйн төвөөр баталгаажуулах;
- e) Далан барих хийх;
- f) Хучилтийн үе барих,
- g) Зам барилгын ажил дууссан үед эцсийн гүйцэтгэлийн зургийг боловсруулж батлуулна.
- h) Барилга хүлээн авсан гэрчилгээг олгох хүртэлх ажлыг бүхэлд нь хариуцах, баталгаат засварын хугацааны туршид засвар арчлалтыг хийж, гэмтэл согогийг арилгах ажлыг гүйцэтгэх;

1.3 ЗУРАГ

Гүйцэтгэгч нь улсын экспертизээр батлагдсан зураг төсөл, мөн тэдгээр зургандаа хийсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу төмөр замын барилгын ажлыг хийж гүйцэтгэнэ. Зохиостой хэмжээнд ажлыг хэрэгжүүлэхийн тулд Захиалагчийн инженерийн тухай бүрт өгөх зааврын дагуу тэдгээр зургуудыг өөрчлөх болон нэмэх байдлаар сайжруулан засварлах боломжтой. Энэхүү өөрчлөлтуүдийг захиалагч болон зохиогчтой зөвшилцэж баталгаажуулсан байна. Ажлын зурагт орсон өөрчлөлт нь чанарыг муутгасан, зураг төсөл зохиогч болон Захиалагчийн инженерийн зохих зөвшөөрлийг авалгүйгээр ажил гүйцэтгэж болохгүй.

1.4. АЖЛЫН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ

Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ Гэрээний нөхцөлд заасан ажлын хөтөлбөр төлөвлөгөөг графикийн хэлбэрээр бэлтгэсэн байх ба үүн дээр, төслийн зам баригдах газар нутгийн болон цаг агаарын нөхцлийг харгалзан хийгдэх бүх бэлтгэлийг хангах, машин техник, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийг оруулж ирэх, барилгын ажлыг явуулах, тэдгээрийн харилцан хамаарал, саад бэрхшээл зэргийг харуулсан нэмэлт графикийг боловсруулан, Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор танилцуулна. Бүх нэмэлт график нь үндсэн графиктайгаа няйт уялдаатай байх буюу түүний үр дагавараас үүдэн гарсан байна. Цаг хугацааны дарааллаар харуулсан график хэлбэрээр танилцуулна. График, нэмэлт графикийн хугацааны нэгж нь 1 өдөр байна.

Ажлын төлөвлөгөөг бэлтгэх, шаардлагатай үед шинэчилж, өөрчилж байх үүднээс Гүйцэтгэгч энэ зорилгоор ашиглах компьютер, тохиромжтой программ хангамжаар өөрийгөө хангах ба эдгээрийн сонголт, төрөл загварын талаар захиалагчийн инженерийн урьдчилан зөвшөөрөл авна. Гүйцэтгэгч, ажлын хөтөлбөрөө улирал бүр тогтмол эсвэл Инженерийн заасан хугацаанд шинэчилнэ. Гүйцэтгэгч, ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх программ хангамжуудын эх хувь ба шаардлагатай үед хөтөлбөрийг шинэчлэн өөрчлөхөд хэрэглэгдэх бүх мэдээллийг захиалагчийн инженер хэрэгцээнд зориулан хангана.

Гүйцэтгэгч, долоо хоног бүрийн нэг дэх өдөр, тухайн долоо хоногт хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлуудын тоо хэмжээг ажлын төрөл тус бүрээр үзүүлсэн долоо хоногийн ажлын төлөвлөгөөгөө, урд дахь 7 хоногийн ажлыг биелэлтийг тогтмол танилцуулна. Хэрвээ Гүйцэтгэгчийн хийж буй ажлын явц нь батлагдсан хөтөлбөрт тусгагдсан тоо хэмжээ буюу дараалалтай тохирохгүй байна гэж захиалагчийн инженер үзвэл, захиалагчийн инженер ба тэдгээрийн төлөөлөгчийн заавраар, Гэрээний нөхцлүүдэд тодорхойлсон эцсийн хугацааны дотор Ажлыг хийж дуусгахыг баталгаажуулан, ажлын хөтөлбөрөө шинэчилж, түүнийг хэрхэн шинэчилсэн тухай арга, аргачлал, нөөцийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн хамт танилцуулна.

Гүйцэтгэгч, зөвшөөрөгдсөн программ хангамжийг ашиглан, өөрийн ажлын хөтөлбөрөө (шинэчилсэнд оролцуулан) дээр өгүүлсэн графикийн хэлбэрт оруулж, түүнийг үндэслэн холбогдох шугаман графикуудыг шинэчилж өөрчлөх замаар хөтөлбөрөө шаардлага хангахаар хэмжээнд боловсруулагдсан болохыг батална.

Тэдгээрийг захиалагчийн инженер зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэгч хугацаа алдалгүй хэрэгжүүлж эхлэх ба шинэчилсэн нэмэлт төлөвлөгөө, хуваариудыг бэлтгэнэ. Хэрвээ тэдгээр шинэчилсэн төлөвлөгөөнүүдийг Захиалагчийн инженер зөвшөөрөхгүй буюу Гэрээний нөхцөлд заасан эцсийн хугацаанд төслийг хэрэгжүүлж дуусгах боломжгүй гэж үзвэл, төслийг эцсийн тогтоосон хугацааны дотор дуусах нөхцлийг хангаж, захиалагчийн инженерийн шаардлагад нийцэх хэмжээнд төлөвлөгөөгөө шинэчлэн засварлаж танилцуулна.

Гүйцэтгэгч, ажлыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, тогтоосон хугацаанд нь дуусгахаар гэрээнд заасан нөхцлийн дагуу ажлын төлөвлөгөөгөө боловсруулахдаа бүх шаардлагатай хүчин зүйлс, бусад нөхцөл байдлын талаар сайтар судалж, тодорхой мэдлэг, мэдээллийг оновчтойгоор тусгасан байх ёстой.

Гүйцэтгэгчээс Захиалагчийн инженерт танилцуулах мэдээлэл нь барихаар төлөвлөж буй түр ажлын байрууд болон бусад түр барилга байгууламжуудын ерөнхий зохион байгуулалтыг харуулсан зураг, нийт ажлыг гүйцэтгэхэд ашиглахаар төлөвлөж буй гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, түр ажил ба бусад бүх нэмэлт шаардлагатай зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна.

Гүйцэтгэгч, Захиалагчийн инженерийн өгсөн зааврыг хүлээн авсанаас хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор ажлын хөтөлбөрөө шинэчилж, (Захиалагчийн инженерийн шаардлага хангасан хэмжээнд хийсэн өөрчлөлтийн хамт) танилцуулна. Гүйцэтгэгч, Захиалагчийн инженерийн зөвшөөрч баталсан хөтөлбөрийн дагуу ажлыг хийж гүйцэтгэх ба Захиалагчийн инженерээс бичгээр зөвшөөрөл авахаас нааш тэрхүү хөтөлбөрөөс гажиж болохгүй.

1.5 АЖЛЫН ДАРААЛАЛ

Ерөнхийдөө, гүйцэтгэгч нь замыг нэг төгсгөлөөс нь (Захиалагчийн инженерээс зааварчилсан буюу тохиролцсон тохиолдолд замын хэсгийг) эхэлж, дунд нь тасархай хэсэг орхилгүйгээр нөгөө төгсгөл рүү чиглэсэн байдлаар үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгчээс танилцуулж, Захиалагчийн инженерийн баталсан ажлын төлөвлөгөөнд (шинэчилсэн ажлын төлөвлөгөөг оролцуулаад) хэсгийн урт ба ажлын бүрэлдэхүүн бүрээр (өөрөөр хэлбэл, газар шорооны ажил, суурь хучилтын ажил, г.м) харуулсан хийгдэх ажлын дарааллыг тусгасан байна.

1.6 ЗАХИАЛАГЧИЙН ИНЖЕНЕРТ ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

Гүйцэтгэгч аливаа санал, асуудал, зураг, тооцоо, мэдээлэл, ном гарын авлага, материал, шинжилгээний хариу, гэрчилгээ, акт, зөвшөөрөл авах хүсэлт, тодруулга, Гэрээний хэрэгжилттэй уялдан гарч буй бусад бичиг баримтуудыг Захиалагчийн инженерт танилцуулах. Шаардлагатай болвол Захиалагчийн инженер танилцуулсан зүйлсийг судалж үзэн, тохиромжтой бол, Гэрээний нөхцлүүдийн холбогдох заалтын дагуу Гүйцэтгэгчид хариуг өгнө. Захиалагчийн инженерээс зөвшөөрөл авах шаардлагатай бичиг баримтуудыг, Гэрээний нөхцлүүдийн холбогдох зүйл, техникийн шаардлагын заалтууд, эсвэл захиалагчийн инженертэй харилцан зөвшилцэх шаардлагатай батлагдсан ажлын хөтөлбөрийг харгалзан, тэдгээр бичиг баримт бурийг судалж үзэх боломжийн хугацааг захиалагчийн инженерт олгох зэрэг шалтгаанаар, хариу өгөх өдрөөс хангалттай хугацааны өмнө захиалагчийн инженерт танилцуулна.

Танилцуулсан зураг ба үйлдвэрлэгчийн гарын авлага, номноос бусад бичиг баримтууд нь А4 хэмжээний, эсвэл захиалагчийн инженерийн зааварласан буюу баталсан хэмжээтэй цаасан дээр үйлдэгдсэн байна. Бүх бичиг баримт монгол хэл дээр байх ба харин үйлдвэрлэгчийн танилцуулга, бичиг баримтуудыг монгол хэлээр үнэн зөв хийж, танилцуулна. Аливаа товчилсон үгийн тайлбарыг оруулсан байна. BS 5775-д заасны дагуу бүх тооцоо, техникийн мэдээллүүд Си системийн нэгжээр илэрхийлэгдэнэ. Захиалагчийн инженерээс өөрөөр зааварласан буюу зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд бүх зурагны гадны хүрээ хүртэлх хэмжээ А3 хэмжээтэй байна. Зургийн тайлбарууд монгол хэл дээр хийгдсэн байна. Бүх хэмжээсүүд нь метр буюу миллиметрээр, бүх хүндийн жинг SI нэгжээр илэрхийлсэн байна.

Гүйцэтгэгч, зурагны хүрээ, дугаарлалт, нэр зэргийн талаар зөвшөөрөл авах зорилгоор ноорог зургийг Захиалагчийн инженерт танилцуулна. Дараагийн бүх зургуудыг энэхүү зөвшөөрөгдсөн загварын дагуу Захиалагчийн инженерт танилцуулна. Бүх зургийн доод талд гэрээний нэр ба зургийн тухайлсан нэрийг бичсэн байна. Бүх зургуудыг тус тусад нь дугаарлаж, хэрэглэсэн масштаб, танилцуулсан өдөр зэргийг тэмдэглэнэ. Мөн зурганд хийсэн нэмэлт өөрчлөлтүүдийг тэмдэглэж, өдрийг нь тавьсан байна. Аливаа танилцуулсан зүйлийг баталж, зөвшөөрөх нь Гүйцэтгэгчийг Гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

1.7 АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ АКТ

Захиалагчийн инженер /Захиалагчийн хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/-ийн саналаар түүнээс гадна баталгаат засварын хугацаанд хийгдэж болох дараахи ажлуудаас бусад бүх ажил уг төмөр замын хэсэгт хийгдсэн гэж үзэхээс бусад тохиолдолд төмөр замын ямар ч хэсгийн ажлыг гүйцэтгэж дууссандаа тооцож ажил хүлээн авах актыг олгохгүй. Үүнд:

1. мэдээлэх тэмдэгнүүдийг байрлуулах

1.8 БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

Гүйцэтгэгч, гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авсанаас хойш 21 хоногийн дотор төлөвлөж буй зохион байгуулалтын арга хэмжээ ба ажлыг хийж гүйцэтгэх аргачлалаа Захиалагчийн инженерт танилцуулна. Аргачлал нь дараахи зүйлсийг агуулсан байх ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Хээрийн лабораторийн зохион байгуулалт хангамж, хэрэгслийн жагсаалт
- Газар шорооны ажлын техникийн шаардлага
- Түр байгууламжуудийн зохион байгуулалт, схемчилсэн зураг
- Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, төлөвлөж буй үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарц хэмжээ, ханган нийлүүлэлтийн хуваарь
- Гүйцэтгэгчийн түр лагерь ба материал нөөцлөх газруудын байршил координат, схемчилсан зураг
- Орд газрын ашиглалт, чулуу бутлалт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт,
- Бусад хэрэгцээт материалын үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, хадгалалт, ашиглалт,
- Шороон ордын ашиглалт, тэдгээрт хүрэх түр замууд,
- Зам барилгын үе шатны ажлуудыг гүйцэтгэх ,
- Замын ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах материалын хангамж, ашиглалт,

хадгалалт,

- Цахилгааны хангамж, ашиглалт
- Түр замыг барих, байнгын усан арчлалт хийж, тоос шороо босохоос сэргийлэх
- Ухмал ухах аргачлал, схемчилсэн зураг
- Усан хангамжийн зохион байгуулалт,
- Ажлын ээлжийн зохион байгуулалт,
- Мэргэжилтэй болон туслах ажилчдын хангамж,
- Гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянах

Ажлыг гүйцэтгэх явцдаа Гүйцэтгэгч, дээр дурдсан зүйлсийн дагуу бэлтгэж танилцуулсан зохион байгуулалт, аргачлалдаа аливаа нэмэлт өөрчлөлт оруулахаар бол тэдгээрийг хэрэгжүүлэхээс өмнө Захиалагчийн инженерт дэлгэрэнгүй байдлаар нарийвчлан танилцуулна. Хэрвээ Гүйцэтгэгч, байнгын ажлын зарим хэсгийг ажлын цагаас бусад үед хийж гүйцэтгэх хүсэлтэй бол, тэдгээрийг хянах боломжоор хангах үүднээс, нэгээс доошгүй хоногийн өмнө Захиалагчийн инженерээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

1.9 ТӨСЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөнхий гүйцэтгэгч нь бүх ажлын чанарын хариуцлагыг дангаараа хүлээнэ. Мөн төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгагдсан чанарын хяналтын арга хэмжээнд бүхэлд нь хяналт тавих, хариуцлага хүлээх чадвартай, дадлага туршлагатай хүнийг Захиалагчийн инженерээс зөвшөөрсөн үндсэн дээр гэрээний дагуу чанарын хяналтын менежерээр ажиллуулахаар томилж, төслийн менежерийн шууд удирдлага, хяналтын дор ажиллуулна. Чанарын хяналтын менежер нь чанарын хяналттай холбоотой бүх үйл явц ажиллагаануудыг хянах ба зохицуулах эрх бүхий хүн байх ба ажлаа төслийн менежерт шууд тайлagnana.

Ерөнхий гүйцэтгэгч нь гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичгийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор буюу Гэрээнд гарын үсэг зурсанаас хойш 21 хоногийн дотор Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөгөө Захиалагчийн инженерт танилцуулан хянуулж батлуулна. Гэрээний нөхцлийн дагуу ажил эхлэх зөвшөөрөл олгосноос хойш гэрээнд заагдсан хугацаанд Гүйцэтгэгч эцсийн байдлаар батлагдаж гарын үсэг зурагдсан 3 хувь төлөвлөгөөг Захиалагчийн инженерт хүргүүлнэ.

Ерөнхий гүйцэтгэгч нь төслийн чанарын баталгаа. Чанарын хяналтын төлөвлөгөөг боловсруулж Захиалагчийн инженерээр баталгаажуулна. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг бүхэлдээ Захиалагчийн инженерийн тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд боловсруулна. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг баталсан ч гэсэн Гэрээний нөхцлүүдийн бүх заалтууд хүчин төгөлдөр үйлчлэх ба энэхүү техникийн шаардлагын дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг баталгаажуулах үүднээс Захиалагчийн инженер шаардлагатай гэж үзвэл, Гүйцэтгэгчийг Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх талаар шаардах, зааварлах эрхтэй.

Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөнд тусгасан туршилт, шинжилгээ хийх хуваарь нь шинжилгээнүүдийг барилгын ажлын гол үе шаттай уялдуулан бэлтгэж, хугацаа алдалгүйгээр цаг тухайд нь хийх, шаардлагатай мэдээллийг өгөх боломжтой хийгдсэн байх ёстой.

ЗАХИАЛАГЧ

Б.Чорлижав

64

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Чорлижав

Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих хугацааны туршид энэхүү техникийн шаардлагын заалтуудыг бүрэн ханган ажиллаж байгааг Захиалагчийн инженерт батлах мэдээ баримтаар хангах явдал юм. Төслийн чанарын хяналтын төлөвлөгөөг бэлтгэхдээ Ерөнхий гүйцэтгэгч дараахи зүйлүүдийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- Ерөнхий гүйцэтгэгч, тухайн ажлыг хянаж, шалгахад шаардагдах зохион байгуулалтын арга хэмжээг авах боломжийг Захиалагчийн инженерт олгохуйц хангалттай хугацааны өмнө, түүнд бүрэн хэмжээний мэдэгдлийг урьдчилан бичгээр ирүүлэхээс нааш уг ажлыг хийхгүй,
- Ерөнхий гүйцэтгэгч нь хянах ажлыг урьдчилан зохион байгуулах боломж олгох үүднээс ажлын аль нэг хэсэгт ажил гүйцэтгэх гэж байгаа тухай хүсэлтээ 48 цагаас доошгүй хугацааны өмнө Захиалагчийн инженерт бичгээр мэдэгдэнэ.

1.10. ХЭМЖИХ НЭГЖ, ТОВЧИЛСОН ҮГС

(а) Хэмжих нэгж

Хэмжих нэгжийн тэмдэглэгээнүүд нь BS 5775 (ISO 31/1)-д өгөгдсөн SI \СИ\ системийн дагуу байх ба тэдгээрийн ердийн товчилсон үгсийг дор жишээ болгон үзүүллээ. Харгалзах нэгжийн талаар бичиг баримтуудад дурдсан байвал, адил SI \СИ\ нэгжүүдийг орлуулна.

$\mu\text{м}$	микрон = $\text{м} \times 10^{-6}$
мм	миллиметр
м	метр
км	километр
мм^2	хавтгай дөрвөлжин миллиметр
м^2	хавтгай дөрвөлжин метр
км^2	хавтгай дөрвөлжин километр
га	гаектар
м^3	шоо метр
л	литр
рад	радиан
с	секунт
$^\circ\text{C}$	Цельсийн хэм
кг	килограм
г	грамм = $\text{кг} \times 10^{-3}$
мг	миллиграмм = $\text{кг} \times 10^{-6}$
мг/л	литр дэх миллиграмм
т	тонн = $\text{кг} \times 10$
$\text{кг}/\text{м}^3$	нэг шоо метрт оногдох килограм
$\text{т}/\text{м}^3$	нэг шоо метрт оногдох тонн
Н	Ньютон
$\text{Н}/\text{м}^2$	нэг хавтгай дөрвөлжин метрт оногдох Ньютон
Па	Паскаль = 1 Н/м
МПа	мегапаскаль = $\text{Па} \times 10^6$
Ж	Жоуль
Вт	Ватт

Кв	Киловатт
А	Ампер
В	Вольт

1.11 СТАНДАРТ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорхи товчилсон үгсийг ашиглав:

MNS	Монголын үндэсний стандарт
AASHTO	Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)
ASTM	Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг
BS	Британы стандарт
ISO	Олон улсын стандартчиллын байгууллага

Эдгээр стандарт техникийн шаардлагууд болон тэдгээртэй адил төстэй бусад бүх зөвшөөрөгдсөн техникийн шаардлагуудын нэг хувилж бүрэн багцыг Гүйцэтгэгч өөрийн хэрэгцээнд зориулан талбай дахь ажлын байрандаа хадгалж ашиглана.

1.12 БУСАД ГҮЙЦЭТГЭГЧ

Төслийн ажилтай холбоотойгоор ажлын талбайд болон ойролцоо ажиллаж байгаа бусад гүйцэтгэгчийг Захиалагчийн инженерт мэдэгдэнэ. Захиалагчийн ба гуравдагч этгээдийн өмч мөн бишээс үл хамааран, нөгөө талаар Захиалагчийн инженерийн зүгээс уг ажлыг Гүйцэтгэгчид хариуцуулсан, эсэхээс үл хамааран гэрээний нөхцлийн дагуу Гүйцэтгэгч нь аливаа ажилд ямар нэг байдлаар хөндлөнгөөс оролцох ёсгүй. Гүйцэтгэгч нь бусдын хийсэн ажил, ханган нийлүүлсэн болон талбайд барьж суурилуулсан зүйлсийг хүндэтгэж үзэх бөгөөд Гүйцэтгэгчийн өөрийн буюу түүний ажиллагсадын, эсвэл туслан гүйцэтгэгчидийнх нь буруугаас тэдгээр зүйлс алдагдсан, эвдэрсэн тохиолдолд хариуцлагыг хүлээнэ.

1.13 АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ

Гүйцэтгэгч барилгын ажилтай уялдуулан өөрийн ажилтан, ажилчдыг ажлын талбай руу болон талбайгаас зөхөн зардалд, гадаадын мэргэжилтэнгүүдийг оролцуулан, гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүйгээр, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, элсүүлэх, ажлын талбай руу болон талбайгаас нааш цааш зөөвөрлөхөд зарцуулах бүх зардлыг төсөвтөө тооцож оруулна.

1.14 ТҮР БАРИЛГА

Гэрээнд гарын үсэг зурсаны дараа, ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч, түр барилгын талаар хийхээр төлөвлөж буй ерөнхий зохион байгуулалтыг харуулсан нарийвчилсан зургийг Захиалагчийн инженерт танилцуулна. Гүйцэтгэгч, доор дурдсан зүйлсийг агуулсан, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдаагүй, бүрэн мэдээллийг гаргаж өгнө.

Үүнд:

- Тооцоо
- Диаграм,

ЗАХИАЛАГЧ

- Түр барилгын ажлыг хэрхэн гүйцэтгэхээр төлөвлөж буйг харуулсан танилцуулга,
- Гадаслагааны тухай мэдээлэл,
- Бусад холбогдох мэдээлэл.

Бүх түр барилгын ажлуудыг Захиалагчийн инженерийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч, гэрээний нөхцөлүүдийн дагуу нийт ажлыг хийж гүйцэтгэхэд түр барилгын ажлууд нь хэрхэн түүний хөтөлбөртэй уялдаж байгаа талаар нотлон харуулна. Түр барилгудыг барих, тэдгээрийн аюулгүй байдал, засвар арчлалт, ажил дууссаны дараа тэдгээрийг буулгах, ажлын үеэр ашигласан тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүд гэх мэт түр ажилтай холбоотой зүйлсийн хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээнэ. Гүйцэтгэгчийн болон түүний туслан гүйцэтгэгчийн түр барилгын ажилтай холбоотой гаргасан саналыг Захиалагчийн инженерээс зөвшөөрсөн аливаа зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийг гэрээний дагуу хүлээх үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

1.15 БАРИЛГЫН АЖИЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

Барилгын ажлын үед дараахи ерөнхий шаардлагууд тавигдана. Үүнд:

- Гүйцэтгэгч шөнийн цагаар ажил гүйцэтгэх тохиолдолд хангалттай гэрлээр хангах ба Захиалагчийн инженерт ажлын явцыг ажиглах, хянах, материалын шинжилгээ, туршилт хийх нөхцлөөр хангах үүднээс нэмэлт гэрэлтүүлэг суурилуулж өгнө.
- Ажлын талбайд нөөцлөн бэлтгэсэн буюу шаардлага хангасан материалыг зөвхөн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ашиглана.
- Гүйцэтгэгч ажлын талбайн ойр орчмын барилга байгууламжид хүрэх замыг гэрээний нийт хугацааны туршид тогтмол арчилж аюулгүй байдлыг хангана.
- Гүйцэтгэгч, тэсрэх, дэлбэрэх болон цацраг идэвхит материалыг тээвэрлэх, хадгалах, ашиглахдаа Засгийн газрын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- Гүйцэтгэгч, ажлын талбайд болон түүний ойр орчны газар, хөрс, зам болон бусад газруудыг бохирдуулахаас сэргийлэх ба ажлыг хэрэгжүүлж байх явцад үүсч болзошгүй аливаа хүндрэлтэй асуудал, саад бэрхшээл зэргийг багасгахад чиглэсэн шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тэдгээр хүндрэлтэй асуудлыг нэгэнт үүссэний дараа багасгах биш, харин гарахаас нь өмнө хянаж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байна. Аливаа ажил ба бусад бүх холбогдох үйл ажиллагаануудыг Монгол улсад дагаж мөрдөгдж буй бүх хууль тогтоомж, журмын (байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг оролцуулан) шаардлагуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Зам барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гэж Захиалагчийн инженер үзэж зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа мод, бут, бусад өвс ургамалыг отолж, тайрч зайлуулахгүй. Гүйцэтгэгч барилгын ажил гүйцэтгэж буй ажиллагсаддаа байгалийн нөөц баялаг, ан амьтдыг хайрлан хамгаалах талаар зааварчилгаа өгсөн байна. Ан хийх ба зөвшөөрөлгүй загасчлах явдалыг хориглох ба энэ талаар Гүйцэтгэгч нь баталгаа гаргана.
- Гүйцэтгэгч дараахи зүйлүүдтэй холбогдуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Үүнд:
 - ✓ Гол горхи, усны урсац, нуур болон бусад адил төстэй зүйлсийг Захиалагчийн инженерийн зөвшөөрөлгүй гео-нэхмэл эдлэл буюу өөр

бусад аргыг ашиглан лаг шаврын хаалт хийж, үерт автых, эрэг ёроол нь угаагдах, ус бохирдооос сэргийлэх, тэдгээрийн чанар, харагдах байдалд сэргээр нөлөөлөхгүй байх, хүн, амьтан, ургамлыг гэмтээх, үхэлд хүргэхгүй байхтай холбогдуулсан арга хэмжээ,

- ✓ Усан хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс, мөн усны чанарт муугаар нөлөөлж, түүнийг бохирдуулахаас сэргийлэхийн тулд гүний усны нөөцтэй (шүүсэн усыг оролцуулан) холбогдуулсан арга хэмжээ.
- f) Ажлыг гүйцэтгэх явцад гарсан хаягдал материал буюу лаг шаврыг ойролцоо газарт зайлцуулах, шаардлагатай бол Гүйцэтгэгч тэдгээрийг зөвшөөрөгдсөн хаягдал материал зайлцуулах газарт зөөн хаяж, тухайн газрыг анхны байдалд нь оруулан нөхөн сэргээх ажлыг Инженерийн тавьсан шаардлагыг хангахуйц хэмжээнд өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.
- g) Гүйцэтгэгч нь чулууны орд газарт олборлолт хийх, чулуу бутлах, бетон зуурах, цутгах г.м болон Гүйцэтгэгчийн бусад үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх тоос шороо, бохирдлыг (гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй,) багасгах үүднээс тунгаагуур болон бусад байгууламжийг барьж, ашиглах ба ажил дууссаны дараа буулгана. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэгчийн гаргах санал нь энэхүү техникийн шаардлагын зүйл 114-ийн шаардлагыг хангаж байх ёстой. Бүх бохир ус болон бусад хаягдал шингэнийг ямар нэг бохирдол үүсгэхгүй байдлаар зайлцуулна. Гүйцэтгэгч, ажлыг хэрэгжүүлэх үед гарсан аливаа хаягдал материалыг Захиалагчийн инженер буюу эсвэл холбогдох байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гол, горхи, нуур, цөөрөмд хаяхгүй.
- h) Гүйцэтгэгч ажилдаа тоосжилт болон агаараар тархдаг хорт хийг багасгахад чиглэгдсэн арга ажиллагааг мөрдөж ажиллана. Тоосжилт үүсч болзошгүй тохиолдолд ус шүрших арга хэмжээг авна. Нөөц материал, хаягдал материалын овоолгыг өөр тийш нь ачиж зөөхөөс өмнө норгож чийглэх тухай зааврыг Захиалагчийн инженер өгч болно. Захиалагчийн инженерийн зүгээс тоосжилт үүсгэж болзошгүй гэж үзсэн бүх материалыг өндөр хашлагатай тэвш бүхий машинаар тээвэрлэн зөөнө. Иймэрхүү материалыг машины тэвшний хашлаганаас илүү гаргалгүй ачиж цэвэрхэн брезентээр тэвшний талууд болон арын хаалтнаас дор хаяж 300 мм илүү гарган унжуулж сайтар хучна.
- i) Гүйцэтгэгч буюу түүний туслан гүйцэтгэгчид, материал, үйлдвэр заводын ханганд нийлүүлэгчдийн машин техникийн ашиглаж буй ажлын нэг хэсэг болох бүх хуучин замууд болон адил төстэй замууд дээрх тэдгээр машин техникийн явалтаас үссэн тоос/шавар буюу бусад гадны биетийг тогтмол цэвэрлэнэ.
- j) Шатахууны агуулах ба машин техникийг цэвэрлэх газар нь ойр хавийн сайд, гол горхиноос хамгийн багадаа 300 м-ийн зайд байрласан байна.
- k) Бетон хольц бэлтгэх завод, чулуу бутлуур зэргийг суурин газар, газар тариалангийн талбай, үйлдвэр, аж ахуйн газруудаас хангалттай хол зайд суурилуулна. Боломжтой бол тэдгээрийг ойролцоо суурин газруудаас 1.0 км-ээс доoshгүй зайд суурилуулна.
- l) Гүйцэтгэгч ажлыг төлөвлөх ба хэрэгжүүлэхдээ, хүрээлэн буй орчинд нөлөөлөх дуу чимээний холбогдолтой, Монгол улсад мөрдөгдөж байгаа шаардлагуудыг судалж үзсэн байна. Гүйцэтгэгч бүх дуу чимээ намсгагч төхөөрөмжүүдийг ашиглалтын бэлэн байдалд байлгах ба ажлыг гүйцэтгэж байх явцад дуу чимээний нөлөөллийг багасгах бүх шаардлагатай арга хэмжээг авна.

- m) Гэрээний нөхцөлд дурдсан шаардлагуудаас гадна Гүйцэтгэгч, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх хууль, дүрэм, зарлиг, тогтоол, журам, шийдвэрүүд болон бусад хуулийн механизмуудын талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд эдгээр нь доорхи зүйлсээс бүрдэх боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд :
- ✓ Техникийн шаардлагын нэмэлт,
 - ✓ байгаль орчин,
 - ✓ эрүүл мэнд, аюулгүй байдал,
 - ✓ ажил олголтын байдал гадаадын мэргэжилтнүүдийг оролцуулан,
 - ✓ сургалт,
 - ✓ татвар, хураамж, төлбөр ба бусад,
 - ✓ түр ба байнгын барилга байгууламж,
 - ✓ түр суурин,
 - ✓ ариун цэврийн байгууламж ба усан хангамж.
- n) Ажлын талбай ба түр сууринд Гүйцэтгэгчийн барьсан бүх барилгууд, тэдгээрийн орчны болон талбайн ерөнхий байдал нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд болон ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдолтой тухайн орон нутгийн бүх дүрэм, журмын шаардлагыг хангах ба гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүй.
- o) Хүмүүсийн амьдрах бүх байр сууцнууд нь бат бөх, цаг агаарын ямар ч нөхцөлд тэсвэртэй байгууламжууд байх ба шаардлагатай зүйлсээр тоноглон засвар арчлалтыг тогтмол хийж ашиглахын зэрэгцээ цэвэр байх нөхцлийг бүрдүүлнэ. Оршин суугчдын ая тухтай, аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагатай бол хангалттай халаалт, гэрэлтүүлэг, агааржуулагч, дулаалга зэргийг хангана.
- p) Барилгын түр суурин нь ойролцоо суурин газраас 200-аас 500 м-ээс хол зайд байрлана. Ажиллагчдын амьдрах байр сууц, бусад байгууламжуудыг стандартын дагуу барьж байгуулан, арчилна.
- q) Түр суурин байгуулах газрууд нь үерт автхаарагүй байх ёстой бөгөөд намаг болон бусад гадаргын ус хуримтлагддаг газруудаас хамгийн багадаа 75 м хол зайд байрлана.
- r) Түр сууринг, түүнээс гарч буй болон түүний дундуур явсан шуудуунууд нь тэр хавийн болон нийтийн усан хангамжийн системд аюул учруулахаарагүй газарт байгуулна.
- s) Хэрвээ өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх байгалийн гаралтай болон тохиromжтой материалын эх үүсвэрүүд нь ажлын талбайд байсан байгаагүйг үл харгалзан, тэдгээрийн байршлыг тогтоох, ашиглалтын зөвшөөрөл, орд газрын лиценз ба ус ашиглах эрх гэх мэт шаардлагатай бүх зөвшөөрлийг авах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.
- t) Хэрвээ Гүйцэтгэгч, ажлын талбайн орчинд радио холбоогоор хангах тохиолдолд, тэдгээр төхөөрөмжийг ашиглах нөхцөл боломжоор Захиалагчийн инженерийг хангана. Зөвхөн Захиалагчийн инженерийн хэрэгцээнд хангах холбооны төхөөрөмжийн хангалтын шаардлагуудыг энэхүү техникийн шаардлагад заасан болно.
- u) Гүйцэтгэгч нь, ажлын талбайн эргэн тойронд шаардлагатай хаалт, хашаа хийж, засаж хамгаалан ажил дууссаны дараа буцааж буулгах ба Захиалагч, Захиалагчийн инженер, бусад гүйцэтгэгчид болон ажлын талбай руу орох эрх бүхий бусад хүмүүсийн аюулгүй байдлыг зохих байдлаар хангах бөгөөд өөрийн хулээсэн

бусад үүрэг хариуцлагад ямар нэг хор хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх ёстай.

v) Гүйцэтгэгч нь түр барилгын тохиромжтой болоод аюулгүй байдал, харуул хамгаалалтын болон шаардлагагүй болсон үед тэдгээрийг буулгах хариуцлагыг бүхэлд нь дангаараа хүлээнэ. Түр барилгын ажилд дараахи зүйлс багтах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- ✓ агуулах, бетон эдлэлийн талбай,
- ✓ тулгуур шон, гадаснууд,
- ✓ тавцан, трап, шат, угсралтын/дамжуурга шат,
- ✓ хэв хашмал, вандан шат,
- ✓ далан, усны хаалт, кессон (ус тусгаарлах хорго),
- ✓ шпунтэн тулгуур, тулаас хийх, нүх ухах,
- ✓ хашаа,
- ✓ бусад холбогдох ажлууд гэх мэт

орох ба үүнээс гадна Гэрээг хэрэгжүүлж, ажлыг гүйцэтгэхэд зориулагдсан буюу угсарч ажиллуулсан Гүйцэтгэгчийн өөрийн тоног төхөөрөмжтэй холбогдолтой түр барилгүүд байж болно. Энэхүү заалт нь ажлыг гүйцэтгэх зорилгоор буюу түүнтэй холбогдуулан Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгчдийн хангаж, угсарсан тоног төхөөрөмжтэй холбоотой бүх түр барилгын ажлуудад хамаарна.

- a) Гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгчдийн түр барилгын ажлууд, тэдгээрийн холбогдолтой аливаа зургуудыг Захиалагчийн инженер хянаж шалгах нь Гүйцэтгэгчийг гэрээний заалтуудын дагуу түүнд оногдсон аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй.
- b) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас болон бусад шалтгаанаар түр зогсоовол талбайд байгаа бүх барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зогсолтын бүх хугацааны турш харж хамгаалан, түүнийг үйл ажиллагаагаа дахин эхлэх үед шууд ашиглахад бэлэн байлгах үргийг хүлээнэ. Гэрээний нөхцлийн дагуу, зогсолтын хугацааны турш ажлын талбайг харж хамгаалах үүрэг, хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.
- c) Хэрвээ, барилгын ажлын явцад, археологийн чанартай малтмал, зоос, олдвор олдсон тохиолдолд Гүйцэтгэгч нь Монгол улсын засгийн газрын холбогдох байгууллагуудад яаралтай мэдэгдэх ба тэдгээр олдворуудыг Монгол улсын өмч болгож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээг авна. Гүйцэтгэгч нь соёл, шашны холбогдолтой аливаа барилга байгууламжид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах явдлыг баталгаажуулна.

1.16 УС, ЦАС, МӨС, ЭЛСНИЙ ХАМГААЛАЛТ БОЛОН СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ

Хэрэв өөрөөр заагаагүй бол, гол, ус, гүний булаг, хур тунадас болон бусад эх үүсвэрээс юмуу ямар нэг шалтгааны улмаас үүссэн ус, цас, мөсийг хэрхэх асуудлыг Гүйцэтгэгч хариуцна. Ус гаргах ба усны чигийг өөрчлөхдөө бусад ажил ба байгууламжуудыг үерт автуулж, эвдэлсэнээс үүдэн элэгдэлд орох, ус бохирдоогоос зайлсхийнэ.

Гүйцэтгэгч, ажлыг бүхэлд нь ус, цас, мөс, элсэнд дарагдахаас хамгаалж, энэ зорилгоор далан, усны хаалт, насосны төхөөрөмж, тулгуур, тулаас, ус зайлзуулах түр байгууламж, худаг, хайс барьж, цас цэвэрлэгч зэргээр хангана. Байнгын ажлыг эхлэхийн өмнө

Гүйцэтгэгч газрын гадаргууг ус, цас, мөснөөс зохистойгоор хамгаалахад шаардагдах ус зайлуулах байгууламж, шуудуу барих, нүх ухах ажлууд болон бусад арга хэмжээг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Барилгын ажлын үед гүйцэтгэгч, элэгдэл, суулт үүссэнээс шалтгаалж ямар нэг увдэрэл үүсэх, элс шуурч урьд хийсэн ажлыг дарж булахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ. Энэхүү урьдчилсан сэргийлэх арга хэмжээнд шуудууны налуу дээрх түр тавцан, угаагдалтыг шалгах, чулуун асгаас хийх болон барьж буй замаас тодорхой зайнд, салхины зонхилох чиглэлд шороон далан хийх, түр хайс барих зэрэг ажлууд байж болох ба гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй. Гол горхи, ус юмуу Захиалагчийн инженерийн заасан бусад ус зайлуулах байгууламжийн ажилд саад болохооргүй газарт хаягдал болон нөөц материалыг буулгана. Гүйцэтгэгч эдгээр урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг аваагүйгээс шалтгаалан ажил болон ойролцоо байгууламж, өмч хөрөнгө эвдээр сүйдсэн тохиолдолд тэрээр өөрийн зардлаар хохирлыг барагдуулна.

Төмөр замын барилгын ажлын үед Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг Монгол улсын соёлын өвийн тухай хууль /2001 он/, түүнд холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна. Төмөр замын барилгын ажлын үед хамгаалах соёлын өвд замын трасс, ашигт малтмал ашиглах карьеер орчмын хөшөө дурсгал, хүн чулуу, эртний хотын туурь, эртний хүмүүсийн бууц, булш, хиргисүүр, зан үлийн байгууламжууд зэргийг хамруулж авч үзнэ. Замын трасс, карьеерт өртөгдөх байдлыг харгалзан авран хамгаалах малтлага хийх, шилжүүлэх арга хэмжээг трассын голын цэгээс 25-50 м-т байгаа соёлын өвд, төмөр замын барилга байгууламжийн үйл ажиллагаанд өртөхөөс хамгаалах арга хэмжээг трассын голоос 25-50 м-т байгаа соёлын өвд хамруулна. Түүнчлэн карьеерт 50 м –т ойр байгаа соёлын өвийг уг арга хэмжээнд хамруулна. Төлөвлөж буй замын трасст өртөж буй соёлын өвд Монгол улсын соёлын өвийн тухай хуулийн 6-р бүлгийн 17.10-д заасны дагуу мэргэжлийн байгууллагаар /трасс дагуу өмнө нь тандан судалгаа хийсэн ШУА-ийн Археологийн хүрээлэн/ авран хамгаалах малтлага хийх, шилжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр зам барилгын ажил эхлэхийн өмнө гүйцэтгүүлнэ. Соёлын өвийг хамгаалах талаар мэргэжлийн зөвлөмж авч хэрэгжүүлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд соёлын өвийг хамгаалах талаар заасан арга хэмжээг барилгын ажлын үед бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

1.17 ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АВААР ОСОЛ

Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах эрхтэй бүх хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллыг хангахад шаардлагатай бүх урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд Монгол улсад буюу тухайн орон нутагтмердөгддөг хууль тогтоомжийн шаардлагуудаас гадна, Захиалагчийн инженерийн бодлоор ажлын талбайд зөвшөөрөлгүй орсон гадны хүмүүс, мөн Гүйцэтгэгчийн хяналтын дор хийгдэж буй аливаа үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийг хамгаалах зэрэгт мөрдөх шаардлагатай гэжүзсэн бусад арга хэмжээнүүд орно. Гүйцэтгэгч дараахи хариуцлагыг хүлээх ба гэхдээ зөвхөн эдгээр хязгаарлагдахгүй:

- Аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмжөөр хангаж, засвар арчлалтыг хийх, ажлын талбайд ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндэд аюул, эрсдэл учруулахааргүй ажлын аргыг мөрдөж ажиллах.
- Ажилд ашиглагдах бодис, бусад зүйлстэй харьцах, тэдгээрийг хэрэглэх, хадгалах, тээвэрлэх, хаяж зайлуулахтай холбоотойгоор аюулгүй байдлыг хангах,

эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй Захиалагчийн инженерийн зөвшөөрлөөр, шөнийн ээлжинд хийж гүйцэтгэх ажлын аюулгүй байдлыг баталгаажуулах үүднээс хангалттай хэмжээний гэрэлтуүлэг болон цахилгаан тасарсан үед ажиллуулах нөөц /аваарын/ гэрэлтуүлгийн төхөөрөмжөөр хангана.

- c) Захиалагчийн инженер, талбайн ажилтан, ажиллагсад болон ямар нэг байдлаар ажилтай холбогдон ажлын талбайд орж ирж буй бүх хүмүүсийн ажлын талбайд ажиллах үеийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад шаардагдах хамгаалалтын хувцас, аюулгүй ажиллагааны багаж төхөөрөмжөөр хангаж, энэ талаар мэргэшсэн хүнийг ажиллуулан, үүнтэй холбоотой мэдээлэл, зааварчилгааг өгч, сургалт зохион байгуулах, хяналт тавих ажлуудыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу хийнэ.
- d) Эдгээр аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэлд дараах зүйлс багтах ба гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:
 - ✓ малгай каск
 - ✓ хамгаалалтын гутал
 - ✓ нүдний хамгаалалтын шил, гагнуурын нүдний шил
 - ✓ чихний хаалт
 - ✓ хамгаалалтын тоноглол
 - ✓ гэрэл ойлгогч хантааз
 - ✓ усан дээр ажиллахад зориулагдсан хамгаалалтын багаж
 - ✓ аврах хэрэгсэл
 - ✓ гал унтараах багаж хэрэгсэл гэх мэт
- e) Талбайд ажиллах бүх хүмүүс хамгаалалтын малгай гутал өмсөнө.
- f) Талбайн бүх газрууд руу ямар нэг аюул, эрсдэл буюу бэртэл гэмтэлгүйгээр хүрч очих туслах зам барьж тогтмол засвар арчлалт хийж байна.
- g) Ажил гүйцэтгэх явцад бүхэлд нь Захиалагчийн тавьсан шаардлагыг хангах хэмжээний сайтар тоноглогдож, зохих мэргэжилтнээр хангагдсан анхны тусламж үзүүлэх цэгийг ажиллуулна. Мөн талбайн хамгаалалт аюулгүй ажиллагаатай холбоотой бүхий л арга хэмжээг авч, бусад шаардагдах зүйлсийг өртөг зардалдаа оруулж тооцох ба үүнтэй холбогdon үссэн бүх хариуцлагыг Гүйцэтгэгч өөрөө хүлээнэ.
- h) Гэмтэж бэртсэн хүнийг хамгийн ойр эмнэлэгт хүргэж өгөх тохиромжтой тээврийн хэрэгсэлийг хангаж, байнгын бэлэн байдалд байлгана.
- i) Эрүүл мэнд аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалалтын бүх асуудлыг хариуцан ажиллах нэг хүнийг, төслийн удирдагч сонгож, аюулгүй ажиллагааны мэргэжилтнээр томилон, өөрийн бүрэн хяналтан доор ажиллуулна. Хөдөлмөр хамгаалалтын мэргэжилтэн нь ажиллах хүчиний хөдөлмөр хамгаалалд нөлөөлж буй бүх зүйл болон хөдөлмөр хамгаалалтыг сайжруулах бүх арга хэмжээнд оролцох төдийгүй үүнтэй холбоотой бүхий л заавар зааварчилгааг эрх бүхий байгууллагуудаас хүлээн авах, авсан даруйдаа биелүүлэх эрх бүхий этгээд байна.
- j) Барилгын ажлын талбай дахь бүх байр сууц, ажлын байр, засварын газар, лаборатори, хяналтын байр, агуулах зэрэгт зориулан ариун цэврийн байгууламж, ашиглах ажлуудыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль журам, тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн дагуу Инженерийн шаардлагыг хангах хэмжээнд хийх ба эрүүл мэндэд хор хохирол учрах, агаар, ус,

ойролцоо гол горхи бохирдуулах явдал гаргуулахгүй ажилана.

- k) Түр суурингуудад хогийн сав байрлуулж, тэдгээрийг тогтмол цэвэрлэж байх, хог хаягдлыг холбогдох дүрэм журмын дагуу эрүүл ахуйн шаардлага хангах хэмжээнд зайлцуулна.
- l) Гүйцэтгэгч, ажил дууссаны дараа өөрийн зардлаар Захиалагчийн инженерийн тавьсан шаардлагын хэмжээнд бүх түр байгууламжуудыг буулган, хог хаягдлыг шатаан, бохирын сав болон нүх, жалгыг буцааж булан, сайтар хааж, гаднах талбайг бүхэлд нь цэвэр цэмцгэр болгоно.
- m) Ажил явагдаж буй газарт хангалттай тооны бие засах газар ба бусад ариун цэврийн байгууламжуудыг барьж байгуулан тэдгээрийг Захиалагчийн инженерийн болон тухайн орон нутгийн нийтийн эрүүл мэндийн эсуудал эрхлэх албаны тавьсан шаардлагыг хангах хэмжээнд, эрүүл ахуйн нөхцлийн дагуу тогтмол цэвэрлэж, ариутгаж байна.
- n) Олон гэр бүл нэг дор амьдардаг газар болон хуаран маягийн байгууламжтай газруудад нийтийн жорлонтой бол хүйс бүрт зориулсан тус тусдаа өрөөтэй барина. Эдгээр тасалгаануудын хаалган дээр „эрэгтэй,, „эмэгтэй,, гэсэн тод тэмдэглэгээ хийх буюу амархан ойлгогдох зураг, тэмдэг наасан байна. Хэрвээ эдгээр хүйс тус бүрт зориулсан бие засах газрууд нь нэг байшинд байвал тэдгээрийг шалнаас тааз хүртэл өндөр хатуу ханан хаалт хийж тусгаарлана.
- o) Олон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан удирдах хүмүүстэй харилцан зөвлөлдөж, ажлын талбай, ажилчдын байр, түр суурин доторхи шумуул, ялаа, хортон шавьж, амьтан зэргийг устгах шаардагатай арга хэмжээг авна.
- p) Хүний амь хохирсон буюу хүнд гэмтсэн, улмаар үүнээс болж эмнэлэгт хүргэгдэж турваас дээш хоногоор хэвтсэн тохиолдолд Захиалагчийн инженерт яаралтай мэдэгдэнэ. Эхний үед ийм мэдээллийг амаар хүргэж болох ба болсон явдлын дараа 24 цагийн дотор Гүйцэтгэгч дэлгэрэнгүй тайланг бичгээр бэлтгэж танилцуулна. Иймэрхүү ноцтой аваар ослын талаар хуулийн байгууллагад мэдэгдэхтэй холбоотой аливаа шаардлагыг Гүйцэтгэгч дагаж мөрдөнө.
- q) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал болон эд хөрөнгийн эвдрэл гэмтэлтэй холбоотой аливаа бусад аваар осол, үйл явдлыг Гүйцэтгэгч бүртгэх ба аваар осол гарсан даруйд зохих маягтын дагуу бэлтгэсэн мэдээллийг Захиалагчийн инженер-д болон хуулийн байгууллагуудад танилцуулна.
- r) Хэрвээ Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа улирлын байдлаас болон бусад шалтгаанаар түр зогсоовол ажлыг аюулгүй байдалд орхиж байгаа эсэхийг баталгаажуулна. Тэрээр өөрийн төслийн удирдлагын багаас Захиалагчийн инженерийн хүлээн зөвшөөрөх нэг хүнийг зогсолтын үеийн хугацааны туршид хөдөлмөр хамгааллыг асуудлыг хариуцан ажиллуулахаар томилон, түүний нэр, холбоо барих утасны дугаарыг Захиалагчийн инженерт мэдэгдэнэ.
- s) Гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, мөн тэдгээрийн ажиллагсад, Гүйцэтгэгчээс талбайд байх эрх олгосон хүмүүс нь эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалалтай холбоотой хууль, дүрэм журмын заалтуудыг бүх талаар дагаж мөрдөнө.
- t) Энэ зүйлийн заалтууд нь Гүйцэтгэгчид хамаарахаас гадна, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийснээр түүний туслан гүйцэтгэгчид хамаарна. Гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгчидтэй байгуулсан гэрээнд эдгээр заалтууд орсон эсэхийг тэрээр баталгаажуулна.

1.18 ХАШАА, ХААЛГА БАРИХ, ХАРИУЦЛАГЫГ ХҮЛЭЭНЭ

Гүйцэтгэгч нь талбайд ажиллаж буй хүмүүс ба эд хөрөнгийн аюулгүй байдал болон барилгын ажлын үед талбайд мал, амьтан оруулахгүй байх зэрэг хариуцлагыг хүлээнэ. Ажлыг зохистой явуулахын тулд хуучин хашаа, хаалга зэргийг буулгах, зөөж барих, хэрвээ эзэн болон эзэмшигч нь уг хашаа, хаалгыг зайлцуулах буюу шилжүүлэх хариуцлагыг хүлээсэн ч тэдгээрт нөхөн төлбөр олгох заалт бүхий хоёр талын гэрээ байгуулаагүй бол Гүйцэтгэгч, мал, амьтан талбайд орохос сэргийлж тур хашаа, хаалга барьж, шаардлагатай бол харуул, манаач ажиллуулна. Ажлыг зохистой хэрэгжүүлэх үүднээс буулгах, зөөх шаардлагатайгаас бусад хашаа, хаалга зэргийг гэрээний хэрэгжилтийн нийт хугацааны туршид эвдлэхгүй, мал амьтан оруулахгүй байх талаар Гүйцэтгэгч өөрийн ажилчдад шаардлага тавьж ажиллана.

1.19 ТЭСРЭХ БОДИСЫГ ХЭРЭГЛЭХ

Гүйцэтгэгч, тэсрэх бодистой хэрхэн харьцах, тэдгээрийг хангах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэх талаарх Монгол улсын хууль, дүрэм, журмын хувийг өөрийн талбайн ажлын байранд байлгах ба тэдгээр хуулиудын нэг нэг хувийг Захиалагчийн инженерийн хэрэгцээнд өгнө. Гүйцэтгэгч, өөрийн ажилтан ажиллагсаддаа өгөх ямар нэг зааварчилгаа буюу мэдэгдэл, дээр дурдсан хуулийн дагуу гаргах ажлын талбайн талаархи мэдээллийн хувийг Захиалагчийн инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгч, хэрэглэхээр төлөвлөж буй тэсрэх бодисуудын талаарх мэдээлэл, хэрхэн хадгалах болон талбайд зөөверлөж авчрах тухай төлөвлөгөөгөө Захиалагчийн инженерт танилцуулна. Тэсрэх бодисыг Монгол улсын холбогдох хууль, дүрмийн дагуу хэрэглэнэ. Гүйцэтгэгч, Ажилд зориулагдсан тэсрэх бодисыг зөвхөн Захиалагчийн инженерийн зөвшөөрч болох цаг, газарт, батлагдсан аргачлал, тэсэлгээний ажлын паспортын дагуу хэрэглэх ба Захиалагчийн инженерийн энэхүү зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийг, тэсрэх бодисыг хэрэглэснээс үүдэн гарч болох ямар нэгэн осол эндэгдэл (хүн, амьтан гэмтэж бэртэх, тэдэнд ая таагүй байдал үүсгэх, саад болох, ажил, түүний ойролцоо болон зэргэлдээ барилга байгууламжууд, зам, газар, эд юмсыг гэмтээх г.м)-ийн төлөө хүлээх хариуцлагаас нь чөлөөлөхгүй.

Гүйцэтгэгч учирч болзошгүй аваар ослын хариуцлагыг хүлээх ба тэдгээрээс үүдэн гарах аливаа заргаас Захиалагчийн эрх ашгийг хамгаалж, нөхөн төлбөрийг олгуулна. Хүн, амьтан, ажил, эд хөрөнгө, газар, объектууд гэмтэх, эвдрэх, таагүй байдал үүсэх буюу аваар осолд өртөх магадлалтай байвал Захиалагчийн инженер тэсрэх бодис хэрэглэх асуудлыг зохицуулах, хориглох эрхтэй бөгөөд ингэсэн тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн эсрэг ямар нэг зарга үүсгэхгүй. Гүйцэтгэгч тэсэлгээ хийхээр төлөвлөх бүртээ урьдчилан анхааруулга өгөх ба аюултай бүсэд хүн, амьтан орж ирэх, хөдөлгөөн явахаас сэргийлж зам дээр болон өөр шаардлагатай газарт түг, бүрээ, шүгэл бүхий хүнийг зогсоож ажиллуулна. Гүйцэтгэгч тэсэлгээ хийхдээ гол замын орчимд зөвшөөрөгдхөн зайны доторхи хөдөлгөөнийг орон нутгийн цагдаагийн болон Замын Цагдаагийн байгууллагатай хамтран хянаж зохицуулна. Гүйцэтгэгчийн тэсэлгээний ажил хариуцсан хяналтын инженер нь Монгол улсын эрх бүхий байгууллагаас олгосон, шаардлагатай бүх төрлийн тэсэлгээг хийх эрхийн лицензтэй байх ба тэрхүү лицензийг Захиалагчийн инженерт танилцуулж баталгаажуулна.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженерийн болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангахуйцаар баригдсан, тохиромжтой газарт байрлах агуулахад тэсрэх бодисыг хадгална. Тухайн газарт “Тэсрэх аюултай” гэсэн тод хараар бичсэн тэмдгийг байрлуулна.

Гүйцэтгэгч бүх урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч, тэсрэх бодистой хэрхэн харьцах, хэрэглэх тухай мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөх ба тэсэлгээ хийх үед дагаж мөрдөх аргачлалыг тайлбарлан бичсэн самбарыг Захиалагчийн инженерийн шаардлагад нийцүүлэн бэлтгэж, талбайд байрлуулна.

Гүйцэтгэгч нь, шаардлагатай төвшингөөс илүү ухагдах, газарт ан цав үүсэх, нурах зэргээс сэргийлж, тэсэлгээ хийх нүхний тоо, байршил, чиглэл, гүн, хоорондын зайд, нэг нүхэнд хэрэглэх тэсрэх бодисын хэмжээ, төрөл болон тэсэлгээ хоорондын тасалдлын тоо, давтамж зэргийг сонгоно. Тэсэлгээ хийж, сүл материалыг зайлцуулсны дараа гадаргууг тэгш үлдээх үүднээс сүүлийн нүхнүүдийг ухалт хийх эцсийн төвшингөөс шаардагдах хэмжээгээр дутуу ухна.

Чухал ач холбогдол бүхий байгууламжийг хамгаалах үүднээс тэсэлгээ хийхийг хориглосон газарт болон авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн болон холбооны шугам зэргээс 400м-ээс дотогш зайнд тэсэлгээ хийх болвол Гүйцэтгэгч нь,

- Холбогдох байгууллагад тэдний эзэмшлийн газрын хүрээнд тэсэлгээ хийх гэж байгаа тухайгаа мэдэгдэж, тухайн байгууллагын төлөөлөгчийг байлцуулах зэргээр тэдгээрийн зүгээс тавьж буй шаардлагыг хангаж чадна гэдгээ баталгаажуулна,
- Захиалагчийн инженер ба холбогдох байгууллагын зөвшөөрөлтэйгээр, тэсэлгээнээс шидэгдэх шороо чулуунаас болж тэдгээр байгууламжид гэмтэл үүсгэхээс сэргийлэх үүднээс тэсэлгээ хийх газрыг бүтээх буюу зөвшөөрөгдсөн бусад аргаар хамгаалах,
- Тасалдалттай тэсэлгээ хийх байдлаар, эсвэл тэсэлгээнд хэрэглэх цэнэгийн хэмжээг хязгаарлах замаар аливаа байшин, барилга, байгууламжууд руу цацагдах чулуу шорооны шидэгдэлтийн хурдыг аль болох бага байлгахаар хянаж, зохицуулна,
- Тохиромжтой доргилт хэмжигчийг талбайд байлгах ба Захиалагчийн инженерийн хүсэлтээр хэрэглэхээр төлөвлөж буй цэнэг нь энэхүү техникийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг багажийг ашиглан үзүүлнэ.

Эдгээр хязгаарлалтыг Гүйцэтгэгчээс хэрэгжүүлж байгаа байдал болон Захиалагчийн инженерийн өгсөн аливаа зөвшөөрлийн аль нь ч тэсрэх бодис хэрэглэсэнээс шалтгаалан байшин, барилга байгууламжуудад учирсан хохирлын хувьд Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй. Дээр дурдсаныг үл харгалзан, Захиалагчийн инженер хүссэн тохиолдолд Гүйцэтгэгч, тэсэлгээ хийхээ зогсоож, бусад зөвшөөрөгдсөн аргуудыг хэрэглэн хадны ухалтыг үргэлжлүүлэн хийнэ.

Тэсэлгээний галыг цахилгаанаар асаах бол цагаасаа өмнө тэсрэлт явагдахаас сэргийлэн урьдчилсан арга хэмжээг авна. Хэрвээ цахилгаан дамжуулах шугамны ойролцоо тэсэлгээ хийх болвол цэнэгийг байрлуулахаас өмнө эрх бүхий хяналтын байцаагч тэсэлгээ хийх талбайд ямар нэг сүл цахилгаан гүйдэл байгаа эсэхийг шалгана.

Эрх бүхий хяналтын байцаагч ба нэг мэргэжсэн туслах ажилчин хоёроос бусад бүх

хүмүүс галын кабель үтсыг цахилгааны утсанд залгахаас өмнө аюулгүй газарт очно. Галын кабель үтсыг цэнэглэгчид залгах нь хамгийн сүүлийн ажил байна. Тэсэлгээ хийх газрын эргэн тойронд дуу цахилгаантай бороо орж, аянгатай байвал галын үтсыг цэнэглэхийг үл зөвшөөрнө.

Тэсэлгээ хийсний дараа эрх бүхий хяналтын байцаагч буюу бусад хариуцсан хүн тухайн газрыг шалгах, мөн цэнэг баарч тэсэлгээ хийгдээгүй бол урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авахаас нааш аюултай бус рүү ямар ч хүнийг оруулахгүй.

Гүйцэтгэгч, тэсэлгээ бүрийн тэсэлгээ хийх цаг, байршил, хэрэглэсэн тэсрэх бодисын төрөл, тэсэлгээний ажилд хэрэглэсэн бусад хэрэгслүүдийн хэмжээ, үлдэгдэл болон бусад холбогдох мэдээллийг агуулсан тэсэлгээний ажлын бүртгэл, тэмдэглэлийг нягт нямбай хөтлөх ба сар бүр тайлангаа Захиалагчийн инженерт танилцуулна. Өмнөх долоо хоногийн ажилтай холбогдуулан эдгээр бүртгэл тэмдэглэлийн хувийг долоо хоног бүр Захиалагчийн инженерт хүргүүлнэ.

Гүйцэтгэгч ажлынхаа төсөвт бүх тэсрэх бодисыг хангах, тээвэрлэх, хадгалах, тэдгээртэй харьцах, ухалт хийх, хяналт тавих болон энэхүү техникийн шаардлагын нөхцлүүдийг дагаж мөрдөхтэй холбоотой зардлыг оруулан, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүйгээр, тооцсон гэж үзнэ.

1.20 ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэгч, газар доор буюу дээр хийгдсэн аливаа Инженерийн байгууламж, шугам сүлжээг (цаашид Инженерийн байгууламж гэх) эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлагыг хүлээж, Захиалагчийн эсрэг гарсан аливаа зарга зардлаар хийж гүйцэтгэх хариуцлагыг хүлээнэ.

Хуучин Инженерийн байгууламжийн ойр орчмын газарт ухалтын ажил эхлэхээс өмнө болон энэ ажил нь Инженерийн байгууламжуудад нөлөөлөхүйц шинжтэй байвал, Гүйцэтгэгч, тэдгээр Инженерийн байгууламжуудыг эзэмшигч буюу тэдгээрийг ажиллуулж буй холбогдох байгууллагуудад мэдэгдэж, Захиалагчийн инженерийн заавраар, ажлаа үргэлжлүүлэхээс өмнө, тэдгээр байгууламжийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлахаар төлөвлөсөн өөрийн ажлын төлөвлөгөөгөө холбогдох байгууллагуудад танилцуулж зөвшөөрөл авна.

Гүйцэтгэгч, дараахи бүх Инженерийн байгууламжийн, гэхдээ зөвхөн тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр, байршил болон холбогдох эд ангиудыг нарийвчлан тогтоох үүрэгтэй. Үүнд:

- Бохирын шугам,
- Гадаргын ус зайлзуулах байгууламж,
- Цахилгаан, холбоо, гэрэлтүүлгийн кабель шугам, шилэн кабель,
- Өндөр хүчдэлийн цамхагийн шон, кабелийн суваг хоолой,
- Ус дамжуулах шугам,
- Дулаан дамжуулах шугам.

Тэдгээр Инженерийн байгууламжууд, шугам сүлжээг булж далдалсан байвал, Гүйцэтгэгч эзэмшигч байгууллагуудаас нь тэдгээрийн байршил, булсан гүн зэргийн талаарх мэдээллийг авна. Гүйцэтгэгч, цахилгаан ба цахилгаан соронзон багажийн аль тохиорохыг ашиглан гараар туршилтын нүх болон шуудуу ухах зэрэг аргаар цааш хайгуул хийнэ. Ил

гарсан Инженерийн байгууламж, шугам сүлжээг хэрхэх асуудлыг Захиалагчийн инженер ба холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж, шийдвэрлэнэ. Эрсдэлтэй байж болох Инженерийн байгууламжуудыг бүрэн ил гаргах ба гарсан ухмалыг нурахаас хамгаална. Ил гарсан шугам сүлжээг барилгын ажил эхлэхээс өмнө газар дээр нь сайтар хамгаална. Ажилтай залгаа суурилуулсан аливаа байгууламжийг ажлыг дуусах хүртэл газар дээр нь аюулгүй байлгах ба дараа нь аюулгүй, тогтвортой байдалд нь буцааж суурилуулна.

Барилгын ажил дууссаны дараа шугам, хоолой, кабель шугамыг шороогоор булах, дүүргэлт хийх, нягтрнуулна. Ухмал, буцаан дүүргэлт, дахин суурилуулах (шаардлагатай үед) зэрэг ажлыг зохих дүрэм, журмын дагуу эзэмшигч байгууллагуудын зааварчлага, хяналтын дор хийж гүйцэтгэнэ. Ажлын шаардлагын дагуухийсэн ухалтаас шалтгаалан замын гадаргуугийн эцсийн төвшинг өөрчлөх бол, тэдгээр хаалтын таг, худаг, үзлэгийн худагны тагуудын төвшин ба тэдгээрийн амсарыг Захиалагчийн инженерийн тавьсан шаардлагад нийцүүлэн тохирох байдлаар өөрчилнө.

Гүйцэтгэгч, зурагт үзүүлээгүй хэдий ч талбайгаас илрүүлсэн Инженерийн байгууламж, шугам сүлжээний талаар Захиалагчийн инженерт яаралтай мэдэгдэнэ. Хэрвээ, Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэн Инженерийн байгууламжид хохирол учирч магадгүй байвал, Захиалагчийн инженерийн зүгээс эдгээр хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс засварлаж болох аливаа арга хэмжээг Гүйцэтгэгч авна.

Өндөр хүчдэлийн цахилгааны шугам нь кран болон бусад овор ихтэй техник хэрэгслийн эд ангиар дамжин газарт богино холбоо үүсгэх аюултай тул Гүйцэтгэгч нь цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын ойролцоо ажиллаж буй бүх хүмүүст аюулгүй зайн баримтлан ажиллах ёстойг таниулж зааварчлага өгсөн байна. Хүснэгт 1-1, 1-2-т өндөр хүчдэлийн дамжуулах шугам ба нам хүчдэлийн түгээх шугамнуудын хувьд баримтлах аюулгүй зайн санал болголоо. Эдгээр саналуудыг үл харгалзан, Гүйцэтгэгч, тэдгээрийн үйл ажиллагааг хариуцсан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөн, төрөл бүрийн хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамнаас гадагш баримтлах аюулгүй зайн өөртөө зориулан тогтооно. Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний болон цахилгааны шугамд ажил ойрхон байгаагаас шалтгаалан зайлшгүй хийгдэх ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

Хүснэгт 1-1: Өндөр хүчдэл дамжуулах шугамнаас доошихи, санал болгож буй цэвэр зайн

Вольт кВ	Зайн
138	7.8 м
230	8.4 м
345	9.4 м
500	10.0 м

Хүснэгт 1-2: Нам хүчдэлийн түгээх шугамнаас доошихи, санал болгож буй зайн

Вольт кВ	Зайн
0 - 750	1 м
750 - 38,000	1 м
38,000 - 86,000	1.5 м

Гүйцэтгэгч нь дээрхи шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхөө үүрэг хариуцлагыг бууруулахгүйгээр, аливаа ажил, Инженерийн байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд, Захиалагчийн инженерт яаралтай мэдэгдэнэ. Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа Инженерийн байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

Гүйцэтгэгч нь дээрхи шаардлагуудыг үл харгалзан, гэхдээ, өөрийнхээ үүрэг хариуцлагыг бууруулахгүйгээр, аливаа ажил, Инженерийн байгууламжууд ил гарсан, тэдгээрийг илрүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд, Захиалагчийн инженерт яаралтай мэдэгдэнэ. Ажлын төлөвлөгөөг боловсруулах, зохицуулах болон хэрэгжүүлэхтэй уялдан, аливаа Инженерийн байгууламжид хийгдэх өөрчлөлтийн бүх зардлуудыг Гүйцэтгэгч хариуцна.

1.21 ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

Зураг дээр үзүүлсэн Инженерийн байгууламжийн байршил, эд ангиудыг үл харгалзан, өгсөн мэдээллийг баталгаажуулах, нарийвчлан тогтоохын тулд Гүйцэтгэгч, нэмэлт хайгуул судалгааг хийнэ.

Гэрээний нөхцөлд болон энэхүү техникийн шаардлагын зүйл 1.4-ийн шаардлагуудын дагуу ажлын хөтөлбөрөө боловсруулж байх явцдаа, Гүйцэтгэгч техникийн шаардлагад тодорхойлсоны дагуу ажлын талбайд ба эргэн тойронд байгаа Инженерийн байгууламжийг илрүүлэх, байршлыг тогтоох, хамгаалах, шилжүүлэх болон холбогдох байгууллагуудад мэдэгдэх шаардлагатай хугацааг тооцож үзсэн байна. Гүйцэтгэгч, аливаа Инженерийн байгууламжийг шилжүүлэх буюу өөрчлөх, шаардлага гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудтай холбоо харилцаатай ажиллах хариуцлагыг хүлээнэ. Хэрвээ Гүйцэтгэгч, Захиалагчаар дамжуулан Засгийн газрын дэмжлэг туслалцаа авах бол, энэ асуудалтай холбогдсон шаардлагуудыг Захиалагчийн инженерт мэдэгдэнэ.

1.22 ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

Хөдөлгөөний хяналт болон ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон бусад асуудлуудын талаар орон нутаг, төмөр зам, цагдаагийн болон Засгийн газрын холбогдох албаны хүмүүстэй харилцан зөвшилцөж ажиллах ба тэдгээр хүмүүст дээр дурдсан чиглэлээр ажил үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүх талын туслалцаа, нөхцөл боломжоор хангана.

1.23 УСАН ХАНГАМЖ

Гүйцэтгэгч, барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, хээрийн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан хангалттай хэмжээний цэвэр усаар тогтмол хангана. Тэрээр усны шугам хоолой, орон нутгийн усны гол шугаманд холбох, тоолуур, насос, усны саваар хангах, шаардлагатай газарт усиг зөөвөрлөх, ус ашигласны төлбөр, зардлыг төлөх, ажил дуусахад усан хангамжийн холбогдолтой байгууламжийг зохих байдлаар нь буулгах зэрэг бүх арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомжийн дагуу байгалийн усны нөөцийг ашиглаж болох ба энэхүү нөөцийг ашиглаж буй бусад хэрэглэгчидтэй хийсэн маргааны улмаас ямар нэг зарга үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрөө зохицуулна. Гадаргын усны байгалийн нөөц байхгүй буюу ямар нэг шалтгааны улмаас хангалтгүй байвал, Гүйцэтгэгч орон нутгийн хууль тогтоомжийн дагуу өөрийн зардлаар газрын гүний эх үүсвэрээс худаг

гаргаж ашиглах ажлыг зохион байгуулна.

Ус нь ажилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, ямар нэг хөвөгч хатуу биет, бодисыг агуулаагүй, цэвэр байна. Барилгын ажил болон бүх байшин, сууц, ажлын байр, хээрийн лаборатори, хяналтын байр, агуулах, засварын газар ба ажилчдын байрны хэрэгцээнд зориулан барилгын талбайд хангах ус нь Захиалагчийн инженерийн болон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан холбогдох байгууллагын шаардлагыг хангасан, унданд хэрэглэх боломжтой, чанартай ус байна. Ундны усны чанарыг Байгаль орчны яамнаас (БОЯ) үхүүчин нэрээр боловсруулсан усны чанарын үзүүлэлтүүдийн дагуу хянана.

1.24 МАТЕРИАЛ БА ХИЙЦ ХЭСГҮҮД

Ажилд хэрэглэгдэх материалууд нь энэхүү техникийн шаардлагын нөхцлүүдийг хангана. Хэрвээ Гүйцэтгэгч, өөр хувилбар техникийн шаардлагын дагуу ижил буюу илүү өндөр стандартын материал хангахыг илүүд үзвэл, санал болгож буй хувилбарыг техникийн шаардлагын хуулбар хувь болон санал болгосон материалын техникийн иж бүрэн шаардлагын хамт Захиалагчийн инженерт хүргүүлнэ.

Эдгээр материалуудыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар Захиалагчийн инженерийн зөвшөөрсөн лабораторт шинжилж, баталгаажуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, ажилд хэрэглэх бүх бараа, материал, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйлчилгээ зэргийг Гүйцэтгэгч хангана. Энэхүү техникийн шаардлагын дагуу ажилд хэрэглэх материалыг олох, нөөцийг тогтоох, хангах, тээвэрлэх, хадгалах зэрэг ажлыг Гүйцэтгэгч дангаараа хариуцна.

Ажилд хэрэглэх ямар нэг материал, хийц хэсгүүдийн захиалгыг өгөхөөс өмнө Гүйцэтгэгч, тэдгээр материал, хийц хэсгүүдийг авахаар төлөвлөж буй компаний нэр, тэдгээрийн эх үүсвэр, бүтээгдэхүүний талаархи үйлдвэрлэгчийн тодорхойлолт, тэдгээрийн чанар, жин, бат бэх болон бусад холбогдох мэдээллийг Захиалагчийн инженерт танилцуулна. Гүйцэтгэгч үйлдвэрлэгчийн тэдгээр материал болон хийц хэсгүүдийн дээжийг мөн шаардлагатай бол адил төстэй материал, хийцийн дээжүүдэд хийсэн сүүлийн шинжилгээнүүдийн сертификатуудыг Захиалагчийн инженерт танилцуулна.

Захиалагчийн инженер шаардсан тохиолдолд ажилтай холбоотойгоор бүх шаардагдах материал, хийц хэсгүүдийн үнийн санал болон захиалгын хувийг Гүйцэтгэгч түүнд танилцуулна.

Хэрвээ байнгын ажилд ашиглахаар төлөвлөсөн буюу эсвэл аль хэдийн ашиглагдаж буй бараа, материал нь холбогдох техникийн шаардлагыг хангахгүй байна гэж Захиалагчийн инженер үзвэл, тэдгээр бараа материалыг хэрэглэхийг хэдийд ч хүчингүй болгох эрхтэй бөгөөд зөвшөөрөгдөх чанар бүхий бараа материалыар солих зааварчилгаа өгнө. Үүний үр дүнд гарах нэмэлт зардал болон чанаргүй хийгдсэн ажлын зардлыг, солих шаардлагатай бараа материал авах бүх зардлын хамт Гүйцэтгэгч гаргана.

1.25 ЦООНГОГ БА ШИНЖИЛГЭЭНИЙ НҮХНЭЭС АВСАН МАТЕРИАЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Захиалагчийн инженерийн бэлтгэсэн материалын тайланг оролцуулаад, Захиалагчийн инженерийн зүгээс тендert оролцогчдод зориулж гаргасан ямар нэг мэдээллийг Гэрээний бүрдэл хэсэг гэж үзэхгүй. Ажлын талбайд Захиалагчийн инженерийн оролцоотойгоор ухсан цооног, шинжилгээний нүх болон бусад судалгааны мэдээлэлд

үндэслэн өөртөө гаргасан аливаа дүгнэлтийнхээ хариуцлагыг Гүйцэтгэгч дангаараа хүлээнэ. Талбайд ухмалын ажил эхэлж, цаашид үргэлжлэх явцад газрын төвөгшил онцлог нөхцөл, цэвдэгийн байдал хөрсний шинж чанар зэрэг тодорхой мэдээлэлд тулгуурлан, газрын төвшнөөс доошхи газар шорооны ажлын болон суурийн төвшинг Захиалагчийн инженер тааруулан өөрчилж болно.

Онцгой нөхцөл төвөгшил ихтэй буюу цэвдэгтэй хэсэгт тусгайлан аргачлал гаргаж Захиалагчийн инженерт танилцуулах ба газар хөлдөх, их хэмжээний ус чийг хуримтлахаас сэргийлэн ажиллаж, ухсанаас хойш 48 цагийн дотор дараагийн шатны ажлыг гүйцэтгэх шаардлагатай. Гэрээний нөхцөлд тодорхойлсоны дагуу Гүйцэтгэгч ажлын талбайг хянах, шалгах үүрэгтэй.

1.26 МАТЕРИАЛ, ХИЙЦ ХЭСГҮҮДИЙГ ХАДГАЛАХ

Бүх материал, хийц хэсгүүдийг техникийн шаардлагад нийцэх байдлаар ажлын талбайд хадгална. Гүйцэтгэгч бүх ажил, материал болон хийц хэсгүүдийг цаг агаар, үер ус болон бусад гадны нөлөөнд өртөхөөргүй байдлаар хадгалж, хамгаална.

1.27 ШИНЖИЛГЭЭНИЙ СЕРТИФИКАТ

Энэхүү техникийн шаардлагын дагуу буюу эсвэл Захиалагчийн инженерийн зааварласны дагуу, Гүйцэтгэгч нь ажилд хэрэглэх материал ба хийц хэсгүүдийг үйлдвэрлэгчийн шинжилгээний сертификатуудтай хамт түүнд танилцуулна. Тэдгээр шинжилгээний сертификатууд нь материал ба хийц хэсгүүд энэ техникийн шаардлагын дагуу шинжлэгдсэн гэдгийг батлах бөгөөд хийгдсэн бүх шинжилгээний хариуг багтаасан байна. Гүйцэтгэгч, талбайд хүргэгдсэн материал ба хийц хэсгүүдийг ялгах хангалттай аргуудыг зохих шинжилгээний сертификатуудын хамт хангана.

1.28 ГЭРЭЛ ЗУРАГ

Энэхүү техникийн шаардлагын дагуу Гүйцэтгэгчийн, Захиалагчийн инженер, төслийн нэр, хүчин чадал, ажлын нэр, төрөл, байршил, огноог харуулсан төмөр замын ажлын явцын самбартай зургийг авч баримтжуулна.

1.29 ТӨМӨР ЗАМЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Гүйцэтгэгч зурагт үзүүлсэн, эсвэл Захиалагчийн инженерийн зааварласан ширхэг, дизайн, өнгө, хэмжээгээр замын мэдээллийн самбарыг хийж, суурилуулан, арчилж хамгаална. Захиалагчийн инженерийн зааварласан цэгүүдэд замын самбуруудыг суурилуулна.

Замын мэдээллийн самбуруудыг Гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичиг олгосноос хойш 28 хоногийн дотор суурилуулсан байна. Гүйцэтгэгч тэдгээр замын самбарыг баталгаат засварын хугацаа дуусах үед буцааж авна.

1.30 ТАЛБАЙН ЕРӨНХИЙ БАЙГУУЛАМЖУУД

Гүйцэтгэгч нь ажлын байр хээрийн лабораторийн барилгыг шинээр барих, засварлах ба лабораторийн тоног төхөөрөмж, ажлын байрны тавилга, тоног төхөөрөмжийг хангаж, засаж арчилна. Энэхүү ажлууд хэрэв Захиалагчийн инженер өөрөөр зааварчилаагүй бол стандартын шаардлага хангасан байна.

а) Хээрийн лаборатори ба ажлын байр

i. Ерөнхий

Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн явцад, гүйцэтгэгч ба Захиалагчийн инженерийн хамтран ашиглах, хээрийн лаборатори болон байр сууцаар хангаж, шаардлагатай тавилга хэрэгсэлээр тохижуулж, засварлаж арчина. Ажлын байр лаборатори нь Захиалагчийн инженерийн зөвшөөрсөний дагуу Гүйцэтгэгчийн талбайн төв байрны ойролцоо байрлана.

Гүйцэтгэгч дээрхи үйлчилгээнүүдийг Захиалагчийн инженер зөвшөөрвөл ойролцоо суурин хотод, тохиромжтой түрээсийн байранд зохион байгуулж болох ба шаардлагатай барилгыг шинэчлэн засварлана.

Хээрийн лаборатори болон ажлын байр тэдгээрт шаардагдах нэмэлт тоноглолыг хангахдаа энэ техникийн шаардлагыг дагаж мөрдөхөөс гадна Монгол улсад мөрдөгджэй буй улсын болон орон нутгийн хууль тогтоомжийг харгалзан үзнэ. Мөн хээрийн лаборатори, ажлын байрыг хангахтай холбогдуулан нарийвчилсан байршлын зураг, барилгын план бүхий өөрийн төлөвлөгөөг энэ техникийн шаардлагад өгөгдсөн зарчмуудын дагуу бэлтгэж, Захиалагчийн инженерт танилцуулан баталлуулна

Хээрийн лаборатори ажлын байрны байршил, чиглэл зэрэг нь Захиалагчийн инженерийн шаардлагын хэмжээнд байх ба харилцан зөвшилцэж, тэдгээрийг тохижуулахаас өмнө бичгээр баталгаажуулна.

Гүйцэтгэгч ажлын байр, лабораторийн барилгын эргэн тойронд түр зам, хашаа хаалт барьж, ус төвийн халаалт, цахилгаан хангамжид холбох, харуулын байр, гадна хамгаалалт, гэрэлтүүлэг, харилцуур, бохирын систем зэргийг хангах, хог хаягдлыг зайлуулах зохицуулах гэх мэт бүх асуудлыг Захиалагчийн инженерийн шаардлагын хэмжээнд хийнэ.

Бүх байр сууц хангалттай газардуулагч бүхий 220В, 50Гц-ийн цахилгаан хүчдэл болон үндны цэвэр усны хэрэгцээгээр 24 цагийн туршид тогтмол хангагдсан байна.

ii. Ажлын байр

Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженерийн хэрэгцээнд зориулан ашиглахад хангалттай талбай бүхий 2 ажлын байрыг өөрийн байрны дэргэд барьсан байх ба шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгаар тоноглогдсон байна.

iii. Хээрийн лаборатори

Лабораторийг ажлын байрны орчимд Захиалагчийн инженерийнг зөвшөөрсөн газар байгуулна. Ашиглахад хангалттай талбай бүхий 2-3 Хээрийн лабораторийг хангана. Лаборатори нь батлагдсан зургийн дагуу ажлын өрөөнүүд хамгийн багадаа 160 ваттын цахилгаан, 480 ваттын гэрэлтүүлэгүүд, суурин утасны аппарат 1 багагүй, 8-аас доошгүй ширхэг хананы давхар залгуур тус тус тавина.

Гүйцэтгэгч нь лабораторийг агааржуулалтын системээр хангах бөгөөд доторхи агаарын температур тогтмол 15-20°C хэмд байлгана.

Лабораторийн барилгын шалыг төмөр бетоноор хийж, нягтуулалт хийхэд зориулан 0.4м-ийн зузаан, 1.5x1.5 м-ийн хэмжээтэй төмөрбетон хавтан шал хийнэ. Бетон бутлах зуурах, хөрсний даацыг шалгах машинуудыг сайтар бэхэлж суурьлуулах бетон тавцан хийнэ. Цонхнуудад хаалт хөшиг хийнэ.

Үүнээс гадна лабораторид залгаа сүүдрэвч, дээжийг усанд сойх сав зэргийг байрлуулна. Хатаах сүүдрэвч нь ойролцоогоор дор хаяж 25m^2 талбай бүхий дээш өргөгдсөн бетон шалтай, хажуу талаараа онгорхой боловч агаарын нөлөөнөөс хамгаалах дээвэртэй байна. Дээжийг усанд сойх сав нь $3\text{m} \times 1\text{m} \times 0.3\text{m}$ гүн байх ба ус нэвтрэхгүй бетон юмуу зөвшөөрөгдсөн материалыар хийгдсэн байна.

iv. Машины зогсоол

Ажлын байр болон лабораторийн барилгын дэргэд машины зогсоол байгуулж, засвар арчлалтыг хариуцна.

Энэхүү зогсоолд тавьж буй машинууд шууд тусах нарны туяа, бороо эсвэл цаснаас тогтмол хамгаалагдсан байхаар барина. Тэдгээр нь ус үл нэвтрэх дээвэртэй байна.

b) Хээрийн лаборатори ба ажлын байрны тавилга, тоног төхөөрөмжүүд

v. Ажлын байрны тавилга, тоног төхөөрөмж

Гүйцэтгэгч гэрээний хэрэгжилтийн нийт хугацааны туршид ажлын байрны тоног төхөөрөмжөөр хангана. Ажлын байр нь холбоо, утас, интернэтээр компьютероор бүрэн хангагдсан байх ба хот хоорондын харилцааны сүлжээтэй байна. Түүнчлэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан байна. Үүнд: Бичгийн ширээ, компьютер, утасны аппарат, интернет сүлжээ, бичгийн хэрэгсэл гэх мэт

vi. Хээрийн лабораторийн тавилга, тоног төхөөрөмж

Шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, эд зүйлсийг Захиалагчийн инженерийн зөвшөөрөлтэйгөөр, энэ техникийн шаардлагад заасан хугацаанд хангана.

Лабораторийн тоног төхөөрөмж нь орчин үеийн загвар дизайнаар бүтээгдсэн, дээж авах, шинжилгээ хийх зэрэг ажлыг алдаа зөрүүгүй зохих хэмжээнд гүйцэтгэхэд шаардагдах хэмжээс, шинж чанар нарийвчлалтай байна. Хэрэглэхээр төлөвлөж буй лабораторийн бүх тоног төхөөрөмжийн марк, загвар, үзүүлэлтийг үйлдвэрлэгчийн бичиг баримтын хамт Захиалагчийн инженерт танилцуулан, зөвшөөрөл авна. Чанарын хяналтын төлөвлөгөөг биелүүлэхэд шаардагдах бусад нэмэлт тоног төхөөрөмжийг сайтар судалж, тооцон оруулж байх шаардлагатай.

1.31 ТҮР СУУРИНГ БУУЛГАХ

Гэрээний дагуу ажил хүлээж авах актыг ирүүлсэний дараа Захиалагчийн инженерээс албан бичгээр зааварчилгаа авсаны үндсэн дээр түр лагерыг бүрдүүлж байсан байгууламжуудыг буулгана. Гүйцэтгэгч өөрийн болон Захиалагч буцааж хүлээлгэж өгөх, инженерийн байгууламжаас бусад ус хангамжийн сүлжээг салгах, бүх хоолой, ус зайлзулах болон бохирын шугамуудыг буулгах, ил суваг шуудуу жорлонгийн нүх, бохирын сав, ухсан ухмалуудыг буцаан дүүргэх гэх мэт ажлыг зохион байгуулна.

1.32 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ

Барилгын ажлын үед замын дагуух гол, горхи зэрэг усны эх үүсвэрүүд зарим тохиолдолд хөндөгдж магадгүй. Баригдаж буй замын дагуу байгаа гол горхийг эргийн хамгаалалт хийх буюу бусад зөвшөөрөгдсөн аргыг ашиглан хамгаална. Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженерийн ба орон нутгийн удирдах байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр гол горхи буюу, гүний худагнуудаас ус авч болно. Гүйцэтгэгч Монгол улсын гадаргын усны чанарын хяналтын стандартын дагуу шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд ингэснээр

барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан ус чанарт өөрчлөлт гарахгүй байх боломжтой.

Чулуу бутлуур ба бетон зуурмагийн үйлдвэр ажиллуулахдаа байгаль орчны хяналтын талаарх Засгийн газрын хууль тогтоомжийг чанд мөрдөх бөгөөд тэдгээрийг хүн ам суурьшсан газраас 1.0 км-ээс хол зайд байршуулна. Тоосжилт үүсэхээс сэргийлж газар шорооны ажил, түр овоолго, түр зам ба суурь ба сууриний доод үеийг тогтмол усална. Агаарын чанар нь орчин тойрны агаарын чанарын тухай Монгол улсын стандартын шаардлагыг хангах ёстой.

Барилгын ажилд хэрэглэгдэж буй бүх тоног төхөөрөмж, үйлдвэр завод, технологийн машин механизм нь холбогдох дуу чимээний стандартыг дагаж мөрдөнө. Барилгын ажлын тоног төхөөрөмж нь 90dB(A)-аас бага дуу чимээ гаргана гэсэн стандартын шаардлагыг хангана. Суурин газраас 150м-ээс ойр зайд явагдаж буй дуу чимээтэй барилгын ажлыг оройны 10.00 цагаас өглөөний 6.00 цагийн хооронд зогсононо. Дуу чимээний төвшинг тогтоосон хязгаарт байлгах үүднээс бүх машин тэрэг, барилгын ажлын техникийдийг тогтмол хянаж, дуу намсгагчаар хангаж, жолооч, операторууд чихэвч зүүсэн эсэхэд онцгойлон анхаарал тавина.

Байгаль орчны чанар, барилгын ажилчдын эрүүл мэнд, ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал зэргийг дараахи байдлаар хянана.

Хүснэгт 1-3: Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг хянах үзүүлэлтүүд

Бүрэлдэхүүн хэсэг	Үе шат	Зүйл
Агаар	Барилгын ажлын үе шат	Бохирдлын элементүүд (SPM), CO, NO ₂ , SO ₂
Ус	Барилгын ажлын үе шат	Физик, хими, биологийн шинж чанар
Дуу чимээ	Барилгын ажлын үе шат	Дуу чимээний төвшин
Ажилчдын эрүүл мэнд	Барилгын ажлын үе шат	Эрүүл мэндийн үзлэг
Ажлын талбайн нөхцөл байдал, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал	Барилгын ажлын үе шат	Ажлын талбайн нөхцөл байдал /түр лагерийн байдлыг ажиглах

1.33 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Энэхүү бүлгийн заалтуудыг биелүүлэхтэй холбоотой зардлыг захиалагчаас техникийн хяналтын зардлыг хэрхэн тооцох талаар Тендерийн баримт бичгийн өгөгдөл, Захиалагчийн инженер болон Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, зураг төсөлд хэрхэн тусгагдсанаас хамааруулан дагуу санхүүжилт төлбөрийг тооцно.

ЗАХИАЛАГЧ

83

ГҮЙЦЭТГЭГЧ

БҮЛЭГ 2 – МАТЕРИАЛ, МАТЕРИАЛЫН ТУРШИЛТ ШИНЖИЛГЭЭ

2.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ бүлэгт Лабораторийн үйл ажиллагаа, материалын сонголт түүний чанар, ажлын арга технологи, барилгын ажлын хяналтанд хэрэглэгдэх туршилт, шинжилгээнүүд, тэдгээрт тавигдах шаардлагуудыг багтаасан.

2.2. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХИЙХ ШИНЖИЛГЭЭ, ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гүйцэтгэх нийт хугацааны туршид, талбайн лабораториудыг байгуулан ажиллах нөхцлийг нь хангаж байх ёстай. Талбайн лабораториуд нь чанарын менежер эсвэл лабораторийн эрхлэгчийн удирдлага, хяналтын дор ажилhana. Гүйцэтгэгчийн барилгын хяналтын шинжилгээний давтамж нь түүний төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу байх ба Инженертэй өөрөөр зөвшилцөөгүй бол энэхүү шаардлагад заасан удирдамжийн дагуу байна. Гүйцэтгэгч нь ажилд хэрэглэх бүх материал болон хийгдэж буй нийт ажлуудад туршилт шинжилгээг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх шинжилгээг хийж, материал болон ажлын шинжилгээний үр дүнг Инженерт танилцуулан шалгуулж нэг хувийг өгнө. Баталгаажуулах шаардлагатай шинжилгээг тохиромжтой байдлаарсайтар төхөөрөмжилсөн хараат бус шинжилгээний лабораторид явуулна.

Инженер нь Гүйцэтгэгчийн лабораторийн дээжлэх ажиллагаа, шинжилгээний байр, тоног төхөөрөмж, лабораторийн ажилтнуудын үйл ажиллагаа болон шинжилгээний үр дүнгийн бүртгэл зэргийг ямар ч үед чөлөөтэй хянаж шалгах эрхтэй.

Инженер нь бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн газарт нь хийх шинжилгээг оролцуулан, чанарын хяналтын төлөвлөгөөний нэг хэсгийг бүрдүүлж байгаа, эсвэл түүн дээр нэмэгдсэн, Гүйцэтгэгчийн лабораторийн ажилтнуудын явуулах бүх шинжилгээг гэрчилж, зааварчилгаа өгөх эрхтэй.

2.3. МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ СТАНДАРТ

Төмөр зам, замын байгууламжийн барилгын ажилд хэрэглэгдэх бүх материал нь энэ шаардлагуудад нийцсэн байх бөгөөд Инженерийн шаардлагын дагуу байх ёстай. Хэрвээ материал нь үйлдвэрлэгчийн худалдааны нэрээр тодорхойлогдсон бол өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг ашиглаж болох ба гэхдээ өөр үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь чанарын хувьд нэрлэсэн бүтээгдэхүүнтэй ижил буюу илүү гэдгийг Гүйцэтгэгч баталж, Инженер зөвшөөрсөн тохиолдолд хүлээн зөвшөөрөгднө. Ажилд хэрэглэхээр төлөвлөсөн бүх материалын дээжийг лабораторид өгч туршиж шинжлэн, шинжилгээний дүнг баталгаажуулснаар материалыг талбайд нийтэд нь татан авчрах зөвшөөрлийг Инженерээс авна. Хэрвээ энэ шаардлагын дагуу зарим материалыг гадны хараат бус лабораторид шинжлүүлэн баталгаажуулах шаардлагатай бол Гүйцэтгэгч нь үүнээс гарах бүх зардлыг хариуцах бөгөөд зардалд дараах зүйлүүд багтана /гэвч эдгээрээр хязгаарлагдахгүй/. Үүнд:

- Лабораторийн шинжилгээний хөлс
- Дээжээр хангах
- Дээжийг талбайгаас лаборатори руу, шаардлагатай бол буцааж талбай руу

тээвэрлэх

- Лабораторийн ажилтнуудын хөлс

Хараат бус лабораторид хийгдэх шинжилгээний төлөвлөгөөг Инженертнэг долоо хоногийн өмнө мэдээлэх ба тэрээр шинжилгээ хийх цагт, газар дээр нь байлцах эрхтэй.

2.4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД

a) Шинжилгээний стандарт шаардлагууд ба аргууд

Ажилд хэрэглэх бүх материал нь Монгол улсад батлагдсан “Тээвэрлэлт, материал, дээжлэх ба шинжилгээний аргуудын стандарт шаардлагууд”-д нийцэж байх ёстой. Монгол улсад мөрдөгдөх байгаа стандарт шаардлагын дагуу хийгдэх ёстой боловч энэ шаардлагуудад хамрагдаагүй шинжилгээний аргууд буюу энэ шаардлагад өөрөөр заагдаагүй шинжилгээний хувьд AASHTO стандарт шаардлагуудын /эсвэл Инженерийн заасан буюу зөвшөөрсөн бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ижил төстэй шаардлагууд/ заалтыг хэрэглэж болно. Энэ тохиолдолд хэрэглэгдэх Олон улсын стандартууд нь монгол хэлнээ орчуулагдсан байх бөгөөд Стандарт хэмжил зүйн төвөөс түр зөвшөөрөл авсан байна. Туршилт хийх лабораторид энэ стандартын албан ёсны орчуулга заавал байх ёстой.

b) Шигшүүр

Бүх шинжилгээнд ASTM E11 шигшүүрүүд хэрэглэгдэнэ. мм болон μm -ээр (микрон) өгсөн шигшүүрийн цувралыг дор үзүүлэв.

(1) Том шигшүүрүүдийн нүхний хэмжээ дараах байдалтай байж болно. Үүнд:

- a/. 100, 75, 63, 50, 37.5, 25.0, 19.0, 16.0, 13.2, 12.5, 9.5, 6.3, 4.75, 4.00 mm
- b/. 100, 75, 63, 50, 37.5, 25.0, 19.0, 12.5, 9.5, 4.75 mm
- v/. 100, 90, 70, 63, 50, 40, 20, 15, 10, 5 mm

Жижиг шигшүүрүүдийн нүхний хэмжээ дараах байдалтай байж болно.

Үүнд:

- g/ 2.80, 2.36, 2.00, 1.70, 1.40, 1.18, 1.00 mm, 850, 600, 500, 425, 355, 300, 250, 180, 150, 125, 75, 63 μm

d/. 4.75, 2.36, 1.18 mm, 600, 425, 300, 150, 75 μm

e/. 5, 2.5, 1.25 mm, 630, 315, 140, 71 μm

(2) Чулууны хэврэг хэсэг буюу урт, хавтгай хэсгийн агуулалтыг тодорхойлоходоо MNS 2998:2009 стандартын дагуу дараах шигшүүрүүдийг хэрэглэнэ.

63.0, 50.0, 40.0, 37.5, 31.5, 28.0, 25.0, 20.0, 16.0, 14.0, 12.5, 10.0, 6.3mm

2.5. ХӨРС

(a) Материалын дээж авах

- Материалын дээжийг ажил гүйцэтгэгч байгууллагын материалын инженер, техник технологийн хяналт гүйцэтгэж байгаа материалын инженер хамтран авна.
- Ажил гүйцэтгэгч байгууллагын материалын инженер, техник технологийн хяналт гүйцэтгэж байгаа материалын инженерүүд нь хүндэтгэх шалтгаанаар ажиллаагүй тохиолдолд дээжийг гүйцэтгэгч байгууллагын ерөнхий инженер болон хяналтын багийн ахлагч хамтран авна.
- Дээжний дагалдах хуудсанд дээж авсан орд газрын нэр, дээжийг авсан хүний нэр

албан тушаал мөн он сар өдрийг бичиж тэмдэглэсэн байна.

(б) Хөрсний шинжилгээнд хэрэглэгдэх стандарт аргууд

Дээж авах, бэлтгэх, савлах, тээвэрлэх, хадгалахдаа MNS 2305-94 стандартыг мөрдөнө. /AASHTO T87-2000 - Эвдэрсэн бүтэцтэй хөрс, хөрсний чулуулгийн дээжийг хуурайгаар бэлтгэх, шинжлэх, AASHTO T146-96 (2000) - Эвдэрсэн бүтэцтэй хөрсний дээжийг нойтон аргаар эсвэл Инженерийн зааврын дагуу бэлтгэх/

- Хөрсийг 60°C-аас хэтрэхгүй темпертурт хатаана.
- Элсэн хөрсийг 3 цаг, бусад хөрсийг 5 цаг, гөлтгөнөжсэн хөрсийг 8 цаг хатаана
- Хөрсний нягтыг пикнометрийн аргаар тодорхойлохдоо MNS 2143-2000 стандартыг мөрдлөг болгоно.
- Хөрсний нягтыг 0.01t/cm³, зохистой чийгийн хэмжээг 0.1%-ийн нарийвчлалтай тодорхойлно

Хөрсний шинжилгээг дараах стандарт аргуудын дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 2-1: Хөрсний шинжилгээний аргууд

Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох	MNS ASTM D 2217:2002
Хөрсний ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох	MNS AASHTO T88-2004
Хөрсний урсалтын хязгаарыг тодорхойлох	MNS ASTM D 4318:2002
Хөрсний уян напархайн хязгаар ба уян напархайн индексийг тодорхойлох	MNS ASTM D 4318:2002
Хөрсний хувийн жин, нягтыг тодорхойлох	MNS AASHTO T100-2003
Стандарт хүчлэл /600кнм/m ³ / -ээр хөрсний чийг-нягтын харьцааг 2.5 кг алхыг 457 мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан тодорхойлох	MNS ASTM D 698:2002
Стандарт бус хүчлэл /2700кнм/m ³ / -ээр хөрсний чийг-нягтын харьцааг 5 кг алхыг 457 мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан тодо	MNS ASTM D 1557:2002
Хөрсний нягтыг газар дээр нь элсэн конусын аргаар тодорхойлох	MNS ASTM D 1556:2002
Хөрсний ачаа даацын үзүүлэлт (CBR)-г тодорхойлох	MNS ASTM D 1883:2002
Хөрсний чийгийн агуулгыг лабораторид тодорхойлох	AASHTO T265-93(2000)
Чийгийн агуулгыг тодорхойлох (талбайд)	AASHTO T217-02
Хөрсний органик хэсгийг шатаах аргаар тодорхойлох	MNS AASHTO T 267-2004
Динамик шигдэлтийн аргаар замын далан, суурин даацыг хэмжих аргачлал	MNS 5678:2006
Замын суурин доод үе болон суурь үеийн материалын техникийн шаардлага	MNS ASTM D 1241: 2002

4.54 кг-ийн алхыг 457 мм-ийн өндөрөөс унагах аргыг ашиглан хөрсний нягт-чийгийн харьцааг тодорхойлох MNS ASTM D 1557:2002-ийн стандарт аргын дагуу хийгдэх

лабораториид нягтыг тодорхойлно. Энэ шаардлагад MDD буюу MNS ASTM D 1557:2002 (хуурай үеийн хамгийн их нягтрал-ХҮХИН)-ийн үзүүлэлтийг мөн тодорхойлно.

(1) Ул хөрсийг шинжилгээний давтамж :

- ✓ чийг нягтын харьцаа 3000 м² буюу трассын дагуу 500м-т нэг шинжилгээ
- ✓ нягтруулалтын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг 1000 м² буюу замын дагуу 100 м-т нэг
- ✓ MNS ASTM D 1557:2002 Хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулгыг шинэ материал бүрт, хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дун нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.
- ✓ Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалд хамгийн багадаа 500 м тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл нэг хэсэгт хамгийн багадаа 2 шинжилгээ явуулах, урт хэсэгт хүсэлт гаргасан тохиолдолд замын 200м тутамд нэг шинжилгээг явуулна.
- ✓ Ул хөрсийг хамгийн их нягтралын 95%-иас багагүй, чийгийн зохист агууллага 2%-иас ихгүй байхаар нягтруулна.

(2) Замын дэвсгэр үе ба ердийн дүүргэлтийн материал

(А) Тавигдах шаардлага

- ✓ Далангийн дүүргэлт болон хөлдөлтөөс хамгаалах үед хэрэглэгдэх дээжний ачаалал даах чадварын туршилтыг хийхдээ хөрсний тохиромжтой чийгээс ±0.5%-ийн чийгтэй болгоод хэвлэж нягтруулна.
- ✓ Материалууд нь бохир ус, навч, ногоо, үндэс зэрэг органик хольц агуулаагүй байна.
- ✓ Далангийн материалын нягтруулах үеийн зузаан нь 250мм-ээс ихгүй байна.
- ✓ Материалын зохистой чийгшилийн агуулгыг нягтруулалтын үед проктор туршилтаар гарсан чийгийн агууламжаас 1%-иар их, 2%-иар бага байхыг зөвшөөрнө.

(Б) Ердийн дүүргэлтийн материалд мөрдөх шинжилгээний давтамж

- ✓ Чийг-нягтын харьцаа 3000m³-д нэг шинжилгээ
- ✓ Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох 3000m³-д нэг шинжилгээ
- ✓ Уян налархайн индекс 3000m³-д нэг шинжилгээ
- ✓ Урсалтын хязгаар 3000m³-д нэг шинжилгээ
- ✓ Нягтруулалтын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг үе бүрийн 3000m³ тутамд нэг шинжилгээ
- ✓ Талбайн хуурай нягтшил үе бүрийн 1000m²- тутамд нэг шинжилгээ
- ✓ Далангийн дүүргэлтийн материалын ширхэглэлийн шинжилгээ, уян налархайн индекс ба урсалтын хязгаарыг ашиглагдсан материалын 1000 m³ тутамд нэг удаа эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.

- ✓ Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрд хамгийн багадаа 1000 м²м тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт хамгийн багадаа гурван шинжилгээг хийнэ.
- ✓ Далан болон дэвсгэр үед хэрэглэх материалуудыг хамгийн их нягтралын 95%-иас багагүй, чийгийн зохицт агуулга 2%-иас ихгүй байхаар нягтруулна.

(3) Суурийн үе

- ✓ Суурийн үе болон холимог материалд MNS ASTM1241:2002 стандартыг мөрдлөгө болгоно.
- ✓ Суурийн үед хэрэглэж буй материалын 0.075мм-ийн шигшүүрээр өнгөрөх хэсэг нь 0.425мм-ийн шигшүүрээр өнгөрөх хэсгийн 2/3-оос ихгүй байна.
- ✓ (AASHTO T180-93)-аар тодорхойлсон MDD-98 % байх үеийн усанд 4 хоног сойсны дараах ачаа даац буюу CBR > 20%
- ✓ Урсалтын хязгаар 20%-иас бага
- ✓ Уян налархайн индекс 6, суурийн үед хэрэглэгдэх материалуудыг 98%-иас багагүй, чийгийн зохицт агуулгын хэлбэлзэл 2%-иас ихгүй байхаар нягтруулна.
- ✓ Чийг-нягтын харьцаа 2500 м³ --д нэг шинжилгээ
- ✓ Уян налархайн индекс 2500 м³ --д нэг шинжилгээ
- ✓ Урсалтын хязгаар 2500 м³ --д нэг шинжилгээ
- ✓ Жигд байдлын итгэлцүүр 2500 м³ --д нэг шинжилгээ
- ✓ Уян налархайн модуль 2500 м³ --д нэг шинжилгээ
- ✓ Хөрсний даацын үзүүлэлт (3 дээжийн иж бүрдэл) 2500 м³-д нэг
- ✓ Ширхэглэлийн бүрэлдэхүүн 2500 м³-д нэг шинжилгээ
- ✓ Нягтруулалтын өмнөх чийгийн агуулга үе бүрийн 2500-м³ тутамд нэг шинжилгээ
- ✓ Талбайн хуурай нягт 1000 м² тутамд нэг шинжилгээ буюу нэг хэсэгт 3 шинжилгээ
- ✓ MNS ASTMD 1557:2002 хамгийн их хуурай нягт ба тохиромжтой чийгийн агуулга хөрсний даацын үзүүлэлтийн MNS ASTM D 1883:2002 (CBR) шинжилгээг (3 дээжийн бүрдэл) суурийн доод үеийн материалын шинэ эх үүсвэр бүрийг нээсний дараа болон боловсруулсан материалын дээрхи давтамжаар хамгийн багадаа нэг удаа тодорхойлно.
- ✓ Материалын үе бүрийг нягтруулахын өмнөх чийгийн агуулгын шинжилгээг нягтруулсан материалын үе бүрийн эсвэл хамгийн багадаа 500 м² тутамд нэг удаа явуулна. Хатах буюу норсоноос шалтгаалж материалын чийгийн агуулга өөрчлөгдөх үед эсвэл өмнөх шинжилгээний дүн нь тодорхой бус байвал чийгийн агуулгын шинжилгээг давтан явуулна.
- ✓ Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрийн хамгийн багадаа 100 м тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх

шаардлагатай хэсэг бүрт хамгийн багадаа гурван шинжилгээг явуулна.

(4) Хучилтын үе барихад мөрдөгдөх шинжилгээний давтамж

- ✓ Чийг-нягтын харьцаа **2000** м3-д нэг шинжилгээ
- ✓ Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох **2000** м3-д нэг
- ✓ Уян налархайн индекс **2000** м3-д нэг шинжилгээ
- ✓ Урсалтын хязгаар **2000** м3-д нэг шинжилгээ
- ✓ Хөрсний даацын үзүүлэлт (3 дээжийн иж бүрдэл) **2000** м3-д нэг
- ✓ Материалын ширхэглэлийн шинжилгээ, уян налархайн индекс ба урсалтын хязгаарыг ашиглагдсан материалын 500 м тутамд нэг удаа эсвэл материалын эх үүсвэр, төрөл өөрчлөгдөх бүрт давтан тодорхойлно.
- ✓ Талбайн хуурай нягтыг нягтруулсан материалын үе бүрд хамгийн багадаа 100-150м тутамд нэг удаа тодорхойлох буюу эсвэл шинжилгээ хийлгэх шаардлагатай хэсэг бүрт хамгийн багадаа гурван шинжилгээг хийнэ.
- ✓ Хучилын үед хэрэглэх материалыудыг хамгийн их нягтралын 98%-иас багагүй, чийгийн зохист агуулга 2%-иас ихгүй байхаар нягтруулна.

Карьераас авсан материалын ширхэглэлийн жигд байдал, урсалтын үзүүлэлт нь бага хэмжээний зөрүүтэйгээр тохиромжтой материал болох нь тогтоогдсон бол Захиалагчийн Инженер дээрх шинжилгээний давтамжийг цөөлөх зөвшөөрөл олгож болно.

2.6. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Материалын шинжилгээ, барилгын туршилт болон барилгын хяналтын шинжилгээнд зориулж тусдаа хэмжилт болон төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь нэгж ажлын үнэлгээ болон нийт үнийн дундээ энэхүү техникийн шаардлагын бүлэг 2-ийн бүх шаардлагыг хангах зардлыг тусгасан гэж тооцно.

ЗАХИАЛАГЧ

89

ГҮЙЦЭТГЭГЧ

БҮЛЭГ 3 - УЛААН ШУГАМ БА ХҮЛЦЭХ АЛДАА

3.1 ТӨМӨР ЗАМЫН ТРАСС СЭРГЭЭЖ, ГАДАСЛАГАА ХИЙХ

(а) Ерөнхий зүйл

Инженер болон Зураг төсөл зохиогч байгууллагын ажилтан нь барилгын улаан шугамыг тавихад хангалттай хайгуулын мэдээллийг Гүйцэтгэгчид өгөх ба Гүйцэтгэгч нь замын трассыг сэргээж, бүх шаардлагатай цэгүүдийн гадаслагааг хийж, тэдгээрийг арчилж хамгаалах хариуцлагыг хүлээнэ. Трасс сэргээх, гадаслагаа хийх нь үндсэн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй дагалдан хийгдэх ажил гэж үзэх бөгөөд үүнийг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийх ба үүнд тусад нь төлбөр төлөгдөхгүй.

Гүйцэтгэгч хайгуулын үндсэн мэдээлэл, гадаслагааг хүлээн авмагцаа анхны хяналтын цэг, шугам, төвшин ба хэмжилтүүдийн нарийвчлалыг тодруулж бодитоор шалган, трасс сэргээлтийг хийж, 2 талын хормойн гадаслагааг хийнэ.

Барилгын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь анхан шатны хэмжилтийн цэгүүд болох, Монгол улсын геодезийн сүлжээний цэгүүдтэй холбогдсон, замын трассын дагууд байгаа репер болон хэвтээ хяналтын цэгүүдийн (өнцгийн орой, замын эхлэл, төгсгөлийн цэг г.м) байршил, өндөр, бэхэлгээ зэргийг шалгаж хүлээн авна.

Үндсэн реперүүд нь замын ихэнх хэсэгт хоорондоо 1 км-ээс ихгүй зайд, гол төлөв замын зурvasын гадна, өнцгийн оройны ойролцоо байрлалтай байгаа. Гүйцэтгэгч цаашид туслах /тур/ реперүүдийг замын дагууд хооронд нь 200м-ээс ихгүй зайд, замын тэнхлэгээс гадагш 50м-ээс багагүй зайд, аль болох өндөрдүү газарт байрлуулж бэхлэнэ. Бэхэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд: 250x250x400мм хэмжээтэй бетон блок цутгаж, түүндээ 22мм-ийн голчтой, 200мм урт төмөр гадсыг блокны дээд гадаргуугаас 20мм дээш цухуйлан суулгаж бэхжүүлсэний дараа уг хийцийг туслах репер байрлуулах цэгт хатуу хөрстэй газарт ухаж суулган, эргэн тойрны газрыг сайтар чигжиж булна. Блокны дээд ирмэг газрын төвшинтэй ижил байх ба дээд гадаргуу дээр тухайн реперийн дугаарыг арилдаггүй будгаар тод бичсэн байна. Газарт суулгасан блокноос хааш хааш 0,5м-т 200мм гүнтэй шуудууг эргэн тойронд нь ухаж, гарсан шороог шуудууны гадна талаар овоолж орхино. Ухсан шуудууны аль нэг өнцөгт төмөр буюу модон гадсиг 400-500мм ил цухуйж байхаар суулгана. Туслах реперүүдийг байрлуулж бэхэлсэний дараа тэдгээрийг үндсэн реперийн цэгүүдтэй холбож өндөржилтийг тогтооно.

Бүх реперүүд, хэвтээ хяналтын цэгүүдийг барилга ашиглалтад хүлээлгэж өгөх хүртэл зохих шаардлагыг хангах хэмжээнд арчилж хамгаалах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.

Гүйцэтгэгч нь замын дагууд бэхэлсэн Геодезийн репер /хатуу/ цэг, тэмдэгтийг эвдэж, гэмтээх болон алга болохоос сэргийлсэн арга хэмжээ авна.

Гүйцэтгэгчийн талаас алдаатай хэмжилт хийснээс болж ажлын явцад ямар нэгэн хэмжилтийн ажлыг нэмж хийх шаардлага гарвал буруу хийгдсэн ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засч гүйцэтгэнэ.

(б) Нарийвчилсан хэмжилт, гадаслагааны ажил

Репер болон хэвтээ хяналтын цэгүүдийг хүлээн авсаны дараа Гүйцэтгэгч тэдгээрийн координат, өндөржилтийг нарийвчлан шалгаж, үр дүнг Инженерт танилцуулж зөвшөөрөл авна. Үүний дараа замын дагууд суулгаж бэхэлсэн туслах реперүүдийн координат болон өндөржилтийг үндсэн реперийнхтэй холбож үр дүнг Инженерээр батлуулна.

Гүйцэтгэгч нь замын тэнхлэгийг зурагт үзүүлсэнээр (20м тутамд) гадаслана. Харин энэхүү ТШ-ийн зүйлд 6.3-т заасан хүлцэх алдааны дотор төмөр замын газар шорооны ажлыг гүйцэтгэхийн тулд хугарлын цэгт болон зарим онцлог газарт дээрхээс богино зайд гадаслагааг хийж болно. Гадаслагааг хийсний дараа Гүйцэтгэгч сэргээсэн замын тэнхлэгийн дагууд пикет болон нэмэх цэгүүдийн зайд хэмжээг шалгаж, улмаар газрын өндөржилтийг дагуу ба хөндлөн огтлолд, замын нийт өргөнд нарийвчлан тодорхойлох хэмжилтийг гүйцэтгэнэ. Мөн үүнтэй адилаар замын тэнхлэгийн дагуух бүх төлөвлөгдсөн хоолой ба байгууламжуудын хөндлөн, дагуу хэмжилтийг гүйцэтгэнэ. Төлөвлөгдсөн гүүр, хоолойны тэнхлэгийн дагууд газрын түвшинг тодорхойлоходо замын тэнхлэгээс хоёр тийш Зөвлөхийн хиймэл байгууламжийн инженерийн зааварчилсан хязгаар хүртэлх тодорхой зайнд хэмжилтийг гүйцэтгэнэ.

Бүх холбогдох мэдээллийг (дугаар, байршил, төвшин г.м) угаагдаж арилдаггүй будгаар, тодорхой тэмдэглэж бичсэн лавлагааны гадас, налуугийн самбарыг ухмал ба далангийн налуу, хучилтын үеүдийн төвшинг ямар ч үед шууд тодорхойлох боломжтойгоор, замын тэнхлэгтэй перпендикуляраар, замаас тодорхой зайд байрлуулна. Эдгээр нь Гүйцэтгэгчид барилгын ажлыг шалгах, хянах зориулалтаар ашиглагдана. Талбайн цэвэрлэгээг хийж дуусмагц Гүйцэтгэгч нь лавлагааны 50x50x1200мм хэмжээтэй модон гадсыг хөрсийг нь хуулсан талбайн хоёр захаас гадагш 0,5-0,8м зайнд, 400мм гүн суулгана. Тэнхлэгийн дагууд байрлах лавлагааны гадаснуудын хоорондын зайд 20м-ээс ихгүй байна. Гадасны газраас дээш ил гарсан хэсгийг цагаанаар будсан байна. Гадсан дээр хадаасыг 25 мм-ээс багагүй урттай цухуйж байхаар үе тус бүрийн өндөрт зоох ба эндээс татсан рулеткны (утас байж болно) тусламжтайгаар хэмжилт хийх цэг ба замын тэнхлэгийг олж, хяналтын ажилд ашиглана. Гадсан дээр пикетийн дугаар болон тэнхлэгээс хуулсан хөрсний зах хүртлэх цэвэр зайд Инженерийн шаардлагад нийцүүлэн тод, арилахааргүй тэмдэглэсэн байна. Замын дагууд хийгдсэн бүх гадаслагааг Гүйцэтгэгч нь ажил явагдах нийт хугацааны туршид арчлан хамгаалж, эвдрэл гэмтэл гарсан бол нэн даруй засварлаж, тэмдэглэгээг тогтмол сэргээж байна. Хэмжилтийн ажлыг Инженерийн зөвшөөрсөн төрөл, маркийн багажаар гүйцэтгэх ба өгөгдлийг түүний зөвшөөрсөн формат ба нарийвчлалын стандартын дагуу нэлтгэн боловсруулна.

Хөндлөн огтлолын зургийг тохиромжтой программ хангамжийг ашиглан боловсруулах ба үндсэн өгөгдлөл болон эхний ноорогийг зөвшөөрөлцөхөөр захиалагчийн инженерт танилцуулна. Дагуу огтлолын зургийг хэвтээд 1:2000, босоод 1:200-гийн масштабтайгаар боловсруулж хэвлэнэ.

Гүйцэтгэгч батлагдсан хөндлөн огтлолын зурагт шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж болох ба ингэхдээ тухай бүрт Инженерээс зөвшөөрөл авна.

Инженер нь нэмж засварлан зөвшөөрөлцсөн хөндлөн огтлолын болон бусад зургийг гүйцэтгэгчээс авсанаас хойш 28 хоногийн дотор зам, хоолой, бусад байгууламжуудын байрлал ба төвшинг эцсийн байдлаар хянаж батлан гүйцэтгэгчид явуулна. Гүйцэтгэгч нь нэг удаад 5 км-ээс багагүй урттай замын хөндлөн огтлолын зургийг танилцуулна. Гүйцэтгэгч эцсийн байдлаар батлагдсан зам, хоолой ба бусад байгууламжуудын төвшинг хүлээн аваад өөрчлөгдсөн өгөгдлийг програмд оруулан хөндлөн огтлолын зургийг шинэчлэн боловсруулж гаргана.

3.2 ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ХҮЛЦЭХ АЛДАА

(а) Газар шорооны ажилд энэхүү бүлэгт заасан хүлцэх алдаанаас хэтрэхгүй байхаар

ЗАХИАЛАГЧ

Родж

ухмал, малталт, дүүргэлтийн ажил хийгдэх ба хэрэв Инженер өөрөөр заагаагүй бол Зургандаа заасны дагуу хөндлөн огтлол, налуу, хэмжээс, өнцөг, түвшин болон тооцоот шугамыг энэхүү бүлэгт заасан хүлцэх алдаанаас хэтрүүлэхгүй байхаар барьж байгуулна.

б) Бүх ажлыг заасан хүлцэл дотор Техникийн шаардлагыг бүрэн дагаж мөрдөн барьж байгуулна. Ухсан гадаргууг маш цэвэр нямбай өөлөх ба ухмалын дээд ирмэгүүдийг цэвэр нямбай дугуйруулна.

3.2.1 Барилгын ажлыг хүлцэл дотор байгаа эсэхийг шалгах

Гүйцэтгэгч нь ажлын холбогдох бүрэлдэхүүн хэсгүүд нь шаардлагатай хүлцэл дотор баригдсан эсэхийг үзүүлэх тохиromжтой туршилт шинжилгээг (хэмжилт, шулуун өнцөг гэх мэт) Инженер шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түүнийг байлцуулан хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч туршилт шинжилгээ болон үзлэгийн цэгүүдийг нэгтгэн, дараагийн ажлыг эхлүүлэхээс өмнө захиалагчийн инженерээс тухайн ажилд заагдсан хүлцлийн дагуу хийгдсэн тухай зөвшөөрлийг авна.

3.2.2 Илүүдэл материал

Заагдсан хүлцлээс гадуурх илүүдэл материалыг Гүйцэтгэгч Гэрээний дагуу зайлцуулан дахин хийж гүйцэтгэнэ. Эсвэл Гэрээний дагуу холбогдох ажлуудыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Гүйцэтгэгч хүлцэх алдаанаас хэтэрсэн материалуудыг засаж сайжруулах талаар захиалагчийн инженерээс зөвшөөрлийг авна.

3.2.3 Цэвэрлэгээ

а) Ус зайлцуулах сувгийн газар шорооны нэмэлт ажил зэрийг хийж гүйцэтгэсэн нийт талбайд Зурагт заасан хязгаарын дагуу эсвэл захиалагчийн инженерийн зааварласны дагуу хийнэ. Гүйцэтгэгч цэвэрлэгээ хийгдэх газрыг тодорхой тэмдэглэн Инженерт батлуулахаар өгнө.

б) Бүхий л ажиллагааг Барилгын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Ерөнхий гүйцэтгэгчийн олгосон цэвэрлэгээ хийх зөвшөөрөл болон ухалт хийх зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2.4 Налуугийн ухалтын хүлцэл

а) Ямар ч тохиолдолд ташуулгыг хөндийлж ухахыг хориглоно. Замын тэнхлэгийн шугамаас 6м-ээс илүү ойр, 3м-ээс өндөр хөрсний ухмалын ташуулгын налууг зургандаа заасан налуутайгаар гаргах эсвэл Геотехникчийн юмуу Инженер Геологчийн зөвшөөрснөөр болон захиалагчийн инженерийн баталсны дагуу тодорхойлно.

б) Дууссан ташуулгын налуу нь заасан хэмжээнээс илүү огцом эгц байж болохгүй.

в) Гүйцэтгэгч өрөмдлөгийн болон тэсэлгээний ухалт хийх хэлбэрийг өмнөх заалтуудад тусгасан хүлцэл дотор хийхээр боловсруулан захиалагчийн инженерээр батлуулсан байна. Өрөмдлөгийн нүх бүрийн байршлыг хэмжилтийн үр дүнд үндэслэн тогтооно. Тэсэлгээ, өрөмдлөгийн нүхний гүн, зайд зэргийн хүлцэх алдаа 100мм дотор байна.

3.2.5 Өргөн болон хөндлөн шугамын хүлцэл

а) Ердийн дүүргэлтийг зургандаа заагдсан хэмжээтэй хийх үед дараах заасан хүлцэх хэмжээнд нийцүүлэн хийнэ.

Далангийн мөргөцөг болон шатлалын өргөн тогтоосон хэмжээ, жишээлбэл 0мм+300мм-с хэтрэхгүй байна. Зөвшөөрч болох хүлцлийн хамгийн их хэмжээг Инженертэй зөвшилцсөний үндсэн дээр Гүйцэтгэгч тодорхойлно.

б) Хийж дууссан далангийн налуугийн дээд ирмэгээс тооцоот тэнхлэгийн шугам хүртэлх далангийн (жишээ нь хучилтын доод үеийн) өргөн болон ташуулгын ёроол нь замын тэнхлэгийн шугамд Зурагт заасан хэмжээнээс хэтрэхгүй, ойр байхгүй байх ба Зурагт заасан хэмжээнээс 200мм-с хэтрэхгүй байна.

3.2.6 Гадаргуугийн хэлбэр, тэгш байдал

Далангийн хучилтын доод үеийн гадаргын хэлбэрийг шалгахаа гадаргын аль нэг ирмэгээс 3м-н эгц шулуунд байх хамгийн их гажилт нь 30мм-с хэтрэхгүй байгаа тохиолдолд зөвшөөрөгднө.

3.2.7 Гадаргуугийн түвшин

Газар шорооны ажлын босоо шугамын хүлцэх алдаа дараах байдлаар байна:

а) Хийж дууссан ул хөрсний гадаргуу нь зурганд заасан түвшнээс $\pm 25\text{мм}$ хүлцэл дотор байна.

б) Ердийн дүүргэлтийн дээд гадаргуу (байгууламжийн дүүргэлтийн хэсгээс доош) Зурагт заасан түвшнээс $\pm 20\text{мм}$ хүлцэл дотор байна.

б) Дууссан хучилтын доод үеийн гадаргууг шалгахад гадаргын оройн хэсгийн аль нэг цэгээс эсвэл захиалагчийн төлөөлөгчийн баталсан зурган дээрх үзлэг хийхээр тогтоосон цэгийн түвшингээс хэмжихэд $\pm 15\text{мм}$ хүлцэл дотор хэмжигдсэн байвал хүлээн зөвшөөрнө.

3.2.8 Хучилтын үе

3.2.8.1 Өргөн

а) Хучилтын үеийн дээд захын ирмэг нь замын тэнхлэгийн шугамд Зурагт заасан хэмжээнээс ойргүй байна.

б) Гадаргын түвшний хэсэг нь замын тэнхлэгийн шугамнаас тэгш хэмтэй байх ба Зурганд заасан өргөнөөс 400мм-с илүү ч үгүй дутуу ч үгүй байна

3.2.9 Гадаргуугийн хэлбэр болон түвшин

а) Хучилтын үеийн гадаргуугийн хэлбэрийг шалгахад тухайн тэгш хэсгийн гадаргын аль нэг ирмэгээс 3м-н эгц шулуунд байх хамгийн их хэлбэлзэл нь 15мм-с хэтрэхгүй байна. Гадаргуугийн хэлбэрийг хамгийн багадаа 20м тутамд шалгана.

б) Хучилтын үеийн аль ч хэсэг Зурагт заасан зузааны хамгийн бага хэмжээнээс багагүй байна. Мөн тэнхлэгийн шугам дээрх хоорондоо 20м салангид хоёр цэг дэх зөв түвшнээс авсан хэлбэлзлийн зөрүү нь 10мм-с хэтрэхгүй байна.

в) Эдгээр шаардлагуудаас гадна хучилтын үеийн аль ч хэсэгт гадаргын ус тогтох хуримтлагдахааргүй байна.

(i) Хучилтын үеийн хувь, замын тэнхлэгтэй параллель байх гадаргын 3м шулуун ирмэгийн налуугийн хүлцэх хэлбэлзэл нь 10мм-ээс хэтрэхгүй байна.

(ii)Хучилтын дээд үеийн түвшинг гадаргын аль нэг түвшинд хэмжихэд Зурагт заасан цэгийн түвшнээс $+10\text{мм}-15\text{мм}$ дотор байгаа гадаргыг хүлцэл дотор байна гэж үзнэ.

3.3 Ухмал, ташуулгын налуу, ухмалын ирмэгийн хүлцэл

а) Ерөнхий

ЗАХИАЛАГЧ

Ташуулгын дундаж налуу нь бүх түвшиндээ заасан налуугаас илүү эгцгүй байх ба бэлэн болсон налуугийн аль ч цэг дэх дундаж хэмжээ нь 5м тутамд 150мм-с илүү хэлбэлзэлгүй байна.

б) Ухмалын ташуулга

Ухмалын ташуулгыг гаргахдаа ташуулгын оройн хэсэг нь замын тэнхлэгийн шугамтай ойр биш зайд байхаар барих ба Зурагт заасан ташуулгын шугамнаас гадагш 300мм-с илүүгүй байна. Ташуулгын дундаж налуу нь бүх хэсэгтээ заасан налуугаас илүү эгцгүй байх ба бэлэн болсон ташуулгын аль ч цэг дэх дундаж хэмжээ нь 300мм-с илүү хэлбэлзэлгүй байна. Шатлалт хийх шаардлагатай газруудад шат бүрийн оройн хэсэг зурагт заасан 300мм-с илүүгээр

хэлбэлзэхгүй байх ба шатны оройн хэсэг нь усыг чөлөөтэй шүүрүүлдэг байна.

в) Дүүргэлтийн ташуулга

Дүүргэлтийн ташуулгыг гаргахдаа ташуулгын ёроол, оройн хэсэг нь замын тэнхлэгийн шугамтай ойр биш зайнд байхаар барих ба Зурагт заасан ташуулгын шугамнаас гадагш 1000мм-с илүүгүй байна. Хоолойн талын болон ташуулгын ёроолын аль аль талд 10м доторх газарт зурганд заасан ташуулгын шугамын гадна талаас 300мм-с илүүгүй байна. Энэ хэмжээнээс хэтрэх аливаа материалыг зайлцуулж, далангийн барилгын ажилд дахин хэрэглэнэ.

г) Ердийн дүүргэлт болон ухмалын гадаргуугийн ерөнхий хүлцэх алдаа

(i) Ухмалын хувьд, хадархаг хөрснөөс бусад төрлийн хөрсний хэсгийн ухмалын ёроолын (ул хөрсний) түвшний хүлцэх алдаа нь Зурагт заасан түвшингээс ± 40 мм дотор байна.

(ii) Ухмалд, хадархаг хэсгийн ухмалын доод ирмэг (ул хөрсний) түвшиний хүлцэх алдаа нь Зурагт заасан түвшингээс +0-ээс -80мм дотор байна.

(iii) Ухмалд, хаднаас бусад хийцийн бүсийн оройн хэсэг Зурагт үзүүлэсэн түвшнээс +0-ээс -50мм байна.

(iv) Бэлэн болсон ташуулгын гадаргуу нь аль ч чиглэлийн 3м шuluун ирмэгээс 25мм-ээс илүү хэлбэлзэхгүй байх ба ус тогтоооргүй байна.

д) Шатлалын түвшин

Шатлалын дээд хэсгийн гадаргуугийн түвшин нь Зурагт заасан түвшингээс ± 50 мм дотор байна.

3.3.1 Ухмал, дүүргэлтийн хоорондын шилжилт

Ухмалын болон дүүргэлтийн доод ирмэг хоорондын шилжилтийн хүлцэх алдаа нь Зурагт заасан хэмжээнээс эсвэл захиалагчийн инженер зөвшөөрсний дагуу +0мм-ээс -50мм байна

БҮЛЭГ 4 – ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАЛТ

4.1 ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

a. Ерөнхий

Талбайн цэвэрлэгээ гэдэг нь хуучин хучилт материалыг хуулж цэвэрлэх, хашлага хаалтыг буулгах зайлцуулах, бут, сөөг, үндэс, хожуул, зулзаган мод, бул чулуу зэргийг булгалах, сугалах, цэвэрлэж, зайлцуулах, тэдгээрийг булгалж сугалахад үүссэн нүхнүүдийг буцаан дүүргэж, засах зэрэг ажлууд орно.

Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлцуулах явцад Гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар анхааралтай ажиллана. Зурагт үзүүлсэн эсвэл Захиалагчийн инженерийн зааварласан газруудад талбайн цэвэрлэгээг хийнэ. Гүйцэтгэгч өөрсдийн тур суурин, шороон ба чулууны орд газар, материал нөөцлөх талбай ба хаягдал зайлцуулах газар болон бусад ажлын талбайд Захиалагчийн инженерийн заавраар талбайн цэвэрлэгээг хийнэ. Дээр дурдсан газрууд нь төлбөрт хамарагдахгүй.

Захиалагчийн инженер талбайн цэвэрлэгээний явцад буулгаж, зайлцуулж болохгүй тусгай мод, хожуул эсвэл объектуудийн талаар зааварлана. Гүйцэтгэгч талбайн цэвэрлэгээний явцад нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй байх шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ба хэрэв өмч хөрөнгө, инженерийн шугам сүлжээнд ямар нэгэн гэмтэл учруулбал Гүйцэтгэгч нь гарсан хохирлыг бүрэн засах хариуцлагыг хүлээнэ.

Ургамалын үеийг зурагт заасан ба Захиалагчийн инженерийн зааварчилсан гүнд хуулж, зайлцуулах ажил талбайн цэвэрлэгээнд багтана.

b. Модноос бусад цэвэрлэгээ

Захиалагчийн инженерийн заавраар талбайн цэвэрлэгээг хийсэн бол цэвэрлэж зайлцуулсан бүх материал нь модноос бусад цэвэрлэгээнд хамаарна. Нийтийн болон хувийн өмчид хохирол учруулах буюу хүрээлэн буй орчинд хамаарах шаардлагыг зөрчихгүйгээр гүйцэтгэгч нь хаягдал материалыг зайлцуулах буюу хаяна. Техникийн шаардлагад заасны дагуу хаягдал зайлцуулах цэгийг тогтооно. Хэрэв Гүйцэтгэгч урьдчилан талбайг цэвэрлэх ажлыг хийсний дараа гол ажил эхлэхээс өмнө зүлэг дахин ургавал нэмэлт талбайн цэвэрлэгээг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

c. Бусад шаардлага

Захиалагчийн инженерийн заавраар талбайн цэвэрлэгээ хийсэн бол цэвэрлэж зайлцуулсан бүх материал нь Гэрээний нөхцөлд хамаарна. Хаягдал зайлцуулах газрыг Техникийн шаардлагад заасны дагуу зохион байгуулна. Хэрэв Гүйцэтгэгч нь барилгын үндсэн ажил эхлэхээс өмнө талбайг цэвэрлэсэн боловч барилгын ажил эхлэхэд дахин цэвэрлэх нэмэлт ажил гарвал өөрийн зардалаар хийж гүйцэтгэнэ.

4.2 ӨНГӨН ХӨРСИЙГ ХУУЛАХ

Талбайн цэвэрлэгээ хийгдэх хэсгүүдэд ургамалын үеийг зурагт заасан буюу Захиалагчийн инженерийн зааварчилсан гүнд Гүйцэтгэгч хуулж зайлцуулна. Хэрэв Гүйцэтгэгч заагдсан гүнээс илүү гүн хөрсийг хуулбал өөрийн өртгөөр заагдсан хэмжээнд хүртэл дүүргэж нягтуулна.

4.3 ХААЛТ, ХАШЛАГА БА БАЙГУУЛАМЖИЙГ ЗАЙЛУУЛАХ

Гүйцэтгэгч зураг болон Захиалагчийн инженерийн зааварчилгааны дагуу барилга, байшин, суурь, хуучин төмөрбетон хоолой, хашаа болон хиймэл байгууламж болон хөшөө, овоо болон бусад байгууламжуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн буулгах, нураан зайлцуулах ажлыг хийнэ. Захиалагчийн инженерийн шийдвэрийн дагуу дахин ашиглах боломжгүй бүх төрлийн материалыг Гүйцэтгэгч талбайгаас зайлцуулан энэхүү Техникийн шаардлагын 4.1(b)-д заасны дагуу хаягдал зайлцуулах цэгт аваачиж буулгана.

4.4 ХУУЧИН ГҮҮРИЙГ НУРААХ ЗАЙЛУУЛАХ

Энэ төсөлд хамаарахгүй.

4.5 ХАШАА, МОД, ХАШИЛТЫГ ХАМГААЛАХ

Захиалагчийн инженер эвдлэлгүй орхихыг зааварласан ямар нэгэн жим зөрөг, хашаа, хана, хашилт, мод, бут, зүлэг ба бусад зүйл зэргийг ажил гүйцэтгэж байх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан шаардлагатай бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс болж ямар нэг хохирол учирвал сэргээн засварлах ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

4.6 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ, СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ

Зам барилгын ажлын талбайд орсон шилэн кабель болон цахилгааны шугамыг өргөх, бэхлэх, шилжүүлэх ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, стандартыг дагуу гүйцэтгэнэ. Инженерийн байгууламжид тодруулга хийх, заасан шаардлагын дагуу гүйцэтгэх хэрэгтэй. Инженерийн шугам сүлжээг хамгаалах, шилжүүлэх ажлыг тухайн шугам сүлжээний ашиглагчийн заавар болон Захиалагчийн инженерийн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэнэ. Энэ ажилтай холбогдох төлбөрийг зөвхөн Захиалагчийн инженерийн баталснаар Гүйцэтгэгчид олгоно.

4.7 ХУДАГ ГАРГАХ

Зам барилгын ажилд хэрэглэх усыг хангах зорилгоор Гүйцэтгэгч худаг гарган ашиглаж болох ба ингэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллана.

4.8 ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

(а) Зүйл: Талбайн цэвэрлэгээ

Нэгж : Га

Замын чулуун ба шороон ордын талбай болон замын уртад хийх талбайн цэвэрлэгээний ажлыг (байгууламжаас бусад) гектараар хэмжинэ. Түр суурин, чулуун ба шороон орд, нөөц материал, хаягдал материалын цэг, тэдгээрт хүрэх түр замууд, суваг, шуудууны талбайн цэвэрлэгээний зардлыг Гүйцэтгэгч өртөг зардалдаа багтаасан гэж тооцино. Талбайн цэвэрлэгээний ажлын зардалд дараах зүйлүүд багтана.

Үүнд:

- Өвс, ногоо, хог шороо, бут ширэг болон бүх төрлийн бартаа саадыг цэвэрлэх, булгалж сугалах, хаях;
- Ургамалын үеийг 200мм зузаантай хуулж зайлцуулах;

- Ургамлын үндсийг ховхлох, сугалж зайлцуулах
- Бул чулуу, хожуул болон үндсийг зайлцуулах гэх мэт мод тайрах ажил;
- Шаардлагатай тээвэрлэлт;
- Ажлыг бүрэн дуусгахад шаардагдах ажилчид, материал, багаж, техник дагалдах материалуудын нөхөн төлбөр;

ЗАХИАЛАГЧ

Б. Чижиг

97

ГҮЙЦЭТГЭГЧ

Б. Чиратжим

БҮЛЭГ 5 - ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

5.1. БҮЛГИЙН АГУУЛГА

Энэ бүлэгт далан барих болон ухмалын ухалтын ажил багтах ба эдгээр нь хажуугийн шуудуу, шатлал, даланд асгаасан чулуун дүүргэвчтэй материалыг асах, тэгшлэх, нягтуулах, суурийн үеийн материалыг асах, тэгшлэх, нягтуулах ажлууд багтана.

5.2. ЕРӨНХИЙ

Газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч Инженерийн зааврын дагуу талбайн цэвэрлэгээ, мод, хожуулыг булгалах, сугалах, намаг болон шаварлаг хөрсийг зайлцуулах, өнгөн хөрсийг хуулах зэрэг ажлыг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг Инженерийн зааварчилснаар буюу зургийн дагуу гүйцэтгэнэ.

Газар шорооны ажлыг энэхүү шаардлагын дагуу хийж гүйцэтгээгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахиж гүйцэтгэнэ. Ухмалаас гарсан тохиромжтой материалыг даланд хэрэглэж болно. Техникийн үзүүлэлтийн хувьд тохирохгүй материалыг далангийн дүүргэлтэд хэрэглэхгүй.

Тохиромжгүй материалд дараах зүйлс багтах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- ✓ Өнгөн хөрс, намгархаг хөрс, хүлэртэй хөрс, хожуул, органик бодис 2%-иас их агуулсан шороо, амархан мууддаг материал холилдсон хөрс шороо;
- ✓ Шигшүүрийн 0.075мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 10 %-иас их;
- ✓ Хөөлт нь 2 %-иас их;
- ✓ Уян налархайн индекс 9 %-иас их;
- ✓ Урсалтын хязгаар 35 %-иас их материал;
- ✓ Бул чулуу, хад болон 75 мм-ээс том хэмжээтэй чулуу.

Тохирохгүй буюу эсвэл илүү гарсан тохирох материалыг Гүйцэтгэгч ашиглагдахгүй материалын талбай руу зөөж зайлцуулна. Гүйцэтгэгч нь дүүргэлтэд тохирох материалыг зөвхөн ухмал ба олборлох талбайгаас ашиглаж болно. Даланд шаардлагатай материалын хэмжээ нь ухмалаас гарсан тохиромжтой материалаас илүү байвал Гүйцэтгэгч Инженерийн заавраар ухмалыг өргөтгөх эсвэл шороон орд нээж болно. Гүйцэтгэгч нь ухмалын болон дүүргэгч материал дэвссэн гадаргууг цаг агаарын нөлөөлөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас гэмтэж эвдрэхээс сэргийлж, хамгаалах үүрэгтэй. Хэрэв ямар нэг эвдрэл гарсан тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар тухайн ажлыг засаж хийнэ. Гүйцэтгэгч далангийн дүүргэлтэд тохиромжтой материалыг ашигласан эсэхийг баталгаажуулах үүднээс нэмэлт хяналт хийнэ. Хэрэв ямар нэг тохиромжгүй материал ашигласан бол түүнийг зайлцуулан оронд нь тохиромжтой материал дэвсэх ажлыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх болно. Ухмал, далан, хажуугийн шуудуу зэргийг тогтоосон налууд хүртэл тэгшилж засах ажлуудыг газар шорооны ажил явагдаж буй байршил, төвшинд нэг зэрэг хийнэ. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг хийж гүйцэтгэхдээ Инженерийн зааварчилгааг биелүүлэх ёстой.

5.3. УХМАЛ МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

Замын ухмалаас гарсан материалыг дараах байдлаар ангилна:

ЗАХИАЛАГЧ

С. Чоромин

98

ГҮЙЦЭТГЭГЧ

С. Чоромин

(a) Ердийн ухалт

- Ердийн ухалтын ажилд хадан хөрсийг ухах болон хучилт хуулахаас бусад бүх ухалтын ажлууд орно.
- Ердийн ухалтад намагжсан, намгаас гарсан материал мөн багтана.

(b) Хатуу материалын ухалт

Хатуу материалын ухалтанд гэдэгт тэслэж суллан улмаар шингэн ба хийн шахуургат бутлагч төхөөрөмж ашиглан боловсруулах материалыг хэлнэ. Хадан хөрсний үнэлгээнд тухайн нөхцөл байдалд шаардагдах бүх аргаар хийх ухалтын ажлууд орсон гэж тооцно. 0.75м³ -ээс том чулууг ухаж зайлцуулах ажил нь хатуу хадан материалыг зайлцуулах ажлын төрөлд орно. 0.75 м³ -ээс бага эзэлхүүнтэй бат бөх хатуу чулууг ухах ажил нь ердийн ухалтанд орно. Ухмалын ангилалыг Инженер/хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/ тогтоох ба түүний шийдвэр эцсийнх бөгөөд Гүйцэтгэгч энэ шийдвэрийг мөрдөж ажиллана. Инженер /хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/-ийн зүгээс хадан хөрсийг ухах ажилд тэсэлгээг зайлшгүй шаардлагатай гэж үзтэл ухалт тэсэлгээг хийхгүй. Ажил үргэлжлэн хийгдэх явцад материалын ангиллыг Инженер болон Гүйцэтгэгч хоорондоо зөвшөөрөлцсөн байна. Материалын ангиллын талаар маргаан гарах тохиолдолд Инженер /хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч/-ийн шийдвэр эцсийн бөгөөд дагаж мөрдөх шийдвэр байна. Хатуу чулуун материалыг далангийн гадаргуугаас 900мм-ийн дотор дэвсэхгүй ба харин ухмалд зурагт үзүүлсэн төвшинд эсвэл Инженерийн зааварчилсан гүнээр ухаж зайлцуулна. Ухмалын ажил эхлүүлэхийн өмнө талбайд хэмжилт хийж Инженерт танилцуулан зөвшөөрөл авсаны дараа ажлыг эхлүүлнэ. Ухмалаас гарч буй материалыудын талаар сайтар судалгаа шинжилгээ хийж, Инженер зөвшөөрсөн тохиолдолд далангийн материал болгон ашиглана. Шинжилгээгээр үзүүлэлт шинж чанар даланд тохирохгүй нь тогтоогдсон бол талбайгаас зайлцуулна.

Талбайд ухмалын ажил эхэлж, цаашид үргэлжлэх явцад газрын төвөгшил, онцлог нөхцөл, цэвдэгийн байдал хөрсний шинж чанар зэрэг тодорхой болсон мэдээлэлд тулгуурлан, газрын төвшнөөс дооши газар шорооны ажлын болон суурийн төвшинг Инженертааруулан өөрчилж болно.

Онцгой нөхцөл төвөгшил ихтэй буюу цэвдэгтэй хэсэгт тусгайлан аргачлал гаргаж Инженерт танилцуулах ба газар хөлдөх, их хэмжээний ус чийг хуримтлахаас сэргийлэн ажиллаж, ухсанаас хойш 48 цагийн дотор дараагийн шатны ажлыг гүйцэтгэх шаардлагатай.

5.4. ДАЛАНГИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ

Далан барих газрын хэвгий 20% буюу 1:4-аас их байвал Гүйцэтгэгч хөрсний өнгөн үеийг хуулсны дараа даланг барих ажлыг эхлэхээс өмнө газрыг шатлан ухна. Дэвсэх ба нягтруулах тоног төхөөрөмжийг ажиллах боломж олгох үүднээс далангийн доорх эхний шатлалыг хангалттай өргөн зайд гаргаж ухна. Дүүргэлт хийж нягтруулсны дараа дараагийн шатлалыг ухна. Газрыг шаталж ухах үед гарсан материал/ ыг зайлцуулах буюу эсвэл Инженер ашиглахад тохиромжтой гэж үзсэн тохиолдолд дүүргэлтэнд ашиглана. Шаталж ухах өндөр нь 500-700мм эсвэл Инженерийн зааварчилсны дагуу байна.

Гүйцэтгэгч нь далангийн доорх болон ухмалын төвшингөөс 300мм-ийн доор байгаа ул хөрсийг нийт өргөнийх нь дагууд хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулна.

Далангийн доорх ул хөрс болон шаталсан талбайн нягт нь дээр зааснаас бага байвал Инженерийн зааварласны дагуу баригдаж буй нийт өргөнд 200 мм буюу түүнээс илүү гүнд сэндийлж, XYXИН-ын 95%-иас багагүй (AASHTO T180) нягтраптай болтол нягтруулна. Нягтруулалт хийх үед хөрсний чийгийн хэмжээ тохиромжтой чийгээс (AASHTO T180) 1%-иас бага, 2%-иас их байж болохгүй. Чийгийн хэмжээ тохиромжтой агуулгаас их бол хөрсийг хатаах ба бага бол дахин чийг өгнө. Далангийн ажилд зарцуулах төлбөрөөс тусдаа ямар нэг төлбөр шатлалын ажилд зориулан хийгдэхгүй.

Далангийн доорх ул хөрсийг дүүргэлт хийхэд тохиромжгүй гэж Инженерийн үзсэн нөхцөлд Гүйцэтгэгч ул хөрсийг Инженерийн заасан гүнд хүртэл ухан, ашиглагдахгүй материалын талбайд зөөж зайлцуулан, оронд нь тохиромжтой материалыг дэвсэж, зохих шаардлагын хэмжээнд хүртэл нягтруулна. Солих материалд хатуу материал орсон байж болно.

5.5. ДАЛАН БАРИХ

a) Далангийн барилгын ажил

- Тохиромжгүй гэж үзэхээс бусад тохиолдолд замын ухмалаас гарсан материалыг даланд хэрэглэнэ. Нөөц газраас авах материалыг зөвхөн ухмалаас гарах материал хангалтгүй гэж Гүйцэтгэгчийн нотолж, Инженерийн зөвшөөрсөн газарт хэрэглэнэ.
- Материалыг зөвхөн чийгтэйгээс болоод тохиромжгүй материал гэж үзэхгүй. Чийгтэй материалыг урсалтын хязгаар нь техникийн шаардлагад заасан чийгийн хэмжээнд нийцэх хүртэл нь борнойдож хатаана.

Зураг төсөлд өөрөөр үзүүлээгүй, эсвэл Инженер өөрөөр зааварчлаагүй бол Инженерийн зөвшөөрсөн шороон орд, эсвэл ухмалаас гарсан тохиромжтой дүүргэгч материалыг далан барихад ашиглана. Өөрөөр тогтоогоогүй бол Гүйцэтгэгч нь газар шорооны ажилд шаардлагатай материал олборлох талбай, ашиглагдахгүй материалын талбайг сонгож, Инженерээс урьдчилан зөвшөөрөл авч, орон нутгийн Засаг захирагааны байгууллагуудтай зөвшилцнө. Гүйцэтгэгч нь материал олборлох талбай ба замын ухмалаас гарсан материалын тохирох эсэхийг шалгах бөгөөд материалын ашиглалтын асуудлыг Инженерийн зөвшөөрлийг авсаны дараа баталгаажуулна. Далангийн материал нь дараах шинж чанарыг хангасан байна.

Үүнд:

- Шигшүүрийн 0.075 мм-ийн нүхээр өнгөрөх хэсгүүдийн жин нь хуурай үеийн жингийн 8 %-иас бага;
- Хөөлт нь 1%-иас бага;
- Урсалтын хязгаар нь 25 %-иас бага;
- Уян напархайн индекс 9 %-иас бага;
- Уян напархайн үржвэр нь 90-өөс бага;

- Хуурай үеийн хамгийн их нягт 1.85t/m^3 -иас багагүй;
- Хөрсний ачаа даацын үзүүлэлт нь 20%-иас багагүй байна.

Хүснэгт 5-1: Далангийн материалд тавигдах ширхэглэлийн шаардлага

Шигшүүрийн хэмжээ	Шигшүүрээр өнгөрсөн материалын жингийн эзлэх хувь
63 мм	95 -100
37.5 мм	85 -100
25.0мм	80 -100
19.0мм	50 - 90
9.5 мм	30 – 70
4.75 мм	25 - 60
2.36 мм	15 – 40
0.425 мм	8 – 20
0.075 мм	0 – 15

Инженерийн зааварчилснаас өөрөөр заагаагүй буюу зурагт үзүүлээгүй бол далангийн дээд хэсэгт дээр дурдсан үзүүлэлт бүхий материалыг Инженерийн зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ. Ухмалын ул хөрс нь далангийн дээд хэсэгт хэрэглэх материалын шаардлагыг хангахгүй нөхцөлд шаардлага хангасан материалаар хийх ёстай.

Ухмалын материалд тавигдах шаардлагыг хангаж байгаа боловч үеийн зузаан нь 30 см-ээс бага байвал далангийн дээд үед тохиromжтой материалыг зөөверлөн авчирч дэвсэнэ. Далангийн дээд үеийн дор байгаа шороо нь шаардлага хангахгүй тохиолдолд Гүйцэтгэгч нь тохирохгүй материалыг Инженерийн заасан гүнд хүртэл ухан авч, ашиглагдахгүй материалын талбайд зөөж зайлцуулан тохирох материалыаар сольж, нягтралын зэрэг нь далангийн дээд үетэй ижил болтол нягтруулна. Материал солих үеийн зузаан нь 250 мм-ээс багагүй байна. Гүйцэтгэгч нь газар шорооны ажлыг дарааллын дагуу тасралтгүй аргаар хийж гүйцэтгэх бөгөөд үе тус бүрийг барьж дуусах бүртээ баталгаа авах хүсэлтээ бичгээр үйлдэнэ. Баталгаа авсны дараа дараагийн үеийг хийнэ. Баталгаа авсан үеийг 24 цагаас дээш хугацаагаар хамгаалалтгүйгээр орхисон тохиолдолд Гүйцэтгэгч нь баталгааг дахин авах бөгөөд энэ үеийн дээр шинээр үе дэвсэхийн өмнө шаардлагатай гэж Инженер үзвэл урьд нь дэвссэн үеийг дахин сэргээн засварлана. Нягтруулагч тоног төхөөрөмж болон ажлын горим, нягтруулалтыг чанартай жигд хийх технологи аргачлалаа боловсруулан талбайн туршилтын үр дүнгийн хамт Инженерт танилцуулж батлуулна. Гүйцэтгэгч нь цаашид далангийн ажил хийхдээ уг аргачлалын дагуу технологийн горимыг баримталж ажиллана.

Хэрэв далангийн ажлыг эхлэхэд түүнд хэрэглэх шороон материал, тоног төхөөрөмж болон ажлын горим нь талбайн туршилтын үед үзүүлж байснаас өөр байвал Инженер болон түүний төлөөлөгч ажлыг урьдчилсан мэдэгдэлгүйгээр зогсоох эрхтэй. Ийм тохиолдолд Гүйцэтгэгч нь шинээр талбайн туршилтыг хийж Инженерээс зөвшөөрөл авна. Нягтруулсан үеийн зузаан нь 250 мм буюу инженерийн зөвшөөрсөн хэмжээнээс хэтрэх ёсгүй. Үе бүр зохистой ширхэглэл бүхий чулуунаас бурдэх бөгөөд жижиг

ширхэглэлтэй чулуунууд хайргатай жигд холилдсон байна. Үе бүрийг далангийн нийт өргөний хэмжээнд техникийн шаардлагад заасны дагуу нягтруулна. Өндөр далан барих тохиолдолд хэрэв Инженер зөвшөөрвөл далангийн дээд үеэс 1.5м-ээс доош орших төвшинд 200 мм-ийн хүртэл хэмжээтэй дүүргэгч хатуу материалыг далангийн үед ашиглаж болно. Өндөрлөгөөнд хэрэглэх хатуу материал нь далангийн нийт өргөнд тараагдахад нягтруулаагүй үеийн зузаан нь 400 мм-ээс хэтрэхгүй байвал зохино. Далангийн шороог бульдозер эсвэл автогрейдерээр тарааж тэгшилнэ.

Инженер нь ажлын аргачлал, талбайн туршилтыг хянаж шалгаад өөрийн санал зөвлөмжийг уг аргачлалд оруулж болно. Далангийн хажуу налууд материал нэмж дэвсэхээс бусад тохиолдолд даланг барихдаа Гүйцэтгэгч нь далангийн нягтрах байдал, суулт, агшилтын зөвшөөрөгдөх хэмжээг бодолцох ёстой. Даланг барих явцад материал нягтарч суух, доод үе рүүгээ шигдэх тохиолдол гарвал Гүйцэтгэгч өөрийн зардлаар үе бүрийн тогтоосон төвшин ба өргөнд хүртэл зөвшөөрөгдсөн дүүргэгч материалыг дахин дэвсэж нягтруулах ёстой. Гүйцэтгэгч нь далан барих ажлын үед нягтруулсан шороон үеийн хамгаалалтгүй гадаргуу дээгүүр ямар нэгэн тээврийн хэрэгслийг явуулахгүй байх арга хэмжээг авна. Хэрэв нягтруулсан шороон үе нь хэв гажилтад орох эсвэл тээврийн хэрэгсэл дээгүүр нь явж эвдсэн бол дараагийн үе шатны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн үеийг дахин засварлаж нягтруулна. Барьж байгаа буюу дууссан далан дээр дүүргэгч материалыг овоолж болохгүй, ийм хэлбэрээр зам хаах, хөдөлгөөн хязгаарлахыг хориглоно.

Даланг гүүр хоолойнуудын төвшинд хүртэл эсвэл хоолойн дээгүүр барихдаа байгууламжийн 2 талаар ижил түвшинд даланг өндөрлөнө. Инженер өөрөөр заагаагүй бол энэ ажлыг байгууламжид дүүргэлт хийх ажилтай хамт нэг зэрэг хийнэ. Даланг нягтруулах тоног төхөөрөмжийн тухайн байгууламжид аль болох ойртуулах ба ингэхдээ тэдгээрт ямар нэг гэмтэл учруулбал Гүйцэтгэгч өөрийн зардалаар засна.

5.6. НАМАГТАЙ БОЛОН БАМБАЛЗУУР ХӨРСИЙГ ЧУЛУУГААР ДҮҮРГЭХ

Намагтай болон бамбалзуур хөрстэй газрыг ухан Инженерийн зааварласан хаягдал зайлцуулах газарт хаяж. Чулуун дүүргэлтийг зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

- Чулуун дүүргэлтийг зааварласан газарт нийтэд нь сайтар суух хүртэл жигд үеэр дэвсэж, индүүдэн хөдөлгөөн явуулна. Тогтвортгүй ул суурь дээр чулуун дүүргэлтийг хийх бол материалыг ажлын талбайд ойрхон газарт буулгаж далангийн өндөр нь барилгын ажлын хүнд машин механизмын ачааллыг даах боломжтой болох хүртэл нь бульдозeroор түрж тараах замаар хийнэ. Хажуу налууг зурагт зааснаар хийнэ.
- Чулуун дүүргэлтийн 10 мм-ээс жижиг ширхэгтэй чулууны хэмжээ нь 5%-иас хэтрэхгүй, хамгийн том нь 250 мм-ийн хэмжээтэй байна. Нягтарсан үеийн зузаан 500 мм буюу үүнээс бага байх ба чулуун дүүргэлтийг хийж байх явцад Инженер тавигдах шаардлагуудыг өөрчилж болно. Дараагийн үеийг дэвсэхээс өмнө урьд дэвссэн үед жижиг ширхэгтэй чулууг хийн, нүх сүвийг чигжиж нягт болгоно. Техникийн шаардлагад зааснаар нэмэлт үеүдийг дэвсэх буюу газар шорооны ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч чулуун үе бүрийг боломжийн хязгаарт

нягтруулсан байна.

5.7. ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН НЯГТРУУЛАЛТ

Гүйцэтгэгч нь нягтруулах ажлыг эхлүүлэхийн өмнө дүүргэгч материалын чийгийн хэмжээг тодорхойлох ёстай. Материалыг услах буюу хатаах замаар нягтруулах үеийн чийгийн хэмжээ нь (AASHTO T180) тохиромжтой чийгийн хэмжээнээс -1 +2%-ийн хооронд хэлбэлзэж байхаар тохируулна. Гүйцэтгэгч нь далангийн дээд хэсгийн 250мм зузаантай үеийн хөрсний чийгийн хэмжээг материалыг услах буюу хатаах замаар (AASHTO T180) тохиромжтой чийгийн хэмжээнээс -1,+2%-ийн хооронд хэлбэлзэж байхаар тохируулна. Дүүргэгч материалыг тодорхой зузаантайгаар жигд тараагаад материалын үе бүрийн чийгийн хэмжээ нь дээр дурдсан хязгаарт байхаар буюу хуурай үеийн нягт нь дор зааснаас багагүй байхаар нягтруулна. Үүнд:

- A. Далангийн дүүргэлтийн бүх үеүдийн дүүргэгч материалыг хуурай үеийн хамгийн их нягтын 95%-иас багагүй байхаар нягтруулах ёстай.
- B. Далангийн суурийн үеийг хуурай үеийн хамгийн их нягтын 98%-иас багагүй байхаар нягтруулах ёстай.
- C. Ухмалд хийсэн шинжилгээний үр дүн суурийн үед тохирохоор гарсан хөрсийг хуурай үеийн хамгийн их нягтын 98% -иас дээш байхаар нягтруулах ёстай
- D. Хучилтын үеийн материалын хуурай үеийн хамгийн их нягтын 98% -иас дээш байхаар нягтруулах ёстай.

Далан ба далангийн дээд хэсгийн нягтруулалтыг Инженерийн зөвшөөрлөөр Гүйцэтгэгчийн санал болгосон горимын дагуу хийж гүйцэтгэнэ. Ухмал ба өндөрлөх хэсгийн 300 мм-ийн зузаантай далангийн дээд хэсгийг 150 мм-ийн зузаантайгаар хоёр үеэр нягтруулна. Нягтруулах явцад Гүйцэтгэгч нь шаардлагатай гэж үзвэл холимог материалын хөндий зайд чигжиж өгөх үүднээс гадаргууг усална. Гүйцэтгэгч нь талбайд нягтруулалтын туршилтыг лабораторийн шинжилгээний хамт хийж гүйцэтгэх бөгөөд нягтруулалттай холбоотой бүх шаардлагыг хангасан байх ёстай. Гүйцэтгэгч Инженерийн санал болгосон нягтруулалтын горимын бусад туршилтыг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь нягтруулалтад зайлшгүй хэрэглэх усаа нөөцлөх ёстай. Нягтруулалтад зөвхөн давсгүй, элдэв хольцгүй цэвэр ус хэрэглэх ба Инженерийн зөвшөөрсөн эх булгаас авна. Хэрвээ Инженер шаардсан бол Гүйцэтгэгч нь усанд шинжилгээ хийлгэж, шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана. Гүйцэтгэгч нь ус зөөврөлөх болон тараах шаардлагатай бүхий л тоног төхөөрөмжөөр хангана. Шүршиг хошуу эсвэл ижил төстэй тоноглолтой усны нөөц сав ашиглан усыг далангийн үеүдийн гадаргуу дээр тогтмол хэмжээгээр жигд шүршинэ. Инженерээс зөвшөөрөгдсөн автогрейдер, анжис эсвэл ижил төрлийн холигч машин ашиглан нягтруулах гэж байгаа шороог устай жигд хольсон байх ёстай. Инженер далангийн тухайн үеийг хангалттай нягтруулсан гэж үзэж зөвшөөрөл өгсөн тохиолдолд дараагийн шинэ үеийг дэвсэнэ.

5.8. ХАЯГДАЛ МАТЕРИАЛ

Замын ухмалаас гарсан далангийн дүүргэлтэд ашиглахад тохиромжгүй буюу дүүргэлтийн болон суурийн үед хэрэглэх шаардлагагүй гэж Инженерийн тодорхойлсон бөгөөд хаягдал зайлцуулах талбайд зөөж буулгах заавар өгсөн материалыг хаягдал материал гэж тодорхойлно. Эхлээд хаягдал материал гэж ангилагдсан боловч дараа нь

Инженерийн зөвшөөрлөөр Гүйцэтгэгч далангийн дүүргэлт, суурийн үе буюу зам барилгын нэг хэсэг болгож ямар нэгэн байдлаар хэрэглэсэн ухмалын материалыг хаягдал материал гэсэн ангиллыг нь өөрчилж, хаягдал материалын хэмжилтэд зохих өөрчлөлтийг хийж болно. Гүйцэтгэгч байршлыг нь тогтоож, Инженер урьдчилан баталж, орон нутгийн захиргааны зөвшөөрсөн хаягдал материал зайлуулах талбайд Гүйцэтгэгч хаягдал материалыг зөөвөрлөж хаяна. Энэ техникийн шаардлагад заасны дагуу Гүйцэтгэгч хаягдал материалын талбайг олж тогтооно. Гүйцэтгэгч хаягдал материалыг зайлуулах үйл ажиллагааг эхлэх тухай мэдэгдлийг хамгийн багадаа 24 цагийн өмнө Инженерт мэдэгдэнэ.

5.9. ШОРООН ОРД, ТУРШИЛТЫН НЯГТРУУЛАЛТ

Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордыг тогтоох бөгөөд материалыг зөвхөн Инженерийн зөвшөөрсөн шороон ордоос авна. Шороон ордын материал шинж чанараараа нэг төрлийн, ижилхэн байх шаардлагыг хангахын тулд шороон орд болон түүнд ойрхон газарт материалыг сайтар холих буюу овоолго хийж, дараа нь хэрэглэхээр бэлтгэнэ. Гүйцэтгэгч нь шороон ордод очих туслах замыг барьж, өвс ургамал, хад чулуу, овор хэмжээ ихтэй тохиромжгүй материал материал, том чулууг зайлуулна. Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордыг нөхөн сэргээх үед ашиглах зорилгоор өнгөн хөрсийг хуулж, овоолон хадгална. Гүйцэтгэгч нь шороон ордод буй тохиромжтой материал нь тохиромжгүй материалтай холилдохгүй байх арга хэмжээг авна. Тохиромжгүй материалыг техникийн шаардлагад заасны дагуу зайлуулах. Зайлуулан ухмалыг нөхөн сэргээхэд ашиглана.

Шороон ордыг тогтоосон өргөн ба хэлбэрээр ухах ажил дууссаны дараа цэвэрлэж, нөхөн сэргээнэ. Нөхөн сэргээсэн шороон ордын хажуу налуу нь хамгийн ихдээ хэвтээ байдлаар 6, босоо байдлаар 1 гэсэн харьцаатай байна. Техникийн шаардлагад заасны дагуу ордын хажуу налуу ба ойр орчим нь цэвэрхэн үзэмжтэй засагдсан байна. Шороон ордыг тойруулж, хашаа хийж, аюулгүй ажиллагааг хангана. Шороон ордыг ашиглахдаа техникийн шаардлагын холбогдох заалтуудын зэрэгцээ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зааврыг баримтална.

Далангийн доорх ул хөрс, ухмалын ёроол, чулуун дүүргэлтийн үеүдийг доргиулагч индүү ба гөлгөр бултай индүүгээр нягтруулна. Инженерийн оролцоотойгоор Гүйцэтгэгч туршилтын нягтруулалтыг хийнэ. Нягтруулалтыг хангалттай гүйцэтгэсний дараа л тухайн үеийг зузаан болон нягтруулалт хийх арга технологийг баталгаажуулна. Туршилтын нягтруулалтын зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Хэрэв туршилтын нягтруулалтын дараа ямар нэг засвар хийх шаардлагатай бол холбогдох зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

5.10. ХАЖУУ НАЛУУГ ТЭГШИЛЖ ЗАСАХ

Гүйцэтгэгч нь далангийн болон ухмалын хажуу налууг зурагт зааснаар буюу Инженерийн зааврын дагуу гараар болон зөвшөөрөгдсөн техник ашиглан тэгшилж янзлах ёстой. Далангийн хажуу налууг зохих ёсоор нягтруулах бөгөөд нягтруулаагүй, дутуу нягтруулсан болон илүүдэл хэмжээтэй материалыг тэгшлэн хусаж, далангийн хажуу налуугаас зайлуулна. Илүүдэл материалыг хаягдал материал зайлуулах талбай руу зөөх эсвэл Инженерийн зөвшөөрлөөр тарааж тэгшилнэ. Ухмалын хажуу налууд ил гарсан том чулуу, хадыг зайлуулан, үссэн зайд нь Инженерийн зөвшөөрсний дагуу тохиромжтой материалаар дүүргэлт хийн нягтруулна. Далан ба ухмалын хажуу налууг

тэгшилж засах нь ухмал болон далангийн ажлын нэг хэсэг гэж тооцогдох ба Гүйцэтгэгчид тусдаа төлбөр хийгдэхгүй.

5.11. ХАЖУУГИЙН ШУУДУУ, ШИРЭГ ДЭВСЭХ

Зураг төсөлд заагдсан буюу Инженерийн зааварласан тохиолдолд Гүйцэтгэгч далангийн хажуу налуу, ухмалын хажуу энгэр, хажуугийн шуудууны бэхэлгээг ширгээр хийх ажлыг дараах байдлаар гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч сонгож, Инженерийн баталсан зохих эх үүсвэрээс ширгийг авч ашиглана. Ширгийн материал нь орон нутгийн олон наст ургамал байна. Ширэгний хамгийн бага зузаан нь 60 мм байна. Инженер өөрөөр зааварлаагүй бол ширгийг хажуу налууд зөвхөн 5, 6, 7 саруудад дэвсэнэ. Ширгийг дэвссэний дараа Гүйцэтгэгч ургаж, бэхжих хүртэл нь усалж арчилна. Ширэг дэвсэхийн өмнө далангийн элэгдэл, эвдрэлийг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засна. Хажуугийн шуудууг барих ажлыг Техникийн шаардлагад заасны дагуу ухмалын нэг адил авч үзэх ба газар шорооны ажлын ангилалд хамаарна. Инженерийн барилгын ажлын явцад хажуугийн шуудууны гүн, налуу хэмжээнд өөрчлөлт оруулж болох ба энэхүү өөрчлөлтийн дагуу барина.

5.12. УХМАЛЫН ХАЖУУ НАЛУУ ДАХЬ ТОГТВОРГҮЙ МАТЕРИАЛ

Ухмалын хажуу налууд нурамтгай, тогтвортгүй материал гарвал Гүйцэтгэгч Инженерт мэдэгдэх ба Инженер заавраар нурамтгай материалыг ухан зайлцуулж оронд нь тохирох материалаар дүүргэнэ. Тохиромжгүй хөрсийг ухаж зайлцуулах ажил нь ухмалын нэг хэсэг гэж тооцогдох ба тохирох материалаар дүүргэх ажил нь далангийн ажлын нэг хэсэг гэж тооцогдож холбогдох зааврыг баримтална.

5.13. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагад 20 м тутамд хэмжсэн хэмжилтийг ашиглан замын хөндлөн отглолыг зурж, газар шорооны ажлын хэмжээг тодорхойлно. Инженерийн зааварчилгааны дагуу хөрсний нөхцөл өөрчлөгддөг газарт болон огцом эргэлттэй газарт хөндлөн отглолын хэмжил болон зургийг илүү ойрхон алхам зайдтайгаар хийж болно. Мөн Инженер зөвшөөрсөн тохиолдолд газрын гадаргын байдлыг харгалзан хөндлөн отглол хийх зайг 50м хүртэл уртасгаж болно. Газар шорооны дүүргэлтийн ажлыг бүрэн дууссан даланд нягтуулсан материалыг шоо. метрээр хэмжинэ. Далангийн дүүргэлтэд хэрэглэх шороог авах зорилгоор ухсан ухмалын ажилд ямар нэгэн тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

Инженер нь шороон ордыг шинээр нээх заавар өгсөн тохиолдолд дор дурдсан зүйлд тусдаа хэмжилт буюу төлбөр хийгдэхгүй.

- Газрын зөвшөөрөл;
- Туслах замын зөвшөөрөл;
- Эзэмшигчид болон засаг захиргаатай хийх гэрээ хэлцэл;
- Олборлосон дүүргэгчийн татвар, хураамж;
- Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордын талбайн цэвэрлэгээ;
- Техникийн шаардлагад заасны дагуу шороон ордын өнгөн хөрсийг хуулан өөр газарт хэрэглэх;
- Тээвэрлэлт;
- Техникийн шаардлагад нийцүүлэх зорилгоор овор ихтэй материал, жижиг

ширхэгтэй болон бусад фракцын чулууг зайлцуулахын тулд материалыг бутлах буюу шигших;

- Шороон ордын тохиромжтой материалыг дахин шилжүүлэн зөөвөрлөх буюу түр зуурын овоолго хийх, Техникийн шаардлагад заасны дагуу өнгөн хөрсийг хуулж, түр зуур овоолон хадгалж, шороон ордыг сэргээн засварлахад хэрэглэх.

Инженер заавар өгсөн тохиолдолд Гүйцэтгэгч ухмал хийх явцад байгалийн хөрсний үе давхаргын өндрийг аль болохоор нарийн тодорхой үзүүлэх боломжийг олгох тийм хэлбэр, хэмжээ, байрлалд гүнийг заагч тэмдгийг тавьж байна. Гүйцэтгэгч гүн заагчийг сүүлчийн хэмжилт хийх хүртэл хэвээр байлгана. Техникийн шаардлагад заасны дагуу тохиромжгүй болон тогтвортгуй материалыг ухан зайлцуулах ажлын хэмжээг ухмалын эзлэхүүнээр хэмжин гаргана. Ухаж зайлцуулах материалын хэмжээг зохих нарийвчлалтай хэмжилтийн багаж болон хөндлөн ба дагуу зүсэлтийн зураг ашиглан гаргана.

(a) Зүйл: Замын далан барих

Нэгж: м³

Далангийн ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Карьер болон шороон ордыг ухах
- Чулуун асгаасыг бэлдэх, ачих, буулгах, өрөх
- Шороон орд, ухмалаас материалыг ачих, тээвэрлэх, даланд дүүргэлт шаардлагатай хэсгүүдэд буулгах;
- Замын зурvasын ухмал, шатлал гаргах ухмал болон шороон ордоос материал ухаж авах;
- Бүх төрлийн зөөвөр, тээвэрлэх ажил;
- Материалыг засах, хэлбэржүүлэх тараах, тэгшлэх, услах болон нягтуулах;

Инженерийн зааврын дагуу барилгын ажил эхлэхээс өмнө, мөн хойш 20 м-ийн зйтайгаар хэмжсэн, эсвэл нугачаатай болон уулархаг газарт илүү бага зйтайгаар хэмжсэн хөндлөн далангийн ажлын эзлэхүүнийг гаргана.

(b) Зүйл: Ердийн ухалт

Нэгж: м³ Ердийн ухмалын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Материалыг ухах;
- Материалыг ухах, ачих, тээвэрлэх ба тогтоосон хаягдал материал зайлцуулах цэгт хаях;
- Бүх төрлийн тээвэрлэлт;
- Өнгөн хөрсийг бэлдэх, хаягдал материалын цэгт өнгөн хөрсийг зайлцуулах;
- Энэхүү техникийн шаардлагад заасны дагуу хаягдал материалын талбайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх;
- Техникийн шаардлагад заасны дагуу далангийн доорх намагтай хөрсний ухалтад ямар нэгэн тусдаа болон нэмэлт төлбөр хийгдэхгүй.

(c) Зүйл: Хатуу материалын ухалт

Нэгж: м³ Хатуу материалыг ухах ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд

багтана. Үүнд:

- Трассын дагуу дахь хатуу материалын ухмал
- Тохиромжгүй материалыг зөөж зайлуулах
- Тэсэлгээний ажилтай холбоотой бүх зардалууд
- Бүх төрлийн тээвэрлэлт,
- Энэ техникийн шаардлагад заасны дагуу талбайг бэлдэх, хэлбэрт оруулах, засах сэргээх,
- Төлбөр хийх зорилгоор ухмалаас гарч буй эзэлхүүнээрээ 0.5м³-аас том хэмжээтэй чулууны эзэлхүүнийг тээвэрлэж буй машины тэвшинд дэх тэдгээрийн сул эзэлхүүний 50%-иар тооцож авна.

(d) Зүйл: Суурийн үеийг барих

Нэгж: м³ Суурийн үеийн ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана.

Үүнд:

- Ширхэглэл тохирсон хэрэглэхэд тохиромжтой материалыг чулуун болон шороон орд, замын ухмалаас ухаж гаргах;
- Материалын сонголт;
- Материалыг ачих, тээвэрлэх, суурийн үе хийх хэсгүүдэд буулгах;
- Овор хэмжээтэй том материалыг шигшиж зайлуулах;
- Бүх төрлийн зөөвөр, тээвэрлэх ажил;
- Материалыг зурагт заасан зузаанаар тараах, хэлбэржүүлэх, тэгшлэх, успах болон нягтруулах;

(e) Зүйл: Ул хөрсийг нягтруулах

Нэгж: м³ Ул хөрсийг ХҮХИН-ийн 95% хүртэл нягтруулах (AASHTO T180) ажлын хэмжилтийн нэгж нь куб метр байна. Нягтруулсан ул хөрсний эзлэхүүнийг нягтруулсан талбай ба тогтоосон, нягтруулсан зузааны үржвэрээр хэмжинэ. Нягтруулалтын ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Ул хөрсийг сийрэгжүүлэх;
- Овор ихтэй материалыг шигших, зайлуулах;
- Чийгийн агуулгыг нь тохируулахын тулд материалыг хатаах болон чийглэх;
- шаардлагатай хөндлөн хэвгийг гаргаж тэгшлэх;
- 150 мм зузаантай хоёр үеэр тэгшлэх болон нягтруулах;
- Энэхүү техникийн шаардлагын заалтуудыг хангаж ажиллах

(f) Зүйл: Хөрс солилт (Намагтай газрыг чулуугаар дүүргэх)

Нэгж: м³

Хөрс солих ажлын хэмжээг төлөвлөсөн дээд, доод суурийн талбайн дундажыг, дүүргэлтийн зузаанаар үржиж гаргана. Энэхүү ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Тохиромжгүй хөрсийг ухаж зайлуулах
- Дүүргэлтийн материалыг ачих, тээвэрлэх, дэвсэх
- Тарааж тэгшлэх нягтруулах

(g) Зүйл: Зүлэгжүүлэлт хийх

Энэ төсөлд хамаарахгүй

(h) Зүйл: Хажуу налууг засах (далангийн, ухмалын)

Нэгж: m^2

Хажуу налууг засах ажлын хэмжих нэгж нь квадрат метр байна. Төлбөрийг зурагт өгсөн хэмжээ эсвэл зассан талбайн хэмжээгээр тооцно. Хажуу налууг засах ажлын үнэлгээнд дор дурдсан ажлын зардлууд багтана. Үүнд:

- Материалыг ухаж авах;
- Материалыг ачих, тээвэрлэх, хадгалах;
- Шигших, том хэмжээст материалыг зайлцуулах;
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ба эдгээртэй холбогдох жижиг зардлуудын бүрэн төлбөр;
- Хөндлөн огтлолын хэмжээнд хүртэл налууг засах;
- Тэгшилж нягтуулах;

БҮЛЭГ 6 – ЧУЛУУН БА ШОРООН ОРД

6.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Цементбетон, буталсан чулуун суурь, чулуун өрлөг, чулуун асгаас, намаг, шавартай газрыг чулуугаар дүүргэх зэрэгт ашиглах чулуун материалуудын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагын бүлэг 6.2(а) -д заасан аргаар ордыг ашиглахад бэлдэнэ.

Замын далан барихад дүүргэлтэд ашиглах шороо болон суурийн үед ашиглах хайрган материалын эх үүсвэрийг Гүйцэтгэгч сонгоно. Энэхүү техникийн шаардлагад зааснаар эдгээрийг авах шороон ордыг тогтооно.

Чулууны болон шороон ордуудын байршилаас хэд хэдэн дээжүүдийг экскаватор, геологийн өрмийн машин зэргийг ашиглан авна. Тэсэлгээний ажил эхлэхээс өмнө Инженерийн оролцоотойгоор дээжүүдийг авч битүүмжлэн Итгэмжлэгдсэн лабораториид илгээж, үр дүнг нь баталгаажуулна. Шинжилгээний үр дүнгээс хамааран тухайн чулууг ямар зориулалтаар хэрэглэхийг шийднэ. Хэрэв шинжилгээний үр дүн бүлэг 2-ийн шаардлагуудыг хангаж байвал тохирсон хийцэд (далан, хучилтийн үе, суурийн доод үе г.м) тухайн ордоос хэрэглэж болно.

Зураг төслийн материалын тайланд дурдсан ямар ч чулуун орд, шороон ордын аль ч материалын чанар болон тэдгээрийн тохиромжтой эсэх талаар Захиалагч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. Тендерийн хугацаанд Захиалагч нь эдгээр бичиг баримтыг тендерт оролцогчдод чөлөөтэй үзэж танилцах боломж олгох бөгөөд тэдгээр нь тендерийн бичиг баримтын хэсэг болохгүй.

6.2. ТОДОРХОЙЛОЛТУУД

- Чулуун орд гэдэг нь зам барилгын ажилд ашиглах чулууг уулнаас өрөмдөж тэслэх буюу бусад арга хэрэгслүүдийг ашиглан олборлох газрыг хэлнэ.
- Шороон орд гэдэг нь зам барихад ашиглах чулуунаас бусад материалуудыг авч буй талбай юм.
- Материал нөөцлөх газар гэдэг нь дүүргэлтийн материал, хайрга, дайрга өнгөн хөрс зэргийг зам барилгын ажилд ашиглахын өмнө түр хугацаагаар нөөцлөн овоолох талбайг хэлнэ.
- Хаягдал материал зайлуулах газар гэдэг нь зам барилгын ажлаас гарсан илүүдэл болон шаардлага хангахгүй материалуудыг тараан асгадаг талбайг хэлнэ. Инженерийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр илүүдэл болон шаардлагата хангахгүй материалыг замын зурvas газарт асгаж болохгүй.

6.3. ГАЗАР ОЛГОХ

Захиалагч нь энэхүү техникийн шаардлагын бүлэг 1-д заасны дагуу барилгын ажилд шаардагдах замын зурvas болон бусад зориулалтын газрыг үнэ төлбөргүй ашиглах боломжийг нөхцөлийг Гүйцэтгэгчид бүрдүүлж өгнө. Үүнд:

- Чулуун ба шороон орд
- Материал нөөцлөх болон хаягдал зайлуулах газар,
- Тэдгээрт хүрэх туслах замууд,

- Замын зурvasын гаднах түр замууд,
- Талбайн лаборатори байгуулах газар,
- Инженерийн орон сууц болон ажлын байрны газар,
- Гүйцэтгэгчийн түр суурин, контор, агуулахууд, засвар үйлчилгээний болон амьдрах байрны газар,
- Түр барилгын ажилд шаардлагатай газар.

Бусад зорилгоор ашиглахад шаардлагатай газар авах асуудлыг Гүйцэтгэгч хариуцна. Чулуун болон шороон ордын газрыг тогтоох, ашиглахдаа гүйцэтгэгч нь Улсын болон орон нутгийн холбогдох хууль журмуудыг баримтлан ажиллана. Гүйцэтгэгчийн сонгож тогтоосон чулуун орд, шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудын байршил болон хэмжээг Инженер хянаж батална. Чулуун болон шороон орд, материал нөөцлөх, хаягдал зайлцуулах газруудын болон тэдгээр рүү хүрэх туслах замуудын байршил нь дор дурдсан нөхцөлтэй байвал Инженер зөвшөөрөл олгохгүй байж болно. Үүнд:

- Хүрээлэн буй орчинд хор нөлөө учруулахаар бол,
- Хот суурины дотор буюу түүнтэй хэтэрхий ойрхон байх,
- Хэтэрхий урт туслах зам шаардахаар бол,
- Дэндүү өргөн талбайг хамарсан байвал,
- Олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар бол,
- Ашиглаж болохуйц тохиромжтой материал болон газруудаас илүү хол байвал,
- Усны эх үүсвэр болон усан хангамжийг таслах, түүнд саад тогтор учруулахаар байвал.

Гүйцэтгэгч нь тухайн чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах талбайд ямар нэгэн ажил эхлэхээс хамгийн багадаа 28 хоногийн өмнө энэ талаар Инженерт бичгээр мэдэгдэнэ.

Дээрх мэдэгдлийг хийхээс өмнө шинжилгээ, судалгааны ажил хийгдсэн байх ёстой бөгөөд Гүйцэтгэгч нь хайгуулын ажил эхлэхээс 7 хоногийн өмнө орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж тэдний зөвшөөрлийг авсан байх ёстой. Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудыг сонгохын тулд тухайн орон нутгийн гэрээ хэлцэл хийж, холбогдох хууль журмын дагуу газар ашиглалтын ба түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр болон бусад шаардлагатай төлбөрийг хийсэн байх ёстой.

Гүйцэтгэгч нь газар ашигласны болон ус хэрэглэх, барилгын материал олборлохтой холбогдсон бүхий л татвар, хураамжийг хуульд заасны дагуу төлж барагдуулах хариуцлага хүлээнэ. Инженерт бичгээр мэдэгдэл өгөхийн өмнө Гүйцэтгэгч чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газар тус бүрд тэмдгүүд тавьж, ажил явагдах, материал нөөцлөх талбай, тэсэлгээний ажлын аюулгүй бүс, туслах зам г.м-ээр тэдгээрийн хил хязгаарыг зааглан тогтоож тэмдэглэсэн байна.

Барилгын ажилд ашиглах бүхий л шороон орд, карьерыг нээж ашиглахдаа дараах хүчин зүйлсийг тооцож үзвэл зохино. Үүнд:

- Төрийн тусгай хамгаалалттай, дархан цаазтай газар нутаг болон усны эх үүсвэр, усан хангамжийн бүст хамаардаг хэсэгт шороон ордыг нээх.

- Палеонтологийн болон тусгай шинжлэх ухаан, түүх, соёлын үнэ цэнэтэй олдвор бүхий газар нутаг болон байгалийн нэн ховор, үнэт ашигт малтмал түүхий эдийг хэвллийдээ агуулсан газарт шороон ордыг нээхийг хориглоно.
- Шороон ордыг хэрэглэж дууссаны дараа техникийн нөхөн сэргээлтийг шаардлагатай түвшинд нөхөн сэргээх арга хэмжээг авах шаардлагатай.

Хэрвээ сонгосон газарт шаардлагатай материалын нөөц хүрэлцээгүй байх буюу эсвэл талбай нь бага байвал Гүйцэтгэгч нь одоогийн ашиглаж байгаа чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газрыг өргөтгөх буюу эсвэл тэдгээрийг шинээр олж тогтоох, ашиглах хүсэлтээ бичгээр өгнө. Өргөтгөх буюу шинээр нээх газрын зөвшөөрлийг энэхүү техникийн шаардлагын 6.3-р бүлэгт заасны дагуу авна.

6.4. ГАЗАР ДЭЭР АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ

Захиалагчаас зохион байгуулж, улмаар тухайн орон нутгаас газрын зөвшөөрөл олгосон даруйд ямар нэгэн ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь тухайн газарт хүрээлэн буй орчныг хамгаалахаас эхлүүлээд бусад бүх ажлыг эхлэх хууль эрх зүйн бүхий л нөхцөл бүрэлдсэн эсэхийг хянаж баталгаажуулсан байх ёстой. Газар шорооны болон зам барилгын үндсэн ажлуудыг эхлүүлэхдээ Инженерээс бичгээр зөвшөөрөл авч байж эхлүүлнэ. Үйлдвэрийн талбай болон бусад ажлыг Гүйцэтгэгчийн ерөнхий инженер болон орон нутгийн зөвшилцөл дээр үндэслэн эхлүүлэх боломжтой бөгөөд ажил эхлүүлэх талаархи албан ёсны мэдэгдэлийг Инженерт бичгээр хүргүүлнэ.

6.5. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОН ЭРҮҮЛ АХҮЙН ШААРДЛАГУУД

Гүйцэтгэгч нь чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газарт үйл ажиллагаа явуулахдаа эрүүл мэнд, ахуйн болон аюулгүй байдлын талаарх орон нутгийн засаг захиргааны дүрэм журмыг мөрдөж ажиллана. Тийм дүрэм, журам байхгүй тохиолдолд, эсвэл тэдгээр дүрэм журмаас гадна дараах нөхцөлийг хангаж ажиллана:

- (а) Ажил явагдаж байгаа бүх газрын усыг байнга зайлцуулж хуурай байлгана. Хэрэв чулуун ба шороон ордын ухагдсан газарт ус гарч тэр нь өөрөө хатахааргүй байгаа бол ажил явагдаж байх хугацаанд усыг байнга соруулж зайлцуулж байна. Тиймэрхүү хонхор газрыг ажил дууссаны дараа Инженерийн заавраар мал услах усан сан болгон үлдээж болно. Энэ тохиолдолд эргийн налууг 1:6-аас алгуур болгон засаж, мал ороход тохиромжтой болгоно.
- (б) Зам барилгын ажилд шаардагдах дээрх газрууд нь усны эх бүхий газар, хот, суурины дотор буюу тэдэнтэй ойр зэргэлдээ оршиж болохгүй.
- (в) Газрууд нь доор дурдсан хил хязгаарын дотор байж болохгүй.

Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар,
- Дархан цаазтай газар,
- Хилийн бүс,
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар,
- Хамгаалалттай ойн бүс,

- Усны эх, усан хангамжийн бүс,

Хаягдал зайлцуулах газар нь гол горхи, суваг шуудуу, усны урсац, усны эх, нуур зэрэг усны нөөцийг боож, бохирдуулахгүй байх ёстой. Гүйцэтгэгч нь олгосон газарт ажлын талбарынхаа хил хязгаарыг тогтоож, Инженерийн зааврын дагуу хашаа хамгаалалт барьж тусгаарлан, үйл ажиллагаагаа зөвхөн тэр хил хязгаарын дотор бие даан явуулна.

- Мөргөцгийн өндөр 1м-ээс илүү болсон газарт, мөргөцөг рүү хүн, мөн мал орохоос хамгаалсан түр зуурын хайс, хашааг Гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж тавина.
- Ажил дуусахад бүх мөргөцгүүдийг нурааж, 1:6-аас багагүй налуу болгож сайтар тэгшлэн засна.
- Ажил дуусахад бүх хайс, хашаа болон түр хугацааны бусад байгууламжуудыг буулгаж, зөөн, жорлонгийн нүхийг булж, өнгөн хөрсийг тарааж тэгшлэн усалж, талбайг цэвэрхэн болгож үлдээнэ.
- Гүйцэтгэгч нь байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллана. Үүнд хөрсний болон гадаргын усанд тос, эрдэсжсэн ус оруулахгүй байх ба гэхдээ энэ чиглэлийн арга хэмжээ нь зөвхөн эдгээрээр хязгаарлагдах ёсгүй бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг дагаж мөрдөнө.
- Ажил дуусахад бүх чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудыг нөхөн сэргээж хүрээлэн буй орчны харагдах байдлыг сайжруулаад зогсохгүй хүн, малд саад болохооргүй байдлаар хуучин төрхийг сэргээнэ. Налуу жигд байх бөгөөд түүнийг өнгөн хөрсөөр хучиж, ургамалжилтыг тэтгэх зорилгоор байнга усалж байна. Газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай бүхий л зүйлийг хийж гүйцэтгэнэ.

6.6. ТУСЛАХ ШОРООН ЗАМУУД

Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудад хүрэх туслах замууд болон барилгын явцад нийтийн хөдөлгөөнийг саадгүй явуулах замыг Гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр барьж, засварлана. Туслах шороон замаас бусад газраар дур мэдэн давхих, тээвэр хийх зэргээр байгаль орчин сүйтгэхийг хатуу хориглоно.

Төслийн замд ойр оршдог, хөдөлгөөн нэвтэрч буй түр замуудад (үүнд салаалсан замууд бас хамаарч болно) тээврийн хэрэгсэлүүд тэгш тал газарт 50 км/цаг, харин уулархаг газарт дор хаяж 30 км/цаг хурдтай явах нөхцөлийг хангаж, барилгын ажлын үргэлжлэх явцад ч байнга засварлаж арчилна. Барилгын ажлын явцад тухайн газар орны онцлогоос (өндөр уул, усаар хашигдсан, барилга байгууламж ойрхон гэх мэт) шалтгаалснаас хөдөлгөөнийг түр замаар өнгөрүүлэх боломжгүй тохиолдолд зайлшгүй байдлыг харгалзан, ажилд эвдрэл, хохирол учруулахгүй байх нөхцлийг хангаж, барилгын ажил явагдаж буй талбай дундуур буюу дээгүүр замын хөдөлгөөнийг нэвтрүүлэн өнгөрүүлэхийг Инженерээс зөвшөөрч болно.

Ажил явагдаж буй газруудтай ойр байгаа замуудын дагуу түр тэмдэг, хаалт байрлуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах ба өөрийн тээврийн хэрэгслүүд болон хүнд механизмын хөдөлгөөний нөлөөллөөс хамгаална.

6.7. ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ БА ХӨРСНИЙ ДЭЭД ҮЕИЙГ УХАЖ ЗАЙЛУУЛАХ

Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч энэхүү техникийн шаардлагын бүлэг 4-д заасны дагуу одоогийн байгаа чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газрууд болон тэдэнд хүрэх туслах замуудыг цэвэрлэнэ.

Инженер заавраар зайлцуулж буюу хөдөлгөж үл болох хашилт, мод, малын хашаа болон бусад зүйлсийг энэхүү техникийн шаардлагын бүлэг 4-д заасан нөхцөлийн дагуу хамгаална. Инженер өөрөөр зааварчлаагүй бол Гүйцэтгэгч чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газруудын болон тэдэнд хүрэх туслах замуудын өнгөн хөрсийг хуулах ба шаардлагатай үед чулуун болон шороон ордод тохиромжтой материалын үе гарч ирэх хүртэл хөрсний дээд хэсгийг ухаж авч зайлцуулна. Өнгөн хөрсийг дангаар нь хуулж зайлцуулах, эсвэл тохиромжтой материалын үе хүртэлх давхаргатай хамт хуулах эсэхийг Инженер зааварчилна. Түүнчлэн Инженер өнгөн хөрснөөс доош тохиромжтой материалын үе хүртэлх давхарга нь шаардлага хангана гэж үзсэн бол зам барилгын ажилд ашиглах талаар зөвлөж болно.

Хуулсан өнгөн хөрсийг 1 м-ээс илүүгүй өндөртэйгээр талбайд буулгана. Борооны усыг шингээн барих, гадаргын ус урсахаас хамгаалах зорилгоор өнгөн хөрсийг шатлан овоолно. Гүйцэтгэгч, салхинд өнгөн хөрсийг хийсгэж алдахгүйн тулд, мөн ургамалжилтыг сэргээх зорилгоор өнгөн хөрсний овоолгыг шаардлагатай бол усалж байна. Чулуун ба шороон орд, материал нөөцлөх болон хаягдал зайлцуулах газар тус бүрт ажил дууссаны дараа ашиглагдаагүй үлдсэн өнгөн хөрс ба тохиромжтой материалын үе хүртэлх давхарга үеийг тухайн газруудад нь тарааж хаялгүй, ойролцоо хонхор хотгор газруудад зөөж аваачин тэгшилнэ. Өнгөн хөрсийг дангаар нь овоолсон тохиолдолд түүнийг нөөцөлж байгаад газраа зассаныхаа дараа тараана.

6.8. МАТЕРИАЛЫГ СОНГОХ, ХОЛИХ, НӨӨЦЛӨХ

Инженер нь олборлох материалын төрөл, талбай, гүн зэргийг Гүйцэтгэгчид зааварчилна. Зохистой ширхэглэлийг хангахын тулд Гүйцэтгэгч байгалиас олборлосон материалыудыг бульдозер, автогрейдер, ачигч ба экскаватор зэрэг тохиромжтой машин техникийг ашиглан холих шаардлага гарч болно. Эдгээр материалыг сайн хольж нэгэн жигд хольц болгоод ажилд ашиглахаас хамгийн багадаа 7 хоногийн өмнө нөөц материал хадгалах талбайд овоолон хадгална.

Гүйцэтгэгч нь том хэмжээтэй буюу шавар, хар шороон хөрс болон бусад чанар муутай, барилгын ажилд хор нөлөөтэй, тохиромжгүй материалыудыг ажилд ашиглах тохиромжтой материалыудаас тусгаарласан байх ёстой. Дээрх тохиромжгүй материалыудыг хаягдал зайлцуулах газар руу зөөж буулгана. Шороон орд бүрт материалыг төрөл, ширхэглэл тус бүрээр нь ялгаж нөөцөлнө.

Материал нөөцлөх газраас материалыг аваахдаа уланд нь байгаа материалтай хольж болохгүй бөгөөд ёроолын үеийг 100мм орчим зузаантай үлдээнэ. Хэрэв нөөц материал нь шаардлагатай хэмжээнээс илүү гарсан бол Инженер өөрөөр зааварчлаагүй тохиолдолд Гүйцэтгэгч түүнийг чулуун болон шороон ордын дотор талбайд тараана.

6.9. МАТЕРИАЛЫГ АШИГЛАХ

Зам барилгын байнгын ажилд хэрэглэгдэх, шороон ордоос олборлосон

ЗАХИАЛАГЧ

Б.Соргин

113

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Соргин

материалд тавигдах шаардлага нь Гүйцэтгэгчийн бусад ажлуудад хамааралтай шаардлагаас давуу байдлаар ашиглагдана. Шороон ордоос олборлосон материалыг туслах зам, түр зам, бусад түр барилга г.м үндсэн ажлаас бусад ямар нэг ажилд Инженерийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй.

6.10. ХЭМЖИЛТ БА ТӨЛБӨР

Техникийн шаардлагын бүлэг 6-д хамааруулан ямар нэгэн хэмжилт ба төлбөр хийгдэхгүй. Гүйцэтгэгч нь техникийн шаардлагын бүлэг 6-д заасан шаардлагуудыг хангахтай холбогдсон зардлыг бусад ажлын нэгж үнэ ба өртөгт тооцсон гэж үзнэ. Хэрэв Инженер чулуун ба шороон ордоос тохиромжтой материалын үе хүртэл ухаж гаргасан давхарга үеийг зам барилгын үндсэн ажилд ашиглахаар зааварчилсан тохиолдолд хэмжилт ба төлбөрийг Техникийн шаардлагын тохирох бүлэгт заасны дагуу хийнэ.

Энэ бүлгийн нөхөн сэргээлтээс бусад ажилд хэмжилт ба төлбөр хийгдэхгүй.

Нэгж - м³

Нөхөн сэргээлт хийх ажлыг м³-ээр хэмжих ба сэргээсэн талбайн дундажыг, дүүргэлтийн зузаанаар үржиж гаргана. Энэ ажлын үнэлгээнд дараахь ажлууд багтана. Үүнд;

- Шороон ордын хажуу налуу, ёроолыг тэгшлэх
- Өнгөн хөрсийг түрж тараах, тарималжуулах
- Материал техник тоног төхөөрөмжийн бүх зардал

Гүйцэтгэгч нь бусад ажлуудын зардлыг тооцсон тооцсон гэж үзнэ.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 1-ТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ҮЙЦЭТГЭХ ЗАХИНАЛ

ТАВАНТОЛГОЙ
ТӨМӨР ЗАМ
ХХК

2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр
Н.УДААНЖАРГАЛ
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 7.-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА, ДЭРСГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 6.-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 6.-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН УЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 6.-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 6.-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

Батзориг

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зэрлөгийн барилга
угралтын ажил гүйцэтгэх гэрээний нөхцөлийн
Хавсралт 2-Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ

**ХАВСРАЛТ №2
ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

(“Тавантолгой Төмөр Зам” ХХК болон Зэвсэгт Хүчний Жанжин Штабын хооронд
2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр байгуулав.)

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ


ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

ГАРЧИГ


1. Гэрээний үнэ	2
2. Урьдчилгаа төлбөр	3
3. Төлбөрийн нөхцөл	3
4. Бараа материал нийлүүлэлт	3
5. Явц дундын төлбөр	3
6. Ажлын тоо хэмжээ – дэлгэрэнгүй	4

ЗАХИАЛАГЧ



1

ГҮЙЦЭТГЭГЧ



1. Гэрээний үнэ

1.1. Энэхүү гэрээний нийт үнийг Захиалагчийн 2022 оны 05 дугаар сард боловсруулж, магадлуулсан “Богдхан төмөр зам” төслийн Техник эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг эх сурвалж болгон нийт үнэд (LUMP SUM) үндэслэн тогтоосныг нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1. Гэрээний нийт үнэ

№	Ажлын төрөл	Үнийн дүн (ам.доллар)
1	Газар чөлөөлөлт	20,000,000.00
2	Нарийвчилсан зураг төсөл	12,000,000.00
3	Доод бүтцийн барилга угсралтын ажил	215,776,492.90
3.1	Газар шорооны ажил	166,892,611.14
3.2	Хоолойн ажил	29,638,381.76
3.3	Гүүрний ажил	19,245,500.00
4	Барилга байгууламжийн ажил	42,798,788.90
5	Угсралтын ажлын зардал (1+2+3+4)	290,575,281.80
6	Захиалагчийн хяналтын зардал	5,811,505.64
7	Магадалшгүй ажлын зардал	14,528,764.09
ДҮН		310,915,551.52
НӨАТ 10%		31,091,555.15
НИЙТ ДҮН		342,007,106.68

1.2. Энэ хавсралтын Хүснэгт 1 нь “Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц болон өртөө, зөрлөгийн барилгын ажил гүйцэтгэх гэрээний үнэ болно. Тус хүснэгтийн 1, 2, 6 болон 7 дахь мөр нь Захиалагчийн мэдлийн зардал байна.


1.3. Энэ хавсралтын Хүснэгт 1-ийн 1 дэх мөрөнд заасан ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 206 дугаар тогтоолын 5 дахь хэсэг, мөн 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт тус тус заасны дагуу Нийспэл болон Төв аймгийн Засаг дарга нар хийж гүйцэтгэх бөгөөд санхүүжилтийг шилжүүлэх үргийг Захиалагч хариуцан гүйцэтгэнэ.

1.4. Энэ хавсралтын Хүснэгт 1-ийн 5 дахь мөрөнд заасан дүнд “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журам”-д заасан хувь хэмжээ 0,18 хувиар тооцсон Нормчлолын сангийн зардал багтсан.

1.5. Захиалагч нь Санхүүжилтэд суурилсан ажлын даалгаврыг баримтлан гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл, тоо хэмжээ, нэгжийн үнэд суурилан явц дундын төлбөрийг тооцож төлнө.

1.6. Технологийн хувьд зайлшгүй бөгөөд илүү оновчтой хувилбарыг сонгох бодит шаардлагын хүрээнд энэхүү хавсралтын 5 дугаар зүйлд нэрлэн заагаагүй нэмэлт ажил (ажилбар)-ыг гүйцэтгүүлэхээр Талууд харилцан тохиролцсон тохиолдолд Гүйцэтгэгчийн гэрээт ажлын нийт үнийн дүнг өөрчлөхгүйгээр, ийнхүү нэмэгдсэн буюу хэтэрсэн ажил (ажилбар)-ын өөрчлөлтийг бусад ажилд дүйцүүлж шилжүүлэх байдлаар ажлын нийт тоо хэмжээнд багтаан гүйцэтгэнэ.

1.7. Энэ зүйлийн 1.6-т заасан өөрчлөлтийг Гэрээний нөхцөлийн дагуу Захиалагчийн зааварчилгааг үндэслэн тухай бүр зураг, төсөлд тусгасан байна.

ЗАХИАЛАГЧ


2

ГҮЙЦЭТГЭГЧ



1.8. Магадалшгүй ажлын нөөц хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна. Үүнд:

а. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан нэмэлт ажил болон үйл ажиллагааны зардлууд;

б. Барилгын материал хийц хэсгийг зураг, төсөл зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр өөрчилснөөс үүдэн гарах аливаа зардлууд;

с. Ажлын баримт бичгийн төслийн шийдлийн өөрчлөлтийн зөрүү;

д. Захиалагчийн шаардлага, хүсэлтийн дагуу аливаа шалтгаанаар гүйцэтгэсэн бусад ажил болон үйлчилгээ.

1.9. Гүйцэтгэгч нь магадалшгүй ажлын нөөц хөрөнгийг зарцуулах хүсэлтээ холбогдох бичиг баримтын хамт Захиалагчид хүргүүлнэ.

1.10. Захиалагч дээрх хүсэлт болон баримт бичигт үндэслэн гэрээний ерөнхий хэлэлцээрт заасан холбогдох журмын хүрээнд шийдвэрлэж, Гүйцэтгэгчид олгоно.

2. Урьдчилгаа төлбөр

2.1. Захиалагч нь гэрээний тусгай нөхцөлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу урьдчилгаа төлбөрийг олгоно.

3. Төлбөрийн нөхцөл

3.1. Захиалагч нь Санхүүжүүлэгчээс олгосон санхүүжилтийн дагуу гүйцэтгэх ажлын цар хүрээ, нэгж үнийг тодорхойлсон “Санхүүжилтэд сууринсан ажлын даалгавар” боловсруулан Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

3.2. Захиалагчийн төлбөр төлөх, ажлын даалгавар хүргүүлэх ажил нь төслийн санхүүжилттэй шууд хамаарна.

3.3. Гүйцэтгэгч “Санхүүжилтэд сууринсан ажлын даалгавар”-т үндэслэн энэхүү хавсралтын 5 дугаар зүйлд заасан ажлыг магадлагдсан зураг, төслийн дагуу зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд Захиалагч хянан баталгаажуулсан тохиолдолд Захиалагч тухайн ажлын үнийг Гүйцэтгэгчид бүрэн төлөх үүрэгтэй.

3.4. Хэрэв Гүйцэтгэгч ажлыг илүү гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх бөгөөд Захиалагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд дараагийн “Санхүүжилтэд сууринсан ажлын даалгавар”-т оруулан тооцож, төлбөрийг төлнө.

3.5. Гүйцэтгэгч нь “Санхүүжилтэд сууринсан ажлын даалгавар”-аас илүү ажил гүйцэтгэсэн хэдий ч Захиалагч тухайн үеийн ажлын даалгаварт заасан үнийн дүнгээс илүү төлбөр төлөх үндэслэл болохгүй.

3.6. Гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээг үндэслэн Захиалагч нь Туслан гүйцэтгэгчтэй Санхүүжилтийн гэрээ байгуулж санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэнэ.

4. Бараа материал нийлүүлэлт

4.1. Талууд ажлын гүйцэтгэлд ашиглах гол нэр төрөл (шатахуун, цемент, арматур)-ийн бараа материалыг тусад нь гурвалсан гэрээ байгуулан зохицуулна.

5. Явц дундын төлбөр

5.1. Гүйцэтгэгч нь явц дундын төлбөрийн хүсэлтийг гэрээний нөхцөлд заасны дагуу боловсруулж, Захиалагчид хүргэх үүрэгтэй.

ЗАХИАЛАГЧ
Б. Чиритжин

5.2. Гүйцэтгэсэн ажлын хэмжээг гаргахдаа ажилбар бүрийн тоо хэмжээг нэгж үнэд үржүүлж нийт үнээр тодорхойлно. Ингэж тодорхойлсон ажлын гүйцэтгэлийн хэмжээг "Санхүүжилтэд сууриссан ажлын даалгавар"-т дүйцүүлэн явц дундын төлбөрийг хүргүүлнэ.

5.3. Гүйцэтгэгч нь төлбөрийн баталгаажуулалтад шаардлагатай гүйцэтгэлийн зураг, холбогдох баримт бичгийг боловсруулахдаа ажлын бодит гүйцэтгэлийг нотлох, баталгаажуулж буй ажилд хамаарах мэдээллийг Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.

6. Ажлын тоо хэмжээ – дэлгэрэнгүй

6.1. "Санхүүжилтэд сууриссан ажлын даалгавар"-аар Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын тоо хэмжээний нэгжийн үнийг талууд тухай бүр тохиролцоно.

6.2. Ажлын тоо хэмжээ, үнэ нь эрх бүхий этгээдийн магадалсан зураг, төсөл, төсвөөр тодорхойлогдоно.

6.3. Гүйцэтгэгч нь эрх бүхий этгээдийн магадалсан нарийвчилсан зураг, төсөл, хэмжилтээр тодорхойлсон ажлын нэр, төрөл, тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгэх бөгөөд тоо хэмжээнд өөрчлөлт оруулах нөхцөл шаардлага үүссэн тохиолдолд Инженерийн зааварчилгаа болон Хүсэлтийн дагуу хийж гүйцэтгэнэ.

6.4. Гэрээний тоо хэмжээ, үнэ өөрчлөгдсөн нь Гэрээнд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй бөгөөд Талууд эцсийн тооцоо нийлэх актаар харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.5. Ажлын тоо хэмжээ, нэгжийн үнэ нь Ажлын нарийвчилсан тоо хэмжээ болон "Санхүүжилтэд сууриссан ажлын даалгавар"-т үндэслэн тодорхойлогдох бөгөөд урьдчилсан байдлаар ажлын задаргааг "Богдхан төмөр зам" төслийн ТЭЗҮ-д үндэслэн харуулав.

Хүснэгт 5.1 Доод бүтцийн барилга угсралтын ажил

№	Ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Газар шорооны ажил	м	
1.1	Талбайн цэвэрлэгээ, бэлтгэл	м	
1.1.1	Замын чиг сэргээх	км	144.90
1.1.2	Технологийн зам барих	м	144,900.00
1.1.3	Ургамлын үе хуулах	м.куб	409,889.45
1.1.4	Хөрс солилт - Ухмал, далангийн ул хөрс (T=15 см)	м.куб	86,504.53
1.2	Далан ухмалын ажил		
1.2.1	Далангийн дүүргэлт-Карьераас	м.куб	12,822,243.91
1.2.2	Хучилтын үе (300 мм зузаантай)	м.куб	467,616.87
1.2.3	Ухмалын ажил-Зөөлөн	м.куб	1,536,363.44
1.2.4	Ухмалын ажил-Хатуу	м.куб	6,145,453.77
1.2.5	Ухмалын хамгаалах далан	м.куб	217,127.02
1.2.6	Ухмалын хажуу налуугийн тортой чулуун бэхэлгээ	м.куб	78,200.33
1.2.7	Түшиц хана (12 м-ээс гүн ухмалд)	м.куб	7,534.80

ЗАХИАЛАГЧ

1.3	Суваг, шуудууны ажил	м.куб	
1.3.1	Шуудуу - Далангийн өөрийн	м.куб	43,840.22
1.3.2	Шуудуу хатуу - Ухмалын өөрийн	м.куб	12,401.70
2	Хиймэл байгууламжийн ажил		
2.1	Хоолойн ажил		
2.1.1	ф1250-20 ш	м	380.39
2.1.2	ф1500-20 ш	м	633.62
2.1.3	1,25x2.0-47 ш	м	1,301.79
2.1.4	1,25x2.0x2-23 ш	м	998.96
2.1.5	1.25x3.00x3-4 ш	м	86.19
2.1.6	1.5x1.5-1 ш	м	20.00
2.1.7	1.5x1.5x2-1 ш	м	13.08
2.1.8	1.5x1.5x3-6 ш	м	117.82
2.1.9	2.00x4.00-4 ш	м	294.70
2.1.10	3.00x3.00-13 ш	м	656.20
2.1.11	4.00x4.00-6 ш	м	254.01
2.1.12	4.00x4.00x2-8 ш	м	355.46
2.2	Гүүрийн ажил		
2.2.1	Дамнуурут гүүр	м	551.00
2.2.2	Жаазан гүүр	м	80.00

Хүснэгт 5.2 Барилга байгууламжийн ажил

№	Ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
A. ЗӨРЛӨГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ			
Нэг. 1 дүгээр зөрлөг			
1.1	Зөрлөгийн удирдлагын байр	м.кв	290.00
1.2	Зөрлөгийн айл-1	м.кв	54.00
1.3	Зөрлөгийн айл-2	м.кв	54.00
1.4	Зөрлөгийн айл-3	м.кв	54.00
1.5	Зөрлөгийн айл-4	м.кв	54.00
1.6	Зөрлөгийн айл-5	м.кв	54.00
1.7	Зөрлөгийн айл-6	м.кв	54.00
1.8	Зөрлөгийн айл-7	м.кв	54.00
1.9	Уурын зуух	ш	1.00
1.10	Цэвэрлэх байгууламж	ш	1.00
1.11	Гүний худгийн барилга	м.кв	20.00
Хоёр. 2 дугаар зөрлөг			
2.1	Зөрлөгийн удирдлагын байр	м.кв	290.00
2.2	Зөрлөгийн айл-1	м.кв	54.00
2.3	Зөрлөгийн айл-2	м.кв	54.00
2.4	Зөрлөгийн айл-3	м.кв	54.00
2.5	Зөрлөгийн айл-4	м.кв	54.00

ЗАХИАЛАГЧ

2.6	Зөрлөгийн айл-5	м.кв	54.00
2.7	Зөрлөгийн айл-6	м.кв	54.00
2.8	Зөрлөгийн айл-7	м.кв	54.00
2.9	Уурын зуух	ш	1.00
2.10	Цэвэрлэх байгууламж	ш	1.00
2.11	Гүний худгийн барилга	м.кв	20.00

Гурав. 3 дугаар зөрлөг

3.1	Зөрлөгийн удирдлагын байр	м.кв	290.00
3.2	Зөрлөгийн айл-1	м.кв	54.00
3.3	Зөрлөгийн айл-2	м.кв	54.00
3.4	Зөрлөгийн айл-3	м.кв	54.00
3.5	Зөрлөгийн айл-4	м.кв	54.00
3.6	Зөрлөгийн айл-5	м.кв	54.00
3.7	Зөрлөгийн айл-6	м.кв	54.00
3.8	Зөрлөгийн айл-7	м.кв	54.00
3.9	Уурын зуух	ш	1.00
3.10	Цэвэрлэх байгууламж	м.куб	1.00
3.11	Гүний худгийн барилга	м.кв	20.00

Дөрөв. 4 дүгээр зөрлөг

4.1	Өртөөний удирдлагын байр, контор	м.кв	580.00
4.2	Өртөөний олон нийтийн барилга, өдөр өнжүүлэх	м.кв	530.00
4.3	12 айлын 3 давхар орон сууц-1	м.кв	810.00
4.4	12 айлын 3 давхар орон сууц-2	м.кв	810.00
4.5	12 айлын 3 давхар орон сууц-3	м.кв	810.00
4.6	Том оврын машины гараж	м.кв	210.00
4.7	УДДТөв	м.кв	108.00
4.8	Цэвэрлэх байгууламж	м.куб	1.00
4.9	Гүний худгийн барилга	м.кв	20.00

Тав. 5 дугаар зөрлөг

5.1	Зөрлөгийн удирдлагын байр	м.кв	290.00
5.2	Зөрлөгийн айл-1	м.кв	54.00
5.3	Зөрлөгийн айл-2	м.кв	54.00
5.4	Зөрлөгийн айл-3	м.кв	54.00
5.5	Зөрлөгийн айл-4	м.кв	54.00
5.6	Зөрлөгийн айл-5	м.кв	54.00
5.7	Зөрлөгийн айл-6	м.кв	54.00
5.8	Зөрлөгийн айл-7	м.кв	54.00
5.9	Уурын зуух	ш	1.00
5.10	Цэвэрлэх байгууламж	м.куб	1.00
5.11	Гүний худгийн барилга	м.кв	20.00

Зургаа. 6 дугаар зөрлөг

6.1	Зөрлөгийн удирдлагын байр	м.кв	290.00
6.2	Зөрлөгийн айл-1	м.кв	54.00
6.3	Зөрлөгийн айл-2	м.кв	54.00
6.4	Зөрлөгийн айл-3	м.кв	54.00
6.5	Зөрлөгийн айл-4	м.кв	54.00
6.6	Зөрлөгийн айл-5	м.кв	54.00
6.7	Зөрлөгийн айл-6	м.кв	54.00
6.8	Зөрлөгийн айл-7	м.кв	54.00

ЗАХИАЛАГЧ

6.9	Уурын зуух	ш	1.00
6.10	Цэвэрлэх байгууламж	м.куб	1.00
6.11	Гүний худгийн барилга	ш	20.00
Долоо. Гадна инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилт			
7.1	Гадна инженерийн шугам сүлжээ	багц	1.00
7.2	Гадна зам талбай тохижилт	багц	1.00
Б. ӨРТӨӨНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ			
Нэг. Хайрхан-Уул өртөө			
1.1	Өртөөний удирдлагын байр, контор	м.кв	580.00
1.2	Өртөөний олон нийтийн барилга, өдөр өнжүүлэх	м.кв	530.00
1.3	12 айлын 3 давхар орон сууц-1	м.кв	810.00
1.4	12 айлын 3 давхар орон сууц-2	м.кв	810.00
1.5	12 айлын 3 давхар орон сууц-3	м.кв	810.00
1.6	УДДТөв	м.кв	108.00
1.7	Цэвэрлэх байгууламж	ш	1.00
1.8	Уурын зуух	ш	1.00
Хоёр. Хөшигт өртөө			
2.1	Өртөөний удирдлагын байр	м.кв	3,500.00
2.2	Зүтгүүрийн бригадын амрах байр (60 хүний)	м.кв	1,800.00
2.3	Вагон засварын газар	м.кв	2,100.00
2.4	Вагоны техник үзлэгийн газрын байр (контор, сэлбэгийн агуулах)	м.кв	510.00
2.5	Зам ангийн барилга (контор, багажны агуулах)	м.кв	1,200.00
2.6	Машин засварын цех	м.кв	450.00
2.7	Зүтгүүрийг зэхэх байгууламж	м.кв	850.00
2.8	Паркийн дулаачах байр (5 хүн)	м.кв	70.00
2.9	Анхны тусламж үзүүлэх төв	м.кв	60.00
2.10	Дэд станц, удирдлага хяналтын өрөө	м.кв	200.00
2.11	Дизель генераторын цогц	м.кв	60.00
2.12	Аюулгүй байдлын хяналтын байр	м.кв	400.00
2.13	Хамгаалалтын болон нэвтрүүлэх хяналтын бүс	м.кв	28.00
2.14	Шатахун цэнэглэх цэг	м.кв	15.00
2.15	Зам тэмрийн засварын машины засвар үйлчилгээ	м.кв	1,000.00
2.16	Дохиолол холбооны хэрэгслийн засвар үйлчилгээ	м.кв	400.00
2.17	Ялгах довын удирдлагын байр	м.кв	1,200.00
2.18	Усны хангамжийн байр	м.кв	1,000.00
2.19	Гүний худгийн барилга 9 м.кв, 6 ш	м.кв	54.00
2.20	Шатах тослох материалын агуулах	м.кв	60.00
2.21	Насосны станц, газар доорх усны агуулах	м.кв	1,000.00
2.22	Хэрэглэсэн тос, масло хагас хатуу хог хаягдлын агуулах	м.кв	280.00
2.23	Цэвэрлэх байгууламж	м.кв	1,500.00

ЗАХИАЛАГЧ

2.24	Технологийн бохир ус цэвэрлэх байгууламж 20 м.куб/хоног	ш	1.00
2.25	Уурын зуух	ш	2.00
2.26	УДДТөв	м.кв	108.00
Гурав. Хөшигт суурьшил (601 - 420) айл			
3.1	Орон сууц	м.кв	4,050.00
3.2	Орон сууцны доорх дулаан гараж	м.кв	108.00
3.3	Зочид буудал	м.кв	1.00
3.4	Цэцэрлэг	м.кв	1.00
Дөрөв. Гадна инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилт			
4.1	Гадна инженерийн шугам сүлжээ	багц	1.00
4.2	Гадна зам талбай тохижилт	багц	1.00

ЗАХИАЛАГЧ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 2-ТОЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:




ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.УДААНЖАРГАЛ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСЭГ" ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАВЫН
ДАРГА, ДЭСЛЭГИ ГЕНЕРАЛ



Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр


БАРИЛГА ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА



Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр


БАРИЛГА ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА



Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр


БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА



У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ




Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200999



ИЛ БОЛСОН

МАШ НУҮЦ

"Богдхан төмөр зам" төслийн доод бүтэц, өртөө зэрлэгийн
барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний Хавсралт 4 -
Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах зөвшөөрөл
авахтай холбоотой үүргийн матриц

**ХАВСРАЛТ №4
ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХТАЙ ХОЛБООТОЙ
ҮҮРГИЙН МАТРИЦ**

(“Таавантолгой төмөр зам” ХХК болон Зэвсэгт хүчний Жанжин штабын хооронд 2022 оны
... дугаар сарын ...-ний өдөр байгуулав.)

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200103

ГҮЙЦЭТГЭГЧ

ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН МАТРИЦ

Хүснэгт 1. Зөвшөөрөл авахтай холбоотой үүргийн матриц

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
1. Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллагаас авах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл				
1.1	Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл	R		Тухай бүр
1.2	Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл	R		Тухай бүр
1.3	Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл	R		Тухай бүр
1.4	Төмөр замын төсөл хэрэгжүүлэх улсын тусгай хэрэгцээний газар эзэмших эрхийг Захиалагчийн нэр дээр авах	R		Тухай бүр
1.5	Барилга угсралтын ўйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл		R	
1.6	Төмөр бетон, ган хийцтэй гүүр барих, угсрах тусгай зөвшөөрөл		R	
1.7	Чийгшил, нягтрал шалгах болон бусад төхөөрөмжийг ашиглах, хадгалах, тээвэрлэх тусгай зөвшөөрөл		R	
1.8	Төмөр замын трастай давхцсан, огтполцсон, дайран өнгөрсөн асуудлаар бусад этгээдтэй техникийн шийдэл тохиорох, зөвшилцэх, техникийн нөхцөл гаргуулах	R		
1.9	Бараа материалын чанар болон тохиорлын гэрчилгээ	R	R	Арматур, цемент, шатахуун
1.10	Гадаад валютаар гүйлгээ хийх зөвшөөрөл	R		
1.11	Туслан гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар		R	
2. Орон нутгийн байгууллагаас авах зөвшөөрөл				
2.1	Түр кемпийн зөвшөөрөл	S	RP	
2.3	Түр замын зөвшөөрөл	S	RP	
2.4	Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл	S	RP	
2.5	ТТАМ ашиглалтын зөвшөөрөл	S	RP	
2.5	Ус ашиглалтын зөвшөөрөл	R	SP	
2.6	Төмөр зам, барилга байгууламжийн ажилд ашиглах хэмжих багаж хэрэгслүүдийн гэрчилгээжүүлэлт		RP	
2.7	Төмөр замын ажилд хэрэглэх өөрөө явагч машин механизмын гэрчилгээжүүлэлт		RP	
2.8	Кемп болон ажлын талбайд ашиглах холбооны тоног төхөөрөмж болон радио давтамжийн зөвшөөрөл авах	S	RP	
3. Зохион байгуулалтын арга хэмжээнүүд				
3.1	Төсдийн санхүүжилтийн болон нүүрс нийлүүлэх гэрээ байгуулах	R		

ЗАХИАЛАГЧ

1

ГҮЙЦЭТГЭГЧ

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
3.2	Төлбөрийн баталгаа гаргах	R		
3.3	Төмөр замын зурvas газрын улсын тусгай хэрэгцээнд авах, газар албадан чөлөөлөх	R		Тухай бүр
3.4	БОНУ боловсруулж магадлуулах	R		
3.6	БОМТ боловсруулж батлуулах	R	S	
3.7	БОМТ-ний биелэлтийн тайлан		R	
3.8	Төсөлд ажиллах ИТА болон түлхүүр ажилтнуудын мэдээлэл, зохион байгуулалтын бүтэц, машин механизм, тоног төхөөрөмжийн баталгаажсан гэрчилгээ		R	
3.9	Гүйцэтгэгч Захиалагчийн өмнө хариуцлага хүлээх тул туслан гүйцэтгэгчийг бие даан шалгаруулж, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээлэл, танилцуулгыг хүргүүлнэ		R	
3.10	Төслийн барилга угсралтын явцад болон гүйцэтгэж дууссаны дараа тохируулах, турших ажлыг бусад гүйцэтгэгч нартай уялдуулах	S	R	
4. Ашиглалтад оруулах				
4.1	Барилга байгууламжийн өөрчлөлтийн болон гүйцэтгэлийн зургууд	R	S	Тухай бүр
4.2	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт	R		Тухай бүр
4.3	Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт	R	S	Тухай бүр
4.4	Барилгын ил, далд ажлын акт	S	R	Тухай бүр
4.5	Барилгын үе шатны гүйцэтгэлийн тэмдэглэл, чанар хяналтын үзлэг, баталгаажилтын хуудас	S	R	Тухай бүр
4.6	Улаан шугам тавьсан акт	S	R	Тухай бүр
4.7	Ашиглалтад оруулахад шаардлагатай эрх бүхий байгууллагын шийдвэр (Улсын комиссын шаардлага хангасан байдлаар)	R	S	Тухай бүр
4.8	Техникийн комисс томилон ажиллуулах, Улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлт гаргах	R	S	Тухай бүр
5. Бусад				
5.1	Баримт бичгийг улсын архив, эзэмшигчид хүлээлгэн өгөх	R	S	Тухай бүр

Хүснэгт 2. Газар чөлөөлөхтэй холбоотой ажил үүргийн матриц

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
1. Эрх бүхий байгууллагуудаас холбогдох шийдвэрүүд гаргуулах болон Зохион байгуулалтын арга хэмжээнүүд				
1.1	Төслийн трассын нөлөөлөлд өртөж байгаа зурvas газар болон трассын дагуух газар чөлөөлөлтийн ажлыг Газрын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 287 дугаар "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг	R		2022 оны 2 дугаар улиралд багтаана

ЗАХИАЛАГЧ

2

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Чорчин

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
	тогтоох, ашиглах журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу хариуцан зохион байгуулах			
1.2	Аймаг, нийслэлийн Засаг дарга нөлөөлөлд өртөж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай “Улсын тусгай хэрэгцээнд газар эргүүлэн авах, солих гэрээ” байгуулж, тухайн газрын өмчлөх, эзэмших эрхийг дуусгавар болгох	R		2022 оны 2 дугаар улиралд багтаана
2. Газар чөлөөлөлтийн ажиллагаа				
2.1	Хашаагүй, барилга байгууламжгүй нөлөөлөлд өртсөн газрыг бүхэлд нь чөлөөлөх;	R		2 сарын дотор
2.2	Хашаатай боловч барилга байгууламжгүй газрыг бүхэлд нь чөлөөлөх	R		3 сарын дотор
2.3	Барилга байгууламжтай газрыг хэсэгчлэн чөлөөлөх, үлдэж байгаа газар дээр барилга байгууламжийг дахин барих	R		5 сарын дотор
2.4	Барилга байгууламжтай газрыг бүхэлд нь чөлөөлөх, барилга байгууламжийг шинээр олгох газар дахин барих	R		6 сарын дотор
2.5	Тодорхой байршид түр зуурын шинжтэй нөлөөлөлд өртсөн газруудын хашааг нүүлгэн шилжүүлж дахин барих	R		2 долоо хоногийн өмнө мэдэгдэл өгч тухай бүр
3. Албадан чөлөөлөх арга хэмжээ				
3.1	Нөлөөлөд өртөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй тохиолдолд Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу газар албадан чөлөөлөх арга хэмжээ авахуулах	R		Тухай бүр
4. Дэд бүтэц, харилцаа холбооны байгууламж бүхий огтлолцож буй газрыг чөлөөлөх				
4.1	Дэд бүтэц, инженерийн байгууламж, харилцаа холбооны шугам сүлжээ, сувагчлалтай давхцсан, огтлолцсон газруудыг Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль зэрэг холбогдох бусад хуулиудад заасан журмаар шийдвэрлүүлэх	P, S		Тухай бүр
5. Бусад				
5.1	Баримт бичгийг улсын архив болон захиалагч, эзэмшигчид хүлээлгэн өгөх	R	R	Тухай бүр

Хүснэгт 3. Ажил хүлээлгэн өгөхтэй холбоотой ажил үүргийн матриц

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
1	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	R	S	

ЗАХИАЛАГЧ

3

ГҮЙЦЭТГЭГЧ

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
2	Барилга байгууламж барих талбайг чөлөөлөх, ашиглалтад оруулах зардлыг хариуцах	R		
3	Ажил хүлээн авах гэрчилгээ олгох мэдэгдэл гаргах, Барилга угсралтын ажил дууссан тухай мэдэгдэл гаргах		R	
4	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах, Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтээ Барилгын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад гаргах	R	S	
5	Төслийн үндсэн мэдээлэл боловсруулж, холбогдох байгууллагыг мэдээлэлээр хангах	R	S	
6	Зураг төсөл зохиогчтой байгуулсан гэрээ, зохиогчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар	R		
7	Архитектур төлөвлөлтийн даалгавар	R		
8	Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд	S	R	
9	Газар олголтын захирамж гаргуулах	R		
10	Төмөр замын төсөл хэрэгжүүлэх болон зурvas газар эзэмших эрхийн гэрчилгээ, холбогдох кадастрын зураг, түүнтэй адилтгах баримт бичиг	R		
11	Газар ашиглахтай (трасс, дохиолол холбоо, эрчим хүч) холбоотой орон нутгийн зөвшөөрөл	R	S	
12	Геодезийн зураглалын ажлын тайлан	R	S	
13	Магадлалаар баталгаажсан инженер-геологийн судалгааны дүгнэлт	R		
14	Магадлалаар баталгаажсан ажлын зураг төсөл, төсөв	R		
15	Зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтын хамт	R		
16	Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг, төсөл баталгаажуулах	R	S	
17	Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	S	R	
18	Захиалагч, Гүйцэтгэгчтэй хийсэн гэрээ	R	R	
19	Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	R		
20	Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл	S	R	
21	Барилгын ажлын ил, далд ажлын акт	S	R	
22	Барилгын ажлын явцад барилгын улсын техникийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан дүгнэлт	S	R	
23	Барилга угсралтын ажлын үе шат бүрт хяналт хийсэн тайлан, фото зураг	R	R	
24	Барилгын материалын гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, лабораторийн дүгнэлт	S	R	

ЗАХИАЛАГЧ

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
25	Инженерийн шугам сүлжээний холболтыг техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн, эсхүл өөрийн эх үүсвэр ашигласныг баталгаажуулсан тэмдэглэл, холбогдох мэдээлэл	S	R	
26	Тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан туршилтын баримт бичиг, зааврын дагуу суурилуулахад хийсэн туршилтын дүгнэлт	S	R	
27	Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт	R		
28	Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт	S	R	
29	Улаам шугам хүлээлцсэн акт боловсруулж бэлтгэх	R	S	
30	Ажлын гүйцэтгэлийн зураг, холбогдох дүгнэлтууд	S	R	
31	Археологийн аврах хамгаалах ажлын тайлан	R	S	
33	Зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн зам, замын байгууламжийн чанар байдлын талаар гаргасан нэгдсэн дүгнэлт	R	S	
34	Нийт төслийн хугацаанд Зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн зүгээс гаргаж байсан зөвлөмж, актууд, албан шаардлагуудын эмхэтгэл. Үүрэг даалгаврын гүйцэтгэлийн тайлан тайлбарын хамт (Тухайн баримт бичгийн хавтас нь нэгдсэн товьёогтой байх)	R	R	
35	Техникийн комиссын акт, төсөл хэрэгжүүлэгчид өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, тайллагнах	R	S	
36	Техник ашиглалтын түвшин тогтоох, чанар байдлын дүгнэлт	R	R	
37	Гүүр хоолойн паспорт (Схем зураг, километрийн тооллын дагуух жагсаалт, техникийн үндсэн тодорхойлолтууд гэх мэт)	S	R	
38	Төслийн хэрэгжилтийн хугацаанд салбар яамнаас өгөгдсөн албан ёсны үүрэг чиглэл, өгсөн баримт бичиг, албан тоотын хуулбар эмхэтгэл	R		
39	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан	R	R	
40	Бусад холбогдох баримтууд	R	R	

Тайлбар: R - Хариуцна;

P - Төлбөр төлнө;

S - Дэмжих.

Дээр дурдсан арга хэмжээ, зөвшөөрлүүд нь эцсийнх биш бөгөөд гэрээг хэрэгжүүлэх хугацаанд дахин шинэчлэх боломжтой.

ЗАХИАЛАГЧ

5

ГҮЙЦЭТГЭГЧ

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 4-ТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
~~ДАИМЖИХИЙН ТӨЛӨӨЛЖ~~:

6375405 СВА2198

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

1119279488

ФОЛУМНЕР ТАБУУДАР САРЫН 07-НИЙ ӨДӨР

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.УДААНЖАРГАЛ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСЭГ" ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

6

ГҮЙЦЭТГЭГЧ

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

"Богдхан төмөр зам" төслийн доод бүтэц, өртөө, зөвлөгийн барилга
үгралтын ажил гүйцэтгэх гэрээний нэхцэлийн Хавсралт 5 -
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө
болон нийгмийн удирдлага

ХАВСРАЛТ №5.

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН
НИЙГМИЙН УДИРДЛАГА**

(“Тавантолгой Төмөр Зам” ХХК болон Зээсэгт Хүчний Жанжин Штабын хооронд 2022
оны ... дугаар сарын ...-ны өдөр байгуулав.)

ЗАКИДАГЧ

ЗХЖШ 2200127

ГҮЙЦЭТГЭГЧ

Б. Нямжил

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГА**

1. Удиртгал

1.1. Гүйцэтгэгч нь дор дурдсан баримт бичгийг үндэслэн “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө” (цаашид “БОХНСНУТ” гэх) боловсруулж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдеж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд:

- a) Захиалагчийн байгаль орчны болон нийгмийн удирдлагын талаар баримтлах бодлого, журам;
- b) Захиалагчийн байгаль орчны болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд тавигдах ерөнхий шаардлага;
- c) “Богдхан төмөр зам” төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан;

1.2. БОХНСНУТ-нд орон нутгийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах, хамгийн бага түвшинд байлгах, зохицуулах, аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг, хариуцлагыг тусгах бөгөөд энэхүү төлөвлөгөөгөөр зерэг өөрчлөлтийг бий болгох зорилготой.

1.3. Захиалагч нь байгаль орчны болон нийгмийн удирдлагын талаар баримтлах бодлого, журам, тавигдах шаардлагад өөрчлөлт оруулж болно. Гүйцэтгэгч нь аливаа өөрчлөлтийг нэн даруй хэрэгжүүлж, өөрөөр зөвлөөгүй бол өөрийн төлөвлөгөө, журмаа шинэчлэх замаар дагаж мөрдөнө.

1.4. Захиалагч нь төсөл хэрэгжиж байх хугацаанд хэдийд ч хяналт шалгалт хийж болно. Хяналт шалгалтын үед Захиалагчийн баталсан маягтыг хэрэглэнэ.

2. Захиалагчийн байгаль орчны болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журам

2.1. Захиалагчийн байгаль орчны болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамд үндэслэн Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомж стандарт, хэм хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2. Энэхүү бодлого, дүрэм, журмыг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор Захиалагч Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд тавигдах ерөнхий шаардлага

Гүйцэтгэгч нь байгаль орчны болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамтай холбоотой дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

3.1. Байгаль орчин

a) Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах (ажлын талбайн гадна болон дотор), элэгдэл, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд халтай үйл ажиллагаанаас шалтгаалан хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол үүсэхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авна.

b) Гүйцэтгэгч нь өөрийн болон Туслан Гүйцэтгэгч, Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд (агаар, ус, хөрс, амьтан, ургамал, хүрээлэн буй орчин) хор хохирол учирсан тохиолдолд түүний үр дагаварыг бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧ

1

ГҮЙЦЭТГЭГЧ

c) Ажил гүйцэтгэх хугацаанд мал болон зэрлэг ан амьтныг агнах, барьсан (санаатай болон болгоомжгүйгээр алсан, дайрсан, нуун дарагдуулсан) тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх;

d) Байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр байгалийн даац болон нөөцдөд нь тохируулан ашиглах, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн ашигласан тохиолдолд үүсэх эрсдэлийг хариуцах;

e) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаар магадлуулсан жил тутмын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх ба төлөвлөгөөнд тусгасан байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлж байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

f) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны талаарх үйл ажиллагааны журам, шийдвэрийг дагаж мөрднө.

g) Гүйцэтгэгч нь хог хаягдалтай холбоотой хууль тогтоомж, шаардлагуудыг мөрдлөг болгон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг боломжит түвшинд хүртэл бууруулах үүрэг хүлээнэ.

h) Гүйцэтгэгч нь агаарын чанар болон ан амьтан, ургамалыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг дагаж мөрднө.

i) Гүйцэтгэгч түр кемпийн газар, төслийн түр зам ашиглах зөвшөөрлүүдийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах үүрэгтэй. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь холбогдох хууль, журмын дагуу төлбөрийг төлж ашиглалт дууссаны дараа нөхөн сэргээлтийг хийж орон нутагт хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ.

j) Гүйцэтгэгч нь химийн бодисын хаягдал, материалын алдагдал хүрээлэн буй орчин, ургамал, ан амьтад, хөрс, гадаргын болон газрын доорх усанд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол зэрэг байгаль орчны зөрчил, осол аваарын талаарх мэдээллийг Захиалагчид тухай бүр тогтмол мэдэгдэж байна. Гүйцэтгэгч нь байгаль орчны тайланг сар бүрийн нэгдсэн тайланд тусгаж Захиалагчид хүргүүлнэ.

k) Гүйцэтгэгч төслийн үйл ажиллагаанаас шалтгаалах элэгдэл, асгаралт, хаягдлын хэмжээ, ус зарцуулалтыг техникийн шаардлага болон холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтрэхгүй байлагах үүрэгтэй.

l) Захиалагч нь Төслийн барилгын ажилд шаардагдах усны хайгуул судалгаа хийх, цооног өрөмдөх, худаг гаргах ашиглалтын үйл ажиллагааг хариуцаж холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулна. Төслийн барилгын ажилд ашиглагдаж байгаа худаг, худгийн тоног төхөөрөмж нь Захиалагчийн эзэмшил, өмчлөлд байна.

m) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгуулсан ус ашиглалтын гэрээний дагуу ус ашиглах бөгөөд ус ашиглалтын тайлан, мэдээ (худаг бүрийн тоолуурын заалт) - г орон нутгийн эрх бүхий байгаль орчны хяналтын байцаагчаар баталгаажуулж Захиалагчид сар бүрийн 25-ны өдрийн дотор ирүүлнэ.

n) Гүйцэтгэгч нь ус хэргэлсэн төлбөрийг худгийн тоолуурын заалтны дагуу Захиалагчийн гэрээний дагуу төлнө.

o) Захиалагчийн хууль ёсны шаардлагыг удаа дараа (2 ба түүнээс дээш) биелүүлэхээс татгалзсан этгээдийг захиалагч нь төслийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх эрхтэй.

ЗАХИАЛАГЧ

р) Захиалагчийн хийсэн хяналт шалгалт нь Гүйцэтгэгчийг энэхүү гэрээгээр хүлээсэн үндсэн үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй.

3.2. Ажлын талбайн менежмент

а) Гүйцэтгэгчийн ажлын талбай гэдэгт ажлын шаардлагаар ашиглаж буй байнгын болон түр талбайг хамруулан ойлгох ба зөвшөөрсөн газруудад тэмдэг, тэмдэглэгээ байршуулна. Гүйцэтгэгч нь өөрийн тоног төхөөрөмж, ажиллах хүчийг ажлын талбайд байршуулах болон ажил гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг авна.

б) Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч нь ажлын талбайг аливаа саадаас ангид байлгаж, Гүйцэтгэгч нь барилгын ажлын сар бурийн төгсгөлд ажлын талбайгаас хаягдал материалыг устгаж зайлуулах арга хэмжээг авна.

с) Гүйцэтгэгч нь барилгын ажлын техникийн нөхөн сэргээлтийг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгаж, стандарт шаардлагыг удирдамж болгон ТТАМ-ын ордыг нөхөн сэргээх ба ажилд үл хамаарах тээврийн хэрэгсэл зорчихгүй байлгах, хамгаалах арга хэмжээ авна.

д) Газар ашиглалтын (түр кемп, түр замууд, салаа зам) үед үүссэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг тухай бүрт хэрэгжүүлж ажиллах;

е) Гүйцэтгэгч нь ажлын талбайд зөөвөрлөн авчирсан химийн болон аюултай материалыг зайлуулах, устгах ажлыг хог хаягдлын тухай хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, ажлын талбайг цэвэрлэж, аюулгүй байдлыг хангана.

3.3. Нийгмийн менежмент

а) Гүйцэтгэгч нь нийгмийн өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түүхийн болон соёлын үнэт зүйлсийг хамгаалах, орон нутгийн оршин суугчид, малчид, засгийн газрын болон төрийн бусад байгууллагуудад сонирхогчийн түвшинд мэдээлэл гаргаж өгөх, оролцох, аливаа хүсэлт, шаардлага, гомдолд хариу өгөх зэргээр хамтын ажиллагааг явуулна.

б) Гүйцэтгэгч нь орон нутгийн уламжлалыг хүндэтгэж, эдийн болон эдийн бус соёлын эд зүйлсийг хүндэтгэнэ. Тахилгатай уул, нутаг дэвсгэр зэргийг хөндөхийг хатуу хориглоно.


с) Нутгийн иргэдийн зан заншлыг хүндэтгэж, малчдын усны эх үүсвэр болон гар худгийг ашиглахыг хатуу хориглоно. Гүйцэтгэгч нь тусгайлан тогтоосон худгийг төмөр замын барилгын ажилд ашиглана.

д) Гүйцэтгэгч нь мэргэжлийн шаардлага хангасан орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахыг хичээнэ.


е) Гүйцэтгэгч нь Захиалагчтай орон нутгийн эдийн засгийг дэмжихэд хамтран ажиллах бөгөөд орон нутгаас эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа, үйлчилгээ худалдан авахыг эрмэлзэнэ.

ф) Гүйцэтгэгч нь орон нутгийн иргэдээс ирсэн аливаа гомдлыг цаг тухайд нь (хамгийн ихдээ 10 өдөр, шаардлагатай бол илүү хурдан хугацаанд) хариу өгч, барагдуулах бөгөөд орон нутгийн иргэд, ажилчид, туслан гүйцэтгэгчдээс ирсэн аливаа гомдолтой холбоотой засварлах ажиллагааг хэрэгжүүлнэ.

Мөн түүнчлэн, гүйцэтгэгч нь орон нутгийн иргэд, туслан гүйцэтгэгч, ажилчдаас ирсэн гомдлыг сар бүр тайлан болгон бэлтгэж, тэдгээр гомдлыг хэрхэн барагдуулах боломжтой эсэх талаар захиалагчтай зөвлөлдөнө. Гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж Захиалагч болон гомдол гаргагчид мөнгөн болон материаллаг хохирол үүссэн бол бүх хохирол зардлыг Гүйцэтгэгч барагдуулна.

ЗАХИАЛАГЧ


3

ГҮЙЦЭТГЭГЧ


3.4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд тавигдах бусад шаардлага

а) Захиалагч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гэнэтийн болон хугацаат үзлэг хийнэ. Гүйцэтгэгч нь ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчил, үл нийцлийг арилгах үүрэгтэй.

б) БОХНСНУТ-д заасан үүргээ биелүүлээгүй, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол үүсэх хариуцлагыг Гүйцэтгэгч хариуцна.

с) Төслийн зам, барилгын ажилд ашигласан ТТАМ-ын орд, кемпийн газар, түр зам зэрэг Гүйцэтгэгчийн зүгээс нөхөн сэргээх шаардлагатай газруудыг холбогдох орон нутгийн төрийн захиргааны байгууллагын томилсон албан тушаалтанд албан ёсоор хүлээлгэн өгөх хүртэл нөхөн сэргээлтийн зардлыг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс барьцаа хэлбэрээр Захиалагчийн дансанд saatулна.

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200131

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 5-ТАЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМ” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАЛ
ХХК

1119279488
РАМБАКАТКАР

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

1119279488
РАМБАКАТКАР

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

1119279488
РАМБАКАТКАР

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.УДААНЖАРГАЛ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ”ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 06-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200132

**ХОГ ХАЯГДЛЫН ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛҮҮЛЭХ
БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

❖ Гүйцэтгэгч бөгөлнө:

Хүсэлт гаргасан огноо:		Хог хаягдлын зөвшөөрлийн дугаар:			
Хамаарах	Сумын нэр:				
	Багийн нэр:				
Хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр:					
Хүсэлт гаргагчийн албан тушаал, овог, нэр:					
Хог хаягдлын түр цэг тогтоох захирамжийн дугаар:					
Хог хаягдлын гэрээний дугаар (TYK-тэй байгуулсан)					
Хог хаягдалын зөвшөөрсөн цэгт байгаа эсэх?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Хог хаягдал ангилан ялгаж хаясан эсэх?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Орчны бохирдлыг цэвэрлэсэн эсэх?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Аюултай хог хаягдлыг тусгай цэгт хаясан эсэх?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Нойл байгуулах, бохир ус хаях цэг тогоолгож захирамж, орон нутгийн захирамж гаргуулсан эсэх ?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Нойл байгуулах, бохир ус хаях цэг тогоолгосон захирамжийн хуулбар хавсаргасан эсэх ?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Хог хаягдал цуглуулах талбайн хэмжээ (м ²)					
Хог хаягдалын хэмжээ (м ³ /сар, жил)					
Хог хаягдлын төлбөрийн хэмжээ (төгрөг)					
Бохир ус, нойл (м ³)					
Тайлбар:					
Хяналт тавих ажилтнууд:					
❖ Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөл:			❖ Захиалагчийн төлөөлөл:		
Овог нэр:			Овог нэр:		

ЗАХИАЛАГЧ

Албан тушаал:		Албан тушаал:	
Гарын үсэг:		Гарын үсэг:	

Баталгаажуулалт захиалагч:

Овог нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	

Шийдвэрлэсэн байдал:

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шийдвэр хавсаргасан эсэх?	<input type="checkbox"/>
Хууль тогтоомж, журам, стандартад нийцүүлж дахин хийх:	<input type="checkbox"/>
Бусад:	<input type="checkbox"/>
Баримтжуулалт: 2-оос доошгүй фото зураг хавсаргана (өмнөх, дараах)	<input type="checkbox"/>
Ашиглалтын үеийн фото зураг	
Дараах фото зураг	

ЗАХИАЛАГЧ
ЧЧ

ЗХЖШ 2200152

**ТҮР КЕМПИЙН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙЖ,
ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН МАЯГТ**

❖ Гүйцэтгэгч бөгөлнө:

Хүсэлт гаргасан огноо:		Түр кемпийн зөвшөөрлийн дугаар:		Трассын аль хэсэгт:	Баруун	Зүүн	ПК
Хамаарах	Сумын нэр:						
	Багийн нэр:						
Хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр:							
Хүсэлт гаргагчийн албан тушаал, овог, нэр:							
Орон нутгийн ЗД-ын олгосон захирамжийн огноо, дугаар:							
Талбайн хэмжээ (m^2)							
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд байгаа эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Орчны бохирдлыг цэвэрлэсэн эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Нөхөн сэргээлтийг холбогдох журам, стандартын дагуу хийсэн эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Ахуйн болон бусад бохирдлыг цэвэрлэсэн эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Тос тослогооны бодисоор бохирдсон талбайг цэвэрлэсэн эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Бусад материалаар цардсан талбайг цэвэрлэсэн эсэх ?		<input type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
Тайлбар:							

Хяналт тавих ажилтнууд:

❖ Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөл:		❖ Захиалагчийн төлөөлөл:	
Овог нэр:		Овог нэр:	
Албан тушаал:		Албан тушаал:	
Гарын үсэг:		Гарын үсэг:	
Баталгаажуулалт захиалагч:			
Овог нэр:			
Албан тушаал:			

ЗАХИАЛАГЧ
Гүйцэтгэгч
Г.Доржнамжил

Гарын үсэг:	
Шийдвэрлэсэн байдал:	
Орон нутагт хүлээлгэн өгсөн акт, бусад холбогдох материалыг хавсаргасан эсэх:	<input type="checkbox"/>
Хууль тогтоомж, журам, стандартад нийцүүлж дахин хийх:	<input type="checkbox"/>
Бусад:	<input type="checkbox"/>
Баримтжуулалт: 2-с доошгүй фото зураг хавсаргана (өмнөх, дараах)	<input type="checkbox"/>
Өмнөх фото зураг	дараах фото зураг

ЗАХИАЛАГЧ
Ч

ЗХЖШ 2200154

**НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ТҮР ЗАМ, САЛАА ЗАМ
ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ МАЯГТ**

❖ Гүйцэтгэгч бөгөлнө:

Хүсэлт гаргасан огноо:		Трассын аль хэсэгт:		Баруун	Зүүн	ПК
Хамаарах	Сумын нэр:					
	Багийн нэр:					
Хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр:						
Хүсэлт гаргагчийн албан тушаал, овог, нэр:						
Зөвшөөрлийн хүрээнд байгаа эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Орчны бохирдлыг цэвэрлэсэн эсэх (нийт уртын дагуу, 200м радиуст)?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Шимт хөрсийг тусгай талбайд овоолж хадгалсан эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Нөхөн сэргээлтийг холбогдох журам, стандартын дагуу хийсэн эсэх?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Нөхөн сэргээлт хийсэн түр замуудыг шимт хөрсөөр хучсан эсэх				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Тос тослогооны бодисоор бохирдсон хэсгийг цэвэрлэсэн эсэх?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Талбайн хэмжээ (m^2)						
Тайлбар:						

Хяналт тавих ажилтнууд:

❖ Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөл:	❖ Захиалагчийн төлөөлөл:
Овог нэр:	Овог нэр:
Албан тушаал:	Албан тушаал:
Гарын үсэг:	Гарын үсэг:

Баталгаажуулалт захиалагч:


Овог нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	

Шийдвэрлэсэн байдал:

Орон нутагт хүлээлгэн өгсөн акт, бусад холбогдох материалыг хавсаргасан эсэх:	<input type="checkbox"/>
---	--------------------------

ЗАХИАЛАГЧ

Хууль тогтоомж, журам, стандартад нийцүүлж дахин хийх:	<input type="checkbox"/>
Бусад:	<input type="checkbox"/>
Баримтжуулалт: 2-оос доошгүй фото зураг хавсаргана (өмнөх, дараах)	<input type="checkbox"/>
Өмнөх фото зураг	Дараах фото зураг

ЗАХИАЛАГЧ


ЗХЖШ 2200156

АСГАРАЛТ ЦЭВЭРЛЭСЭН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Ерөнхий мэдээлэл:

Асгаралт цэвэрлэсэн бүртгэлийн дугаар:

Асгаралт
үүссэн огноо:

Асгаралт
цэвэрлэсэн огноо:

Асгаралт болсон
газрын байршил:

Асгаралтын мэдээлэл:

Асгарсан
бодис:

Дизель
 Хөдөлгүүрийн ба бусад
шингэн
 Техникийн тос

Бензин
 Химийн бодис
 Бохир ус

Бусад

Бодисын асгарсан
хэмжээ:

литр

Өртсөн талбайн хэмжээ:

M²

Бохирдсон хөрсний
хэмжээ:

M³

Бохирдсон
талбай:

Ургамалтай газар
шимиж хөрстэй газар

Элэгдэлд орсон газар
Уст цэгийн орчим

Зам дээр
Бусад

Асгаралтыг цэвэрлэсэн байдал:

Асгаралт
цэвэрлэх үеийн
баримтжуулалт

Цэвэрлэхийн өмнө

Цэвэрлэсний дараа

Фото зураг

Фото зураг

Асгаралтыг
хэрхэн
цэвэрлэсэн
тайлбар:

Тэмдэглэл
хөтөлсөн
ажилтан:

Албан тушаал:

Огноо:

Баталгаажуулалт захиалагч:

Овог нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

Шийдвэрлэсэн байдал:

ЗАХИАЛАГЧ

МАЛ, АМЬТАН ҮХСЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ МАЯГТ

❖ Гүйцэтгэгч бөгөлнө:

Огноо:		Трассын аль хэсэгт:		Баруун	Зүүн	ПК дугаар
Төслийн талбайгаас алслагдсан зай, /км/						
Хамаарах		Сумын нэр:				
		Багийн нэр:				
№	Үхсэн амьтан	Тоо, толгой	Шалтгаан	Хариу арга хэмжээний тухай санал	Хариуцсан ажилтан	
1						
2						
3						
4						
5						
Авсан арга хэмжээний тайлбар						
6						
Сэг зэмийг устгасан тухай мэдээлэл						
7	Анхны байдал фото зураг			Устгалын дараах фото зураг		

- ❖ Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд ажиллах;
- ❖ Амьтан гэж Монгол орны нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загс, хавч хэлбэртэн, шавьж, зөвлөн биет, эгэл биетэн хамаарна – Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйл /4/;

ЗАХИАЛАГЧ

**УС ХЭРЭГЛЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ
МАЯГТ**

❖ Гүйцэтгэгч бөгөөн:

Хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр:					
Хүсэлт гаргагчийн албан тушаал, овог, нэр:					
Хүсэлт гаргасан огноо:		Ашигласан худгийн дугаар:	Трассын аль хэсэгт:		
			Баруун	Зүүн	ПК
Хамаарах	Сумын нэр:				
	Багийн нэр:				
Ус түгээлтийн бүртгэлтэй эсэх?		<input type="checkbox"/>	Тийм	<input type="checkbox"/>	Үгүй
Усны тоолуурын заалт (м ³)					
Эхлэх		Дууссан			
Ашигласан усны хэмээ м ³					
Хоног		Сар		Жил	
Ашигласан усны төлбөр (төлбөр төлсөн баримт):					
Тайлбар:					
Баталгаажуулалт ус түгээгч:					
Овог нэр:					
Албан тушаал:					
Гарын үсэг:					
Баталгаажуулалт орон нутаг, байцаагч:					
Овог нэр:					
Албан тушаал:					
Гарын үсэг:					
Баталгаажуулалт захиалагч:					
Овог нэр:					
Албан тушаал:					
Гарын үсэг:					
Шийдвэрлэсэн байдал:					

ЗАХИАЛАГЧ

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРД АШИГЛАСАН,
НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

❖ Гүйцэтгэгч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:		Карьериин дугаар:		Трассын аль хэсэгт:	<input type="checkbox"/> Баруун	<input type="checkbox"/> Зүүн	<input type="checkbox"/> Зай (м)
Хамаарах	Сумын нэр:						
	Багийн нэр:						
Хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн нэр:							
Хүсэлт гаргагчийн албан тушаал, овог, нэр:							
Тайлбар:							
Талбайн хэмжээ (m^2)				Хөрс хуулалтын хэмжээ (m^2)			
Үүнээс:	<input type="checkbox"/> Шимт хөрс (m^3)			<input type="checkbox"/> Хаягдал хөрс (m^3)			
Тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөл олгосон захирамжийн огноо, дугаар:							
Сум, дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээний хуулбар хавсаргасан эсэх?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр төлсөн баримт хавсаргасан эсэх?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Зөвшөөрөл авсан талбайн хэмжээнд ашигласан эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Орчны бохирдлыг цэвэрлэсэн эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Нөхөн сэргээлтийг холбогдох журам, стандартын дагуу хийсэн эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан эсэх ?				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй		
Хяналт тавих ажилтнууд:							
❖ Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөл:				❖ Захиалагчийн төлөөлөл:			
Овог нэр:				Овог нэр:			
Албан тушаал:				Албан тушаал:			
Гарын үсэг:				Гарын үсэг:			
Баталгаажуулалт захиалагч:							
Овог нэр:							
Албан тушаал:							
Гарын үсэг:							

ЗАХИАЛАГЧ

Шийдвэрлэсэн байдал:	
Орон нутагт хүлээлгэн өгсөн акт, холбогдох материалыг хавсаргасан эсэх:	<input type="checkbox"/>
Хууль тогтоомж, журам, стандартад нийцүүлж дахин хийх:	<input type="checkbox"/>
Бусад:	<input type="checkbox"/>
Баримтжуулалт: 2-с доошгүй фото зураг хавсаргана (өмнөх, дараах)	<input type="checkbox"/>
Анхны байдал фото зураг	
Нөхөн сэргээлтийн дараах	
Ашиглалтын үеийн фото зураг	

ЗАХИАЛАГЧ

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөвлөгийн барилга
угсралтын ажил гүйцэтгэх гэрээний нөхцөлийн
Хавсралт 3-Ажлын график төлөвлөгөө

**ХАВСРАЛТ №3
АЖЛЫН ГРАФИК ТӨЛӨВЛӨГӨӨ**

(“Тавантолгой Төмөр Зам” ХХК болон Зэвсэгт Хүчний Жанжин Штабын хооронд
2022 оны 7 дугаар сарын 07-ны өдөр байгуулав.)

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

"БОГДХАН ТӨМӨР ЗАМ" ТӨСЛИЙН ДООД БҮТЭЦ, ӨРТӨӨ, ЗӨРЛӨГИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ
ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ХАВСРАЛТ №3 - АЖЛЫН ГРАФИК ТӨЛӨВЛӨГӨӨ

"БОГДХАН ТӨМӨР ЗАМ" ТӨСЛИЙН ГРАФИК ТӨЛӨВЛӨГӨӨ
ДООД БҮТЭЦ БОЛОН ӨРТӨӨ, ЗӨРЛӨГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМИХ БАРИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эхлэх хугацаа: 7/1/2022
Дуусах хугацаа: 6/15/2024

№	Хийгдэх ажил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Үргэлжлэх хоног	7. САР	8. САР	9. САР	10. САР	11. САР	12. САР	2022	2023	2024
					1 САР	2 САР	3 САР	4 САР	5 САР	6 САР	7 САР	8 САР	9 САР
1. Судалгааны ажлууд													
1.2	Кемпүүдийн байршлүүдиг тодорхойлох	7/1/2022	7/20/2022	19									
1.3	Карьеруудын байршлүүдиг тодорхойлох	7/1/2022	7/20/2022	19									
1.4	Кемпүүдийн байгуулах	7/1/2022	7/20/2022	19									
2. Төслийн талбайн ажил													
2.1	Нүүлгэн шилжүүлэлт, тохижилт хийх	7/3/2022	7/20/2022	17									
2.2	Улаан шугам хүлээлцэх ажил хийх	7/21/2022	7/27/2022	6									
3. ПК0+000-ПК144+900													
3.1	Карьеруудыг нээх	7/22/2022	7/30/2023	373									
3.2	Технологийн зам байгуулах	7/25/2022	8/25/2022	31									
3.3	Түр репер байгуулах	7/24/2022	8/29/2022	36									
3.4	Тэнхлэг болон хормойн гадаслагаа байгуулах	7/27/2022	8/30/2022	34									
3.5	Үргамалын үе хуулах	7/30/2022	5/23/2023	297									
	Сэтэрхий байгуулах	8/2/2022	9/23/2023	417									
4. ПК0+000-ПК144+900													
4.1	Багц 1: Рашиант өртөөнөөс 1 дүгээр зөвлөгүүртэлх доод бүтцийн ажил	4/10/2023	10/30/2023	203									
	Далан байгуулах	4/10/2023	10/30/2023	203									
	Хоолой хийх	4/10/2023	9/30/2023	173									
	Гүүр барих	4/10/2023	9/30/2023	173									
4.2	Багц 2: 1 дүгээр зөвлөгүүс Хайрхан-Уул өртөөхүртэлх доод бүтцийн ажил	4/10/2023	10/30/2023	203									
	Далан байгуулах	4/10/2023	10/30/2023	203									
	Хоолой хийх	4/10/2023	9/30/2023	173									
	Гүүр барих	4/10/2023	9/30/2023	173									
4.3	Багц 3: Хайрхан-уул өртөөнөөс 2 дугаар зөвлөгүүртэлх доод бүтцийн ажил	4/10/2023	10/30/2023	203									
	Далан байгуулах	4/10/2023	10/30/2023	203									
	Хоолой хийх	4/10/2023	9/30/2023	173									

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

	Гүүр барих	4/10/2023	9/30/2023	173	
4.4	Багц 4: 2 дугаар зэрлөгөөс Хөшигт өртөө хүртэлх доод бүтцийн ажил	4/10/2023	10/30/2023	203	
	Далан байгуулах	4/10/2023	10/30/2023	203	
	Хоолой хийх	4/10/2023	9/30/2023	173	
	Гүүр барих	4/10/2023	9/30/2023	173	
4.5	Багц 5: Хөшигт өртөөнөөс 3 дугаар зэрлөг хүртэлх доод бүтцийн ажил	7/1/2022	8/30/2023	425	
	Далан байгуулах	7/1/2022	8/30/2023	425	
	Хоолой хийх	7/1/2022	7/30/2023	394	
	Гүүр барих	7/1/2022	7/30/2023	394	
4.6	Багц 6: 3 дугаар зэрлөгөөс 4 дүгээр зэрлөг хүртэлх доод бүтцийн ажил	7/1/2022	8/30/2023	425	
	Далан байгуулах	7/1/2022	8/30/2023	425	
	Хоолой хийх	7/1/2022	7/30/2023	394	
	Гүүр барих	7/1/2022	7/30/2023	394	
4.7	Багц 7: 4 дүгээр зэрлөгөөс 5 дугаар зэрлөг хүртэлх доод бүтцийн ажил	7/1/2022	8/30/2023	425	
	Далан байгуулах	7/1/2022	8/30/2023	425	
	Хоолой хийх	7/1/2022	7/30/2023	394	
	Гүүр барих	7/1/2022	7/30/2023	394	
4.8	Багц 8: 5 дугаар зэрлөгөөс 6 дугаар зэрлөг хүртэлх доод бүтцийн ажил	7/1/2022	8/30/2023	425	
	Далан байгуулах	7/1/2022	8/30/2023	425	
	Хоолой хийх	7/1/2022	7/30/2023	394	
	Гүүр барих	7/1/2022	7/30/2023	394	
4.9	Багц 9: 6 дугаар зэрлөгөөс Мааньт өртөө хүртэлх доод бүтцийн ажил	7/1/2022	8/30/2023	425	
	Далан байгуулах	7/1/2022	8/30/2023	425	
	Хоолой хийх	7/1/2022	7/30/2023	394	
	Гүүр барих	7/1/2022	7/30/2023	394	
4.10	Багц 10: Барилга байгууламжийн ажил	4/10/2023	10/10/2024	549	
4.11	1, 2, 3, 4, 5, 6 дугаар зэрлөг	4/10/2023	6/1/2024	418	
4.13	Хайрхан-Үул өртөө	4/10/2023	6/1/2024	418	
4.14	Хөшигт өртөө	4/10/2023	6/1/2024	418	
4.15	Хөшигтийн өртөөний суурьшлын бус	4/10/2023	6/1/2024	418	
5.1	Карьерийн нөхөн сэргээлт	4/10/2024	6/2/2024	53	
5.2	Техникийн комисс ажиллуулах	6/3/2024	6/8/2024	5	
5.3	Улсын комисс ажиллуулах	6/10/2024	6/15/2024	5	

ЗАХИАЛАГЧ

Сү

ГҮЙЦЭТГЭГЧ

Б.Нямжаргалан

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ З-ТАЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМУХЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

6375405 СБА2198

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.УДААНЖАРГАЛ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.Батзориг Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН
ДАРГА, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

Х.БАТСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

У.Ундрах У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

Б.Цэрэнпил Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

ИЛ БОЛСОН

МАШ НҮҮЦ

“Богдхан төмөр зам” төслийн доод бүтэц, өртөө, зөрлөгийн барилга
угсралтын ажил гүйцэтгэх гэрээний нөхцөлийн Хавсралт 6 –
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ХАВСРАЛТ 6

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

(“Тавантолгой төмөр зам” ХХК болон Зэвсэгт Хүчний Жанжин Штаб-ийн хооронд 2022
оны ... дугаар сарын ... -ний өдөр байгуулав.)

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200145

ГҮЙЦЭТГЭГЧ

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ
ХАНГУУЛАХ ХҮРЭЭНД:**

1. УДИРТГАЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь нэг талаас “Тавантолгой төмөр зам” ХХК цаашид “Захиалагч” гэх бөгөөд байгуулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гэрээний (энэ гэрээг цаашид “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гэрээ” гэх) дагуу өөрийн ажилтан, тоног төхөөрөмж, машин техник, механизмыг захиалагчийн талбайд ажиллуулах гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, иргэн, хуулийн этгээд (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбоотой бүх хууль, дүрэм, журам, заавар, тогтоомжыг мөрдөж ажиллах, талууд хоорондын хүлээх эрх, үүрэг, хариуцлага, шаардлагуудыг тодорхойлоход оршино.

1.2. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудлыг хариуцаж осол, зөрчил, гамшиг, үл тохиролыг 24 цагийн дотор мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай авч захиалагч талын баримт бичгийн хавсралтын дагуу шийдвэрлэнэ.

1.3. Гүйцэтгэгч нь эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээх эрх, үүргийг энэхүү гэрээний З дугаар зүйлд тодорхойлсон ба өдөр тутмын найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах, хүлээсэн үүрэг даалгаврыг чанд биелүүлж ажиллана.

1.4. Гүйцэтгэгч нь өөрийн болон туслан гүйцэтгэгч талын ажиллах хүчиний аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, тайлан мэдээг хугацаанд ирүүлж гэрээний хэрэгжилтийг хангана.

1.5. Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэгчээс өгсөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбоотой зөрчлийн талаар санал зөрөлдвөл захиалагч талыг оролцуулан хөндлөнгийн шийдвэр гаргуулж болно.

1.6. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбоотой зөрчлийг арилгуулахаар талаар удаа дараа шаардлага хүргүүлсэн, зөрчил арилгаагүйн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул үүссэн, эсвэл эрсэдсэн тохиолдолд туслан гүйцэтгэгч талын гэрээг цуцлах үндэслэл байж болно.

1.7. Гүйцэтгэгч нь захиалагчийн шаардлагыг бүхий л заалтыг хэрэгжүүлнэ.

1.8. Гэрээний хавсралтууд нь төслийн баримт бичгийн нэг хэсэг байна.

1.9. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй тохиолдоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах, зайлшгүй шаардагдах хөрөнгийт баталсан байна.

1.10. Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү гэрээг захиалагч байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж буй бүх гүйцэтгэгч үйл ажиллагаандаа дагаж мөрднө.

3. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

а) Гүйцэтгэгч аюултай тохиолдоос урьдчилан сэргийлэх албан тушаалтан (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл аухийн ажилтан) төслийн хугацаанд ажлын талбайд томилон ажиллуулах бөгөөд уг ажилтан нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, аюултай тохиолдол (осол, осолд дөхсөн тохиолдол)-оос урьдчилан сэргийлэх,

ЗАХИАЛАГЧ
Гүйцэтгэгч

судлан бүртгэх арга хэмжээг хариуцаж ажиллана. Тухайн ажилтан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны сургалтанд хамрагдсан ажил үүргээ биелүүлэх ур чадвартай байна.

b) Гүйцэтгэгч нь захиалагчийн гаргасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журамтай танилцаж ажлын туршид дагаж мөрдөнө.

c) Аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаагүй, шалгалтанд тэнцээгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

d) Гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны MNS4969:2000 стандартын дагуу өдөр бүр ажилтнууддаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг тухайн ажлын онцлогт тохируулан өгч гарын үсэг зуруулсан байна. Хэрэв Гүйцэтгэгч нь зааварчилгаа өгч тухайн ажилтнаар гарын үсэг зуруулаагүйгээс болж үүдэн гарах аливаа асуудлыг бүрэн хариуцана.

e) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөрийн дагуу аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулах (үндсэн болон гэрээт байгууллагын ажилтнуудыг бүгдийг хамруулах).

f) Эрүүл аюулгүй ажлын орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бүх арга хэмжээг авч ажиллана.

g) Гүйцэтгэгч байгууллагын ажилтан нар төслийн талбайд байрлуулсан аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглээг чанд мөрдөж биелүүлэх үүрэгтэй ба захиалагчийн ажилтны тавьсан шаардлагад нийцүүлж ажиллана.

h) Аливаа ажлыг шинээр эхлүүлэхийн өмнө ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж түүний дагуу арга хэмжээ авсаны дараа ажлыг эхлүүлнэ. Энэ тухай мэдээллийг захиалагчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдэгдсэн байна.

i) Ажлын байрны үзлэгийг графикийн дагуу тогмол хийж осол зөрчлийг багасгах, арилгах болон аюулгүй ажиллагааны заавар дүрэм журам хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах

j) Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх ажлын байранд хяналт тавьж ажиллах ба өөрийн ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.

Үүнд:

- Хамгаалалтын малгай (каск)
- Нүдний шил
- Хөл хамгаалах гутал
- Өндрийн бүс
- Ажлын бээлий
- Ажлын хувцас, цацуулагчтай
- Mask

k) Гүйцэтгэгч байгууллага нь өөрийн ажилтнуудад аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгаа, зөвлөгөө, зөвлөмжийг тогтмол өгнө.

l) Гүйцэтгэгч нь тоног төхөөрөмжийг бат найдвартай угсарсан байдлыг болон тэдгээр тоног төхөөрөмжүүдийг ажлын гүйцэтгэлийн шаардлагатай дарааллын дагуу таслахгүй найдвартай үргэлжлүүлэх шаардлага хангасан байдлыг шалгаж үзнэ.

m) Машин тоног төхөөрөмж нь бүрэн зогссон мөн тоног төхөөрөмжийг цахилгаанаас бүрэн тусгаарлагдсан, аюулгүй байдлыг бүрэн хангасан үед түүнд засвар үйлчилгээ хийнэ.

n) Гүйцэтгэгч нь эд материал тоног төхөөрөмжид учирч болох гарз хохирол болон ажилчдад гэмтэл бэртэл учирхаас урьдчилан сэргийлэх зорилгоор түүнээс хамгаалах арга

ЗАХИАЛАГЧ

хэмжээний заавар зөвлөгөөг боловсруулан ажилчдад байнга даган мөрдүүлэх ба түүнд хэрэглэгдэх шаардлагатай эд материалын хангах үүрэг хүлээн ажиллана.

о) Гүйцэтгэгч нь аливаа бараа материал, хийн баллон, газ, тэсэрч дэлбэрэх аюултай бодис ашиглах зэрэгт гарал үүслийн бичиг авсан байх ба захиалагийн инженерээс зөвшөөрөл авч ажлыг эхлүүлнэ.

р) Ажлын байрны эмх цэгц, талбайн зохион байгуулалт, ажлын байрны болон амрах байр, усанд орох болон бие засах газар зэргийн цэвэрлэгээг тогтмол хийж байх.

4. ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

а) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөтэй танилцаж, хэрэгжилтэнд хяналт тавих.

б) Онцгой байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, журам гаргах, хэрэгжүүлэх.

с) Ажилтнуудад өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа нь үнэн зөв өгч буй эсэхэд хяналт тавих.

д) Тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт хийсэн, үзлэгээр илэрсэн алдаа дутагдлыг гүйцэтгэгч байгууллага залруулсан эсэх тайланг авах, залруулах ажлыг хугацаанд нь биелүүлээгүй бол зөрчлийг арилгуулах хүртэл ажлыг түр хугацаагаар зогсоож болно.

е) Ажлын байрны үзлэгийг графикийн дагуу тогтмол хийж осол зөрчлийг багасгах, арилгах болон аюулгүй ажиллагааны заавар дүрэм журам хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

ф) Талбайн харуул хамгаалалтыг хариуцаж байгаа үед нэвтрэн орж, гарч байгаа гүйцэтгэгч компанийн ажилтнуудын үнэмлэх бичиг баримтыг шалгах.

г) Захиалагч нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гэнэтийн болон хугацаат үзлэг хийх эрхтэй. Гүйцэтгэгч нь ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчил, үл тохирлыг арилгаж, мэдээллийг тухай бүр нь захиалагчид хүргүүлнэ.

5. Талуудын хамтын ажиллагаа.

а) Өөрийн ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи, сургалт, семинарт хамруулах үүрэгтэй.

б) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж түүнийг мөрдлөг болгон ажиллах тал дээр хамтран ажиллах.

с) Ажлын байрны аюулгүй ажиллагааны 3 шатны хяналтыг шаардлагатай тохиолдолд хамтран хийх.

д) Тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай, аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллах дээр хамтран ажиллах.

е) Эрсдэл өндөртэй ажлын байран дээр эрсдэлийн үнэлгээг хамтран хийх.

ф) Аливаа осол эндэгдэл зөрчил, бэртэл гэмтэл, осолд дөхсөн шалтгааныг судлан тогтоох, холбогдох мэдээллийг зөв шуурхай мэдэгдэх, хариу арга хэмжээ авах, уг осол зөрчлийг дахин гаргахгүй байх тал дээр хамтран ажиллах.

г) Ажлын байрны аюулгүй ажиллагаа алдагдсан, байгалийн гамшиг, халдварт өвчин болон төлөвлөгдөөгүй түр болон удаан хугацааны ажил зогссон шийдвэрийг яаралтай шийдвэрлэх.

х) Ажлын тайлбайд нэвтрэх эрхгүй хүмүүст зөвшөөрөл авах тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч нар харилцан мэдээлэлийг хүргүүлсэн байна.

ЗАХИАЛАГЧ

6. Гүйцэтгэгч, гэрээт байгууллагуудад тавигдах шаардлага

- a) Гүйцэтгэгч нь кранист, оосорлогч, машин механизмын оператор, цахилгаанчин, гагнуурчин, засварчин, жолооч гэх мэт тусгай мэргэжлийн эрхтэй хүнийг ажиллуулна.
- b) Гүйцэтгэгч нь өөрийн ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах талаар бүх арга хэмжээг авна. Эрүүл ахуйн шаардлагыг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, анхны тусламжийн өрөө, эмнэлэг/эмч/-ийн ажилтантай байна.
- c) Гүйцэтгэгч кемп, тоног төхөөрөмж, машин техник, механизмын онцлогт тохирсон аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулсан байна. Мөн шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлт хийхдээ захиалагч талд мэдэгдэж аюулгүй ажиллагааны бүхий л горимыг мөрдөнө.
- d) Гүйцэтгэгч нь ажилд гаражын өмнө машин техник, тоног төхөөрөмжийн холбогдо бичиг баримтын бүрдэл, баталгаажилт, үзлэг оношлогоо, нэр төрөл, багаж хэрэгсэл тэдгээрийн бүрэн бүтэн байдал, хүн хүчний тоо зэргийг захиалагч талд гарган өгнө.
- e) Гүйцэтгэгч гэрээт компанийн машин механизм, тоног төхөөрөмж болон ажилтан албан хаагч осолдвол үйлдвэрлэлийн ослын актыг зохих журмын дагуу үйлдэж учирсан хохиролыг өөрийн зардлаар бүрэн барагдуулж холбогдох материалуудыг захиалагчид бүрдүүлж өгөх ба нуун дарагдуулахыг хориглоно.
- f) Үйлдвэрлэлийн ослыг захиалагч тал өөр дээрээ бүртгүүлэхгүй бөгөөд гүйцэтгэгч болон гэрээт компани өөрийн аж ахуйн нэгж дээрээ хүлээн авч бүртгүүлнэ. Аливаа осол эндэгдлийг тухайн компани өөрөө бүрэн хариуцаж, нөхөн олговортой холбоотой зардлыг бүрэн хариуцана.
- g) Гүйцэтгэгч, гэрээт компанийн ажилтан төслийн талбай дээр ажиллаж байх хугацаанд бусдыг зодож хэл амаар доромжилж танхайрсан, архи уусан, согтууруулах ундааны тестээр шалгахад 0.00 хувиас өөр үр дүн гарсан, эрх бүхий удирдах ажилтаны зүй ёсны тавьсан шаардлагыг биелүүлээгүй хэл амаар доромжилсон тохиолдолд захиалагч тал тус ажилтныг төслийн талбайгаас явуулах шаардлагыг гүйцэтгэгч компанийд тавих бөгөөд гүйцэтгэгч компани нь өөрийн зардлаар тухайн ажилтныг төслийн талбайгаас 24 цагийн дотор явуулах бөгөөд дахин ирүүлэхгүй байлгах арга хэмжээг авна.

ЗАХИАЛАГЧ

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 6-ТАЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР
ЗАМ" ХХК ИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Н.УДААНЖАРГАЛ


1119279488
2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Б.БОЛОР-ЭРДЭНЭ


2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

 Э.ЭРДЭНЭБАТ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА

 Т.БАТЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ГҮЙЦЭТГЭГЧ "ЗЭВСЭГТ" ХҮЧНИЙ
ЖАНЖИНШТАБ"-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИНШТАБЫН
ДАРГА, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ

 Д.ГАНЗОРИГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

 Х.БАТСАЙХАН


2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ОРЛОГЧ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ХУРАНДАА

 Ц.ГАНХӨЛӨГ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

 У.УНДРАХ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН
УДИРДАХ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН ОФИЦЕР,
ДЭСЛЭГЧ

 Б.ЦЭРЭНПИЛ

2022 оны 7 дугаар сарын 07-ний өдөр

ЗАХИАЛАГЧ

ЗХЖШ 2200150

